

МОНТЕ КРИСТО ГҮН

2-р дэвтэр

Гуравдугаар бүлэг

I. Альберын зочид

Де Морсер бэйс бүр Ром хотод байхдаа Монте-Кристо гүнтэй уулзахаар болзсон Эльдер гудамжин дахь байшинд тавдугаар сарын 21-ний өглөө зочноо нэр төртэй хүлээн авахаар бэлтгэл хийж байв.

Альбер том хашааны булан дахь, албаны байшингийн өөдөөс харсан жигүүрийн байшинд суудаг байжээ. Энэ байшингийн зөвхөн хоёр цонх нь гудамж руу харж, гурав нь хашаа уруу, бусад хоёр нь цэцэрлэг өөдөө харжээ.

Хашаа цэцэрлэг хоёрын хооронд гүн ба гүнгийн авгай де Морсерын суудаг наполеоны үеийн үзэмж муутайхан маягаар барьсан байшин байна. Эзэмшил газрын өргөний хирээр дагуу гудамжны хашаа байх бөгөөд түүнийхээ дээгүүр савтай цэцэг тавьж, дунд нь алтадсан жаднуудаар хийсэн том гол хаалга байна. Хаалгачийн байшингийн дэргэдэх явган хаалга нь үйлчлэгч зарц нар болон эздийн байшингаасаа явганаар гарч орж ирэхэд зориулжээ. Альберт тусгай байшин гаргаж өгсөн нь, хүүгээсээ холдох дургүй мөртөө өдий насны залуу хүн дүүрэн чөлөөтэй байхыг хүсдэг болохыг мэдэх эх хүний энхрийлэл, алсын хараатай сэтгэлийг харуулна. Нөгөө талаас, баян эцэг эхийн дур зоргоороо цэнгэн амьдрам дуртай тийм хөвгүүдийн биеэ тоосон байдал тодхон харагдана.

Альбер гудамж уруу харсан цонхоороо гадаад ертөнцийг харж байж болно. Ер нь залуу хүмүүст нүдний нь өмнө сайхан хүүхнүүд харагдаж байх нь чухал байдаг шүү дээ. Тэгээд хэрвээ нэлээд гүнзгий судлах хэрэг тохиолдвол Альбер, үүдний манаачийн байшингийн дэргэдэх явган хаалгатай адилхан үүдээр гарья болох байв.

Энэ хаалгыг байшин барьсан өдрөөс хойш мартаж орхисон мэт үл ажиглагдам, тоос шороо дарсан байх харагдана. Гэвч цоож цуургыг нь нямбайлан тосолсон байх нь энэ хаалгыг байн байн нууцаар хэрэглэдгийг гэрчилнэ. Энэ нууц хаалга, бусад хоёр хаалгатай өрсөлдөн, манаачийн сэрэмжтэй нүднээс далдуур “Мянга нэгэн шөнийн үлгэр”-ийн агуй шиг Али Бабын шидэт “Сезам” шиг, эелдэг урьхан дуугаар хэлсэн хоёр гуравхан нууцат үг ч юм уу, эсвэл орчлон дээрх хамгийн нарийн хуруугаар учиртайхан тогшиход сэм онгойн түүнийг элэг барина.

Энэ хаалганаас эхэлсэн удам хөндийн гудмын эцэст, баруун талд нь Альберын хоолны өрөө, цонх нь хашаа уруу харж байна. Зүүн талд нь цэцэрлэг үрүү харсан цонхтой зочдын өрөө байна. Ширэнгэ бут, ороогч ургамал цонхны өмнүүр дэвүүр мэт унжиж гаднаас шагайж болох боломжтой доод давхрын энэ хоёр тасалгаан доторх зүйлийг бусдын нүднээс халхална.

Хоёрдугаар давхарт мөн ийм хоёр тасалгаа Ўайх ба гурав дахь нь гудмын дээд талд байна. Энд зочдын өрөө, унтах тасалгаа, эчэгтэйчүүдийн зочны өрөө байна.

Доод давхрын зочдын өрөө нь алжирын буйдантай өрөө шиг бөгөөд тамхи татдаг хүмүүст зориулагджээ.

Хоёрдугаар давхар дахь эмэгтэйчүүдийн зочны өрөө нь унтах өрөөтэйгээ холбоотой бөгөөд хажуугийн хаалга шат уруу шууд гарна. Ер нь болгоомжлох бүх арга хэмжээг урьдаас авсан ажээ.

Гуравдугаар давхар нь тэр чигээрээ зураачийнх ч биш, ганган дэгжин эрийнх ч бус буруу номтны дуган гэлтэй том танхим байлаа. Тэнд Альбертын янз бүрийн гайхамшгууд бие бие дээрээр овооролдон холилдон байна. Анчны үлээдэг эвэр, ахмад хийл, лимбэ гээд л бүхэл бүтэн найрал хөгжмийн зэмсэг байх бөгөөд энэ нь Альбер нэгэн үеийн хөгжим сонирхож байсныг гэрчилнэ. Зургийн тавиур, хөл, илүүр, хатсан будаг байх нь өнөөх хөгжимчин маань удалгүй уран зураг сонирхох болсныг үзүүлнэ. Эцэст нь туялзуур жад, нударган зодооны бээлий, элдэв сэлэм ба олон янзын муна байлаа. Бидний өгүүлж байгаа тэр үеийн язгууртан залуучуудын заншлыг даган Альбер Де Морсер хөгжим, уран зургаар оролдохоосоо илүү дээдсийн хүрээлэнгийн хүмүүжлийн дээд болох сэлэм эргүүлэх, нударган зодоон ба муна хэрэглэж чадах урлагаар ихэд шаргуу оролдож байжээ. Энэ тасалгаанд Гризье, Кукс ба Шарль Лебуше нарын оролддог асан бүх л төрлийн биеийн тамирын хэрэгсэл байв.

Тасалгааны бусад хэсэгт нь хятадын шаазан эдлэл, японы ваар сав, Лукка Дел Роббиагийн паалантай эдлэл, Бернер Де Цйлиссийн тавагнууд өрсөн Францискийнүеийн хуучин шүүгээ III Ген°их, эсвэл Сюлли, XIII Людловик ч юм уу Ришелье ч сууж байсан байж магадгүй гэмээр түшлэгтэй сандал байв. Эдгээрийн хоёр дээр нь хааны титэмтэй хөх дэвсгэр дээр Францын гурван сараана цэцэгтэй сүлд байхыг нь үзвэл Луврын санч юм уу үгүйдээ л аль нэгэн хааны ордноос гарч ирсэн бололтой. Эдгээр төвхөн бараан сандлууд дээр персийн хурц нарны гэрэл шингэсэн буюу калькутагийн болон чандернагорын хүүхнүүдийн гараас гарсан байж таарах олон өнгийн нэхмэл эд хамаа намаагүй хөсөр хэвтэнэ. Нэхмэл эд ямар хэрэгтэйг энд байгаа хэн ч мэдэхгүй. Эдгээр торгонууд эзэн нь ч хэлж мэдэхгүй үүргээ хүлээн, тасалгааг өөрийн алтлаг өнгөөр гийгүүлэн байлаа.

Хамгийн ил харагдахуйц байранд Роллер ба Бланшийн хийсэн ягаан модон төгөлдөр хуур, хэмжээгээрээ жижигхэн, зочдын өрөөнд тохирох боловч, цаад гүнээсээ Бетховен, Вебер, Моцарт, Гайдн, гретер, Порпора нарын сонгодог хөгжмүүдийн бүхэл бүтэн найрал хөгжмийг багтаан уянгалсан аялгуу гаргана.

Хана, хаалга, тааз ер нь энд тэндгүй сэлэм, чинжаал хутга, муна, сүх, алтдаж хээ угалз гаргасан, хар чийтэй хуяг дуулга, хатаамал өвс, шороо шавар, хошуугаараа ангайж улбар өнгөт далавчаа нисэж байгаа юм шиг тэлсэн шувууны чихмэл зэрэг зүйл байлаа.

Энэ бол Альберын дуртай тасалгаа гэдгийг хэлэх юун.

Харин болзоо хийсэн өдрөө Альбер өглөөнийхөө хувцсыг өмсөөд доод давхрын зочдын жижиг өрөөнд сууж байв. Өргөн буйдантай өмнөх ширээн дээр петербургийн ш р тамхинаас, синайн хар тамхи хүртэл мерилэнд, порто-рико, латаки гэх мэтийн сайн чанарын тамхийг голландын паалантай шаазан савнуудад хийж тавьжээ. Эдгээрийн дэргэд сайхан үнэртэй модоор хийсэн хайрцаг дотор пурес,

регал, гавань, манил зэрэг ороомол навчин тамхийг урт богино, сайн муугаар нь ялган тавьжээ. Эцэст нь онгорхой шүүгээн дотор герман гаанс, алт, шүрээр гоёж чимсэн, урт хүзүүтэй хув соруудтай могой шиг мушгирсан усан гаанс зэрэг тамхичингуудын дурыг татан байлаа. Өглөөний сайн зоог зооглож, аяга сайхан кофе уусны дараа манарсан утаа өөд нь цагираглуулан баагиулж суух дуртай орчин үеийнхээ тамхичингуудад зориулсан энэ хамаа намаагүй тавьсан зүйлээ Альбер өөрөө эрхлэн зохион байгуулжээ.

Арван цагт арван таван минут дутуу байхад гэрийн хиа орж ирэв. Энэ бол зөвхөн англи хэлээр л ярьдаг арван таван настай зарц Жоныг эс тооцвол Морсерын ганц зарц нь болой. Жирийн өдрүүдэд эцэг эхийн тогооч, баяр ёслолын үеэр эцгийн нь зарц Альберын мэдэлд ирдэг нь мэдээж.

Хиаг Жермен гэнэ. Энэ хүн залуу эзнийхээ бүрэн итгэлийг хүлээжээ. Орж ирээд бөөн сонин ширээн дээр тавьж, баглаатай захидал Альбертэд өгөв.

Альберт тэдгээрийг хайхрамжгүйхэн хараад, цэвэрхэн үсгээр хаягласан зузаан хоёр дугтуйг авч задлаад, нэлээд анхааралтай уншив.

- Энэ хоёр захидал яаж ирэв? гэж асуув

- Нэг нь шуудангаар, нөгөөхийг нь Даглар авгайн хиа авчирч өгсөн.

Дангдар авгайн лоожиндоо урьсан урилгыг хүлээн авлаа гэдгийг хэлүүл. Байз байз ... Дараа нь Роза дээр оч. Намайг дуурь тараад очно гэж хэл. Тэгээд зургаан шил шилдэг сайн дарс, киприйн херес, малаги, бас нэг сав остендийн хавч... аваачиж тавь. Харин хавчийг Борелиас аваарай, тэгэхдээ надад авч байгаа юм гэдгийг хэлэхээ битгий мартаарай.

- Хэдэн цагт өглөөний зоог барих вэ?

- Одоо хэдэн цаг болж байна?

- Арван цагт арван таван минут дутуу байна.

- Яг арван цаг хагаст оруулаарай. Дебрэ яам уруу яарч магадгүй дээ.... Түүнээс гадна (Альбер тэмдэглэлийнхээ дэвтрийг харж) би гүнд: тавдугаар сарын хорин нэгний арван цаг хагаст гэж болзоо тавьсан. Хэдийгээр амласан үгэнд нь төдий л их найдахгүй байгаа боловч хэлсэн үгэндээ хүрдэг байхыг хүсэж байна. Ингэхэд гүн ахай боссон болов уу, мэдээгүй биз?

- Хэрвээ эрхэм бэйст хэрэгтэй бол би очиж үзээд ирье.

- Тэг ... Ликер дарстай савыг нь гуйгаад ир, минийх дундуурхан болчихож, нэгэн эрхэмсэг хүнийг танилцуулах зөвшөөрөл аваад ир.

Альбер, хиагаа гараад явчихтай зараг зөөлөн сандал дээр лагхийн суугаад, сонингоо дэлгэж театрын зарлал харж, бүжгийн жүжиг биш, дууль гарахыг нь мэдээд өөрт нь ярьж байсан шүдэнд хэрэглэх шинэ аргыг дэмий баахан эрснээ Парисын нэрийг гурван сониныг цувуулан хаяад уртаар эвшээлгэн аман дотроо,

- Сонингууд өдрөөс өдөрт улам л уйтгартай болоод байх юм гэж бувтнав.

Энэ үеэ хаалга дээр хөнгөн тэрэг ирж зогсон, Люсьбен Дебрэ ирлээ гэж хиа мэдэгдэв. Шаргал үстэй, цайвар царайтай, бор нүд нь ихэд биеэ тоосон байдалтай, уруулаа ихэмсгээр жимийж, алтан товчтой хөх фрак өмсөж, нарийн торгон оосроор ганц нүдний шил оосорлон зүүж, түүнийгээ зовхиныхоо булчингийн хүчээр баруун нүдэндээ хааяа хааяа тогтоож чаддаг ийм нэгэн залуу хүн албархуу байдалтай, инээмсэглэх ч үгүй орж ирэв.

- Сайн байна уу, Льюсен! гэж Альбер хэлээд – Та ер нь намайг өөрийхөө цаг баримталдаг нямбайгаараа айлгах юм! Би таныг хамгийн сүүлд ирэх байх гэж бодож байсан чинь харин аравт арван таван минут дутуу байхад хүрээд ирж. Өглөөний зоогийг арван цаг хагаст гэж захиалсан байдаг! Догь хэрэг ээ! Танай яам чинь татан буулгагдсан юм биш биз дээ гэв. Тэгэхэд орж ирсэн залуу буйдан дээр суугаад,

- Үгүй, найз минь, зовох юмгүй, бид цаг үргэлж дэнжигнэж байх боловч хэзээ ч татан буугдахгүй, тэгээд ч хагас аралд дээрх хэрэг явдал манай байдлыг бэхжүүлж байгааг хэлэлтгүйгээр бид бүгд солигдошгүй улс болж байна гэж бодоход хүрээд байна хэмээн хэлэв.

- Аа тийм, та нар Дон Карлосыг Испаниас хөөж байгаа л даа.

- Тийм юм байхгүй, бүү андуур. Бид түүнийг наад тал уруу явуулж, Буржид хааны зочлолыг хүлээн ав гэж байгаа.

- Буржид ий?

- Тийм ээ, ямар ч юм гэж гомдоллох юмгүй, чөтгөр ав! Бурж гэдэг чинь долдугаар Карлын нийслэл хот. Яалаа гэнэ ээ! Та үүнийг мэдэхгүй байсан юм уу? Өчигдөрөөс хойш үүнийг Парис дагуараа мэдэх болсон, харин уржигдлараас эхлэн Буржид мэдэгдсэн юм. Данглар (энэ хүн болж байгаа шинэ сонин зүйл бүхнийг яаж бидэнтэй зэрэг мэдчихээд байгааг би мэдэхгүй байна) их мөнгөнд тоглож, саяыг хожсон.

- Өө, та чинь шинэ туузтай болчихсан байх шив? Урьд нь харагдаагүй цэнхэр тууз байх чинь.

- Тийм ээ, гуравдугаар Карлын одонг ирүүлсэн байна гэж Дебрэ хайхрамжгүй хариулав.

- Битгий хайнга байдал үзүүлэх гэж оролдоод бай, одон хүлээж авахад сайхан байна гэдгээ зүгээр л хэлчих.

- Нуулгүй хэлэхэд сайхан байна. Гоёл чимэгт нэмэр болж, товчилсон фрак дээр одон зүүгээд явахад их зохиж байна. Гоё юм.

- Тэгээд Уэльсийн хан хүү, эсвэл Рейхштатын бэйлтэй адилхан болно доо гэж Альбер инээмсэглэн хэлэв.

- Би танайд ийм эрт ирсний учир ийм л юм л даа, эрхэм минь.

- Өөрөөр хэлбэл гуравдугаар Карлын одонг хүлээж аваад, энэ сайхан мэдээгээ надад хэлэх гэж бодсон юм биз дээ?

- Үгүй дээ, тийм учраас ирсэн юм биш. Би дипломат захидал бичиг явуулах гэж шөнөжингөө суулаа. Тэгээд үүрээр гэртээ хүрч ирээд унтах гэсэн чинь толгой өвдөөд байхаар нь гадуур салхинд явъя гэж шийдлээ. Булоны ойд явж байтал гэдэс ч өлсөж, уйтгартай санагдав. Бие биедээ харш энэ хоёр сэрэл нэгэн зэрэг тохиолдох нь маш ховор байдаг боловч энэ удаа карлын бүгд найрамдахчуудын холбоо шиг юм болж миний эсрэг нэгджээ. Тэгээд өнөө өглөө танайд найрлана гэдгээ гэнэт санаад, яваад ирлээ. Би өлсөж байна, хоол унд өгөөч, уйдаж байна, зугаацуулаач.

- Энэ бол эзэн хүн миний үрэг, хайрт нөхөр минь гэж Альбер хэлээд, хонх дар хиагаа дуудаж,- Жермен чи нэг хундага дарс, бисквит боовтой хамт аваад ир. Аа одоохондоо Люсьвен та тамхи татаж бай, хил сэм давуулдаг наймааны юм шүү. Та үүнээс татаж үзээд, сайн санаат иргэд бидний татаж байгаа тамхины оронд ийм тамхи авчирч худалдаж байвал зүгээр юм гэж сайддаа хэлээрэй гэв.

Энэ зуур Люсьен алтан байриултай таягаараа дэлгээтэй байсан сонинг өлгөн хаяж байв.

- Энэ чинь тийм биш л дээ! Та нар энэ тамхийг хил сэт давуулж наймаалхаа больчихоор л хэрэглэхээсээ татгалзан энүүн шиг муухай юм гэж байхгүй болчихно доо. Харин энэ хэрэг бол дотоод яаманд хамаагүй, сангийн яаманд хамаарагдах ажил шүү дээ. Шууд биш татварын хэрэг эрхэлсэн ноён Юманд хэсэх хэрэгтэй, "А" гудмын хорин зургадугаар хаалганд бий.

- Та юмны учир их мэдэх хүн юм гэж Альбер хэлээд, - Тамхи аваач гэв.

- Люсьен манилын ороомол навчин тамхи, алтан суурьтай лаанаас асаагаад, буйданг налж суув.

- Та бас хийх юмгүй жаргалтай хүн юм. Үүнийгээ мэддэггүй байх даа гэж Люсьен хэлэв.

- Эрхэм вант улсын амгалан тайваныг сахиулагч огт хийх юмгүй байсан бол яах байсан бэ гэж Морсер бага зэрэг ёжлон хэлээд, - Та европын их улс төрийн бодлогоос эхлээд Парисын өчүүхэн жижиг будлиануудыг хамарсан сайдын гарын нарийн бичгийн дарга шүү дээ. Та хаадыг хамгаална, бас хатан хаадыг хамгаалах нь бүр ч таатай, юмыг тогтоон баталж, сонгууль удирдаж, өөрийнхөө тасалгаан дотор үзэг, цахилгаан мэдээний тусламжтайгаар Наполеоны сэлэм, ялалтаараа дайны талбар дээр олж чадсан юмнаас илүү их юманд хүрнэ. Та цалин пүнлүүнээсээ гадна, жилд хорин таван мянган ливрийн орлоготой, бас Шато-Рено дөрвөн зуун луйдар өгсөн боловч, түүнд өгөөгүй морьтой хүн. Танд нэг ч өмдийг чинь эвддэггүй сайхан үйлчилдэг сайван бий. Опера театр, Жокей клуб, Варьете театр байхад та уйдлаа гэнээ? За яах вэ тэгвэл би таныг зугаацуулъя гэв.

- Юугаар тэр вэ?

- Шинэ танилаараа.

- Эрэгтэй хүн үү, эмэгтэй хүн үү?

- Эрэгтэй хүн.

- Тэртээ тэргүй би олныг танина шүү дээ.

- Үгүй ээ, та тийм хүн танихгүй байх.

- Тэр чинь хаанаас гараад ирсэн хүн бэ? Тэнгэрийн хаяанаас ирсэн хүн үү?

- Тэрнээс ч холоос байж магадгүй.

- Чөтгөр ав, үгүй тэр чинь танд өглөөний зоог авч ирэх юм биш биз?

- Үгүй энэ талаар сэтгэл бүү зов. Өглөөний зуушийг энд, энэ байшинд хийж байгаа. Та ер нь өлсчихсөн байна аа даа.

- Тийм ээ, хэдийгээр ичмээр боловч, хүлээхээс өөр аргагүй. Би өчигдөр ноён Вильфорынд хоол идсэн. Харин та энэ шүүхийнхэн дандаа муу хооллодгийг ажиглаагүй гэж үү? Сэтгэл нь тэвчдэггүй юм гэж бодмоор шүү.

- Хүний хоолыг муу хэлээд л байх юм, харин танай сайдынх яаж хооллодог вэ дээ?

- Бид үгүйдээ тохитой томоотой хүмүүсийг урьдаг, хэрвээ бид бидний төлөө саналаа өгдөг сайн санаат борчуудыг зочлох хэрэггүй байсансан бол гэртээ хоол идэхийг үхлээс илүүд үзэж айх байсан билээ.

- Тэгвэл нэг хундага херес ууж, бисквит боов ид.

- Дуртайяа идье. Танай испани дарс тун сайхан юм. Бид энэ оронд энх тайваныг тогтоосон нь хичнээн зөв байгааг та харж байгаа биз дээ?

- Тийм ээ, дон Карлос яах вэ?

- Яах вэ дээ, дон Карлос бордоо ууж л байг. Арван жилийн дараа түүний хүүг бяцхан хатан хаантай гэрлүүлнэ.

- Та хэвээ тэр үед алба хааж байвал, алтан ноос одонгоор шагнуулна даа.

- Альбер, та өнөөдөр намайг хоосон яриагаар хооллох гэсэн юм шив.

- Энэ бол ходоодыг юунаас ч илүү зугаацуулдаг юм шүү. Байзаарай, Бошаны дуу гарч байх шив, та түүнтэй маргалдан зугаагаа гаргана биз.

- Юун тухай маргах хэрэг вэ?

- Сонинд бичиж байгаа зүйлийн тухай маргахгүй юу.

- Би сонин уншдаг гэж үү? Гэж Люсьен жигшсэн байртай хэлэв.

- Тийм тусмаа л маргах үндэс их байна.

- Эрхэм Бошан ирлээ! гэж хиа мэдэгдэв.

- Ор ор, аймшигт үзэг минь гэж Альбер хэлээд, шинэ орж ирсэн зочныг угтан очиж, - Дебре, таны өгүүллүүдийг уншдаггүй боловч, таныг тэвчиж чаддаггүй гэж байна гэв.

- Түүний хэлдэг маш зөв. Би ч бас түүний юу хийж суудгийг мэдэхгүй боловч зүхэж байдаг юм. Сайн байна уу, дарга минь.

- Өө, та бас дуулчихаа юу? гэж сайдын нарийн бичгийн дарга инээмсэглэн хэлээд, сэтгүүлчийн гарыг атгав.

- Мэдэхээр барах уу.

- Улсууд энэ тухай юу гэж ярьж байна?

- Ямар улсууд? Христосын төрж мэндэлснээс хойших мянга найман зуун гучин найман онд, тийм улсууд олон бий.

- Гол хүний нэг та болдог шүүмжлэгч, улс төрийнхний дунд,

- Энэ бол зүй ёсны хэрэг, тэгээд ч бага зэрэг цэнхрийг ургуулахын тулд хүрэлцэхүйц хэмжээний ухааныг суулгаж байгаа юм байна гэж ярьцгааж байна.

- Догь хэлжээ гэж Люсьен хэлээд, - Хүндэт Бошан та яагаад манайх биш юм бэ? Ийм ухаантай хүн гурав, дөрөвхөн жилийн дотор өндөр тушаалд гарна даа.

- Би таны зөвлөгөөг дагахад ганцхан юм л, хагас жил ч болов тогтож чадах яам бий болохыг л хүлээгээд байна. Одоо хэлэх нэг үг байна, Альбер, хөөрхий люсьенийг амраах хэрэгтэй. Бид өглөөний зоог идэх үү, аль эсвэл өдрийнхийг үү? Би танхим уруу явах хэрэгтэй. Танай ажилд бүх юм сайхнаараа байдаггүйг харж байгаа биз дээ.

- Бид өглөөний зоог иднэ, харин одоо хоёрхон хүн хүлээж байна. Тэднийг ирэхээр л ширээнд сууцгаана.

- Та чухам хэнийг хүлээж байгаа юм бэ, гэж Бошан асуухад, Альбер- Нэг нь язгууртан, нөгөө нь дипломат гэж хариулав.

- За тэгвэл язгууртныг нь хоёр цаг, дипломатыг нь түүнээс ч удаан хүлээх хэрэг болох нь ээ.

- Би сүүлчийн хөнгөн цайн дээр л ирье, надад жимс, кофе, тамхи тауйж байгаарай. Одоо очоод танхимд хоол идчихье.

- Боль доо Бошан, язгууртныг нь Монморанси, дипломатыг нь Меттерних гэдэг ч байлаа гэсэн ялгаагүй. Арван цаг хагаст хоолоо идэхээр ширээнд сууна. Харин одоохондоо Дебрегийн үлгэрээр херес ууж, бисквит зооглох тун.

- За яах вэ, би үлдье. Өнөөдөр заавал зугаацмаар санагдаад байна.

- Та яг л Дебре шиг боллоо! Яам нь гутарч гунихарч ирэхэд, эсрэг тал нь хөгжилтэй байх ёстой гэж бодож байна.

- Тийм ээ, гэсэн ч та надад юу заналхийлж байгааг мэдэхгүй байна! Өнөөдөр бид депутатуудын танхимд Дангларын үг хэсэхийг сонсоно. харин орой нь францын тайжийн эмгэнэлт жүжгийг эхнэртэй нь хамт үзнэ. чөтгөр ав, үндсэн хуулийн байгуулалт ч гэж дээ! Бид сонгож болох байсан гэж улс ярьцгаах юм! Бид яаж Дангларыг сонгогчоо юм бэ?

- Та хөгжилтэй байх хэрэгтэй болсныг би ойлгож байна. – Дангларын хэлэх үгийг хайхрахгүй бүү байгаарай, тэр таны төлөө санал өгч байгаа, тэгээд ч бас сөрөг талын хүн шүү дээ, гэж Дебрэ хэлэв.

- Харин хамаг гай л тэнд байгаа юм! Та нар түүнийг Люксембургийн ордон уруу донгосуулахаар явуулахыг л би тэсэж ядан хүлээж байна. Тэгвэл л би нэг чөлөөтэй болно доо.

- Испанид ажил хэрэг тохиносон байна гэдэг нь шууд харагдаж байна гэж Альбер Бошанд хэлээд – Та бас өнөөдөр их эмзэг, ёжтой байна аа. Парисын дээдсийн хүрээлэн намайг Дангларын охин Эженитэй хурим хийх гэж байгааг ярьж буйг санаарай. Хожим надад: “Бэйс та, миний охиндоо хоёр саяын инж өгсөн байгааг мэднэ шүү дээ” гэж хэлэх хүний уран цэцэн үгийг шоолж яромжлохыг миний сэтгэл төвдөхгүй байна шүү гэв.

- Энэ хурим болохгүй, гэж Бошан түүний яриаг таслан-Ван түүнийг түшээ гүн болгож болно, тайжаар шагнаж чадна, тэгэхдээ ингэлээ гээд сурвалжит язгууртан болохгүй шүү дээ. Тэгэхэд Морсер гүн бол өчүүхэн хоёр саяын холбоог зөвшөөрнө гэхэд дэндүү томдох язгууртан хүн. Бейс Де Морсер бол зөвхөн л сурвалжит хүнтэй сууж болно гэв.

- Үгүй, хоёр сая гэдэг чинь муугүй хэрэг шүү гэж Морсер зөрөв.

- Энэ бол ямар нэг театр, эсвэл ургамлын цэцэрлэгээс Рапэ хүртэлх төмөр замын салбарын хувь нийлүүлсэн хөрөнгө шүү дээ.

- Морсер та түүний үгэнд бүү ор, сууж л орхи гэж дебрэ залхуу нь хүрсэн байдалтай дуугараад, -Та мөнгөний ууттай ураг төрлийн барилдаантай болно шүү дээ. Энэ нь танд хамаагүй юм биш үү? Тэр уут нь нэг сүлдээр бага боловч, нэг тэгээр илүү байх болно. Танай сүлдэн дээр долоон шувуу бий, түүнийхээ гурвыг нь эхнэртээ өг, өөрт чинь дөрөв үлдэнэ. Гэсэн ч хан Гизаас нэгээр илүү байх болно. Харин тэгэхэд тэр арай л Францын ван болчихоогүй, үеэл ах нь Германы эзэн хаан байсан шүү дээ.

- Нээрээ тийм дээ гэж Альбер алмайрсхийн хариулав.

- Тэгэлгүй яах вэ! Тэгээд бас саятан бүхэн бутчийн хүүхэд шиг удам угсаатай байдаг.

- Иш, дуугүй бай, Дебрэ, гэснээ Бошан инээж, -Шато-Рено ирж явна, орж ирээд таныг хуулийн зүйл анги шохоорхдог өвчнөөс чинь эмчлэхийн тулд өвөг дээдэс Рено де Монтобаныхаа сэлмээр нэвт хатгана даа гэж хэлэв.

- Би маш доорд язгуурын гаралтай хүн болохоор Шато-Рено зөвхөн өөрийнхөө л нэр төрийг алдах болно.

- За тэр шүү! Яам, Беранжегийн аяар дуулж эхлэх нь. Бурхан минь, бид хаашаа явах нь энэ билээ! гэж Бошан дуу алдав.

- Эрхэмсэг де Шато-Рено! Эрхэм Максимилиан Моррель гэж хиа айлтгав.

- За тэгвэл бүрдэл болох шив! гэж Бошан хэлээд, - Одоо бид өглөөнийхөө зоогийг барих уу? Би андуураагүй бол, та хоёр хүн ирэхийг хүлээж байна гэсэн биз дээ, Альбер? гэж асуухад,, Альбер гайхсан байдалтайгаар,

- Моррель ий! Моррель гэдэг чинь ямар хүн билээ? гэж шивгэнээд үгээ ч бүрэн хэлж дуусаагүй байтал, хөлөөсөө толгой хүртэл язгууртны шинжтэй нэг үгээр Гиш шиг гадаад төрх байдалтай, Мортемар шиг ухаантай гуч орчим насны сайхан залуу гараас нь барьж,

-Миний найз намайг аврагч спагийн ахмад Максимилиан Моррелийг тантай танилцуулахыг Альберт та зөвшөөрнө үү? Ер нь ийм хүнийг танилцуулах ч шаардлагагүй. Бэйс та миний баатартай мэндлээч гэж хэлэв.

Тэгээд тэр манай уншигчид мартахааргүй хэцүү явдлын үед Марсель хотод үзсэн нөгөө хар сахалтай, нэвт шувт харцтай, өргөн духтай, өндөр гуалиг биетэй залуу хүнд зай тавьж, хажуу тийшээ болов. Хагас Франц хагас Дорно зүгийн хийцтэй өнгөлөг сайхан ёслолын цамц нь сайхан зохиж, хүндэт Легонны хирээс одон зүүсэн өргөн цээж, гуалиг биеийг нь жавхайлан барьжээ. Залуу дарга ихэд цэцгэрхэнээр мэхийн мэндлэв. Залуу хүч чадалтай хүн болохоор хөдөлгөөн нь даанч нямбайлаг сайхан байлаа.

- Эрхэм Моррель, түшээ гүн Шато-Рено таныг надтай танилцуулахдаа надад их тааламжтай сэтгэл төрнө гэдгийг мэдэж байжээ. Та түүний найз нөхөр болохоор мөн л бидний найз нөхөр болно гэж хэлэв. Тэгэхэд Шато-Рено,

- Маш сайн хэрэг, хүндэт бэйс та түүнээс хэрэг тохиолдвол надад хүргэсний адил тусыг хүргээрэй гэж гуйхгүй юу гэж Шато-Рено хэлэхэд Альберт,

- Ямар тус хүргэсэн юм бэ? гэж асуув.

- Түшээ гүн дэндүүлж байна, үнэндээ энэ тухай ярих ч хэрэггүй юм! гэж Моррель хэлэхэд Шато-Рено,

- Юу ярих хэрэггүй юм гэж? Амь нас гэдэг чинь ярих хэрэггүй эд үү? Хүндэт Моррель та чинь дэндүү их гүн ухаантан хүн юм. Өдөр бүр таны амь насанд халтай юм тохиодог болохоор та тэгж ярьж болно, харин тийм явдал санамсаргүй тохиолдсон надад бол... гэж хэлэв.

- Энэ бүхэн дотроос, ахмад Моррель, таны амийг аварч гэдэг ганцхан зүйл тодорхой байна.

- Тийм ээ, зөвхөн л энэл дээ гэж Шато-Рено хэлэхэд,

- Тэр явдал яаж болсон юм бэ? гэж Бошан асуув.

- Бошан, найз минь би өлсөж үхэх гэж байна шүү дээ, урт яриа дэлгээд яах вэ гэж Дебрэ хэлэхэд,

- Би та нарыг ширээнд суухад саад болж байна гэж үү... Шато-Рено хоол идэх зуур бүгдийг ярьж өгөг гэж Бошан хариулав.

- Эрхэмүүд ээ, одоо дөнгөж арван цагаас арван таван минут өнгөрч байна, бид сүүлийнхээ зочныг хүлээж байна гэж хэлэхэд, Дебрэ,

- Өө тийм, дипломат хүнийг гэж хэлэв.

- Дипломат ч юм уу, аль эсвэл өөр ч юм уу бүү мэд. Би түүнд итгэл найдвар өгөхөд маш амжилттайгаар биелүүлсэн гэдгийг мэдэж байна. Хэрвээ би ван байсан бол бүх одонгуудаараа нэгэн зэрэг шагнана. Хэрвээ миний мэдэлд алтан ноос татуургат одон байсан бол хоёулангаар нь шагнах байсан даа.

- Тийм бол бид ширээнд хараахан суугаагүй болохоор бидэн шиг хундагандаа херес дарснаас хийж аваад өөрийнхөө түүхийг ярь даа гэж Дебрэ хэлэв.

- Та нар намайг саяхан Африк явсан гэдгийг мэднэ шүү дээ.

- Энэ бол таны өвөг дээдсийн зааж өгсөг зам шүү. Хүндэт Шато-Рено гэж найрсгаар хэлэв.

- Тийм ээ, тэгэхдээ та тэдэн шиг бурхан багшийн шарилыг чөлөөлөхийн тулд итгэж явсан нь юу л бол.

- Бошан таны хэлдэг зөв гэж залуу язгууртан хэлээд, би зүгээр л гар буугаар буудах дур минь хүрсэн юм. Хэрэг явдлыг эвээр зохицуулахаар шилж авсан хоёр зуучлагч маань намайг сайн нөхдийн минь нэг болох... Хөөрхий францад Эпинеийн гарыг буудахад хүргүүлснээс хойш халз тулалдаан гэдгийг тэвчин үзэж чадахаа больсон гэдгийг та бүгд мэднэ... Та нар францад Эпинеийг цөмөөрөө танина шүү дээ.

- Өө тэгэлгүй яах вэ, та хоёр чинь нээрээ нэг үзэлцсэн л дээ. Юунаас болсон билээ гэж Дебрэг асуухад Шато-Рено

- Ална ч гэсэн санахгүй юм байна. Харин надад дөнгөж бэлэглэсэн шинэ буугаа Араб хүмүүс дээр туршиж үзье гэж хүссэнээ л санаж байна. Тийм учраас би Оран орж, тэндээсээ Константин уруу явж яг бүслэлтийг зогсоож байх үед хүч очлоо. Би бусад улстай хамт ухарч эхлэв. Хоёр хоног өдөр нь бороо, шөнө нь цас орсон ч аргацаан тэсвэрлэж өнгөрүүлээд, гурав дахь өдөр нь морь минь хөлдөж үхлээ. Хөөрхий амьтан дулаан саванд байж сурчихаж, энэ бол Араб угсааны морь байсан боловч, арван градусны хүйтэнтэй эх орноо таньсангүй гэж Шато-Рено ярив.

- Өө та англи хурдан морийг минь авах гээд байдаг учир ийм юм бий. Миний морийг Араб морьноос илүү хүйтэнд тэсвэртэй гэж бодож байна аа даа гэж Дебрэ хэлэв.

- Та андуурч байна. Би одоо дахин Африк явахгүй гэж ам тангараг тавьсан.

- Та тэгээд айчихсан хэрэг үү? гэж Бошан асуухад, Шато-Рено

- Тийм ээ, үнэн айх хэрэг байсан. Тэгээд морио хаячихаад цаашаа явган явлаа. Тэгтэл миний толгойг авах гэж зургаан Араб хүн дайраад ороод ирлээ. Хоёрыг нь урт буугаар, хоёрыг нь гар буугаар тулгаж байгаад буудчихлаа, гэтэл хоёр нь үлдчихээд би зэвсэггүй болчихсон байв. Нэг нь миний үснээс зуураад авав. Би үсээ ингэж богино засуулдаг болсны учир энэ байгаа юм. Юу болохыг яаж мэдэх вэ. Нөгөөх нь миний хүзүүн дээр махир сэлмээ тавьж, хүйтэн төмөр хайрах нь мэдэгдэв. Тэгтэл энэ эрхэм хүн тэдэн уруу довтлон орж, үснээс минь зуурчихсан хүнийг буудан алаад, махир сэлмээр хоолойг минь огтлох гэж байсан хүний толгойг хяргаж орхив. Энэ хүн тэр өдөр нэг хүний амийг аврах ёстой гэж бодож байжээ. Харин тэр хүн нь би болж таарчээ. Би баун болохоор Клагман буюу Марокентид энэ тохиолдлын баримал хөшөөг захиалж хийлгэнэ гэв.

- Энэ бол есөн сарын таван байсан юм гэж Моррель инээмсэглэн хэлээд, эцэг минь гайхамшгаар аврагдсан ойн өдөр. Би жил бүрэн өдрийг чадлынхаа хирээр ямар нэг сайн юм хийж байхыг хичээдэг юм... гэв.

- Ямар нэг баатарлаг явдал юм биз гэж Шато-Рено үгийг нь таслан хэлээд,

- Товчхон хэлэхэд миний аз болсон юм. гэвч ингээд төгсөөгүй тэгээд хутганаас амийг минь аварсныхаа дараа надад гэгээн Мартин шиг цувныхаа хагасыг биш харин бүтнээр нь өгч, намайг хүйтний аюулаас аварсан юм. тэгээд сүүлд нь өлсгөлөнгөөс аварсан юм... Нэг юмаа хувааж шүү гээд.. Юу вэ таацгаа гэхэд Бошан

- Феликсийн жигнэсэн мах уу? гэж асуув.

- Үгүй ээ, өөрийнхөө морийг. Түүнээс нь хоёулаа хэрчим хэрчим мах идсэн. Мөн ч амаргүй байдаг шүү.

- Үгүй дээ ийм гарлага гаргаж байгаа нь танихгүй хүн Англи угсааны хурдан морио гарздах уу гэж Дебрэгээс асуу л даа хэмээн Шато-Рено хариулав.

- Танихгүй хүнд бол үгүй. Найз нөхөртөө бол магадгүй гэж Дебрэг хэлэхэд Моррель

- Би таныг миний найз болох юм гэж мэдээд байсан юм. түүнээс гадна үүнийг баатарлаг явдал гэнэ үү, эсвэл гардаг золиос гэж үзнэ үү, өөрсдөө мэдэцгээ гэж би хэлсэн. Юу ч л гэсэн би тэр өдөр нэгэн цагт манайд тохиолдсон зол заяатай ямар нэг юмаар хариулах ёстой байсан юм. Түшээ гүн минь гэв.

- Моррелийн цухуйлгаж байгаа энэ түүх маш сонин зүйл байгаа юм. та нартай ойр дотно танил таахаараа ярьж өгөх байх. Харин одоохондоо дурдатгал ярианы

тухай хангалттай ярьсан болохоор гэдэс ходоодныхоо тухай бодоцгооё. Альбер та хэдэн цагт өглөөнийхөө зоогийг барьдаг вэ гэж Шато-Рено хэлэв.

- Арван цаг хагаст.

- Яг уу? гэж Дебрэ цагаа гаргаж асуув.

- Та надад бас таван минут сунгаж өгөөч гэж Морсель хэлээд,

- Би ч бас аврагчаа хүлээж байна гэв.

- Хэний аврагчийг?

- Миний өөрийн, чөтгөр ав гэж Морсель хариулаад,

- Эсвэл таны бодлоор намайг бусдын адил ямар нэг юмнаас аварч болохгүй, зөвхөн Арабууд л толгой авдаг болж байна уу? манай өглөөний зоог хүнийг хүнийг энэрэн хайрлагчдын зоог болох нь. Ширээний ард хүн төрөлхтний хоёр ариун үйлстэн суух болох нь ээ гэж Морсель хэлэв.

- Яадаг юм билээ ? Манайд чинь ганцхан Монтинонын шагнал байдаг байх аа гэж Дебрэ хэлэв.

- Тэгвэл түүнийг юу ч хийгээгүй хүнд юм хийг гэж өгчихгүй юу гэж Бошан хэлээд

- Ер нь академи тэгж л хүнд байдлаас гардаг шүү дээ гэхэд Дебрэ Альберээс

- Таны аврагч хаанаас ирэх юм бэ? Шалаад байгааг минь уучлаарай, та их бүдэгхэн хариулсан болохоор би дахин асуух зүрх гаргав гэв.

- Үнэнээ хэлэхэд би ч өөрөө мэдэхгүй байна. Гурван сарын өмнө намайг урьхад тэр хүн Ром хотод байсан энэ хугацаанд хаагуур хаагуур явж амжчихсаныг хэн мэдэх вэ дээ гэж Альбер хариулав.

- Та тэгээд түүнийг хэлсэн цагтаа ирэх нямбай хүн гэж бодож байна уу? гэж Дебрэ асуув.

- Тэр ер нь юу ч хийж чадах хүн гэж би бодож байна.

- Таван минут нэмж өглөө ч гэсэн одоо дөнгөж аравхан минут хүлээх хугацаа үлдээд байна гэдгийг бодоорой.

- Тэгвэл би энэхэн хугацааг ашиглаад зочныхоо тухай ярьж өгье.

- Уучлаарай таны ярианаас шог найруулал бичиж болох уу? гэж Бошан асуув.

- Маш сайхныг ч болно гэж Морсель хариулав .

- Тэгвэл яриач. Би нэгэнтээ л танхимд очиж чадахгүй гээс хойш ямар нэгэн юмаар биеэ зугаацуулах хэрэгтэй байна.

- Би Ромд сүүлийн багт наадмын үеэр байсан. Үүнийг чинь бид мэднээ гэж Бошан үгийг нь таслан хариулав.

- Тийм ээ, гэсэн ч намайг дээрэмчдэд баригдсаныг та нар мэдэхгүй.

- Дээрэмчид байдаггүй юм шүү дээ гэж Дебрэ хэлэхэд,

- Үгүй, байдаг юм. тэгээд бас ямар аймшигтай гэж санана. Гайхмаар улс гэж би хэлмээр байна. Тэд надад үнэхээр сайхан санагдсан.

- Хүндэт нөхөр Альбер минь, танай тогооч чинь хоолоо оройтуулж, хавчаа Мерен эсвэл Остейдегээс авчраагүй байгаа болохоор та Монтеном авгай шиг хоолоо үлгэрээр солихгээ юу? Бид таныг уучлаад яриа хэдийгээр үнэмшмээргүй боловч, сонсож суухаар эелдэг улс гэж бодсоноо хүлээ л дээ гэж Дебрэ хэлэв.

- Энэ яриа хэдийгээр үнэмшмээргүй боловч, эхнээсээ аваад эцсээ хүртэл цөм үнэн зүйл шүү. Тэгээд намайг дээрэмчид барьж аваад Сан-Себастьяно гэдэг тун ч тохигүй газар доорхи агуйд аваачсан юм.

- Би түүнийг мэдэн, арай ч халуун хижиг өвчин авчихаагүй юм гэж Шато-Рео хэлэхэд, Альбер яриагаа үргэлжүүлэн,

- Би үнэн хэрэгтээ авчихсан, тэд намайг олзлогдсон хүн гэж хэлээд, золиосны мөнгө төлөхийг шаардсан. Дөрвөн мянган Ромын пиастр, хорин зургаан мянган түрэг ливр л дээ. Гэсэн ч гай болоход надад дөнгөж мянга таван зуу үлдсэн байлаа. Аялал төгсөх ойртож, мөнгө дуусаж байв. Тэгээд би францад захидал бичлээ... Франц тэнд байсан болохоор намайг нэг боловч үг санаанаасаа зохион ярьж байгаа эсэхийг асуугаарай. Би Францад маргааш өглөө зургаан цагт дөрвөн мянган пиастр авч ирэхгүй бол зургаан цагаас арван минут өнгөрөхөд диваажингийн оронд тонилох нь ээ гэж бичив. Дээрэмчдийн толгойлогч Луйжи Вампа хэлсэн үг,эндээ хүрэн байсан юм гэж яриу .

- Тэгээд Франц дөрвөн мянган пиастр авчраа биз дээ? гэж Шато-Рено асуугаад, - Тэгэлгүй яах вэ! Францад Эпипе эсвэл Альвер де Морсер хоёр дөрвөн мянган пиастр олно гэдэг амархан хэрэг гэв.

- Үгүй, харин миний өнөөдөр та нарт танилцуулах гэж байгаа тэр хүнтэй хамт ирсэн юм.

- Тэгвэл энэ эрхэм хүн чинь Какаг алсан Геракль эсвэл Андромедыг чөлөөлсөн Персей юм уу?

- Үгүй, миний зэргийн л хүн.

- Шүдээ хүртэл зэвсэглэсэн хүн үү?

- Түүнд нэхмэлийн зүү ч байгаагүй.

- Тэгвэл золиосны мөнгийг төлж өгсөн үү?
- Атаманы чихэнд хоёрхон үг хэлэхэд л намайг суллан тавьсан.
- Тэгээд бас чамайг барьж авсан буруугаа хүлээгээ биз дээ? гэж Бошан нэмж хэлэхэд, Альбер
- Чухам тийм гэв.
- Үгүй, тэр чий ариосто биш биз дээ? гэхэд
- Биш ээ, зүгээр л Монте Кристо гүн гэдэг юм.
- Тийм нэр байхгүй, гэж Дебрэ хэлэхэд,
- Тийм шүү, байхгүй гэж бүх л европын гэрийн бичгийг цээжээр мэддэг хүний байдлаар Шато-Рено итгэлтэйгээр хэлээд, - Монте Кристо гүн гэдэг нэрийг сонссон хүн байна уу? гэв.
- Гэгээн газраас гаралтай хүн байж магадгүй еэ, түүний өвөг дээдсийн аль нэг нь Мортемар сөнөмөл тэнгис эзэмшиж байсан шигээр Гольгофыг 1эзэмшиж байсан байж таарна гэж Бошан хэлэхэд Максимилиан
- Уучлаарай эрхэмүүд ээ, би та нарыг хүнд байдлаас хүнд байдлаас гаргаж чадмаар юм шиг санагдаж байна. Монте Кристо гэж арал байдаг, түүний тухай манай эцэгт ажиллаж байсан далайчид дандаа ярьдаг байсан юм. газрын дундад тэнгис доторх нэг жаахан элсний ширхэг хязгааргүйн доторх хумхи гэсэн үг гэж хэлэв.
- Таны хэлдэг туйлын зөв. Миний ярьж буй хүн бол тэр өчүүхэн элсний ширхэг, тэр хумхыг чинь эзэмшдэг хүн байгаа юм. тэгээд Тосканаас гүн цол худалдаж авсан бололтой гэж Альбер хэлэв.
- Тэгэхээр таны гүн баян хүн байх нь ээ.
- Баян гэж бодож байна.
- Үгүй, хараад л мэдэгдэх юм биш үү?
- Дебрэ та ташаарч байна.
- Таны хэлж байгааг ойлгохгүй байна.
- Та мянга нэгэн шөнийн үлгэр уншсан уу?
- энэ чинь юу гэсэн үг вэ?
- Таны өмнө баян ч хүн байгаа юм уу, ядуу ч хүн байгаа юм уу, хэн мэдэх вэ дээ? тэдэнд улаан буудайн үр ч юм уу эсвэл бадмаараг, очир эрдэнэ байгааг хэн мэдэх вэ? Таныг харахад л ядарсан муу загасчин шиг хүн байж байснаа ямар нэгэн

нууц агуйд оруулаад иртэл, бүх энэтхэг орныг ч худалдаа авчихаар тийм эрдэнэс байдал яана?

- Тэгээд?

- Миний ярьж байгаа Монте Кристо гүн бол тийм л загасчдын нэг дээ. нэр нь ч мөн тийм. Синдбад далайчин гэдэг. Түүнд дүүрэн алттай агуй бий.

- Морсер, та тэр агуйг нь үзсэн үү? гэж Бошан асуув.

- Би үзээгүй, Франц үзсэн. Харин түүний дэргэд энэ тухай нэг ч үг бүү дуугараарай. Францын нүдийг боож оруулаад нэг хэлгүй хүн бас Клеопатра ч дэргэд нь жирийн охин шиг харагдах тийм хүүхнүүд үйлчилсэн гэнэ лээ. Тэгэхдээ гашиш идсэн хойноо хүүхнүүдийг үзсэн учир, тэдний тухай бүрэн итгэлтэй биш байна лээ. Ямар нэгэн баримал, хөшөөнүүдийг ч хүүхэн гэж андуурсан байж болох юм.

- Залуу хүмүүс Морсер өөд харахад, тэдний нүдэнд чи солиорчихов уу эсвэл зүгээр л биднийгээ мангуутуулж байна уу? гэсэн асуулт тодорч байлаа. Моррель бодлогоширсон байдлаар

- Би я бас эрхэм де Морсерын ярьж байгаатай адил зүйлийг Пенелон гэдэг өвгөн далайчинаас сонссон юм байна гэв.

- Эрхэм Моррель намайг дэмжиж буй явдалд их баярлаж байна, миний мэдэхгүй юманд зам заашч шижмийг хаяж өгч байгаа нь та нарт таалагдахгүй байгаа юм биз дээ? гэж Альберыг хэлэхэд Дебрэ

- Уучлаарай хайрт нөхөр минь, та үнэмшмээргүй юм яриад байна шүү... гэж хэлэв.

- Танай элчин сайд төлөөлөгчид чинь иймэрхүү зүйлийн тухай та нарт бичдэггүй болохоор үнэмшмээргүй байгаа юм. тэд жуулчлан яваа нутгийнхаа хүмүүсийг хавчиж шахах аргаар хөөцөлдөж, тийм юм бичиж байх завгүй суудаг улс.

- За тэр, та уур унтуу болж танай хөөрхий төлөөлөгчид рүү довтолж гарлаа. Тэд чинь та нарын сонирхлыг яаж хамгаалах вэ дээ. танхим зардлыг нь цаг үргэлж багасгаж оддог энэ тушаалд ажиллах хүсэлтэй хүн олдохоо больчихоод байна. Альбер та элчин сайд болох дуртай юу? Тэгвэл би таныг Константино Полд томилуулж өгье.

- Уухай даа, намайг дөнгөж л Магомета Аалийг¹ өмгөөлөх төдий болмогц Султан надад дээс явуулж, нарийн бичгийн дарга нар маань намайг боож алаг гэж үү?

- За тэр харж байна уу? гэж Дебрэ хэлэв.

- Хэдийн тийм боловч, миний Монте Кристо гүн бий дээ...

- Дэлхий дээр юм бүхэн бий. Гайхалтай юм болж дээ.

- Юм бүхэн байдаг нь мэдээж хэрэг. Гэвч хүн бүхэн хар арьстай боол, ван хүнд байдаг зургийн үзэсгэлэн, зэвсгийн музей зургаан мянган франкын үнэтэй морьд, явдаг Грек хүүхэнтэй байдаггүй шүү дээ.

- Аа та тэр Грек хүүхнийг нь харсан уу?

- Тэгсэн харсан, сонссон. Вале театрт харсан. Харин гүнгийнд өглөөний зууш зооглож байгаад дууг нь сонссон.

- Тэгвэл танай тэр ер бишийн хүн чинь юм иддэг байх нь ээ?

- Үнэнийг хэлэхэд энэ тухай юм яриад баймааргүй тийм жаахан иддэг юм.

- Харж л байгаарай, хүний цус сордог орооло байх вий.

- Лорд Рутвеныг таньдаг гүнгийн хатан бас тэгж хэлж байна билээ. та нар доогловол доогло л доо.

- Альбер чамд баяр мургэе, энэ бол сэтгүүлчийн ажлаар оролддоггүй хүнд маш сайхан хэрэг. “Конетуционалист” сэтгүүлд гарсан нөгөө далайн могой шиг л юм болно доо. Ороолон гэдэг тун догь хэрэг байна даа гэж Бошан дуу алдав.

- Цөцгий нь дуртай цагтаа л том бага болж байдаг улаавтар нүдтэй, бүргэдийн хамартай, өргөн мэлгэр духтай, нүүрэндээ нэг ч дусал цусгүй, хар сахалтай, хурц цагаан шүдтэй, гял цял гэсэн хүн байгаа биз гэж Дебрэ хэлэхэд

- Яг тийм Люсьен, бүх шинж тэмдэгүүд нь тохирч байна. Хурц ширүүн, ёжтой зантай энэ хүнтэй хамт байхад миний нуруугаар байсхийгээд хүйт оргидог байсан сан. Нэгэн удаа хамт хүн цаазлахыг хараад, алуурчны ажиллагаа болон, ялтны орилж хашгирахаас илүү гүнгийн царай цаазаар аваачих янз бүрийн аргуудын тухай ярьж байгааг нь сонсоод, ухаан алдах нь гэсэн бодол төрж билээ гэж хэлэв.

- Морсер тэгээд тэр хүн таны цусыг сорох гэж Колизейн эвдэрхий балгасанд дагуулж аваачсангүй юу? гэж Бошан асуув.

- Таныг суллаж тавихдаа ямар нэгэн галын өнгөтэй элгэн дээр өөрийнхөө сүнсийг Исав шиг түүнд өглөө гэж албадан бичүүлэхгүй байна уу? гэж асуухад Морсер бага зэрэг гоморхсон байдалтайгаар

- Тоглоом хийж л бай, хичнээн л бол хичнээн тоглоом хий. Гантын цэцэрлэгт сэлгүүцэгч, Буланы ойгоор зугаацагч сайхан Парисынхан та бүхнийг харахад энэ хүн надад бодогдож бид цөм өөр өөр төрлийн хүмүүс юм шиг санагдах юм даа гэв.

- Би үүгээр бахархаж явдаг гэж Бошан хэлэхэд, Шато-Рен® дээрээс нь нэмж

- Юу ч л гэсэн таны Монте Кристо гүн завтай цагт зугаатай сайхан хүн юм. Харин тэгэхдээ Италийн дээрэмчид гэж юу ч байхгүй! Гэж Дебрэ хэлэв.

- Ороолонгууд ч байхгүй гэж Бошан дэмжихэд, Дебрэ цааш үргэлжлүүлэн,

- Монте Кристо гүн гэдэг ч бас байхгүй, Альбер та арван цаг хагас дуугарч байгааг дуулж байна уу? гэв.

- Та одоо аймшигтай зүүд зүүдлэж гэдгээ хүлээгээд явж өглөөнийхөө зоогийг зоогловол дээр юм биш үү? Гэж Бошан хэлэв. Ханын цагны дуу намдаагүй байхад хаалга онгойж Жермен орж ирээд,

- Гэгээн ноён Монте Кристо гүн ирлээ гэж айлтгав. Тэгэхэд тэнд байсан хүмүүс өөрийн эрхгүй давхийн Морсерын яриа тэдний сэтгэлд хир гүн шингэснийг харууллаа. Альбер ч гэсэн гэнэт догдолсон сэтгэлээ дарж чадахгүй байв. Сүйх тэрэгний дуу үүдний өрөөнд хүний хөлийн чимээ гарахыг хэн ч дуулсангүй. Тэр ч байтугай хаалга дуугүй нээгджээ. Монте Кристо гүн босгон дээр гарч ирлээ. Маш энгийн байдлаар хувцасласан боловч, дээд зиндааны ямар ч хүн түүний хувцсыг өөлөх өөгүй байлаа. Дотуур гадуур хувцас, малгай нь хамгийн уран сайвны гараар хийгдсэн хүмүүсийн дурлан шохоорхож өмсдөг хэв маягт яг тохирсон байлаа. Түүнийг харахад гучин таваас хэтрэхгүй настай болов уу гэмээр. Ялангуяа Дебрэгийн дүрслэн хэлсний яг адил байгаа нь бүхний гайхлыг төрүүлэв. Гүн инээмсэглэн шууд Альбер өөд очиход, цаадах нь өөдөөс нь тосч ирээд гарыг нь халуунаар атгав.

- Яг таг байна гэдэг бол вангийн эелдэг сэтгэлийн илрэл гэж танай эзэн хаадын нэг нь батлан хэлсэн шиг билээ. Гэвч жуулчлан яваа хүмүүс хичнээн өсөвч, энэ журмыг алдалгүй дандаа биелүүлээд байж чадахгүй. Эрхэм хүндэт бэйс та намайг яг цагтаа ирэх гэж бодсоныг нь харгалзан үзэж, хоёр гурван секунд хожимдож ирсэнийг минь уучлаарай. Хоёр мянга таван зуун мод газрыг ямар я саадгүй явж өнгөрнө гэдэг амаргүй хэрэг, тэгээд ч бас хөтчийг зодож болдоггүй франц оронд гэж Монте Кристо хэлэв.

- Таныг манайд ирэх явдлыг тохиолдуулан урьсан найз нөхөддөө таны ирэх тухай ярьсан. Одоо танилцуулахыг зөвшөөрнө үү: гүн Шато-Рено, арван хоёр тайжаас¹ удам угсаатай энэ хүний өвөг дээдэс нь Дугуй ширээнд сууж байсан хүн, эрхэм Люсьен Дебрэ дотоод яамны сайдын нарийн бичгийн дарга, эрхэмсэг Бошан аюултай сэтгүүлч, францын засгийн газрын аянга, энэ хүн эх орондоо бол их нэр цуутай хүн, харин Италид сониныг нь тараахыг хориглоод байдаг учир та хэзээ ч дуулаагүй байх, хамгийн сүүлд нь морин цэргийн ахмад Максимилиан Моррель.

Бүхэнтэй эелдэг мэхийн, ёстой л Английн хайхрамжгүй хүйтэн байдалтай мэндэлж байснаа энэ нэрийг сонсоод гүн өөрийн эрхгүй урагш нэг алхаж, цав цагаан царай дээр нь улбар туяа тодроод өнгөрөв.

- Та ялан диэцлэгч францчуудын ёслолын хувцас өмсдөг юм аа, сайхан хувцас шүү гэж хэлэв.

Ямар их сэрэхүйн хүчин гүнгий хоолойноос ийм эелдэг дур зоргоор ангид дуу гаргаж, хэзээ ч юунд ч халхлагдаж байгаагүй тайван сайхан нүдэнд нь тод гэрэл үүсгэв гэдгийг хэлэхэд бэрх ажээ.

- Та манай Африкийнхныг ердөө үзээгүй юу? гэж Альбер асуухад, гүн хуучин байдалдаа дахин орж, - Ердөө ч үгүй гэж хариулав.

- энэ хувцасны цаана манай армийн хамгийн аймшиггүй сайн сайхан сэтгэлтэний зүрх цохилж байгаа юм.

- Өө, бэйс! Гэж Моррель түүний үгийг таслахад, Альбер цааш үргэлжлүүлэн,

- Ахмад та миний ярьж гүйцэхийг зөвшөөрнө үү... Бид дөнгөж сая эрхэм Моррелын баатарлаг явдлын тухай мэдлээ л дээ. эрхэм Моррельтай дөнгөж өнөөдөр танилцуулж байгаа боловч, гүн танд энэ хүнийг өөрийн хуучин найз шигээ танилцуулахыг өөрөөс нь гуйя.

Энэ үгийг хэлэхэд, гүнгийн ширтсэн харц, царай нь эгшин зуурын дотор улбартан ягаарсан зовхи нь үл мэдэг хөдлөн түүний сэтгэл дахин хөдөлснийг харууллаа.

- Өө, мөн! Ахмад чинь сайн санаатай хүн байх нь ээ. Тэр тусмаа сайн даа! гэж гүн хэлэв.

Альберын үгний хариуд хэлэхээсээ илүү өөрийн бодолд хариу болгож хэлсэн энэ үг бүх хүнд, ялангуяа Монте Кристо өөд гайхан харж байгаа Моррельд бүр ч хачин санагдлаа. Түүний хажуугаар, хэдийгээр хачин санагдавч, тийм их эелдэг зөөлөн хэлсэн учир гүнд уурлан гомдохын аргагүй байлаа.

- Үүнд эргэлзэх ямар үндэс түүнд байж болох билээ? гэж Бошан, Шато-Реногоос асуухад цаадах нь Монте Кристоос мэдэгдэж байгаа бүхнийг дээдсийн хурц нүдээр ялган хараад,

- Үнэндээ ч, Альбер бидэнд худлаа хэлээгүй шүү. Энэ гүн ер бишийн хүн юм . моррель танд ямар санагдаж байна? гэж асуув.

- Тэр хэдийгээр миний тухай хачин үг хэлсэн боловч илэн далангүй яриа, аятайхан дуу нь надад таалагдаж байна.

-Эрхэмүүд ээ, өглөөний зоог бэлэн болсныг Жермен илтгэж байна. Эрхэм хүндэт гүн танд зам зааж өгөхийг зөвшөөрнө үү гэж Альбер хэлэв.

Хүмүүс цөм дуугүй явж хоолны өрөөнд орж сууцгаав.

Гүн суух зуураа,

- Эрхэмүүд ээ, би та нарт үнэнээ хэлэхийг зөвшөөрнө үү. Энэ маань миний эндэл ослыг уучлаарай гэж байгаа үг л дээ. би Парист анх удаа ирж байгаа болохоор, францын амьдралыг огт мэдэхгүй гадны хүн. Би одоо хүртэл францынхаас шал өөр, дорнод маягаар амьдарч ирсэн хүн. Хэрэв надаас дэндүү их түрэг неополитан, араб байдал гараад байвал урьдчилан уучлахыг гуйя. За одоо зооглоцгооё гэв.

- Энэ хүний ярихыг! Ноён хүн шиг л юм! гэж Бошан шивгэнэхэд Дебрэ дээрээс нь нэмж,

- Харь газрын ноён байна гэв.

- Эрхэм Дебрэ минь энэ хүн ч бүх л газар орны ноён гэж Шато-Рено дүгнэн хэлэв.

II. Өглөөний зоог

Гүн тун ялихгүй жаахан иддэг гэдгийг уншигчид мартаагүй байх аа. Тийм учир Альбер парисын амьдралын хэлбэр эхнээсээ аваад өөрийн материаллаг, тэгсэн мөртөө байхаас өөр аргагүй талаар гүнд эвгүй сэтгэл төрүүлэх вий гэж болгоо-жилж байв.

- Эрхэмсэг гүн танд Эльдэр гудамжны хоол, Пьяццади-Спаньяагийн хоолноос бага таалагдах болов уу гэж айж байна. Би тны ямар хоолонд дуртай болохыг урьдчилан лавлаж, захиалан бэлтгэдэг байж гэж хэлэхэд, гүн инээмсэглэн,

- Хэрвээ та намайг ойр сайн мэддэг байсан бол ийм дэмий юмны төлөө санаа зовохгүй байсан биз. Би аялан явах зуураа Неапольд хөндий гоймон, Миланд польента, Валенсид оллаподрида, Константинопольд полов, Энэтхэгт халуун ногоо, Хятадад алтан хараацайн үүр гээчийг идэж явлаа. Над шиг ертөнцийн иргэн болсон хүнд ийм тийм хоолонд дуртай гэх юм байдаггүй. Би хаана ч байсан, юу ч хамаагүй иднэ, харин тэгэхдээ жаахан иддэг. Харин өнөөдөр та нар намайг жаахан идлээ гэж байхад, би чоно шиг л хоолонд дуртай байна. Би өчигдөр өглөөнөөс хойш юу ч идээгүй гэв.

- Яалаа гэнээ, өчигдөр гөлөөнөөс хойш ий? Та тэгээд бүтэн хоног юм идсэнгүй хэрэг үү? гэж бүгдээрээ гайхав.

- Тийм ээ, намгийн ойролцоох газраас зарим нэг мэдээ цуглуулж авахаар замаас хазайх хэрэг болсон юм . энэ явдал намайг баахан саатуулсан болохоор дахин зогсохыг хүсээгүй юм гэж Монте Кристо гүн хариулав.

- Та сүйх тэргэн дотроо хооллож явав уу? гэж Морсер асуухад,

- Үгүй ээ, би унтаж явсан. Би уйдаад зугаацах дур хүрэхгүй байвал, эсвэл өлсөөд юм идэх дургүй байвал дандаа унтаж явдаг юм гэж хариулав.

- Та тэгвэл өөрийгөө албаар унтуулж чаддаг юм уу? гэж Моррель асуухад

- Бараг л тийм.

- Унтахад хэрэглэдэг ямар нэг юм танд бий юу?

- Хамгийн найдвартай юм бий.

- Тэр чинь л бидэнд, Африкийнханд баймаар юм гэж Моррель хэлээд, - Бидэнд цаг үргэлж хоол байгаад байдаггүй, уух юм бол бүр ч ховор гэв.

- Хэрэг болох нь ч зайлшгүй л дээ, тэгэхдээ миний тэр арга над шиг гойд амьдралтай хүнд хэрэгтэй болохоос армид хэрэглэхэд аюултай. Хэрэгтэй цагт сэрэхгүй байж мэднэ гэж Монте Кристо гүн хэлэхэд,

- Тэр чинь ямар гээчийн эд вэ, мэдэж болох уу? гэж Дебрэ асуув

- Бололгүй яах вэ. Би түүнийгээ нуудаггүй юм. энэ бол чанарт нь итгэлтэй байхын тулд өөрийн биеэр Кантонд очиж авсан онц сайн чанарын хар тамхи, Тигр Ефрат хоёр мөрний хоорондоос түүсэн шилдэг сайн гашиш хоёрын холимог. Тэнцүү хэмжээтэй хольж бөөрөнхийлөөд хэрэгтэй болохоороо л залгичихдаг юм. арван минутын дараа л үйлчилж эхэлнэ. Франц де Эпинегээс асуугаарай, нэгэн удаа амсаж үзсэн юм даг.

- Тийм ээ, тэр надад ярьсан. Тэр тухайгаа их л сайхан сэтгэгдэлтэй явдаг юм билээ гэж Альбер хэлэхэд, сэтгүүлч хүний итгэлгүй байдлаар Бошан,

- Тэгвэл тэр юм, танд дандаа байдаг байх нь ээ? гэж асуухад, Монте Кристо гүн,

- Дандаа, хэмээн хариулав.

- Тэрхүү үнэт үрлүүдээ бидэнд үзүүлэхгүй юу гэж гуйвал дэндүү даруу биш хэрэг болохгүй байгаа, гэж Бошан харь орны хүнийг тэвдүүлэх санаатай асуув.

- Болно болно гэж хэлээд, гүн хармаанаасаа цул маргад эрдэнийн чулууг ухаж хийсэн, гайхам сайхан алтан тагтай сав гаргаж ирээд, тагийг нь эргэдэн ногоовтор өнгөтэй, том багаар вадуй шиг бөөрөнхий үрэл гаргаж ирэв. Үрлээс хурц эхүүн үнэр ханхална. Маргад саван дотор тийм дөрөв, таван үрэл байхаа бөгөөд уг нь арван хэдийг ч багтаах зайтай ажээ. Тэр савыг зочид ширээ тойруулан үзэж, бие биесээ дамжуулан авахдаа, доторх үрлүүдийг нь үнэртэж үзэх гэхээсээ, гайхамшгийн сайхан маргад эрдэнийг нь үзэх гэж яарч байлаа.

- Энүүнийг чинь таны тогооч бэлтгэж өгдөг үү? гэж Бошаныг асуухад, Монте Кристо гүн,

- Өө үгүй шүү, хамгийн сайхан зугаа болгодог юмаа би хүнд итгэн хийлгэдэггүй. Би тийм ч муу биш хувилахуй ухаанч хүн болохоороо үрлээ өөрөө бэлтгэдэг юм гэв.

- Тун сайхан чулуу юм. Манай ээжид тийм ч багагүй үнэт эрдэнэс байдаг боловч би ийм томыг ердөө үзээгүй юм байна гэж Шато-Рено хэлэхэд, Монте Кристо тайлбарлан,

- Надад гурван ийм чулуу байлаа. Нэгийг нь падишахад бэлэглэсэн, тэр түүгээр өөрийн сэлмийг гоёсон. Хоёр дахийг нь гэгээн хутагт хамба пап ламд бэлэглэсэн, тэр түүнийг өөрийн овоодой малгайндаа, өөрийнх нь өмнөх долдугаар Пийд эзэн хаан наполеоны бэлэглэсэн бараг адил үнэтэй боловч ийм сайхан биш маргадын дэргэд тавиулсан. Гурав дахийг нь авч хоцроод үүнийг хийлгэсэн юм. энэ нь үнэнийх нь хагасыг үгүй болгосон боловч миний хэрэглэх гэсэн санаанд тохирсон юм гэж ярив.

Цөм Монте Кристо өөд гайхаж харна. Жирийн ойлгомжтой яриа нь нэг бол чин үнэн үг, эсвэл солиотой хүний дэмийрэл гэж бодмоор байжээ. Гэвч одоо хүртэл түүний барьж байгаа маргад нь түрүүчийнх нь зөв болохыг хэлээд өгч байлаа.

- Тэгээд энэ хоёр эзэн сайхан бэлгийн чинь хариуд юу өгсөн юм бэ? гэж Дебрэ асуухад,

- Падишах эмэгтэй хүнд эрх чөлөө бэлэглэсэн. Гэгээн хутагт хамба эрэгтэй хүний амь насыг хэлтрүүлсэн. Ингэж би амьдралдаа эзэн хаан шиг хүчирхэг болж үзсэн юм гэж гүн хариу өгүүлэв.

- Таны аварсан хүн чинь Пеппино байсан, тийм биз. Та түүнд өршөөл үзүүлэв эрхийг хэрэглэсэн байх аа гэж Морсер дуугарахад, Монте-Кристо инээмсэглэн,

- Юм бүхнийг хийж болно хэлж хариулав.

- Гүн таны ярьж байгааг сонсоход надад ямар сайхан байгааг та төсөөлөн мэдэхгүй байгаа даа. Би таныг өөрийнхөө нөхдөд “Мянга нэгэн шөнийн үлгэрийн” гайхамшиг, дундад зууны үеийн илбэч гэж танилцуулсан. Гэвч парисынхан өөрсдийнх нь өдөр тутмын амьдралын хэмжээнд нь багтахгүй л юм байвал түүнийг хий хоосон санаа бодлын үүр гэж үзэж сурчихсан улс байдаг юм. жишээлбэл, шөнө орой явж байсан Жоккей клубын гишүүнийг Бульварт барьж авч зогсоогоод дээрэмдэж гэнэ, Сен-Дени гудамж, эсвэл Сен-Жермений тэнд дөрвөн хүн алж гэнэ, Бульвар Тамплъ буюу Терм Юлианд байдаг кафенаас арав, арван тав, хорин хулгайч барилаа гэж Бошан өдөр бүр хэвлээд, Дебрэ уншиж суудаг юм. Тэгсэн мөртөө эд нар Маремма, ромын кампанье, эсвэл Пунтийн намагт дээрэмчийн байдаг гэдгийг үгүйсгэж байгаа юм. Тэгэхээр гүн та намайг тэдгээр дээрэмчдэд баригдаж, таны энэрэгүй сэтгэлийн оролцоо байгаагүйсэн бол би өнөөдөр энд, Эльдер гудамжны өчүүхэн муу гэртээ эд нарыг хүлээн авч байхын оронд, Сан-Себастьяно хонгилд үхэгсдийг дахин сэргээх ээлж хүлээгээд л хэвтэж байх байсан тухай ярьж өгөхгүй юу гэв Альбер хэлэв.

- Боль доо, гэж Монте-Кристо гүн хэлснээ, - Та энэ дэмий юмыг давтан ярихгүй гэж амласан шүү дээ гэв.

- Үгүй, би тэгж амлаагүй. Та тиймэрхүү тус хүргэсэн өөр хүнтэй намайг андуурч байх шиг байна. Харин ч бүр энэ тухай ярьцгаая. Та миний мэдэж байгаа зүйлийг давтан яриад ч зогсохгүй, бас миний мэдэхгүй юмыг ч ярьж өгч магадгүй гэж Морсер хэлэхэд, гүн инээмсэглэн,

- Та тэр бүх явдалд надаас дор мэдэхээргүйгээр тийм хангалттай үүрэг гүйцэтгэсэн шиг санагдаж байна гэв.

- Хэрвээ намайг мэдэж байгаа бүхнийгээ ярьвал та миний мэдэхгүй байгаа зүйлийг ярьж өгөх үү? гэж Морсер асуухад,

- Энэ чинь л шударга хэрэг болно доо гэж Монте-Кристо хариу өгүүлэв.

- За тэгвэл энэ яриа миний нэрэнд хэдийгээр сайхан биш боловч ярья л даа. Би гурван өдрийн турш Тулли юм уу Поппейгээс шууд гаралтай баг өмссөн язгууртан хүүхэн надтай даажигнаад байна гэж бодсон чинь, ердийн нэг хөдөөний сайхан хүүхэн л даажигнаад байсан юм санж. Энэ ч яах вэ, би арван таван настай, тэгш шулуун биетэй, сахалгүй залуухан дээрэмчнийг тариачин хүүхэн байна гэж бодож мангартсаныг яана. Би түүний булбарай мөрөн дээр үнсэх гэж зориг гаргасан чинь харин нөгөөдөх маань цээжинд гар буу тулгаж, долоо найман нөхдийнхөө хамт намайг Сан-Себастьяно агуйд аваачиж чухамдаа чирээд оруулсан юм. би тэнд тэдний толгойлогч их эрдэмтэн хүнийг харав. Тэр хүн “Цезарийн тэмдэглэлийг”

уншиж сууснаа, зөвхөн маргааш өглөөний зургаан цагт кассанд нь дөрвөн мянган пиастр хийхгүй бол зургаан цагаас арван таван минут өнгөрөхөд намайг амьд байхгүй болно гэж хэлэх л гэж уншиж байсан номоосоо хөндийрлөө. Луйжи Вампын цохолттой миний захидал Францад бий дээ. хэрвээ та нар эргэлзээд байвал Францыг баталгаа ирүүлээч гэж захидал бичиж болно. За миний мэдэж буй юм энэ. Харин хүмүүсийг тун ч бага хүндэтгэдэг Ромын дээрэмчид таныг яагаад тэгтлээ хүндэтгэх болсон юм бэ гэдгийг мэдэхгүй байна. Үнэндээ Франц бид хоёр шагшин гайхсан шүү гэж Морсер ярив.

- Энэ бүгд амархан. Би алдарт Луйжи Вампыг арваад жилийн өмнөөс танина. Түүнийг малчин жаал байхад нь би зам зааж өгсөнд нь алтан зос өгч байсан юм. тэгэхэд тэр надад өртэй хоцрохгүйн тулд өөрийн хийсэн ишиндээ сийлбэртэй кинжаалаа хариу бэлэглэсэн. Энэ хутга миний зэвсгийн цуглуулга дотор байсныг та харсан байх аа. Тэгээд сүүлд нь тэр хүн бидний нөхөрлөлийн билэг тэмдэг болох бэлгээ мартчихсан юм уу, эсвэл намайг таниагүй ч юм уу барьж авахыг оролдсон юм. тэгсэн чинь тэр намайг барих биш, харин би түүнийг хэдэн арван дээрэмчидтэй нь хачт барьчихваа. Би түүнийг шуурхаа ажилладаг, ялангуяа түүний хувьд бүр ч шуурхай ажиллах Ромын шударга үнэний шүүхэд өгч болох байсан боловч тэгээгүй юм . би тэднийг цөмийг нь зүгээр л тавьчихсан.

- Дахин нүгэл хийхгүй гэж ам өчгийг нь аваад л тавиа биз дээ? гэж сэтгүүлч асуугаад инээж, - Би тэдний хэлсэн үгэндээ хүрснийг нь харж л байна гэв.

- Үгүй шүү, гэж Монте-Кристо татгалзан хэлээд,

- Зөвхөн тэд намайг ба миний найз нөхдөд гар хүрэхгүй гэдэг амыг нь авсан. Эрхэм социалист, дэвшилт үзэлтэн, хүнийг энэрэн хайрлах үзэлтэн нар минь миний ярьж байгаа та нарт хачин санагдаж байж магадгүй. Би бол хэзээ ч харсан хүндээ санаа тавьдаггүй, зөвхөн надад хор хүргье д гэхээрээ надаар оролддог нийгмийг хамгаалахыг оролддоггүй хүн. Би нийгэм ба ойрын хүмүүсийг хүндэтгэхээс татгалзаж зөвхөн төвийг сахисан байдлыг хадгалж явдаг ч гэсэн тэд надад өртэй үлдэж байгаа юм даа гэв.

- Тэнгэр минь! Хувиа хичээх гэдгийг илэн далангүйгээр шуудхан номлодог зоригтой хүнийг ингэж хардаг байжээ. Догь хэрэг, зүйтэй гүнтэн минь, гэж Шато-Рено дуу алдав.

- Наад зах нь илэн далангүй л юм гэж Моррель хэлээд – Гүн ийм шийдэмгий тунхаглаж байгаа зарчмаасаа нэг удаа хазайсандаа харамсахгүй байгаа юм байна гэдэгт итгэж байна гэв. Монте-Кристо гүн Моррель өөд байн байн анхааралтайгаар харж, аймшиггүй дайчин залуу эр, гүнгийн тэр тунгалаг зөөлөн харцнаас хэдэн ч удаа нүд буруулж байлаа.

Тэгээд Монте-Кристо гүн,

- Би зарчмаасаа юугаараа хазайчихваа? гэж асуухад Моррель

- Та огт танихгүй эрхэм де Морсерыг аварснаараа, хавьтсан хүндээ, нийгэмд тус хүргэсэн байна гэж бодогдох юм хэмээв.

- Тийм ээ, чимэг болсон хүнийг нь үү гэж Бошан баяртайгаар хэлээд хундагатай Шампаан дарсаа нэг амьсгаагаар хоослон уув.

- Та хэлснээсээ зөрж байна, гүн. Та бол миний л мэдэх хамгийн сүрхий учир шалтгааныг ойлгодог хүн. Та бол тийм сүрхий хувиа бодсон хүн биш, харин энэрэнгүй үзэлтэй хүн гэдгийг чинь нотлоод өгье. Та өөрийгээ дорнодын хүү, левантин, малай, энэтхэг, хятад, зэрлэг хүн гэж ярьдаг. Таны нэр бол Синдбад далайчин, Монте-Кристо гүн. Та дөнгөж л парист ирмэгц, парисынхан бидэнд байдаг гол ололт буюу гол дутагдал танаас гарч ирж байна. Та дутагдалтай хүн болох гэж сайн үйл явдлаа нууж байна гэж Альбер хэлэхэд, Монте-Кристо татгалзан,

- Хүндэт бэйс, би өөрийнхөө үг буюу үйл явдлаар ийм магтаалыг хүлээх ёсгүй. Та бол миний хувьд огт танихгүй хүн байгаагүй. Би тантай танил байсан хоёр тасалгаагаа найр тавин өгсөн, хамт зоог барьж байсан, нэг сүйхээ танд хэрэглүүлж, хамт Корсогийн багт наадам сонирхон үзэж, Пьяцца-дель-Пополлогийн цонхоор цаазаар аваачих ял гүйцэтгэхийг харсан. Тэр үед та маш их сандран, муужрах гэж байсан шүү дээ. тэгэхээр ийм зочноо тэр та нарын хэлдэг аймшигт дээрэмчдийн гарт орхиж бо«ох уу? түүнээс гадна, таныг аврахдаа надад бас өөр санаа намайг Францад ирэхэд Парисын дээдсийн хүрээлэнтэй танилцуулж өгөх байм гэж бодож байсан юм гэдгийг т а мэднэ шүү дээ. урьд нь бол т а миний үгийг зүгээр л хэлээд өнгөрсөн байх гэж бодож болох байсан бол, одоо чин үнэн зүйл болж, та хэлсэн үгэндээ хүрэх болоод байна шүү дээ гэж хэлэв.

- Би хэлсэн үгэндээ хүрнэ, гэвч эрхэм гүн таныг их л гутрах болов уу гэж айж байна. Та чинь үзэсгэлэнтэй сайхан газар нутагт, их л адал явдалтай учирч сурчихсан хүн шүү дээ. таны дасаж сурчихсан баялаг үйл явдалтай амьдралтай адил юм энд байхгүй. Монмарт бол манай Чимборазо, Монвалериен бол манай Гималай, гренелийн тэгш тал газар бол манай Их цөл, бас тэнд жинчдэд зориулж өрөмдмөл худаг гаргадаг. Манайд хүмүүс хулгайчийг тийм олонгүй гэж ярьдаг ч чамлалтгүй олон хулгайч бий. Гэвч эд нар хамгийн хүндтэй язгууртнаас айхаасаа хамгийн наад захын эрүүлч мөрдөгчдөөс илүү их айна. Ер нь Франц гэдэг чинь асар олон талтай улс, Парис гэдэг чинь соёлжилж боловсорсон хот, манай бүх наян таван мужид (Корсикийг Францын тужийн тооноос хасаж байгаа нь мэдээж) төмөр утасны мод зоогоогүй өчүүхэн төдий боловч уул, цагдаагийн комиссар хийн гэрэл тавиулаагүй нэгээхэн ч харанхуй агуйг олохгүй. Тэгэхээр би эрхэм хүндэт гүн танд ганцхан л тус хүргэж чадна, би таны бүрэн мэдэлд байна. Таныг өөрөө буюу нөхдөөрөө дажуулан хаа л бол оруулж болох ганц зүйл байна. Гэвч энэ хэрэгт танд хэн ч хэрэг болохгүй. Тан шиг нэ° цуутай, тан шиг ухаантай, тан шиг баян хүнийг (Монте-Кристо ёжтойхон инээмсэглэн мэхийв) хаана я сайнаар хүлээж авна. Ер нь би танд ганцхан зүйлээр л хэрэг болно байх. Хэрвээ танд миний парисын амьдралыг мэддэг хийгээд, ая тохийн асуудлаар олсон бага зэргийн туршлага ба хоршоо дэлгүүрүүдийг мэддэг минь хэрэг болбол би таны бүрэн мэдэлд байж, төвхнөхөд чинь тус болж чадна. Та Ромд байхдаа надад байрнаасаа өгч байсан шиг би өчүүхэн гэрээ хувааж сууя гэж хэлэх зүрх алга хэдийгээр би хувиа хичээх талаар номлоогүй боловч ясандаа хүртэл хар амиа боддог хүн. Миний энд надаас өөр сүүдэр ч байхгүй, харин эмэгтэй хүний тухайд биш шүү гэж Морсер хэлэв.

- Өө энэ үг чинь эхнэр авах тухайгий чинь сануулчихав. Та Ромд байхдаа гэр бүлтэй болох тухай надад дурсаж байсан шүү дээ. ойртож байгаа зол жаргалд чинь баяр хүргэх ёстой биз? гэж Монте-Кристо гүн хэлэв.

- Энэ маань төлөвлөгөө хэвээрээ л байгаа.

- Тэгэхдээ тун ч тодорхойгүй гэж Дебрэ хажуугаас нь хэлэхэд,

- Тийм биш ээ, манай аав үүнийг их хүсэж байгаа юм. би удахгүй та нарыг эхнэртэйгээ биш гэхэд, болзоот хүүхэн Эжени Данглартайгаа танилцуулна даа гэж Морсер хэлэхэд Монте-Кристо угтан авч,

- Эжени Данглар ий? Тэр хүүхний чинь эцэг нь түшээ гүн Данглар мөн үү? Гэж асуув.

- Тийм ээ, тэгэхдээ шинэ үеийн түшээ гүн байгаа юм гэж Морсер хариулав.

- Улсдаа л ийм хэргэм шагнуулахаар тус хүргэсэн юм бол адил юм биш үү гэж Монте-Кристо татгалзан хэлэхэд,

- Их ялгаатай шүү. Сэтгэл санаагаараа либерал хүн боловч мянга найман зуун хорин есөн онд аравдугаар Карлд зориулж зургаан саяын зээллэг гаргасан юм. мөн үүний нь төлөө түүнийг түшээ гүн болгож Хүндэт Легионы одонгоор шагнасан юм. тэрээр одонгоо бодвоос хантаазныхаа хармаанд авч явдаг гэж бодож болох боловч бүр номоор нь цахлай цамцныхаа энгэр дээр нүүр бардам зүүж явдаг юм шүү гэж Бошан хэлэв.

- Ай, Бошан, Бошан гээд Морсер инээн – энэ үгээ “Корсер” ба “Шаривари”-даа зориулж хадгалж үлдээ. Харин миний дэргэд ирээдүйн хадам эцгийг минь өршөөж хайрла гэж хэлэв.

Тэгээд Монте-Кристо уруу хандаж,

- Та сая түшээ гүний нэрийг танил хүн шиг хэллээ гэхэд Монте-Кристо хайнга байдлаар,

- Би түүнийг танихгүй, гэвч Лондонгийн Ричард ба Блаунт, Венийн Арштайн ба Экселес, Ромыэ Томсон ба Френчийн банкууд надад зориулж түүний банкинд зээллэг нээсэн болохоор би удахгүй танилцаж таарна л даа гэв.

Гүн сүүлийн хоёр банкны эздийг хэлэхдээ Моррель өөд сэм харав.

Харт газрын хүн. Максимилиан Моррельд сэтгэгдэл төрүүлэх гэж бодсон бол ташаарсангүй. Максимилиан цахилгаан гүйдэлд цохиулсан мэт давхийв.

- Томсо ба Френч ий? Та энэ банкийг мэддэг юм уу? гэж асуухад гүн тайвнаар,

- Тэд бол Христосын шашинтны ертөнцийн нийслэл дэх миний банкны эзэд. Би танд ямар нэгэн тус хүргэх хэрэгтэй байна уу? гэж асуув.

- Одоо хүртэл бид үр ашиггүй эрж байгаа нэгэн зүйлийг олоход гүн та тусалж магадгүй л юм. тэр банк нэгэн цагт миний пүүсэд асар их ач тус хүргэсэн хэр нь яагаад ч юм үүнийгээ үгүйсгээд байгаа юм.

- Би таны мэдэлд бэлхэн байна Монте-Кристо мэхийн хэлэв.

- Бид чинь Данглараас болоод ярианаасаа дэндүү холдоод явчихлаа. Монте-Кристо гүнд тохирох байшин олж өгөх тухай ярьж байсан шүү дээ. за алив, агуу Парисын шинэ зочныг хаана суулгах тухай бодоцгооё гэж Морсер хэлэхэд, Шато-Рено,

- Сен-Жермений дүүрэгт дотроо цэцэрлэгтэй муугүй шилтгээн олж болно гэв.

- Та зөвхөн өөрийнхөө л, хүн байхын аргагүй Сен-Жерменээ л бодох юм, Шато-Рено гэж Дебрэ хэлээд

- Гүн та үүний үгэнд бүү ор. Шоссе, д' Антенд байр олж суу, энэ бол хаанаас нь ч харсан Парис даа гэв.

- Оперын цэцэрлэгт гудамжинд хоёрдугаар давхарт тагттай байшин байгаа. Гүн тэнд мөнгөн саатай хоргой дэр тавиулаад анхилуун үнэртэй гаансаа нэрэх ч юм уу эсвэл нөгөө үрлээ залгисан шигээ хэвтэхдээ өмнөө ярайх нийслэлийг сонирхон харж болно гэж Бошан хэлэв.

- Моррель таны санаанд юу ч орж ирэхгүй байна гэж үү, та ямар ч санал гаргахгүй юм уу? гэж Шато-Реног асуухад,

- Үгүй гаргана гэж залуу хүн инээмсэглэж, - Надад нэг санаг байна. Гэсэн би та нарын сайхан саналд гүн татагдах нь уу, үгүй юу гэж хүлээж байсан юм, Меле гудманд байгаа намхан гоёмсог шилтгээнд багахан байр гаргах санал гаргаж байна. Энэ байшинг охин дүү минь хөлсөлж аваад арваад жил болж байгаа гэв.

- Та дүүтэй юм уу? гэж гүнг асуув.

- Тийм ээ, гүн минь маш сайхан дүүтэй.

- Нөхөртэй юү?

- Есөн жил болж байна.

- Жаргалтай сайн суугаа юу? гэж гүн дахин асуув.

- Хүн ямраар л жаргалтай байж болдог бол тэр хэмжээгээр жаргалтай байгаа. Дүү минь манайд золгүй явдал тохиолдоход биднийг хаяж яваагүй, угийн дурлаж байсан Эмманюель Эрботой суусан гэж Максимилиан хариулав.

Монте-Крсто үл мэдэг инээмсэглэв.

- Би амралттай байхдаа тэднийд байдаг юм. би хүргэнтэйгээ хамт танд хэрэгтэй зүйлд чинь үйлчилэхэд бэлэн байна гэв.

Монте-Кристо хариу хэлэхээс өмнө Альбер түүний яриаг таслан

- Алив байзаарай! Моррель та яаж байгаа чинь энэ вэ? Та чинь жуулчин Синдбад далайчныг гэр бүлийн байдалд оруулж тав алдуулах нь уу. парисыг үзэх гэж ирсэн хүн гэрээс гарахгүй болчих нь уу гэв.

- Ердөө ч үгүй, миний дүү хорин тавтай, миний хүргэн гучтай. Тэр хоёр залуу аз жаргалтай хөгжилтэй улс. Тэгээд ч гүн тусдаа сууж хүссэн цагтаа тэдэнтэй уулзаж байх болно гэж Моррель инээмсэглэн хариулав.

- Баярлалаа танд, баярлалаа. Хэрвээ та дургуйцэхгүй бол би таны дүү ба хүргэнтэй танилцахдаа баяртай байна. Харин би та бүхний хэний ч саналыг хүлээн авахгүй. Надад байр бэлэн байгаа гэж Монте-Крсто хэлэхэд,

- Яалаа гэнэ ээ! Та зочид буудалд суух гэж үү? Танд их л тавгүй байх болно доо гэж Морсер дуу алдахад, Монте-Крсто гүн

- Би Ромд муу сууж байсан гэж үү? Хэмээн асуув.

- Та өрөөнүүдээ засуулах гэж тавин мянган пиастр зарцуулсан шүү дээ. байр бүрд л ийм зардал гаргаад байя гэж бодоогүй биз дээ.

- Энүүнээс ч болсон юм биш. Би Парист өөрийн гэсэн тусдаа байшинтай болохыг хүссэн юм. би гэрийн хиагаа түрүүлээд нааш нь явуулчихсан, одоо лав байшин худалдаж аваад төхөөрч засчихсан байх гэж Монте-Кристо хариулав.

- Тэгвэл танд Парисыг мэддэг хиа байдаг юм шив дээ? гэж Бошаныг дуугарахад,

- Тэр надтай л адил. Францад анх ирж байгаа юм. хар арьстай, тэгсэн мөртөө хэлгүй хүн гэж Монте-Кристо хариулав.

- Тэгвэл тэр чинь Али юу гэж Альбер хүмүүсийн гайхах дууны дундуур хэлэв.

- Тийм ээ, миний хэлгүй Нуби хүн. Та түүнийг Ромд харсан байх аа.

- Харалгүй яах вэ, би түүнийг сайн санаж байна. Та тэгээд хэлгүй Нуби хүнийг Парисаас байшин худалдан авч, засуулж төхөөрүүл гэж яаж явуулж чадав. Хөөрхий амьтан холион бантан хийчихсэн байх даа гэ Морсер хариу хэлэв.

- Та дэмий тэгж бодож байна. Харин би түүнийг миний дур хүслийн дагуу бүхнийг хийчихсэн гэж итгэж байна. Миний дур сонирхол зэгсэн ер бусын болохыг та мэднэ шүү дээ. Тэр ирээд долоо хонож байна. Бодвол ганцаараа агнаж сурсан үнэрч нохой шиг бүх хотоор гүйж үзсэн байгаа. Бүх зүйлийг зохих ёсоор нь төхөөрчихсөн байгаа байх. Тэр намайг өнөө өглөө арван цагт ирнэ гэдгийг мэдэх учир өглөө есөн цагаас хойш Фонтенблогийн харуул дээр хүлээж байгаа билээ. тэгээд надад энэ цаасыг өгсөн юм. энэ миний шинэ хаяг, унш л даа гээд Монте-Кристо тэрхүү хуудсаа Альберт өгөхөд,

- “Елисейн тал, гучдугаар байшин” гэж Морсер уншив.

- Энэ чинь ёстой догь хэрэг байна даа! Бошан хэлэхэд, Шато-Рено дээрээс нь нэмж,

- Ёстой л ноён шиг хүн байна гэв.

- Та чинь байшингаа үзээгүй юм уу? гэж Пебрэ асуухад,

- Үгүй, би болзсон цагаасаа хожимдохыг хүсээгүй гэж та нарт хэлсэн шүү дээ. сүйх тэргэн дотроо хувцсаа сольж өмсөөд, бэйсийн үүдэнд гарч ирсэн гэж Монте-Кристо хариулав.

Залуу хүмүүс бие биет өөдөө харж, түүний тоглоом тохуу хийж байгаа эсэхийг ойлгохгүй байв. Энэ хүний хэлж байгаа үг бүхэн нь ердийн биш боловч түүнийг худлаа хэлж байна гэхийн аргагүй энгийн байлаа. Ер нь тэгээд ч худлаа хэлэх арга юу байх билээ?

- Тэгвэл би гүнд өчүүхэн төдий тус хүргэж чадах нь ээ. би сэтгүүлчийн хувьд парисын бүх театрт орох үүдийг нээж өгье гэж Бошан хэлэхэд, Монте-Кристо инээмсэглэн,

- Баярлалаа танд, би хэрэг хөтлөгч даамлууддаа бүх театруудаас нэг нэг лоож захиалан ав гэж даалгасан.

- Таны даамал бас л нуби үндэстэн, хэлгүй хүн үү? Гэж Дебрэ асуулаа.

- Үгүй, тэр та нартай эх орон нэгтэй хүн. Гэхдээ хэрвээ Корсик үндэстний хүнийг нэг эх лронтой гэж хэлвэл шүү, эрхэм де Мосер та түүнийг танина даа.

- Тэгвэл тэр чинь үзвэрийн цонх чадварлаг ар хөлслөн авдаг синьор Бертуччо байж таарах нь ээ.

- Яг тийм, та манайд өглөөний зоог бархдаа харсан. Тэр бол цэрэг ч байсан, сэм хил давуулагч наймаалагч ч байсан, ер нь юм юмтай цовоолог хүн дээ. тэр ч байтугай хутгалсан хэрэг мэтийн үл ялиг хэргээс болоод цагдаагийн газартай түнжин хагарч байгаагүй гэж мэтгэж чадах л юм байна.

- Та тэгээд ертөнцийн энэ үнэнч эрийг хэрэг хөтлөгч даамлаар авсан хэрэг үү? Тэр чинь жилд хичнээнийг хулуулчихдаг вэ? Гэж Дебрэ асуув.

- Үнэндээ, бусад хэнээс ч илүүгүй би түүнд итгэдэг. Гэвч тэр надад тохирдог юм. түүнд бүтэхгүй юм гэж байдаггүй, тиймээс би байлгаад байдаг юм.

- Тэгвэл таны бүх л аж ахуйн ажил төвхнөжээ. Елисейн талд байшин байна, зарц, хэрэг хөтлөгч цөм байна. Харин ганц л сэтгэлтэй хүүхэн дутаад байх шив гэж Шато-Рено хэлэв.

Альбер инээмсэглэж, Валле ба Ардентины театруудад гүнгийн лоожинд сууж байсан албани ч юм уу, грек ч юм уу хүүхнийг санав.

- Надад арай дээр юм бий. Надад эрх чөлөөгүй боол хүүхэн бий. Та нар бол өөрсдийн нууц амрагийг Опера, Водевил, Варьета дээрээс хөлслөн авдаг. Аа харин би бол өөрийнхөө Константинополиос худалдаж авсан юм. баахан үнэтэй л олдсон, гэвч өөр юуны төлөө ч санаа зовохгүй болсон гэж Монте-Кристо хэлэв. Тэгэхэд нь Дебрэ инээд алдан,

- Ингэхэд та биднийг чөлөөг францчууд, таны боол чинь францын газар дээр хөл гишгэмэгц чөлөөтэй болсон гэдгийг мартаж байна аа? Гэв.

- Хэн түүнд тэгж хэлэх юм бэ? гэж Монте-Кристо асуув.

- Хэн дайралдсан хүн.

- Энэ хүүхэн минь зөвхөн шинэ грег хэлээр л ярьдаг юм.

- Өө, тэгвэл ч өөр хэрэг ээ!

- Бид түүнийг харж болох болов уу? Аль эсвэл та хулгүй хүнээсээ гадна тайган нарыг байлгаж байдаг юм уу? гэж Бошан асуухад,

- Үгүй, би одоогоор ийм байдалд хүрээгүй байна. Намайг тойрон байгаа хүмүүс дуртай цагтаа намайг хаяад явах эрх чөлөөтэй хүмүүс байдаг, гэхдээ явлаа гэхэд надад ч өөр хүнд ч хэрэг болохгүй. Ийм учраас л намайг орхиж явдаггүй юм гэж Монте-Кристо хэлэв.

Ярилцаж байгаа хүмүүс аль хэдийн хоолны сүүл цай тамхиндаа орчихсон байлаа.

Дебрэ босож,

- Хайрт нөхөр минь, хоёр цаг хагас болчихсон байна. Таны зочин гайхам сайхан хүн юм. Гэвч салж болохгүй хүмүүс гэж байдаггүй болохоор, түүнийг заримдаа орхиж эвгүй хүмүүсийн дунд орох хэрэг болдог. Би нам уруугаа явах боллоо. Би гүнгийн тухай сайдад ярья. Ер хэн гэгч болохыг бидэнд мэдэх хэрэг байна гэв.

- Болгоомжлоорой, хамгийн нарийн хянуур хүмүүс энэ таавраас ухарч байсан юм шүү гэж Морсер хариу хэлэв.

- Цагдаагийн газарт зориулж бидэнд гурван саяыг өгдөг юм. Үнэндээ энэ хөрөнгө бараг л урьдчилан зарагдчихаад байдаг юм. гэвч энэ хэрэгт зарцуулахаар тавин мянган франк олдох байлгүй.

- Та үүнийг хэн болохыг мэдчихээрээ надад хэлэх үү?

- Заавал хэлнэ. Баяртай Альбер, эрхмүүдэд мэхийн ёсолъё.

Тэгээд Дебрэ үүдний өрөөнд гарч,

- Уналга өг гэж тушаагаадаа гэж чанга хашхирав.

- Би ч танхимд очиж амжихаасаа өнгөрөв бололтой. Гэвч өөрийн уншигчдад Дангларын хэлсэн үгнээс арай илүү ч юм хүргэж чадах нь гэж Бошан Альберт хэлэв.

- Бурхан минь, Бошан, чи түүнийг олонд үзүүлэх гэсэн миний онцгой эрхийг бүү алга болгодох. Сонирхолтой хүн шүү тийм ээ, гэж Альбер хэлэв.

- Миний л үзсэн дуулсан хүмүүсийн дотроос хамгийн ер бишийн гайхалтай нь энэ хүн юм Шато-Рено хэлээд, - Моррель, явах уу гэв.

- За, одоохон. Би гүнд энэ нэрийн хуудсаа өгчихье. Гүн манайд Меле гудамжны арван дөрөвт очно гэж найрсгаар тал өгч байна.

- Би үүнийг мартахгүй гэдгээ танд итгүүлэн хэлэх байна гэж гүн мэхийн ёслов.

Тэгээд Максимилиан Моррель түшээ гүн Шато-Рено хоёр Монте-Кристо Морсер хоёрыг орхиод гарч одов.

III. Анхны уулзалт

Альбер Монте-Кристотой хоёулханаа үлдээд,

- Эхнэргүй залуу ямар шуухан суудгийг үзүүлэх тайлбарлагчийн ажилдаа орохыг гүн та зөвшөөрнө үү? Тан шиг Италийн орнуудыг үзээд дасчихсан хүнд эндхийнхний үздэгээр бол тийм ч муугүй үзэж байгаа залуу хүн хэдэн хавтгай дөрвөлжин фут газар эзэлдгийг сонин байх байлгүй. Өрөөнөөс өрөөнд орохдоо таныг бүгчимдүүлэхгүйн ту«д цонхнуудыг нь онгойлгож байя гэв.

Монте-Кристо хоолны өрөө ба доод давхрын зочдын өрөө үзсэн байлаа. Альбер түүнийг хамгийн түрүүнд өөрийн гол танхимд оруулав. Энэ бол түүний дуртай тасалгаа байсан гэдгийг уншигчид санаж байгаа байх аа.

Монте-Кристо Альберын цуглуулсан юмыг зүй ёсоор нь үнэлж чадах хүн байв. Тэнд байсан хуучин цашгийн авдар, япон шаазан, дорнодын нэхмэлүүд, венецийн шил сав, улс бүхний зэвсэг, энэ бүхэн нь гүнгийн мэдэл зүйлүүд байв. Гүн тэдгээрийг хараад л тухай бүрт нь аль улсад, хэддүгээр зууны үед хийж, яаж бий болсныг тодорхойлж байв. Морсер уг нь түүнд тайлбарлан ярьж өгнө гэж бодож байсан чинь, харин өөрөө гүнгийн удирдлаган доор хуучны судлал, эрдэс судлал байгалийн түүхийн хичээ хийж өнгөрөв. Тэд хоёрдугаар давхарт бууж ирэв. Альбер зочноо зочдын өрөөнд оруулав. Энэ өрөөний ханан дээгүүр орчин үеийн зураачдын зурсан зургуудыг хаджээ. Дюпрейн зурсан байгалийн зураг: өндөр ургасан зэгс, гуалиг шулуухан модод, мөөрч байгаа үхэр ба тунгалаг сайхан тэнгэр байлаа. Делакруагийн зурсан гялалзсан бүс бүслэн, зэр зэвсэг зүүж урт цагаан нөмрөг нөмөрсөн арабын морьтон байна. Морьд нь янцгаалдан цавчилж, унасан хүмүүс нь төмөр мунаар нүдэлдэнэ. Булантейн усан будгаар зурсан “Парисын эх дагины сүм” гэдэг зураг байна. Зураач энэ бүдээлийг яруу найраг гэлтэй зуржээ. Диасын зурсан тосон будгийн зургууд байх бөгөөд цэцгүүд нь амьд цэцгээс ч илүү сайхан, нар нь тэнгэрт мандан байгаа нарнаас ч илүү тод байлаа. Диканд зурсан харандаан зургууд байх бөгөөд эдгээр нь Сальбатор Розагийнх шиг хурц тод боловч илүү яруу сайхан ажээ. Жиро ба Мюллерийн чигаа тэнгэрийг үурсан хүүхдүүд ба гуалиг булбарай царайтай хүүхнүүдийн зураг байв. Дозо дорно зүгт явж байхдаа зурсан зургуудын альбомаас

авсан хуудсууд байлаа. Тэмээний нуруун дээрээс хэдхэн хормын дотор зурсан зураасан зургууд, ер нь л үхэж үрэгдсэн буюу өнгөрч мөхөж байгаа урлагийн оронд орчин үеийн урлагийн өгч чадах зүйлүүд байлаа.

Альбер одоо л харь газрын хачин хүнийг гайхуулна гэж найдсан боловч, гүн тэдгээрийн зурсан хүний гарын үсгийг ч харалгүй, заримдаа хүний нэрийн эхний үсгийг дуулмагц нэрийг нь хэлэхэд учиргүй гайхав. Гүн эдгээрийг зурсан хүний нэрийг мэдээд ч зогсохгүй, тус бүрийг нь үнэлэн судалж амжсан хүн байлаа.

Тэд зочдын ерөөнөөс унтлагын ерөөнд орж ирэв. Энэ бол нямбай, юмыг нарийн мэддэгээ харуулсан ерөө байв. Алтан жаазтай ганц зураг байсан нь Льеополд Роберын гарын үсэгтэй байв.

Энэ зураг Монте-Кристогийн анхаарлыг тэр дороо татан, түүн рүү яарч дөхөн очиж өмнө нь зогсов.

Энэ бол хорин тав орчим насны хагас буулгасан зовхиныхоо цаанаас харсан гялалзсан хурц нүдтэй боровторхон царайтай эмэгтэйн зураг байв. Каталан үндэстний загасчин хүүхний гоёмсог хувцас өмсөж, үсэндээ алтан зүү хатгажээ. Далай өөд харж, гуалиг лэгш бие нь хөх тэнгэр, цэнхэр далайн өнгөнд тод харагдана.

Тасалгаа бүдэгхэн гэрэлтэй байгаагүй бол гүнгийн царай ямар аймшигт й цайж, мөр цээж нь чичирхийлэхийг Альбер ажиглан харчих байсан биз ээ.

Минут хэртэй дуугүй зогсоход Монте-Кристо гүн нүд салгалгүй ширтэнэ.

- Таны сэтгэлтэй бүсгүй чинь гоо сайхан хүүхэн байна шүү гэж Монте-Кристо хэлээд – Энэ хувцас нь багт наадмын хувцас байх аа, их зохисон байна шүү гэв.

- Хэрвээ энэ зургийн ойролцоо ямар нэгэн зураг байсан бол би таны энэ алдааг уучлахгүй байсан юм. Гүн та миний ээжийг танихгүй, энэ бол миний ээжийн зураг, зургаа ч билүү үү, найм ч билүү жилийн өмнө өөрөө хөөцөлдөж зуруулсан юм. Хувцсыг нь санаагаар зуруулсан байх, харин царай нь гайхам адилхан болсон. Би ээжийгээ мянга найман зуун гучаад оны үед байгаагий нь харж байгаа юм шиг санагдаж байна. Ээж аавыг эзгүй хоорондуур нь энэ зургийг захиалж хийлгэсэн юм. тэгээд түүнд санаандгүй сонин юм болгох гэсэн чинь яагаад ч юм аавын сэтгэлд таараагүй юм. тэр ч байтугай зураачийн уран чадвар нь ч дургүй байдлыг нь нугалж чадаагүй юм. энэ бол Леополд Роберын хамгийн шилдэг бүтээлүүдийн нэг байхгүй юу. үнэндээ энүүхэндээ л гэж ярихад эрхэм де Морсер бол Люксембургийн ордонд хуралддаг тайж нарын дотроос хамгийн хартай нь бөгөөд цэргийн хэргийг сайн мэддэг боловч, урлагт тун ч тааруу хүн шүү дээ. Харин ээж минь уран зураг ойлгодог, өөрөө ч сайхан зурдаг хүн. Ээж энэ зургийн уран чадварыг дэндүү үнэлдэг болохоор, бүр алга болгохын оронд аавын нүдэнд цөөн харагдаж байг гээд надад бэлэглэчихсэн юм. Грогийн зурсан түүний хөргийг бас танд үзүүлье. Гэр зуурын үл ялих юм ярьж байгааг минь уучлаарай. Би таныг гүнтэй танилцуулах болохоор, санаанд оролгүйгээр ээжийн зургийг магтчих бий гэж бодоод хэлж байгаа юм. Тэгээд ч бас энэ яриа ээжид их муу нөлөө үзүүлдэг юм. Ээж над дээр ирж энэ зургаа харахаар нүднийхээ нулимсыг гаргалгүй байж чаддаггүй юм. Ээж аав хоёр ганцхан удаа л энэ зурагнаас болж ам мурийлцсан юм. Тэр хоёр суугаад хорь гаруй жил болж байгаа боловч сая л суусан юм шиг бие биедээ сайн байдаг. Монте-Кристо ярьж

байгаагийн цаад учрыг мэдэх гэсэн мэт Альбер өөд хяламхийн харсан боловч залуу хүү үнэн сэтгэлээсээ ярьж байгаа нь илэрхий байлаа.

- Гүн та миний бүх л нандин зүйлийг үзлээ. Та энд гэртээ юм шиг бай. Таныг манайд улам дасгахын тул ноён де Морсертай уулзуулъя. Би бүр Ромд байхдаа таны үзүүлсэн ач тус, мөн таныг манайд ирнэ гэсэн тухай захидал бичсэн юм. Эцэг эх хоёр танд баяр талархлаа илэрхийлэх завшааныг хүлээн ядаж байгаа. Гүн та их юм үзэж нүд тайлсан хүн болохоор гэр бүлийн тэр талархал Синдбад далайчны сэтгэлийг хөдөлгөхгүй байх. Та бол өчнөөн их юм үзсэн хүн шүү дээ. Та миний хүслийг хүлээн авч, үүнийгээ Парисын амьдралд орж байгаа нь энэ гэж үзээрэй. Эндхийн амьдрал бол бүхэлдээ л бие биедээ найрсаг талархал илэрхийлэх, бие биеийгээ урих, очихоор л бүрддэг юм.

Монте-Кристо гүн үг дуугаралгүй мэхийн ёслов. Тэр бодвол энэ саналыг боловсон хүн заавал гүйцэтгэвэл зохих дээдсийн заншил болсон зүйл гэж үзэж баярласан ч үгүй, тээршаасан ч үгүй хүлээн авав бололтой. Альбер, хиагаа дуудаж Монте-Кристо гүн, гүн Морсер дээр орохыг хүсэж байна хэмээн айлтга гээд явуулав.

Альбер гүн хоёр хиагийн араас явав.

Гүнгийн үүдний өрөөнд орж ирэхэд бусад тасалгаануудын засал чимэгтэй ихэд тохирсон баялаг сайхан хийцтэй сүлд, зочдын өрөөний үүдэн дээр байгааг нь үзвэл, энэ гэрийн эзэн үүнийгээ хичнээн их үнэлж үздэгийг харуулна.

Монте-Кристо хаалганы өмнө зогсож түүнийг анхааралтай гэгч нь харав.

- Тунгалаг хөх суурин дээр, цувсан долоон шувуу байх чинь, бодвол танай удмын сүлд мөн биз, бэйс? Гэж гүн асуугаад,- Зөвхөн сүлдний дүрсүүдийг л мэддэгийг минь тооцохгүй бол би энэ сүлдний талаар муу мэддэг хүн шүү. Би чинь гэгээн Стефаны бүлэглэлийг байгуулсны төлөө Тосканаас авсан тохиолдлын гүн юм шүү дээ. Жуулчлан явдаг хүнд заавал хэрэгтэй байдаг гэж амьтан хүн ятгаагүй бол би ч энэ хэргэмийг авахгүй байсан юм. Дор хаяад гаалийн түшмэл шалган үзэхгүй байхын тулд ч билээ сүйх тэрэгнийхээ хаалган дээр ямар нэгэн юмтай байх хэрэгтэй. Ийм учраас ингэж асуусныг минь уулаарай гэхэд Морсер бүрэн итгэсэн хүний жирийн байдлаар,

- Энэ асуултад тийм даруу биш юм алга байна шүү дээ. Та таасан байна. Энэ бол манай сүлд, өөрөөр хэлбэл манай удмын сүлд. Гэхдээ өөр сүлдтэй ч холбоотой. Энэ улаан суурин дээр байгаа мөнгөн цамхаг бол манай ээжийн удмын сүлд. Би бол эхийн талаас испани хүн гэхдээ Морсеруудын удам бол өмнөд Францын эртний удмын улс байсан юм гэж хариулав.

- Тийм байна гэж Монте-Кристо хэлээд – шувуунууд үүнийг харуулж байна. Гэгээн газрыг байлдан эзлэх гэж явсан мөргөлчид өөрсдийн сүлд болгож загалмай, эсвэл өөрсдийн туулах холын аяны тэмдэг болгож нүүдлийн шувууны дүрийг авдаг байлаа Танай эцгийн талын өвөг дээдэс загалмайтын талын довтолгооны аль нэгэнд оролцож байж л дээ. Хэрвээ энэ довтолгоо Гэгээн Людовикийн довтолгоо байлаа ч гэсэн арван гуравдугаар зууны үед хүрч очно. Энэ ч муу хэрэг биш ээ гэв.

- Тун болох хэрэг. Миний эцгийн тасалгаанд манай удам угсааны тэмдэглэл бий, энэ л бидэнд бүгдийг тайлбарлаж өгдөг юм. Би дээхнэ үед эдгээрт д” Озые ба Жокур нар ч өөрсдөдөө хэрэгтэй юмаа авч болохоор тодорхойлолт гаргасан юм. Одоо ийм юм хийхээ больчихсон, гэхдээ тайлбарлагчийн хувиар манай арчилсан засгийн үед ийм зүйлүүдийг хүчтэй сонирхох болсон гэдгийг хэлчихье.

-Тийм бол танай засгийн газар өнгөрсөн үедээ, таны юман дотор миний харсан, ямар ч сүлд тэмдгийн утгагүй, өлгөөснөөсөө өөр илүү сайн юм

сонгож авах ёстой байж дээ. Таны тухайд гэвэл, танай сүлд сэтгэлийг баясгасан юм бодогдуулах учир та засгийнхаа газраас илүү аз жаргалтай юм. Тэгээд ч та Провансал ч хүн, Испани ч хүн. Хэрвээ таны үзүүлсэн зураг адил болсон бол миний гайхшийг түрүүлсэн буянт каталан хүүхний сайхан бор царай үүгээр тайлбарлагдах нь байна.

Гүнгийн энэ их л ёсорхоогоор хэлсэн үгэнд нуугдан байгаа ёгт санааг тааварлан мэдэхэд Эдип ч юм уу эсвэл бүр ховдос ч байх хэрэгтэй байжээ. Тэгээд Морсер түүн өөд талархан инээмсэглээд, зам зааж өгөхөөр түрүүхэн алхаж зочдын өрөө уруу орсон сүлдтэй хаалгыг нээж өгөв:

Зочдын өрөөний хамгийн түрүүнд нүд тусах газарт, генерал хувцастай, өндөр цолны нь тэмдэг болсон мушгимал ёслолын погонтой. Хүндэт легионы хэрээс одон хүзүүндээ зүүсэн нь дээд тушаалыг нь харуулсан, гучин тав, гучин найм орчмын эрэгтэй хүний хөрөг өлгөжээ. Энгэртээ зүүсэн одонгуудын баруун талд нь Авран гэтэлгэгчийн одон, зүүн талд нь Ш Карлын одон зүүсэн байхыг нь харвал энэ хөрөг дээрх хүн Грег Испанид онц гарамгай тулалдсан буюу ямар нэгэн дипломат үүргийг гүйцэтгэсэн болох нь илэрхий ажээ.

Монте-Кристо түрүүчийн хөргийг үзсэний адил маш анхааралтай харж байтал хажуу талын үүд нээгдэж гүн өөрөө гарч ирэв. Энэ хүн дөчин тав орчим насны боловч харахад хамгийн багадаа л тавин настай гэмээр ажээ. Түүний хар сахал хар хөмсөг нь цэрэг янзаар зассан бараг цагаан шахам үстэй нь харшлан эвгүй харагдана. Энгийн хувцастай ч энгэр дээрх өнгө өнгийн тууз нь олон олон тэмдгээр шагнагдсан байсныг гэрчлэх ажээ. Тэрээр нэлээд буянтай хүний төлөвтэй бөгөөд их л баяртай царайтай орж ирэв. Монте-Кристо түүн өөд нэг ч алхам дөхсөнгүй, газартай наалдчихсан мэт яг дороо зогсон, Морсер гүнгийн царай өөд ширтэн

- Аав минь, миний аз болж хүнд хэцүү цагт тохиолдсон сайн санаат найзыгаа танд танилцуулахыг зөвшөөрнө үү гэж Альбер хэлэхэд, Морсер гүн инээмсэглэн Монте-Кристо гүнд баяр хүргэж,

- Гүн бол манай хүсэн хүлээж байсан зочин мөн. Та манай удам угсааг маань залгамжлагч ганц хүнийг нь хамгаалан хадгалж өгсөн, бид танд үүрд баярлан талархаж явах болно гэж хэлэв. Морсер гүн ингэж хэлээд Монте-Кристо гүнд сандал заан, өөрөө цонхны өөдөөс харж суув. Монте-Кристо сандал дээр нь суугаад, хилэн хөшигний сүүдэрт үлдэж, гүнгий цагаасаа урьд үрчийсэн нүүрний үрчлээс бүрд нууцлагдан шингэсэн зовлон зүдгүүрийн түүхийг сэм ажиглах гэж бодлоо.

- Хатан маань хүн ирж хэлэхэд хувцсаа өмсөж байсан, одоо арваадхан минут болоод орж ирнэ гэж Морсер хэлэв.

- Парист ирсэн өдрөө алдар гавьяа нь жигд хийсэн юмтай нь адил, хувь заяатай ийм хүнтэй танилцсан минь их нэр төрийн хэрэг болж байна. Митижийн тал ч юм уу, Атласын ууланд таныг маршал цол хүлээж байж болох юм гэж Монте-Кристо хэлэхэд, Морсер үл мэдэг царай нь улайн,

- Өө үгүй, би цэргийн алба хаахаа больчихсон. Би дахин сэргэлтийн үед тайжийн зэрэгт хүрээд, анхны довтолгоонуудад оролцож, мршал де Бурманы удирдлаган доор явж байсан. Би дараа нь командлалын өндөр тушаал олж болох байсан боловч хөгшин цэрэг хуучнаараа үлдсэн байсан бол юу болох байсныг хэн мэдэх вэ. Долдугаар сарын хувьсгал маш ширүүн болж эзэн хааны үед хамаарагдахгүй цол хэргэмийг тоохгүй байж ч мэдэхээр болсон юм. Иймээс би халагдах өргөдөл өгөх ёстой болсон бөгөөд, над шиг тулааны талбар дээр цол тушаал олж авсан хүн, зочдын өрөөний гялгар шалан дээр учраа олж гишгэж чадахгүй юм байна. Би цэргийн албыг орхиж, улс төрийн бодлого, үйлдвэр хавсрах урлагаар оролдох болсон. Би эдгээр зүйлүүдийг дандаа сонирхож явсан боловч, хориод жио цэргийн алба хааж байхдаа оролдох зав байхгүй байсан гэж хэлэв.

- Танай угсаа бусад угсаа язгуураас илүүтэй байдгийн учир энд байдаг юм байна. Та нэр алдартай удмын хүн, их хөрөнгийн эзэн, анхныхаа цол хэргэмийг авахдаа жирийн цэргээс эхэлсэн, ийм явдал цөөн тохиолддог л доо. Та генерал болж, францын тайж болоод, Хүндэт легионы одон шагнуулсан атлаа хэргэм шагналын төлөө биш, зөвхөн өөрийн ойр дотны хүмүүст тус болохын тулд ямар нэг шинэ юм сурч эхэлж байна. Энэ тун ч сайхан хэрэг. бүр гайхам сайхан юм гэв.

Монте-Кристо гүнгээс ийм талархлын үг гарч байхыг огт дуулаагүй Альбер гайхан харж чагнан суув.

- Италид бид л тийм байдаггүй нь харамсалтай гээд харь газрын хүн Морсерын царай дээр гарч ирсэн үл мэдэг сүүдрийг арилгахын тулд, - Бид өөрсдөө л заяагдсанаар өсөж торнидог юм. тэгээд бүх л амьралынхаа турш тэр навч, тэр хэлбэр дүрс, тэр үр ашиггүй байдлаа хадгалж үлдэнэ дээ гэхэд Морсер гүн татгалзан,

- Тан шиг ийм хүнд Итали тохирох орон биш. Франц өврөө дэлгэн таныг угтаж байна. та үүнд нь хариулаач дээ. франц бол дандаа ч тийм хариу талархалгүй байдаг орон биш шүү. Өөрийн хүүхдүүдтэй хатуу ширүүн харьцах боловч, харь орны хүмүүсийн олонхийг баяртайгаар хүлээн авдаг юм.

- Аав та харваас Монте-Кристо гүнг мэдэхгүй байна. энэ хүнийг зугаацуулж, сэтгэлийг нь хангах юм манай ертөнцөөс гадуур байгаа. Нэр хүндийн хойноос хөөцөлддөггүй, түүнээс зөвхөн л паспорт дээр байх тэрхэн зүйлийг л авдаг юм гэж Альбер инээмсэглэн хэлэхэд,

- Миний тухай хэлж байсан үгний дотроос, хамгийн үнэн үг энэ байна гэж Монте-Кристо хэлэв.

- Гүн амьдралаа зохиох боломжтой байгаад цэцэг навч дэлгэрсэн зам шилж сонгон авчээ гэж Морсер гүн санаа алдан хэлэхэд, Монте-Кристо гү нэг ч уран зураач дүрслэн зурж, нэг ч хүн дүрслэн тодорхойлж чадахгүйгээр инээмсэглэн,

- Яг тийм шүү гэж хариулав.

- Би таныг ядраачих байх гэж айгаагүйсэн бол таныг Танхимд дагуулж аваачих сан. Манай орчин үеийн сенатч нарыг мэдэхгүй хүнд өнөөдрийн хуралдаан их л сонирхолтой болно доо гэж үгэнд баярласан генерал хэлэв.

- Хэрвээ та үүнийг өөр нэгэн удаа хэлбэл би маш их баярлах байна аа, харин одоо хатантайгаа танилцахыг хүлээж, хүлээж байна.

- Өө, ээж ирлээ! Гэж бэйс дуу алдав.

Монте-Кристо ч яаран эргэж зочдын өрөөний босгон дээр зогсож байгаа Морсер хатагтайг харав. Хатагтай нөхрийнхөө орж ирсэн хаалганы эсрэг талын үүдэн дээр цонхигор царайлан хөдлөлгүй зогсоно. Монте-Кристо түүн рүү эргэж харахад хаалганы алтадсан бариулаас барьж байсан гараа яагаад ч юм доош буулгав. Хатан тэнд хэдэн секунд зогсож, зочны хэлсэн үгний сүүлийг сонсжээ.

Гүн босож хатанд доор гэгч мэхийн ёслоход цаадах нь их л ёсорхоогоор хариу мэхийв.

- Хатантан та яагаа вэ? Бие чинь муу байна уу? Аль эсвэл дэндүү халуун байна уу? гэж Морсер гүн асуухад бэйс Мерседес өөд ухасхий очоод,

- Ээжээ, таны бие эвгүй байна уу? гэж асуув.

Хатантан хариуд нь инээвхийлэн,

- Үгүй, зүгээр л гүнтэй уулзахад сэтгэл минь хөдөлжээ. Хэрвээ энэ хүн байгаагүйсэн бол бид уйтгар гунигт автсан байх байлаа гэснээ гүн үрүү хатан хааны сүрлэг байдлаар ойртон ирээд,

- Хүүгийн минь амийг аварсан танд ачийг тань хариулах ёстой. Би үүнийгээ танд чин зүрхнээсээ ерөөж байна. би танд баярласнаа нүүрээр учран хэлсэндээ их баяртай байна гэж хатагтай хэлэв.

Гүн дахин түрүүнийхээсээ дор гэгч мэхийн ёслоход царай нь Мерседесийнхээс цонхигор харагдав.

- Та дэндүү их сайхан сэтгэлтэй хүн юм гэж ер бишийн зөөлөн, хүндэтгэлтэй хэлээд – Би ямар ч ер бишийн юм хийгээгүй. Хүний амь аврах, эцгийг нь зовлонгоос, эхийг нь нулимаснаас зайлуулах гэдэг бол тийм сүрхий хэрэг биш, зүгээр л хүний үүрэг шүү дээ гэв.

- гүн тан шийг ийм сайхан нөхөртэй байна гэдэг миний хүү аз завшаантай хүн юм гэж Морсер авхай гүн хүндэтгэлтэй хэлээд 2 Тэгж заяасан бурханд би баярлаж байна гэж хэлэв.

Тэгээд Мерседес хязгааргүй их баярласан сайхан нүдээрээ өөдөө харахад нүдэнд нь нулимс гүйлгэнэх шиг гүнд санагджээ.

Ноён Морсер эхнэр рүүгээ дөхөж очоод,

- Би гүнг орхих болсондоо уучлал гуйчихсан. Та бас намайг уучлахыг түүнээс гуйна гэдэгт найдаж байна. хурал хоёр цагт эхлэх ёстой, одоо гурав болж байна. би үг хэлэх хэрэгтэй хүн гэлээ.

- Таныг эзгүй хооронд зочноо уйдуулахгүй байхыг би хичээе гэж хатагтай сэтгэл догдолсон байгаа хэвээр хэлээд, - Гүн та өнөөдөр манайд өнжихгүй юу гэж Монте-Кристо өөд хэлэв.

- Би танд их баярлалаа хатагтай, гэвч би дөнгөж танай үүдэн дээр замын сүйх тэрэгнээс бууж ирсэн. Намайг Парист яаж төвхнүүлснийг мэдэхгүй, хаана байр зассаныг л муухан мэднэ. Энэ үл ялих хэрэг боловч би бага зэрэг сэтгэл зовоод байна.

- Тэгвэл та өөр өдөр ирж гийгүүлнэ гэдгээ амлах уу? гэж хатагтай асуув.

- монте-Кристо үг дуугаралгүй мэхийн ёсолсон нь зөвшөөрсний тэмдэг болов.

- Тэгвэл би таныг энд барихаа больё. Баяр талархлаа илэрхийлсэн минь эв зүйгүй шалж нэхсэн зүй» болохыг хүсэхгүй байна гэж хатагтай хэлэв.

- Хүндэт гүн минь, Ромд байхдаа үзүүлсэн ачийг чинь Парист хариулахыг хичээе. Та одоохондоо унаа уналгатай болж чадаагүй бол миний сүйх тэргийг хэрэглэж байхгүй юу гэж Альбер өгүүлэхэд, Монте-Кристо,

- Бэйс, маш их баярлалаа. Бодвол Бертуччо энд байсан дөрвөн цаг хагасын хугацааг дэмий өнгөрөөгөөгүй байх, танай үүдэнд сүйх тэрэг хүлээж байгаа байх гэж найдаж байна.

Гүн дандаа л Нерон шиг бололцоогүй юмны хойноос хөөцөлдөж байдгийг Альбер мэдэх учир огт гайхсангүй. Тэгээд гүнгийн тушаал хэрхэн биелэгдсэнийг нүдээрээ үзэх гэж түүнийг үүд хүртэл гаргаж өгөв.

Монте-Кристо андуурсангүй. Түүнийг Морсер гүнгийн үүдний өрөөнд гарч ирэхэд Ромд байхад гүнгийн нэрийн хуудсыг Альбер Франц хоёрт аваачиж өгсөн зарц ухасхийн гүйж, алдарт аянчинг шатан дээр гарч ирэхэд, үнэхээр нэгэн сүйх хүлээж байлаа. Энэ бол Келлерийн хийсэн хоёр хүний суудалтай сүйх тэрэг бөгөөд урьд нь Дрей, парисын ямбатан ихсийн мэдэж байсан, арван найман мянган франкаар өгөхийг татгалзаж байсан хос морь хөллөөтэй байлаа.

- Бэйс, би өнөөдөр таныг урихгүй. Намайг түр байрлах газраа ч гэсэн тохилог байхыг хүсдэг гэдгийг та мэднэ шүү дээ. тэгэхээр өнөөдөр хамаг юмыг хам хум бэлдсэн тохь муутай байгаа байх. Тэгэхээр надад нэг хоногийн хугацаа өгөөд дараа нь таныг урихыг зөвшөөрнө үү. Тэгвэл би зочилон хүндэтгэх ёсыг зөрчихгүй байж чадна гэдэгтээ бүрэн итгэлтэй байх болно гэж гүн Альберт хэлэв.

- Хэрэв та нэг өдрийн хугацаа гуйж байгаа бол зүгээр нэг байшин биш, харин ордон үзүүлнэ гэдэгт итгэлтэй байна. танд ямар нэгэн сайн санаат сүнс туслаад байдаг байх.

- За яах вэ, тэгж бодож л бай гэж гүн хариулаад, үзэмжит сайхан сүйх тэрэгний хилэн бүрээстэй гишгүүр дээр хөлөө тавьж, -Энэ минь авгайчуудад амжилт олоход тус болно гэж хэлэв.

Гүнг сүйх тэргэнд суухад үүд нь хаагдан морьд давхилдан одсон боловч, тэрээр Морсер хатагтайн хоцорсон зочны өрөөний цонхыг үл мэдэг хөдлөхийг ажигла амжив. Альберыг буцан орж ирэхэд ээж нь хүн хүлээн авдаг жижиг өрөөндөө зөөлөн сандалд шигдэн сууж байв. Тасалгаан дотор бүдэг гэрэлтэй бөгөөд ваар сав, алтадсан жаазны ирмэг булан гялалзахаас өөр хурц тод юмгүй байв.

Гүнгийн хатан сийргэр нимгэн алчуур толгой дээрээ сэжүүрий нь унжуулан тавьсан учир Альбер түүний царайг сайн харж чадсангүй. Гэхдээ хоолой нь чичирч байх шиг санагджээ. Тэнд тавьсан анхилуун сарнай, башир цэцэгний үнэртэй хамт үнэрлэх давсны хурц үнэр холилдон үнэртэнэ. Хатагтай жижиг шилээ сарьсан уутнаас нь гарган задгай зуухан дээр байгаа хавтгай зуухан дээр тавьсан байхыг Альбер сэтгэл зовон харлаа. Тэгээд эхдээ ойртон,

- Таны бие муу байна уу? Намайг байхгүй хоорондуур би? чинь туудав уу? гэж сэтгэл зовон асуув.

- Үгүй дээ Альбер минь, дулаараад ирэхээр энэ сарнай, алтан жүрж цэцгүүдийн үнэр их үнэртэх юм...

Тэгэхээ Альбер хонхны оосрыг татаж,

-Тэгвэл энэ цэцгүүдийг гаргах хэрэгтэй. Таны бие үнэхээр муу байх шиг байна шүү. Та түрүүн зочды өрөөнд орж ирэхдээ л их цонхигор царайтай байсан шүү гэж хэлэв.

-Их цонхигор байсан гэнэ ээ?

- Танд зохиж байсан боловч аав бид хоёр айсан шүү.

- Аав чинь чамд тэгж хэлэв үү? Гэж Мерседес яаран асуув.

-Үгүй танд өөрт чинь хэлсэн шүү дээ, санаж байна уу?

-Үгүй, санахгүй байна гэж тэр хэлэв.

Альберын дуудсанаар зарц орж ирэв.

-Энэ цэцгүүдийг үүдний өрөөнд гаргаач, хатагтайд эвгүй оргиод байна гэж бэйс хэлэхэд зарц түүнийг ёсоор болгов.

Зарцыг цэцэг гаргаж байхад дуугүй сууж байгаад сүүлийн цэцгийг гаргахад хатан,

- Монте-Кристо гэдэг чинь юуны нэр вэ? Овог юм уу эсвэл газрын нэр үү, эсвэл цол хэргэм үү? гэж асуухад,

- Зөвхөн л хэргэм байх гэж би санаж байна. энэ гүн Тосканы олтригоос нэгэн арал худалдан авч, өнөө өглөөний нь ярьж буйгаар нэг бүлэглэлийн зөвлөл байгуулж өгсөн бололтой. Флоренцийн гэгээн Стефан, Пармын хутагт Георгийн ба Мальтийн загалмай зэрэг бүлэглэлд ийм зөвлөл байдгийг та мэднэ биз дээ. түүнээс гадна өөрийгөө язгууртан гаралтай гэж сайрхдаггүй, би бол санамсаргүй тохиолдлын гүн байгаа юм гэж ярьдаг хүн. Ромд түүнийг алдар хүндтэй язгууртан гэлцэх юм билээ.

- Байж байгаа байдал яриа хөөрөө нь их сайхан хүн. Гүн үнэхээр байгаа байдал шигээ л тийм хүн гэж санагдлаа гэж хатагтай хэлэв.

-Өө тэр ч бүр өөлөх юмгүй л дээ. европын хамгийн бардам гурван язгууртан болох англи, испани, герман чиний л харсан ихэс дээдсээс хамаагүй хол давсан хүн билээ.

Хатан бодлогошрон байснаа бага зэрэг эргэлзсэн байдалтай үргэлжлүүлэн,

-Хайрт хүү минь чи харсан шүү дээ... Би эхийн хувьд чамаас асууж байгааг ойлгож байгаа биз... Чи Монте-Кристо гэртээ байхад нь харсан шүү дээ. чи өөрийнхөө наснаас хэтэрсэн хянамгай гярхай хүн. Гүн үнэхээр байгаа байдал шигээ л тийм хүн гэж бодож байна уу?

-Ямар байдал шигээ гэж?

-Чи сая хэлсэн шүү дээ. алдар хүндтэй язгууртан гэж.

- Түүний тухай хүмүүс тэгж боддог.

- Аа, чи юу гэж бодож байна вэ?

- Би үнэндээ хэлэхэд түүний тухай тодорхой дүгнэлт хийгээгүй. Гэхдээ түүнийг малт үндэстний хүн гэж бодож байна.

- Би түүний гарал үүслийн тухай асуугаагүй. Ямар хүн болох тухай нь л асууж байна.

- Өө энэ бол өөр хэрэг. би түүний зүгээс хачин сонин зүйл гарахыг нь харж байсан. Өвөг дээдсийнхээ өвийг авч чадалгүй алдаад, эцэс нь өөрийн суу ухааныхаа ачаар дахин олж авсан эрт дээр үеийн удмын нэгэн удам угсаа, Манфред, Лара, Вернер шиг гай зовлонгийн тамгаар тамгалуулсан, байроны баатар шиг л санагдах юм.

- Чи тэгээд...

- Монте-Кристо бол газрын дундад тэнгис шиг хүн амьтан цэрэг цагдаагүй хил сэм давуулан наймаалагчид, орон бүхний дээрэмчдийн орогнох газар болсон арал байгаа юм. энэ эрхэм хүмүүс өөрийн зочломтгой эзэнд ачийг нь хариулж, төлбөр төлдөг байж ч болох юм.

- Тийм ч байж магадгүй гэж хатагтаа© бодлогшрон хэлэв.

- Монте-Кристо хил давуулан наймаалцъя биш ч бай, мөн ч бай ер нь л гайхалтай сайн хүн. Та өөрөө харсан үүнийг зөвшөөрөх байх гэж бодож байна. тэр хүн Парисын зочдын өрөөдөд их л амжилт олно доо. Өнөө өглөө ирээд л дээдсийн хүрээлэнд эхлэн орж, түүгээрээ Шато-Реног хүртэл гайхууллаа шүү дээ гэж Албер хэлэв.

- Тэр хүн хэдэн настай бол? гэж Мерседес энэ асуултыг их л чухалчилж буй бололтой асуув.

- Гучин тав, зургаа орчим байх аа.

- Тийм залуу гэж үү! Үгүй байх аа! Гэж Мерседес хариулахын хамт өөрийнхөө бодолд хариулан хэлэв.

- Үгүй, тийм байх. Тэр надад хэдэн удаа мэдээж юм бодож саналгүйгээр “Тэгэхэд би таван настай байсан, тэгэхэд би арван настай байсан, тэгэхэд арван хоёр настай байсан” гэж ярьсан юм. сонирхон харьцуулж үзэхэд цөм л тохироод байх юм. насыг нь тодорхойлж болохгүй энэ хүн үнэндээ гучин тавтай. Та түүний галтай нд, хар үсийг нь санаж байна уу. түүний царай хэтэрхий цагаан боловч, духанд нь нэг ч үрчлээс байхгүй. Тэр хүн чадалтайн гадна залуу байгаа хүн.

Хатагтай гашуун бодолд автсан мэт толгойгоо доош унжуулав.

- Тэгээд энэ хүн чамтай найзархаг харьцаж байна уу, Альбер? гэж авгай сэтгэл хөдлөн асуув.

-Надад тийм шиг л санагдаж байна.

- Аа, чи түүнд хайртай юу?

-Франц де Эпине түүнийг нөгөө ертөнцөөс ирсэн хүн гэж хэлдэг боловч надад аятайхан хүн санагддаг гэхэд хатагтай давхийн цочив.

Морсер авгайн дуу өөр болж,

- Би чамайг шинэ танилтай болох бүрд чинь болгоомжилж байхыг захидаг. Одоо бол чи том болж, харин ч надад зөвлөгөө өгөх болсон. Гэвч болгоомжтой байгаарай гэж дахин захъя гэв.

- Таны зөвлөгөө надад тус болохын тулд би юунаас эхлэхээ мэдэх хэрэгтэй байна. гүн хөзөр тоглодоггүй, зөвхөн испани дарсаар өнгийг нь хувиргасан ус уудаг. Тэр тийм их баян учир надаас мөнгөө зээлье гэвэл би өөдөөс нь харж инээхээс өөр юмгүй. Би тэгээд юунаас болгоомжлох ёстой болж байна?

- Хүү минь, амийг чинь аварсан хүний тухай ярьж байгаа болохоор миний ингэж болгоомжлоод байдаг дэмий хэрэг юм. аа харин эцэг чинь үүнийг яаж хүлээж авах вэ? Бид гүнд анхааралтай байх хэрэгтэй байна. эцэг чинь зав муутай, элдвийн ажил явдлаар оролдож яваад санаандгүй... гэхэд Альбер яриагийн нь тасалж,

-Тэр өөлөхийн аргагүй байсан. Гүн түүнийг гучин жилийн өмнөөс таньдаг байсан юм шиг тийм амжилттайгаар манж үг хэлсэн учир аавын сэтгэлд ихэд таалагдсан. Тэр бүх найрсаг үг нь аавд аятайхан байсан болохоор гээд Альбер инээж, - аав бүр хэлэх үгээ сонгог гэж гүнг танхимд очихыг урьсан, тэр хоёр их л найзархагаар салсан шүү гэв.

Гүн авгай юу ч хэлсэнгүй. Гүнзгий бодолд автан бор нүдээ ч анив. Эхийгээ залуу сайхан байхад нь хүү нь хайрладаг хайраар Альбер хайрдан эхийгээ харж зогсов. Хатагтай нүдэс анихыг хараад жигд амьсгалах амьсгааг нь чагнан унтаад өглөө гэж хүү бодон хүү өлмий дээрээ аяархан гарч хаалга хаав. Тэгээд тэглгойгоо сэгсрэн,

-Энэ бол хүн биш, чөтгөр юм. би бүр Ромд байхдаа энэ хүн их шуугиан дэгдээнэ дээ гэж хэлж байсан. Одоо түүний нөлөө хир болох нь мэдэгдэж байна. ээж анхаарч үзсэн л болохоор энэ хүн яах аргагүй гайхамшигтай хүн юм гэж аман дотроо шивнэв.

Тэгээд гүнг, хуруугаа ч хөдөлгөлгүй байж байгаад морь таньдаг хүмүүсийн ярьдгаар өөрийнх нь морьд хоёрдугаар зэрэгт хаягдах тийм сайхан морьд олоод авчихсанд дотроо атаархан морьдынхоо хашаанд оров.

- Хүмүүс адил тэгш байна гэж байдаггүй юм байна. энэ санааг дээд Танхимд дэлгэрэнгүй ярь гэж ааваас хүсэх юм байна гэж дотроо бодов.

iv. Эрхэм Бертучо

Тэр завсар гүн гэртээ хүрч ирэв. Замдаа зургаан минут л явжээ. Энэ зургаан минут нь сүйхэнд хөллөсөн хос морийг худалдан авах чадалгүй боловч үнийг нь мэдэх хориод залуу хүн харж амжихад хүрэлцэхүйц хугацаа байв. Тэд саях хоёр морийг тус бүрийг нь арван мянган франкаар авсан баян язгууртанг халти боловч харахыг хүсэж мориндоо ташуур өгөн ухасхийнэ.

Монте-Кристогийн хотын гэрт зориулан Алийн сонгож авсан байшин уул уруу явбал Елисейн талын баруун талд, хашаа цэцэрлэг хоёрын хооронд байлаа.хашааны дунд ургасан хэсэг өтгөн мод байшингийн нүүрэн талын хагасыг халхална. Энэ хэсэг модны баруун зүүн талаар хоёр гар адил таримал модот гудамж гарч, хоёр шат уруу очсон бөгөөд шатны гишгүүр бүрийн өнцөг дээр шаазан ваар дүүрэн цэцэг тавьсан байв. Энэ байшин өргөн зай дотор ганцаархнаа сүндэрлэх бөгөөд гол хаалганаас нь гадна Понтые гудамж өөд нэг хаалга байлаа.

Хөтөч хаалга онгойлгохоор манаачийг дуудахаас өмнө хүнд хаалга нээгдэв. Гүнг ирж явахыг холоос харжээ. Парист мөн л Ромын адил ер нь хаана ч гэсэн гүнд цахилгаан мэт түргэн үйлчилнэ. Хөтөч мориныхоо амыг таталгүйгээр хашаан дотор давхин орж, хагас тойрог хийн зогсоход элсэн дээрх тэргэний дугуйн чимээ намдахаас өмнө хаалга хаагдав.

Сүйх тэрэг үүдний шатны зүүн талд ирж зогсоход, шатан дээр хоёр хүн гарч ирлээ. Тэр хоёрын нэг нь Али бөгөөд ноён өөдөө үнэн сэтгэлээсээ инээмсэглэн зогсож байлаа. Хоёр дахь хүн нь гүнг сүйх тэрэгнээс гаргахад нь туслах гэсэн

боллолтой гараа сунгаж, хүндэтгэн ёслол. Тэгэхэд гүн тэрэгний гурав дахь гишгүүр дээрээс ихэд хөнгөн үсрэн бууж,

- Бертуччо, танд баярлалаа. Аа, Нотариус хаана байна? гэж хэлэхэд,

- Гэгээн эзэн минь, зочдын жижиг өрөөнд хүлээж байгаа гэж Бертуччо хариулав.

- Байшингийн дугаар мэдмэгц захих ёстой байсан нэрийн хуудсууд яасан бэ?

- Гэгээн эзэн минь, бэлэн байна. Пале-Роялийн шилдэг сийлбэрчдээр, очиж өөрөө харж байгаад хийлгэсэн.

- Таны тушааснаар хамгийн түрүүний хуудсыг Шоссе де Антен гудамжны хорин долдугаар байшинд суудаг депутат түшээ гүн Дангларт даруй хүргэж өгсөн. Бусад нь таны унтлагын өрөөний задгай зуухан дээр байгаа.

- Тийм бий. Одоо хэдэн цаг болж байна?

- Дөрвөн цаг болж байна.

Монте-Кристо бээлий, малгай, таягаа Морсер гүнгийхээс гарахад сүйх тэрэг дуудах гэж гүйсэн франц зарцад өгөөд, зам зааж яваа Бертуччо даган зочдын бага өрөөнд оров.

- Үүдний өрөөний энэ баримлууд ямар өөдгүй юмнууд вэ, эндээс зайлуулах юм байгаа биз дээ гэж Монте-Кристо хэлэхэд Бертуччо дуугүй бөхөсхийв

Хэрэг хөтлөгч даамлын хэлснээр нотариус зочдын жижиг өрөөнд хүлээж байлаа.

Энэ бол хотын захын нотариус болтлоо дэвшсэн, нийслэлийн албан хаагчийн төрх байдалтай хүн байлаа.

- Миний авах гэж байгаа хотын захын байшинг худалдах ажлыг гүйцэтгэ гэж танд тушаасан уу? гэж Монте-Кристо асуухад,

- Тийм ээ, эрхэмсэг гүн гэж нотариус хариулав.

- Баримт бичиг чинь бэлэн үү?

- Бэлэн, эрхэм гүн минь.

- Одоо танд байна уу?

- Энд байна.

- За сайн байна. миний авах гэж байгаа байшин хаана байгаа юм бэ? гэж гүн, Бертуччоогоос ч биш, нотариусаас ч биш асуулаа.

Даамал, мэдэхгүй гэдгээ дохиогоор мэдэгдэхэд нотариус гайхсан байдлаар гүн өөд харж,

- Юу? эрхэмсэг гүн авах гэж байгаа байшингаа хаана байдгийг нь мэдэхгүй гэж үү? Хэмээн асуухад,

- Үнэндээ мэдэхгүй байна гэж гүн хариулав.

-Гүн та үзээгүй юм уу?

- Би яаж үзэх вэ дээ? Би өнөө өглөө Кардиксаар ирсэн. Урьд нь Парист ирж байгаагүй, тэр ч байтугай францад анх удаа ирж байгаа минь энэ.

- Тэгвэл ч өөр хэрэг ээ. гүнгийн худалдан авах гэж байгаа байшин Отейлд байдаг юм гэж нотариум хэлэхэд, Бертуччо энэ үгийг сонсоод царай нь цайв.

- Аа, тэр Отейл чинь хаана байдаг юм бэ? гэж гүн асуухад нотариус,

- Энүүхэнд ойрхон. Пассын цаахан талд, Буллоны ой дотор, сайхан газар шүү гэж хариулав.

- Тийм ойрхон уу? гэжээ. Түүнийг чинь яаж хотын захын байшин гэдэг юм бэ? Бертуччо,

- Та юу болоод харуулын дэргэд байшин худалдаж авч байгаа юм бэ? гэж гүн хэлэхэд, Бертуччу тун адган хариу өгүүлж,

- Би юу! Өршөөж хайрлаарай! Гэгээн эзэн та намайг “хотын захад” байшин худалдаж ав гэж тушаагаагүй шүү дээ. гэгээн эзэн та санахгүйсэн болов уу? гэв.

-өө тийм, одоо саналаа. Би сонин дээр байсныг нь уншаад “Хотын захад” гэсэн үгэнд хууртаад авах болсон юм байна гэж гүн хэлэхэд, Бертуччо сэргэж, яаран:
- Одоо ч оройтоогүй байна. хэрвээ гэгээн эзэнтэй та хүсвэл Анген, Фонтенэ Ро, эсвэл Бельвюд илүү аятайхан байшин эрж олъё гэж хэлэв.

- Ер нь энэ их чухал юм биш ээ, нэгэнт л ийм байшин байгаа хойно үүнийг л авъя гэж гүн хайнгадуу татгалзан хэлэхэд, шагналгүй хоцрохоосоо айж байсан нотариус түүний үгийг шүүрэн авч,

- Гэгээн эзэн таны зөв. Энэ бол их сайхан эдлэн байшин шүү. Өтгөн төгөл дундуур нь урсгал устай, аль хэдийнээс хүн суугаагүй боловч тохилог, байшин төхөөрөм хэрэглэл нь шинэ биш боловч хуучныг нь хэрэглэх дуртай болсон энэ үед зэгсэн үнэтэй эд байгаа юм. Уучлаарай намайг гэгээн эзэн та ч бас л одоогийн хүмүүсийн дурлаж сонирхдогийг дурлаж сонирхдог биз.

- Ярь ярь, битгий зов гэж гүн хэлээд, - Энэ чинь тийм аятайхан байшин юм уу? гэж асуув.

-Гүн минь, тэр байшин аятайхнаар барахгүй туйлын сайхан байшин даа.

- За тэгвэл тийм сайхан юмыг алдаад яах вэ, эрхэм нотариус тэр баримт бичгээ аваад ир гэж хэлэв.

Тэгээд худалдан авсан бичиг дээрээр байшингийн байгаа газар эздийнх нь нэр бүхий хэсгийг хялавхийн хараад гарын үсэг зурав.

- Бертуччо, эрхэм нотариуст тавин таван мянган франк авчирч өг гэж хэлэв.

Хэрэг хөтлөгч даамал салтирганан алхаж гараад, боодолтой мөнгө барин эргэж ирэв. Нотариус өөрийн шагнал хамт байгааг мэдэх хүний ёсоор тэдгээрийг нарийвчлан тоолов.

- Одоо чи бүх ёсыг гүйцэтгэсэн биз? гэж гүн асуув.

- бүгдийг гүйцэтгэсэн.

- Түлхүүр нь танд байна уу?

- Байшинг нь сахиж байгаа хүнд бий.

- Энэ тушаалыг аваад очиход байшинг чинь онгойлгож өгнө.

- За тэгвэл сайн хэрэг. тэгээд гүн нотариус өөд харж “Та одоо хэрэггүй, явж болно” гэсэн байдалтай толгой дохив. Тэгэхэд үнэнч нотариус зүрх гаргаж,

- Эрхэмсэг гүн та андуурсан бололтой санагдаж байна. надад бүх л суутгалуудыг нь аваад зөвхөн тавин мянга өгөх ёстой шүү дээ гэж хэлэв.

- Аа, таны шагнал чинь яах юм бэ?

- Эрхэм гүн минь, ерөнхий үнэнд нь багтаж байгаа юм.

- Гэхдээ та Отеллаас ирсэн биз дээ?

- Тийм ээ, тэгсэн.

- Тэгэхээр танд яршиг удсаны хөлс төлөх ёстой шүү дээ гээд гараа хөдөлгө түүнийг явуулав.

Нотариус араараа ухарч газар хүртэл бөхийсөөр гарав. Нотариус болсноосоо хойш анх удаа л ийм хүнтэй наймаа хийж үзжээ.

- Эрхэм нотариусыг гаргаж өг гэж гүн хэрэг хөтлөгчдөө хэлэв.

Бертуччо гарч одлоо.

Гүн ганцаараа үлдээд цоожтой байдаг түрийвчээ хармаанаасаа гаргаж, үргэлж хүзүүндээ зүүж явдаг түлхүүрээрээ онгойлгож дотроос нь юм тэмдэглэсэн хуудас гаргаж түрүүн гарын үсэг бичсэн хуудастай тулгаж үзэв.

- Отейль, Фонтын гудам хорин найм. Зүйтэй. Сүсэг бишрэлээрээ юу эсвэл тамлагдахаасаа айж хүлээгээ юү гэдэг асуудал байна? За ямар ч л гэсэн цагийн дараа бүгдийг нь мэдэх болно гэв. тЭгээд эвхмэл бариултай жижигхэн алх шиг юмаар тогшин хүнгэнэсэн дуу цуурайтан гарахад,

-Бертуччо! гэж дуудав.

Хэрэг хөтлөгч орж ирэв.

- Эрхэм Бертуччо, та өөрийгөө францад байсан гэж ярьж байсан байх аа? гэж гүн асуув.

- Тийм ээ, гэгээн эзэн минь. Зарим нэг газар байсан.

- Та парисын орчин тойронг мэдэх байх аа гэхэд хэрэг хөтлөгч,

- Үгүй гэгээн эзэн минь, үгүй гэж чичирхийлэн хэлэхэд Монте-Кристо үүнийг нь сэтгэл ихэд догдолсны шинж гэж мэдлээ.

- Та Парисын хавьцаа байгаагүй чинь харамсалтай байна. би өнөөдөр л шинэ эдлэн байшингаа үзэх гэсэн юм. та надтай хамт явж, үнэт зөвлөгөө өгч чадах байсан юм гэж гүн хэлэхэд Бертуччогийн бор царай үхдэлийн мэт зэвхийрSn,

- Отейльд уу! Би Отейль явах гэж үү гэж дуу алдав.

- Та Отейльд очиход гайхаад байх юу байгаа юм бэ, хэлж өгнө үү? Та миний дэргэд ажиллаж байгаа болохоор намайг тэнд очиж суухаар та я бас тэнд байх болно доо.

Бертуччо эзнийхээ захирангуй харцын дор хөдлөлгүй дуугүй зогсоно.

-Энэ юу гэсэн үг вэ? Та яаж байна? надад сүйх тэрэг ирүүл гэж хоёр удаа хонх дуугарга гэж тушаана уу? гэж гүн XIV Людовик өөрийн цуут: “Би хүлээх шахлаа” гэдэг үгээ хэлж байгаа юм шиг хэлэв.

Бертуччо зочдын өрөөнөөс гүйн гарч үүдний өрөө рүү бүдэг дуугаар,

- Гэгээн эзний сүйх тэргийг! гэж хашхирав.

Монте-Кристо хэдэн захидал бичиж сүүлийн захидлыг дугтуйлж байхад даамал орж ирэв.

- Гэгээ эзний сүйх тэрэг ирсэн гэж хэлэхэд гүн,

- За! Малгай бээлий ав гэж хэлэв.

- Би гэгээн эзэн тантай явах юм уу? гэж Бертуччо дуу алдахад,

- Би тэнд суух болохоор та зарим нэг зүйлийг захиран хийлгэх хэрэгтэй биз дээ гэж хэлэв.

Гүнгийн хэлэх үгнээс зөрнө гэж байхгүй учир хэрэг хөтлөгч даамал түүнийг үг дуугүй даган явав. Гүн сүйх тэргэндээ суугаад, Бертуччог бас суу гэж толгой дохив.

Хэрэг хөтлөгч урьд талын суудал дээр ихэд хүндэтгэлтэйгээр суулаа.

V. Отейль дахь байшин

Бертуччо шатаар бууж явахдаа корсик ёсоор мөргөж, өөрөө хэлбэл эрхий хуруугаараа агаарт хирээс тэмдэг хийж, тэргэнд суухдаа товч маань уншсаныг гүн ажиглав. Гүнг хотын захаар зугаацах гэхэд хүндэт хэрэг хөтлөгч хачин дургүйцэж байгааг нь сониуч биш хүн бол өрөвдөх байсан биз. гэвч гүн Бертуччо энэ зугаалганд заавал явуулах дуртай байгаа ажээ. Тэд хорин минутын дараа Отейльд хүрч ирлээ. Хэрэг хөтлөгчийн сэтгэл хөдлөх нь улам нэмэгдлээ. Сууринд орж ирэхэд Бертуччо сүйх тэрэгний буланд шигдэн сууж, хажуугаар нь өнгөрөн гарч байгаа байшин бүрийг их л сандарсан байдалтай харна. Гүн хэрэг хөтлөгч өөд харж,

- Фонтен гэдэг гудамжны хорин наймдугаар байшингийн дэргэд зогс гэж тушаа гэж хэлэв.

Бертуччогийн духан дээр хөлс дааварлан гарсан боловч тушаалыг биелүүлэн сүйх тэрэгнээс цухуйж, хөтлөгчид,

- Фонтен гудамж, хорин найм гэж хашхирав.

Энэ байшин суурингийн хамгийн цаад зах нь байлаа. Тэднийг явсаар байтал бүр харанхуй болж, цахилгаан гэрлийн хүчинд улам бараантан харагдах хар үүлс тэнгэрийг бүрхэж, муу үйл зөгнөсөн мэт ажгуу.

Тэрэг зогсож зарц ухасхийн хаалга онгойлгоход, гүн,

- За Бертуччо, та гарахгүй юм уу? Эсвэл та тэргэн дотроо үлдэх гэж байна уу? Та ер нь өнөөдөр яагаад байна? гэж асуув.

Бертуччо сүйх тэрэгнээс гарч гүнд мөрөө өгөхөд цаадах нь мөрнөөс нь түшин гурван гишгүүр дамжиж аяархан буув.

- Хаалгыг нь црхиж намайг ирлээ гэж хэл гэж гүн хэлэхэд Бертуччо хаалга цохив. Хаалга нээгдэж байшин харгалзаж байсан хүн гарч ирээд,

- Юу хэрэгтэй вэ? Гэж асуув.

- Танай шинэ эзэн ирлээ гэж зарц хэлэв.

Тэгээд тэр нотариусын өгсөн бичиги©г манаачид өгөв.

- Өө байшингаа худалдчих аа юу? энэ ноён энд суух юм уу? гэж асуув.

- Тийм ээ найз минь гэж гүн хариулаад, - Хуучин эзэн минь байсан болоосой гэж танд бодогдохгүй байхыг хичээнэ гэхэд,

- Эзэн минь, үнэнээ хэлэхэд надад тэгж харамсаад байх юмгүй. Би түүнийг бараг хараагүй. Эзэн энд ирэхгүй болсоор таван жил болж байна. Ер нь ямар ч орлогогүй энэ байшинг худалдсан нь сайн болж гэж хариулав.

- Танай түрүүний эзнийг хэн гэдэг байсан юм бэ? гэж гүн асуув.

- Бейс де Сен-Меран. Тэр хүн байшингийнхаа үнэд хүрэх юм авч чадаагүй гэдэгт би итгэлтэй байна.

- Де Сен-Меран бэйс гэж гүн давтан хэлээд, - Дуулсан нэр шиг санагдаж байна гэв.

Тэгээд мартсанаа санах гэж буй мэт бодлогошров.

- Хуучин язгууртан. Бурбоны үнэнч зарц. Ганц охинтой байгаад түүнийгээ Нимад, дараа нь Версальд вангийн прокурор байсан ноён де Вильфортой суулгасан гэж сахигч хэлэв.

Гүн Бертуччо өөд харахад цаадах нь унахгүйн тулд түшсэн хананаасаа ч цагаан царайтай болсон байлаа.

- Тэгээд тэр охин нь талийгаач болчихсон байх аа? Би тэгж дуулсан юм шиг санаж байна гэж гүн асуув.

- Тийм ээ, хорин нэгэн жил болж байна. түүнээс хойш бид бэйсийг ганц удаа ч харсангүй дээ.

Гүн тамирдаж цөхөрсөн Бертуччо хараад одоо илүү чангалаад яах вэ, утас нь тасарчихаж мэднэ гэж бодоод,

- За танд их баярлалаа, одоо бидэнд гэрэл гаргаж өгнө үү? гэж хэлэв.

- Танд замчилж өгөх үү?

- Үгүй, Бертуччо надад гэрэл гаргаж өгнө.

Монте-Кристо ингэж хэлээд хоёр алтан зоос гарган өгөхөд баяр талархлын үгс ирсан гарч ирэв. Сахиулын хүн задгай зуух ба тавиур дээгүүр дэмий л тэмтрэн,

- Эзэн минь энд надад нэг ч лаа алга гэж хэлэв.

- Бертуччо тэргэн дотроос дэнлүү авч асаа, тасалгаануудыг нь үзье гэж гүн хэлэв.

Хэрэг хөтлөгч даамал тушаалыг нь дуугүй биелүүлсэн боловч авч яваа бамбар нь салганан чичирч байхыг харахад энэ ажил түүнд багагүй хүнд байгаа нь илэрхий.

Тэр хоёр нэлээд өргөн доод давхраар нь явж зочдын өрөө, халуун ус ба унтлагын өрөөтэй хоёрдугаар давхрыг үзэв. Хоёр тасалгааны нэг нь доошоо цэцэрлэг рүү гардаг эргүүлгэн шаттай холбоотой ажээ.

- Харж байна уу, гарах тусгай хаалгатай юм. энэ чинь тохитой юм байна даа. Алив Бертуччо минь өмнө орж гэрэл гаргаач, энэ шат хаашаа орсныг нь харъя гэж гүн хэлэв.

- Гэгээн эзэн минь, цэцэрлэг рүү гардаг юм.

- Та үүнийг яаж мэддэг юм бэ?

- Үгүй би үүнийг цэцэрлэг рүү гардаг байх гэж хэлэх гэсэн юм.

- За яах вэ шалгаад үзье.

Бертуччо хүндээр санаа алдаад урьд нь явав. Шат үнэхээр цэцэрлэг рүү оржээ.

Гадаа хаалганы дэргэд очоод хэрэг хөтлөгч зогсов.

- Та яав? Гэж гүн асуув.

Гэвч цаадах нь мэгдэж сандран байрнаасаа хөдөлсөнгүй. Ийш тийшээ харах нь өнгөрсөн үеийн ямар нэгэн аймшигт явдлын ул мөрийг эрэх мэт бөгөөд зангидсан гар нь аймшигт дурдатгалыг цааш зайлуулан түлхэх гэсэ мэт байлаа.

- За яав? Гэж гүн давтан хэлэхэд, Бертуччо гэрлээ доош буулгаж, өөрөө хана налав.

- Үгүй, үгүй гэгээн эзэн минь. Би цааш явж чадахгүй. Ийм арга алга гэж дуугарав.

- Энэ чинь юу гэсэн үг вэ? Гэж гүн хатуухан шиг хэлэхэд,

- Гэгээн эзэн минь, ямар нэгэн туу ёрын аймшигт юм байна. та Парист байшин авахдаа заавал Отвейлд авч байдаг. Тэгэхдээ бүр заавал Фентон гудамжны хорин наймдугаар байшинд дайраллдаг нь юу вэ. Ай хөөрхий, би гэртээ байхдаа таныг цөмийг нь хэлэлгүй яав. Тэгсэн бол та намайг заавал авч явах шаадлагагүй байсан байх. Би таныг арай ч энэ байшинг авчихаагүй байх гэж бодож байна. хүн амины хэрэг гарсан энэ байшингаас өөр байшин Отейльд байхгүй юм шиг! хэрэг хөтлөгч дуу алдан хэлэв.

- Та юун дэмий юм яриад байгаа юм гэж гүн хэлээд – Хүн л юм даа. ёстой корсик хүн юм. үргэлж л ямар нэгэн нууц эсвэл мухар сүсэгтэй байх юм! дэнлүүгээ өөд нь өргө, цэцэрлэгийг нь үзье. Надтай явж байхад танд ямар ч аймшигтай юм болохгүй гэж хэлэв.

Бертуччо дэнлүүгээ өргөж, тушаалыг биелүүлэв. Хаалга онгойлгоход бүдэг тэнгэр харагдаж, саран тэнгис мэт бүрхэх үүлтэй дэмий л тэмцэлдэн тулалдаж, гэн цухуйн гарч гэрэлтүүлсэнээ улам гүн хар хязгааргүйн дунд дахин орж алга болно.

Хэрэг хөтлөгч зүүн тийшээ эргэх гэтэл гүн,

- Үгүй, үгүй, бид модот гудамжаар явах ямар хэрэг байна? тэнд сайхан зүлэг байна, тэр уруу очъё гэж хэлэв.

Бертуччо нүүр уруугаа урссан хөлсийг арчаад тушаалыг даган биелүүлэв. Гэвч тэр бас л зүүн тийшээ эргэв.

Харин гүнг баруун ийшээ эргэж бөөн ургасан модод тийш зогсов.

Хэрэг хөтлөгч үүнээс цааш биеэ барьж чадахаа болив.

- Гэгээн эзэн минь эндээс зайлаач, би танаас гуйя. Та яг л тэр газар дээр зогсож байна гэж дуу алдав.

- Ямар газар?

- Түүний унасан газар.

- Хүндэт Бертуччо та ухаарч үзээч, таныг гуйя. Би чинь Сартена буюу Кортод байгаа биш шүү дээ. энэ чинь зэрлэг ой биш. Харин арчлалт хамгаалалтгүй болсон боловч анхил цэцэрлэг байна. тэглээ ч туу нэр өгөх хэрэг алга гэж гүн инээн хэлэв.

- Эрхэм та тэнд бүү зогсооч, би танаас гуйя!

- Бертуччо та солиорч байх шиг байна шүү гэж гүн хүйтнээр хэлээд, - Хэрвээ тийм бол хэлээрэй, эртхэн таныг эмнэлэг хүргэе гэв.

Тэгэхэд Бертуччо толгойгоо сэгсрэн гараараа савчин, арчаагүй байдлаар,

- Ай гэгээн эзэн минь. Золгүй явдал аль хэдийн болчихсон юм шүү... гэж хэлэхэд гүнгийн инээд хүрэх байсан боловч энэ удаа санаанд нь илүү чухал байдал байсан учир инээсэнгүй.

- Бертуччо та чинь гар хөлөө савчин, халаг хоохойлж, чөтгөр шүгэлчихсэн юм шиг л нүд ам чинь эргэлдээд байх юм. хамгийн зөрүүд чөтгөр бол битүүлэг нууц болохыг би сайн мэднэ. Гэвч би Италид байхдаа тэнд ийм юм зөвшөөрдгийг мэдэх учир үүнийг анхаараагүй байсан юм. харин Францад бол хүн алах явдлыг маш муухай гэж үздэг юм. энэ ийм асуудлыг сонирхдог цагдаа, ийм хэргийг шүүдэг шүүх, мөн энэ хэргийн өшөөг авдаг цаазын индэр байдаг юм.

Бертуччо залбиран гараа өргөвөл гарт нь байсан дэнгийн гэрэлд түүний айж хачин болсон царай харагдана.

Монте-Кристо түүнийг Ромд байхдаа Андреаг цаазлахыг харсан лугаа адил харцаар харав. Тэгээд дараа нь хөөрхийг дахин чичрэхээр үгийг шивнэв.

- Тэгвэл Бузони ламтан мянга найман зуун хорин есөн онд Францаар явсныхаа дараа таныг над руу итгэмжлэх захидалтай ирүүлэхдээ худлаа хэлж, таныг дэндүү өөд нь өргөсөн хэрэг байх нь ээ? За яах вэ, би ширээт ламд захидал бичье. Тэр итгэмжилсэн захидлынхаа тухай хариу ирүүлэх байх, тэгээд би ямар хүн амины хэрэг гарсан болохыг мэднэ ээ. Би сууж байгаа орныхоо хуулийг хүндэтгэн үздэг учир танаас болж Францын засгийн газартай муудалцахыг хүсэхгүй байна гэдгийг танд урьдчилан сануулъя.

- Гэгээ эзэн минь, та бүү тэгээч! Би танд үнэнч итгэлтэй зүтгэж байгаагүй гэж үү? Би ямагт үнэнчээр явсан, хүнд сайн юм хийхсэн гэж хичээж явдаг гэж Бертуччо сандран хэлэв.

- Би үүний эсрэг маргалдаагүй. Тэгвэл та яагаад ингэтлээ сандраа вэ? Энэ чинь муу шинж шүү. Хэрвээ хүний зүрх сэтгэл ариун бол царай нь ингэж цонхийж, гар нь салганан чичирдэггүй юм... гэж гүн хариулав.

- Үгүй гэгээ эзэн минь. Нимагийн шоронд байхдаа нүглээ наманчилсан Бузони лам намайг тан уруу явуулахдаа миний сэтгэл зүрхэнд хадгалагдсан хүнд гэм би ингэж танд урьдчилан хэлсэн гэж та хэлсэн шүү дээ гэж Бертуччо хулчгардуухан татгалзав.

- Тэр таныг надад туйлын авьяастай хэрэг хөтлөгч гэж ирүүлсэн болохоор ямар нэг хулгайн хэрэг л байлгүй гэж бодсон юм.

- Яалаа гэж эзэн минь хэмээн Бертуччо сэжиглэн дуу алдав.

- Эсвэл та корсикчуудын заншлаар тэсэлгүй эндхийнхний ярьдгаар “арьсыг нь хуулчихсан” юм уу?

- Тийм ээ гэгээн эзэн минь, тийм л учиртай юм гээд Бертуччо гүнгийн хөлд сөгдөн унаж, - Өшөө авсан хэрэг байсан юм, зөвхөн л өшөө авсан гэв.

- Би үүнийг ойлгож байна, харин чухам яагаад энэ байшин таныг ийм байдалд хүргэж байгааг л ойлгохгүй байна.

- Гэгээн эзэн минь, энэ бол зүй ёсны хэрэг. Яг энэ байшинд хамаг хэрэг болсон юм.

-Яалаа гэнэ ээ, миний байшинд уу?

- Тэгэхэд энэ байшин таных байгаагүй юм гэж Бертуччо хариулахад,

- Тэгэхэд хэнийх байсан юм бэ? Бэйс де Сан-Мераных гэж манаач хэлсэн байх аа? Чөтгөр ав та яагаад Сан-Меранас өшөө авах болсон юм бэ?

- Гэгээн эзэн минь, би түүнээс өшөө аваагүй өөр хүнээс авсан юм.

- Таны сэтгэлийг ингэж их зовоож байгаа хэрэг явдал гарсан байшинд санаандгүй хүрч ирнэ гэдэг хачин тохиолдол байна даа гэж гүн бодож буй мэт хэлэв.

- Гэгээн эзэн минь, энэ бол хувь зохиол гэдгийг би мэдэж байна. та заавал Отейлд байшин худалдаж авч, тэр нь миний хүн алсан байшин байдаг. Та түүний бууж ирсэн шатаар буусан. Би түүнийг хутгалсан газар та зогсож байна. эндээс хоёр алхмын зайтай тэрүүхэнд хүүхэд булсан. Үгүй, энэ бүгд цөм тохиолдлын хэрэг биш ээ. тийм бол тохиолдсон явдал тэнгэрийн бошгийг үзүүлсэн хэрэг болчихно гэж хөтлөгч хэлэв.

- За яах эрхэм корсик минь, үүнийг чинь бошгийг үзүүлсэн хэрэг гэж үзье. Би ер нь юм бүхнийг тийм байх гэж боддог эмзэг сэтгэлтэй хүмүүст бууж өгөхийг зөвшөөрдөг. Одоо ухаан санаагаа ажиллуулж, бүгдийг нь надад ярьж аль.

- Би энэ тухай амьдралдаа Бузони ламтанд ярьсан юм. ийм зүйлийг гээд Бертуччо толгойгоо сэгсрэн – Зөвхөн нүглээ наминчлах үед л хэлж болно гэв.

- За тэгвэл хүндэт нөхөр минь би таныг тэр лам уруу чинь явуулъя. Та түүнтэйгээ тэгээд өөрийнхөө нууцыг ярьж бай. Миний тухайд гэвэл би ийм аймхай даамалтай байж болохгүй. Зарц нар маань цэцэрлэг дотор үдэш орой зугаалахаасаа айх нь надад таалагдахгүй байна. түүнээс гадна манайд цагдаагийн комиссар ирээсэй гэж хүсэхгүй байна. эрхэм Бертуччо та, Италид шударга үнэний шүүх ажилгүй сууж байвал мөнгө авдаг, харин Францад бол ажил хийвэл мөнгө авдаг юм гэдгийг бодож үзээрэй. Би таныг хагас корсик хүн, хагас хулгайн дамчин боловч чадвартай хэрэг хөтлөгч гэж бодож байсан юм. Гэтэл одоо бол та их олон талтай хүн болж байна, эрхэм Бертуччо та одоо надад хэрэггүй хүн гэв.

- Гэгээн эзэн минь, гэгээн эзэн минь! Хэрэв та намайг зөвхөн энэ явдлаас болоод хөөх гэж байгаа юм бол би цөмийг нь ярья. Танаас хагацаж салсанд орохноо цаазаар ав хуулсан нь дээр гэж Бертуччо айн сандарч хэлэв.

- Тэгвэл өөр хэрэг. Харин бодоорой, хэрвээ та худлаа хэлэх юм бол огт хэлэхгүй байсан нь дээр шүү гэж гүн хэлэв.

- Би сүнсээ аврахын тулд танд тангараглая, танд ёсоор нь хэлье. Лам Бузони ч гэсэн миний нууцын зөвхөн хагасыг нь мэднэ. Харин таныг юуны өмнө эндээс наад модноосоо холдохыг гуйя. Саран үүлний цаанаас цухуйхад та цуваа нөмрөөд зогсож байгаа нь эрхэм Вильфорын цувтай адил харагдаад байна.

- Яалаа гэнэ ээ. Тэр чинь Вильфор байсан юм уу... гэж Монте Кристо дуу алдав.

- Гэгээн эзэн та түүнийг таньдаг юм уу?

- Тэр Нимад вангийн прокурор байсан юм уу?

- Тийм ээ.

- Тэгээд бэйс де Сен-Мераны охинтой суусан юм уу?

- Тийм.

уу?

- Тэгээд хамгийн үнэнч, хатуу ширүүн тал тохой татдаггүй шүүгч гэгдэж байсан
- Тийм ээ, их л нэр хүндтэй... тэр хүн хэмээн Бертуччо дуу алдахад,
- Юу гэж? гэв.
- Үл бүтэх амьтан байсан юм.
- Үгүй байх аа гэж гүн татгалзав.
- Гэлээ ч гэсэн энэ үнэн л дээ.
- Нээрээ тийм гэж үү? Тэгээд танд үүнийг гэрчлэх юм байна уу?
- Уг нь байсан.
- Та тэнэг амьтан. Тэгээд тэрнийгээ алга болгочихсон юм уу?
- Тийм ээ, гэсэн ч сайн эрвэл олж болно.
- Уухай Бертуччо, та энэ тухайгаа надад ярьж өгөөч, үнэхээр сонин санагдчихлаа гэж гүн хэлэв.

Тэгээд гүн “Лючийн” аялгуунаас аялан сандал дээр очиж суув. Бертуччо болсон явдлаа ухаандаа эргэцүүлэн санасаар түүнийг даган явла .

Бертуччо гүнгийн өмнө зогсов.

VI. Вендетта¹

- Гэгээн эзэн минь, юунаас нь эхэл гэж тушаахсан бол гэж Бертуччо асуув.
- За юу дуртайгаасаа эхэл. Би юу ч мэдэхгүй шүү дээ гэж гүн хэлэв.
- Бузони лам танд хэлсэн байх гэж би бодсон юм...
- Тийм ээ, зарим нэг зүйлийг нь хэлсэн. Гэвч түүнээс хойш долоо найман жил өнгөрсөн болохоор мартчихаж.
- Тэгвэл би гэгээн таны уйтгарыг хүргэчих болов уу гэж айлгүй ярих уу?
- Ярь, ярь Бертуччо. Та өнөө оройн сонинг орлож чадна.
- Энэ явдал мянга найман зуун арван таван онд эхэлсэн юм.
- Уухай, эртний түүх байх нь ээ гэж гүн хэлэв.
- Тийм ээ гэгээн эзэн минь. Гэвч энэ хэрэг дөнгөж өчигдөр болсон мэт миний санаанд ил байна. би нэг ахтай байсан юм. тэр маань эзэн хааны армийн дан

корсикчуудаас бүрэлдсэн хороонд цэргийн алба хааж бага дарга цолтой болсон билээ. тэр маань арван найман настай, би таван настай байхдаа өнчирсэн улс. Тэр намайг өөрийнхөө хүү шиг хүмүүжүүлсэн юм. мянга найман зуун арван дөрвөн онд, Бурбоны үед тэр маань эхнэр авсан. Эзэн хаан Эльба арлаас ч буцан ирж, манай ах ч тэр дороо дахин цэрэгт орж, Ватерлоогийн дэргэд хөнгөн шархдаад, армитайгаа хамт Луврын цаад тал уруу дайрчээ.

- Үгүй та чинь надад зуун өдрийн түүх яриад байх шив. хэрвээ би андуураагүй бол энэ түүх аль хэдийнэ бичигдсэн байх аа гэж гүн түүний яриаг таслан хэлэв.

- Уучлаарай гэгээн эзэн минь. Гэвч энэ байдлыг эхлээд ярих хэрэгтэй юм. та тэсвэртэй сонсоно гэсэн шүү дээ.

- За за ярь, би хэлсэн үгэндээ хүрнэ.

- Тэгж байтал нэгэн өдөр захирагч ирэв. Би тэгэхэд Корсо хошууны үзүүрт байдаг Рольяно гэдэг жижиг тосгонд сууж байсан юм. тэр захидал ахаас иржээ. Армийг тараасан учир Шатор, Клерман-Ферран, Пюи ба Нимийг дайран гэртээ харина, хэрвээ мөнгө байвал Нимд байдаг жаал зугаа харьцаатай буудлынхаа эзнийхээ нэр дээр ирүүлнэ үү гэж бичсэн байлаа.

- Хил сэм давуулдаг наймаатай холбоотой юу? гэж гүн хэлэв.

- Гэгээн эзэн минь амь зуух хэрэгтэй шүү дээ.

- Мэдээж хэрэг цааш нь ярь, ярь.

- Би ахдаа их хайртай байсан гэдгийг түрүүнд хэлсэн билээ. тэгээд мөнгө явуулахын оронд өөрөө аваачиж өгөхөөр шийдэв. Надад мянга шахав франк байсан таван зууг нь бэр хүүхэн Ассунтад орхиод бусдыг нь өөрөө авч Ним орохоор явав. Энэ бол тийм хүнд ажил биш байв. Нада завь байсан бөгөөд тэнгист гарч ачаа хүлээж өгөх ажилтай байв. Гэвч намайг ачаа хүлээж авмагц ачаа өөрчлөгдөж бид дөрвөн өдөр турш Ронд орж чадахгүй байв. Тэгээд эцэст нь арай гэж Арль хүртэл өгсөв. Би завиа Бельград, Бокер хоёрын хооронд орхиод өөрөө Нимийг чиглэн явлаа.

- Бид гол юмандаа хүрч байх шив, тийм үү?

- Тэгж байна, гэгээн эзэн минь уучлаарай, би зөвхөн хамгийн чухлыг нь ярьж байна гэдгийг та ойлгох хэрэгтэй. Тэр үед өмнөд францад аллага болж байлаа. Тэнд Трестальон, Трюфеми, Граффан гэдэг гурван дээрэмчний бүлэг байсан бөгөөд тэд бонапартизмын талынх гэж сэжиглэсэн бүхнийг алан хядаж байв. Гэгээн эзэн та энэ аллагын тухай сонсоо биз дээ.

- Бага зэрэг сонссон юм. би тэгэхэд Францаас хол газар байсан юм. цааш нь ярь ярь.

- Нимад цусан намаг дундуур л явахад хүрч байсан. Алхам бүрт л үхдэл хүүр дайралдаж, алуурчид бүлэг бүлгээрээ алж хядан, дээрэмдэж, шатааж байв. Би энэ аллагыг хараад дагжин чичирдэг байлаа. Тэгэхдээ өөрийнхөө төлөө биш, бидэн шиг корсикийн загасчдыг яах ч үгүй. Харин ч хил давж хулгай наймаа хийдэг хүмүүст энэ

бол алтан үе байв. Би ахынхаа төлөө л айж байсан юм. эзэн хааны цэрэг тэрээр луарын армиас цэрэг хувцас, тэмдэгтэйгээ ирж байгаа болохоор юм бүхнээс болгоомжлох хэрэгтэй байсан юм.

Би өөрийн танил буурчийн газар очтол зөгнөн бодсон минь худал болсонгүй. Ах минь урьд өдөр нь энд ирээд амь хорогдоно гэж бодож байсан тэр байшингийнхаа босгон дээр алагджээ. Би түүнийг ямар хүмүүс алсан бол гэж мэдэх гэж бүх хүчээрээ оролдсон боловч хүмүүс тэднээс айгаад хэн ч хэлж өгсөнгүй. Тэгэхээр нь би юунаас ч айдаггүй Францын шударга үнэний шүүх гэж байдгийг санаад вангийн прокурорт очив.

- Вангийн прокурорыг чинь вильфор гэдэг байсан уу? гэж гүн хайхрамжгүй асуув.

- Тийм ээ, Марсельд вангийн туслах прокурор байж байгаад ирсэн юм. Хичээнгүй ажилласныхаа төлөө тушаал дэвшсэн бөгөөд Наполеон буужээ гэдгийг хамгийн түрүүнд Бурбончууд д мэдэгдсэн гэж улс амьтан ярилцаж байв.

- Тэгээд та түүн дээр очсон уу? гэж Лүн үгийг нь таслан асуувал,

- “Ноён прокурор ө-игдөр миний ахыг Нимийн гудамжинд алчихаж. Хэн алсныг нь мэдэхгүй. Гэвч таны үүрэг бол тэдгээрийг олох шүү дээ. та энд шударга үнэний шүүхийн тэргүүн учраас биеэ хамгаалж чадаагүй тэдгээр хүмүүсийн өшөөг авах ёстой” гэж түүнд хэлэв.

- “Ах чинь ямар хүн байсан юм бэ?” гэж вангийн прокурор асуув.

- “Корсикийн батальоны бага дарга”

- “Өөрөөр хэлбэл Узурбаторын цэрэг үү?”

- “Францын армийн цэрэг”

- “Тэгвэл тэр чинь сэлэм далайгаад, тэр зэвсгэндээ үхсэн юм шив дээ” гэж прокурор татгалзан хэлэв.

- “Эрхэм та ташаарч байна. тэр хутганд үхсэн юм.”

- “Тэгээд та надаас юу хүсэж байгаа юм бэ?”

- “Түүний өшөөг авч өгөөч гэж түрүүн хэлсэн шүү дээ”

- “Хэнээс?”

- “Түүнийг алсан алуурчдаас”

- “Би тэднийг яаж мэдэх вэ?”

- “Эрж ол гэж тушаал өгөөч”

- “Яах гэж эрж олох юм бэ? Танай ах ямар нэг хүнтэй маргалдаа халз тулаан хийсэн байлгүй. Энэ хуучин цэргүүд агсамнаж танхайрах дуртай улс. Эзэн хааны үед дураараа туйлдаг байсан. Харин одоо манай өмнөдийнхөн тийм юманд дургүй”.

“Ноён прокурор би өөрийнхөө төлөө гуйж байгаа юм биш. Гашуудах ч юм уу өшөө авах гэдэг миний өөрийн хэрэг. гэвч миний золгүй ах эхнэртэй байсан юм. хэрвээ надад ямар нэг явдал тохиолдвол хөөрхий эмэгтэй өлсөж үхэх болно. Тэр зөвхөн нөхрийнхөө олсоноор арь зууж байсан юм. жаахан ч гэсэн тэтгэвэр олж өгөөч” гэж би хэлэв.

- “Хувьсгал бүхэн өөрийн хохиролтой байдаг. Танай ах сүүлийн эргэлтийн хохирол болж орхиж. Энэ золгүй явдал боловч засгийн газар танай гэр бүлд үүнийг төлж өгөх үүрэггүй. Хэрвээ бид узурпаторын талд орж, роялистуудаас өшөө авах хэрэг байсан бол бүх хүмүүсийг шүүх хэрэг болсон сон бол танай ах алагдах ял заагдсан ч байж мэднэ. Тэр болсон явдал бол зүй ёсны хэрэг. энэ бол харилцан өшөө авахын хууль” гэж Вильфор хариу хэлсэн юм.

- “Энэ чинь юу гэсэн үг вэ? Шударга үнэний төлөөлөгч та ингэж хариу өгч байгаа юм уу?” гэж би хэлэхэд,

- “Яг тийм, энэ корсикчууд солиотой улс одоо хүртэл нутаг нэгт эзэн хаанаа байгаа юм шиг бодоод байх юм. та цаг алджээ. Хоёр сарын өмнө та надтай ингэж ярьж болох байсан юм. одоо дэндүү оройтож. Эндээс зайл, үгүй бол би эндээс гарга гэж тушаана шүү” гэв.

Дахиад сайн гуйвал яадаг бол гээд түүн өөд харав. Гэвч тэр хүн биш, чулуу ажээ. Тэгэхээр нь би түүнд дөхөж очоод,

“За яах вэ, та корсикчуудыг тийм сайн мэддэг юм бол, тэдний хэлсэндээ яаж хүрдгийг мэдэх л ёстой. Тэр бонапартич, та роялист хүн болохоор миний ахыг алсан хүний зөв болж байх шив. за яах вэ! Би бас бонапартич хүн, таныг ална гэдгээ урьдчилан хэлчихье. Би энэ минутаас эхлээд танд вендетта зарлалаа, иймээс болгоомжлоорой. Би тантай нүүр тулгаран уулзсан эхний удаад л таны амьдралын сүүлийн цаг цохино доо” гэж шивгэнэв.

Тэгсэд би түүнийг ухаархаас өмнө гүйн одсон билээ.

- Үгүй ер Бертуччо, та ийм нүдэнд дулаахан хүн байж тийм юм ярьж чадна гэнэ ээ. тэгээд бүр хааны прокурорт шүү. Туу байна! Цаадах чинь Вендетта гэдгийг мэдэх болов уу?

- Тэр сайн мэддэг юм байна лээ. Тэр минутаас эхлээд ганцаараа гадагшаа гарахаа больж, гэртээ шигдэн, намайг хаа байгаа газраас нь ол гэж тушаал буулгасан байна лээ. Аз болоход би олдохооргүй газар бүгж байсан юм. тэгэхэд түүнд их аймшигтай санагдаж, Нимад байхаасаа айж өөр газар шилжүүлэн суулгаж өгөөч гэж гуйжээ. Тэр их нөлөөтэй хүн байсан учир хүсэлтийг нь хүлээн авч, Версальд шилжүүлэн суулгасан юм. Өшөөгөө авна гэж тангарагласан корсик хүнд хол ойр гэж байдаггүйг та мэднэ дээ. би хэдийгээр явган явж, түүний сүйх тэрэг хэдий яаравч надаас хагас өдрийн зайгаас илүү түрүүлж чадаагүй юм.

түүнийг зүгээр алчих нь чухал биш байлаа. Ингэчих бололцоо зөндөө байсан. Харин өөрийгөө танигдахгүй, баригдчихгүйгээр алах хэрэгтэй байсан. Бэрээ тэжээх хэрэгтэй байлаа. Бүтэн гурван сарын турш Вильфорыг амдан сахисан, тэр хугацаанд миний нүдэнд харагдаагүй нэг ч алхам гэж байгаагүй билээ. тэгж байгаад түүнийг Отейль руу сэм очдогийг мэдэж авлаа. Дараа нь бид хоёрын байж байгаа энэ байшинд ирдэг болохыг нь мэдэв. Тэгэхдээ бусдын адил гол хаалгаар орж гарахгүй, морь юм уу сүйх тэргээр ирж, түүнийгээ зочид буудлын тэнд орхиод өөрөө тэр харагдаж байгаа явган хаалгаар орж ирдэг байлаа.

Монте-Кристо, Бертуччоги©н зааж байгаая явган хаалгыг харанхуйд харж байгаагаа мэдэгдэж дохив.

- Версальд хийх өөр ажил байгаагүй учир Отейльд нүүн ирж, мэдээ цуглуулж эхлэв. Би түүнийг барьж авья л гэвэл энд занга тавих ёстой газар байлаа.

Энэ байшин, танд манаачийн хэлснээр Вильфорын хадам эцэг бэйс де Сен-Мераны байшин байлаа. Бэйс өөрөө Марсельд сууж байсан учир энэ хотын захын байшин түүнд хэрэггүй байлаа. Бэйс түүнийгээ залуу бэлэвсэн авгайд хөлсөлж өгсөн бөгөөд тэр эмэгтэйг нь энд зөвхөн л түшээ гүнгийн авхай гэж мэддэг байлаа.

Нэг орой хашаан завсраар шагайж байтал цэцэрлэг дотор нэгэн эмэгтэй зугаалан байн байн хаалга уруу харж байхыг олж үзэв. Эмэгтэй өнөө орой Вильфорыг хүлээж байгаа юм байна гэж мэдэв. Тэгээд надад ойртож ирэхэд арван найм орчим насны хөөрхөн өндөр цагаан хүүхэн байхыг харанхуйд олж харав. Тэр хүүхэн жирийн хүлхгэр хувцас өмссөн байсан бөгөөд бүсэлхий нь барьсан юм юу ч үгүй байхыг нь харвал бие шалтгаантай, тэгээд ч удахгүй гарах болсон нь мэдэгдэж байлаа. Хэдэн минутын дараа хаалга онгойж нэгэн эрэгтэй хүн орж ирэхэд залуу бүсгүй чадах чинээгээрээ яаран угтав. Тэр хоёр тэврэлдэж, эелдгээр үнсэлдээд гэртээ оров. Тэр эрэгтэй нь Вильфор байлаа. Би түүнийг цэцэрлэг дотуур шөнө ганцаараа буцна гэж бодож байлаа.

- Аа, та сүүлд нь тэр хүүхний нэрийг мэдсэн үү? гэж гүн асуухад,

- Үгүй, гэгээн эзэн минь. Нэрийг нь мэдэж чадаагүй шалтгааныг та одоохон дуулна гэж Бертуччо хэлээд,

- Би тэр үдэш вангийн прокурорыг алж чадах байсан боловч цэцэрлэгийг нарийвчлан судалж амжаагүй байлаа. Би түүнийг дор нь алчихаж чадалгүй, тэр хашхирвал, хүн гүйж ирээд би нуугдаж чадахгүй гэж айж байлаа. Тэгээд дараагийн уулзалт хүртэл хойшлуулж бүхнийг нарийвчлан сайн ажиглаж байхын тулд цэцэрлэгийн хана өөд харсан цонхтой байшин хөлслөн авч суув.

Гурав хоногийн дараа орой долоон цагийн үед морьтой зарц Севрийн замаар давхин одоход түүнийг Версаль орох нь гэж тааварласан маань алдсангүй. Тэгээд тушаалыг гүйцэтгээд гурван цагийн дараа тоос шороонд дарагдчихсан хүн хүрч ирэв. Тэгтэл арваад минутын дараа цув өмссөн ван хүн явган хаалга онгойлгож цэцэрлэгт орж ирээд хаалгаа хаачхав.

Тэгэхээр нь би гэрээсээ гүйн гарав. Вильфорын царайг хараагүй боловч зүрхнийхээ цохилтоор түүнийг мөн гэж танин, гудамж хөндлөн гарч цэцэрлэгийн буланд байсан шон дээр гарч анх удаа цэцэрлэг рүү харав.

Энэ удаа би зөвхөн хараад зогссонгүй, хармаанаасаа хутгаа гаргаж хэр зэрэг сайн билүүдсэнийг нь шалгаад хашаа давж оров. Юуны өмнө би хаалга руу гүйн очиж түлхүүрээ орхисон байсныг нь авч урьдаас болгоомжлохын тулд хоёр эргүүлэв. Ингэж энэ хаалгаар зугтахад юу ч саадгүй болохоор болгов. Тэгээд эргэн тойрноо харав. Цэцэрлэгийн төв дунд тэгшхэн зүлэг байх бөгөөд түүниг захгаар өтгөн навчгүй модод ба амрын цэцгийн бут ургажээ.

Вильфор гэрээс гарч халга хүрэх буюу хаалганаас байшин уруу очихдоо заавал энэ моддын хажуугаар явах ёстой байв.

Есөн сар өнгөрч байсан учир хүйтэн салхи салхилж байлаа. Цонхигор цагаан сарыг нүүж байгаа үүлс байн байн халхална. Сар зөвхөн модот гудамжны хоорондох явган элсэн замыг гийгүүлэх тул түүний хажуугийн модны сүүдэр нь хүн нуугдчихаад огтхон ч харагдахааргүй харанхуй байлаа. Вильфор хамгийн ойр өнгөрөх газар би нуугдав. Би дөнгөж нуугдаж амжтал моддыг нахилзуулан салхилж байсан салхи исгэрэн шуугьж байх завсар хүн гиншиж байх нь сонсогдов. Хүн алах гэж бэлдэж байгаа хүнд ямар нэгэн юм хашгирах шиг санагдаад байдгийг та мэдэх байх, үгүй мэдэхгүй гэж хэлсэн нь ч дээр байх аа даа. Хоёр цаг өнгөрөхөд тийм гиншин орилох дуу хэд хэд сонстов. Шөнө дунд боллоо.

Цагны сүүлийн дуу намдаагүй байтал та бид хоёрын дөнгөж сая бууж ирсэн шатны цонхонд бүдэг гэрэл гарав. Хаалга онгойж өнөөх цувтай хүн гарч ирэв. Аймшигт минут дөхөж ирсэн боловч би энэ минутад аль хэдийнээс бэлтгэж ирсэн учир огтхон ч догдлон чичирсэнгүй. Хутгаа сугалж бэлэн барьж зогсов.

Цувтай хүн шууд над руу чиглэн ирлээ. Сүүлийн газраар явж байхыг нь харахад баруун гартаа ямар нэгэн зэвсэг барьсан байхыг нь хараад, тэмцэлдэхээс бус харин амжилтгүй болохоос айж байв. Гэвч надад хэдхэн алхач ойртож ирэхээр нь хартал түүний барьж яваа юм нь зэвсэг биш харин царил байлаа. Би түүнийг яах гэж царил авч яваа юм бол гэж улаараагүй байтал Вильфор зулгийн хажууд зогсоод ийш тийшээ харснаа нүх ухаж гарлаа. Тэгээд Вильфорын садаа болоод байхаар нь тайлаад хаячихсан цуван дор нь ямар нэгэн юм далдлагдсан байхыг харлаа. Үзэн ядах сэтгэлийн хажуугаар сониуч сэтгэл төрлөө. Би түүний юу хийж байгаа мэдэхийг хүсэв. Тэгээд амьсгаагаа дарж төдөлгүй хүлээж зогсов. Тэгэхэд надад нэг санаа төрж, вангийн прокурор цуван дороосоо хоёр фут урт, долоон ямх өргөн хайрцаг гаргаж ирэхэд улам ч батлагдав. Би түүнийг хайрцага нүхэнд хийж булах бололцоо олгов. Тэрээр шөнийн ажлынхаа ул мөрийг нуухын тулд шинэхэн шороог хөлөөрөө гишгэж дагтаршуулав. Тэгэхэд нь би түүн рүү ухасхийн дайрч цээж уруу нь хутга шааж,

- “Би Жованни Бертуччо байна! Чи миний ахын амийг өөрийнхөө амиар төлнө. чиний хөрөнгө түүний бэлэвсэн эхнэрт оногдоно. Миний өшөө хорслоо авах гэж бодож байсан минь илүү дээр бүтлээ” гэж хэлэв.

Тэр миний хэлсэн үгийг сонссон эсэх нь бүү мэд. Бодвол үгүй байх. Огт дуу гаралгүй уначихсан. Би түүний халуун цус гар нүүр рүү минь үсрэхийг мэдэрч

мансууран ухаан алдахад хүрч байв. Гэвч энэ цус намайг түлсэнгүй, харин сэхээ оруулав. Би нэгэн минутын дотор царилаар хайрцгийг ухан гаргалаа. Дараа нь хайрцаг ухаад авчихаж гэж мэдэгдүү«эхгүйн тулд нүхийг нь дахин шороогоор булж царилыг нь хашаа давуулан чулуудаад өөрөө хаалгаар гарч гадна талаас нь цоожилж орхиод түлхүүрийг нь аваад явсан билээ.

- аа мөн, энэ чинь хулгайн хэргээр хүндрүүлэгдсэн хүн амины хэрэг байна шүү дээ гэж гүн хэлэхэд, Бертуччо татгалзан,

- Үгүй гэгээн эзэн минь, энэ бол өшөө буцааж авсан хонзон байсан юм гэв.

- Ядахдаа их хэмжээний мөнгө олоо биз дээ.

- Үгүй дээ, мөнгө байгаагүй.

- Аа тийм, та чинь нэг хүүхдийн тухай ярьсан билээ гэхэд

- Чухам тийм гэгээн эзэн минь. Би гол өөд гүйж очоод эргэн дээр сууж, хайрцаг дотор юу байгааг нь үзэхийг яаран цоожийг нь хутгаараа эвдэв.

Түүн дотор нарийн сайн даавуунд ороолттой саяхан төрсөн хүүхэд хэвтэж байв. Түүний нүүр нь хар хүрэн болж, гар нь хөхөрсөн байхыг үзвэл хүйс нь хүзүүгийг нь ороогоод боочихсон шиг харагдав. Гэвч арай хөрчихөөгүй байсан учир би түүнийг хөлийнхөө дор урсан байгаа голд шидчихэж зүрхлээгүй юм. тэгээд хэсэг зуур болсны дараа зүрх нь цохилох шиг надад санагдлаа. Тэгэхээр нь хүзүүгийг нь ороосон хүйсийг нь салгаж, Бастийн эмнэлэгт сувилагч байсан болохоор ийм явдал тохиолдоход эмч яаж аргалж болох вэ тэр аргаар аргалав. Тэгээд арваад минут хиртэй болсны дараа ихээхэн хүч гаргасны хирээр тэр нялх амьтан амьсгалж эхлэн сүүлд нь орилов. Би ч хашхирчихлаа. Харин тэгэхдээ баярласандаа болоод хашхирчихсан юм. “Нэгийн амийг авсны оронд нөгөөгийн амийг аварсан учир намайг хараа зүхэхгүй” гэж би бодов.

- Та тэгээд хүүхдээ яасан бэ? Зугтаах хэрэгтэй болсон хүнд ч тохирохгүй ачаа байсан биз дээ гэж гүн асуув.

- Чухам тийм учраас түүнийг нэг ч минут өөрийн дэргэд байлгах хэрэгтэй байв. Гэвч Парист ийм золгүй хүүхдүүдийг хүлээн авдаг асрамжийн газар байдгийг мэддэг байлаа. Тэгээд харуул дээр очоод зам дээрээ хүүхэд оллоо, асрамжийн газар хаана байдаг юм бэ гэж асуув. Хайрцаг нь миний үгийг баталж өгөв. Хүүхэд ороосон нарийн сайн даавуу нь баян гэр бүлээс гарсан болохыг гэрчилж, миний будагдсан цус хүүхдийн цус мөн гэж харагдлаа. Миний яриаг үнэмшихгүй хүн гарсангүй. Анфер гудамны адагт байгаа асрамжийн газрыг зааж өгөв. Хоёр үсэг бичсэн боосон даавууны нэг үсэгтэй талыг нь өөрөө огтолж аваад, нөгөө талыг нь хүүхдэд үлдээж дараа нь авч байгаа юмаа босгоны хажууд тавьж орхиод, хонхыг нь дарж дуугаргаад хөл мэдэн зугтав. Тэгээд хоёр долоо дараа Ролянод очиж, Ассунтад,

“Эгч минь тайвшир. Израэл үхсэн болов ч би түүний өшөөг авсан” гэж хэлэв. Тэгэхэд тэр надаас энэ чинь юу гэсэн үг вэ гэж асуухад би цөмийг нь ярьж өгөв.

“Жованни чи тэр хүүхдийг аваад ирдэг байж. Бид түүний эцэг эх нь болж болох байсан юм. би түүнд Бенедетто¹ гэж нэр өгөөд энэ сайн үйлийнхээ төлөө тэнгэрийн адис хүртэх байсан юм” гэж Ассунта хэлэв.

Би түүнд хариу хэлэхийн оронд сүүлд баян болоод хүүхдийг нэхэж авахын тулд хадг лсан өнөөх ороолт даавууны хэсгийг гаргаж өгөв.

- Аа, тэр даавуу чинь ямар үсэгтэй байсан бэ? гэж гүн асуухад,

- Түшээ гүнгийн титмийн доор Н ба И гэдэг хоёр үсэг байсан.

- Та чинь нээрээ сүлднүүдийн учрыг мэддэг шүү дээ. хаана тэгж сурчихсан юм бэ?

- Гэгээн эзэн минь нөгөө албанд байж байхад бүх юм сурч болно шүү дээ.

- Ярь ярь цааш нь. Би хоёр зүйлийг мэдэхийг хүсч байна.

- Гэгээн эзэн минь ямар хоёр зүйл вэ?

- Тэгээд тэр хүүхэд яасан бэ? Та тэр хүүхдийг эрэгтэй хүүхэд гэж хэлсэн шиг санагдаж байна.

- Үгүй, гэгээн эзэн минь. Би тэгж хэлсэнээ санахгүй байна.

- Надад тэгэх шиг л санагдсан. Би андуурсан юм байлгүй дээ.

- Үгүй та андуураагүй тэр чинь эрэгтэй хүүхэд байсан юм. харин хоёр дахь мэдэх гэсэн зүйл чинь юу вэ?

- Та ямар хэрэгт шийтгэгдэж лам ирүүлэхийг гуйгаад, Нимийн шоронд байхад чинь Бузони лам ирсэн юм бэ?

- Гэгээн эзэн минь, энэ их урт яриа болох болно.

- Үгүй, яах вэ дээ. одоо дөнгөж арван цаг болж байна. та намайг бага унтдаг гэдгийг мэднэ. Та ч бас унтахааргүй байгаа байлгүй.

Бертуччо мэхийн ёслоод цааш нь үргэлжлүүлэн,

- Үргэлж бодогдох байх дурдатгалыг мартаж, бас хөөрхий бэлэвсэн эхнэрийн амьдралд мөнгө олоход туслахын тулд би дахин хил сэм давуулж наймаа хийж эхлэв. Хувьсгалын дараа болдог ёсоор хууль ч зөөлөрч ирлээ. Авиньон, Ним, Юзест байн байн хөдөлгөөн гарах учир өмнөд эрэг т муу хамгаалагдах боллоо. Бид засгийн газраас олгосон энэ түр амьсгалыг ашиглаж бүх эргийн оршин суугчидтай харилцаа тогтоов. Би ахыг минь алчихсанаас хойш тэр хотод очих дургүй байв. Иймээс бидэнтэй холбоотой байсан тэр буудлын эзэн өөрөө бидэн дээр хүрч ирээд өөрийнхөө буудлын нэгэн хэсгийг бидэнд зориулан нээв. Белгардаас Бокер орох зам дээр “Гаарын гүүр” нэртэй байгуулсан юм. бид Эг-Морт Мартиг ба Букийн замд дээр арваад газартай болж тэнд бараагаа нууж, хэрвээ хэрэг тохиолдвол өөрсдөө гаалийн

байцаагч, цагдаа нараас амь хорогддог байлаа. Ухаан самбаатай ажиллавал хил сэм давуулах наймааны ажил нь ашигтай байдаг юм. би тэр үед ууланд сууж байв. Хэрвээ гаалийн байцаагч цагдаа нарт баригдах юм бол мөрдөн байцааж эхэлнэ гэж давхар айж байлаа. Мөрдөн байцаана гэдэг өнгөрсөн явдлыг сонирхон үзнэ гэсэн үг, тэгэхээр миний өнгөрсөн үед гаалийн татвар өгөлгүй оруулж ирсэн ороомол навчин тамхи, торхтой спиртээс илүү чухал хэрэг олдох байлаа. Тиймээс баригдсанд орохноо үхсэн нь дээр гэж их л зоригтой ажиллаж, өөрийнхөө амины тухай хэтэрхий их санаачилга тавина гэдэг чинь түргэн шалмаг шийдвэрлэх ажилд ихээхэн саад болдогийг мэдэж авлаа. Хэрвээ амиа хайрлахаа больчихвол чи өөр хүнтэй адилгүй буюу эсвэл өөр хүмүүс чамтай адилгүй болчихдог юм. тэгж шийдсэн хүний хүч чадал нь их болж үйл ажлын нь талбай өргөн болно гэж ярив.

- Бертуччо та гүн ухаан ярьж эхлэх чинь! гэж гүн үгийг таслаад – Та ер нь амьдралдаа бүх юмнаас оролдож үзсэн хүн юм аа даа гэхэд,

- Уучлаарай гэгээн эзэн минь.

- Болно болно. Харин шөнийн арван цаг хагаст гүн ухаан ярих чинь арай л орой хэрэг шиг байна. таны ярьж буй гүн ухаан ч маш шударга зүйл байгаа учир надад өөр татгалзаад байх юм алга. Тэгэхдээ би гүн ухаан систем бүрийн тухай яриагүй юм шүү.

- Миний аялалууд улам ашигтай болж, улам их олз олох боллоо. Ассунта аж ахуйч хүн байсан учир бидний багахан хөрөнгө өслөө. Нэгэн удаа намайг замд гарч явах гэж байхад тэр надад “За чи яв. чамайг ирэхэд чинь нэг сонин юм бэлтгэсэн байя” гэж хэлэв.

Би түүнээс хичнээн шалсан боловч тэр надад хэлсэнгүй, тэгээд би яваад өглөө. Би сар хагас явлаа. Бид Луккаас шар тос, Ливорноос англи цаасан даавуу авав. Тэгээд маш амжилттай буулгаж их хожоотой худалдаад олз омогтой гэр гэртээ хүрч ирэв.

Би гэртээ ирээд хамгийн түрүүнд үзсэн юм бол, Ассунтын өрөөнд бусад юмнуудын дэргэд л гоё гэгдэх өлгий дотор найман сартай хүүхэд байхыг харав. Би баярлан хашхирав. Хааны прокурорыг алчихсанаас хойш орхисон хүүхдийн тухай бодол сэтгэлийг минь зовоож байв. Харин хүн алсан тэр явдалдаа огтхон ч харамсаагүй юм.

Хөөрхий Ассунта бүх зүйлийг тааварлан мэджээ. Ассунта намайг явсны хойгуур өнөөх хүүхэд ороосон даавууны хагасыг авч, асрамжийн газрын үүсэнд орхисон өдөр цагийг мартагчгүйн тулд тэмдэглэж аваад хүүхэд авахаар Парис оржээ. Цаадуул нь хүүхдийг огтхон ч татгалзалгүй өгчээ. Өлгий дотор унтаж байгаа тэр жаахан хүүхдийг хараад миний нүдний нулимс гарсан гэдгийг танд хэлэх ёстой.

“Ассунта чи сайн хүүхэн юм. Тэнгэр чамайг тэтгэж яваг” гэж түүнд хэлэв.

- Харин энэ чинь гүн ухааны шударга зүйл биш байна. Үнэндээ энэ чинь сүсэг бишрэлийн асуудал байна гэж гүн хэлэв.

- Гэгээн эзэн минь таны хэлдэг зөв гэж Бертуччо санаа алдан хэлээд,- Бурхан энэ хүүхдийг намайг залхаах зэвсэг болгон илгээжээ. Тийм жаахан байхаасаа эхлээд төрхгүй зан төлөвтэй болдог жишээ ер мэдэхгүй юм. бэр хүүхэн түүнийг ноёны хүү шиг л асрамжлан хүмүүжүүлсэн учир муу хүмүүжүүлснээс боллоо гэж хэлэхийн аргагүй юм. энэ бол хятад ваар саван дээр зурсан багацуул шиг тунгалаг цэнхэр нүдтэй, тэр нь сүүн цагаан царайд нь их л зохисон тун хөөрхөн жаал байв. Гагцхүү түүний алтлаг, дэндүү гялалзсан үс нь харц ба залирхаг инээмсэглэлд хачин жигтэй байдал төрхийг бий болгоно. Улаан шар үстэй хүмүүс эсвэл маш сайн хүмүүс байдаг, эсвэл маш муу хүмүүс байдаг. Гай болоход хуучны энэ үг Бенедеттод их л тохирч, зөвхөн муу зан төрх гаргаж өгч байлаа. Үнэндээ өсгөсөн эхийнх нь эрхлүүлэх явдал энэнд нь их тус боллоо. Манай хөөрхөй бэр таван бээл хол орших зах дээр очиж анхны жимс олж ирж өгдөг байтал, түүний© мэдэлд манай өөрийн цэцэрлэгийн туулайн бөөр б алим байдаг байсан боловч тэр жаал, хөршийнхөө хашааг даван хулгайлж авсан палийг зүрж байшингийн дээвэр дээрээс авсан гэнүүгийн туулайн бөөрийг хатаасан жимсийг илүүд үздэг байлаа.

Нэгэн удаа Бенедеттог зургаан настай байхад айлын Василио түрийвчнээс нэг луйдор алга болчихлоо гэж гомдол мэдүүлэн орж ирэв. Манай корсикт хулгай байдаггүй болохоор корсикчуудын заншлаах түрийвч ба үнэт зүйлээ хэзээ ч далд хийдэггүй байлаа. Би түүнийг мөнгөө муу тоолсон байх гэхэд тэр огт алдаагүй тоолсон хэмээн батлаад байлаа. Бенедетто энэ өдөр өглөө эрт алга болчихсон учир бид их л сэтгэл зовж байв. Тэгтэл үдэш сармагчин хөтөлсөөр хүрч ирэв. Түүнийг модноос уячихсан байхаар нь олж авлаа гэж хэлэв. Тэр золигийн жаал сармагчинтай болох юмсан гэж сар шахам үглэсэн юм. энэ тэнэг бодлыг Рольянд ирсэн илбэчин л түүний толгойд шингээсэн байлаа. Түүнд янз бүрийн юм хийдэг сармагчин байхыг Бенедетто үзээд их л хөөрчихсөн байсан юм.

“Би түүнд, манай ойд сармагчин байхгүй, ялангуяа гинжтэй сармагчин байхгүй. чи яаж үүнийг олсон үнэнээ хэл” гэв. Бенедетто өөрийнхөөрөө зүтгээд үнэн голоосоо биш харин хууран мэхлэх чадвараа харуулсан олон юм ярив. Тэгэхэд нь миний уур хүрээд, түүнийг айлгах гэтэл тэр ухраад,

“Чи намайг зодож болохгүй. Чамд тийм эрх байхгүй. Чи миний аав биш” гэв.

Би түүнээс үхтлээ нууж байсан тэр нууцыг хэн хэлчихсэнийг одоо хүртэл мэдээгүй байна. хүүхдийн зан чанарыг харуулсан энэ хариулт намайг бараг айлгаж, миний гар хүүхдэд хүрэлгүй аяндаа буув. Тэр дийл, энэ ялалт түүнд зориг оруулав. Энэ минутаас эхлээд Ассунтын мөнгө түүний дур хүслийг хангах бүх хэрэггүй зүйлд зарагдаж эхлэв. Ассунта түүнд учиргүй хайртай тул тэр татгалзаж чаддаггүй байлаа. Намайг Рольянод байхад ч бас гайгүй, харин яваад л өгвөл Бенедетто гэрийн эзэн болж хамаг ю болохоо байна. тэр дөнгөж арван нэгэн настай байсан боловч Басти ба Кортын хамгийн төрхгүй, арван найман насны харчуултай үерхэж байлаа. Түүний хэд хэдэн удаагийн сүрхий явдлаас болж бид засаг захиргаанаас сануулга авч байлаа.

Ямар нэгэн мөрдөн байцаалт надад маш хортой ул мөр үлдээж болох байсан тул миний сэтгэл зовж эхлэв. Тэр үед маш чухал ажилд явах хэрэгтэй байлаа. Би удаан бодсоны дараа Бенедеттог аваад явбал нэн гайгаас гарч болно гэж шийдлээ. Хил сэм давуулагчдын хатуун ширүүн амьдрал, онгоцон дээрх нарийн чанд сахилга бат, энэхүү бүр яахаа алдчихаагүй байдлыг нь засаж магадгүй гэж горьдов.

Тэгээд би Бенедеттог дуудаж, надтай хамт явахгүй юу гээд арван хоёр настай хүүхдийн хорхой хүрмээр янз бүрийн юм өгнө барина гэж амлав.

Тэр миний яриаг сонсож байснаа ярьж дуусахаар инээд алдан,

“Ах та солиоров уу! (овоо сайхан зантай үедээ намайг тэгж дууддаг байсан юм) Би өөрийн хийх юмгүй энэ сайхан амьдралаа т нарын аймшигт ажлаар солих гэж үү. Шөнө даарч, өдөр наранд шарагдаж, үргэлж нуугдаж явж, өчүүхэн төдий л цухуйвал суманд явагдахад бэлэн явж хэдэн мөнгө олох гэж үү! Надад хэчнээн л бол хэчнээ мөнгө байна. ассунта намайг гуйхаар л өгдөг юм. би тантай явбал тэнэг хэрэг болно гэдгийг ч харж байгаа шүү дээ” гэж хэлэв.

Би энэ булай үгэнд нь цочирдон гайхав. Бенедетто нөхөд дээрээ очоод, над уруу зааж намайг шоолон ярьж байхыг нь би холоос харав.

- Гайхам хүүхэд юм даа! гэж гүн шивнэхэд, Бертуччо үргэлжүүлэн,

- Ай хөөрхий, тэр миний хүүхэд ч юм уу ядахдаа хамаатан садан минь байсан бол түүнийг зөв замд оруулж болохсон. Эрхээ ухамсарлах нь хүч чадлыг өгнө. Алчихсан хүнийхээ хүүг зодно гэдэг бол түүнийг засаж залруулах бүх бололцоог үгүй хийж байв. Бид маргалдах үедээ дандаа л золгүй хүүхдийг хамгаалдаг бэрдээ сайн санааны зөвлөгөө өгдөг байв. Тэр надад зэгсэн мөнгө алга болоод байна гэж хэлэхэд түүнд өчүүхэн хөрөнгөө нуух газар хэлж өгөв. Миний тухайд гэвэл бүрэн шийдсэн байлаа. Бенедетто сайн уншиж, бичиж бодож чаддаг байлаа. Хэрэв дур нь хүрвэл долоо хоног сурах юмыг нэг хоногийн дотор сурдаг байлаа. Би түүнийг нэгэн сайхан өглөө л дагуулж гараад алсын аялалын хөлөг онгоцонд бичиг хэрэг хөтлөгчөөр оруулж, ахмадад нь захиж өгье гэж шийдлээ. Тэгвэл түүний амьдрал нь бүхлээрээ өөрөөс нь шалтгаалах болно.

Би ингэж шийдээд Франц орохоор явав. Энэ удаа бидний бүх ажил Лионы буланд дуусах ёстой байлаа. Мянга найман зуун хорин есөн он болж байсан учир энэ ажил улам нарийн төвөгтэй болсон байлаа. Амгалан тайван тогтоогдож, хил хязгаарын харуул манаа ч улам чангарсан байлаа.

Анхандаа хамаг ажил бүтэмжтэй явж байв. Бид хориотой бараа нуусан хоёр давхар ёроолтой завиа Бокэрээс Арль хүртэлх үргэлжилсэн Зоно голын эрэг дагуу байгаа олон завинуудын дунд зогсоосон байлаа. Бид тэнд очоод хориотой бараагаа буулгаж бидэнтэй холбоо харьцаа бүхий хүмүүс, буурчийн газрын эздээр дамжуулан хо оруулж, агуулахад нь хураадаг байлаа. Бидний амжилт болгоомжлох явдлыг мартуулсан ч юм уу, эсвэл бидний аль нэгэн этгээд урваж мэдэгдсэн ч юм уу, нэгэн өдөр оройн таван цагийн хирд хоолоо олохоор цуглараад байтал манай жижигхэн туслах далайчин сандран гүйж ирээд бидний зүг гаалийн байцаагч нар ирж явна гэдгийг мэдэгдэв. Үнэдээ Роны эргээр бөөн бөөнөөрөө явдаг тэр баг биднийг айлгасангүй, харин бидэнд мэдэгдэхгүй ирж явна гэдэг хүүхдийн үг биднийг айлгав. Бид ухасхийн босцгоосон боловч хожигджээ. Нэгжихээр сонгож авсан байж таарах манай завийг тал бүрээс нь бүсэлжээ. Гаалийн байцаагч нарын дотор цагдаа байхыг хараад хулчийлаа. Цэргийн хүнийг хараад айдаггүй хирнээ тэднийг харахаараа л айдаг байв. Би ачааны нүхээр дамжин ус уруу харайн орж, усан доогуур хөвж, хааяа нэг амьсгаа авсаар яваад Роныг Бокэрээс Эг-Морт орсон сувагтай холбосон татуургад мэдэгдэлгүй хүрч очив. Би энд хүрмэгц өөрийгөө аврагдсаныг мэдээд суваг

даган хөвөв. Ийм маягаар хөвсөөр сувагт хүрэв. Би энэ замыг учиртай сонгосон юм. Бельградаас Бокэр орох зам дээр багахан буурчийн газар нээсэн хүнийг танина гэдгээ гэгээн эзэн танд хэлсэн билээ.

- Сайн санаж байна. би андуураагүй бол энэ хүнлэг хүн, та нарын сүлбээтэн байсан гэсэн байх аа? гэж гүн хэлэв.

- Тийм тийм, түүнээс долоон жилийн өмнө тэрээр буурчийн газраа Марсельд сайван байгаад хоосорч, өөр ажлаар аз жаргалаа турших гэсэн нэгэн хүнд шилжүүлэн өгсөн юм. түрүүчийн эзэнтэй холбоотой байсан нь дараагийн нь эзэнтэй үргэлжилсэн нь мэдээж хэрэг. би тэнд амь хорогдох газар олно гэж найдаж очсон юм.

- Тэр хүнийг хэн гэдэг байсан бэ? гэж Бертуччогийн яриаг гүн дахин сонирхон асуув.

- Гаспар Кадрусс Карконта суурингаас эхнэр авсан учир бид эхнэрийг нь түүгээр дууддаг байсан юм. хөөрхий эмэгтэй намгийн халуун хумх өвчтэй учир алгуурхан тураалдаа орж байв. Кадрусс өөрөө дөчин тав орчим насны чийрэг эр. Хэрэгтэй цагт зоригтой, золбоотой хүн болохоо бидэнд нэг бус удаа харуулсан юм.

- Та энэ явдлаа хэзээ болсон гэж ярив? гэж гүн асуулаа.

- Гэгээн эзэн минь мянга найман зуун хорин есөн онд.

- Хэдэн сард вэ?

- Зургадугаар сард.

- Сарын сүүлээр үү, эхээр үү?

- Зургадугаар сарын гуравны үдэш байсан.

- Үгүй ер гэж гүн дуугараад,

- Мянга найман зуун хорин есөн он» зургадугаар сарын гурван... Ярь ярь гэв.

- За тэгээд би Кадруссын дүр хоргодохыг гуйх гэсэн юм. Бид таван цагт ч зам уруу харсан гол хаалгаар нь ордоггүй байсан учир, энэ удаа ч гэсэн заншсанаа өөрчлөхгүйгээр шийдэж цэцэрлэгийн хашаа давж, намхан тослог мод, зэрлэг удамборын моднуудын хоорондуур мөлхөн, буудалд ямар нэгэн аянчин байх вий хэмээн болгоомжлон залгаа байшинд нь хүрч очив. Би тэнд нэг биш удаа хамгийн сайхан хөнжилд унтсанаас ч илүү тухтай унтаж байсан юм. энэ барилга нь доод давхрын тасалгаанаас зөвхөн банзан хаалтаар тусгаарлагдах бөгөөд биднийг ирсэнээ мэдэгдэж байг гэж зориуд үлдээсэн завсартай байв. Би хэрвээ Кадруссын дүр хүн байхгүй байвал ирсэнээ мэдэгдэж гаалийн байцаагч нар ирэхэд тасалчихсан хоолоо гүйцээн идэж, дахин Роны эрэг рүү эргэн очиж тэнд үлдээсэн завь ба хүмүүс юу болсныг мэдэхийг хүсэв. Тэгээд залгаа байшин сэм мөлхөв. Яг тэр үед Кадрусс нэгэн танихгүй хүнтэй хамт гэртээ ирж байсан болохоор ингэсэн маань сайн болжээ. Амьсгаагаа хурааж буурчийн газрын эзний нууцыг сонсох гэсэндээ биш өөр аргагүй болсон учир дуугүй хүлээн хэвтэв. Ийм явдал олон тохиолдсон билээ. Кадрустай

ирсэн хүн Өмнөд Францынх лав биш байлаа. Эн бол үнэт эдлэл худалдахаар Бокэрын яармагт ирдэг худалдаачин байв. Яармагт европын өнцөг булан бүхрээс худалдаачин ба худалдан авагчид ирж заримдаа зуу, зуун тавин мянган франкийн наймаа хийдэг байлаа. Кадрусс түрүүлэн хурдан алхалж орж ирэв. Дараа нь доод давхрын тасалгаа дандаа л хоосон байдлаараа хүн амьтангүй зөвхөн ганц муу нохой нь харж хамгаалан хэвтэж байгааг хараад эхнэрээ дуудаж,

- Хөөш, Карконтаа өнөө лам чинь биднийг хуурсангүй, жинхэнэ очир эрдэнэ гэнэ гэж хашхирав. Дээд давхраас баярлах дуу сонстож, өвдөж суларсан хөлийн аяар шатны гишгүүр хяхналаа.

- Чи юу гэнэ ээ? гэж тэр асуув.

- Тэр очир эрдэнэ жинхэнэ гэнэ. Парисын эрдэнийн зүйл наймаалдаг энэ хүн манай энэ очир эрдэнийг тавин мянган франкаар худалдаж авъя гэж байна. харин тэгэхдээ энэ чулууг үнэхээр манай юм гэдгийг мэдэх хүсэлтэй байгаа юм байна. Чи бас миний ярьсан шиг тэр чулууг ямар гайхалтай байдлаар бидний гарт орж ирсэнийг яриарай. Харин одоо эрхэм та суу, их бүгчим байгаа болохоор танд сэрүүцэх юм авчирч өгье. Эрдэнэсийн наймаачин буурчийн газрын дотор талыг анхааралтай ажиглан ноёны хуурцагт байхаар очир алмасыг өөрт нь худалдах гэж байгаа хүмүүсийн ядуу зүдүү байдлыг харав. Тэгээд тэр хүн нөхрийг нь байхгүй байгааг ашиглан эхнэр нөхөр хоёрын яриа хэрхэн тохирохыг үзэхээр шийдэв бололтой.

“Авгай минь ярь ярь” гэв.

“Ай бурхан минь. Энэ бол тэнгэрийн хишиг, бид ийм юм болно гэж бодоо ч үгүй байсан улс. Эрхэм та бод л доо. Миний нөхөр мянга найман зуун арван дөрвөн онд ч юм уу, мянга найман зуун таван онд ч юм уу Эдмон Дантес гэдэг далайчЁнтай найз байжээ. Тэгтэл Кадруссын мартчихсан тэр хөөрхий амьтан Кадруссыг санаж, үхэхдээ таны өгсөн тэр очир эрдэнийг өгсөн байна” гэж Карконта ярив.

“Тэр хүн яаж доржпаламыг олж авсан юм бол? Эсвэл шоронд орохоос нь өмнө түүнд байсан юм уу?” гэж наймаачин асуув.

“Үгүй эрхэм минь. Тэр хүн шоронд байхдаа нэг их баян англи хүнтэй танилцсан юм гэнэ. Тэгээд өвчтэй байхад нь Дантес төрсөн ах шиг ээ асран байжээ. Англи хүн шоронгоос гарахдаа Дантесын ачийг бодож энэ очир эрдэнийг өгсөн юм гэнэ лээ. Тэгтэл хөөрхий Дантесын аз дутаж шорондоо үхэж, амьсгаа хураахын өмнө энэ чулууг бидэнд өгөөрэй гэж өглөөний авчирч өгсөн ламд гэрээслэн захиж орхижээ”.

“Энэ авгай ч мөн адил ярьж байна. анх харахад үнэмшимгүй боловч энэ үнэхээр гайхам юм” гэж наймаачин аман дотроо шивгэнээд – “Тэгвэл одоо тохироогүй байгаа үнийнхээ тухай ярих л үлдэж байх шив” гэж чангаар хэлэв.

“Яалаа гэж тохироогүй гэж. миний хэлсэн үнээр авна гэдэгт итгэж байна шүү” гэж орж ирсэн Кадрусс хэлэхэд, наймаачин зөрж,

-“Би танд дөчин мянга гэж үнэ өгсөн шүү дээ” гэв.

“Дөчин мянга ий! Тэгвэл бид ийм үнээр өгөхгүй. Лам бидэнд энүүний хүрээг тооцохгүйгээр тавин мянга хүрэн гэсэн юм шүү” гэж Карконта дургүйцэв.

“Тэр ламыг чинь хэн гэдэг юм бэ?”

“Лам Бузони”

“Гадаадын хүн үү?”

“Мантуу мужаас гаралтай Итали хүн байх аа”

“Алив, тэр очир эрдэнээ, чулууг анх нэг хараад андуурах ч явдал байдаг” гэж наймаачин хэлэв.

Кадрусс хар илгэн савтай нэг юм гаргаж ирээд наймаачинд өгөв. Карконта багахан самрын хэмжээтэй очир эрдэнийг хараад нүд нь улайран шунахыг би одоо ч сайн санаж байна.

- Ингэхэд хажуугаас нь сэм сонссон эрхэм та энэ бүхний тухай юу гэж бодов? Та энэ үлгэрт үнэмшив үү? Гэж гүн асуув.

- Үнэмшсэн, гэгээн эзэн минь. Би Кадруссыг муу хүн гэж боддоггүй, гэмт хэрэг, хулгай хийчихгүй хүн гэж боддог байсан юм.

- Эрхэм Бертуччо таны амьдралын туршлагаас чинь илүү зүрх сэтгэлээр чинь уян зөөлөн гэдгийг мэдэж болох юм. та тэр ярьсан Эдмон Дантес гэдгийг мэдэх үү?

- Үгүй, гэгээн эзэн минь, би түүнээс ч өмнө, хойно я тэр хүний тухай юу ч дуулаагүй. Харин намайг Нимийн шоронд байхад ирсэн Бузони ламтангаас дахин нэг сонссон юм.

- За цааш нь ярь ярь .

- Тэгээд эрдэнэсийн наймаачин Кадруссын гараас бөгжийг нь авч, хармаанаасаа жижигхэн төмөр чимхүүр, зэр дэнс гаргаж ирээд, дараа нь очир эрдэнийг хүрээлсэн алтан бөгжийн тээглүүрүүдийг тэнийлгэж чулууг нь аваад дэнсэн дээрээр их л болгоомжлон тавив.

“Би дөчин таван мянган франк өгье. Нэг ч зоос илүү өгөхгүй шүү. Тэгээд ч энэ бол доржпаламын хамгийн дээд үнэ. Би тийм л мөнгөтэй гарсан”.

“Тэр хамаагүй ээ. би тантай хамт Бокэрт очоод үлдсэн таван мянгыг нь аваад ирье” гэж Кадрусс хэлэхэд эрдэнэсийн наймаачин Кадрусст бөгж ба очир алмазыг нь эргүүлэн өгч,

“Үгүй, үгүй үүнээс илүү өгч чадахгүй. Би анх харахдаа чулууд цав гарсныг харалгүй ийм үнэ өгчихсөндөө харамсаж байна. гэвч одоо яая гэх вэ. Би хэлсэн үгнээсээ буцахгүй. Дөчин таван мянган франк л гэж хэлсэн, энэ тоогоо өөрчлөхгүй” гэж хэлэв.

“За тэгвэл ядахдаа чулуун шигтгээг нь буцаагаад шигтгэчих дээ” гэж Карконта ууртайяа хэлэхэд, эрдэнэсийн наймаачин,

“Таны хэлдэг зөв” гэж хэлээд чулууг нь буцаан шигтгэв.

“Тэгвэл яах вэ. өөр хүнд л худалдаж орхиё” гэж Кадрусс хуурцгийг халаасандаа хийнгээ аман дотроо бувтнахад эрдэнэсийн наймаачин,

“Тийм ээ, харин өөр хүн бол над шиг ийм цааштай, нааштай байхгүй л болов уу. таны надад хэлсэн үгэнд өөр хүн үнэмшихгүй л байх даа. таны зэргийн байдалтай хүнд тавин мянган франкийн үнэтэй бөгж байна гэдэг ерийн хэрэг биш. Тэгэхээр тэр хүн чинь дээш нь мэдэгдэж лам Бузонийг эрэх хэрэг болно. Хоёр мянган луйдорын үнэтэй доржпалам тарааж явдаг тийм ширээт ламуудыг эрж олно гэдэг амар хэрэг биш. үнэн мөний шүүх түүнийг олохоосоо өмнө таныг шоронд хийнэ. Тэгээд таныг ямар ч буруугүй гэж үзвэл суллан тавина. Харин эрдэнийн чулуу чинь алга болдог ч юм уу, эсвэл тавь юм уу тавин таван мянган франк ч хүрч мэдэх энэ чулууны чинь оронд гурван франкийн үнэтэй хуурамч очир эрдэнэ өгчхөж мэдэх л байх. Ийм л эгзэгтэй наймаа шүү дээ” гэж хэлэв.

Кадрусс эхнэр хоёр бие биенийгээ харав.

“Үгүй дээ, бид таван мянган франкаа сул хаях улс биш” гэж Кадрусс хэлэхэд, эрдэнэсийн наймаачин:

- Найсаг нөхөр минь, таны л хэрэг. харин би мөнгөө бэлэн аваад ирсэн шүү гэж хэлэв.

Тэгээд нэг хармаанаасаа гялалзсан алтан зооснууд, нөгөөгөөсөө боодолтой бөөн мөнгөн дэвсгэрт гаргав.

Тэгэхэд Кадруссын сэтгэлд хүнд тэмцэл явагдаж буй бололтой. Гартаа эргэлдүүлэн байгаа элгэн савтай жижиг зүйл, түүний харааг татаж байгаа их мөнгөний дэргэд юу ч биш бололтой.

Кадрусс эхнэр рүүгээ эргэж,

“Чи юу гэж бодож байна гэж” асуухад эхнэр нь,

“Өг өг. Цаадах чинь эрдэнийн чулууг авалгүй буцвал биднийг очоод ховлочихож мэднэ. Тэгээд ч ер нь үнэн юм хэлж байна. бид ширээт лам Бузонийг олж чадах үгүйг хэн мэдэх билээ” гэж хэлэв.

“За яах вэ, тэгвэл тэрүүгээр чинь больё. Очир эрдэнийг дөчин таван мянган франкаар ав. Харин эхнэр минь алтан зүүлт, би хос мөнгөн гархи авмаар байна” гэж Кадрусс хэлэхэд, наймаачин дурдсан зүйл бүхий урт хайрцаг өврөөсөө гаргаж ирээд,

“Ав ав. Би наймаанд гар татдаггүй хүн шүү. Дуртайгаа л ав” гэв. Эхнэр нь тав зургаан луйдорын бололтой алтан зүүлт, нөхөр нь арван тав орчим франкийн хос гархи авав.

“Таны сэтгэлд тохирсон байх гэж найдаж байна” гэж наймаачин хэлэхэд Кадрусс аман дотроо бувтнан,

“Лам үүнийг тавин мянган франк хүрнэ ээ гэж хэлсэн л юм даа” гэв.

“За за яах вэ! Яасан зовлонтой хүн бэ. би дөчин таван мянган франк, жи«д хоёр мянга таван зуун луйдорын орлого өгч байхад бас л ханахгүй байх юм. би ч гэсэн ийм орлогоос буцахгүй хүн юм даг” гэж хэлээд Кадруссын гараас бөгжийг авахад,

“Нөгөө дөчин таван мянган франк, мөнгө чинь хаана байна?” гэж Кадрусс сөөнгөтөн асуув.

“Энд байна аа” гэж эрдэнэсийн наймаачин арван таван мянган франк алтаар нь, гучин мянгыг цаасаар нь тоолж ширээн дээр тавив.

“Базаарай би дэн асаагаад орхиё. Бүрэнхий болчихлоо. Андуурахад амархан шүү” гэж Карконта хэлэв. Нээрээ ч тэднийг маргасаар байтал шөнө болж хажуугаар нь цахилгаантай бороо орж эхлээд хагас цаг гаруй болж байлаа. Алсад тэнгэр дуугарах дуу бүдэг сонстох боловч эрдэнэсийн наймаачин, Кадрусс, Карконта гурвын аль нь ч түүнийг үл анхааран ганцхан л бие биеэ хожиход бүх сэтгэлээ тавьчихсан байв. Би ч гэсэн энэ их мөнгө цаасыг хараад сэтгэл хачин болж , энэ бүхнийг зүүдэндээ үзэж байгаа юм шиг яг л зүүд шиг хөдөлье гэсэн ч хөдөлж болохгүй байлаа.

Кадрусс алтан зоос мөнгөн тэмдэгт хоёрыг хоёр дахин тоолоод, эхнэртээ өгөхөд тэр нь дахин хоёр дахин тооллоо.

Тэр завсар эрдэнэсийн наймаачин дэнгийн гэрэлд очир эрдэнийн бөгжөө эргэлдүүлэхэд , ширүүн бороо зөгнөн цонхны цаана гялалзаж байгаа аянга цахилгааныг мартуулам хурц гэрэл цацран байлаа.

“За яав, гүйцэд байна уу?” гэж наймаачин асуухад Кадрусс эхнэртээ,

“Гүйцэд байна. карконта чи яваад түрийвч, бас нэг хүүдий олоод ир дээ” гэж хэлэв.

Карконта шүүгээ рүүгээ очиж хуучирч элэгдсэн түрийвч олж ирэв. Тэгээд дотроос нь хэдэн шарлаж хуучирчихсан хэдэн захидал гаргаад оронд нь цаасан мөнгөө хийж орхиод, бас нэг хүүдий авчрахад дотор нь зургаан ливрийн хоёр гурван экко байсан нь хөөрхий хоёрын байгаа хөрөнгө бололтой.

“За тэгэхээр та биднээс арваад мянган франкийг минь сул авчихсан ч гэлээ хамт оройн зоог барихгүй юу? Би чин сэтгэлээсээ хэлж байгаа юм шүү” гэж Кадрусс хэлэв.

“Баярлалаа танд, одоо их орой болсон байх ёстой. Бокэр уруу явалгүй болохгүй. Эхнэр маань сэтгэл зовж байгаа гэснээ цагаа харж - Чөтгөр ав. Ес болох гэж байна. шөнө дундаас нааш гэртээ хүрэнгүй нь. Баяртай найзууд аа, хожим

танайхаар Бузони ламтан шиг хүн ирвэл намайг санаарай” гэж эрдэнэсийн наймаачин хэлэхэд,

“Яармаг ирэх долоо хоногт хаагдах болохоор та долоо хоногийн дараа Бокэрт байхгүй болчихно шүү дээ” гэж Кадрусс хэлэв.

“Тийм ээ гэсэн ч надад “Парис, эрхэм Жоаннес, Палле-Рояль Пьерийн гудамж дөчин тав” гэж захидал бичээд явуулчихаарай. Хэрвээ хэрэг болбол би дороо л хүрээд ирэмз”.

Тэнгэр дуугарч цахилгаан цахихад бараг дэнгийн гэрэл ч үзэгдэхгүй боллоо.

“Пөөх, та ийм байхад яаж явах юм бэ?” гэж Кадрусс хэлэхэд,

“Би тэнгэрийн дуунаас айдаггүй” гэж наймаачин хариулав.

“Яармагийн үеэр, их замаар сэлгүүцэн явдаг дээрэмчдээс айхгүй юу?” гэж Карконта хэлэхэд, Жоаннес хариу болгон,

“Хулгайчдын тухайд гэвэл тэдэнд зориулсан эм нада бас бий” гэж хэлэхэд дүүрэн сумтай хоёр жижигхэн гар буу гаргаж харуулаад “Миний хуцдаг ч урдаг ч нохой энэ дээ. кадрусс гуай таны очир эрдэнэсэд шунасан эхний хоёр хүнд энэ болно” гэж хэлэв.

Эхнэр нөхөр хоёр бие бие рүүгээ хачин эвгүй харав. Тэр хоёрын санаанд нэгэн зэрэг аймшигт бодол төрсөн мэт ажгуу.

“За тэгвэл сайн яваарай” гэж Кадрусс хэлэхэд,

“Баярлалаа” гэж наймаачин хэлээд хуучин хайрцаг түшүүлэн тавьсан таягаа аваад гарч одов.

Түүнийг хаалга онгойлгонгуут нь хүчтэй салхи орж ирэн арай л дэнг унтраачихсангүй.

“Энэ тэнгэрийн байж байгааг. Гэтэл би хоёр бээр газар явган явах хэрэгтэй байдаг. Мөн таарав аа!”

“Хоноод яв хоноод яв” гэж Кадрусс хэлэхэд Карконта чичирсэн хоолойгоор,

“Тэг тэг, хоноод яв. Бид таныг тохь алдуулахгүй байхыг хичээе” гэж хэлэв.

“Яагаад ч болохгүй. Би шөнө дунд гэхэд Бокэрт очсон байх хэрэгтэй. За баяртай!”

Кадрусс аяархан алхалж хаалга уруу очив.

“Усан галав юүлж байна даа” гэж наймаачин хаалганы цаанаас хэлээд – би хаашаа эргэх вэ, баруун уу, зүү үү? гэхэд Кадрусс,

“Баруун тийшээ, та төөрөхгүй. Замын хоёр хажуугаар таримал модтой” гэж хэлэв.

“Наад хаалгаа хаагаач, тэнгэр дуугарч цахилгаан цахиж байхад хаалга онгорхой байлгаж болдоггүй юм” гэж Карконта хэлэв.

“Тийм ээ үнэн. Гэрт мөнгө байхад уу?” гэж Кадрусс хариулаад түлхүүрээ хоёр эргүүлж цоожлов.

Тэгээд шүүгээ рүүгээ очиж хүүдийтэй алт түрийвчтэй ц асан мөнгөө авчирч гурав дахиа тоолов. Дэнгийн бүдэг гэрэлд харагдаж буй ийм шунахай царайг би урьд нь хараагүй юм. Ялангуяа эмСгтэйных нь царай бүр жигшим муухай болж байсан юм. хүүхний угийн чичирдэг нь улам хүчтэй болж, цонхигор цагаан царай нь үхээрийнх шиг болж, хөнхийсэн нүд нь улайран эргэлдэнэ.

“Чи түүнийг яах гэж энд унтаад яв” гээд байв гэж хүүхэн аяархан асуухад,

“Яахав дээ. Бокэр руу үйлээ үзэж явахаар гэж бодсон юм” гэж нөхөр нь татвалзан хэлэв.

Тэгэхэд хүүхэн тийм гэж хэлэхийн аргагүй хачин байдлаар

“Аа тийм бий. Би өөр учиртай юм байх гэж бодсон юм” гэхэд,

“Эхнэр минь эхнэр минь! Чамд хаанаас ийм санаа төрөв. Тэгээд үүнийгээ дотроо хадгалаад байхгүй яагаа вэ?” гэж Кадрусс дуу алдан хэлэв. Карконта хэсэг зуур дуугүй байснаа,

“Юу ч гэсэн чи эр хүн биш юм” гэхэд, Кадрусс,

“Яагаад тэр билээ” гэж асуув.

“Хэрэв чи эр хүн байсан сан бол тэр эндээс явахгүй байсан даа”

“Эхнээр”

“Эсвэл Бокэр хүрэхгүй байсан”

“Эхнээр”

“Зам мурийдаг. Тэр өөр зам мэдэхгүй. Сувгийн дагуу тийшээ шуудхан очих зэрэг бий.”

“Эхнээр, чи тэнгэрийг хилэгнүүлж байна. Тээр сонсож байна уу...”

тасалгаан дотор цахилгааны цэнхэр туяа татаж, түүний хамт тэнгэр тасхийн дуугараад дуу нь алгуурхан замхрах нь саях нүгэлт байшингаас холдохоос дургүйцэн мэт байлаа. Карконта залбираад,

“Тэнгэр минь!” гэв.

Тэгтэл тэнгэрийн дууны дараах эвгүйцэм нам гүмийн дунд хаалга логших чимээ сонстов.

Кадрусс эхнэр хоёр цочин бие бие өөд харлаа.

“Хэн бэ?” гэж хашхираад Кадрусс босож ширээн дээр тарааж хаясан мөнгөө цуглуулан хоёр гараараа дарав.

“Би байна аа!” гэж дуу гарав.

“Би гэж хэн бэ?”

“Би л байна даа! Эрдэнэсийн наймаачин Жоаннес!”

“Харж байна уу! Нүгэлтэй юм ярилаа гээд байсан чинь!”... гээд Карконта бузар булай царайгаар инээмсэглэн, -“Тэнгэр өөрөөр түүнийг бидэн рүү буцаалаа” гэж хэлэв.

Кадрусс царай нь зэвхийрэн бие нь чичрэн сандал дээрээ суун тусав. Харин Карконта босож чанга чанга алхлан очиж хаалга тайлан,

“Эрхэм хүндэт Жоаннес ор ор” гэж хэлэхэд бороонд шал норсон эрдэнэсийн наймаачин,

“Чөтгөр л намайг өнөөдөр Бокэрт очуулахгүй саад болоод байна. оргүйд дээр бол охинтой нь дээр гэдэг. Та намайг хүндэлж зочилъё гэснийг чинь хүлээн авч, танайд хонохоор ирлээ” гэж хэлэв.

Кадрусс духныхаа хөлсийг арчин ямар нэгэн юм аман дотроо хэлэв. Карконта эрдэнэсийн наймаачныг оруулаад түлхүүрээ хоёр эргүүлж цоожлов.

VII. Цусан бороо

Эрдэнэсийн наймаачин орж ирээд тасалгааг ажиглан харав. Гэвч түүнд сэжиг төрүүлэх ч юм уу сэжиг төрсөн байвал түүнийг нь лавшруулах зүйл огтхон ч байсангүй.

Кадрусс алт мөнгөө хоёр гараараа дарсан хэвээрээ л байв. Харин Карконта зочиндоо чадлынхаа хэрээр найрсаг инээж байв.

“Намайг явсан хойно баялгаа дахин тоолж байгааг бодоход буруу тоолоод авчхаагүй байгаа гэж айсаар л байна уу?” гэж эрдэнэсийн наймаачин хэлэхэд, Кадрусс,

- “Хаанаас даа. Энэ баялаг огт санамсаргүй олдсон болохоор л бид аз завшаандаа итгэж чадахгүй байгаа юм. Хэрвээ бидний өмнө эд мөрийн баримт нь байхгүй бол үүнийг зүүд л гэж бодохоор байгаа юм” гэж хэлэв.

Эрдэнэсийн наймаачин инээмсэглэж,

“Танайд өөр хүн байхгүй биз?” гэж асуухад,

“Үгүй, манайд хүн хонодоггүй юм. хот хүртэл ойрхон болохоор хэн ч манайд хонодоггүй юм” гэж Кадрусс хариуллаа.

“Тэгвэл би та нарт тээр болох юм биш биз?”

“За хаанаас даа, Эрхэм минь! Өчүүхэн ч тээр болохгүй” гэж Карконта тун ч найрсгаар хэлэв.

“Та нар намайг хаана унтуулах юм бэ?”

“Дээд давхрын тасалгаанд”.

“Үгүй тэр чинь, та хоёрын тасалгаа биз дээ?”

“Энэ хамаагүй. Хажуу талын өрөөнд нь илүү ор бий”.

Кадрусс эхнэр рүүгээ гайхан харав.

Эрдэнэсийн наймаачин задгай зуухны галд ээн дуу аялан эхлэхэд Карконта зочноо хувцсаа хатааг гэж тэвэр мөчир авчирч галд хаялаа.

Тэр зуур Карконта ширээний өнцөгт алчуур дэлгэн, хомсхон хоолныхоо үлдэгдлийг, хэдэн өндөгтэй хамт авчирч тавив.

Кадрусс дахиад л цаасан мөнгөө түрийвчиндээ, алтан зоосоо хүүдийндээ хийж цөмийг нь шүүгээндээ хийчихлээ. Тэгээд бодолд автаж баргар царайлан тасалгаан дотуур хойш урагшаа алхалж, задгай зуухны дэргэд зогсож хувцсаа хатаах гэж тал тал руугаа эргэж байгаа бөөн уур суунаглуулсан наймаачныг байн байн харна. Карконта нэг шил дарс авчирч ширээн дээр тавиад

За одоо оройн зоог зооглож болно гэж хэлэхэд,

А , та нар өөрсдөө! гэж Жоаннес өөдөөс нь асуулаа.

“Би юм идэхгүй ээ” гэж Кадрусс хариулахад, эхнэр нь яаран - Бид өдрийнхөө хоол»г их орой идсэн гэж нэмж хэллээ.

Тэгвэл би ганцаараа идэх болох нь ээ? гэж эрдэнэсийн наймаачин асуухад, Карконта үнийг нь төлөөд идэж байгаа зочдод ч тэгж найрсаг байдаггүйгээр,

Бид танд үйлчилж байна гэж их л бэлхэн байгаа янзтай хариулав.

Кадрусс байн байн эхнэр өөдөө хялавхийн харна. Тэнгэр дуугарч цахилгаан гялалзсаар л байлаа.

“Дуулж байгаа биз? таны ирсэн чинь зөв болж” гэж Карконта хэлэхэд, наймаачин,

“Энэ яах вэ, намайг хоол идэж байх хооронд тэнгэр онгойвол явна даа” гэв.

“Энэ чинь баруун хойд зүгийн салхи болохоор маргаашнаас нааш намдахгүй” гэж Кадрусс толгойгоо сэгсрэн хэлэв. Тэгээд хүндээр санаа алдлаа.

Эрдэнэсийн наймаачин ширээнд ирж суугаад,

“Одоо яая гэх вэ. Замд яваа улсад л муу юм болж байна даа” гэж хэлэхэд

“Тийм ээ тэдэнд тавгүй шөнө боллоо” гэж Карконта хариулав.

Эрдэнэсийн наймаачин зооглож эхлэхэд Карконта анхааран эзэгтэйгээс шаардах бүхнээр үйлчиллээ. нөгөө яншаа олон үгтэй хүүхэн маань анхаарал тавих, эелдэг аашлахын үлгэр жишээг үзүүлж гарав. Хэрвээ наймаачин түүнийг урьд нь мэддэг байсан бол ааш зан нь ингэж хувирсныг хараад лав гайхах байсан биз. кадруссын тухайд гэвэл дув дуугүй өрөөн дотуур алхалж зочноо харахаас ч зайлсхийж байв. Эрдэнэсийн наймаачинг зооглож дуусахад Кадрусс хаалга онгойлгон

“Бороо намдаж байх шиг байна” гэхэд түүний ташаарчээ гэснийг батлах мэт байшин доргитол тэнгэр дуугарч хаалгаар салхи бороо орон ирж дэнг унтраачихав. Кадрусс хаалгаа хааж эхнэр нь шатаж дуусаж байгаа нүүрсний цогоор дэнгээ асаав.

“Та ядарсан байх, би цэвэр даавуу тавиад ор засчихсан, явж тайван нойрс” гэж Карконта наймаачинд хэлэв.

Жоаннес бороо намдаж магадгүй гэж хэсэг зуур хүлээснээ, бороо улам ширүүсэж байгааг мэдээд гэрийн эздэд тайван нойрсохыг ерөөгөөд дээшээ гарлаа.

Тэр миний толгой дээрх банзаар өгсөхөд түүний хөлийн доор банз хяхнах сонстлоо.

Карконта түүний хойноос шунал шүглэсэн харцаар харж, харин Кадрусс түүний хойноос эргэж ч харсангүй.

Миний нүдний өмнө болж байсан энэ явдлыг би дараа нь нэхэн санахад надад төдий л гайхалтай санагдаагүй юм. надад үнэмшмээргүй санагдаж байсан очир эрдэнийг эс тооцвол бүх зүйл ердийн бөгөөд нэг нь нөгөөгөөсөө уялдан гарсан байлаа. Би үхтлээ ядарсан байсан боловч бороо намдахад явах гэж байсан болохоор хэдэн цаг дуг хийгээд шөнө дунд эндээс зайлан явахаар шийдэж билээ. дээд давхарт наймаачинг унтах гэж тухлан хэвтэж байгаа дуулдана. Ор дуугарч тэр хэвтээд өглөө.

Миний нүд анилдаж, тэгээд ч сэжиг төрөх өчүүхэн ч юм байгаагүй учир унтахгүй байх гэж тэмцээд байх ч хэрэггүй байлаа. Тэгээд зэргэлдээ тасалгаа руу сүүлийн удаа харлаа. Кадрусс хөдөөгийн буудлуудын сандал болдог урт вандан дээр сууж байлаа. Цаашаа хараад сууж байсан учир би царайг нь харж чадсангүй. Ерөөсөө ч хоё° гараараа толгойгоо бариад сууж байсан болохоор наашаа хараад сууж байгаа ч царай нь нада харагдахгүй байлаа.

Карконта дуугаралгүй түүнийг хэсэг ажиглан байснаа, өөдөөс нь харж суув.

Энэ үед унтарч байсан галд шатаагүй нэгэн мөчир дүрсхийн харанхуй тасалгаа овоо гэрэлтээд ирэв. Карконта нөхрөө ширтсэн хэвээр. Цаадах нь хөдлөх ч үгүй, нөгөө л хэвээрээ суугаад байхаар, эхнэр нь чөгчийсэн хуруугаараа духанд нь хүрээд авав.

Кадрусс цочлоо. Карконтын уруул хөдлөх шиг надад санагдаж билээ. гэсэн ч хүүхэн дэндүү аяархан дуугарсан юм уу эсвэл миний мэдрэхүй нойронд мансуурсан юм уу алин боловч л түүний дуу сонстсонгүй. Миний нүд бүрхэж, зүүдэлж байгаа юм шиг боллоо. Тэгээд зовхи анилдаж орчин тойрныг ухаарахаа болив.

Би их л бөх унтаж байтал буу дугарч залгуулаад хүн хашхирах дуунаар сэрж билээ. толгой дээр гуйвлах хөлийн чимээ гарч, яг миний дээр нэг хүнд юм унав. Би бүрэн сэрсэнгүй. Нэгэн газар тэмцэл болж байх шиг гинших дуу сонсогдож, бүдэг хашхирах дуу гарна. Хашхирах сүүлийн дуу нь бусдаасаа илүү удаан, сүүлдээ гиншин ёолох болж хувирсан учир намайг бүрэн сэрээчихлээ. Би тохойлдож өндийгөөд нүдээ нээсэн боловч харанхуйд юу ч олж харсангүй. Харин духаа тэмтэрч үзвэл шалны банз завсраар бүлээн бороо нэгэн жигд дуслан байх шиг санагдав.

Намайг сэрээсэн чимээ шуугианы дараа нам гүм боллоо. Миний толгой дээр эрэгтэй хүний хөлийн чимээ сонстож шал хятаналаа. Тэр хүн доод давхрын задгай зуухны дэргэд очиж лаа асаав.

Тэгсэн чинь Кадрусс байж байлаа. Түүний царай нь зэвхийрч цамц нь нэл цус болжээ. Кадрусс лаа асаагаад буцан шатаараа яаран өгсөж сандарсан хөлийн нь чимээ миний толгой дээр дахин гарав.

Тэгээд хэсэгхэн болоод дахин бууж ирэв. Гартаа өнөөх илгэн сав барьжээ. Дотор нь очир эрдэнэ байгаа эсэхийг шалган үзээд түүнээ хоёр хармаандаа хийж үзсэнээ төдийлөн найдвартай биш гэ бодов бололтой улаан алчууртаа боогоод хүзүүгээрээ ороочихов.

Дараа нь шүүгээ рүү очиж өнөөх алтан зоос цаасан мөнгөө амд цамцныхаа хармаанд хувааж хийгээд хоёр гурван цамц шүүрэн аваад алга боллоо. Энэ болсон явдалд би өөрөө буруутан мэт зэмлэв.хүн гинших шиг санагдлаа. Эрдэнэсийн наймаачин арай үхээгүй байж магадгүй, хэрвээ би түүнд тус хүргэвэл өөрөө нүгэлт явдал үйлдээгүй ч гэсэн ийм явдал болоход саад хийгээгүй нүглийнхээ хагасыг ч босон нимгэлж магадгүй гэж бодлоо. Тэгээд доод давхрын залган барьсан ханын муу бэхлэсэн банзыг нуруугаараа түлхсэн чинь банз цөмөрч би байшинд орж явчихлаа.

Лааг нь шүүрч аваад дээшээ шатаар гүйхэд нэгэн хүний хүүр хөндлөн хэвтэж байлаа. Миний сонссон буун дуу бол Карконта уруу буудсан бууны дуу байжээ. Сум хүзүүг нь нэвт гарч хоёр талын шарх ба амнаас нь цус садарч байлаа.

Карконта үхчихсэн байв.

Би хүэн дээгүүр алхаад цааш гүйлээ.

Унтлагын өрөө нь аймаар эмх замбараагүй болжээ. Ньодон хэрэглэлийн хагас ийш тийшээ унаж, золгүй туу эрдэнэсийн наймаачин амь тавин сарвалзахдаа ор дэрний цагаан хэрэгслэлийг тараан хаяжээ. Өөрөө цээжний гурван том шархнаас асгарсан шалбааг болон цусан дотор толгойгоо хана уруу харуулан хэвтэж байлаа. Дөрөв дэх шархад нь том балиус хутга шаалттай байр бөгөөд зөвхөн бариул нь л цухуйж байв.

Миний хөл доор хоёр дахь гар буу нь дайралдлаа. Дарь нь чийг аваад асаагүй бололтой.

Би эрдэнэсийн наймаачин уруу дөхөж очиход тэр арай үхээгүй голтой байлаа. Миний хөлийн чимээ гол нь шал доргисноос болж мэдэрсэн нүдээ нээж, намайг хараад юм хэлэх гэсэн бололтой уруулаа хөдөлгөснөө тэр дороо л амьсгаа хураачихав.

Энэ аймшигтай юмыг хараад би бараг ухаан алдчихлаа. Би нэгэнт хэнд ч тус хүргэж чадахгүй болсон учир ганцхан л зугтаах хэрэгтэй боллоо. Тэгээд толгойгоо бариад аймшигтай хашхиран доошоо гүйлээ.

Доод тасалгаанд гаалийн байцаагч зургаан хүн, хоёр гурван цагдаагийн хамт бүхэл бүтэн зэвсэгт баг байж байлаа.

Тэд намайг барьж авахад би эсэргүүцэх гэж оролдсонгүй, бүр алмайрч орхиод юм хэлэх гэсэн чинь нэл цус болчихсон байлаа. Шатны завсраар дусаж байсан бүлээн бороо бол Карконтын цус байлаа.

Би өөрийн нуугдаж байсан газар руугаа хуруугаараа заалаа.

“Энэ юу гэх гээд байгаа юм бол?” гэж нэгэн цагдаа асуухад гаалийнхны нэг нь тийшээ харж,

“Энэ хүн түүгээр орж ирсэн гэж хэлж байгаа юм байна” гэж хариулаад, миний орж ирсэн цөмөрхий рүү шаалаа.

Тэгэхэд нь би намайг хүн алсан гэж байгаа юм байна гэж ойлгов. Тэгээд надад дуу орж хүч чадал минь эргэн бий болоод намайг барьж байсан хүмүүсийн гараас мулт үсрэн гараад,

“Би биш, би биш” гэж хашхирав.

Хоёр цагдаа над руу буугаа чиглүүлж,

“Хөдөлбөл чинь өнгөрөх нь тэр шүү” гэж хэлэв.

“Би биш гэдгээ та нарт хэлж байна шүү” гэж хэлэхэд тэд,

“Энэ бүхнээ Нимд байдаг шүүхэд очоод хэлээрэй, харин одоо биднийг дагаад яв. Бүү эсэргүүц гэж чамд зөвлөө” гэж хариулав.

Би эсэргүүцэх ч гэж бодсонгүй. Надад айх гайхах зэрэгчихлээ. Миний гарт гав зүүгээд, морины сүүлнээс холбож Ним уруу авч явав.

Гаалийнханы нэг нь намайг мөрдөөд байсан юм байжээ. Тэгээд тэр буудлын дэргэд миний барааг алдаж орхиод, намайг тэндээ хононо гэж бодоод нөхдөдөө хэлэхээр явсан юм байжээ. Тэгээд яг буу дуугарч байх үед олуулаа эргэн ирж, намайг тийм илэрхий баримттайгаар барьж авсан юм байжээ. Буруугүйгээ нотлоход маш хэцүү болохыг ойлгов.

Тэгээд би ганцхан зүйлд хүчээ тавьж тэр өдөр “Гаарын гүүр” гэдэг буурчийн газар ирсэн лам Бузони гэгчийг олуулах тушаал өгөөч гэж мөрдөн байцаагчаас гуйлаа. Хэрэв Кадрусс бүх юмыг санаанаасаа зохиож, тэр лам нь ерөөсөө байгаагүй байвал, Кадруссыг өөрийг нь л барьж тэрээр бүх үнэнээ л хүлээдэггүй л юм бол би гэдэг хүн өнгөрөөд байлаа.

Мөрдөн байцаагч маань сайн мүн байсан юм. ламыг эрэх бүх арJa хэмжээг аван, хоёр сар өнгөрлөө. Би бүх л горьдлогоо барлаа. Кадруссыг олсонгүй. Ойрын үед болох шүүх цуглаанаар намайг шийтгэх гэж байтал хүн амины хэрэг гарснаас гурван сар тав хоногийн дараа өнөөх Бузони ламтан шоронд хүрч ирлээ. Нэгэн хоригдол түүнтэй уулзах гэж байгааг мэдээд хүрч иржээ.

Би түүнийг хүрээд ирэхийн чинээ санаагүй билээ. түүний хэлснээр бол энэ тухай Марсельд байхдаа дуулаад яаран иржээ. Би ямар их баяртайгаар түүнийг хүлээн авсан гэж санана. Би өөрийн үзсэн харсан бүхнийг түүнд ярив. би сэтгэл түгшин байж очир эрдэнийн түүхийг ч ярив. Энэ явдал миний санаснаас шал өөр болж яах аргагүй үнэн зүйл ярилаа. Мөн тэр хүн тэгнэ чинээ санаагүй байтал миний ярьсан бүхнийг үнэмшсэн юм. Би түүний энэрэнгүй сэтгэлд автан, миний эх орны зан зашлыг мэддэгийг нь ч харав. Тэгээд өөрийн үйлдсэн ганц гэмт хэргийг уучлах үгийг энэ энэрэнгүй сэтгэлт хүний амнаас дуулах магадгүй хэмээн горьдохдоо Отейльд болсон явдлыг нүглээ наманчлан нэгд нэгэнгүй ярилаа. Миний чин зүрхнээсээ хэлсэн үг цаанаа тооцоолсон хэлсэн юм шиг л үр дүнтэй болж , анх хүн алснаа хэний ч юуны ч хавчилгагүйгээр хүлээсэн минь хоёр дахь хэргийг хийгээгүй болохыг нотлон итгүүлж, лам явахдаа миний буруугүйг шүүгчид итгүүлэхэд өөрийн талаас чадах бүх зүйлийг хийхээр ам өгөөд явсан билээ.

Шоронгийн журам аажмаар зөөлөрч, миний хэргийг дараагийн цуглаан хүртэл хойшлуулсан байхыг хараад тэр лам мини© хэрэгт оролцсон юм байна гэдги©г ойлголоо. Энэ хугацаанд тэнгэрийн бошгоор Кадруссыг гадаадад байхад нь барьж Францад авчирсан байлаа. Эхнэр нь л хамаг муу санааг гаргасан хэрэгт турхирсан гэж буруугаа чихээд, хэргээ хүлээлээ. Түүнийг бүх насаар нь ялт хөдөлмөр хийлгэхээр шийтгээд, намайг суллан тавив.

- Тэгээд л та лам Бузониос дагавар бичигтэй над дээр ирсэн биз дээ гэж гүн хэлэв.

- Тийм ээ, гэгээн эзэн минь. Тэр хүн миний төлөө их юм хийсэн юм даа.

“Хориотой бараа тээж худалдах ажил чинь таныг үрж мэднэ. Хэрвээ та эндээс л гардаг юм бол та намайг орхих хэрэгтэй” гэж надад хэлсэн юм.

“Лам эцэг минь! Би яаж амьдарч хөөрхий бэрээ тэжээх билээ” гэж би асуулаа.

“Намайг ихэд хүндэтгэдэг нэгэн шавь минь итгэлтэй хүн олж өгөхийг надад даалгасан юм. та ийм хүн болохыг хүсэж байна уу? Би түүнийг тан уруу явуулъя” гэж надад хариулсан юм.

“Эцэг минь, та бас их сайн сэтгэлтэй хүн юм!” гэж би дуу алдлаа.

“Харин намайг ийм юм хийсэндээ хэзээ ч харамсахгүй гэж та надад амлах уу”

Би тангараглах гэж гараа өргөхөд,

“Хэрэггүй ээ, би корсикчуудын занг мэднэ. Тэдэнд хайртай байдаг юм. май энэ дагавар бичгийг аваад яв” гэж надад хэллээ.

Тэгээд хэдэн мөр юм бичиж түүнийх нь үндсэн дээр гэгээн эзэн та намайг өөрийн албанд авсан билээ. таны сэтгэлд тохироогүй явдал гаргас н удаа бий юу гэж би танаас ам бардам асууж чадах байна?

- Үгүй, харин та нада тэтглээ итгэдэггүй боловч, би таныг сайн зарц гэж үздэгээ ам бардам хэлнэ гэж гүн хариулав.

- Гэгээн эзэн минь, би юу?

- Тийм ээ, та. Та өргөмөл хүүтэй бэртэй байж тэр тухайгаа надад хэлдэггүй нь юу билээ?

- Гэгээн эзэн минь, амьдралынхаа хамгийн гунигт хэсгийг ярих үлдээд байна. тэгээд би корсик руу явлаа. Хөөрхий муу бэртэйгээ уулзаж сэтгэлийг нь тайвшруулах хэрэгтэй байсныг та ойлгох биз. гэтэл Рольянод золгүй явдал намайг угтав. Манай гэрт айлынхан маань одоо хүртэл дурсан ярьдаг аймшигт явдал болжээ. Хөөрхий бэр минь, миний зөвлөн хэлснийг дагаж үргэлж мөнгө нэхдэг Бенедеттод мөнгө өгөхгүй гэжээ. Нэг өглөө бэрийг минь занаж орхиод бүтэн өдрийн турш алга болжээ. Энэ бузар амьтанд хайртай төрсөн хүү лүгээ адил байдаг Ассунта гашуунаар уйлан өнжжээ. Үдэш болоход Ассунта унтсангүй түүнийг хүлээж суулаа. Оройн арван нэгэн цаг болж байтал, Бенедетто өрөөсөн дугуй нь болсон хоёр найзын хамт иржээ. Ассунта түүнийг тэврэх гэсэн чинь цаадуул нь барьж аваад тэдний нэг нь чухамдаа нөгөө өөдгүй жаал биш байгаа гэхээс айдаг юм.

“Бид шүүлт явуулж тоглоно. Тэгэхээр мөнгө байга газраа хэлж өгөхгүй хаачих вэ” гэж хэлжээ.

Манай айлын Василио Басти орохоор явчихаад гэрт нь ганцхан эхнэр үлджээ. Бэрийн минь гэрт болсон явдлыг түүнээс өөр хэн ч дуулж чадахгүй байжээ. Хоёр Ассунтыг чанга барьж, хөөрхий Ассунта тэгнэ чинээ санаагүй болохоор алуурчдынхаа өөдөөс эелдэгээр харж зөөлнөө° инээмсэглэж байжээ. Гурав дахь нь хаалга цонхыг сайн битүүлж орхиод бусад дээрээ ирж, энэ бүх бэлтгэл хийж байгааг хараад хашхирсан Ассунтын дууг дарах гэж оролдон, түүнийг хөлөөр нь шатаж байгаа гал уруу аваачлаа. Тэд ингэхээр нуусан мөнгөө хэлж өгнө гэж боджээ. Гэтэл хүүхнийг тэдэнтэй ноцолдож байх зуур хувцсанд нь гал авалцахад өөрсдийн нь

хувцсанд гал хүрчих вий гэсэндээ түүнийг хаяж орхижээ. Галд автагдсан хүүхэн үүд рүү гүйсэн боловч үүд түгжээтэй байлаа. Цонх руу гүйхэд нь цонх бас хаалттай байжээ. Ассунта туслахыг гуйн аймшигт хашхирахыг айлын авгай сонсжээ. Дараа нь дуу нь бүдгэрч сүүлдээ гиншиж эхэлжээ. Аюулт явдал болсны маргааш шөнөжингөө айж түгшсэн Василиогийн эхнэр арай гэж гэрээсээ гарч хуулийн газар очин мэдэгдэн, манай хаалгыг эвдэн оржээ. Ассунта хагас шатаж голтой төдий байсан бөгөөд шүүгээ эвдрэн мөнгө нь алга болсон байлаа. Бенедеттогийн тухайд гэвэл тэр Рольяногоос үүрд зайлан лага болжээ. Түүнээс хойш би түүнтэй дайралдсангүй, сургийг нь ч дуулсангүй.

- Би ийм гунигт юм болсныг мэдэж аваад, гэгээн эзэн минь тан руу хүрч ирсэн билээ. Бенедетто алга болчихсон болохоор би үүний тухай танд хэлээгүй юм. Бэр маань үхчихсэн болохоор бас ярих хэрэггүй байлаа.

- Тэгээд та тэр явдлын тухай юу гэж бодов? гэж гүн асуухад

- Энэ бол миний үйлдсэн гэмт хэргийн шийтгэл байх гэж бодсон юм гэж Бертуччо хэлээд – Ай тэр Вильфорынх гэдэг чинь нүгэлт хүмүүс байгаа юм! гэж хэлэв.

- Би ч бас тэгж бодож байна гэж гүн царай барайлган шивгэнэлээ.

- Гэгээн эзэн та одоо тэр цагаас хойш хараагүй энэ байшин, гэнэт орж ирэх болсон энэ цэцэрлэг, хүн алсан энэ газар энэ бүхэн таны мэдэж авсан тэр шалтгааны улмаас надад түгшүүртэй сэтгэл төрүүлснийг ойлгож байгаа. Эрхэм де Вильфор энд, миний хөлийн доор, өөрийнхөө хүүхдэд зориулж ухсан нүхэн дотроо хэвтэж байгаа гэдэгт л итгэж байгаа шүү гэж хэлье гэж Бертуччо үргэлжлүүлэн хэлэв.

- Магадгүй дээ гэж гүн босох зуураа хэлснээ дөнгөж сонстох төдийгөөр – Тэр бүү хэл вангийн прокурор амьд ч байж магадгүй гэснээ – Бузони лам таныг над уруу ирүүлсэн явдал сайн болж. Бас та надад өөрийн түүхийг ярьсан чинь сайн хэрэг. би одоо таны тухай муу юм бодохгүй. Аа харин тэр нэрэндээ зохиогүй Бенедетто чинь хаана байгаа вэ? Та түүний мөр улыг олж юу болсныг нь мэдэхийг хичээв үү? гэж асуув.

- Огт үгүй. Би түүний байгаа газрыг мэддэг байлаа ч гэсэн түүнтэй уулзах гэхгүй, мангасаас айх мэт зугтаана. Харин аз болоход бм хэзээ ч хэнээс ч түүний тухай юу ч сонсоогүй. Амьд байхгүй байх гэж найдаж байна.

- Тэгж бүү найд, Бертуччо. Хортон санаатнууд тийм амар үхдэггүй юм. Бурхан тэднийг өшөө авах зэвсгээ болгох гэж хамгаалан хадгалж байдаг юм гэж гүн хэлэхэд,

- Тийм болог. Би түүнтэй дайралдахгүй юм сан гэж бурханд мөргөж явдаг юм гэж хэлээд хэрэг хөтлөгч толгойгоо гудайлган – Гэгээн эзэн та одоо бүгдийг мэдэх боллоо. Та бол тэнгэр бурхан байдаг шиг газар дээрх миний шүүгч, та намайг тайвшруулах ямар нэгэн юм хэлэхгүй юу? гэлээ.

- Тийм ээ, таны хэлдэг зөв. Би Бузони ламтны хэлдэг үгийг л давтан хэлэх байна. таны гар далайсан тэр Вильфор таны тухайд өшөө авахуйцаар юм хийсэн байна, бас өөр бусдын талаар ч магадгүй. Хэрвээ тэр Бенедетто миний хэлснээр

амьд байгаа бол бурхны цээрлүүлэлтийн зэвсэг болоод, эцэст нь өөрөө ялаа эдлэх болно. Та үнэндээ ганц зүйлээр өөрийгөө зэмлэх болно. Тэр хүүхдийг үхлээс авраад яагаад эхэд нь буцааж өгөөгүй билээ гэж өөрөөсөө асуу. Энүүнд л Бертуччо таны буруу байгаа юм.

- Тийм ээ, гэгээн эзэн минь, үүнд л миний буруу байгаа юм. би энэрэнгүй бус явдал гаргажээ. Би хүүхдийн амийг авармагц л таны хэлснээр эхэд нь буцаан өгөх ёстой байж. Гэвч ингэхийн тулд мэдээ цуглуулж, түүнээсээ болоод хүний анхаарлыг өөртөө татаж бүр өөрийгөө илрүүлчхэж ч магадгүй байсан юм. би үхэх дургүй байлаа. Намайг амьд явахад миний бэр, бас эцэс төгсгөлд нь хүртэл өшөөгөө авах гэдэг корсик зан түлхсэн юм. эцэст нь би амьдралд дуртай хүн л дээ. би золгүй ах шиг ээ тийм зоригтой хүн биш ээ!

Бертуччо хоёр гараараа нүүрээ дарахад гүн түүнийг удаанаар ширтэн харлаа. Дараа нь энэ газар, ийм байдлын нөлөөнд улам ч сүртэйгээр хэсэг зуур имээгүй байснаа, өөрөө заншаагүй, уйтгар гунигтай дуугаар,

-Манай яриаг аятай зүйтэй төгсгөхийн тулд лам Бузонийн дандаа хэлдэJ үгийг саная:"Ямар нэгэн гай зовлонг цаг хугацаа ба дуугуй байх гэдэг хоёрхон эмээр эмнэж болно"Одоо би цэцэрлэг дотуур зугаацахыг хүсэж байна.Аймшигт явдалд оролцсон танд хүнд байгаа тэр зүйл надад аятайхан сэтгэл төрүүлж,энэ байрыг хоёр дахин үнэтэй болгож өглөө.Бертуччо, модод сүүдэр тусгадгаараа сайхан,харин сүүдэр өөрөө хүсэл мөрөөдлийг төрүүлдгээрээ сайхан юм.Би зөвхөн хашаа хүрээтэй газар худалдаж авлаа гэж бодоод цэцэрлэгтэй болсон.Харин тэгтэл энэ хашаа хүрээтэй газарт маань эдлэнг авсан газарт дурдагдаагүй буг дотуур нь сэлгүүцэн явдаг газартай болжээ.Би буг сүгэнд дуртай хүн.Амьд хүн ганц өдөр хийдэг шиг гай зовлонг үхдэлүүд зургаан мянган жилийн дотор ч хийдэггүй юм.Бертуччо,гэртээ харьж тайван нойрс.Хэрвээ таны сүүлчийн цаг ирж хойдхыг чинь унших лам чинь Бузони шиг тийм энэрэнгүй сэтгэлтэй хүн биш байвал намайг дуудаарай. Хэрвээ тэр цагт би амьд байвал ирж,сүнсийг чинь тайвшруулан бүүвэйлэх үг олж чадна шүү.

Бертуччо гүнгийн өмнө их л хүндэтгэлтэй мэхийн ёслоод,хүндээр санаа алдан,холдож явлаа.Монте-Кристо ганцаараа үлдээд хэд алхлаа.

-Энд энэ чинарын дэргэд хүүхэд оршуулсан булш,тэнд цэцэрлэг рүү орж ирсэн явган хаалга,тэр буланд унтлагын өрөө рүү ордог нууц шат байна. Энэ бүгдийг тэмдэглэлийн дэвтэрт бичих шаардлагагүй гэж бодож байна. Нүдний өмнө, хөлийн доор илхэн байгаа хойно юу хийх вэ гэж шивэгнэв. Тэгээд гүн цэцэрлэгийг нSг удаа тойроод сүйх тэрэг уруугаа очив.Бертуччо түүний бодлогошрон явааг хараад дуугаралгүй хөтөчтэй зэрэгцэн суулаа.

Сүйх тэрэг Парисыг чиглэн давхилаа. Монте-Кристо гүн тэр оройдоо Елисейн талд байдаг гэртээ хүрч ирээд,олон жил суусан хүний мэдэмгий байдлаар явж үзлээ. Гүн бусдаас түрүүлэн явсан боловч нэг ч хаалга андуурсангүй,орох гэсэн өрөө тасалгааныхаа үүд хонгилыг огтхон ч алдахгүй орж байлаа.Али энэ шөнийн аянд гүнг дагалдан явлаа.Гүн тасалгаануудыг хуваарилах ба гоёж чимэх ажилтай холбогдсон зарим нэг тушаал шийдвэрийг Бертуччод өгөөд цагаа харж,анхааралтай сонсож байсан Нуби хүнд,

-Арван нэгэн цаг хагас болчихлоо.Гайда удахгүй ирэх ёстой.Франц шивэгчингүүдэд хэлсэн үү?гэж асуув. Али гоо үзэсгэлэнт албани хүүхэнд зориулсан хэсэг рүү хуруугаараа заалаа.Энэ хэсэг нь маш сайн нууцлагдсан бөгөөд ,хэрвээ үүдийг нь хивсээр халхлан хадчихвал байшингийн тэр талд зочдын өрөө,хүн суудаг хоёр өрөө байгааг хэн ч мэдэхгүй өнгөрч болох ажээ.Али энэ хаалга өөд хуруугаараа зааж,зүүн гарынхаа гурван хурууг гозойлгон,гарынхаа алган дээр толгойгоо тавиад унтаж байгаа хүний дүр үзүүлэн нүдээ анилаа.

-Ойлголоо гэж ийм ярианд дассан Монте-Кристо хэлээд, - Унтлагын өрөөнд гурвуулаа хүлээж байгаа юм уу?гэж асуулаа.

- ТЭйм ээ хэмээн Али толгой дохилоо.

- Хатагтай өнөөдөр ядарсан. Ирээд л шууд унтах гэх байх. Түүнтэй юу ч ярих хэрэггүй. Франц шивэгчингүүд шинэ эзэгтэйтэйгээ зөвхөн мэндлээд л явах ёстой. Грег шивэгчин франц шивэгчингүүдтэй ойртож болохгүй.. ажиглаж байгаарай.

Али мэхийн ёсоллоо.

Удалгүй хаалгачийг дуудах чимээ гарч хаалга онгойгоод сүйх тэрэг модот замаар шатны дэргэд ирж зогслоо.

Гүн доошоо буухад, сүйх тэрэгний хаалга нээгдчихсэн байлаа. Гүн алтаар чимсэн ногоон торгон нөмрөг хөлөөсөө толгойгоо хүртэл битүү нөмөрсөн залуухан бүсгүйд гараа өглөө. Бүсгүй түүн өөд сунгасан гарыг барьж, хайр хүндтэйгээр үнэсээд, хэдэн үг эелдэг зөөлнөөр хэлэхэд, гүн өвгөн Гомерын алдарт дууллуудаа шүлэглэн хэлж байсан тэр яруу хэл дээр хариу хэдэн үг эелдэгхэн хэллээ.

Дараа нь өнөө италид гүнтэй хамт явж байсан гоо сайхан албани хүүхэн лаван лаа барьж өмнө нь яваа Алийг дагаж байр уруу ороход, гүн ч өөрийн өрөө рүү орлоо.

Арван хоёр цаг хагаст байшингийн бүх гэрэл унтарч, эндхийн бүх хүн амар жимэр унтжээ гэж бодож болохоор боллоо.

VIII. Хэмжээгүй зарцуулах мөнгө

Маргааш нь өдрийн хоёр цагийн үед хоёр сайхан англи морь хөлөглөсөн сүйх тэрэг гүнгийн гадаа ирж зогслоо. Хөх өнгийн торгон товч хадсан фрак хэмээх хөх цамцтай, цагаан хантаазан дээрээ том алтан товч зүүж, самрын модны өнгөтөй мод өмсөн, дух руугаа доор унжсан төрөлхийн гэхэд эргэлзэм хар үстэй, тэгээд ч энэ үс нь хөмсөгний дээрх гүн үрчлээсийг нь халхалж ч чадаагүй, ер нь л тавь орчим насны боловч дөчөөд настай болж харагдах гэж хүссэн байрын эрэгтэй хүн түшээ гүнгийн титэм дүрсэлсэн сүйх тэрэгний цонхоор харж, Монте-Кристо гүнг байгаа эсэхийг асуулгахаар хиагаа явуулав.

Энэ хүн хариу хүлээх зуур байшингийн гадна тал, цэцэрлэг ба хашааны цаана харагдах зарц нарын байшинг ихэд эрээ цээргүй байдлаар сонирхон харлаа. Нүд нь цогтой боловч ухаантайгаасаа зальтай нь илүү ажээ. Уруул нь маш нимгэн, урагшаагаа төвийхөөсөө илүү хойшоогоо шигдэх ажээ. Учир мэдэхгүй хүнд бол сайхан сүйх тэрэг, цардмал өвчүүндээ тээглүүр болгосон засмал том алмааз, энгэр

дүүрсэн одонгийн урт тууз нь бага биш сэтгэгдэл төрүүлэхээр боловч хорон санаатайн үнэн шинж тэмдэг гэмээр өргөн товгор шанаа, хөвсгөр дух, гүрийсэн шилэн хүзүү, язгууртан хүнд даанч зохимгүй дэлдгэр чих, энэ бүгдийг харсан, нүүр царайгаар хүнийг тодорхойлдог судлаач саях хүний зан араншингийн талаар олигтой юм хэлэхээргүй ажээ.

Хиа хаалгачийн хонхыг цохиж,

- Монте-Кристо гүнгийнх энэ үү? гэж асуув.

- Тийм ээ, гэгээн эзэнтэн энд суудаг юм, гэхдээ... гэснээ хаалгач Али өөд асуусан янзтай харахад цаадах нь үгүй гэсэн дохио өглөө.

- Гэхдээ юу гэж? гэж хиа асуухад

- Гэхдээ, гэгээн эзэнтэн хүн хүлээж авахгүй гэж хаалгач хариулав.

- Тэгвэл май, энэ манай ноён түшээ гүн Дангларын нэрийн хуудас. Үүнийг гүн Монте-Кристорд өгөөд, манай ноён танхимд очих замдаа уулзах гэж ирээд явсныг хэлээрэй.

- Би гэгээн эзэнтэй үг ярих эрхгүй. Таны даалгаврыг гарын зарц гүйцэтгэх болно гэж хаалгач хэллээ. Хиа тэргэндээ буцаж ирэхэд Данглар,

- За юу гэж байна? гэж асуув.

Авсан хариундаа ичиж зовсон жаал хүү хаалгачийн хэлсэн хариуг ноёндоо айлтгалаа.

- Үгүй ер. Гэгээн эзэн гэж хүндэлдэг, тэгээд гарын зарцаас нь өөр хүн үг ярих эрхгүй их гарын хүн байх нь ээ. За яах вэ, миний банкнаас мөнгө авч байх болохоор хэрэгтэй үедээ над дээр ирж л таарна даа.

Тэгээд Данглар сүйх тэрэгнийхээ ар руу шигдэн налж суугаад замын цаад талд дуулдахаар чанга дуугаар хөтөчдөө,

- Депутадуудын Танхим руу гэж хашхирав.

Данларын ирэхийг тэр дор нь мэдэгдсэн болохоор гүн хаалганыхаа цонхны хаалтын завсраар сайн татдаг дурангаараа, Дангларыг харж, байшин, цэцэрлэг, зарц нарын байрыг нь ажиглаж байгаагаас нь дутахгүйгээр өөрийг нь сонирхож байлаа. Тэгээд сунгасан дурангаа ясан хүрээнд нь буцаан суулгаж, зэвүү нь хүрсэн шинжтэй,

- Энэ хүн үнэхээр зальхай өдгүй амьтан байна. түүнийг нэг л хараад налуу духаар нь могой, гэдгэр гавлаар нь элээ, хурц хоншоороор нь сар шувуу гэдгийг нь хэлэхгүй байх арга алга гэж хэлэв.

- Али гэж хашхираад дараа нь зэс хонхыг нэг цохилоо. Али орж ирэхэд Бертуччогууд гэж түүнд хэлэв. Бертуччо тэр дороо орж ирлээ.

- Гэгээн эзэн та намайг асуугаа юу ?

- Тийм ээ гэж гүн хэлээд – Дөнгөж сая чиний хаалган дээр зогсож байсан морьдыг харав уу? гэв.

- Гэгээн эзэн минь, харалгүй яах вэ. Сайхан амьтад гэж бодож байна гэж Бертуччо хэлэхэд гүн хөмсгөө зангидан,

- Парисын хамгийн шилдэг хос морь олж авчир гэж би танаас шаардсан байхад, яагаад миний морьдтой эн зэрэгцэх морьд бас байдаг, тэгээд тэр нь яагаад миний морьдын хашаанд байдаггүй билээ? гэж асуулаа.

Гүн хөмсгөө зангидан ширүүн дуугарч байхыг харсан Али толгойгоо бөхийлөө.

- Миний сайн санаат Али, чи энд ямар ч хамаагүй гэж гүн гаргана гэж санамгүй эелдэг царай гарган зөөлнөөр хэлээд - Чи англи морьдыг мэддэггүй шүү дээ гэлээ. Алийн царай дахин гэрэлтлээ.

- Гэгээн эзэн минь таны хэлдэг тэр морьдыг худалдаагүй юм гэж Бертуччо хэлэхэд Монте-Кристо мөрөө хавчаад,

- Эрхэм хэрэг хөтлөгч та хэрэгтэй үнийг нь өгөхөд худалддаггүй юм гэж байдаггүй гэдгийг мэдэж ав гэж хэллээ.

- Ноён Данглар тэднийг арван зургаан мянган франкаар авсан юм билээ.

- Тэгвэл түүнд гучин хоёр мянган франкийн үнэ өгөх хэрэгтэй байсан юм. Тэр чинь банкийн эзэн хүн. Тэгэхээр банкын эзэн хүн хөрөнгөө хоёр дахин нэмэгдүүлэх азтай тохиолдлыг хэзээ ч алддаггүй юм.

- Гэгээн эзэн та үнэхээр тэгж бодож байна уу? гэж Бертуччо асуулаа.

Тэгэхэд Монте-Кристо өөдөөс нь, юм асууж зүрхэлсэн хүнийг гайхан хардаг тийм харцаар хэрэг хөтлөгч даамлаа хараад,

- өнөө орой би айлд зочлон очино. Энэ морьд мий сүйх тэргэнд шинэ тоногтой хөллөгдсөн байхыг хүсч байна гэлээ.

Бертуччо мэхийн ёслоод явснаа үүдэнд очиж зосоод,

- Гэгээн эзэн та хэдэн цагт явахсан бол? гэхэд

- Таван цагт гэж гүнг хариулахад,

- Одоо хоёр цаг болж байна гэдгийг хэлмээр байна гэж хэрэг рөтлөгч шийдмэг биш хэллээ.

- Тийм ээ мэдэж байна гэж Монте-Кристо хариулаад Али руу эргэж, бүх морьдоо хатагтайд үзүүл, дуртайгаа шилж аваг. Хатагтай надтай хамт өдрийн зоог

зооглох эсэхийг мэд. Хэрвээ тийм бол тасалгаанд нь зоог аваачиж өгөөрэй. За яв, гарын зарцыг над уруу ирүүл гэж хэллээ. Алиг дөнгөж гармагц зарц орж ирэв.

- Батистен, та надад бүтэн жил алба хаалаа. Би ийм хугацаагаар зарц нараа шалгадаг юм, та надад тохирч байна гэж гүн хэллээ. Батистен мэхийн ёслов.

- Одоо ганцхан би танд тохирох эсэхийг мэдмээр байна.

- Ай гэгээн эзэн минь.

- Дуустал нь сонс гэж гүн цааш нь үргэлжлүүлэн, - Та жилд мянга таван зуун франк авдаг, өөрөөр хэлбэл өдөр бүр аминдаа халтай ажилтай байдаг зоригт сайн офицерын жилийн цалин. тАнаас их ажилд дарагдсан албан хаагчдын олонх нь атаархахаар тийм хоол иддэг. Та зарц ч гэсэн таны гадуур дотуур хувцасны төлөө санаа тавьдаг зарц нар танд бий. Та авч байгаа мянга таван зуун франкаасаа гадна миний ариун цэврийн хэрэглэлийг худалдан авахдаа жилд бас л мянга таван зуун франк надаас хулгайлан авдаг гэж ярихад,

- Ай гэгээн эзэнтэн минь гэлээ.

- Би танд гомдол мэдүүлж байгаа юм биш. Зүгээр л хэлж байна. гэвч та энэ хэмжээнээсээ битгий хэтрүүлээсэй гэж хүч байгаа юм байна. таны аз болж орсон энэ ажоаасаа илүү ажил та олохгүй ээ. би хэзээ ч өөрийнхөө зарц нарыг зоддоггүй, харааж зүхдэггүй, хэзээ ч тэдэнд уурладаггүй, алдааг нь дандаа уучилж байдаг боловч, хайхрамжгүй буюу мартамхай явдлыг хэзээ ч уучилж үздэггүй. Миний тугаал товч боловч тодорхой нягт байдаг, би тушаалаа ойлгоогүй байгааг харснаас хоёр, гурав дахин давтан хэлэх минь тээр санагддаг. Би сонирхон юм бүхнээ мэдэж чаддаг тийм баян хүн, бас их сониуч хүн шүү гэдгийг танд сануулчихъя. Иймээс та хэзээ нэгэн цагт миний тухай сайнаар ч бай муугаар ч бай хамаагүй юм ярьж, миний хэлж байгаа зүйлийг зөв буруу гэж шүүмжлэн, ажил явдлыг минь мөрдөн сонирхох юм бол таныг тэр дор чинь хөөж яюуулна. Би өөрийн зарц нарт нэг л удаа урьдчилан сануулдаг. Танд урьдчилан санууллаа, за яв.

Батистен мэхийн ёслоод үүд рүү хоёр гурав алхтал гүн үргэлжлүүлэн,

- Байзаарай, би өөрийнхөө зарц нарт жил бүр тодорхой хэмжээний мөнгийг хураан хадгалдаг. Хөөгдсөн хүн бол энэ мөнгөө алдаж, бусад нь намайг үхсэн хойно хуваан авах болно. Та нада бүтэн жил үйлчилсэн болохоор таны хөрөнгөний эхийг хийж эхэлсэн. Үүнийгээ ихэсгэх нь танаас л шалтгаална гэж хэллээ.

Франц хэл мэдэхгүй учир огт санаандгүй зогсож байсан Алийн дэргэд ярьсан энэ яриа нь франц хүний сэтгэл зүйг мэдэх хүн бүхэнд ойлгогдох тийм сэтгэгдлийг зарцад төрүүллээ.

- Би бүх зүйлийг таны хүсэлд нийцүүлэхийг хичээе гэж Батистен хэлээд,

- Би эрхэм Алийн жишээг удирдлага болгон явъя гэхэд нь

- Хэрхэвч тэгж болохгүй. Али сайн талтайгаас гадна дутагдалтай хүн. Тэр бол онцгой хүн учраас түүнээс жишээ авч болохгүй. Али хөлс авдаггүй, энэ бол зарц биш

миний боол, миний нохой. Хэрвээ энэ өөрийн үүргийг зөрчвөл би түүнийг хөөж явуулна гэхгүй шууд ална гэж хүйтнээр хэллээ. Батистен нүдээ бүлтийлгэлээ.

- Та үнэмшихгүй байна уу? гэж гүн асуугаад Батистенд францаар хэлсэн үгээ Алид давтан хэлэхэд Али түүний үгийг сонсож байснаа инээмсэглээд ноён руугаа очиж нэг өвдөг дээрээ сөхрөн гарыг нь үнслээ.

Энэ хичээл Батистеныг бүрэн гайхууллаа. Гүн түүнийг яв гэж дохилоо. Али ноёноо дагаад тасалгаанд нь орж тэр хоёр удаан ярилцав. Таван цаг болоход гүн гурван удаа хонх цохилоо. Нэгээр нь Алиг, хоёроор нь Батистеныг, гурваар нь Бертуччо дууджээ.

Хэрэг хөтлөгч даамал орж ирлээ.

- Морьд! гэж гүнг хэлэхэд,

- Морьд гадаа байгаа . би гэгээн эзэн танд бараа болж явах чстой юу гэж Бертуччо асуухад

- Үгүй ээ, зөвхөн хөтөч, Батистен, Али л явна.

Гүн шатан ээр гарч өглөө нь Дангларын хөллөж ирэхэд шохоорхож байсан өнөөх хос морь шинэ тоног хэрэглэлтэйгээр өөрийнх нь сүйх тэргэнд хөллөгдсөн байхыг харлаа. Гүн морьдын хажуугаар өнгөрөхдөө тэдгээрийг эгшин зуур харж,

- Энэ хоёр үнэхээр сайхан морьд юм. жаахан хожимдсон боловч худалдаж авсан нь сайн хэрэг гэхэд Бертуччо,

- Энийг авах гэж их ажил болж, их үнээр олдлоо шүү гэлээ.

Гүн мөрөө хавчиж,

- Энүүнээс болж морьд муудаагүй биз дээ гэв.

- Хэрвээ гэгээн эзэн таны сэтгэлд л ханамжтай байвал бүх юм сайн болсон нь тэр гэж Бертуччо хэлээд – Хаашаа яв гэж тушаахсан бол гэж асуулаа.

- Шоссе де Антен гудамж, түшээ гүн Дангларынд. Өө тийм Бертуччо надад тэнгисийн эрэг дээр Нормандад ч юм уу, эсвэл Гавр Бульон хоёрын хооронд ч юм уу хэсэг газар хэрэгтэй байна. би таныг дуртай газраа сонгож ав гэж байна. харин тэр газарт чинь миний гурван далбаат онгоц зогсож болох жижиг булан тохой байх хэрэгтэй. Усан суулт нь ердөө л арван таван фут. Тэгээд өдөр шөнө аль ч цагт тэнгист гарч явахад бэлэн байх ёстой. Энэ шаардлагад тохирох газрыг үүнтэй холбоотой бүх нотариусаас асууж сурагла. Тэгээд мэдээ цуглуулаад явж үз, хэрвээ тохирох газар байвал өөрийнхөө нэр дээр худалдаж ав. Гурван далбаат хөлөг маань Финан орох замд яваа байх аа гэж гүн хэлээ.

- Биднийг Марселиэс гарах үдэш далайд гарч байхыг нь харсан.

- Аа дарвуулт онгоц маань хаана явна.

- Мартигад зогсож байх тушаал өгсөн.

- Сайн байна. Цаад хоёр ахмад чинь нойрмоглож орхих бий, та үе үе холбоо барьж байгаарай.

- Уурын онгоцоо яах вэ?

- Шалонд зогсож байгааг уу?

- Тийм ээ.

- Хоёр далбаат онгоцонд өгсний адил тушаал өг.

- Мэдлээ.

- Зогсоол газар худалдаж авмагц, та хойд болон өмнөдийн хоёр зам дээр арван бээр тутамд морьд өртөөлүүлж бэлтгэ.

- Гэгээн эзэн та надад итгэж болно.

Гүн толгойгоо дохиод сүйх тэргэнд үсрэн ороход сайхан морьд ухасхийн давхилдаж, банкны эзний гадаа очиж зогслоо.

Монте-Кристо гүнг ирсэн тухай Дангларт айлтгахад, тэр төмөр замын комиссын хурал даргалж байлаа. Гэхдээ хурал нь тарах шахаж байжээ. Гүнгийн нэрийг сонсмогц Данглар суудлаасаа босож, ихэнх нь дээд доод танхимын хүндэт гишүүд болох нөхдөдөө хандан,

- Ноёд оо, уучлаарай. Би та нарыг орхих хэрэгтэй боллоо. Ром хотын Томсон ба Фрэнчийн пүүс Монте-Кристо гэгчид хэмжээгүй зарцуулах мөнгөний эрх нээн над руу явуулжээ.. надтай харилцагчид хэзээ ч ийм тэнэг тоглоом хийж байгаагүй юм. миний сонирхол төрөх нь аргагүй биз дээ. Өнөө өглөө би тэр хуурамч гүнгийн очлоо. Тэр жинхэнэ гүн юм бол тийм их баян байх ёсгүй гэдэг нь ойлгомжтой биз. тэр намайг очиход хүлээж авсангүй. Та нар үүнийг юу гэх вэ? Зөвхөн өндөр дээд тушаалтнууд буюу сайхан хүүхнүүд л энэ Монте-Кристо шиг зан гаргадаг байх. Елисейн тал дээрх байшин үнэн хэрэг дээрээ түүнийх бөгөөд тун ч муугүй байшин байдаг шүү. Харин хэмжээгүй зарцуулах мөнгө гэдэг нь гээд Данглар зальтайгаар инээж,

- Данс нээж байгаа банкны эзний шаардлагыг улам ч дээшлүүлэх нь мэдээж. Энэ эрхийг үзэх гэж тэсэж чадахгүй байна. тэр хэнтэй ажил хэрэг явуулж байгаагаа мэдэхгүй байна. хэн нь эцэстээ инээхээ үзье гэж хэллээ.

Эрхэм түшээ гүн энэ үгийг ихэд ихэмсэг байдлаар хэлээд зочдоо орхиж, бүх Шоссе де Антенд алдаршсан алтан чимэгтэй цагаан тасалгаандаа орлоо. Зочныг шууд гайхуулах гэж тийш оруул гэж тушаасан байжээ.

Банкны эзэнд жинхэнэ эх зураг нь хэмээн худалдсан Албанийн болон Фторийн зургаас хуулан зурсан зургийг гүн харж зогслоо. Эдгээр нь зөвхөн хуулбар зураг төдий учир алтан жаазандаа огтхон ч зохисонгүй.

Данглар орж ирэхийг сонсоод гүн эргэж харлаа. Данглар толгойгоо үл мэдэг дохиод, алтдан цагаан атласаар бүрсэн зөөлөн сандал дээ суухыг урилаа. Гүн суулаа.

- Би эрхэм Монте-Кристотой ярилцах завшаан тохиолдож байна.

- Аа би депутатын танхимын гишүүн, хүндэт легионы одон тэмдэгт эрхэм түшээ гүн Данглартай нүүр учирч байна уу гэж гүн хариу хэлэв.

Монте-Кристо түшээ гүний нэрийн хуудсан дээр байсан бүх л хэргэм цолыг нь дуудав. Данглар ёжилж байгааг нь мэдээд хөмхийгөө хазлаа.

- Таныг ирсэн тухай надад айлтгасан тэр хэргэмээр таныг дуудаагүй бол уучлал гуйя. Гэвч бид ардчилсан засгийн үед амьдарч байгаа. Би бол ард түмний ёонирхлыг хамгаалагчдын төлөөлөгч хүн гэж хэлэв.

- Тэгэхлээр та өөрийгөө түшээ гүн гэж дууддаг заншлыг хэдийн хадгалж чадсаар бусдыг гүн цолоор нь дуудахаа мартаж орхисон юм аа гэж Монте-Кристо хэлэхэд,

- Өө би ч түүнийгээ санаанд ордоггүй хүн шүү гэж Данглар хайхрамжгүй хариулаад – Миний үари нэг гавьяаг анхааран үзэж түшээ гүн цол олгож, хүндэт легионы одонгоор шагнасан юм. харин ... гэхэд Монте-Кристо,

- Харин та Монморанси, Лафайт хоёр цол хэргэмээсээ татгалзсан жишээ шиг татгалзсан хэрэг үү, дууриалтай жишээ байна даа гэхэд,

- Яг ч тийм бишээ, зарц нараас болоод гэж Данглар хэлэхэд,

- Тийм ээ, таны зарц нар таныг эрхэм дээдэс гэж дууддаг, сэтгүүлчдэд бол та энэрэлт эзэн, өөрийнхөө сонгогчдод бол зүгээр л иргэн. Үндсэн хууль байгуулалтын үед их хэрэглэгддэг өнгө дөө, би таны хэлж байгааг сайн ойлгож байна гэлээ.

Данглар хөмхийгөө зуулаа. Энэ талаар Монте-Кристо өөрөөс нь илүүг мэдээд ердийн ярианд эргэж орохоор шийдлээ.

- Эрхэм гүн би Томсон-Фрэнчийн банкнаас илгээсэн бичиг хүлээн авсан гэж мэхэсхийн хэлэв.

- Маш таатай байна түшээ гүн минь. Би таныг таны зарц нарын хүндэтгэдгээр дуудахыг зөвшөөрнө үү. Энэ бол түшээ гүн хэргэм шинээр шагнагддаггүй боловч одоог хүртэл гүнтэй газар сурч дадсан муу заншил л даа. тэгэхээр надад бол тун аятай байна. энэ бол өөрийгөө танилцуулах гэдэг эвгүй явдлаас намайг чөлөөлж байна. та тэгээд илгээмж бичгийг хүлээж аваа юу?

- Тэгсэн, харин тэгэхдээ учрыг нь бүрэн ойлгож чадсангүй.

- Пөөх

- Тэр ч байтугай зарим нэг тайлбар авах гэж танайд хүртэл очсон.

- Одоо би энд байна таны хэлэхийг сонсьё.

- Тэр бичиг надад байгаа байх аа гээд Данглар хармаандаа үзэж

- Өө энэ байна. Энэ илгээмж бичиг Монте-Кристо гүнд манай банкинд хэмжээгүй зарцуулах мөнгө нээж өгч байна гэнэ ээ?

- Тийм ээ, танд юу нь тодорхой биш байна?

- Үгүй ээ, зөвхөн хэмжээгүй гэдэг үг л...

- Буруу биччихэж гэж үү? Англичууд бичсэн гэдгийг та мэднэ шүү дээ.

- Үгүй үгүй дүрмийн хувьд зөв. Харин нягтлан бодохын талаас тийм биш байгаа юм.

- Таныхаар бол Томсон-Фрэнчийн банк бүрэн найдвартай биш үү? Гэж аль болохуйц хайнга асуугаад, - Чөтгөр ав энэ чинь эвгүй хэрэг болох нь байна даа, тэнд миний жаал зугаа мөнгө байдаг юм гэхэд Данглар бараг дооглосон маягтай,

- Үгүй, бүрэн найдвартай. Харин хэмжээгүй гэдэг үг санхүүгийн хувьд баахан бүдэг байна гэж Данглар хариулав.

- Хэмжээ байхгүй гэдэг нь үү гэж Монте-Кристо хэлэхэд

- Тийм ээ, тодорхой биш бүх зүйл эргэлзээ төрүүлдэг юм. харин эргэлзвэл түдгэлз гэж мэргэд сургасан байдаг.

- Энэ юу гэсэн үг вэ? Хэрвээ Томсон-Фрэнчийн пүүс хөнгөмсөг ажил хийвэл Дангларын пүүс түүнийг дууриах ёсгүй гэсэн үг үү?

- Өөрөөр хэлбэл?

- Өө маш амархан. Эрхэм Томсон-Фрэнч хоёрт мөнгөний хэмжээ байдаггүй. Харин эрхэм Дангларт бол хэмжээ хязгаар байдаг юм байна. саяны хэлсэн шиг ухаантай хүн юм аа.

- Эрхэм гүн гэж Данглар бардмаар – Хэнч миний мөнгийг хараахан тоолоогүй байгаа юм шүү гэж хэллээ.

Тэгэхэд Монте-Кристо хүйтнээр,

- Тийм бол энэ ажлыг би л түрүүлж хийх болж байх шив.

- Та яагаад тэгж бодож байна?

- Таны надаас асуугаад байгаа чинь нэг л эргэлзсэн шинжтэй учраас

Данглар хөмсгөө зангидав. Энэ хүн өөрийг нь хоёр дахь удаагаа мадалж, ана удаа бүр өөрийнх нь байм ёстой гэсэн юман дээр тавлажээ. Нөгөө зориудын ёсорхуу

байдал нь хэмжээндээ хүрч шазруун зан гаргах дөхөж байхад харин Монте-Кристо найрсгаар инээмсэглэн өөрт нь багагүй давуу тал өгсөн хайхрамжгүй байдал гарган суув.

- Ингэхэд эрхэм та надад нэг юм ойлгуулмаар байх санж. Хичнээн хэмжээний мөнгө авах гэж байгаагаа л тогтоож өгөөч гэж Данглар хэлэхэд, энэ маргаанд өчүүхэн ч ухрах шинжгүй Монте-Кристо,

- Үгүй ээ, эрхэм ээ. би нэгэнт л хэмжээгүй зарцуулах мөнгөний тухай ярьж байгаа болохоор энэ бол хичнээн мөнгө зарцуулахаа урьдчилан мэдэхгүй байгаагаас болсон хэрэг гэж хэллээ.

Банкны эзэн одоо л миний дийлэх цаг боллоо гэ бодоод сандлынхаа түшлэгийг налж,

- Зоригтойхон хэлчих, Дангларын пүүсийн бэлэн мөнгө хэмжээ хязгаартай ч хамгийн өндөр шаардлагыг хангаж чадан. Хэрвээ та нэг саяыг авья гэсэн ч... гэхэд Монте-Кристо

- Уучлаарай гэлээ.

- Би сая гэж хэлж байна шүү гэж Данглар биеэ тоосон байдлаар хэлэхэд,

- Сая гэдэг чинь надад юу болох юм бэ гэж гүн хэлээд, - Бурхан өршөө. Надад зөвхөн сая л хэрэгтэй байсан бол ийм өчүүхэн юмны төлөө банкинд данс нээх тухай ярих хэрэггүй байсан. Сая гэнээ, миний түрийвч эсвэл аяны хайраг дотор үргэлж нэг сая явдаг юм гэлээ. Тэгээд Монте-Кристо нэрийн хуудас хийсэн жижиг дэвтэр дотроосоо тав таван зуун мянгатын мөнгий нь төлчихсөн хоёр тэмдэгт гаргаж ирлээ.

Данглар шиг ийм хүнийг хатгах биш харин толгой руу нь шууд цохих хэрэгтэй юм. энэ цохилт өлөөгөө үзүүлжээ. Банкны эзэн салганан чичирч толгой нь эргэлээ. Тэр Монте-Кристо өөд мэлрэн харахад, нүдний нь цөцгий хачин жигтэйгээр томров.

- Та ер нь Томсон ба Фрэнчийн банкинд итгэхгүй байвал үнэнээ хэл. Би ажил төрөлд дадлага муутайхан ч ийм явдал болж магадгүй гэж бодоод урьдчилан арга хэмжээ авсан юм. танд ирүүлсэн шиг тийм хоёр итгэмжлэх бичиг надад бий. Нэг нь Венийн банкны эзэн Арштейн Эсколес хоёроос түшээ гүн Рочшильдэд, нөгөөх нь Лондоны Берингийн банкнаас ноён Лафитад бичсэн байгаа. Та нэг л үг хэлвэл би энэ хоёр банкны аль нэгэнд хандаж таныг элдвийн юманд санаа зовохоос чинь чөлөөлж өгье гэж гүн хэллээ.

Энэ үг хэргийн явцыг шийдвэрлэлээ. Данглар ялагджээ. Данглар гүнгийн хайнга байдлаар өгсөн Юен ба Лондоны хоёр бичгийг илт тэвдсэн байдалтайгаар задлан үзээд, гарын үсгий нь тун нарийн нягтлан үзэх нь Монте-Кристо банкны эзний сандран тэвдсэнийг бодолцоогүй бол доромжилж байгаа юм шиг санагдахаар байлаа. Тэгээд Данглар өмнө нь хүн болон хувираад сууж байгаа алтны агуу их хүчийг хүндэтгэн чслох гэсэн мэт болоод,

- Тийм ээ, энэ гурван гарын үсэг олон саяын үнэтэй юм. гурвын гурван хэмжээгүй зарцуулах мөнгө. Гүн минь уучлаарай, эргэлзэхээ болилоо гэхэд, гайхсан хэвээрээ байж болно биз дээ гэж лавлав.

- Өө, таны банкиг юугаар ч гайхуулах аргагүй гэж Монте-Кристо аль болох ёсорхог байдлаар хэлээд

- Тэгвэл та надад жаахан мөнгө ирүүлж болохсон болов уу? гэлээ.

- Гүн минь хичнээн хэрэгтэйгээ хэлээч, би танд тус болоход бэлэн байна.

- За яах вэ. Бид тохирсон хойно, үгүй бид тохирсон биз дээ гэж гүн асуув.

Данглар толгой дохилоо.

- Та одоо эргэлзэхгүй болоо биз гэж Монте-Кристо үргэлжлүүлэн асуухад, банкны эзэн,

- Юу хэлнэ вэ дээ, гүн минь би огт эргэлзээгүй байсан шүү гэж хэллээ.

- Та зөвхөн баталгаа авах гээд байснаас өөр юмгүй тийм биз? Тэгэхээр та бид хоёр хэлэлцэн тохироод, танд ямар ч эргэлзээ байхгүй болсон болохоор эхний жил зарцуулах ерөнхий хэмжээг тогтооё. За зургаан сая гэж бодъё.

- Зургаан сая ий?! Болно оо гэж Данглар амьсгаадан хэлэхэд, гүн хайхрамжгүйгээр,

- Хэрвээ надад илүү хэрэгтэй бол бид ярилцамз. Гэвч би францад жилээс илүү болохгүй санаатай. Тэгэхээр энэ хэмжээнээс маань нэмэгдэхгүй байх гэж бодож байна. Аяндаа мэдэгдэнэ биз дээ. эхний удаад, надад маргааш иаван зуун франк ирүүлнэ үү. Би үд болтол гэртээ байна. хэрвээ байхгүй бол хэрэг хөтлөгчдөө гарын үсэг үлдээнэ гэж хэллээ.

- Маргааш өлөөний арван цагт мөнгө бэлэн байна гэж Данглар хариулаад – Алт ар авах уу, цаасаар авах уу аль эсвэл мөнгөөр авах уу? Алинаар нь авах вэ?

- Хагасы нь алтаар, хагасы нь цаасаар өгөхөд болно гээд гүн суудлаасаа бослоо.

- Би европын бүх томхон хөрөнгөтэй хүмүүсийг мэддэг гэж боддог байсан юм. Гэтэл харваас үлэмж их байж таарах таны хөрөнгөний талаар би юу ч дуулаагүй байх юм. саяхнаас бий болсон уу? гэж Данглар асуухад Монте-Кристо,

- Үгүй, маш эртний гаралтай юм. энэ бол гар хүрэхийг хориглосон байсан гэр бүлийн хөрөнгө, тэгээд хүү нь нэмэгдсээр байгаад энэ хөрөнгийг гурав дахин нэмэгдүүлсэн юм. Үүсгэн эхэлсэн хүний тогтоосон хугацаа хэдхэн жилийн өмнө дууссан тул, би саяхнаас хэрэгдэх болсон юм. та энэ тухай юу ч мэдэхгүй байгаа нь зүйн хэрэг ээ. гэсэн ч удахгүй үүнтэй ойрхон танилцах болно.

Гүн энэ үгийг хэлэхдээ Франц де Эпинеид аймшиг төрүүлсэн нөгөө инээмсэглэлээрээ инээв.

- Та өөрийн дур сонирхол бодож байгаагаараа манай нийслэлд хөөрхий саятан биднийг давахаар тийм баян тансгийг бий болгож таарна. Та намайг орж ирэхэд миний зургуудыг үзэж байсан, бодвол урлаг сонирхдог бололтой юм. зургийн үзэсгэлэнгээ үзлэхийг зөвшөөрнө үү. Цөмөөрөө л жинхэнэ эх зураг нь гэсэн баталгаатай нэрт мастеруудын зургууд байгаа юм. би шинэ цагийнханд дургүй.

- Тийм ээ таны хэлдэг зөв. Тэд цөм хуучин болж чадаагүй нэг дутагдалтай юм.

- Би танд гадаадын хэдэн мастер Торвальдсен, Бартоломи, Канова нарын хийсэн баримлуудыг үзүүлбэ. Францын мастеруудыг сонирхдоггүйг минь харж байгаа биз дээ.

- Та тэдэнд шударга биш байх эрхтэй, яагаад гэвэл тэд таны нутаг нэгтэнгүүд байх эрхтэй шүү дээ.

- За яах вэ, энэ бүгдийг ойр дотно танилцах хүртлээ хойш тавья. Харин өнөөдөр таныг зөвшөөрвөл Данглар авгайтай танилцуулах төдийхнөөр хязгаарлая. Та миний яарч байгааг уучилна уу. тан шиг үйлчлүүлэгч бол бараг л манай гэр бүлийн нэгэн гишүүн болно.

Монте-Кристо банкны эзний найр тавихыг хүлээн авснаа үзүүлэн мэхэсхийлээ. Данглар хонхоо дарахад гоё хувцастай зарц орж ирлээ.

- Хатагтай өрөөндөө байна уу? гэж Данглар асуулаа.

- Байна аа эрхэм түшээ гүн.

- Ганцаараа байна уу?

- Үгүй зочидтой байна.

- Найз нөхдий нь дэргэд тантай танилцуулахад гүн та дургүйцэхгүй биз дээ. тья нэрээ мэдүүлэх дургүй байгаа юм биш биз.

- Үгүй дээ түшээ гүн, би тэгэх эрхтэй хүн гэж өөрийгөө бодлохгүй байна гэж Монте-Кристо инээмсэглэн хэллээ.

- Хатагтай дээр хэн байна? Эрхэм Дебрэ юу? гэж Данглар асуухад гэр бүлийнх нь нууцыг хэдийнээ мэдсэн Монте-Кристо дотроо инээмсэглэв.

- Тийм ээ эрхэм түшээ гүн.

Данглар толгой дохиод, гүн рүү хандаж,

- Эрхэм Люсьен Дебрэ бол манай хуучин анд, дотоод яамны сайдын гарын нарийн бичгийн дарга. Миний эхнэрийн тухайд гэвэл надтай тэнцвэргүй гэр бүл

болохыг зөвшөөрсөн юм. Их хуучны гаралтай хүн дээ. Де Наргон бэйстэй сууж байгаад бэлэвсрэн хоцорсо юм.

- Надад танай эхнэртэй танилцах завшаан олдоогүй, харин эрхэм Люсьен Дебрэтэй уулзаж байсан.

- Уухай, хаана тэр вэ?

- ЭрхСм де Морсерынд.

- Та бэйстэй танил юм уу?

- Бид хоёр Ромд багт наадмын үеэр дайралдсан юм.

- Өө нээрээ тийм. Ямар нэг дээрэмчин, эвдэрхий балгасанд байдаг тонуулчны ер бусын адал явдлыг тухай сонссон юм байна. тэндээс их л гайхамшигтайгаар аврагдсан юм шиг байна лээ. Морсер Италиас ирээд эхнэр охин хоёрт ярьсан шиг байна лээ.

- Хатагтай орохыг айлтгаж байна гэж зарц хэлэв.

- Би түрүүлэн танд зам заая гэж Данглар мэхэсхийн хэлэхэд, Монте-Кристо,

- Би таныг дагаад явья гэлээ.

9. Сартай хоёр буурал

Түшээ гүн гүнг дагуулан учир утгагүй их гоёмсоглон чимсэн олон тасалгаа өнгөрч ханы нь энэтхэг бөс, ягаан атласаар бүрсэн, хатагтай Дангларын хүн хүлээж авдаг жижигхэн найман талт тасалгаанд орлоо. Хуучин цагийн хоргойгоор өнгөлсөн алтадмал зөөлөн сандлууд байлаа. Хаалганыхаа дээд талд малчны байдлыг Бушейн маягаар зуржээ. Мөн гонзгой хэлбэртэй хоёр харандаан зураг тасалгаан дахь бусад тавилгатай хоршин энэ байшиндаа л өвөрмөц зүйл нь болж байлаа. Тасалгааны гоёл Данглар ба эзэн хаант улсын хамгийн нэрт уран барилгач хоёрын боловсруулсан төлөвлөгөөнд ороогүй нь аз болжээ. Тасалгааны чимэглэлийг хатагтай, Люсьен Дебрэ хоёр хийжээ. Хуучны юмыг л сонирхдог Данглар энэ жижигхэн буланг ойшоон үздэггүй агаад түүнийг хэн нэгнийг дагуулан орж ирэхэд нь хүлээн авдаг байжээ. Үнэндээ Данглар бусдыг авчирч танилцуулдаггүй, харин түүний дагуулж ирсэн хүн хатагтайд аль зэрэг таалагдахаас шалтгаалан сайн муу аль нэгээр нь хүлээн авдаг байжээ. Данглар авгай хэдийгээр нас гучин зургаа хүрсэн боловч гоо үзэсгэлэнтэй хэвээр агаад, урлагийн бяцхан гайхамшигт болсон төгөлдөр, баян хуур хөгжмийн ард сууж Люсьен Дебрэ ажлын бяцхан ширээн дээр зургийн цомог үзэж суулаа. Гүнг ирэхээс өмнө Люсьен түүний тухай хатагтайд хангалттай ярьж амжжээ. Альберынд өглөөний зоог барихад, Монте-Кристо түүний зочдод хичнээн их хүчтэй сэтгэгдэл төрүүлснийг уншигчид мэднэ. Дебрэг ямар нэгэн юмаар гайхуулах нь хэцүү боловч, түүнд төрсөн сэтгэгдэл арилаагүй байгаа нь хатагтайд ярьсан саяын ярианаас харагдаж байлаа. Морсерын түрүүчийн яриа ба Люсьений саяын ярьсан шинэ тодорхой зүйлүүдээс түшээ гүнгийн хатны сонирхох сэтгэл туйлдаа хүрчээ. төгөлдөр баян хуур зургийн цомог бол догдолсон сэтгэлээ нуух дээдсийн хэрэгсэл байлаа. Иймийн учир хатагтай эрхэм Монте-Кристок урьд нь мэдэхгүйгээр инээмсэглэн

хүлээн авав. Гүнд мэхийн ёсолсны хариуд нь ёсорхог боловч сайхан хөдөлгөөнөөр намалзан ёслов. Люсьен гүнг шинэхэн танилын ёсоор мэндэлж Данглартай найзархаг янзаар мэндлэв.

- Хатагтай. Ром дахь харилцагчдын минь ихэд итгэмжлэн зөвлөж илгээсэн Монте-Кристо гүнг танилцуулахыг зөвшөөрнө үү? Энэ хүн манай сайхан хүүхнүүдийн шохоорхох хүн нь болно гэдгийг нэмж хэлж чадах байна. энэ хүн Парист жил болох бодолтой юм байх. Гэхдээ энэ хугацаанд зургаан саяыг үрэх гэнэ. Энэ бол өдийн төдий бүжиг цэнгэл, будаалга цайллага болно гэсэн үг. Манайд болох өчүүхэн баярт бид таныг урихаа мартаггүйн адил гүн бас биднийг мартаггүй биз.

Энэ үг нилээд бүдүүлэг атаархал шиг сонсогдон боловч, нэг жилийн дотор вангийн хөрөнгөний дайтай мөнгө зарцуулдаг хүн Парист цөөн ирдэг учир Данглар авгай гүнг нэлээд сонирхон харлаа.

- Тэгээд гүн та... гэж хатан хэлтэл,

- Өчигдөр өглөө ирсэн гэв.

- Та миний дуулсан тэрхүү заншлаараа ертөнцийн хязгаараас ирэв үү?

- Энэ удаад зөвхөн Кадиксаас ирсэн.

- Харин та жилийн хамгийн муухай цагт иржээ. Зун цагт Парист муухай байдаг юм. Италийн дуурь Лондон руу явчихсан, францын дуурь хаана ч явж байгаа. Харин францын театр ерөөсөө байхгүй болсныг та мэдэх байх. Бидний зугаацдаг юм бол марсын тал Саторид болдог муухан шиг морин уралдаан л болсон. Гүн таны морьд уралдаанд оролцох уу?

- Хэрвээ аз болж францын заншлыг зааж сургах хүн олдвол, би Парист бүх хийж заншсан зүйлийг хийнэ.

- Моринд дуртай юу?

- Би дорно зүгт амьдралынхаа хагасыг өнгөрүүлсэн. Дорнодын ардууд гэдэг чинь энэ дэлхий дээр хоёрхон юмыг үнэлдэг улс байдаг юм. сайн морь, сайхан хүүхэн хоёр доо.

- Та ёсыг бодоод ч гэсэн хүүхнийг нь түрүүн хэлэх байсан юм.

- Харж байна үү, би францын заншилд сургах хүнтэй болох хүслээ илэрхийлсэн минь зөв байгаа биз, хатагтай.

Энэ үед Данглар авгайн шивэгчин орж ирээд эзэгтэйнхээ чихэнд хэдэн үг шивгэнэлээ. Данглар авгайн царай зөвхийрч,

- Үгүй, тэгэх ёсгүй гэж хэллээ.

- Яг үнэн, эзэгтэй минь. Данглар авгай нөхөр өөдөө эргэж

- Энэ үнэн гэж үү?
- Юу тэр вэ гэж Данглар сэтгэл түгшсэн бололтой асуулаа.
- Шивэгчний хэлсэн...
- Тэр танд юу хэлсэн юм бол доо
- Миний хөтөч морио хөллөх гээд адууны хашаанд ороход нь байсангүй гэнэ гэж хэлж байна. Яаж байгаа нь энэ вэ, хэлж өгнө үү?
- Хатагтай минь миний хэлэхийг сонс гэж Данглар хэллээ.
- За таны юу гэж хэлэх сонин байгаа учраас сонсьё. Энэ эрхмүүд бидний буруу зөвийг олно биз.
- Би эхнээс нь аваад ярья. Эрхмүүд ээ, түшээ гүн Дангларын адууны хашаанд арван морь бий. Энэ арван морины хоёр нь болох Парист хамгийн шилдэг хос морь минийх билээ. миний сартай буурлыг Дебрэ та мэднэ шүү дээ. вильфор авгай намайг тэдгээрийгээ хөллөж ирэхийг хүсэж, би түүнд маргааш Булоны ойд зугаална гэж амлачихаад байгаа яг энэ үед морьд минь алга болчихож. Эрхэм Данглар хэдэн мянган франк хожихын тулд л худалдчихсан байх. Бурхан минь энэ наймаачид гэдэг юутай бузар амьтад вэ?
- Хатагтай минь, энэ морьд чинь маш их омголон морьд байсан. Би тэдний төлөө дандаа сэтгэл зовж байдаг байсан гэж Данглар хэлэхэд
- Парисын хамгийн шилдэг хөтөч надад үйлчилж байгааг та сайн мэднэ шүү дээ. хэрвээ л та түүнийг морьдтой нь хамт худалдчихаагүй бол гэж хатагтай хариулав.
- Найз минь, би танд хэрвээ болдог бол тэднээс чинь илүү морь о«ж өгнө. Эдэн шиг айдас хүрээд байхааргүй номхон морьд олж өгөмз. Хатагтай тун жигшсэн янзтай мөрөө хавчлаа. Данглар үүнийг эр эм хоёрын хоорондын жирийн явдал мэт болгон ажиглаагүй дүр үзүүлэн Монте-Кристо гүн рүү хандаж,
- Би гүн тантай түрүүн танилцаагүйдээ харамсаж байна. та чинь одоо л төвхнөж байгаа хүн биз гэхэд
- Тэгэлгүй яахав гэж гүн хариулав.
- Тэдгээрийг таныг ав гэх л байсан байж дээ. би тэр морьдыг сул шахам өгчихсөн. Тэгэхдээ тэр морьдоос салж сэтгэл амарсан гэдгээ түрүүн хэлсэн. Тийм морьд зөвхөн залуу хүмүүст л тохирно.
- Би танд их баярлалаа. Би өнөөдөр овоо эдэлгээтэй морь хямдхан авсан. Аа, эрхэм Дебрэ та моринд дуртай юм шиг билээ? Хар л даа гэж гүн хэллээ.

Дебрэ цонх уруу очиход Данглар эхнэр уруугаа ойртлоо.

- Тэр хоёр моринд галзуурсан үнэ өгсөн юм. Өнөөдөр над уруу хэрэг хөтлөгчөө явуулдаг тэр хоосрохоор шийдсэн тэнэг хүн хэн болохыг бүү мэд. Харин би арван зургаан мянган франк хожсон шүү. Битгий уурлаарай, би дөрвөн мянгыг нь танд, хоёр мянгыг нь Эженид өгнө.

Данглар авгай нөхөр өөдөө тун ч муухай харлаа.

- Бурхан минь! Гэж Дебрэ дуу алдахад,

- Юу болов? гэж хатан асуулаа.

- Үгүй, би андуурах ёсгүй, таны морьд гүнгийн сүйх тэргэнд хөллөөтэй байна.

- Миний сартай хоёр буурал уу? хэмээн Данглар аўгай дуу алдлаа.

- Үгүй байлгүй гэж Монте-Кристо гайхсан дүр үзүүлэн хэлэхэд банкны эзэн,

- Хачин л юм! гэж бувтнав.

Хатагтай ДеҮрэ хэдэн үг шивэgnэвэл цаадах нь Монте-Кристо уруу очиж ,

- Нөхөр нь энэ морийг хичнээнээр хөлсөлсөн болохыг хатагтай мэдэхийг хүсч байна гэв.

- Үнэндээ мэдэхгүй байна. Миний хэрэг хөтлөгч л надад авчирсан байна билээ. Гучаад мянгаар авсан байх аа.

Дебрэ энэ хариултыг хатагтайд дамжуулахаар явлаа. Дангларын царай маш их зэвхийрч, уруу царайлсан байхыг нь хараад гүн түүнийг өрөвдсөн дүр үзүүллээ.

- Харж байна уу? Хүүхнүүд ийм л хачин талархалгүй улс даа. Таны урдаас болгоомжилсон чинь хатагтайн сэтгэлийг хөдөлгөсөнгүй. Одоо яая гэх вэ, хамгийн амархан юм бол тэднийг дураар нь тавих явдал. Тэд толгойгоо хагалчихвал өөртөө л гомдохоос өөр яах вэ? гэж гүн түүнд хэллээ.

Данглар юу ч хэлсэнгүй. Удахгүй хатуу ширүүн юм болохыг мэдэж байлаа. Хатагтай хөмсгөө өргөж аянга цахилгааны тэнгэр Юпитерийн зулай аадар орохыг бэлэгдэх мэт харагдана. Дебрэ ширүүн юм болох дөхөж байгааг мэдээд ажилтай хэмээн яваад өглөө. Монте-Кристо хийе гэж санасан юмаа дэмийн болгочихгүйн тулд түшээ гүнг эхнэрий нь гарт үлдээгээд, хатагтайд мэхийн ёслоод гарч одлоо. “Маш сайн хэрэг! Миний хүссэнээр боллоо. Одоо гэр бүлийн энх тайван байдлыг дахин сэргээх явдал миний мэдэлд орж, нөхөр эхнэр хоёрын зүрхийг хоёуланг нь эзэмдэн авна. Ямар аз вэ! Танилцъя гэж хүсэж байсан мадмаузель Эженитэй дайралдсангүй гэж гүн өөртөө хэлээд ердийнхөөрөө инээмсэглэн –За яах вэ, би Парист байгаа хойно олдоно. Зайлаад явчихгүй” гэж гүн бодсоор гарлаа. Гүн ийнхүү бодсоор сүйх тэргэндээ сууж гэр өөдөө явлаа. Хоёр цагийн дараа Данглар авгай Монте-Кристо гүнээс сэтгэл сэргэм үгтэй захиа авлаа. Парисынхаа амьдралыг сахйан хүүхнийг гомдоосноор эхлэхгүйн тулд хатагтай морьдоо буцаан авна уу хэмээн гуйсан ажээ. Тэр нь хатан өдрийн үзсэн тоногтойгоо бөгөөд харин чихэвч тус бүрт нь нэг нэг очир эрдэнэн шигтгэхийг тушаажээ.

Данглар ч бас захидал авчээ. гүн түүнээс, саятны давилуун зангаар хандан дорно зүгийнхний заншлаар морь буцааж байгааг минь уучлаарай гэжээ.

Орой нь Монте-Кристо Алийг дагуулан Отейль руу явлаа. Али гүнгийн тасалгаанд орлоо.

- Али чи бугуйл сайн хаядаг гэж надад дандаа ярьдаг байх аа гэж гүнг хэлэхэд, Али толгойгоо дохиод бардмаар биеэ тэгшлэн зогслоо.

- Маш сайн. Тэгвэл чи бугуйлын тусламжтайгаар бухыг ч зогсоож чадах юм шив дээ?

Али дахин толгой дохилоо.

- Барыг ч барих уу?

Али толгой дохилоо.

- Аа арсланг?

Али бугуйл хаяж байгаа хүний байдал, бачимдан хүрхрэх дуу гаргав.

- Өө тийм, чи арсланг агнаж байсан шүү дээ гэж гүн хэлэхэд Али бардмаар толгой дохилоо.

- Аа чи туйлж давхисан морийг зогсоож чадах уу?

Али инээмсэглэв.

- За тэгвэл сонсож бай. Өчигдөр надад байсан сартай хоёр буурал морь удахгүй манай хажуугаар эзнээ авч давхина. чамайг дайрсан ч хамаагүй тэр сүйр тэргийг ман й үүдэнд зогсоох ёстой.

Али гадаа гарч гудамж хөндлөн зураас татчихаад буцан ирж хойноос нь харж байсан гүнд зураасаа харууллаа. Гүн түүний мөрийг аяархан алгадлаа. Тэр ингэж Арид талархаснаа илэрхийлдэг байжээ. Тэгээд нуби хүн дахин гарч байшингийн өнцгийн модон дээр суугаад гаанс тамхиа нэрж эхлэхэд гүн өөр юуны ч тухай бодолгүй өрөө рүүгээ оров.

Гэвч таван цаг болж сүйх тэргийг гарч ирхийг хүлээх зуур гүнгийн байдалд бага зэрэг яарсан шинж мэдэгдэж байлаа. Гүн тасалгаан дотуураа хойш урагш явж, байна байн цонхны цаанаас чимээ чагнан , цонхоор харна. Али тамхиа татаж утаагий нь бөөн бөөнөөр гаргаж, энэ чухал ажилдаа бүрэн автсан янзтай сууж байна.

Тэгтэл алсад тэрэгний дугуйн чимээ гарч цахилгаан мэт хурдлан ойртон ирлээ. Дараа нь сүйх тэрэг, галзуурсан мэт давхих морьдоо зогсоох гэж оролдон байгаа хөтөч харагдлаа. Сүйх тэргэн дотор залуу хүүхэн долоон настай жаал хоёр суужээ. Тэр хоёр дэмий л бие биедээ наалдах бөгөөд учиргүй их айснаасаа болоод хашхирах ч чадваргүй болжээ. Сүйх тэрэг нь нажигнана. Дугуй нь чулуун дээгүүр гарах буюу модонд тээглэвэл зайлшгүй хэмхэрч бутрахаар байлаа. Тэрэг гудамжны голоор давхих бөгөөд айсан хүмүүсийн хашхиралдах нь зүг бүрээс сонстоно.

Тэгэхэд Али гаансаа хажуу тийш нь тавиад, хармаанаасаа бугуйл гаргаж шидээд зүүн талын морины урд хөлийг гурван давхар цагиргаар бугуйлдан авлаа. Морь урагшаа хэд алхсан боловч бугуйлд ороогдон унаж, нөгөө морины цааш явахад саад болов. хөтөч ийнхүү зогссоныг ашиглан суудлаасаа үсрэн буулаа. Харин Али аль хэдийн амжиж хоёр дахь морины хамраас төмөр мэт хуруугаар атгахад, морь өвдөн янцгааж гэдийснээ, зүүн талын морьтой зэрэгцэн ойчлоо.

Энэ бүхэнд буун сум гарч байгаа оноход л зарцуулагдах тийм хугацаа өнгөрчээ. гэвч өмнө талд нь энэ бүх явдал болж байгаа байшингаас нэгэн хүн хэдэн зарцынхаа хамт ухасхийн гарч ирэхэд хүрэлцэхүйц хугацаа байлаа. Хөтөч хаалгыг онгойлгомогц нэг гартаа ухаан алдсан хүүгээ тэвэрч, нөгөө гараасаа суудлаасаа зууралдан байгаа хүүхнийг гаргаж авав. Монте-Кристо хоёуланг нь зочдын өрөөнд оруулж буйдан дээр хэвтүүллээ.

- Эрхэмсэг хатагтай танд айх юм байхгүй та аврагдсан гэж хэллээ.

Хүүхэн ухаан орж, хариу хэлэхийн оронд нүдээрээ хүү рүүгээ заалаа. Түүний харц нь ямар ч үгнээс илүү тодорхой байв. Үнэндээ ч хүүхэд ухаангүй хэвээр байв. Гүн хүүхдийг үзэж,

- Ойлгож байна эрхэмсэг хатагтай, бүү зов хүүхдэд юу ч болоогүй, зүгээр л айснаасаа ингэж байгаа юм гэлээ.

- Бурхан минь та зүгээр л тайвшруулж байгаа юм биш биз? Ямар их цонхигор байх юм бэ! Хүү минь! Эдуар! Дуугараач! Эмч рүү бушуухан явуулаач. Хүүгээ аврахын тулд би юүгээ ч хайрлахгүй гэж хүүхэн дуу алдлаа.

Монте-Кристо түүнийг тайвшруулах гэж гараараа дохиод, нэгэн хайрцгийг онгойлгож алтаар чимсэн богемийн болор савтай цус шиг шингэн улаан зүйл хүүхдийн уруул дээр дусаала .

Царай нь зэвхий хэвээрээ байсан хүүхэд нүдээ нээлээ. Эх нь түүнийг хараад баярлан арай л ухаан алдчихсангүй.

- Би хаана байна? Тийм аюултай юмны дараа ийм аз жаргалтай явдал болсны ачийг хэнд хариулах ёстой вэ? Гэж хүүхэн хэлэхэд

- Таныг уй гашуунаас аварсандаа баяртай байгаа тэр хүний гэр байна гэж гүн хариулав.

- Сониучийн гай ийм байх юм. данглар авгайн морьдын сайхныг Парис даяар л гайхан ярьцгаагаад байхаар нь би түүгээр нь зугаалж үзмээр санагдсан юм л даа гэж хүүхэн хэлэв.

- Яалаа гэнэ ээ, эд чинь түшээ гүнгийн авгайн морьд гэж үү? гэж гүн гайхсан дүр үзүүллээ.

- Тийм ээ эрхэм минь. Та түүнтэй танил юм уу?

- Хатагтай Данлартай юу? Түүнтэй танилцах завшаан тохиолдсон юм. энэ морьдоос болж аюулд ороод аврагдсанд тань маш их баяртай байна. Яагаад гэвэл та энэ золгүй явдлын бурууг надад өгч болох байсан юм. би энэ морьдыг өчигдөр түшээ гүнээс худалдаж аваад, хатныг нь гомдоочихсоноо мэдээд тэр дор нь буцаагаад өгчихсөн юм.

- Тэгвэл та чинь Эрминагийн тэглээ их яриад байсан Монте-Кристо гүн байх нь ээ?

- Тийм ээ, эрхэмсэг хатагтай гэж гүн хариулав.

- Аа намайг Элоиза де Вильфор гэдэг.

Гүн огт дуулаагүй хүнийг сонссон адил мэхийн ёсоллоо.

- Эрхэм Вильфор танд яасан их баярлах бол? Та бид хоёрын амийг аварч түүнд эхнэр хүүхэд хоёрыг нь эргүүлэн өглөө. Хэрвээ таны зоригт зарц байгаагүй бол бид хоёр хоёулаа балрах байсан юм.

- Эрхэмсэг хатагтай минь, та хоёр ямар аюулд ороод байсныг бодоход ч хэцүү байна.

- Тэр хүний эрэлхэг зоригийг сайшаан хөхүүлэхийг та зөвшөөрнө гэдэгт итгэж байна.

- Үгүй шүү, Алийг минь магтаал шагналаар бүү муу зан сургачихаарай гэж гуйя. Али бол миний боол. Тэр таны амийг аварснаар надад үйлчилж байгаа хэрэг. Надад үйлчилнэ гэдэг бол түүний үүрэг гэж гүн хэллээ.

Хатагтай Вильфор түүний захирангуй дуунд номхорсон боловч,

- Гэхдээ л амь биеэ хайрлаагүй дээ! гэхэд нь

- Тэр амий нь би аварсан юм. тэгэхээр нь амь бие нь надад хамаарагдах ёстой гэж гүн хариулав.

Вильфор авгай дуугүй байлаа. Энэ хүн яагаад харсан хүн бүхэндээ тийм их хүчтэй сэтгэгдэл төрүүлдэг юм бэ гэж бодож байсан байж магадгүй.

Энэ чимээгүй байгаа богино хугацаанд эхдээ үнсүүлэн таалуулан байгаа хүүхдийг гүн сайн харж амжлаа. Бяцхан, эмзэгхэн бөгөөд улаан шар үстэй хүүхдүүдэд байдаг цагаан арьстай хүүхэд байлаа. Хөнхөр дух уруу нь унжсан өтгөн хар үс нүүрийг нь эмжин хүрээлэх мэт мөрөө хүртэл унжиж, залирхаг хоржин байрын нүдний нь харцыг бүдэгрүүлнэ. Жаал үл мэдэг ягаарах нимгэн уруултай том амтай хүүхэд ажээ. Энэ найман настай хүүхдийг царайгаар нь үгүйдээ л арван хоёртой гэх байлаа. Жаал хүү дөнгөж сэрмсэгцээ эхийнхээ гараас ухасхийн гарч, гүнгийн өнөөх шингэн зүйлийг гаргаж ирсэн хайрцаг уруу очиж, дуртай юмаа хэнээс ч асуулгүй хийж сурсан хүүхэд зангаараа болор савнуудыг оролдож эхлэв.

- Найз минь эднийг бүү оролд гэж гүн яаран хэлээд – Энэ шингэнүүдийн зарим нь зөвхөн уугаад биш, үнэртээд хорддог юм шүү гэж гүн хэллээ.

Вильфор авгайн царай цайрч, хүүгээ өөр рүүгээ татаж гары нь холдууллаа. Хүүхэн тайвшраад хайрцаг уруу түргэн гэгчийн шимтэн харахад гүн түүнийг алдалгүй ажиглачихав.

Энэ үед Али орж ирлээ.

Вильфор авгай түүн рүү инээмсэглээд, хүүгээ улам чанга тэврэв.

- Эдуйар энэ сайн зарц өөд хар. Энэ хүн маш их зоригтой, галзуурах дөхсөн омголон морьдыг салж унах гэж байсан сүйх тэргийг амь харгүй барьж зогсоосон юм. энэ хүнд баярлаж гялайснаа хэл. Энэ хүн байгаагүй бол чи бид хоёр өдийд амьд байхгүй байсан юм.

Жаал хүү хацартаа хий дүүргэж төмбийлгөөд жигшсэн янзтай буруу хараад,

- Ямар муухай амьтан бэ! гэж хэллээ.

Жаал хүүгийн хэлсэн үн яг гүнгийн санаснаар болсон мэт гүн инээмсэглэлээ. Вильфор авгай хүүгээ зэмлэсэн боловч хэрэв бяцхан хүүг Эмиль гэдэг байсан бол Жан-жак Руссогийн санаанд таарахааргүй зөөлөн байлаа.

- Харж байгаа биз гэж гүн Алид араб хэлээр хэлээд - Энэ авгай чамайг хүүхдээ амий нь аварсан хүн, талархал илэрхийл гэж хэлж байна. тэгэхэд хүүхэд нь чамайг ямар муухай амьтан бэ гэж байна гэлээ.

Али ухаалаг нүүрээ эргүүлж хүүг харахдаа царай нь өөрчлөгдөөгүй боловч хамрынх нь самсаа чичрэхийг хараад араб хүн үнэн голоосоо гомджээ гэдгийг гүн мэдлээ.

- Гүнтэн та энэ байшинд байнга суудаг уу? гэж Вильфор авгай явах гэж босонгоо асуулаа.

- Үгүй дээ, энд хааяа ирдэг юм. би Елисейн талын гучдугаар байшинд суудаг. Би энэ морьдыг миний сүйх иэргэнд хөллө гэж тушаасан. Энэ мухай амьтан Али гээд гүн жаал хүү рүү харж инээмсэглэн – Та хоёрыг гэрт чинь хүргэж өгнө. Танай хөтөч энд үлдэж тэргээ харж засуулаг. Засаж дуусмагц миний морьдоос хөллөж Данглар авгайд шжжд аваачиж өгнө гэж гүн хэллээ.

- Үгүй би юу болдог ч байсан энэ морьдоор явахгүй гэж Вильфор авгай хэлэхэд,

- Эд Алийн гарт орохоороо хонь шиг номхон болохыг та үзнэ дээ гэж гүн хариуллаа.

Тэр завсар Али их л зовж хөл дээр нь босгосон морьд дээр очлоо. Тэр гартаа анхилуун үнэртэй цуу шингээсэн далайн хөвөн барьж очоод хөлс хөөс цахарсан хамар, шанаагийн нь арчихад морьд тэр дороо тургиад, хэдэн хором бүх бие нь чичрэн зогслоо. Дараа нь сүйх иэрэг хэмхэрч болсон явдлын сургаар цугларсан олны нүдний өмнө Али морьдыг гүнгийн сүйх тэргэнд хөллүүлээд, жолоогий нь авч хөтчийн суудал дээр суулаа. Саяхан хуй салхи мэт хурдлан давхиж байсан морьдыг

байрнаас нь хөдөлгөх гэж ташуурдан гуядаж арай хэмээн хүчээр хөдлөлгөж байхыг харсан хүмүүс их гайхлаа. Нөгөө их магтдаг байсан хоёр буурал байдгаараа хөшиж, хөдөлж чадахаа болиод, ташуурын хүчээр дөнгөж шогшуулах төдийн байлаа. Вильфор авгай гэр нь байдаг Сент-Оноред хоёр цаг шахам явж очжээ. Вильфор авгай гэртээ ирээд гэр бүлийн сэтгэл хөөрсөн яриа хөөрөө намдаж эхэлмэгц Данглар авгайд дараахь захидлыг бичлээ.

“Хайрт Эрмина!”

бидний өчигдөр орой яриа болоод байсан өнөөх Монте-Кристо гүн, хүү бид хоёрын амийг гайхамшигтайгаар аварлаа. Би тэр хүнтэй өнөөдөр ингэж дайралдана гэж огт бодсонгүй билээ. Өчигдөр таныг тэр хүнийг гайхан шагширан ярьж байхад би хамаг муу үгээрээ ёжлон тоглоом хийж байсан сан. Харин өнөөдөр бол тийм хүнийг үнэлэхдээ дэндүү багаар гайхан шагширч байжээ гэдгийг мэдлээ. Ранелагийн танд тэнд таны морьд авч давхиад, хэрвээ гүнгийн тушаалаар араб негр нуби ч юм уу ер нь нэг хар арьстан зарц амиа хайрлалгүй биднийг барьж аваагүй бол, бид анх дайралдсан мод чулуу мөргөж үхэх байсан биз. тэр өөрөө бүрэн бүтэн байсан нь гайхалтай. Гүн тэр дороо гүйж ирээд бид хоёрыг гэртээ аваачиж Эдуарын минь амийг аварлаа. Биднийг гүнгийн өөрийнх нь сүйх тэргээр гэрт маань хүргэж ирлээ. Танай сүйх тэргийг маргааш буцааж өгнө. Танай морьд энэ золгүй явдлаас хойш бүзр хулхи нь буучихжээ. Тэд хүний гарт ингэж номхорсоноо санахаас л өөрсдийгөө уучилж чадахгүй байна уу гэлтэй санагдана. Тэднийг вандуйгаар тэжээ хоёр хоног адууны жүчээнд тайван байлгавал өчигдөрийнх шигээ гялалзсан сайхан омголон морьд болно гэдгийг дамжуулаарай хэмээн гүн хэлсэн шүү.

Баяртай! Зугаалуулсанд чинь баярласангүй. Гэхдээ таны морьдын омголон зангаас болж танд уурлавал миний зүгээс талархалгүй хэрэг болно. Яагаад гэвэл үүнээс болж би Монте-Кристо гүнтэй танилцсан юм. гадаадын энэ нэртэй хүн олон сая хөрөнгий нь ярихаа больё гэхнээ ч тун оньсого шиг битүүлэг хүн юм. би үүнийга тааж олохын тулд бүх хүчээрээ хичээнэ. Тэр ч байтугай хэрэг тохиолдвол таны морьдыг хөллөж дахин Булоны ойгоор давхисан ч хамаагүй.

Эдуар энэ явдлыг гайхам зоригтойгоор давсан. Тэр ухаан алдсан л даа, гэхдээ ухаан тавьтлаа нэг ч удаа хашхираагүй, дараа нь ганц ч нулимс дусаагаагүй шүү. Та бас л намайг эхийн хайраас болоод тэгж байна гэх биз. гэвч энэ гялх булбарай биенд хатуу зориг байгаа юм.

Валентина танай хонгор Эженид зүрхний халуун мэнд хүргэж байна. би таныг чин зүрхнээсээ үнсье.

Элоиза де Вильфор

Жич: Энэ Монте-Кристо гүнтэй танайд ямар нэг аргаар уулзах бололцоо гаргаж өгөөч. Би түүнтэй дахин уулзахыг хүсэж байна. Түүнээс гадна эрхэм де Вильфорыг түүнтэй уулзуулахаар болсон шүү. Тэр тэднийд очино байх гэж найдаж байна” гэжээ.

Орой нь Отейлд болсон энэ явдлыг ам амандаа ярьцгаалаа. Альбер энэ тухай эхдээ, Шато-Рено Жокей клубт, Дебрэ сайдын тасалгаанд ярилаа. Тэр ч байтугай Бошан гүнг анхааран үзэж болсон явдлын тухай сониныхоо булад хорин мөр юм бичсэн нь харь орны сайн сэтгэлт хүнийг дээдсийн хүрээлэнгийн хүүхнүүдийн нүдэнд баатар

болгон харуулжээ. Олон хүн Вильфор авгайтай уулзаж тэр ер бусын явдлын тухай амнаас нь сонсохыг хүсчээ.

Эрхэм де Вильфорын тухайд гэвэл тэр Элойзагийн бичсэнээр, тэр оройдоо хар цахлай цамц өмсөж, цагган цээлийн хийгээд, зарц нараа хамгийн сайхан хувцсаар нь хувцаслуулж, ёслолынхоо сүйх тэргэнд сууж Елисейн талд гучдугаар байшинд очихоор явлаа.

Х. Гүн ухаан

Монте-Кристо гүн парисын дэдсийн хүрээлэнд удаан байсан сан бол эрхэм де Вильфорын ингэж байгааг зүй ёсоор үнэлэх байсан биз ээ. ван ахмад үеийнх эсвэл залуу үе аль нь ч байсан хамаагүй вангийн ордонд нэр хүндтэй, улс төрийн талаар нэг ч удаа амжилтгүй явдалд орж байгаагүй хүнд байдагчлан овсгоотой хэмээн хүндлүүлэх авч олонд үзэн ядагддаг, хэнд ч хайрлагддаггүй боловч цөөнхөөр хамгаалагдаж байдаг Вильфор шүүх цаазын албан тушаал эзэлж, Арле ба Моле¹ шиг энэ тушаалаа эдэлдэг байлаа. Залуу эхнэр болон түрүүчийн эхнэрээс нь гарсан арван найман настай охины нь ачаар хөл үймээнтэй байдаг түүний зочдын танхим нь уламжлал заншил шүтэх ёс журмыг сахихыг юунаас ч илүү эрхэмлэдэг парисын зочдын танхимын нэг байв. Хэйтнээр ёсорхох, засгийн газрын зарчимд туйлгүй үнэнч байх, онол ба онолч хүмүүсийг байдгаараа жигшин, аль нэг гүн ухааны асуудлыг үзэн ядах, энэ бүхэнд эрхэм де Вильфорын хувийн ба нийгтийн амьдралын гол утга учир нь байдаг байлаа. Вильфор бол зөвхөн хууль фаазын зүтгэлтэн биш, бараг дипломат хүн байлаа. Байнга хүндэтгэн үнэлж, дурсан байдаг түрүүчийн ордонтой холбоотой харьцаа нь одоогийн ордноос Вильфортой хүндэтгэлтэйгээр харьцах болгож, тэр ч байтугай түүнийг тоохоор тогтохгүй заримдаа зөвлөгөө заавар авахад хүргэсэн олон олон зүйлийг мэддэг байв. Хэрвээ Вильфороос хагацаж зайлах болоцоо байсан бол бүх зүйл өөрөөр байх байсан байх. Гэвч тэрээ засаг ноёндoo захирагддаггүй феодалын эрхтэн дархтан шиг гар хүршгүй цайзад бат суусан хүн ажээ. Энэ цайз нь вангийн прокурорын тушаал бөгөөд тушаалынхаа давуу талыг маш сайн ашиглаж чаддагаас гадна, эн тушаалаа зөвхөн төвийг сахисан байдлаасаа эсрэг бүлэгт орж болох боломжтой депутатаар сонгогдвол л орхиж болох ажээ.

Вильфор ер нь хүн урих буюу уригдан очих нь ховор. Энэ ажлыг түүний орноос эхнэр нь гүйцэтгэнэ. Дээдсийн хүрээлэн үүнд нь дасаж, шүүгчийг олон төрлийн чухал ажилтайгаас имй болжээ гэж үзжээ. Гэтэл энэ нь зориудын ихэмсэг язгууртны үан гаргаж “өөрийгөө хүндэтгэж байгаа дүр үзүүл, тэгвэл бусад хүн чамайг хүндлэх болно” гэдэг зарчмыг баримталж явдгийн үр дүн байлаа. Энэ нь манай нийгэмд бол өөрийгөө танин мэд гэдэг грегийн зарчмаас зуу дахин илүү зүйл байв. Вильфор нөхдөдөө бол авран хамгаалагч, дайсандаа бол эвлэрэшгүй нууц дайсан юм. хайхрамжгүй хүмүүст бол Вильфор амьд хүний дүрд харагдахаасаа илүү хуулийг дүрслэн харуулсан баримал мэт харагдах ажээ. Ихэмсэг байдал хайнга царай, өнгөгүй бүдгэр эсвэл нэвт шувт харсан харцтай энэ хүний байр суурийг дээр дээрээсээ зовлонгүй овоорсон дөрвөн хувьсгал бий болгоод цаашид улам ч бэхжүүлээд өгчээ.

Вильфор бол францын хамгийн сониуч биш хамгийн үг дуу цөөнтэй хүн гэгддэг. Жилд нэг удаа бүжигт наадам зохиох боловч түүн дээр дөнгөж арван таван минут орж ирээд гардаг аж. Энэ нь ван ордныхоо бүжигт наадамд биеэр байдгаас дөчин таван минутаар бага болой. Вильфор ший жүжиг концерт дээр ер нь олны цуглардаг

газар огт үзэгддэггүй. Хааяа нэг хөзрөөр вист тоглоход нь өөрт нь тэнцэх ямар нэгэн элчин төлөөлөгч хамба ноён ч юм уу аль нэг ерөнхийлөгч дор хаяж ханы бэлэвсэрсэн эхнэр хам тоглогчоор нь олж өгөхийг хичээнэ.

Монте-Кристо гүнгийн үүдэнд сүйх тэрэг нь ирж зогссон хүн иймэрхүү янзын хүн байлаа. Гүн Санкт-Петербургээс Хятад орох замыг судлан ширээн дээрх том зураг дээр тонгойн байх үед гэрийн даамал орж ирж эрхэм Вильфорыг ирснийг мэдэгдлээ. Энэ хүн бол Марсельд прокурорын туслах байсан хүн буюу чухамдаа тэр хүний үргэжлэл байлаа. Зарчимдаа тууштай абхй нь энэ хүний хувьд өөрийн урсгалдаа юу ч өөрчилсөнгүй. Зөвхөн туранхай байснаа тарга, цагаа байснаа шар болжээ. Хөнхөр нүд нь улам ширгэж зүүсэн шил нь ухархайтай нь налж хаяв гэлтэй нүүрий нь нэг хэсэг мэт харагдах ажээ. Цагаан зангиаг нь тооцохгүй юм бол бүх хувцас нь хар бөгөөд зураач хүн цусны толбыг улаан будгаар түрхсэн юм шиг харагдах энгэр дээрх тууз нь энэ муухай гашуудлын өнгийг эвдэнэ.

Монте-Кристо хэдийгээр биеэ баривч хариу мэхийн ёслохдоо прокурорыг илтэд сонирхон харчихлаа. Хүнд итгэдэггүй дээдсийн амьралын сайн сайхныг сохроор бишрэн шагширдаггүй зантай Вильфор харь газрын сурвалжит хүнийг (Монте-Кристок тэгж нэрлэх болжээ) хутагт хамбын ноён ч юм уу, мянга нэгэн шөнийн үлгэрийн Султан гэж үзхээсээ өөр газар ирж ажиллагаагаа үргэлжлүүлэх гэж байгаа зальхай этгээд ч юм уу оргож боссон хэрэгтэн биш байгаа гэж харах нь их байлаа.

- Энэрэнгүй эзэн та өчигдөр миний эхнэр хүүхэд хоёрт үзүүлсэн үлэмж их ач тус тань намайг танд баяр талархлаа илэрхийлэх үүрэгтэй болголоо. Миний танд талархаж быайгааг минь хүлээн авна уу гэж Вильфор прокурор хүмүүс шүүхийн хурал дээр үг хэлэхдээ хэрэглэдг энгийн яриандаа ч гэсэн хагацаж чаддаггүй царгиа дуугаар хэллээ. Ингэж хэлж байхдаа ч Вильфорын харц ихэмсэг ширүүн хэвээр байлаа. Тэр энэ үгээ ерөнхий прокурорын ердийн аялгуугаар бялдууч хүмүүс хуулийн амьд хөшөө гэж нэрлэдэг тэрхүү хүзүү толгой нь хөдөлдөггүй хөшмөл байдлаар хэллээ. Монте-Кристок мөн л тийм хүйтэн байдлаар

- Өршөөлт эзэн минь, эхийн хайр гэдгээс илүү гэгээн ариун юм энэ дэлхийд байхгү учир эхэд нь үрийг нь аварч өгсөндөө би их баяртай байна. миний хувьд ноогдсон энэ аз завшаан нь танаас үүргээ гэж үзэж байгаа зүйлийг биелүүлэхээс ангижруулж байна. эрхэм де Вильфор имй хүндэтгэлийг ховор үзүүлдэг гэдгийг мэдэх учир би үүнийг надад их гавяатай явдал гэж хэдийгээр өндөрт тавих боловч сэтгэл хангалуун байхаас илүү үнэтэй гэж миний нүдэнд харагдахгүй байна гэв.

Хуягий нь нэвтрэн орох цохилтыг мэдэрсэн дайчин шигээр Вильфор гэнэтийн энэ дайралтанд мэгдэн Монте-Кристок хэзээ ч хүндэтгэж байгаагүй гэдгийг харуулан зэвүүн инээмсэглэл уруулд нь илрэв. Тэгээд найдваргүйгээр алга болсон санагдах яриагаа үргэлжлүүлэх гэж өөр сэдэв эрэн тасалгаг тойруулан харлаа. Орж ирэхэд нь гүнгийн үзэж байсан газрын зургийг харж,

- Та дэлхийн байдал сонирхож байна уу? Улсын ярьж байгаагаар тан шиг энэ зураг дээр дүрслэгдсэн бүх орныг үзсэн хүнд өргөн хэмжээний судлах зүйл дээ гэж хэллээ.

- Тийм ээ, би таны өдөр бүр цөөхөн хүн дээр хийдэг зүйл буюу өөрөөр хэлбэл сэтгэл судлалын судалгааг хүн төрөлхтөнд бүхэлд нь хийх гэсэн юм. сүүлд нь хэсгээс бүхэлд нь шилжсэнээс бүхлээс хэсэгт шилжих нь амархан байх болно. Алгебрын

үнэн бол мэдэгдэж байгаагаас мэдэхгүйг гаргахыг шаардахаас биш мэдэгдэхгүйгээс мэдэгдэж байгаа гаргахыг шаарддаггүй юм. Үгүй та суугаач гэж гүн хэллээ. Тэгээд Монте-Кристо гүн вангийн прокурорт сандал зааж өгөхөд цаадах нь өөрөө сандлаа ойртуулах хэрэгтэй болов. харин гүн өөрөө Вильфорын орж ирэхэд өвдөглөж байсан сандал дээрээ суулаа. Ингэж гүн хажуу тал, нуруугаараа хана руу харж нөгөө яриа болоод байгаа дэлхийн байдлын зураг дээр тохойлдон суулаа. Тэдний яриа байдал төрхөөрөө Морсер ба Днгларианд ярьсан яриатай адил авч байр байдал нь л өөр байв. Энэ завсар аюултай өрсөлдөгчтэй тулгарсан тамирчин бүх хүчээ хураан бэлтгэж байгаа юм шиг хэсэг зуур амс хийсэн Вильфор,

- Та ч гүн ухааны юм ярьж байх шив. нээрээ би тан шиг хийх юмгүй байдагсан бол бага уйтгартай ажил сонгож авах байсан юм гэж эхлэн ярихад,

- Таны хэлдэг зөв. Нарны гэрэлд хүн гээчийг судлахад эвгүй харагддаг. Ингэхэд та намайг юу ч хийдэггүй гэж хэлэв үү? Аа та өөрөө ямар нэг юм хийдэгсэн болов уу? Хялбархнаар хэлэхэд та өөрийнхөө хийж байгаа ажлыг ажил гэж хэлж болно гэж үздэг үү? гэж гүн хэллээ.

Энэ хачин этгээд ширүүн дайралт лахин хийхэд Вильфор улам ч их гахйав. Прокурор ийм зоригтой үгийг дуулаагүй удсан буюу үнэндээ анх удаагаа дуулж байгаа нь энэ аж. Вангийн прокурор хариу хэлэхээр шийдэж,

- Та гадаадын хүн. Таны хэлснээр амьдралын чинь хагас дорнодод өнгөрсөн гэсэн. Тэгэхээр хүн төрөлхтний шударга үнэний шүүх хичнээн ширүүн байдаг бол манай энд болгоомжтой хатуу эрэмбэтэй үйлчилдэгийг та мэдэхгүй байх нь зөв гэж хэллээ.

- Мэдэлгүй яах юэ, мэдэлгүй яах вэ. Энэ чинь эртний Pede Claudio¹ байхгүй юу. би орон бүхний хууль зүйг юунаас ч илүү сонирхож үндэстэн бүрийн эрүүгийн хэрэг таслах ажиллагааг жинхэнэ шударга үнэний шүүхтэй харьцуулж үзлээ. Анхны хүй нэгдлийн үеийн хүмүүсийн өшөө авах хууль бол бурханд хамгийн тааламжтай хууль байжээ гэж боддог.

- Хэрвээ тэр хуулт хэрэгжддэг бол ч үнэхээр хууль цаазны бичгийг энгийн болгож, таны хэлснээр манай шүүгчдэд хийх юм байхгүй байхсан гэж вангийн прокурор хэлэхэд, гүн,

- Энэ асуудалд бид эргэж орж болох л юм. хүмүүсийн шиэн бүтээл гэдэг нарийн төвөгтэйгээсээ энгийн хялбарт шилждэг. Энгийн хялбар зүйл бол дандаа л гүйцэд болосрогдсон зүйлүүд байдгийг та юу эс андах вэ гэж хэллээ.

- Гэсэн ч одоогоор манайд Галлчуудын заншил Ромын эрх зүй Францын уламжлалаас авсан хоорондоо харшилдсан зүйл ангитай хууль тогтоомж байна. энэ бүх хуулиудыг мэдэж авна гэдэг удаан няхуур хөдөлмөр шаардах агаад олж авснаа мартаггүй байхад оюун ухааны багагүй чадвар байх хэрэгтэй гэдгийг та зөвшөөрөх биз дээ гэж прокурор хэллээ.

- Би ч бас тэгж боддог. Харин та францын холбогдолтой хуулиудыг мэддэг бол би бүх үндэстний хуулийг мэднэ. Францын хуультай адилаар Англи, Түрэг, Япон, Энэтхэгийн хуулийг санй мэднэ. Иймээс миний хийсэнтэй харьцуулахад та өчүүхэн юм хийжээ, мөн миний үзэж судалсантай жишихэд таных даанч бага байна даа. та

миний судалж үзсэний чинээнд хүрэх гэвэл их юм сурах хэрэгтэй байна гэж хэлэх бүрэн үндэс байна.

- Ингэхэд та энэ бүгдийг чухам юуны тулд судалсан юм бэ? гэж Вильфор гайхан асуухад, гүг инээмсэглэн,

- Та хэдийгээр ер бишийн хүн гэгддэг боловч харин та бол юмыг олон түмний өдөр тутмын материаллаг талаас нь хүнээр эхэлж хүнээр дуусдаг, өөрөөр хэлбэл хүний оюун ухаан хүрэх боломжтой хамгийн хязгаарлагдмал үзлээр үздэг хүн юм гэж хэллээ.

- Та үүгээр юу хэлэх гээд байна даа? гэж улам ч гайхсан Вильфор асуугаад – Би таныг огт ойлгохгүй байна.

- Та үндэстнүүдийн нийгмийн байгууллага өөд хандсан харцаараа зөвхөн хөдөлгөгч механизмы нь харахаас биш түүнийг хөдөлгөөнд оруулж байгаа бүрэн төгс боловсорсон дарханг олж харахгүй байна. та орчин тойрондоо байгаа сайд эсвэл вангаас тушаан томилсон түшмэлүүдийг харахаас биш, бурхнаас сайд түшмэд вангаас дээгүүр тавьж, албан тушаал гүйцэтгэхийн оронд хийх юмаа хийж яв гэсэн үүрэг өгсөн хүмүүс таны харалган нүднээс мултран өнгөрөөд байх юм. энэ бол сайтар боловсроогүй сул эрхтэнтэй хүн гээчийн сул тал л даа. товы өөрийг нь харан оруулах гэж ирсэн сахиусан тэнгэрийг ердийн залуу хэмээн бодсон гэж ярьдаг. Ард түмэн өөрсдийг нь устгах гэж ирсэн Атиллыг бусад байлдан дагуулагчдын нэг л гэж үзсэн. Тэгэхээр тэр хоёр өөрснийгөө бурхны лүндэнгээр ирснээ мэдэгдэн танигдах хэрэгтэй болсон. Нэг нь би бурхны илч, нөгөөх нь би бурхны алх гэж хэлсэн байдаг.

- Та тэгээд өөрийнхөө саяынхаа хэлдэг ердийн биш хүний нэг гэж бодож байна уу? гэж галзуу солиотой амьтантай ярьж байна хэмээн гайхсан Вильфорыг асуухад,

- Яагаад болохгүй гэж хэмээн өөдөөс нь асуув.

Тэгэхэд нь учраа олохоо больсон Вильфор,

- Уучлах ажаам уу, би танайд ирэхдээ ердийн мэдлэг, жирийн хүний ухаанаас хэд дахин давсан мэдлэг ухаантай хүнтэй танилцана гэж мэдсэнгүй. Соёл иргэншил гээчид эвдэгдсэн бид мэтийн хөөрхий хүмүүс тан шиг ийм үлэмж хөрөнгөтэй баян хүмүүс дор хаяхад ингэж батлаад байгаа юм. би танаас юу ч асуугаагүй, хүмүүсийн ярьж байгааг л давтан хэлж байгаа юм шүү. өөрөөр хэлбэл аз нь дайрсан ийм хүмүүс газар дэлхийн баялгаас хувь заяа нь татгалзаад байгаа тэдгээр хүмүүсийг тайвшруулах гэсэн юм шиг нийгмийн асуудал гүн ухааны мөрөөдлийн хойноос хөөцөлдөн цагаа үрэхийг тэгтлээ таашаадаггүй юм даа гэв.

- Та одоогийнхоо энэ эзэлж байгаа өндөр тушаалд хүртэл явахдаа хааяа уучлагдах зүйл бий гэж нэг ч удаа бодоогүй тийм юмтай дайралдаагүй явлаа гэж үү? Та өөрийн энэ хурц мэргэн байж таарах хараагаа ялд унасан хүнийхээ хамгийн гүн дотор ортол харахыг хэзээ ч бодоогүй юм гэж үү? Шүүгч хүн бол зөвхөн хуулийг хамгийн сайн хэрэглэгч хамгийн бүрхэг бүдэг зүйлийг тайлбарлагч байгаад зогсохгүй, харин хүний зүрхийг шинжлэгч ган хэмжүүр амьд сэтгэхүй бүхнийг бүтээгдсэн тэр алтны хольц их байга алин болохыг шалган хольцыг турших шалгуурын чулуу байж байх ёстой юм биш үү? гэж гүн хэллээ.

- Та намайг мухардуулж байна гэж Вильфор хэлээд – Тан шиг ийм юм ярьдаг хүнтэй хэзээ ч би дайралдсангүй гэлээ.

- Энэ бол та ердийн амьдралын хүрээнээс хэтэрч гараагүйг бурхан үл үзэгдэг онцгой бүтээлээрээ дүүргэсэн тэр өндөр ээд орчинд хүрэхийг зүрхэлж байгаагүйг тань харуулж байна.

- Тэгвэл та ийм орчин байдаг тийм үл үзэгдэгч онцгой бүтээлүүд биднийг хүрээлэн байдаг гэж хэлж байгаа юм уу?

- Яагаад тийм байж болохгүй гэж. та амьсгалж буй, түүнгүйгээр амьдарч чадахгүй агаарыг хардаг гэж үү?

- Тэгвэл бид таны тэр ярьж байгаа юмыг чинь харж чадахгүй байх нь ээ?

- Үгүй, бурхан түүнийг биетэй зүйл болог гэж хүсвэл та харж чадна. Та тэдгээрт хүрч, тэдэнтэй учирч ярилцаж, тэд танд хариу хэлэх болно.

- Бурхны тийм бүтээлүүдийн нэг надтай дайралдах үед нь урьдчилан мэдчихсэн байх юмсан гэж Вильфор инээмсэглэн хэлэв.

- Таны хүсэл биелээд байна шүү дээ. танд урдаас хэлсэн одоо ч бас дахин хэлчихье...

- Тэгэхээр та өөрөө...

- Тийм ээ би тэр онцгой бүтээлийн нэг. Одоог хүртэл энэ ертөнц дээр нэг ч хүн миний байгаа шиг байдалтай байгаагүй байх. Хаант гүрэн ч гэлээ уул ус, элэг буруу зан заншил ч юм уу, өөр хэл аялгуугаараа хязгаартай байдаг. Миний хаанчлал бол орчлон ертөнц шиг хязгааргүй уудам. Би бол Итали, Франц, Энэтхэг, Америк, Испани хүн аль ч биш. Би бол космополит 1хүн. Нэг ч орон миний төрсөн нутаг болж чадахгүй бөгөөд, ганцхан бурхан л хаана үхэхийг минь мэдэх биз. би шазар бүхний заншлыг дагаж хэл бүхэн дээр ярьж чадна. Та намайг франц хэлээр өөр шигээ цэвэрхэн ярьж байгаа болохоор франц хүн гэж бодож байгаа биз. миний нуби хүн Али намайг араб үндэстэн гэдэг. Миний хэрэг хөтлөгч Бертуччо намайг Ромынх гэдэг. Миний эрх чөлөөгүй боол Гайде намайг грег хүн гэдэг. Би нэг ч оронд хамаагүй нэг ч засгийн газраас хамгаалалт эрэхгүй. Нэг ч хүнийг өөрийн ах дүү гэж боддоггүй. Хүчирхэгүүдийн гарыг хөдлөлгүй болгочихдог эргэлзэл тээнэгэлзэл дорой хүмүүсийг дор нь зогсочихдог саад бэрхшээлийн аль нь ч намайг хөдлөхгүй байлгаж чаддаггүй юм даа. надад хоёрхон л дайсан бий. Тэгэхдээ энэ хоёр намайг дийлдэг гэж би хэлэхгүй, яагаад гэвэл би шаргуу зүтгэлээрээ эрхэндээ оруулж чаддаг юм. энэ бол цаг хугацаа зай хоёр юм. гурав дахь нь болох хамгийн аймшигтай үхэх тавилантай төрсөн явдал. Ганцхан үхэл л тавьсан зорилгод минь хүргэлгүй замыг минь зогсоож мэднэ. Бусад бүх зүйлийг би тооцоолсон. Хувь заяаны эргэлт гэж хүмүүсийн нэрлэдэг хоосрол өөрчлөлт гэнэтийн тохиолдлуудыг би урьдаас харсан. Эдгээрийн аль нэг нь надад дайралдаж болно. Гэхдээ аль нь ч унагааж чадахгүй. Би үхээгүй л байгаа цагтаа одоогийн энэ хэвээр байх болно. Ийм л учир би танд хэзээ ч тэр бүү хэл вангийн амнаас ч сонсохгүй зүйлийг ярьж байгаа юм. ванд та хэрэгтэй бусад хүмүүс танаас айдаг. Тиймээс та ийм үг сонсоогүй явсан нь тэр. Манай энэ инээд хүрмээр

бүтээгдсэн нийгэмд вангийн прокурорт очих ямар нэг хэрэг болж магадгүй гэж хэлдэггүй хэн байх билээ.

- Аа танд өөрт чинь энэ үг хамаагүй юу? Та францад сууж байгаа болохоор францын л хуулинд захирагдах ёстой биш үү?

- Би үүнийг мэднэ гэж гүн хариулаад би аль нэг улс оронд очихдоо өөрийн мэдэх арга замаар тэр оронд байгаа надад тус болох эсвэл дайсан болж болох хүмүүсийг судлан мэдэхийг хичээдэг бөгөөд, эцсийн эцэст тэднийг өөрсдөөс нь илүү сайн мэдэж чаддаг юм. энэ бол аль нэг вангийн прокурортой уулзах хэрэгтэй боллоо гэхэд түүнийг өөрөөсөө илүү хүнд байдалд оруулахад хүргэдэг юм гэв. Тэгэхэд Вильфор бага зэрэг эргэлзэн,

- Та тэгээд хүн гэдэг амьтан угийн сул болохоор хүн бүхэн амьдралдаа ямар нэг алдаа хийсэн байдаг гэж хэлэх гээ юу гэж... үг сөрөн хэлбэл гүн

- Алдаа ч юм уу эсвэл гэмт хэрэг гэж хайхрамжгүй хэллээ.

- Тэгвэл хүнтэй ах дүү болохыг үзэж чаддаггүй таны хэлж байгаагаар та л ганцаараа алдаа дутагдалгүй бүрэн төгс хүн байх нь уу гэж Вильфор бага зэрэг дуу нь өөрчлөгдөн хэллээ.

- Би бүрэн төгс болсондоо биш. Харин намайг хэн ч нэвт харж чадахгүй хамаг учир байгаа юм. за энэ яриа таны сэтгэлд нийцэхгүй байгаа бол больё. Таны шударга үнэний шүүх чинь миний алсын хараа таныг айлгаж байгаагаас илүүгээр намайг айлгахгүй гэж гүн хариулав.

Тэгэхэд Вильфор энэ яриаг зогсоох хүсэлтэй байгаа юм байна гэж харагдахгүйн тулд

- Үгүй, үгүй яалаа гэж. та энэхүү урам зоригтой яриагаараа намайг ердийн хэмжээнээс минь дээш өргөлөө. Та бид хоёр зүгээр ярилцаж байгаа биш шүүмжлэн хэлэлцэж байна. сарбоны их сургуулийн индэр дээрээс номлогчид ч юм уу, гүн ухаантнууд маргалдахдаа бие биедээ хатуу ширүүн үнэнийг хэлдэг юм. бид нийгмийн шашны номлол эсвэл шашны гүн ухаанаар оролдож байгаа юм гэж бодъё. Би танд ямар ч гашуун байлаа гэсэн дараахь нэгэн үнэн зүйлийг хэлье. “Дүү минь та хэт бардам загнаж байна. та бүхнээс дээр боловч танаас дээр бурхан байдаг юм” гэв.

- Өөрсдийг нь няц гишгээгүй өөрөөсөө дээр хүн өөд босдог тийм бузар амьтдад бол миний бардам сэтгэл бүхнээс дээр гэвч намайг өчүүхэн амьтан болж хувирахаас аварч одоогийн байдалд минь оруулсан бурхны өмнө би бардам сэтгэлээ бөхийлгөдөг гэж гүн шүд зуун хэлэхэд, Вильфор өөрийн эрхгүй цочин агдасхийв.

-тэгвэл би гүн танаар бахархаж байна гэж Вильфор бүх ярианы туршид гүн гэдэг үгийг анх удаа хэлж,хэрвээ та үнэхээр хүчтэй,дээд зэргийн ариун гэгээн мэдэж танихын аргагүй юм бол таны хэлдэг зөв.Үндсэндээ энэ бараг адилхан л даа.Таны бардам байдал ойлгогдож байна.Үүн дээр л засаг төр үндэслэгддэг юм.Гэлээ ч танд улиглан хүсч байсан юм бий биз дээ.

-Тийм ээ, байсан

-Чухам юу вэ?

-Бүхний амьдралд нэг удаа тохиолддогийн адил, чөтгөр шулам намайг ертөнцийн хамгийн өндөр уулан дээр гаргасан удаа бий. Тэгэхэд, нэгэн цагт Христост¹ үзүүлж байсан шиг тэндээс надад орчлонг харуулаад: "Хүний хүү чи надад баярлахын тулд юу хүсмээр байна" гэж асуусан юм. Намайг удаан хугацаагаар аймшигт хүсэл мөрөөдөл эзэлж байсан тул би удаан бодлоо. Тэгээд би түүнд "Сонсож бай, би дээд тэнгэрийн тухай дандаа сонсож ирлээ. Гэвч түүнийг нэг ч удаа биеэрээ харсангүй. Тэгээд одоо байхгүй хэмээн бодох боллоо. Тэгэхээр орчлон дээр шагнах цээрлүүлэхээс илүү сайхан юм байхгүй болохоор би бурхан болохыг хүсч байна" гэж хэллээ. Тэгэхэд чөтгөр толгойгоо бөхийлгөн санаа алдаж "Чи андуурч байна. Бурхан байдаг юм. Харин чи түүнийг олж харахгүй байна. Дээд тэнгэрийн хүү мөн л эцэг шигээ нүдэнд үл үзэгдэнэ. Тэрээр оньсон хөдөлгүүрээр хөдөлж, харанхуй замаар явдаг учир түүнтэй адилханыг хараагүй юм байна. Чамд миний хийж чадах зүйл бол чамайг бурхны нэгэн хэсэг болгож болно" гэж хэлсэн юм. Тэгээд бид гэрээгээ хийчихсэн. Би сүнсээ үгүй хийчихсэн байж магадгүй. Гэхдээ хамаагүй дахиад гэрээ хийх хэрэгтэй бол дахиад л хийнэ гэж Монте-Кристо үргэлжлүүлэн хэлэв. Вильфор Монте-Кристо өөд хязгааргүй гайхан харлаа.

-Гүн танд төрөл садан бий юу? гэж тэр асуулаа.

-Байхгүй. Би орчлонд ганцаараа хүн.

-Тэр тусмаа муу.

-Яагаад тэр вэ? гэж Монте-Кристо асуув.

-Яагаад гэвэл та бардам сэтгэлийг тань эвдэж болох явдлын гэрч болж болох юм даа. Та зөвхөн үхлээс айдаг гэж хэлсэн байхаа?

-Би түүнээс айдаг гэж хэлээгүй. Зөвхөн надад саад болж болно гэж хэлсэн.

-Аа, хөгширвөл?

-Би хөгшрөхөөсөө өмнө тавилангаараа ирсэн үүргээ гүйцэтгэж дуусна.

-Галзуурвал яана.

-Би галзуурахын даваан дээр байсан хүн. Та "non bis idem"² гэдэг дүрмийг мэднэ. Энэ бол эрүүгийн эрхийн дүрэм болохоор таньд хамаарагдана.

-Зөвхөн үхэл, өвгөрөл, галзуурал, аймшигтай биш гэж Вильфор хэлээд –Жишээлбэл саа дайрах гэж нэг юм байдаг. Энэ бол аянга адил тань дээр бугаад алчихгүй боловч, дараа нь бүх зүйл өнгөрнө. Та мөн байх боловч үнэндээ биш болчихно. Та Ариель³ шиг бараг сахиусан тэнгэр байснаа Калибан шиг адгуус гэмээр амьтан болж хувирна. Үүнийг миний түрүүний хэлсэнчлэн дайрлага дайрах гэдэг юм. Хэрвээ та энэ яриагаа хожим үргэлжлүүлэхийг хүсвэл манайд очоорой. Таныг ойлгож чадах, таныг няцаах хүсэлтэй өрсөлдөгчтэй буюу миний эцэг эрхэм Нуарьтетэй уулзуулъя. Чийрэг бие, хатан зоригтой энэ хүн анхдугаар хувьсгалын үеийн хамгийн хурц ширүүн яkobинчуудын нэг байсан юм. Тэр тан шиг улс бүхнийг үзээгүй ч хамгийн хүчирхэг

улсын нэгийг унагахад оролцсон юм. Тэр мөн л тань шиг өөрийгөө бурхны элч биш юм гэхэд хувь тавилангийн элч гэж үзэж байсан юм. Тэгтэл тархины нь судас тасарч цус харваад энэ бүхнийг нь өдрийн дотор биш, цагийн дотор ч биш, ганц хормын дотор устгачихсан билээ. Өмнөх нь якобинч, сенатч байсан цаазын заазуур, кинжал, үхэр бууны амнаас ч айдаггүй, хувьсгалаар тоглож байсан Нуарьте, франц улс түүнд шатрын том хөлөг мэт болж, хаанд л мад тавьж байвал, хүү, тэрэг, морь алга болох ёстой байсан аймшигт Нуарьте маргааш нь золгүй Нуарьте болон хувирч, гэрийн хамгийн сул дорой гишүүн ач охин Валентины захиргаанд орж, матери задран сарних төгсгөлийг л хүлээж байгаа хэлгүй хүүр болсон юм” гэж хэллээ.

- Энэ зүйлд миний нүд миний ухаанд шинэ сонин санагдах юм юу ч байхгүй нь харамсалтай. Би эмчирхүү хүн болохоор нөхдийнхөө адил амьд үхсэн матери дотроос сүнс олох гэж олон удаа оролдсон юм. гэвч тэр нь тэнгэрийн бошго адил зүрхэнд мэдэгдэвч, нүдэнд харагдахгүй хэвээр байлаа. Сократ, Сенет гэгээн Август Галлын дараагаар хэдэн зуун зохиолчид шүлэг зохиолдоо мөн л таных шиг тийм зүйрлэлийг бичиж ирсэн юм. гэвч эцгийн зовлон хүүгийн санаа бодлыг хүчтэй өөрчилсөн байж болохыг ойлгож байна. та намайг урьж байгаа болохоор таны гэр бүлийг тэгтлээ гунихруулж байгаа явдлыг хүлцэнгүй харахаар очъё.

- Хэрэв бурхан надад түүний ор төлөөсийг өгөөмрөөр хайрлаагүй бол тийм байж болох байсан юм. энэхүү булш өөд аажимхан алхан яваа өвгөний дэргэд амьдралын босгон дээр зогсож байгаа хоёр хүүхэд байна. нэг нь миний түрүүчийн эхнэр, Рене де Сен-Меранаас гарсан охин Валентина, нөгөө нь таны үхлээс аварч өгсөн хүү Эдуар.

- Та бурхны энэ төлөөсөөс ямар дүгнэлт хийж байна вэ? хэмээн гүнг асуухад,

- Миний эцэг гал цогоор бадарч явсан үедээ, хүний шударга үнэний шүүхээс мултарсан ч гэсэн бурхны шүүхээс мултарч үл чадах алдаа хийжээ гэж дүгнэж байна. тэгээд бурхан зөвхөн ганц хүнийг цээрлүүлье гэж бодоод түүнийг ганцааранг нь ниргэсэн байх гэж Вильфор хариулав.

Гүн инээмсэглэсэн хэвээр байсан боловч, зүрхнийхээ гүнд хорсон архирсан агаад, үүнийг нь Вильфор дуулдагсан бол ухаан жолоогүй зугтаах байлаа.

Нэлээд түрүүн сандал дээрээсээ босон зогсож ярьж байсан вангийн прокурор,

- Баяртай ноёнтон. Би таныг хожим надтай ойр танилцах үед сэтгэлд чинь тааламжтай санагдах гүнээ хүндэтгэсэн сэтгэлтэй буцлаа. Би тийм ч зожиг хүн биш шүү. Тэгээд бас хатагтай Вильфор таны бүх насны найз чинь болно гэв.

Гүн мэхийн ёслоод Вильфорыг тасалгааныхаа үүд хүртэл үдэж гаргалаа. Вангийн прокурор хоёр зарцаа түрүүлүүлэн сүйх тэрэг өөд очиход цаадуул нь түүний тушаалаар хаалгыг нь яаран онгойлгов.

Вангийн прокурор явж бараа нь далд ороход Монте-Кристо уртаар амьсгаа аван инээмсэглэж,

- За боллоо. Хор шингэж гүйцлээ. Нэгэнт зүрх минь хороор дүүрэн болохоор хорыг эсэргүүцэх эм олъё гэж хэлэв. Тэгээд харангыг нэг удаа цохив.

- Би хатагтай дээр орно гэж орж ирсэн Алид хэлээд, - Хагас цагийн дараа сүйх тэрэг ирүүлээрэй гэв.

XI. Гайде

Монте-Кристо гүнгийн Меле гудамжинд суудаг шинэ танил буюу чухамдаа гэвэл хуучин танилууд нь хэн болохыг уншигч таньж байгаа байх. Эд бол Максимилиан, Жюли, Эммануэль нар байлаа.

Энэ хонгор сайхан уулзалтын жаргалтай хэдэн минутыг өнгөрөхийг санахаас өөрийгөө сайн дураар оруулсан тамын гийгүүлэгч, диваажингийн гэрлийг бодохоос л Вильфорыг далд оронгуут гүнгийн царай гэрэлтэн туяарлаа. Харангын дуугаар гүйж ирсэн Али энэ ер бишийн баяраар гэрэлтсэн царайг хараад эзнийг нь эргэн тойрон хүрээлэн байгаа сайхан бодлыг нь үргээчихгүйг хичээн өлмий дээрээ сэмхэн гарч одлоо.

Үд болчихсон байлаа. Гүн Гайдетай өнгөрүүлэх гэж сул цаг үлдээсэн байжээ. Энэ тарчлан зовсон сэтгэл оюуныг баяр цэнгэл тийм амархан эзэмдэж авахгүй. Бусад хүн хүчтэй сэтгэгдэл төрхөд бэлтгэхийн адил энэхүү баярт сайхан сэтгэгдэл төрөхөд бэлтгэх хэрэгтэй байжээ. Залуу грег хүүхэн гүнгээс тусдаа өрөө тасадгаатайг нь бид мэднэ. Эдгээр тасалгаа нь дорно зүгийн маягаар төхөөрөгдсөн ажээ. Шалан дээр нь зузаан түрэг хивс дэвсэж, ханыг нь хоргойгоор бүрж, тасалгаа бүрийн ханын дагуу эргэн тойрон буйдан тавьж, дэрнүүдийг эмх замбараагүй хаяжээ. Гайдед гурван франц нэг грег шивэгчин бий. Эхний тасалгаанд гурван франц шивэгчин алтдан хонхны дуугаар өөрийн эзэн авхайн хүслийг дамжуулан хэлэхэд хүрэлцэхүйц франц хэл мэддэг грег боол хүүхний тушаалыг биелүүлэхээр гүйж ирэхэд бэлэн байна. Монте-Кристо энэ гурван хүүхнийг Гайдед хатах хаан шиг хүндэтгэлтэй байхыг сануулан хэлжээ.

Залуу охин, тасалгаануудын хамгийн мухрын хүн хүлээж авдаг дугариг тасалгаанд байна. энэ өдрийн гэрэл дээрээсээ ягаан шилээр дамжин орж ирнэ. Залуу охин шалаш дээр нөмгөн саатай цэнхэр атлас дэрэн дээр нуруугаараа буйдан наласхийн хэвтэж байлаа. Бүсгүй баруун гараараа толгойгоо тулж зүүн гартаа усан доогуур гүйж аманд очдог шүрэн соруултай Калиан хэмээх гаанс барьжээ. Дорны хүүхэнд бол байгаагаараа л байх авч, франц хүүхэнд бол илт маягласан юм шиг харагдахаар байжээ. Эпир эчэгтэйн өмсдөг энгийн хувцас өмсжээ. Ягаан цэцэг шаглан оёсон, хэрвээ алт сувд шигтгэсэн шангар хошуутай шаахай өмсөөгүй бол Парросын гантигаар хийсэн мэт хүүхдийнх шиг жижигхэн хөлөө хүрэх урт цагаан атласан шалбуур, мөнгөн гогцоо сувдан голчтой өргөн ханцуйтай тууш цагаан цэнхэр судалтай цамц, мөн гурван доржпалам товчтой цээживч маягийн хантааз өмсжээ. парисын ганган хүүхнүүдийн хүсэл болсон урт торгон цацагтай хурц өнгийн бүсээр бүсэлхийгээ жавхайтал ороожээ.

Толгой дээрээ сувдан хэлхээ оёсон алтан тоорцог хэлтгий тавьж, гялтганасан хар үсэндээ гайхам сайхан улаан сарнай цэцэг хатгажээ. Түүний царайны нь гоо сайхны тухайд гэвэл грегийн гоо үзэсгэлэн энэ хүүхэнд цогцолжээ. Гялтганасан хилэн хар нүд, шулуун хамар, шүр шиг улаан уруул, хаш цагаан шүдтэй ажээ. Энэ сайхан бүхэн нь залуу халуун насны цог хиймориор гийгүүлэгджээ. Тэрээр арван ес, хориос хэтрээгүй настай.

Монте-Кристо грег шивэгчин хүүхнийг дуудаж, Гайде дээр орж болох эсэхийг асуугаад ир гэж явуулав. Гайде хариу хэлэхийн оронд шивэгчиндээ үүдний хөшиг сөхөхийг тушааж, дөрвөлжин жаазан дотор хэвтэж байгаа залуу охины зураг шиг харагдлаа. Монте-Кристо тасалгаанд орлоо.

Гайде гаансаа тавилгүй өндийн тохойлдоод, гүнд чөлөөтэй гар сунган өгч инээмсэглээд Спарт-Афины хүүхнүүдий яруу тунгалаг хоолойгоор,

- Чи яагаад над дээр орохыг асууж байгаа юм бэ? Чи миний ноён, би чиний боол байхаа больчихсон гэж үү? Гэж асуулаа. Гүн бас инээмсэглэн,

- Гайде та мэдэж байна уу... гэхэд

- Чи яагаад урьдынх шигээ чи гэж ярихгүй байгаа юм бэ? гэж залуу хүүхэн үгийг нь таслан асуугаад – Би ямар нэг буруу хэрэг хийчхэв үү? Хэрвээ тийм бол намайг та гэлгүй шууд л цээрлүүлэх ёстой юм биш үү? гэлээ.

- Гайде бид францад байна. тиймээс чи эрх чөлөөтэй болсон гэж гүнг хэлэхэд,

- Юугаараа эрх чөлөөтэй гэж? хэмээн залуу охин асуулаа.

- Намайг хаяж явж болно.

- Чамайг хаях ий? Надад чамайг хаях ямар хэрэг байна?

- Юмыг яаж мэдэх вэ, бид хүмүүстэй уулзаж байх болно тэгээд...

- Би хэнтэй ч уулзахыг хүсэхгүй.

- Бидний уулзах залуу хүмүүсийн дотор чамд таалагдах залуу хүн байвал би чамд хатуу ширүүн байхгүй...

- Би чамаас сайн хүн үзээгүй, аав та хоёроос өөр хэнийг ч хайрлаж байгаагүй.

- Хөөрхий хүү минь чи хэзээ ч эцэг бид хоёроосоо өөр хүнтэй уулзаж үзээгүй юм шүү дээ гэж гүн хэллээ.

- Яах вэ! Би хэнтэй ч яримааргүй байна. эцэг минь намайг миний баяр баясгалан гэж дууддаг, чи намайг миний хайр гэж хэлдэг, тэгээд хоёулаа намайг миний хүү гэдэг.

- Гайде чи эцгээ санаад л байна уу? гэхэд залуу бүсгүй инээмсэглэн,

- Энд маань байна гэж охин гараараа нүд зүрхэн дээрээ дарлаа.

- Аа би хаана нь байна гэж гүн инээмсэглэн асуухад,

- Энд тэндгүй гэж хариулав.

Гүн Гайдегийн гарыг авч үнэсэх гэтэл цагаан сэтгэлт охин гараа гэдрэг татаж аваад духаа ойртуулж өглөө.

- Гайде чи одоо эрх чөлөөтэй хатагтай, хатан хаан. чи хуучин хэвээрээ хувцсаа өмсөж болно. Дуртай цагтаа гарч бай. Сүйх тэрэг үргэлж бэлэн байна. Али, Мирто хоёр чамайг даган бараа болж, тушаасан бүхний чинь биелүүлнэ. Харин би ганцхан л юм гуйя..

- Би чийний хэлэхийг сонсьё.

- Төрөл гарлаа нууж, өнгөрсөн үеийнхээ тухай хэнд ч нэг ч үг бүү хэл, алдар цуут эцэг ба хөөрхий эхийнхээ нэрийг ямар боловч бүү хэл.

- Би хэнтэй ч уулзахгүй гэж түрүүн хэлсэн шүү дээ ноён минь.

- Дорнодын ийм ганцаардмал даяанч байдал францад тохирохгүй байж магадгүй. Чи Ром, Флоренц, Милан, Мадридад байсан шигээ л умардын орнуудын зан заншлыг цааш нь үргэлжлүүлэн судал. Чи энд суусан ч дорнод руугаа буцаж явсан ч хэрэг болно.

Залуу охин урсгал том нүдээрээ гүнг харж,

- Ноён минь, бид дорнод руугаа буцна гэж хэлэх гээ юу? гэж асуулаа.

- Тийм ээ охин минь. Би чамайг хэзээ ч хаяхгүй. Мод нь навчнаасаа салдаггүй, навч нь модноосоо салдаг биш билүү гэж гүн хэлэхэд Гайде

- Ноён минь. Би чамайг хэзээ ч хаяхгүй. Би чамгүйгээр бол амьдарч чадахгүй гэдгээ мэдэрч байна гэлээ.

- Хөөрхий хүү минь! Би арван жилийн дараа өвгөн болчихно, тэгэхэд чи бас л залуу хэвээрээ байна шүү дээ.

- Эцэг минь урт цагаан сахалтай байсан. Энэ сахал аавдаа хайртай байхад минь садаа болоогүй. Эцэг минь жаран настай байсан боловч миний л дайралдсан залуу хүмүүсээс хэнээс нь ч хавьгүй илүү сайхан санагддаг ба©сан даа.

- Чи энэ оронд дасах нь шиг байна уу? Ямар байна?

- Би чамтай уулзаж байх уу?

- Өдөр бүр

- Тэгвэл ноён минь та юу гэж асууж байгаа нь энэ вэ?

- Би чамайг уйдчих вий гэж айж байна.

- Үгүй, ноён минь, би өглөө болоход чамайг ирнэ гэж хүлээгээд л, үдэш болоход чамайг ирсэн гэж бодоод л байх болно. Тэгээд ганцаараа байхдаа алс холын Пимд Олимптой өргөн уудам нутгийг дурсан санаж сууна. Сэтгэлд минь уйтгар гуниг хайр хариу талархал ийм гурван сэтгэхүй байх бөгөөд үүнтэй байхад огтхон ч уйдаагүй.

- Чи бас Эпир нутагтаа тэнцэх, эелдэг зөөлөн, уран яруу охин, Гайде. Чиний газар шороонд төрсөн охин тэнгэрээс чи гаралтай байж таарна. Охин минь санаа бүү зов, би чиний залуу насыг дэмий өнгөрөөхгүй тулд бүхнийг хийнэ. чи надад эцэг шигээ хайртай бол би чамд хүү шигээ хайртай.

- Ноён минь, чи андуурч байна. Би аавыгаа чамайг хайрладаг шиг хайрлаж байгаагүй. Таныг өөрөөр хайрладаг. Миний эцэг үхчихсэн байхад би одоо амьд үлдчихсэн байна. харин чи үхчихвэл би бас үхнэ.

Гүн уяхан зөөлнөөр инээмсэглээд гараа өгөхөд, бүсгүй ердийнхөө заншлаар гарыг нь уруулдаа аваачлаа.

Гүн Моррелийнхантай уулзахдаа иймэрхүү янзаар бэлтгээд, Пиндарын шүлгийг аман дотроо шивэгнэн гарч явлаа.

-“Залуу нас гэдэг бол цэцэг, дурлал гэдэг бол түүний үр жимс...”

Аажуухан боловсрохыг нь харж байгаад жимсий нь хураасан үзэмчин жаргалтай...”

Сүйх тэрэг лушаасан ёсоор хүлээж байлаа. Гүнг суухад морьд ердийн заншлаар хурдлан давхив.

XII. Моррелийнхан

Хэдэн минутын дараа гүн Миле гудамжны долдугаар байшинд хүрч ирлээ.

Сэтгэл хөгжмөөр цагаан байшин, хашаа байх бөгөөд байшингийн өмнө гоёмсог цэцгийн мандал байна.

Үүд нээж өгсөн хаалгач өвгөн Коллекс мөн болохыг гүн танилаа. Энэ хүний өрөөсөн нүд сохор болохыг бид мэдэх агаад эрүүл нүд нь сүүлийн арван жилд их муудсан учир гүнг таньсангүй.

Сүйх тэрэг шатанд хүрэлцэн очихын тулд дун чулуугаар хүрээлэн хийсэн усан сангаас оргилсон бяцхан оргилолт булгийг тойрон гарах ёстой байлаа. Энэ оргилолт булаг айлын хүмүүсийн атаархлыг багагүй төрүүлдэг бөгөөд, байшинг “Жижигхэн Версаль” гэж нэрлэдгийн шалтгаан нь болжээ. Усан санд олон улаан шар загас бужигналдан байдгийг хэлэх юун.

Байшинд гал тогоо зоорь байдаг доод давхраас гадна дээрээ хоёр давхар мөн дээврийн тасалгаатай. Залуу хүмүүс энэ байшинг том дархны газар ба хоёр жигүүрийн саравчтай цэцэрлэгийн хамт худалдан авсан байлаа. Эмманюель анх байшинг хараад л бага зэрэг орлого олж болохыг шууд ойлгожээ. Тэр өөртөө цэцэрлэгийн хагас ба байшинг үлдээгээд, дархны газар өөрийн эзэмшил хоёрыг зааглан хана барьж хоёр жигүүрийн саравч, цэцэрлэгийг үлдсэн газартай нь хамт түрээсээр өгчээ. Тэр ийнхүү хямра төсөрхнөөр төвхнөж, Сен-Жермений ямар ч ямбатнаас дутахгүй тусгаарлаж авчээ.

Хоолны өрөөг царс модоор хийжээ. Зочдын өрөөг улаан зандан модоор хийж, хөх хилэнгээр доторложээ. Унтлагын өрөөг нимбэгний модоор хийж, ногоон торгоор

доторложээ. Түүнээс гадна ямар ч ажил хийдэггүй, Эмманюелийн ажлын тасалгаа, ямар ч хөгжим дардаггүй Жюлийн хөгжмийн тасалгаа байдаг ажээ.

Гуравдугаар давхар нь бүхэлдээ Максимилианы мэдэлд байх бөгөөд энэ нь яг охин дүүгийнх нь хэсэгтэй адил, харин хоолны өрөөг нь бильярдын өрөө болгон тэндээ нөхдөө авчирдаг байв. Гүнгийн сүйх тэрэг үүдэнд ирж зогсоход, Максимилиан ороомол навчин тамхи татан, морьдоо цэвэрлэхийг өөрийн биеэр шалган цэцэрлэгийн хаалганы дэргэд зогсож байлаа.

Коклюс хаалга онгойлгож өгөхөд, Батистен хөтчийн суудлаас ухасхийн бууж, ноён хатан Эрбо, Максимилиан Моррельтой Монте-Кристо гүн уулзаж болох болов уу? гэж асуув.

- Монте-Кристо гүн гэж Моррель дуу алдаад тамхиа хаяж ирсэн гийчнийг угтан гүйж – Тэгэлгүй яах вэ бид баяртай байна. гүн та хэлсэн үгээ мартаагүйд тань хязгааргүй их баяртай байна.

Тэгээд залуу офицер чин зүрхнээсээ гүнгий гарыг атгахад, цаадах нь үнэн сэтгэлээсээ авч байгаад эргэлзсэнгүй, ирэхийг нь тэсэлгүй хүлээн, баяртай угтаж байгааг нь харав.

- Явья, явья, би өөрөө таныг танилцуулъя гэж Максимилиан хэлээд – Та шиг ийм хүнийг зарц айлтгах ёсгүй. Охин дүү маань цэцэрлэг дотор ургаж гүйцсэн саргай цэцэг огтолж байна. хүргэн маань өөрийн сонинууд, “Пресс” “Дебатийг” уншаад дэргэд нь байж байгаа. Ер нь Үолитехникийн сургуулийнхны хэлд Жээр хатагтай Эрбо хаана л байна, түүнээс эргэн тойрон дөрвөн метрийн дотор Эммануэлийг байж байгаа гэж итгэлтэй бодож болно.

Шар саргайн бутнаас шарласан навчий нь нямбайлан зулгааж байсан торгон цамцтай залуу хүүхэн хөлийн чимээ сонсоод толгой өндийлгөн харлаа.

Энэ бол бидний танил, хатагтай Эмманюель Эрбо болон хувирсан бяцхан Жюли байлаа. Жюли танихгүй хүн ирсэн байхыг хараад хашхирахад Максимилиан инээд алдаж,

- Дүү минь битгий ай гэж хэлээд, гүн хэдийгээр Парист ирээд хэдхэн хонож байгаа боловч, - Марегийн түрээслэгч гэж юу болохыг мэдэж амжсан байх, хэрвээ мэдээгүй байгаа бол мэдэж аваг гэлээ.

- Өө, эрхэмсэг таныг нааш нь ингэж дагуулж ирнэ гэдэг бол ахын зүгээс урвасан хэрэг. Хөөрхий дүүгээ ямаршуу байдалтай байгааг огт бодохгүй юм гэж Жюли хэлснээ - Пенелон! Пенелон! хэмээн дуудав

Бенгалийн саргай цэцэг ухаж байсан өвгөн хүрзээ газар зоож орхиод, малгайгаа авч,ажилж явсан бохио тэдэнд мэдэгдэхгүйн тулд завжиндаа лав нуугаад тэдэн дээр хүрч ирлээ. Түүний өтгөн хэвээрээ байгаа үсэнд нь хэсэг хэсэг буурал орж, хүрэн бор царай, зоригтой хурц харц нь экваторын наранд шарагдаж, шуурга салхитай танил байсныг нь гэрчилнэ.

-Мадмуазель Жюли та намайг дуудав уу? гэж асуугаад –Юу гэсэн юм бол ? гэлээ.

Пенелон эзнийхээ охиныг сурсан заншлаараа Жюли авхай гэж дуудах бөгөөд хатагтай Эрбо гэж дуудаж хэрхэвч сурахгүй ажээ.

-Пенелон,эрхэм Эмманюельд хүндэт зочин ирээд байна гэж хэл. Максимилиан зочныг өрөө руу оруулна гэлээ. Дараа нь Монте-Кристо хандаж,

-Таныг ганц минут орхихыг зөвшөөрөх байх гэж найдаж байна гэж хэлээд,гүнгийн зөвшөөрөх эсэхийг хүлээлгүй хажуугийн замаар цэцгийн хүрээлэн тойрч гэр уруугаа гүйлээ.

-Эрхэм Моррель, танай гэр бүлийн амгалан байдлыг алдуулчихлаа гэж зовж байна хэмээн Монте-Кристо хэлэхэд Максимилиан инээж,

-Хараач,хараач,нөхөр нь бас хувцсаа солих гээд гүйлээ. Меле гудамжныхан таныг мэднэ,ирэхийг чинь хүлээж байсан юм. Нээрээ шүү гэлээ. Гүн бодолдоо хариулав уу? гэлтэй

-Танай гэр бүл ч жаргалтай юм шиг надад санагдаж байна гэв.

-Эргэлзэх юмгүй,яг тийм шүү. Аз жаргалд хэрэгтэй юм бүхэн эдэнд бий. Эд нас залуу,амьдрал нь жаргалтай,бие биедээ хайр дуртай, энэ хоёр хэдийгээр үлэмж хөрөнгөтэй болж болох байсан боловч,хорин таван мянган франкийн орлогоо, Ротчильд шиг баян гэж үздэг юм.

-Үнэндээ ч хорин таван мянган франкийн орлого гэдэг бага юм шүү гэж Монте-Кристо эевэргүү зөөлнөөр хэлэхэд түүний дуу нь Максимилианы зүрхэнд хайрт эцгийнх нь дуу шиг сонстжээ.,-гэсэн ч энэ бол залуу хоёрын хөрөнгийн хязгаар биш,эд лав сая хөрөнгөтэй болцгоох байх. Танай хүргэн чинь өмгөөлөгч юм уу,эмч юм уу?

-Худалдаачин байсан юм. Талийгаач эцгийн минj ажлыг үргэлжлүүлж байсан юм. Эрхэм Моррель таван зуун мянган франкийн хөрөнгө орхиод өөд болсон. Үүний хагас нь надад,хагас нь дүүд минь ногдсон. Бид хоёр хоёулхнаа улс. Нөхөр нь анх суухдаа сайхан сэтгэл,саруул ухаан,хиргүй нэр төрөөс өөр юу ч үгүй байсан юм. Тэгээд эхнэрийнхээ хирийн хөрөнгөтэй болохыг хүсч,хоёр зуун тавин мянган франктай болтлоо ажил хийв. Үүнд зургаан жил шаардагдсан. Эдний хөдөлмөрт дуртай,найрсаг дотныг нь харахад сэтгэл хөдөлмөөр байдаг. Эд үлэмж баялагтай болохоор авъяас чадвартай боловч эцгийнхээ фирмийн заншлаас юуг ч өөрчлөхийг хүссэнгүй. Энэ хоёр зургаан жилийн дотор шинээр сэтгэдэг хүмүүс хоёр гурван жилд хийх юмыг л хийжээ. Марселийнхан одоо болтол эдний хичээнгүй зүтгэлийг гайхдаг юм. Эцэст нь нэг өдөр Эмманюель хүнд өгөх ёстойгоо төлөөд дуусч байсан эхнэртээ “ Жюли, бид эцсийнхээ зорилго болгосон хоёр зуун тавин мянган франкад дутагдаж байгаа Коклюсийн надад өгсөн сүүлчийн хэдэн зуун франк энэ байна. Чи үүгээр хангагдах уу? Манай пүүс саяар тоологдох эргэлтийн хөрөнгөтэй болохоор дөчин мянган франкийн орлоготой байж чадна. Хэрвээ бид хүсвэл цагийн дараа пүүсээ гурван зуун мянгаар худалдаж болж л байна. Өөрийн пүүсэндээ манайхыг нэгтгэхийг хүссэн эрхэм Делони захиа энэ байна. Яахаа шийд” гэв.

“Найз минь Моррелийн фирмийг зөвхөн Моррель л хөтлөн явуулж болно. Манай эцгийн нэрийг хувирах тавилангаас үүрд аврахын тулд гурван зуун тавин мянган франкаас татгалзах хэрэггүй гэж үү” гэжээ.

“Би бас тэгж бодсон. Гэхдээ чиний саналыг мэдэх гэсэн юм” гэж Эммануэль хэлжээ.

“За тэгвэл ийм байна. бид авах юмаа авлаа, төлөх бүх зүйлээ төлчихлөө. Бид одоо дүнгээ гаргаад кассаа хаачихаж болно. Тгэхээр дүнгээ гаргаад кассаа хаачих уу”

Тэгээд тэд үүнийгээ даруй гүцэтгэжээ. Энэ явдал гурван цагт болжээ. Гурван цагаас арван таван минут өнгөрөхөд хоёр хөлөг онгоцоо даатгуулах гэж хүн ирсэн бөгөөд энэ нь арван таван мянган франкийн цэвэр орлого байлаа.

“Энэ даатгалаа аваад миний түнш эрхэм Далонд оч. Бидний тухайд гэвэл бид ажлаа хаачихсан” гэжээ.

“Удаж байна уу” гэж гайхсан хариуцагч асуухад

“Нэгэн мөчийн өмнө” гэв.

Ингэж дүү хүргэн хоёр маань жилд зөвхөн хорин таван мянган франкийн орлоготой үлдсэн юм гээд Максимилиан инээмсэглэв.

Максимилиан гүнгийн сэтгэлийг улам их баясгасан энэ яриагаа дөнгөж дуусмагц сюртук дээл малгайгаар гоёсон Эммануэль хүрч ирлээ. Тэгээд гүнг зочлон ирсэнд далархсан хүний ёсоор мэхийн хүндлээд, дараа нь гүнтэй хамт цэцэглэж байгаа цэцэрлэг дотуураа явж гэртээ оров.

Зочдын өрөөний том япон ваартай цэцэгнээс анхилам үнэр ханхална. Зохих ёсоор хувцаслаж үсээ маягтайгаар зассан Жюли босгон дээр зогсож байлаа. Үүнд арваас илүүгүй минут зарцуулжээ.

Янз бүрийн шувууд торон хашаан дотор шулганалдан цэцэгт бут, сарнайн хуайсны мөчир, цэнхэр хилэн хөшгийг эмжээрлэх мэт цонхны цаанаас харагдан шувуу жиргэхээс эхлэн эзний баяртай инээмсэглэх хүртэл цөм амгал н тайвныг илтгэх ажээ. Гүн байшинд ормогц эдгээр хүмүүсийн аз жаргал өөрийг нь бүрхэх мэт санагдав. Мэнд усаа мэдэлцсэний дараа тасалсан яриагаа үргэлжлүүлэхийг мартаж бодлогшрон дуугүй зогслоо. чимээ аниргүй болчихсон байхыг гэнэт мэдээд хүч гарган бодлоос ангижрав.

- Хатагтай миний сэтгэл хөдөлснийг уучлаарай. Энэ маань танд лав хачин санагдсан байх. Их нар энэ тайван жаргалдаа дасчихсан улс, харин надад бол хангалуун жаргалтай царай харах гэдэг цоо шинэ зүйл учраас та болоод таны нөхдөөс нүд салгаж чадахгүй байна гэж хэллээ.

- Бид үнэндээ аз жаргалтай улс. Бид маш удаан хугацаагаар зовон зүдэрсэн. Өөрийн аз жаргалыг ийм их үнэтэйгээр олсон хүмүүс цөөхөн байх гэж Жюлийг хэлэхэд гүнгийн царайд сонирхсон төлөв илрэв.

- Энэ бол Шато-Реногийн танд ярьсанчлан гэр бүлийн урт түүх. Та шиг айхавтар гай зовлон, гайхамшигт байрыг үзээд сурчихсан хүнд энэ алын ялихгүй түүх сонин биш байх. Гэхдээ Жюлийн хэлдэг үнэн. Бид хэдийгээр энүүхэн гэр бүлийн хэмжээнд боловч бага биш зовлон үзсэн л дээ гэж Максимилиан хэлэв.

- Бурхан та нарын зовсон сэтгэлийг тайвшруулж байна уу? гэж гүн асуув.

- Тийм ээ гүнтэн. Биднийг онцгойл үзсэн гэхэд болно. Өөрийн сахиусан тэнгэрийг бидэнд ирүүлсэн юм гэж Жюли хэлэв.

Гүнгийн царай улайгаад явчихад түүнээ нуухын тулд ханиалгаад, уруулдаа алчуураа барилаа.

- Баян чинээлэг гэрт төрж өссөн, юу ч хүсэж мөрөөддөггүй хүн бол салхилан давалгаалсан тэнгисээр явж үзээгүй хүн цэлмэг тэнгэр гэж байдгийг үнэлдэггүйн адил амьдралын аз жаргалыг мэдэрдэггүй юм гэж Эмануэль хэлэв.

Гүнгийн хоолой нь чичирч өөрийгөө илрүүлчих вий гэж болгоомжлон босож, тасалгаан дотуур урагш хойш аажим алхав.

- Манай тансаг чимэг таны инээдийг хүргэж байгаа байх аа гэж гүнгийн хойноос харж байсан Максимилиан хэлэхэд, царай нь их л цагаан болсон гүн нэг гараараа хүчтэй цохилон байгаа зүрхэн дээрээ дарж, нөгөө гараараа хар хилэн жинтүүн дээр тавьсан торгон түрийвч дотор нь байгаа болор бумба уруу зааж,

- Үгүй шүү үгүй, би зүгээр л нэг талдаа бичигтэй цаастай нөгөө талдаа дориун доржпалам чулуутай түрийвчийг харж байна гэлээ.

Максимилианы царай төвшин байдалтай болж,

- Манай гэр бүлийн эрдэс баялгийн хамгийн нандин нь энд байдаг юм, гүн минь гэвэл гүн

- Нээрээ ч овоо сайхан доржпалам байна шүү гэлээ.

- Үгүй дээ хэдийгээр чулуу маань зуун мянган франкаар үнэлэгдэх боловч ах маань энэ тухай яриагүй, харин энэ түрийвчин дотор байгаа зүйл бидэнд их үнэ цэнэтэй гэдгийг хэлж байгаа юм. Үүнийг саяхан танд ярьсан хэж сахиулсан тэнгэр орхисон юм.

- Хатагтай таны хэлж байгааг би ойлгохгүй л байна. гэхдээ тайлбарлаж өгөөч гэж зүрхлэхгүй байна. Уучлаарай би ёс алдахыг хүсэхгүй байна гээд гүн мэхийн ёслов.

- Ёс алдах ий? Үгүй шүү харин ч бид тэр тухай ярих дуртай байдаг юм. би энэ түрийвч санагдуулж байдаг тэр сайхан явдлыг нуух гэж бодсон сон бол ингэж ил тавихгүй байсан юм. үгүй бид манай нүдэнд үл үзэгдэгч аврагч ядахдаа далавчаа ч болов хөдөлгөн өөрийгөө ирүүлээсэй гэхдээ энэ орчлон даяар ярих болоцоотой болох сон гэж хүсэж байдаг юм.

- Аа мөн гэж гүн бүдэг дуугаар хэлэхэд, Максимилиан болор бумбыг авч өнөөх түрийвчинд уруулаа хүргээд,

- Гүэ минь манай эцгийг үхлээс, биднийг хоосролоос, бидний нэр төрийг гутамшгаас аварсан тэр хүн үүнийг гартаа брьж байсан юм. уй гашуу үгүйрэл хоосролд нэрвэгдэх байсан золгүй хүүхэд бид тэр хүний ачаар одоо бидний аз жаргалтайг бахдан сайшаах дууг тал бүрээсээ сонсож сууна. Энэ захидлыг гээд Максимилиан түрийвч дотроос нэгээн зурвас гаргаж гүнд өгөөд – Манай эцэг аймшмгт юм шийдээд байсан тэр өдөр энэ захидлыг бичсэн юм билээ. энэ очир эрдэнийг тэр сайхан сэтгэлт хүн миний дүүгийн инжинд зориулж өгсөн юм гэлээ.

Гүн захидлыг задалж үгээр илэрхийлэхийн аргагүй баяр хөөрөөр уншив. Энэ бол Жюлид хаяглаж, Синдбад далайчин гэж гарын үсэг зурсан, манай уншигчдын мэдэх өнөөх захидал байлаа.

- танихгүй хүн гэв үү? Тэгээд тус хүргэсэн хүн чинь та нарт мэдэгдэхгүй байгаа хэрэг үү?

- Тийм ээ түүний гарыг атгах хувь заяа бидэнд олдсонгүй гэж Максимилиан хариулаад- Бид энэ тухай бурханд хүсэж мөргөөгүйгээс болсон хэрэг биш. Харин энэ явдалд өчнөөн битүүлэг нууц зүйл байсныг бид одоо хүртэл учрыг нь олж чадаагүй юм. бүх зүйлийг л шидтэний гар шиг үл үзэгдэгч хүчирхэг гар хийж байсан юм гэлээ.

- Харин би тэр хүний гар хүрсэн энэ түрийвчийг үнэсэж байдгийн адил хэзээ нэгэн цагт гарыг нь үнэснэ гэдэг горьдлого тасраагүй байна гэж Жюли хэлээд,

- Дөрвөн жилийн өмнө Пенелон Триест орсон юм. Пенелон гэдэг маань таныг ирэхэд хүрз бариад явж байсан өвгөн далайчин. Далачнаас цэцэрлэгч болчихоод байгаа нь тэр. Тэгээд дарвуулт онгоцонд суухаар завдаж буй англи хүнийг харж, мянга найман зуун хорин есөн оны зургадугаар сарын таванд надад энэ захидлыг илгээсэн хүн мөн болохыг таньсан байна билээ. Пенелоны баталсанаар бол тэр хүн мөн гэдэг нь эргэлзээгүй байсан ч зүрхлэн уулзаж чадсангүй гэнэ билээ гэв.

- Англи хүн гэнэ ээ! гэж Жюлийн харах бүрд түгшин суусан гүэ хэлээд – Англи хүн гэж хэлэв үү? Гэхэд Максимилиан,

- Тийм ээ, Ромын Томсон ба Фрэнчийн онц төлөөлөгч гэж манайд ирсэн хүн. Морсерынд таныг өөрийгөө Томсон ба Фрэнчийн эзэн гэхээр миний давхийдгийн учир энэ л дээ. энэ явдал бидний хэлсэнчлэн мянга найман зуун хорин есөн онд болсон юм аа. гүн та тэр Англи хүнийг танихгүй биз? гэлээ.

- Гэвч Томсон ба Фрэнчийн пүүс ийм тус хүргээгүй гээд байсан гэж та хэлсэн байх аа?

- Тийм ээ.

- Тэгвэл тэр Англи хүн чинь аавын чинв хийсэн боловч мартчихаад байсан сийан үйлсийн хариуд бололцоотой цаг гарахаар нь тус хүргэсэн байж болох юм даа.

- Юу ч гэж бодож болох юм, тэр ч байтугай ид шид ч гэж хэлж болох юм.

- Түүнийг хэн гэдэг байсан юм бэ гэхэд

- Тэр хүн өөр нэр хэлээгүй гэж Жюли гүнг анхааралтай ширтэн харж – Зөвхөн захидал дээр гарын үсэг зурдаг Синдбад далайчин гэдгээрээ байсан гэв.

- Энэ бол овог нэр нь биш нууц нэр нь байж тарна гэснээ гүн, Жюлийг улам их харж, дууг нь анхааралтай чагнаад байхаар нь

- Тэр хүн миний хэрийн жаахан өндөр ч байж магадгүй нуруутай, нарийхан өндөр захтай, зангиагаа чанга зангидсан биеэ барьсан Сюртук дэлийн товчийг бүрэн товчилсон гартаа дандаа харандаа барьж явдаг хүн биш биз? гэв.

- Та тэр хүнийг таних уу? гэж Жюли баярлан нүд нь гялалзан асуухад

- Үгүй гэж гүн хэлээд – Би зүгээр л тийм хүн болов уу гэж хэлж байгаа юм. тий явдалд өгөөмөр гартай лорд Уйлмор гэдэг хүнийг таньдаг байсан юм.

- Хэн болохоо танигдуулагүйгээр үү?

- Ачийг санах гэдэгт итгэдэггүй хачин хүн байсан юм.

- Бурхан минь гэж Жюли хачин царайлан алгаа хавсраад – Тэгээд тэр хөөрхий амьтан юунд итгэдэг юм бэ? гэхэд,

- Лав л надтай уулзсан үедээ юунд ч итгэдэггүй хүн байсан юм гэж Жюлийн чин сэтгэлийн дуунд сэтгэл нь хөөрсөн гүн хэлээд – Тэрнээс хойш хариу талархал гэж байдаг юм байн гэдэгт итгэх болсон ч байж маг дгүй юм гэж хэллээ.

- Гүн та тSp хүнтэй танил юм уу? гэж Эмманюель асуухад, Жюли хажуугаас нь,

- Хэрвээ та түүнийг таньдаг бол түүнийг бидэнтэй уулзуулж,эсвэл хаана байгааг нь хэлж өгч болохсон болов уу? Хэрвээ бид нэгэн цагт түүнтэй уулзвал,тэр хүн сэтгэл зүрхний нандин дурсгалд итгэхгүй байж чадахгүй гэж дуу алдлаа. Монте-Кристо нүдэндээ нулимс бүрхээд ирэхээр дахин босч зочдын өрөө дотуур хойш урагш явлаа.

- Гүн та бурхныг бодож,тэр хүний тухай юм мэддэг бол хэлж өгнө үү гэж Максимилиан хэлэхэд, Монте-Кристо сэтгэл догдолсон байдлаа дууныхаа өнгөнд мэдэгдэхгүйг хичээн,

- Хэрвээ та нарт ач тус болсон хүн лорд Уилмор мөн байсан бол та нар хэзээ ч түүнтэй уулзахгүй байх гэж айж байна. Би хоёр гурван жилийн өмнө Палермод түүнтэй уулзахад тэр үлгэрийн юм шиг орноор явна гэж байсан. Түүнийг тэндээсээ буцаж ирнэ гэж бодохгүй байна гэлээ.

-Та яасан айхавтар юм ярьж байна гэж Жюли нүд нь нулимсаар дүүрч бүр арга барагдсан байдалтай дуу алдлаа.

Монте-Кристо Жюлийн хацар дээгүүр урсан байгаа тунгалаг сувд мэт усан хэлхээг харж,

- Хэрвээ лорд Уилмор миний харж байгаа энэ бүхнийг харсан бол дахин амьдрал гээчид дурлах байсан байх. Яагаад гэвэл таны асгаруулж байгаа нулимс түүнийг хүн төрөлхтөнтэй эвлэрүүлэх байсан даа гээдгараа өгөхөд гүнгийн дууны өнгө, харцанд автсан бүсгүй мөн өөрийн гарыг өгөв. Бүсгүй горьдлого тасарсангүй,

- Үгүй, тэр лорд Уилморт эх орон, гэр бүл, төрөл садан ч юм уу түүнийг мэдэх хүн баймаар юм аа? Бид бас оролдоод үзвэл... гэж хэлтэл гүн,

- Эрэх хэрэггүй. Миний амнаас гарсан сайхан үгэнд бүү хуурт. Ер нь та нарын эрж байгаа хүн лорд Уилмор гэдэг юу л бол. Бид хоёр үерхдэг байсан болохоор би түүний бүх нууцыг мэднэ. Тэгэхээр надад энэ тухай заавал хэлэх ёстой гэж хэллээ.

- Танд юу ч хэлээгүй юу гэж Жюли асуулаа.

- Юу ч яриагүй.

- Тэгж бодмоор үг ч хэлээгүй юу?

- Хэзээ ч үгүй шүү.

- Гэсэн ч та түүний нэрийг шууд хэлсэн шүү дээ.

- Аль юм санаанд орохыг тэр гэх вэ?

- Дүү минь гээд Максимилиан гүнд туслахыг бодож- Манай зочны хэлдэг зөв. Аав минь энэ аз жаргалыг англи хүн авчраагүй гэж дандаа ярьдаг байсныг санаач гэхэд, Монте-Кристо давхийн цочив.

- Танай эцэг эрхэм Моррель та нарт юу гэж хэлээ вэ? гэж шүлэнгэтэн асуув.

- Эцэг минь энэ явдлыг ид шид гэж үздэг байсан . Аав минь бидэнд ач тус болсон тэр хүнийг авснаас босч ирсэн гэж хэлдэг байсан юм. Сэтгэл хөдөлмөөр итгэдэг байсан болохоор би өөрөө хэдийгээр тэгж боддоггүй боловч, тэр сайхан зүрхэн дэх бодлыг нь үгүй хийхийг хүсдэггүй байлаа. Нас барсан хайрт нөхрийнхөө нэрийг аман дотроо шивэгнэн хэлж бодлогошрон суух нь олон байдаг сан. Мөнхийн орон ойртож, үхлийн даваан дээр ирэхэд, түүний санал бодолд таамаглаж байсан зүйл нь итгэл болон хувираад, үхэхдээ хэлсэн үг нь:" Максимилиан, тэр бол Эдмон Дантес байсан юм" гэсэн б'Элээ.

Гүнгийн цонхийн байсан царай нь улам ч аймшигтай болж, бүх цус нь зүрх рүү нь юүлэгдэж, нэг ч үг хэлж чадахгүй боллоо. Тэгээд гэнэт санасан мэт цагаа хараад бүрх малгайгаа авч хатагтай Эрботай тэвдсэн мэт салах ёс гүйцэтгээд, Эммануэль Максимилиан хоёртой гар барьснаа

- Хатагтай минь хааяа ирж байхыг зөвшөөрнө үү, танай гэр бүлд байхад надад сайхан санагдаж байна. танайд трээд олон жилийн турш анх удаа цаш хугацаагмартсан болохоор ингэж хүлээж авсанд их баярлаж байна гэлээ.

Тэгээд түргэн түргэн алхлан гарч одлоо.

- Энэ Монте-Кристо гэдэг ямар хачин хүн бэ? гэж Эммауэль хэлэхэд Максимилиан,

- Тийм ээ. гэвч энэ хүн надад алтан зүрхтэй хүн шиг санагдсан. Бид түүний сэтгэлд аятай таатай санагдсан гэдэгт би итгэж байна.

- Түүний дуу нь миний зүрхэнд шингэчихлээ гэж Жюли хэлээд – Тэр бүү хэл энэ дууг урьд нь сонссон юм шиг надад санагдлаа.

XIII. Пирам Фисба хоёр¹

Сен-Опоре хэмээх парисын захын хэсгийн гуравны хоёрыг явж өнгөрвөл, энэ баян хорооны олон сайхан байшингуудын дотроос гэсэн онцлон харагдах үзэмжит сайхан шилтгээний ард талд өргөн цэцэрлэг байгааг үзэж болно. Түүний өтгөн ургасан туулайн бөөр модод бараг цайз болон өндөр хана дээгүүр цухуйн XIII Людовикийн үеийн төмөр сараалжин хашаа бэхлэн тогтоосон дөрвөлжин баганууд дээгүүр тавьсан чулуун ваар саванд өөрийн цагаан, ягаан цэцгүүдийг унжиулан хавар бүр цэцэглэнэ.

Эдгээр ваар савнууд дотор үзэсгэлэнт сайхан шимтэглэй цэцэг улаан цоохор навчсаа салхины аясаар намируулан байх боловч энэ шилтгээний эзэд зөвхөн эргэн тойрон мод тарьсан байшин ба цаад талдаа сайхан ногоон газартай байсан төмөр хашаа бүхий цэцэрлэг рүү харсан хаалгатай хашаа хоёрыг эзэмших болсон тэр эрт цагаас хойш энэ сайхан хаалгыг хүн хэрэглэхгүй болсон ажээ. Гэтэл дамын наймааны шулам ирж Парисын гол гудамж болох Сент-Оноре хэмээх гудамжтай өрсөлдөх тийм гудамж байгуулна хэмээн төлөвлөөд явжээ. Төмөр самбарын хүчээр байгуулагдахаасаа өмнө нэр авсан энэ гудамж баригдаж эхлэн ёстой байсан учир, ногооны газрыг худалдчихжээ. Хэрэг дээрээ хүн нь төсөвлөн бодож, хөрөнгө нь шийдвэрлэн гүйцэтгэдэг болохоор энэ гудамж өлгий дотроо нас барчихжээ. Ногооны газрын бүтэн үнийг худалдаж авсан тэр хүн энэ газраа хүссэн үнээрээ худалдаж чадсангүй, харин эрт орой алин боловч үнэ хүрч алдсан мөнгөө олж авна гэж горьдоод энэ газраа жилд таван зуун франкаар түрээслэн өглөө.

Ийнхүү өөрийн мөнгөний хагас хувийг авах болсон нь тавин хувь аваад дэндүү ядуу орлоготой байна гэж байгаа одоо үед тун ч ялихгүй юм санжээ. Ямар ч байлаа гэсэн ногооны газар өөд ордог байсан цэцэрлэгийн хаалгаа хаалттай, цоож цуургы нь зэв иджээ. Бас тэгээд хүдэг ногоочид язгууртны цэцэрлэгийн дотор талыг харахаас болгоомжлон газраас зургаан тохой өндөр банзан хашаа барьжээ. Үнэндээ завсраар нь зэрвэсхэн харахын аргагүй чигжүү хадаж чадсангүй. Гэхдээ энэ хүндтэй байшинд бусдын харцнаас айх юм байсангүй.

Тэрхүү ногооны газар байцаа, лууван, тарвас буурцгийн оронд өндөр царгас ургах нь энэ хоосон газрыг хэн нэгэн хүн бас л санаж байдгийн ганц баталгаа юм. барихаар төлөвлөж байсан гудамж уруу харсан намхан явган хаалга нь энэ ханаар хүрээлэгдсэн хэсгийн орох гарах үүд нь болжээ. Түрээслэн авсан хүмүүс энэ газрыг ургац муутай юм гээд саяхан хаясан учир энэ газар урьдын хагас хувиа ч өгөхөө болиод долоо хоног болж байгаа ажээ.

Бидний дээр дурьдсан туулайн бөөр мод шилтгээний талаас хашаан дээгүүр давж, цэцэглэн багширч ургасан бусад модод завсраар нь шурган агаар амьсгалахад нь саад үл болно. Өтгөн навчсын завсраар гэрэл арай ядан нэвтрэх нэгэн газар өргөн чулуун сандал ба хэдэн жижиг цэцэрлэгийн сандал байгаа нь зуугаад алхмын цаана ногоон шугуй завсраар бараг л үл харагдах тэрхүү шилтгээнд оршин суугчдын аль нэгийнх нь хүнтэй нуугдан уулздаг газар ч юм уу, эсвэл ганцаараа цаг өнгөрөөх байр болохыг харуулна. Зуны ямар ч халуун өдөр нарны илч нэвтрэхгүй сэрүүн айдаг бөгөөд элдэв чимээ шуугианаас хол, шувууны жиргээн дунд умбан хүн амьтны нүднээс алслагдсан болохоор нь энэ газрыг сонгон авсан нь илт ээ.

Энэ хавар Парисынханд заяасан нэгэн халуун өдрийн үдэш энэ чулуун сандал дээр ном, шүхэр, ажлын сагс булан дээр нь юм хатгамлаж эхэлсэн алчуур хэвтэж байлаа.

Сандлын ойролцоо банз хадсан хаалганы дэргэд залуу бүсгүй зогсож, завсраар нь өнөө бидний мэдэх хоосон ногооны газар руу шагайн харна.

Яг тэр үед ногооны газрын хаалга чимээгүй онгойж хилэн малгай, ширүүн даавуун цамц өмссөн зоригтой байрын өндөр залуу орж ирлээ. Энэ ердийн хувцас нь хар үс сахалд нь арай л зохисонгүй. Хүн харж байгаа эсэхийг шалган ийш тийшээ бушуухан хараад ногооны газрын явган хаалгыг хааж шилтгээний хашааны хаалга руу яаравчлан алхав.

Ирэх нь ч ирнэ, гэхдээ ийм хувцастай ирнэ гэж бодоогүй байсан охин түүнийг хараад айн ухарлаа.

Гэвч ирсэн хүн хайр сэтгэлтэй хүн байдаг харцаар ногооны хашааны завсраар цагаан палааж, урт цэнхэр бүс цухалзахыг ажиглан харж амжлаа. Залуу хаалга уруу гүйн ирж, уруулаа завсраар нь наалдуулж,

- Валентина битгий ай, би байна гэж хэлбэл бүсгүй ойртон ирээд,

- Та өнөөдөр яагаад оройтов? гэж асуугаад - Үдийн хоол болох ойртож байгаа, тэгээд бас алхам бүрийг минь мөрдөж байдаг хойд эх, үргэлж намайг тагнаж байдаг шивэгчин хүүхэн, дургүйг минь хүргэдэг дүүгээсээ мултран гарч ажлаа аваад энд ирнэ гэхэд хичнээн амаргүй их болгоомжлол, уран арга хэрэгтэй байдгийг та мэднэ шүү дээ. та яагаад саатсанаа хэлэхдээ бас яагаад ийм хувцас өмссөнөө хэлнэ үү. Би энэ хувцаснаас чинь болоод анхандаа таныг таньсангүй гэлээ.

- Хонгор Валентин минь гээд залуу хүү - Та миний хайр сэтгэлд ахадсан санагддаг болохоор энэ тухай би танд зүрхэлж хэлэхгүй юм. гэлээ ч таныг хаахаараа л тэсэж чадахгүй, хүндэтгэн талархаж явдгаа хэлэхгүй байж чадахгүй юм. тэгээд танаас салаад явсны чинь дараа хэлсэн үгийн тань цуурай намайг тайвшруулж байдаг. Аа харин одоо таны зэмлэсэн явдалд баярлалаа. Энэ надад сайхан байна. энэ бол та намайг хүлээж байсан л юм байна гэж хэлж зүрхлэхгүй байна л даа, тэгэхдээ л намайг бодож байсныг тань харуулж байна. би яагаад хожимдсон яагаад ийм хувцас өмссөнийг та мэдэх гэсэн юм уу? Би үүнийг одоо танд хэлье, тэгэхээр та учрыг нь мэдэж намайг уучлах байх. Би мэргэжил сонгож авлаа гэв.

- Мэргэжил ий? ... Та юу гэж хэлэх гээ вэ Максимилиан? Та бид хоёр ийм дотно юмаараа доог тохуу хийх тийм аз жаргалтай улс гэж үү?

- Амь наснаасаа илүү үзэг юмаараа тоглоом хийхээс тэнгэр намайг зайлуулж яваг гэж залуу хэлээд,

- Харин би зэлүүд хоосон газраар тэнүүчилж, хашаа хороон дээгүүр давж явахаасаа залхаж гүйцлээ. Бас танай аав намайг хулгайч гэж шүүхэд өгчхөж мэднэ гэдэг бол намайг үнэхээр айлгав. Ингэвэл бүх францын армийн нэрийг гутаана. Тэгээд л жижигхэн ч гэсэн хамгаалалтын нэг ч цайзгүй хамгаалалт шаардагдах нэг ч бэхлэлтгүй газар ахмад цолтой дарга хүн дандаа л байж байх явдал хүмүүст сэжиг төрүүлж мэднэ. Ийм учраас ногоон болж тохирох хувцсыг нь өмссөн юм.

- Ямар тэнэг хэрэг вэ?

- Үгүй, энэ бол бидний аюулгүй байдлыг хангаж байгаа зүйл учраас бүх амьдралынхаа туршид хийсэн хамгийн ухаалаг ажил минь гэж би бодож байна.

- За тэгвэл юу болсноо яриач.

- Болно оо! Би энэ ногооны газрын эзнийд очлоо. Түрүүчийн түрээсэлж авсан хүний хугацаа дууссан учир би хөлсөлж авав. Одоо энэ царгас бүгдээрээ минийх. Энэ өвс ногоон дотор овоохой босгож аваад танаас хоёрхон алхмын зайтай байхад хэнд ч саад хийхгүй болсон! Би зол жаргалтай болсондоо баяр хөөрөө барьж чадахгүй байна. Валентина тэгээд энэ бүхнийг мөнгөөр авч болдгийг хараач, тэгж бодохын аргагүй тийм ээ? Арван жилийнхээ амьдралыг ч өгөхөд бэлэн энэ аз жаргал, баяр хөөр ямар үнэтэй олдсон гэж санана таа л даа... Жилд таван зуухан франк. Тэгэхдээ улирал болгонд төлнө. Одоо надад айх юм байхгүй. Би энд гэртээ байгаа юм шиг байж, хашаа уруу шат тавьж танай цэцэрлэгийг харж, ямар ч эргүүл манаанаас айлгүйгээр танд өөрийнхөө сэтгэлийн тухай ярьж байх болно. Харин тэгэхдээ энэ үг муу хувцастай ажилчин хүний амнаас гарлаа гэж таны бардам сэтгэл чинь дургүйцэхгүй бол шүү гэв.

Валентина баярласандаа болоод үл мэдэг дуу гаргалаа. Дараа нь гэнэт атаархлын хар үүл зүрхэнд нь ассан нарны илчийг бүрхэв үү гэлтэй болж уйтгартайгаар,

- Максимилиан, бид хоёр дэндүү чөлөөтэй боллоо. Тэгэхээр болгоомжлохгүй бол энэ аз жаргалаа устган үгүй хийчхэж мэднэ шүү хэмээн өгүүлэв.

- Та ингэж ярьж яаж болноо. Би тантай танил болсон цагаасаа хойш өөрийн санаа бодол, амьдралаа таны санал бодол амьдралд чинь захируулна гэдгийг өдөр бүр нотлон харуулж байгаа биш үү. Таныг надад итгэхэд юу тус болов? миний нэр төр шүү дээ. тийм биш гэж үү? Аюул тохиолдох нь гэдэг сэтгэл намайг түгшүүлээд байна гэж та хэлсэн билээ. тэгэхэд би танд үйлчлэхээс өөр ямар ч шан хишиг горьдохгүйгээр үнэнч шударга үзүүлж, тусламж үзүүлье гэж хэлсэн шүү дээ. түүнээс хойш таны төлөө амь насаа ч өгөх хүмүүсийн дундаас намайг сонгосондоо харамсах тийм шалтгааныг би ам хэл, дохио тэмдгээр ч болов өгсөн гэж үү? Хөөрхий минь та эрхэм де Эпинетэй гэрлүүлэхээр сүй тавьсан ингэж гэрлүүлэх гэж танай эцэг нэгэнт шийдсэн болохоор эрхэм де Вильфорын шийдвэр эргэлт буцалтгүй гэж надад хэлсэн

шүү дээ. одоо яая гэх вэ, би сүүдэрт хоцорч, бүх найдлага горьдлого таны дур зоригт ч биш, өөрийнхөө дур зоригт ч биш харин цаг хугацаа хувь тавилангийн эргэлтэнд тэнгэрт тавьж байна. гэхдээ Валентина та намайг хайрлаж өрөвддөг гэж хэлсэн шүү дээ. таны энэ үлэмж баршгүй үгэнд чинь баярлалаа. Харин энэ үгээ хааяа нэг давтан хэлж байгаарай гэж хүсье. Энэ чинь надад өөр ямар ч юмны тухай бодохгүй айх хүчийг өгдөг.

- Максимилиан энэ л танд зориг чадлыг өгч, энэ л миний амьдралыг баяртай ч золгүй ч болгосон юм даа. би хойд эхийн хатуу ширүүн зан, хүүхдээ хайрлах сохор хайраас нь болж гашуун зовлонг амсаж явах нь дээр үү, аль эсвэл таныг дэргэд минь байхад мсдаг аюул заналаар дүүрэн аз жаргал дээр үү гэж өөрөөсөө олон дахин асуудаг юм.

- Аюул ий гэж Максимилиан дуу алдаад – Та яаж ийм хатуу ширүүн шударга биш үг хэлж чадна вэ. Би таны хамгийн дуулгавартай боол биш үү? Та намайг өөртэйгээ заримдаа ярьж болно гэж зөвшөөрсөн. Харин тантай уулзаж учрах арга хайхыг минь хориглосон шүү дээ. тэгэхэд чинь би таны аяар л болсон. Би энэ ногооны газраар дамжин тантай уулзаж, хаалганы завсраар таныг харалгүй, тэгэхдээ танд ийм ойрхон байж ярилцах арга олсноос хойш таны палаажны хойрмойд ч болсон хүрье гэж гуйгаагүйсэн билээ. залуу чадалтай хүний инээд хүргэм нэн хашаан саадыг давж орох гэж ганц удаа ч болсон оролдсон гэж үү? Би эрт цагийн морьт баатар шиг хэлсэн үгэндээ хүрч байгаа шүү дээ. би таныг шударга биш байна гэж үзэхгүй тул, ядахдаа үүнийг хүлээнэ биз дээ гэж хэлэхэд, Валентина хоёр банзны завсраар хурууныхаа үзүүрийг цухуйлгаж өгөөд Максимилиан түүний нь үнэсэхэд

- Энэ үнэн, та бол миний үнэнч найз. Гэхдээ л та хувийн сонирхлоо бодож ингэсэн байна. Хайрт Максимилиан минь, боол шаардлага тавиад ирэх өдөр тэрээр юм бүхнээсээ хагацна гэдгийг та сайн мэдэж байсан. Найз нөхөдгүй, эцэг минь мартаж, хойд эх минь мөрдөж мөшгөөд байдаг, ганц тайвшруулах юм нь хөрч орхисон, хэлгүй, хөдөлж чадахаа больсон өвгөн л байгаа надтай та ах дүүгийн ёсоор нөхөрлөнө гэж амласан. Тэр ганц өвгөн миний гарыг барих гэж гараа ч хөдөлгөж чадахгүй, надтай зөвхөн нүдээрээ ярьдаг, харин намайг энхрийлэх өчүүхэн юм зүрхэнд нь хадгалагдаж үлдсэн байх. Хувь заяа намайг гашуунаар доог хийж, надаас илүү хүч чадалтай бүхний дайсан, тэдний золиос болгоод, хүүрийг л миний найз, түшиг болгон үлдээжээ. Максимилиан, би их золгүй хүн юм. Та надад дурлахдаа өөрийнхөө тухай биш, харин миний тухай боддог чинь сайн хэрэг гэв.

- Валентина гээд Максимилиан сэтгэл ихэд догдолсон бололтой – Би энэ ертөнц дээр ганц танд хайртай биш, бас охин дүү, хүргэн хоёртоо хайртай. Гэвч энэ хайр бол эелдэг зөөлөн, таныг бодож санагалздагаас шал өөр юм. Таны тухай бодоход бүх цус минь оргилж, амьсгалахад ч хэцүү болж, галзуурсан мэт зүрх минь цохилдог. Хүний хэмжээнээс хэтэрсэн энэ хүч чадлаа танд дурласан сэтгэлдээ шингээсэн юм. Та надад хэлсэн өдөр чинь л би энэ бүхнийгээ аз жаргалд чинь зориулан өгнө. Франц де Эпине бас нэг жил байхгүй байх юм гэж ярьцгааж байна. Энэ нэг жилийн дотор хичнээн ч олон завшаантай явдал, аятайхан учрал тохиолдож болох юм. Ингэж горьдож сууя. Итгэл горьдол гэдэг хичнээн амттай, хичнээн сайхан гэж санана. Та намайг хувиа бодсон гэж зэмлэж байна. Та надад ариун явдалтай Венерийн гоо сайхан боловч хүйтэн баримал хөшөө л гэсэн үг. Та миний үнэнч шударга, дуулгавартай, биеэ барьж байдгийн хариуд юу амласан билээ? Юу ч үгүй. Та надад юу бэлэглэсэн билээ? Бас л юу ч үгүй. Та өөрийнхөө болзоот нөхөр эрхэм

де Эпинегийн тухай надад ярьдаг, тэгэхдээ хэзээ нэгэн цагт түүнийх болно гэж бодохоороо санаа алддаг. Валентина, энэ л таны сэтгэлд байгаа бүх зүйл чинь үү? Яалаа гэж. Би танд бүх амьдрал, сэтгэл зүрхээ өгч, зүрх минь ганцхан таны төлөө цохилж,би таныг алдвал үхнэ гэж өөрөө өөртөө ярьж, өөрийгөө бүхлээр нь танд хамааруулан өгч байхад, өөр хүнийх болно гэдэг бодол таныг айлгах ч үгүй байдаг. Би таны оронд байгаад,би танд дурлаж байгаа шиг надад та тэгтлээ дурлаж байна гэдгийг мэдэрвэл энэ төмөр сараалжны завсраар гараа зуун удаа ч гэсэн сунгаж,хөөрхий муу Максимилианы гарыг атгаж,” Максимилиан,би ганцхан таных л байна. Энэ ертөнц дээр ч тэр,нөгөө ертөнц дээр ч тэр ганцхан л таных” гэж хэлнэ дээ.

- Валентина хариу юу ч дуугарсангүй,гэвч Максимилиан түүний санаа алдан уйлж байхыг сонсов. Тэгээд дороо ухаан орж,

- Валентина, Валентина , Хэрвээ миний үг таныг гомдоосон бол түүнийг минь мартаж орхиорой! гэж дуу алдан хэлэхэд,

- Үгүй,энэ бүгд үнэн. Би ямар золгүй ганцаардмал байгааг та харахгүй байна гэж үү? Аав минь намайг хайхардаггүй болохоор би бараг л хүний гэрт сууж байгаа. Арван жилийн турш миний хүсэл зоригийг өдөр бүр, цаг бүр, минут бүр захирагчдын минь хүсэл зориг хавчин дарж ирлээ. Миний зовлон зүдүүрийг хэн ч мэддэггүй, би ганцхан танд л энэ тухайгаа ярьсан. Хүн бүхэн л надад сайн, надад хайртай юм шиг харагдавч,үнэн хэрэг дээрээ цөм надад дайсагнаж байдаг. Эрхэм де Вильфор охиноо энхрийлхээргүй хатуу чанга хүн, харин Вильфор авгайгаар хоёрдугаар ээжээ болгосондоо Валентина аз жаргалтай байж таарна гэж хүмүүс ярьцгаадаг. Ингэж хүмүүс ташаа боддог. Эцэг минь намайг огт хайхардаггүй,хойд эх минь намайг үзэн яддаг. Энэ нь үргэлжийн инээмсэглэлээр халхлагдаж байдаг учраас улам ч аюултай гэж хариулав.

- Валентина,таныг үзэн яддаг ий? Таныг үзэн ядаж яаж болдог юм бэ?

- Найз минь гэж Валентина хэлээд,-Түүний үзэн яддаг нь маш амархан юмаар тайлбарлагдана. Тэр ганцхан хүүгээ,миний дүү Эдуардыг л боддог гэлээ.

- Тэгээд яагаа вэ?

- Эд мөнгөний асуудлыг хутгах надад үнэндээ эвгүй байна. Гэсэн ч чухам үүнээс л болоод намайг үзэн ядаад байгаа юм. Түүнд өөрт нь ямар ч хөрөнгө байхгүй. Би эхээсээ их хөрөнгө үе залгамжлан авсан хүн. Энэ маань бас, нэгэн цагт эрхэм Сен-Меран, хатагтай Сен-Меран хоёроос өв залгамжлан авахаар хоёр дахин нэмэгдэх юм. Ийм болохоор л надад атаархаад байгаа юм шиг надад санагддаг. Хэрвээ би хөрөнгөнийхөө хагасыг түүнд өгчихөөд, өөрийгөө эцгийн гэрт төрсөн охины нь ёсоор сууж байгаа хүн гэж бодож болдог бол дор нь түүнд өгчихмөөр байна.

- Хөөрхий Валентина минь!

- Тийм ээ би хавчигдсан, тэгээд бас сул дорой гэж өөрийгөө боддог. Энэ шахалт хавчилт маань намайг тогтоон дэмжиж байгаа шиг санагдах учир түүнээсээ ч элахаас айх юм. Аав бол ямар ч үлгүйгээр үгэнд нь орохгүй байж болдог хүмүүсийн нэг биш. Хир буртаггүй өнгөрсөн үе ба бараг халдашгүй тушаалаараа намайг,таныг

тэр ч байтугай ванг ч захирч чадах хүн. Би таныг өөртэйгээ хамт үрчих бий хэмээн айх учир түүнтэй тэмцэлдэхгүй гэж танд тангараглая.

- Валентина, гэлээ ч гэсэн гутарч гунихраад ирээдүйг муухайгаар харахын хэрэг юу байна? гэж Максимилиан зөрж хэлэв.

- Найз минь, би үүнийг өнгөрсөн үеийн явдлаар л ингэж үздэг юм.

- Би сурвалж язгуурын талаар тийм гялалзсан хүн биш ч гэсэн таны дотор нь амьдарч байгаа тэр хүрээлэнд харьяалагдсан хүн. Франц дотор хоёр Франц байсан үе өнгөрсөн. Вант засгийн үеийн дээд язгууртнууд эзэн хаант засгийн язгууртнуудтай холилдож, хүйтэн жад сэлмийн дээдчүүл их бууны дээдчүүлтэй сүлэгдэн нийлсэн... Би энэ сүүлчийнхэд нь харьяалагддаг. Армид намайг сайхан ирээдүй хүлээж байна. Надад их биш боловч хэнээс ч хараат биш хөрөнгө бий. Эцэст нь манай хязгаар нутагт миний аавыг хамгийн гүндүүгүй буянтай худалдаачдын нэг гэж санан дурсаж байдаг юм. Би таныг бараг Марселийн хүн болохоор чинь "Манай хязгаар нутаг" гэж байгаа юм шүү.

- Максимилиан, та надад Марселийн тухай бүү яриач. Зөвхөн энэ үг л ганц охиноо энэ дэлхий дээр удаан харж хамгаалж чадаагүй эхийг минь санагдуулдаг юм. Тэр минь охиноо мөнхийн орноос харж хамгаалсаар байгаа гэж би итгэж явдаг. Ай, хөөрхий ээж минь амьд байсан бол айх юм юу ч байхгүй байсан. Би шууд л тань дуртай гэж хэлэхэд, ээж минь бие хоёрыг хамгаалах байсан.

- Хэрвээ эх чинь амьд байсан бол би таныг танихгүй байсан байх. Та түүнийгээ байсан бол аз жаргалтай байсан байх гэж хэлдэг. Аз жаргалтай Валентина намайг тоож харахгүй байх ёстой гэж Максимилиан зөрж хэлэхэд, Валентина,

- Найз минь, та одоо намайг шударга бишээр хэллээ... Харин та хэлээч... гэж дуу алдахад, - Максимилиан түүний тээнэгэлзэн эргэлзэж байгааг хараад,

- Та надаар юу хэлүүлэх гээ вэ? гэж асуулаа.

- Марсельд байхад танай, манай аавын хооронд ямар нэг зөрөлдөөн байсан уу? Надад хэлж өгөөч? гэж бүсгүй хэлэхэд,

- Үгүй, би энэ тухай хэзээ ч , юу ч дуулаагүй гэж Максимилиан хариулаад, - Танай эцэг Бурбоны талыг хатуу баримталсан байсан бол манай эцэг императорт үнэнч байснаас өөр юу ч мэдэхгүй юм. Энэ нь л тэдний ганц зөрөлдөөн байсан байх. Харин та яагаад энэ тухай асуух болов? гэлээ.

- Би одоо учрыг нь хэлж өгье. Энэ явдал бол таныг хүндэт легионы одонгоор шагнасан тухай сонинд нийтлэгдсэн тэр өдөр болсон юм. Бид цөмөөрөө өвгөн аав Нуартъегийн өрөөнд байлаа. Тэнд бас банкны эзэн Данглар байсан. Яагаа вэ, уржигдар морьд нь хойд эх, дүү хоёрыг золтой л алчихаагүй юу. Би өвгөн аавд сонин уншиж өгч, бусад нь Дангларын охиныг гэрлүүлэх тухай ярьж байсан юм. Тэгээд өглөө нь та надад Энэ сайхан мэдээг хэлсэн болохоор, танд холбогдох тэр газарт хүрэхэд хичнээн их баярласан гэж санана... Би таны нэрийг дуулдахаар хэлэх болсондоо сэтгэл минь их хөдөлж билээ. Намайг тэр хэсгийг хэлэлгүй дуугүй

өнгөрчихвөл муу юм бодож магадгүй гэж айгаагүйсэн бол би орхичих байсан юм. Тэгээд зориг гаргаж түүнийг уншсан гэж залуу охин хэллээ.

- Хонгор Валентина минь!

- Тэгээд таны нэрийг хэлмэгц, эцэг маань эргэж харлаа. Данглар ч бас цочсон. Таны нэр тэднийг тэнгэр ниргэсэн юм шиг цочоосон гэдэгт би итгэж байна.

- “Байз,байз, Моррель ий! (тэгээд тэр хөмсгөө зангидан) Өнөө мянга найман зуун арван таван онд бидэнд өчнөөн төвөг удсан Марселийн Моррель биш биз” гэж аав хэлэхэд, Данглар,

- “Тийм ээ. Тэр ч байтугай хөлгийн эзний хүү байх аа” гэж хариулсан.

- Ухай! Тэгээд танай эцэг юу гэж хариулав? Гэж Максимилиан асуулаа.

- Аймшигтай, би танд хэлж зүрхлэхгүй байна.

- Яах вэ, хэл,хэл гэж Максимилиан гуйлаа.

- “Тэдний эзэн хаан, тэр хэнхэг юмнуудаа байр байрыг нь олж тавьж чадаж байсан юм. Тэднийгээ үхэр үхэр бууны зоог гэж хэлдэг байсан нь зөв олсон нэр шүү. Шинэ засгийн газар энэ аврагч зарчмыг дахин явуулж байгаад би баяртай байна. Засгийн газар зөвхөн үүний тулд Алжирыг хадгалж байгаа бол, хэдийгээр Алжир бидэнд үнэтэй олдож байгаа боловч би засгийн газарт баяр хүргэж байна”гэж хөмсгөө зангидсан хэвээр үргэлжлүүлэн ярьсан.

- Энэ ч үнэхээр гүжирмэг бодлого байна шүү. Гэж Максимилиан хэлээд - Та эрхэм де Вильфорын хэлсэнд бүү санаа зов. Манай аав энэ тухай дандаа л “ Үргэлж эрүүл ухаанаар ажил төрлөө явуулдаг эзэн хаан яагаад шүүгч өмгөөлөгчдийн хороо байгуулж тэргүүн шугаманд явуулдаггүй юм бол” гэж хэлдэг байсан юм. Хоёр тал зөөлөн сэтгэл,сайхан үгээрээ бие биеэсээ дутахгүй байгааг харж байгаа биз. Вангийн прокурорын тэр ёжтой үгэнд Данглар юу гэж хариулав?

- Тэр өөрийн заншлаараа уйтгартай инээвхийлсэн. Гэхдээ их хорлонтой юм шиг санагдсан шүү. Тэгээд минут хиртэй болоод гарцгаасан. Тэгэхэд л өвгөн аавын сэтгэл их хөдөлсөн байхыг ажигласан. Хөөрхий саа өвчтэй энэ өвгөний сэтгэл хөдөлсөн байхыг ганцхан би л мэддэг юм. Тэр яриа түүнд лав хүнд сэтгэгдэл төрүүлсэн байх аа. Хөөрхий өвгөн аавыг хэн ч анхааран үздэггүй юм. Тэр эзэн хаандаа үнэнч хэвээрээ шүү.

- Эзэнт улсын үед түүний нэр үнэхээр цуутай байсан юм гэж Максимилиан хэлээд,- Тэр сенатач байсан, бас Дахин сэргэлтийн үед бонапартын талын бараг бүх хуйвалдаанд оролцож байсныг та мэдэх болов уу.

- Мэднэ, надад их хачин санагддаг. Өвгөн аав бонапартынх,аав минь роялист байх гэдэг хачин хэрэг шүү, тийм ээ?... Тэгээд би өвгөн аав руу эргэн харлаа. Тэгэхэд нүдээрээ сонин руу дохилоо.

- “Өвгөн аав, та яав? Сэтгэл ханамжтай байна уу?” гэж асуухад тэр тийм гэж нүдээрээ дохилоо.

- “Аавын хэлсэн үгэнд үү?” гэхэд тэр үгүй гэж дохив.

- “Эрхэм Дангларын хэлсэн үгэнд үү?” Тэр бас л үгүй гэж дохилоо.

- “Тэгвэл эрхэм Моррель Хүндэт легионы одонгоор шагнагдсанд уу?” Тэр тийм гэсэн дохио өглөө.

- Максимилиан, тэр таныг танихгүй мөртөө таны шагналд сэтгэл ханамжтай байсан шүү. Магадгүй, түүний зөнөглөж ухаан нь муудсаны тэмдэг байж болох юм. Багаасаа л ойчдог байсан юм гэнэ лээ. Гэсэн ч тийм гэснээрээ намайг их баярлуулсан шүү.

- Максимилиан бодлогоширсон байдлаар

- Танай аав намайг үзэн ядаж байхад харин өвгөн аав чинь... Хачин л юм даа. Энэ улс төрийн талархах, эс талархах гэдэг ямар хачин эд вэ? гэж хэлэхэд Валентина гэнэт,

- Чишш! гэж дуугараад –Нуугдаарай, бушуухан яв, хүн ирж явна гэв.

- Максимилиан хүрээ шүүрч аваад, царгасаа хамаагүй ухаж гарлаа.

- Мадмазуаель! Хэмээх нэгэн дуу модны цаанаас гарч- Вильфор хатагтай дуудаж байна. Зочдын өрөөнд гийчин ирээд сууж байна гэж хэллээ.

- Гийчин ий? гэж Валентина тэвдэн асуугаад

- Тэр чинь хэн байдаг билээ? гэв.

- Хүндэт зочин! Монте-Кристо гүн гэж их л ямбатан хүн юм байх.

- Очлоо, очлоо гэж Валентина чанга хэлэв. Максимилиан энэ нэрийг сонсоод цочин агдасхийж, “Уухай! Монте-Кристо гүн, Вильфортой яагаад танил байдаг юм бол” гэж хүрээ тулж зогсоод бодлоо.

XIV. Хорын судлал

Үнэндээ ч вангийн прокурорын айлчилсны хариу болгон эрхэм Вильфортой уулзах гэж ирээд, хатагтай Вильфор дээр ирсэн Монте-Кристо гүн байлаа. Энэ нэрийг сонсоод цөм сандран тэвдсэн нь мэдээж хэрэг.

Гүнг ирсэ тухай айлтгах үед зочдын өрөөнд байсан хатагтай Вильфор хүүгээ гүнд дахин тала°хал илэрхийлэг хэмээн дуудуулахаар хүн явуулав. Энэ хоёр өдрийн дотор тэр нэрт хүний тухай их юм сонссон учир ээжийнхээ үгэнд ороод ч юм уу эсвэл гүнд талархалд илэрхийлэх гэсэндээ биш, харин сонирхож, ямар нэгэн юм яриан дундаас нь шүүрэн авч, ямар нэгэн тэнэг үг хэлчих хүсэл нь төрсөн жаал хүү тэр

дороо гүйж ирэв. Эх нь түүний ямар нэг тэнэг үг хэлэх бүрд “Ай ямар зүггүй хүүхэд вэ! Гэвч ийм ухаантай болохоор нь уурлаж чаддаггүй юм!” гэж өхөөрдөн дуу алдана.

Гүн ердийн заншлаар харилцан мэндэлсний дараа эрхэм де Вильфорыг асуулаа.

- Манай нөхөр шүүх яамны сайдынд зоог барьж байгаа гэж залуу хүүхэн хариулаад – Дөнгөж саяхан явсан тантай уулзаж чадаагүйдээ их л харамсах байх даа гэв.

Гүнг орж ирэхэд зочдын өрөөнд байсан хоёр гийчин түүнээс нүд салгалгүй ширтэн байснаа, ёсыг бодсондоо бус харин сонирхсондоо болоод хэдэн минут байзнаж байгаад босон гарч одлоо.

- Ингэхэд Валентина эгч чинь юу хийж байна вэ? гэж хатагтай Вильфор Эдуараас асуугаад – Би түүнийг гүнтэй танилцуулья дууд гэж хэллээ.

- Хатагтай та бас охинтой юу, бүр жаахан хүүхэд байгаа байх даа?

- Эрхэм де Вильфорын түрүүчийн эхнэрээс гарсан охин, том болсон сайхан хүүхэн бий.

- Тэгэхдээ гунихарсан амьтан шүү гэж хэлээд Эдуар султан хаан болох гэж ара хэмээх том тотийн сүүлний өднөөс зулгааж авахад, цаадах нь өвдөж учиргүй орилов. Хатагтай Вильфор зөвхөн

- Эдуар дуугүй бай гэж хэлэх төдийнхнөөр өнгөрөв.

Тэгээд сүүлд нь нэмж,

- Энэ дүрсгүй амьтан тийм ч оргүй юм яриагүй. Миний л дэргэд гуниглахдаа үглэж байдаг юмыг ярьж байгаа нь тэр. Де Вильфор авхайг бид зугаацуулан сэргээх гэж хэчнээн оролдовч, дуу шуугүй уйтгартай зан төрхтэй хүн. Энэ нь түүний гоо сайхныг зарим талаар эвддэг юм. Үгүй яагаад ирэхгүй байна, Эдуар чи яагаад ирэхгүй байгааг нь мэдээд ир.

- Байхгүй газар нь эрээд байгаа болохоор л тэр биз.

- Аа түүнийг хаана эрээ вэ?

- Нуартье өвөөгийн

- Чи тэнд байхгүй гэж бодож байна уу?

- Байхгүй э, байхгүй, байхгүй, байхгүй Валентина тэнд байхгүй гэж Эдуар дуржигнуулан хэлэв.

- Тэгээд хаана байгаа юм бэ? Мэдэх юм бол хэлээч. Зүггүй жаал эхийнхээ зандрахыг ч хайхрахгүй тоть шувуугаа их л амттайхан зууш бололтой амьд ялаагаар хооллон

- Том туулайн бөөр модны дэргэд гэж хэлэв.

Вильфор хатагтай Валентиныг дуудуулах гэж хонх дуугаргах хэмээн гараа сарвайхад охин өөрөө гэнэт тасалгаанд орж ирлээ.

Бүсгүй үнэхээр уйтгартай царайтай бөгөөд, анхааралтай ажиглавал саяхан уйлсан ажээ. Бид уншигчдаа хальт танилцуулаад орхисон Валентина бол өндөр зэгзгэр нуруутай, цайвар хүрэн үстэй, хар хөх нүдтэй, эх шигээ гуайлаг цэвэрхэн, намбайтай алхаатай, арван есөн настай бүсгүй байлаа. Нарийхан цагаан гар, сувд шиг цагаан хүзүү, улаа бутарсан хацар нь түүний усанд тэльдсон хун шувуу шиг зүйрлүүлэн хэлдэг гоо сайхан англи хүүхнүүдтэй анх харахад адилхан ч гэмээр санагдана.

Охин орж ирж өчнөөн сонссон гадаадын хүн хойд эхтэй нь хамт байхыг хараад залуу бүсгүйн ямар ч цэмцэгнүүр маяг гаргалгүй нүдээ ч доош харалгүй ихэд донжтой сайхан хөдөлгөөнөөр мэхийн ёслоход гүн түүнийг улам ч илүү анхааралтай харлаа.

Тэгээд гүн бослоо.

Хатагтай Вильфор буйдангийнхаа дэрэнд налж гараараа Валентинаг заагаад,

- Мадмаузель де Вильфор, манай охин гэлээ.

- Бас Монте-Кристо, хятадын хаан, кохинхины эзэн хаан гэж төрхгүй хүү, эгч өөдөө сэм харж хэлэв.

Энэ удаа ээж нь царай нь зэвхийрч уурлахад бэлэн байсан боловч, гүн инээмсэглэж хүүхэд өөд эелдэгээр харахад эхийн нь зүрх хязгааргүй баяраар дүүрлээ.

- За хатагтай минь гээд гүн үргэлжлүүлэн хатагтай Вильфор, Валентина хоёрыг ээлжлэн хараад – Би Мадмаузель де Вильфор та хоёрыг нэг л газар харсан шиг санагдах юм. би тэгж бодож байтал харин Мадмаузель орж ирээд миний бүдэг бадаг санаж байсан зүйлийг хурц гэрэл шиг тодорхой болгож өглөө.

- үгүй л болов уу, мадмаузель де Вильфор олон хүн дунд байх дургүй, бид гадуур явах маань цөөн байдаг гэж залуу хүүхэн хэлэв.

- Би мадмаузель де Вильфор ба хатагтай таныг мөн энэ цовоо жаалыг олны дунд байхад үзээгүй. Тэгээд ч би парисын дээдсийн хүрээлэнгийнхнийг танихгүй. Паристо ирээд хэдхэн хонож байгааг танд хэлсэн байх аа. хэрвээ та санаж олохыг зөвшөөрвөл... Байзаарай... гээд гүн урьдын явдлуудыг ухааран бодож олох гэсэн мэт дихан дээрээ гараараа дарлаа.

- Үгүй цэвэр агаарт, тэр бол яагаад ч юм нэг хурц нартай өдөр, шашны баяр санаанд ороод байна. мадмаузель де Вильфор гартаа цэцэг барьж, жаал хүү цэцэрлэг дотор сайхан тогос шувууны хойноос хөөцөлдөөд л, та усан үзмээр хүрээлэгдсэн сэхээвчийн дор сууж байсан. Хатагтай та нада туслаач, миний хэлсэн зүйл таны санаанд юу ч оруулахгүй байна уу?

- Гүн ат биднийг Италид үзсэн юм биш байгаа гэж Валентина шийдмэггүйхэн хэллээ.

- Нээрээ Италид ч юм уу.. магадгүй гэж гүн хэлээд – Мадмаузель та Италид байсан юм уу? гэж асуулаа.

- Хатагтай Вильфор бид хоёр, хоёр жилийн өмнө тэнд байсан. Эмч нар миний уушиг муудаж магадгүй гэж болгоомжлон Неаполд суухыг зөвлөсөн юм. бид Болонье, Перуж, Ром хотуудаар орсон.

- Тийм байх ёстой гэж гүн энэ ердийн яриа хаана байсныг нь сануулсан мэт хэлээд- Перужид, бурхны баярын өдөр, Шуудангийн зочид буудлын цэцэрлэгт бид учирлаар тохиолдож хатагтай та, мадмаузель де Вильфор болон таны хүнтэй танилцах аз надад тохиолдсон юм.

- Би Перуж, шуулангийн зочид буудал, бурхны баярыг санаж байна. харин хичнээн бодовч тантай уулзах аз тохиосныг огт санахгүй байна гэж хатагтай Вильфор хэлэв.

- Хачин юм аа би ч бас санахгүй байна гэж Валентина хэлээд сайхан нүдээрээ гүн өөд харлаа.

- Би л сайн санаж байна гэж Эдуар хажуунаас нь орж хэ«эв.

- Би одоо та нарт тусалъя гэж гүн үргэлжлүүлэн хэлээд –Тэр өдөр их халуун байсан. Та нар морьд хүлээгээд л цаадуул чинь баур болж байсан учир саатуулаад л байсан. Мадмаузель цэцэрлэгт орж, хүү чинь тогос хөөгөөд алга болчихсон байсан гэхэд Эдуар,

- Ээж ээ би түүнийг бариад авчихсан тийм ээ, тэгээд сүүлнээс нь гурван өд зулгааж авсан гэлээ.

- Хатагтай та усан үзмийн сэхээвч доор сууж байсан. Та хүү охин хоёроо байхгүй хооронд чулуун сандал дээр суугаад нэг хүнтэй нэлээд удаан ярьж суусан та үнэхээр санахгүй байна уу?

- Нэрээ тийм ээ гэж хатагтай царай нь улайн хэлээд – Би одоо л саналаа. Тэр хүн урт ноосон нөмрөгтэй байсан..доктор хүн байсан шиг санагдана.

- Туйлын үнэн. Тэр хүн чинь би байсан юм. би тэр зочид буудалд хоёр долоо хоноод байсан. Хумхаа туссан хиагаа бас шарласан зочид буудлын эзнийг эмчилж байсан. Тэгээд л намайг алдартай доктор гэж бодож л дээ. та бид хоёр Перужингийн тухай, зан заншил, хувцасны тухай, Перужид ганц нэг хүн нууцыг нь мэдэж байгаа тэр өнөө цуутай аква-тофаны¹ тухай ярьсан шүү дээ.

- Тийм тийм гэж хатагтай бага зэрэг зовсон байдалтай яаран хэлээд – Би одоо санаж байна гэхэд гүн маш тайвнаар үргэлжүүлэн,

- Би таны ярьсан болгоныг тэр болгон санахгүй байна. харин та хүмүүсийн төөрөгдлийн тухай миний санааг дэмжингээ Мадмаузель де Вильфорын эрүүл мэндийн талаар зөвлөж байсан.

- Та хэд хэдэн хүн эмнэж эдгээсэн болохоор үнэхээр эмч хүн байлгүй яахав гэж хатагтай Вильфор хэлэв.

- Мольер, Бомарше хоёр байсан бол танд чухам эмч биш болохоороо л эдгээчихсэн юм. би тэднийг эдгэрүүлсэн биш, харин өөрсдөө эдгэрсэн юм хариулах байсан биз. би бол зөвхөн хувилахуйн ухаан ба байгалийн шинжлэх ухааныг нэлээд үндэстэй судалсан гэдгээ хэлж чадах байна. тэгэхдээ сонирхогчийн хувьд шүү.

Энэ үед зургаан цаг цохив.

- Зургаан цаг болчихжээ гэж хатагтай сэтгэл түгшсэн байдалтай хэлээд – Валентина та өвгөн аавыгаа хоолоо идэх болсон эсэхийг асуугаад ирэхгүй юу гэлээ.

Валентина босч гүн уруу мэхийн ёслоод тасалгаанаас дуугүй гарч одлоо. Гүн Валентинаг гарсны дараа,

- Бурхан минь та надаас болоод хатагтай де мадмаузелийг явуулчихав уу? гэж асуулаа.

- Огтхон ч үгүй шүү гэж залуу хүүхэн яаран хариулаад – Бид энэ цагт эрхэм Нуартъед голыг нь зогоож байдаг өчүүхэн хоолыг нь өгдөг юм. манай нөхрийн эцэг ямар гунигтай байдалд байдгийг та мэдэх үү гэж асуулаа.

- Надад эрхэм де Вильфор ярьсан. Саад дайрагдсан хүн гэсэн байх аа.

- Тийм ээ тийм, золгүй явдал болсон юм. хөөрхий өвгөн огтхон ч хөдөлж чаддаггүй юм. энэ хүний хөшиж орхисон биед зөвхөн сүнс л байгаа юм. гэр бүлийнхээ золгүй явдлыг гүн танд танилцуулсанд уучлаарай. Би таныг чадвартай химич гэж ярьж байхад чинь яриаг чинь тасалсан.

- Би тэгж хэлээгүй шүү гэж гүн инээмсэглэн – Би гол төлөв дорнодод амьдрах гэж шийдсэн учир химийн ухааныг судалсан юм. Метридат хааныг дуурайх гэсэн юм гэв.

- Mithridates, rex Ponticus, өглөө бүр цөцгийтэй аяга хор уудаг хүн гэж төрхгүй жаал хэлээд, сайхан зурагтай номын хуудсыг дүрс гарган хайчилж байв.

- Эдуард муухай хүүхэд шүү гэж хатагтай хэлээд хүүхдийн гараас зэрэмдэглэгдсэн номыг булаан авч - Тэсвэрлэхийн аргагүй яасан хүүхэд вэ? Чи бидэнд яршиг болж байна. явж Нуартъегийн тасалгаанд эгч дээрээ оч гэж зандрав.

- Ном ... гэж Эдуар хэлэв.

- Номоор яах гэсэн юм бэ?

- Би номоо авмаар байна.

- Яагаад чи зургий нь хайчилсан юм?

- Аятайхан болохоор нь тэгсэн юм.

- Яв эндээс! Зайл!

- Ном өгөхгүй бол явахгүй гээд жаал хүү юунд ч бууж өгдөггүй зөрүүд зангаараа зөөлөн сандалд шигдэн хэлэхэд, хатагтай Вильфор

- Ав ав. Бидэнд битгий яршиг болоод бай гэж хэлэв.

Тэгээд Эдуард ном өгч үүд рүү дагуулан очив. Гүн хатагтайн хойноос харж суулаа.

- Хойноос нь хаалга хаах нь уу үгүй юу харъя гэж гүн аман дотроо шивэглэв.

Хатагтай хүүхдийн араас хаалга сайтар хаахад нь гүн түүнийг мэдээгүй юм шиг байлаа.

Дараа нь залуу хүүхэн ийш тийшээ харснаа буцаад сандал дээрээ суув.

Гүн бидний мэдэх ердийн байдлаараа,

- Та энэ өхөөрдмөөр зүггүй амьтантай дэндүү ширүүн харьцах юм аа гэж хэлэхийг зөвшөөрнө үү? Гэж хэлэхэд хатагтай эхийн үнэн сэтгэлээр татгалзан,

- Өөрөөр болохгүй юм гэлээ.

- Эдуар түрүүн бидэнд, Миьридаь хааны тухай Ко^онели Нелотын хэлсэн үгнээс авч хэлсэн. Түүний багш цагшаа дэмий үрдэггүй болохыг нотолсон зүйл дээр та үгийг нь тасаллаа. Танай хүү өөрийнхөө наснаас хэтэрсэн ухаантай хүү юм гэж гүн хэлэв.

- Гүн таны хэлдэг үнэн гэж баярласан эх нь хэлээд, - Их авьяастай хүүхэд. Дуртай л юмаа тогтоодог юм. тэр ганцхан л дутагдалтай дэндүү дураараа даа... тэгээд түүний хэлсэн рүү эргэж оръё. Митридаг тимй болгоомжлох арга хэмжээ авч байсанд та үнэмшдэг үү? Тэгээд тэр нь хэрэг болж байгаа юм уу? гэж асуулаа.

- Итгэхээр барах уу, өөрөө ч тэр аргыг нь хэрэглэж байлаа. Хэрвээ тийм арга хэмжээ аваагүйсэн бол Неополь, Палермо, Смирнд гурван удаа хорлогдож талийгаач болох байлаа.

- Тэгээд танд тус болсон хэрэг үү?

- Бүрэн дүүрэн.

- тийм ээ нээрэн Перужид байхад та надад тиймэрхүү юм ярьж байсныг би одоо л саналаа.

- Нээрэн тэгсэн гэж үү? Гэж гүн маш чадамгайгаар үл мэдэгчийн дүр үзүүлэн асуугаад – Би түүнийг огт санахгүй байна гэлээ.

- Умардын ба өрнөдийн хүмүүст адил муу нөлөө үзүүлэх үү гэж намайг асуухад, та хөөрүү хөдөлгөөнтэй өмнөдийнхнөөс хүйтэн, хөдөлгөөн муутай умардынхан бага хордоно гэж хэлж байсан шүү дээ.

- Тэр үнэн гэж гүн хэлээд – Неополитан ба араб хүнийг зайлшгүй алах тийм ургамлын зүйлийг орос хүн огт ажиг ч үгүй залгиж байхыг би харсан.

- Тэгэхээр энэ талаар манай энд, Дорнодынхноос илүү үр дүн олж болно гэж бодож байна уу. халуун цаг ууртай газар байснаас бороо манант й газар амьдарч байгаа хүн хоронд амархан дасах нь ээ?

- Яриагүй тийм. Харин тэгэхдээ бие махбодио дасгасан тэр л хороос хамгаа«ж чадна.

- Тийм ээ би ойлгож байна. Харин та өөрийгөө яаж сургах байсан буюу чухамдаа яаж тэгж дассан юм бэ?

- Энэ маш амархан. Танд ямар хор өгөх гэж байгааг мэдсэн байж гэж бодъё. Жишээлбэл тэр хор чинь бруцин байж гэж саная...

- Бруцинийг хуурамч ангустурын холтсоор хийдэг байх аа гэж хатагтайг хэлэхэд Монте-Кристо,

- Маш зөв гэж хариулаад, танд заагаад байх юм надад алга. Танд баяр хүргэхийг зөвшөөрнө үү. Эмэгтэйчүүд ийм мэдлэгтэй байх нь ховор байдаг юм гэлээ.

- Би яруу найраг шиг сэтгэлийг хөдөлгөж, алгебрийн тэгшитгэл шиг бодолтоор шийдвэрлэгддэг битүүлэг шинжлэх ухааныг маш их сонирхдог гэдгээ хэлэх хэрэгтэй юм байна. За, энэ ч яах вэ, та цааш нь ярь л даа. Таны ярьж байгаа юм надад их сонин байна гэж Вильфор авгайн хэлэхэд,гүн үргэлжлүүлэн,

- За тэгвэл! Тэр хор чинь бруцин байвал та эхний өдөр нэг миллиграмм, маргааш нь хоёр гэх мэт хүртсээр байгаад арав хоногийн дараа центиграммд хүрнэ. Тэгээд өдөрт миллиграммаар нэмсээр байгаад хорь хоногийн дараа гурван центиграмм хүрэх буюу өөрөөр хэлбэл ийм урьдчилсан арга хэмжээ аваагүй хүнд бол маш их аюултай, өөртөө бол ямар ч муу юм болохгүй хэмжээнд хүрнэ. Эцэст нь сар болсны дараа хортой галуун хүзүүтээс аягаар хийж хээв нэг уухад хамт уусан хүн чинь үхСх болно. Харин танд бол энэ усанд хор уусгасан юм уу даа гэж үл мэдэг мэдэгдэнэ гэв.

- Хорноос хамгаалах өөр арга мэдэхгүй биз.

- Үгүй, мэдэхгүй.

- Би тэр Митридатын тухай дахин дахин уншсан боловч түүнийг зохиомол үлгэр л гэж боддог байсан юм гэж Вильфор авгай бодлогоширсон байдалтай хэлэв.

- Үгүй шүү. Харин ч үнэн зүйл. Харин бидний энэ ярьж байгаа зүйл танд огт санамсаргүй юм биш бололтой. Та хоёр жилийн өмнө асууж байсан, одоо энэ тухай аль хэдийнээс сонирхох болсон гэж байна.

- Энэ үнэн. Би залуудаа ургамал судлал, эрдсийн судлалыг илүү сонирхож байсан юм. Харин эмийн ургамлуудыг хэрэглэх аргыг судлах явдал нь дорнодын ард түмний бүх түүх, бүх амьдралыг ойлгоход, янз бүрийн цэцэг тэдний дурлалын тухай ойлголтын илэрхийлэл болдгийн адил түлхүүр нь болдог гэдгийг мэдэх болсноос хойш Фламель¹, Фонтан², Кабанис шиг хүн болохын тулд эр хүн болж төрөхгүй явдаг гэж харамсдаг юм.

- Тэгэх тусмаа хатагтай минь дорнодын хүмүүс Митридат шиг хороор зөвхөн хамгаалалт хуяг хийгээд зргсрхгүй, бас чинжаал хутганы оронд хэрэглэдэг юм. шинжлэх ухаан тэдний гарт зөвхөн хамгаалалтын зэвсэг болоод зогсох бус, бас довтолгооны зэвсэг болдог юм. тэд нэгээр нь биеийн зовлонгоо хамгаалдаг ба нөгөөгөөр нь дайсантайгаа тулалдан тэмцдэг. Хар тамхи, чувай хатан, ангустур, могойн хор зэргээр тэд өөрсдийг нь сэрээх гэсэн хүмүүсийг унтуулчихдаг юм. сайн санаат авгайчуул гэж нэрлэдэг, миссир, түрэг грег хүүхнүүдийн дотор хувилахуй ухааныхаа мэдлэгээр ямар ч эмчийг гайхуулдаггүй, сэтгэл судлалын талаар ямар ч санваартныг андраадаггүй хүүхэн гэж байдаггүй билээ.

- Үгүй ер! Гэж ярианы үеэр нүд нь аймшигтайгаар гялалзан байсан хатагтай Вильфор хэлэхэд гүн үргэлжлүүлэн,

- Тийм ээ, дорнодынхны бүх л нууц явдлууд, дурлуулдаг өвснөөс эхлээд үхүүлдэг өвс хүртэл хүн амьтанд дээд тэнэргийг нээж өгдөг үхлийн өвснөөс эхлээд эсвэл түүнийг тамд явуулдаг ундаанд хүртэл зангилаа нь тайлагдаж уягдаж байдаг. Хүний бие махбодын ба сэтгэл санааны байдал төрх хэчнээн олон янз, хачирхалтай байдаг нь энд харагдаж байгаа биз. ийм химич хүмүүсийн уран чадвар нь өвчин ба эмийг өөрсдийн дурлалын шунал, өс авах хүсэлтэйгээ хэчхээх сайхан хослуулж чаддаг гээч гэж хэлэхэд далуу авгай зөрж,

- Ингэхэд гүн минь таны олон жилийн турш дотор нь амьдарч ирсэн дорнодынхон гэдэг чинь тэдгээр гайхамшигт орнуудын тухай үлгэр домог шиг бас л тийм гайхалтай биз. тэнд хүнийг ямар ч ял зэмлэлгүйгээр устгаж болдог байх нь ээ? Таманы³ бичсэн тэр Багдад, Бассор гэдэг үнэхээр байдаг байх нь ээ? Манай францынхаар бол зүасгийн газар нь болдог тэр орны эрх баригч султан хаан ба тайж нар нь жинхэнээрээ хар-аль-Рашидууд ба Жаффарууд байж, тэд хорлон алагчийг зөвхөн уучлаад зогсохгүй, хийсэн гэмт хэрэг нь зальтай уран чадварлаг хийгдсэн байвал тэргүүн сайд болгож уйдсан цагтаа зугаа болгох гэж тэр явдлын түүхийг алтан үсгээр бичихийг тушаадаг байх нь ээ? гэв.

- үгүй хатагтай минь, ер бишийн тэр цаг дорнодод ч гэсэн өгөрч алга болсон. Тэнд өөр маягийн хувцастай, өөр нэртэйгээр цагдаагийн комиссар, мөрдөн байцаагч, вангийн прокурор ба хуулийн шинжээчид байдаг юм. хэрэгтэнгүүдийг дүүжилж толгойг нь авч, шор дээр суулгаж чаддаг юм. гэвч самбаа зальтай нэг нь хүн төрөлхтөний шударга шүүхээс зайлан зугтаж чадаад зальт төлөвлөгөөгөө биелүүлж дөнгөдөг юм. манайд бол үзэн ядах ховдог үунахайн чөтгөр шүглэсэн тэнэг амьтан дайснаа юм уу нас хөгширсөн төрөл саднаа зүйл дуусгая гэхдээ, жинхэнэ нэрээ хэлснээс ч түргэн баригдахаар, зохиомол нэрээ эмийн сангаас хулгана унтуулахаа байлаа гэдэг шалтаг зааж тав зургаан грамм хүнцэл худалдаж авна. Хэрвээ их болгоомжтой хүн бол тав зургаан эмийн санд очиж баригдах болоцоогоо тав зургаа дахин хөнгөлж өгнө. Тэгээд хэрэгтэй юмаа олж аваад өнөөх дайсан буюу нас хөгширсөн садандаа аварга зааныг ч унагах тийм их тунгаар өгч орхино. Цаадах нь

гудамж донслохоор их дуугаар орилон хашхирч, тэр чимээгээр нь цагдаа нар хүрч ирээд эмч домч дуудуулж, гэдсийг нь хагалж үзээд ходоод гэдэс дотроос нь хүнцлийг халбага халбагаар хутгаж гаргана. Маргааш нь өдий төдийн сонитнд энэ явдлын тухай алсан алагдсан хүний нэртэй гарч ирнэ. Орой нь эмийн сангийн эрхлэгч ирж “Энэ хүн надаас хор худалдаж авсан” гэж мэдэгдэнэ. Тэгээд л нөгөө нэг амьтныг барж аваад шоронд хийж нүүрэлдүүлэн, хэргийг нь хүлээлгэж байцааж цаазаар авах буюу эсвэл нэлээд нэртэй авгай байсан бол бүх насаар нь хорих ял заана. Танай умардынхан хувилахуй ухааныг ингэж л хэрэглэдэг юм даа. Ингэхэд Дөро¹ л хамгийн ухаантай нь байсан гэж хүлээх хэрэгтэй гэхэд хатагтай Вильфор,

- Гүн та юу гэх гэв, хүн чаддаг л юмаа хийдэг шүү дээ. хүн бүр Медич ба Божиагийн нууцыг мэддэг биш шүү дээ хэмээн инээмсэглэн хэлэв. Тэгэхэд гүн мөрөө хавчисхийгээд цааш нь,

- Одоо би танд энэ тэнэг явдлууд юунаас болдгийг хэлж өгөх үү? Юунаас гэвэл танай театруудад тоглодог жүжгийн уншиу үзэхэд, хүмүүс шил савтай буюу бөгжинд хийсэн хорыг залгиад амьсгаагүй унаад өгснөөр гарч байх юм. тэгээд таван минутын дараа хөшиг хаагдаж үзэгчид тарж одно. Харин амь хорлосон энэ явдлын үр уршиг юу болох нь нарахгүй өнгөрнө. Ороолтоо бүсэлсэн цагдаагийн комиссар, дөрвөн цэрэг дагуулсан бага дарга ч үзэгдэхгүй учраас ухвар мөчид хүмүүс амьдрал дээр ийм л байдаг юм байна гэж итгэнэ. Харин францын хилээс гарч, Алеппо, Кайр наанадаж неапольд эсвэл Ромд очвол та ягаан хацартай эрхэмсэг хүн явж байхыг хараад “Энэ хүн хорлогдчихоод гурван дорлоо хонож байгаа юм. Одоо сар болоод хүйтэн хүүр болно доо” гэж доголон чөтгөр танд шивэгнэн хэлдэггүй л юм бол та хорлогдсоныг нь анзаарах ч үгүй гэв.

- Тэгвэл намайг Перужид байхад нууц нь алдагдсан юм гэж хэлж байсан тэр аква-тофаны нууцыг тэд олоод авчихсан хэрэг үү? Гэж хатагтай асуув.

- Ерлөнц дахь ямар нэг юм алга болдог гэж үү? Урлдаг гэдэг чинв энэ дэлхий дээгүүр хэрэн хэсэж байдаг юм шүү дээ. юмс гэдэг чинь өөр нэр лож авахаас биш алга болчихдоггүй, бааздуухан хүн үүнийг ойлгодоггүй юм. харин хорын үр дүн нь хэвээрээ үлддэг юм. биеийн аль нэг эрхтэн зөвхөн ходоод гэдэс ч юм уу аль эсвэл тархи толгойнд л нөлөө үзүүлнэ. Жишээ нь ханиалгадаг хор байна гэж бодъё. Тэр нь цаашаа үгдрээд уушгины хатгалга буюу үгүй гэхдээ дээрээс нь эм уучихвал үхүүлж чадах өвчин болдог. Манай болхи эмч нар болох олонхдоо дунд зэргийн химич хүмүүс өөрсдийн нь эм тан өвчинтэй тэмцэж чадаж байгаа эсэхийг хайхралгүй аз болж эдгэрвэл тэр гээд сууж байна. хүнийг ингээд л урлагийн бүхий л ном ёсоор алж байхад хуульзүй ямар ч хүч чадалгүй болж хоцордог гэж Сицилийн сайн химич миний дотно найз энэхүү үзэгдлийг сайтар судалсан Тармины Адольмонте ламтан хэлсэн юм.

- Аймаар хэрнээ гайхмаар юм хэмээн их л анхааралтай сууж байсан залуу хүүхэн хэлснээ – Би энэ бүхнийг дундад үеийн зохиомол юм гэж бодож байсан юм.

- Тийм ээ, тэр ч эргэлзээгүй хэрэг. харин манай үед энэ нь улам сайжирсан юм. юуны төлөө цаг хугацаа, элдвийн урамшуулал, шагнал байдаг гэж санана. Энэ бол нийгмийг улам илүү төгөлдөржүүлэхийн тулд шүү дээ. хүн бурхан шиг л хүссэнээ бүтээж, үгүй болгож чаддаг болсон тэр цагт и«үү сайнаы туйлд хүрч байгаа нь тэр. Одоогоор устгаж сурсан болохоор замынхаа хагаст хүрсэн байна гэсэн үг.

Тэгэхэд хатагтай өөрийнхөө санаанд эргэн орж,

- Боржиа, Медичи, Рене¹ Ружьери² хожим нь түшээ гүн Тренк нарын хэрэглэж байсан орчин үеийн жүжиг романд улиг болтлоо дурдагдсаар байгаа хорууд чинь... гэж хэлэхэд гүн өөдөөс нь,

- Урлагийн бүтээлүүд байсан юм. Жинхэнэ эрдэмтэй хүн бол жирийн хүнтэй зууралдан гэж үү? Хэрхэвч үгүй, шинжлэх ухаан бол уран арга, илбэ шид, зөн билэгт дуртай. Миний түрүүчийн хэлсэн ээд төрөлт лам энэ талаар гайхалтай туршилт хийсэн юм.

- Тийм гэж үү?

- Тийм ээ, би танд ганц жишээ хэлье. Түүнд цэцэг жимс ногоо дүүрэн ургасан сайхан цэцэрлэг байсан юм. тэгээд энэ ногоонуудаасаа хамгийн ердийн нэг бөөрөнхий байцаа сонгон авчээ. байцаагаа гурван өдрийн турш хүнцлээр хордуулан шавшжээ. Тэгээд гурав дахь өдөр нт байцай шардаж тасалж авах болжээ. Гаднаас харахад огт жирийн ургасан байцаа байна. ганц Адельмонте л энэ байцайг хордуулсан гэдгийг мэднэ. Тэгээд байцаагаа гэртээ авчраад туулай барьж (тэднийд жимс ногооноос илүү олон төрлийн туулай, муур усан гахай бий), байцааныхаа навчнаас идүүлэв. Туулай нь мажийж орхижээ. Ямар ч мөрдөн байцагч үүнээс сонжилттой юм огтхон ч олохгүй. Вангийн ямар прокурор нь Маженди Флуранс³ нарыг туулай муур усан гахай нар алчихсаных нь төлөө хэрэг сэдэж байх вэ дээ. нэг нь ч чадахгүй. Ингээд туулай шударга үнэний шүүхийн анхаарлыг таталгүйгэр үхнэ. Тэгэхээр нь лэмтан того⁴доо тушааж гэдэс дотрыг нь хаялна. Энэ хог дээр тэнэж явсан тахиа тэр гэдэс дотроос нь идээд, мөн л өвдөн маргааш нь үхэн, үхэх гэж тийчилж байгааг нь харсан харцага (ламын нутагт харцага олон байдаг) хүүрийг шүүрэн аваачиж хаданд аваачин иднэ. Тэгээд хөөрхий харцага тахиа идсэнээсээ хойш бие нь эвгүй оргисоор айгаад гурав дахь хоног дээрээ толгой нь гэнэт эргэн танай цэцэрлэгийн годл унаж ирнэ. Цурхай могой загас зэрэг ховдог загаснууд түүнийг дайран иднэ. Ингээд маргааш нь дөрөв дэх үе, хордсон нөгөөх загаснуудыг ширээн дээр чинь тавихад танайд ирсэн зочин тав дахь нь болж хордоод найм ес хоногийн дараа гэдэсний өвчин зүрхний багтраа ходоодны хавдраар үхнэ. Хагалж үзсэн эмч “элэг буюу хижиг өвчнөөр үхжээ” гэж хэлнэ гэхэд хатагтай,

- Харин таны энэ нөхцөл байдлын холбоо амархан ьасарч мэдэх юм. харцага хэрэгтэй цагт тэр газар дээгүүр нисэхгүй буюу эсвэл усанд унаж загасны олз болохгүй байж болох юм.

- Чухам энүүнд чинь л урлаг нь байгаа юм. Дорнодод агуу их химич байхын тулд учрал тохиолыг удирдаж чаддаг байх хэрэгтэй,үүнийгээ ч тэд чаддаг юм. Хатагтай Вильфор бодлого болон чагнаж байснаа

- Гэхдээ хүнцлийн ул мөр алга болохгүй шүү дээ. Ямар ч замаар хүний биед орсон байлаа гэхэд үхүүлэхээр л хэмжээтэй бол мэдэгдэж таарна биз дээ гэв.

- Тийм шүү. Яг үүнийг би Адельмонте ламд хэлсэн юм гэж Монте-Кристо дуу алдав

- Тэр бодлого болж байснаа инээмсэглээд, франц хэлэнд ч байж мэдэх сицили зүйр үл, "Хүү минь хорвоо ертөнц гэдэг ганцхан өдөр бүтээгдчихээгүй, долоо хоногийн дотор бүтээгдсэн юм. Тэгэхээр ням гаригт ирээрэй" гэж хэлсэн билээ. Ням гаригт би түүн дээр дахин очлоо. Тэгэхэд тэр байцаагаа хүнцлээр биш харин шинжлэх ухаанд *Strychnos colubrina* гэж нэрлэдэг хүнж уусгасан давсны уусмалаар шавшиж байлаа. Энэ удаа байцаа муудаж шарласангүй, туулайд ямар ч өөрчлөлт орсонгүй. Гэтэл таван минутын дараа туулай үхлээ. Тахиа түүнийг тоншиж орхиод маргааш нь бас үхлээ. Тэгэхээр нь бид тахиаг гэртээ авчраад задалж үзлээ. Энэ удаа ямар ч онцгой шинж тэмдэг үзэгдсэнгүй, ердийн л байдлаараа байлаа. Харин мэдрэлийн систем нь цочиж, тархинд нь цус харвасан байлаа. Тахиа маань хордсоноос биш, харин саа дайрч үхжээ. Энэ явдал тахианд олон тохиолдохгүй гэдгийг би мэднэ, харин хүнд бол ердийн үзэгдэл байдаг.

Хатагтай Вильфор улам бодлогошрон байснаа,

- Ийм бэлдмэлүүдийг зөвхөн химич хүмүүс хийж чаддаг нь яамай даа. Тэгэхгүй болж ч хүн төрөлхтний тал хувь нь нөгөө талыгаа хорлоод дуусчих байсан биз гэж хүүхнийг хэлэхэд,

- Химич, эсвэл химийг хамгаалдаг хүмүүс бэлтгэдэг юм гэж гүн хайхрамжгүй хариуллаа.

Тэгэхэд хатагтай өөрийнхөө бодож байгаа зүйлээс хүчээр ангижран,

- Гэлээ. ч гэмт хэрэг хэчнээн чадварлаг хийгдсэн байлаа ял гэмт хэрэг хэвээрээ үлдэнэ шүү дээ. хүмүүсийн шүүхээс зайлж чаддаг юм гэхэд бурхны шүүхээс зайлж чадахгүй. Дорнодынхон манайхан шиг тийм сул ухамсартай улс биш, тэд там гээчийг устган алга болсон гэдэг нь ухаалаг хэрэг. энүүнд л хамаг учир байгаа юм гэв.

- Тан шиг ийм цэвэр ариун сэтгэлтэй хүнд ийм эргэлзээ төрөх нь зүйн хэрэг боловч, нээгдсэн ухаан бодол түүнийг таягдан хаяхад хүргэсэн юм. хүний санаа бодлын бүрхэг тал нь Жан-Жак Руссогийн хэлсэн "Таван мянган бээр газрын тэртээгээс хуруу нь хөдөлмөгц алж орхидог хүн" гэсэн олны мэдэх үгэнд илэрч байна. хүний амьдрал ийм явдлаар дүүрэн бөгөөд, түүний ухаан нь үргэлж ийм хүсэл мөрөөдлийг төрүүлнэ. Өөр шигээ хүний зүрхэнд хутга шаачхаад эсвэл та бид хоёрын ярьж байсан хүнцлээс хорлохын тулд тунгаар нь өгчихөөд тайван байдаг хүн гэж даанч цөөн. Энэ нь их хачнаар барахгүй тэнэг хэрэг болно. Үүний тулд бүх сэтгэл санаа нь өөрчлөгдөн, цус нь хөөрч, судас нь булгилан цохилох явдал чухал. Хүний бие судлалд хэрэглэдгийн адилаар үгий нь зөөлнөөр хэлбэл алга болгох гэсэн үг. зальхайгаар хүн алахын оронд та зүгээр л саад болсон этгээдийг замаасаа зайлуулж байгаа хэрэг. энэ бол таныг ч цусанд дуртай араатан гэхгүй тэр хүнийг ч тамлагдан үхсэн хүн гэхээргүй нам гүм, ямар ч хүчирхийлэлгүйгээр хийгдэнэ. Хэрвээ энэ явдал урсах цус, хашхирах гинших дуу, атиганан таталдах эсвэл эгшин зуур сэжигтэйгээр эцэс болох мөчийн аймшигт тэмдэггүйгээр өнгөрвөл та "Олон нийтийн амгалан тайван байдлыг бүү эвд" гэж хэлдэг хүн төрөлхтний хуулий хариу өшөө авах явдлаас зайлж чадна. чухал хэрэгтэй зүйлдээ цаг хугацааг хайрладаггүй дорнодын хүмүүс ингэж ажиллаж, зорьсон зорилгодоо хүрдэг юм.

- Аа тэгвэл дотоод сэтгэл нь яах вэ? гэж хатагтай амьсгаагаа дарж түгшсэн байдалтай асуухад,

- Тийм ээ, тийм, аз болоход дотоод сэтгэл гэж байдаг. Хэрвээ тийм юм байдаггүйсэн бол бид маш их золгүй улс байхсан. Ямар нэгэн эрс шийдэмгий явдлын дараа биднийг гагцхүү ухамсартай сэтгэл л авардаг юм. бид өөрсдөө шүүгч нь болдог тэр хэрэгт дотоод сэтгэл минь мянга мянган уучлалтыг гаргаж ирдэг юм. энэ нь биднийг тайван нойрсоход тус болохоос биш, бидний амийг гэмт хэргийн ялнаас аварч чадахгүй. III Ричард, IV Эдуардын хоёр хүүг алчихсаны дараа дотоод сэтгэл нь түүнийг гайхалтайгаар тайвшруулсан байж таарна. Үнэ хэрэг дээрээ, тэр өөртөө: “Тарчилган зовоогч хааны эдгээр хүүхдүүд өөрийн эцгийг туу туухай бүгдийг үе залгамжлан авсан бөгөөд үүнийг нь ганцхан би багаас нь ажиглан мэдсэн юм. эдгээр хүүхдүүд английн ард түмэнд гай зовлон авчирч, сайн сайхан байдалд нь зайлшгүй саад болох байсан юм” гэж хэлж чадсан юм. Шекспир юу ч гэж бичиж байсан хамаагүй нөхрөө бус хүүгээ хаан ширээнд суулгах гэж хүссэн Макбет хатагтайг мөн л дотоод сэтгэл нь тайвшруулж байжээ. Эхийн хайр гэдэг бол аугаа Ёх нандин зүйл бөгөөд урагш хөдөлгөгч агуу хүчин юм. хэрвээ Макбетэд дотоод сэтгэл байгаагүй бол, тэр хүүхэн Дунканыг нас барсна с хойш их л зовох байсан юм.

Гүн ердийн ёжтой байдлаар хэлсэн энэ аймшигт нотолгоонуудыг хатагтай их л хомхойрон чагнаж байлаа. Тэгээд минут хэртэй дуугүй байснаа,

- Гүн гуай, таны хэлж байгаа зүйл аймшигтай бөгөөд та орчлонг зэгсэн бүдгээр хардаг хүн юм аа! Эсвэл та хүн төрөлхтнийг шилэн сав, гуурсны завсраар харж дүгнэдэг хүн үү? Та үнэндээ гарамгай химич хүн, та миний хүүд өгч тэр дор нь шингээсэн тэрхүү шингэн...гэж хэлэхэд гүн,

- Хатагтай минь, түүнд тэгтлээ итгэж болохгүй шүү. Үүний нэг дусал нь үхэж байгаа хүүд амь оруулахад хангалттай, харин гурван дусал өгчихвөл уушгинд цус хөөрч, зүрх хүчтэй цохилох болно. Зургаан дуслыг өгчихвөл амьсгаа нь боогдож түрүүчийнхээс хүчтэйгээр ухаан алдуулна. Харин арван дусал өгчихвөл тэр дор нь ална. Жаал хүүг шилтэй шингэнээр оролдох гэхэд хориглоод байсныг санаж байгаа биз? гэв.

- Тэгвэл тийм их хүчтэй хор байсан хэрэг үү?

- Үгүй дээ, юуны өмнө хор гээч ийм байдаггүй гэдгийг мэдэж авах хэрэгтэй. Эмнэлгийн ухаан нь хамгийн хүчтэй хоруудыг хэрэглэдэг бөгөөд тэдгээрийг чадварлагаар ашиглавал аврагч эм болдог юм.

- Тэгээд тэр чинь юу байсан юм бэ?

- Энэ бол миний сайн найз, сайн сэтгэлт Адельмонте ламтаны анх найруулж, надад яаж хэрэглэхийг зааж өгсөн бэлдмэл юм.

- Энэ бодвол татаж унахад хэрэглэдэг сайн эд байх даа! гэж Вильфор авгай хэлэхэд,

- Тун сайн, та харсан шүү дээ гэж гүн хариулаад,

- Би байн байн хэрэглэдэг юм. Харин тэгэхдээ аль болох болгоомжтойгоор гэж инээмсэглэн хэлэв.

- Тэгэлгүй яах вэ. Над шиг ийм мэдрэл султай, унадаг өвчтэй хүнд чөлөөтэй амьсгалж явахад минь тус болохуйц эм хийж өгчихөөр Адельмонте шиг эмч хэрэгтэй байлаа даа. Гэвч Францаас тийм эмч олно гэдэг хялбар хэрэг биш, аа лам миний төлөө Парис хүртэл аялал хийхгүй болохоор эрхэм Планшийн хийж өгсөн эмээр л сэтгэл ханахаас өөр арга алга. Би батраш болон гофманы дуслыг энгийнээр хэрэглэдэг л дээ. Надад тусгай захиалгаар бэлтгэж өгдөг энэ хавтгай үрэлд хоёр тунгаар хийж ирүүлдэг юм.

Монте-Кристо, залуу хүүхний өгсөн яст мэлхийн хуягаар хийсэн хайрцгийг нээж, ийм хэрэглэлийг мэддэг хүний ёсоор үнэртэж үзэв.

- Сайн эд байна гэж гүн хэлээд-Харин ухаан алдсан хүн үүнийг залгихад хэцүү юм байна. Тэгэхлээр миний хэрэглэдэг зүйл илүү дээр юм байна гэлээ.

- Би ч гэсэн ямар нөлөө үзүүлдгийг нь үзсэн болохоор илүү дээр гэж үзэлгүй яахав. Энэ нууц зүйл байх л даа. Тэгэхээр түүний тухай танаас лавлан асуувал даруу биш хэрэг болно биз дээ.

- Харин би элдэг хүн болохоор таньд үүний тухай хэлэхийг өөрийн үүрэг гэж үзэж байна гэж Монте-Кристо босонгоо хэлэв.

- Өө Гүн!

- Харин бага хэмжээгээр хэрэглэвэл эм, их хэмжээгээр хэрэглэвэл хор болно гэдгийг санаж явах мэрэгтэй. Нэг дусал нь хүнийг амь оруулна. Үүнийг та өөрөө харсан. Тав, зургаан мусал нь зайлшгүй гэнэтийн үхэлд учруулна. Хундагатай дарсанд хийлээ гэхэд амтыг нь огтхонч өөрчлөхгүй. За больё, таньд зөвлөгөө өгсөн хэрэг болж байх шиг байна.

Зургаан цаг хагас цохив. Хатагтай Вильфорын хоол зооглох ёстой танил хатагтай нь хүрч ирсэн тухай зарц орж ирж хэлэв.

- Хэрвээ би тантай дөнгөж хоёр дахиа биш, гурав, дөрвөн удаа уулзсан бол, зөвхөн ачийг чинь хариулагч биш, найз дотно хүн чинь байсан бол таныг манайд хоол идээд яв гэж шалаад, татгалзахыг тань хүлээж авахгүй байсан даа гэж хатагтай Вильфор хэлэхэд, Монте-Кристо,

- Би танд их талархаж байна, гэвч биелүүлэхгүй байж болохгүй нэг юм байна. Грегийн нэг ноёгтойг театр үзүүлнэ гээд хэлчихсэн юм. Тэр авхай дуурь үзээгүй бөгөөд намайг тийш нь дагуулж аваачна хэмээн хүлээж байгаа гэж хэлэв.

- Тэгвэл яах вэ, баяртай, харин миний эмийн тухай бүү мартаарай.

- Хатагтай минь, хэрхэвч мартахгүй. Хэрвээ тэгвэл би тантай ярьж өнгөрүүлсэн энэ цагийг мартана гэсэн үг. Энэ бол байж болохгүй зүйл. Монте-Кристо мэхийн ёслоод гарч одлоо. Хатагтай Вильфор бодлогшрон хоцров.

- Хачин хүн юмаа. Адельмонте өөрөө мөн байхаа гэж өөртөө хэлэв.

Монте-Кристын тухайд гэвэл энэ яриа нь түүний бодож явснаас ч илүү үр дүнтэй болжээ. “Сайн суурь тавигдлаа. Энд цацсан үр зүгээр өнгөрөхгүй гэдэгт итгэж байна” гэж тэр гарах зуураа бодлоо.

Маргааш нь хэлсэн үгэндээ хүрдэг хүн нөгөөх өгнө гэсэн жорыг хүргүүлэв.

XV. Роберт-чөтгөр

Энэ орой вангийн хөгжмийн академид том баяр бөх байсан учир гүн Операг үзнэ гэдэг нь үндэстэй зүйл байв. Өнөөдөр, Левассер удаан хугацаагаар өвчилж байсны дараа Бертрамын дүрд тоглож, олонд сонирхогдож байсан хөгжмийн зохиолчийн бүтээл хуучин шигээ парисын дээдсийн хүрээлэнгийн сонирхлыг ихэд татна.

Баян залуучуудын адил Альберт хөгжимчдийн байранд ногдсон суудал байдаг байлаа. Түүнээс гадна ойрын танил нөхдийн арваад лоожид ч бас суудал олдоно.

Зэргэлдээх сандал нь Шато-Реногийнх байлаа. Бошан сэтгүүлч хүний хувьд бүх тасалгааны эзэн нь байсан бөгөөд дуртай газраа сууна.

Энэ орой Люсьен Дебрэ сайдынхаа лоожийг эзэмших болж, түүнийгээ Морсер гүнд өгөхөд цаадах нь Мерседесийг дургүйцсэн болохоор Дангларт өгч, хатагтай нар лоож хүлээн авахыг зөвшөөрвөл түшээ гүнгийн хатан охин хоёр дээр оройхон ирнэ гэж хэлүүлжээ. Авгайчуул татгалзаагүй нь мэдээж хэрэг. Зүгээр олдох юманд, саятан шиг дуртай хүн байхгүй.

Дангларын хувьд, өөрийн нь улс төрийн зарчим ба эсрэг бүлгийн депутатын хувьд сайдын лоожинд сууж тохирохгүй гэж үзжээ. Авгай охинтойгоо хоёулхнаа дуурь үзэх нь эвгүй болохоор бидэнтэй хамт юм үзнэ үү гэж Люсьенд зурвас явуулжээ.

Нээрээ ч хүүхнүүд хоёулхнаа лоожинд сууж байвал хүмүүс дургүйцэн зэвүүрхэх бөгөөд, харин мадмуазель Данглар ээжтэйгээ, бас түүний нууц амрагтай театрт очвол олон нийт буруушаахгүй ажээ. Нийтийн заншилтай эвлэрэхээс өөр я х вэ.

Заншсан ёсоор үзэгчдийн тасалгаа бараг хоосон байхад хөшиг нээгдлээ. Жүжиг эхэлсэн хойно театрт хүрч ирэх нь дээдсийн хүрээлэнгийнхний заншил юм. Ийнхүү цагтаа ирсэн хүмүүс нэгдүгээр үзэгдлийг үзэж сонсож чаддаггүй ажээ. Тэд зөвхөн орж ирж байгаа хүмүүсийг харж, хаалга үүд дуугарах ба ярилцахыг сонсоно.

Альбер доод талын хажуугийн лоожны нэг үүд нээгдэж байхыг хараад,

- Хараач! Гүнгийн хатан Г орж ирж байна гэхэд,

- Гүнгийн хатан Г гэдэг чинь хэн бэ? гэж Шато-Рено асуулаа.

- Түшээ гүн,энэ чинь яасан уучилмааргүй асуулт вэ? Түшээ гүн Г гэдэг хэн болохыг та мэдэхгүй юү?

- Өө тийм, өнөөх гоо сайхан венец хүүхэн үү? гэж Шато-Рено асуув.

- Тэгэлгүй яах вэ.

Энэ минутад хатан Г.Альберийг харчихаад түүний мэндэлсний хариуд инээмсэглэн толгой дохилоо.

- Та таньдаг юм уу? гэж Шато-Рено асуухад,

- Тийм ээ гэж Альбер хариулаад – Ромд байхад Франц намайг танилцуулсан юм.

- Ромд, Франц танд үзүүлсний адил тусыг одоо та надад хүргэнэ үү?

- Дуртайяа.

- Чимээгүй! гэж үзэгчдийн дундаас дуугарлаа.

Үзэгчид хөгжим сонсох гэж хүсч байгааг залуу хүмүүс огтхон ч хайхрахгүй яриагаа үргэлжлүүлж байлаа.

- Энэ хүүхэн өнөөдөр Марсын Талд болсон морин уралдаан дээр байсан гэж Шато-Рено хэлэв.

- Өнөөдөр ий?

- Тийм ээ.

- Нээрэн өнөөдөр чинь уралдаан болсон л доо. Та хожив уу?

- Үгүйтэй адил, таван луидор л хожлоо.

- Ямар мo°ь түрүүлэв?

- Наутилус. Би тэр торинд тавьсан юм.

- Гурван удаа уралдах байсан биз дээ?

- Тийм ээ. Жокей-клубын шагнал алтан цом ч байсан. Их хачин юм болсон шүү.

- Ямар?

- Чимээгүй байгаач гэж дахин тэдэн рүү хашгирав.

- Ямар? гэж Альбер дахин асуув.

- Энэ уралдаанд огт дуулдаагүй морь хүн хоёр түрүүлсэн.

- Яаж тэр билээ?

- Ийм явдал боллоо. Вампа нэр дээр бичигдсэн морь ба Иов нэртэй унах хүнийг нь хэн ч анзаарсангүй. Тэгтэл гайхамшгийн сайхан хээр морь унасан жижигхэн биетэй хүн гарч ирлээ. Хармаанд нь хорин фут тугалга хийсэн ч гэлээ түүнийг “Ариеля” ба “Барбаро” хоёроос үүд хоймрын зайтай түрүүлэхэд саад болсонгүй.

- Тэгээд тэр хэний морь хүн байсныг мэдсэнгүй юү?

- Үгүй.

- Тэр морь ямар нэрээр бичигдсэн гэнэ ээ...

- Вампа нэрээр.

- Тэгвэл би танаас илүү мэдэх юм байна. Хэний морь болохыг нь би мэдэж байна гэж Альбер хэлэхэд,

-Та минь дуугүй суугаач! Гэж гурав дахь удаагаа голын суудлаас хэлэх сонстлоо.

- Энэ удаа ихэд уцаарласан байсан тул, залуу хүмүүс энэ үг өөрсдөд нь хандсан болохыг ойлголоо. Тэд тэгж зоримгоор хашгирсан хүнийг эрж, үзэгч өөд харсан боловч ямар ч хүн дахин дуугарсангүй тул дахин тайз өөд харлаа.

Энэ үед сайдын лоожны үүд нээгдэж, хатагтай Данглар, түүний охин ба Люсьен Дебрэ гурав орж суудлаа эзлэв.

- Бэйс, таны танилууд орж ирлээ гэж Шато-Рено хэлээд,- Та юунд баруун тийшээ хараад байгаа юм? Таныг хайгаад байх шиг байна гэв.

Альбер эргэн харвал үнэхээр хатагтай Дангларын харцтай тулгарсан бөгөөд хүүхэн дэвүүрээ хөдөлгөн түүнтэй мэндэллээ. Мадмуазель Эжений тухайд гэвэл тэр охин зөвхөн том нүднийхээ харцыг доошлуулах төдий болжээ.

- Үнэндээ доод гаралтай гэдэггүй юм бол энэ ч танд их саад болохгүй л дээ. Та мадмуазель Дангларт дургүйцэхээр юм юу байгааг би огт ойлгохгүй юм, маш сайхан охин юм биш үү.

- Мэдээжийн сайхан охин. Гэвч гоо сайхан гэдэг бол илүү эелдэг зөөлөн, өөрөөр хэлбэл илүү хүүхнэрхүү байх нь дээр гэж би боддог гэж Альбер хэлэхэд гучин настайдаа Альберын дэргэд их л аавархуу байдаг Шато-Рено зөрж,

- Одоогийн залуучууд гэдэг юу ч тоохгүй юм. Эрхэм минь танд анчин Диана охин тэнгэрийн дүрээр бүтээгдсэн хүүхэн өгч байхад та бас дургүйцэнэ гэнэ ээ! гэв.

- Чухам тийм, би Милосийн ч юм уу Калуаны Венера шиг хүүхнийг илүү үзнэ. Энэ анчин Диана чинь нэг л айдас хүргээд байдаг юм. Актеон шиг явдал надад тохиолдох вий гэж айдаг юм.

Нээрээ ч энэ охиныг хараад байхад, Альберт төрсөн сэтгэгдлийг аргагүй юм гэж бодмоор ажээ. Мадмуазель Данглар үнэндээ гоо сайхан боловч цаанаа л нэг

ширүүвтэр байдалтай ажээ. Байгалаас заяасан долгионт сайхан хар үс нь үзэмжтэй боловч, түүнийг илэн засах гэсэн гарт дийлдэхгүй юм сан гэмээр харагдана. Сайхан хөмсөгтэй. Ганц өөлөх юм гэвэл заримдаа зангидахад нь хатуу зоригтойг нь илтгэсэн эмэгтэй хүнд зохимгүй мэт сайхан хөмсөгний нь дор сайхан хар нүд гялалзана. Хамар нь Юоны хамар шиг, харин ам нь ялимгүй том боловч цонхигор царайнаасаа хурц ялгарсан уруулы нь тодруулсан цагаан шүд нь тун сайхан ажээ. Бас байгалиас заяадаг ердийн хэмжээнээс арай том гэмээр завжин дээрх хар мэнгэ нь Альберыг айлгасан энэ хүүхний царайг улам ч шийдмэг болгох ажээ. Эжений биеийн хэлбэр нь бидний дүрслэх гэсэн царайтай тохирно. Шато-Реногийн хэлснээр энэ хүүхэн анчин Дианатай адил боловч түүний гоо сайханд илүү хатуу зориг бах ажээ.

Хэрвээ охины олж авсан боловсролд ямар нэгэн дутагдал байдаг бол тэр нь мөн л царай шиг нь өөр хүйсийн хүнд тохирох байв. Хэд хэдэн хэлэх ярьдаг, сайхан зурдаг, шүлэг бичиж, хөгжим зохионо. Хөгжимд илүү их дуртай, сургуулийнхаа нэгэн ядуу найз охинтой хамт хичээллэх бөгөөд тэр охины нь сайн дуучин болох бүх зүйл нь бүрдсэн гэж хүмүүс ярина. Нэгэн нэрт хөгжмийн зохиолч түүнийг хожим сайн дууч болж баяжина гэж бараг л эцэг ёсны анхаарал санаачилга тавин хичээллэдэг гэнэ. Луйза де Армили гэдэг энэ охин хожим тайзан дээр дуулж болох бололцоо нь мадмаузель Дангларыг түүнтэй хамт олны дотор явахад саад болно. Харин гэртээ бол хүлээж авна. Луйза банкны эзний гэрт найз охины хувиар чөлөөтэй байдаг болохоор ердийн багшаас илүү байдаг байлаа.

Хатагтай Дангларыг орж ирснээс хойш хэдэн секунд болоод хөшиг хаагдлаа. Хагас цан шахам завсарлах учир амрах танхимаар зугаацах ч юм уу эсвэл танил нөхдийнхөө лоожоор хэсэж болно. Хөгжимчдийн байр ч бараг хоосорлоо.

Альбер Шато-Рено хоёр хамгийн түрүүнд шахам суудлаа орхиж босов. Альбер ийн яаран гарсан хэрэг нь надтай ирж мэндлэх гэснийх гэж хатагтай Данглар бодоод, охин руугаа тонгойж энэ тухай хэлэхэд, цаадах нь зөвхөн толгойгоо сэгсрээд инээмсэглэв. Яг энэ үед Альбер Эженийн итгээгүйг батлах гэсэн мэт нэгдүгээр эгнээний хажуугийн лоожинд гарч ирлээ. Энэ бол гүнгийн хатан Г-н лоож байлаа.

- Өө эрхэм жуулчин гэж хатагтай хуучин танилын ёсоор гараа өгч, - Намайг таньсанд чинь, ялангуяа хамгийн түрүүнд над дээр орж ирсэн чинь сайхан байна.

- Хатагтай минь хэрвээ би таныг Парист ирсэн гэж дуулаад хаяг чинь байсан сан бол ингэж удаан хүлээхгүй байсан юм. Ингээд францад цөөхөн үлдсэн дээдсүүлийн нэг миний найз түшээ гүн Шато-Ренотой танилцуулахыг зөвшөөрнө үү? Таныг Марсын талд болсон морин уралдаан үзэж явна билээ гэж надад хэлсэн юм.

Шато-Рено мэхийн ёсоллоо.

- Та уралдаан дээр байсан уу? гэж хатагтай сонирхон асуулаа.

- Байсан авхайтан.

- Тэгвэл Жокей клубын шагнал авсан тэр морь хэнийх вэ? Надад хэлж өгнө үү? гэж сонирхоход

- Мэдэхгүй юм. Би дөнгөж сая энэ асуултыг Альберээс асуугаад байгаа юм гэж Шато-Рено хэллээ.

- Хатагтай, энэ танд их чухал бацна уу? гэж Альберт асуулаа.

- Юу тэр вэ?

- Морины эзний нэрийг?

- Тэгэлгүй яах вэ? Бодоод үз...үгүй ингэхэд бэйс та түүний нэрийг мэдэж байж болох юм аа.

- Хатагтай та ямар нэгэн юм хэлэх гэв дээ. Янз нь “Бодоод үзээч” гэж хэлсэн шүү дээ.

- Бодоод үзээч, тэр хурдан хээр морь ба ягаан хувцастай жижигхэн хүн хоёрыг анх хараад л би түрүүлнэ гээд хөрөнгөнийхөө хагасыг тавьчихсан хүн шиг л түрүүлээсэй гэж хүсэж байлаа. Тэгээд бусад бүх морьдоос үүд хоймрын зайтай гарч ирэхэд нь учиргүй их баярлаж ухаангүй юм шиг алгаа ташсан. Тэгээд гэртээ хүрээд иртэл шатан дээр өнөөх жижигхэн хүнтэй дайралдаад, хичнээн их гайхсаныг яана аа. уралдаад түрүүлсэн энэ хүн надтай хамт нэг байшинд сууж байгаа юм байжээ гэж бодоод хаалгаа нээтэл өнөө танихгүй хүн морь хоёрын өнөөдөр авсан алтан цом нүдэнд харагдлаа. Цомон дотор “Лорд Рутвенээс гүнгийг хатан Г-д” гэж бичсэн бичиг байлаа.

- За тэр дээ гэж Альбер хэллээ.

- Энэ чинь юу гэсэн үг вэ? Та юу гэх гэв?

- Өнөөх лорд Рутвен мөн байна гэх гэсэн юм.

- Ямар лорд Рутве бэ?

- Яагаа вэ, бидний Аржентиний театрт харсан буг.

- Тийм гэж үү? Тэр энд байгаа юм уу гэж хатагтай дуу алдлаа.

- Тэгэлгүй яах вэ.

- Тэгээд та түүнтэй уулздаг уу? Та тэднийд очдог уу? Тэр танайд ирдэг үү?

- Тэр бол миний ойрхны найз. Тэр ч байтугай эрхэм Шато-Рено ч түүнтэй танилцсан.

- Та яагаад заавал түүнийг шагнал авсан гэж бодож байна?

- Түүний морийг Вампа гэдэг нэрээр оруулсан юм байна.

- Тэгээд яагаа вэ?

- Намайг олзолж авсан цуут дээрэмчинг хэн гэдэг байсныг санахгүй байна уу?
- Нээрээ тийм шүү.
- Түүний гараас гүн намайг гайхалтайгаар аварсан шүү дээ.
- Тийм тийм.
- Түүнийг Вампа гэдэг байсан юм. тэгэхээр миний хэлдэг хүн мөн болохыг та өөрөө харж байгаа биз дээ.
- Харин тэр яагаад надад энэ цомыг өгсөн юм бэ?
- Нэгдүгээрт чи таны тухай түүнд их ярьдаг байсан юм. хоёрдугаарт тэр лав нутгийнхаа хүүхнийг хараад өөрт нь тэгж анхаарал тавьсанд баярласан байх.
- Түүний тухай бидний ярьсан дэмийн яриаг түүнд хэлээгүй байх гэж найдаж байна.
- Илэн далангүй хэлэхэд би тэгж яриагүй гэж баталж чадахгүй. Харин танд энэ цомыг лорд Рутвений нэрээр өгч байгаа нь...
- Үгүй энэ чинь аймаар хэрэг байна. тэр намайг үзэн ядаж байгаа юм байна.
- Түүний ингэсэн нь түүнд дайсагнаж буйг гэрчилж байгаа гэж үү?
- Үгүй л дээ.
- За тэр шүү!
- Тэгвэл тэр хүн Парист байгаа байх нь ээ?
- Тийм ээ
- Тэгээд ямаршуухан сэтгэгдэл төрүүлж байна даа.
- Түүний тухай бүтэн долоо хоног ярьсан. Дараа нь английн хатан хааныг ширээнд залсан ба мадмаузель Марсын очир алмаасыг хулгайлсан тухай л ярих боллоо гэж Альбер хэлэхэд Шато-Рено,
- Найз минь та гүнгийн найз, тэгээд түүнд талтай байдаг юм байна. Хатагтай минь хүний үгэнд бүү үнэмшээрэй. Парист одоо ганцхан Монте-Кристо гүнгийн тухай ярьцгааж байна. Тэр хатагтай Дангларт гучин таянган франкийн үнэтэй хос морь бэлэглэсэн. Дараа нь хатагтай Вильфорын амийг аварсан. Сүүлд нь Жокей клубын шагнал авсан байх шив дээ. Морсер юу ч гэж ярьсан одоо хүн бүхэн гүнг сонирхож, гүнгийн тухай лав л нэг сарын турш ярьцгаана гэдгийг батална гэв.
- Магадгүй гэж Альбер хэлээд,-Байз, тэр хуучин оросын элчингийн лоожийг хэн авчхаа юм бол гэж асуулаа.

- Аль нь вэ гэж хатагтай асуухад

- Багануудын хоорондох нэгдүгээр эгнээнд цоо шинээр засчихсан байх шив.

- Нээрээ тийм байна. Нэгдүгээр үзэгдлийн үед тэнд хүн байсан уу? гэж Шато-Рено асуув.

- Хаана?

- Тэр лоожинд.

- Үгүй, надад л юм харагдаагүй гэж хатагтай хэлснээ түрүүчийнхээ ярианд эргэн орж, - Тэгвэл та Монте-Кристо гүн шагнал авсан гэж бодож байна уу? гэж асуулаа.

- Би үүнд итгэлтэй байна.

- Тэгээд надад цомоо явуулсан байх нь уу?

- Эргэлзээгүй хэрэг.

- Бид хоёр танил биш шүү дээ. Цомыг нь буцааж өгмөөр байна гэж хатан хэлэв.

- Та битгий тэгээрэй. Хэрвээ буцаагаад өгвөл бадмаараг, эсвэл индранилээр сийлсэн цомыг ирүүлнэ. Тэр дандаа тэгдэг хүн. Үүнтэй эвлэрэхээс өөр аргагүй.

Энэ үед хонх дуугарч, хоёрдугаар үзэгдэл эхэлснийг мэдэгдэхэд, Альбер суудал дээрээ очиж суухаар бослоо.

- Би тантай дахин уулзах болов уу? гэж хатагтай асуулаа.

- Хэрвээ таныг зөвшөөрвөл би завс рлагаагаар орж ирж, Парист байхад чинь ямар нэг талаар тус болж болох эсэхийг асуумз.

- Эрхмүүд ээ, би бямба гариг бүрийн орой айз нөхдөө хүлээн авдаг. Манайх Риволи гудамжны хорин хоёрдугаар байшин. Манайд очоорой гэж хатагтай хэлэв.

Залуу хүмүүс мэхийн ёслоод лоожноос гарцгаалаа.

Тэр хоёр үзэгчдийн гол суудал руу ороод хүмүүс цөм босч нэг зүг харж байхыг үзлээ. Тэд цөм тэр зүг хараад хуучин оросын элчний лоожинд хараа нь туслаа. Тэр лоожинд гучин тав, дөч орчим насны нэгэн эрхэм, дорнодын маягийн хувцастай залуухан бүсгүйн хамт орж ирлээ. Тэр охин гайхалтай гоо сайхан бөгөөд хувцас нь их л тансаг дэгжин тул хүмүүсийн нүдийг булаажээ.

- Монте-Кристо албани хүүхэнтэйгээ орж ирсэн байна шүү дээ гэж Альбер хэлэв.

Үнэндээ ч гүн, Гайде хоёр байлаа. Хэдэн минут ч болоогүй байтал Гайде зөвхөн гол танхимын үзэгчдийн анхаарлыг татаад зогсоогүй, театрт байсан бүх л хүний анхаарлыг татлаа. Авгайчуул цэцгэн дэнгийн гэрэлд машид туяаран гялалзсан доржпалам чимгийг нь харах гэж лоожноосоо цухалзана.

Цугларсан олон гайхан догдолсныг харуулсан чимээн дунд хоёрдугаар үзэгдэл өнгөрлөө. Хэн ч чимээгүй байлгах гэж бодсонгүй. Ийм залуухан, ийм гоо үзэсгэлэнтэй, ийм сайхан охин хамгийн үзүүштэй зүйл боллоо.

Энэ удаа Альберт өгсөн дохио нь хатагтай Данглар түүнийг дараагийн завсарлагаар өөрийнхөө лоожинд ирэхийг хүссэн дохио байлаа.

Алјбер, түүнийг хүн хүлээж байгаагаа илтэд мэдэгдсэн бол тэр хүнийг удаан хүлээлгэж чилээлгэхээр хүмүүжсэн хүн биш ажээ. Ийм учраас үзэгдэл дөнгөж дуусмагц хатагтайн лоожинд очихыг яарав. Альбер авхай нарт мэхийн ёслоод, Дебрэтэй гар барилаа.

Хатагтай Панглар түүнийг ихэд баярлан угтсан бөгөөд харин Эжени өнөөх л хүйтэн маягаараа угтлаа.

- Хайрт нөхөр минь, таны өмнө гайхаж, аль ч учраа олохыг болиод, танаар туслуулахаар урьсан хүн зогсож байгааг хар даа гэж Дебрэ хэлээд,- Хатагтай надаас гүнгийн тухай асууж, бүгдийг мэдэх гэж шаардаад байна. Би Калиостро¹ биш, хэцүү байдлаас гарах гэсэндээ.” Морсероос асуу, тэр Монте-Кристог арван хуруу шигээ мэднэ “ гэж хэлчихлээ. Тэгээд л таныг дуудсан юм гэж Дебрэ хэлэв.

- Хагас саяар тооцогдох нууц фондтой байж, иймхэн зүйлийг мэдэхгүй байна гэдэг итгэшгүй хэрэг байна гэж хатагтайг хэлэхэд, Люсьен,

- Надад тэр хагас сая байсан бол, би зүгээр л хязгааргүй баянаас цааш юмгүй, Монте-Кристо гүнгийн тухай мэдээ цуглуулах гэж явахгүй, өөр юманд хөрөнгийг зарцуулна. За би суудлаа найз Морсертоо тавьж өгье. Одоо үүнээс асуугтун, надад хамаа байхгүй боллоо гэж хариулав.

- Ямар ч баян гэсэн гучин мянган франкийн үнэтэй хоёр морь, дөрвөн чихэнд нь тус бүр таван мянган франкийн үнэтэй засмал алмаас шигтгэж ирүүлнэ гэж үү?

- Очир эрдэнэ гэдэг түүний ганц дуртай юм нь байгаа юм гээд Альбер инээж – Тэр Потемкин шиг хармаа дүүрэн алмааз чулуутай явж, хуруун чинээ хүү лугаа адил унагалж явдаг шиг цацан явдаг юм шиг 1 санагдана.

Тэр лав нэг газраас очир эрдэнийн уурхай олсон байхаа гэж хатагтай Данглар хэлээд – Түшээ гүнгийн банкинд хэмжээгүй их зарцуулах мөнгөний эрх нээсэн гэдгийг та нар мэдэх үү? Гэлээ.

- Үгүй би мэдээгүй гэж Альбер хэлээд – Гэсэн ч би үүнийг гайхахгүй байна.

- Монте-Кристо гүн Парист нэг жил болно, тэгэхдээ зургаан сая франк зарна гэж эрхэм Дангларт хэлсэн байна лээ.

- Нэрээ өөрчлөөд жуулчилж яваа персийн хаан гэж бодох хэрэгтэй.

- Тэр хүүхэн нь ямар гоо сайхан юм бэ! Люсьен та ажиглав уу? гэж Эжени асуулаа.

- Би таныг бусад хүүхний сайн сайхныг үнэнээр нь дүгнэдэг ганцхан хүн гэж боддог.

Люсьен нүдэндээ өрөөсөн шилээ аваачиж хараад,

- Гайхам сайхан хүүхэн байна гэж хэллээ.

- Энэ хүүхэн хэн гээ болохыг эрхэм де Морсер мэдэх болов уу?

- Бидний ярьж байгаа битүүлэг хүний тухай бусдын адил тийм барагцаагаар мэднэ гэж энэ шаргуу асуултад нь Альбер хариулаад – Энэ чинь албани хүүхэн гэж хэлэв.

- Тийм байна, хувцсаараа танигдаж байна. таны бидэнд хэлж байгаа үйл чинь хэдийнээ олны мэдэх болсон зүйл.

- Би тийм бүдүүлэг тайлбарлагч болсондоо харамсаж байна гэж Альбер хэлээд – Харин үүгээр миний мэдэх зүйл төгслөө. Бас тэр хүүхнийг хөгжимчин гэдгийг мэднэ. Намайг гүнгийн өглөөний зоог барьж байхад тэр бүсгүй хөгжимдөж байсан юм.

- Тэгвэл тэр танай гүн чинь гэртээ зочид хүлээж авдаг байх нь ээ? гэж хатагтай Данглар асуулаа.

- Маш сайхнаар хүлээж авна гээч.

- Дангларыг шахаж байж түүнд зориулж үдийн хоол, эсвэл үдэшлэг хийлгэвэл биднийг хариуд нь урих байх.

- Та түүн дээр очно гэж үү? Гэж Дебрэ инээн хэлэхэд,

- Яагаад болдоггүй юм бэ? Хар хүнтэйгээ хамт очихгүй юу гэв.

- Тэр учир нь олдохгүй гүн чинь эхнэргүй хүн шүү!

- Тийм биш юм гэдгийг нь та харж байга биз дээ гэж хатагтай Данглар хэлээд гоо үзэсгэлэнт хүүхэн өөд зааж инээлээ.

- Энэ хүүхэн чинь боол хүүхэн, мОрсер, танайд өглөөний цайн дээр тэр өөрөө хэлж байсан санаж байна уу?

- Эрхэм Люсьен та түүнийг хааны гүнжийн дүртэй болохыг зөвшөөрвөл таарна гэж хатагтай хэлэхэд Альбер тосоод

- “Мянга нэгэн шөний үлгэрийнх” шиг гээч гэлээ.

- Зөвшөөрнө, эрхэм хааны гүнжийг юу бүтээдэг билээ? Очир эрдэнийн чулуу шүү дээ. тэгвэл энэ хүүхэн энэ эрдэнэс дотор умбаж байдаг хүн юм.

- Эрдэнэс нь дэндүү ихэдсэн юм гэж Эжени хэлээд - Үүнгүй байсан бол хүзүү гар нь харагдаад улам ч сайхан байх байсан юм гэхэд,

- Ай энэ зураачид уу? Харж байна уу, бүр сэтгэл нь хөдөлчихөж гэж хэлэв.

- Би сайхан юм бүхэнд дуртай гэж Эжени хэлэхэд Дебрэ

- Тэгвэл та гүнг юу гэх вэ? Надад бол аятайхан л хүн шиг байна гэхэд

- Гүн үү? Гэж Эжени сая болтол түүн рүү харах гэж бодоогүй байсан шиг байдалтайгаар асуугаад,

- Гүн дэндүү цагаан царайтай юм гэлээ.

- Тийм ээ чухам тэр цар йны нь цагаан бидэнд сонирхогдоод байгаа юм гэж хэлээд- Гүнгийн хатан Г түүнийг цус сордог буг гээд байдаг юм гэв.

- Өө гүнгийн хатан буцаад ирсэн үү? Гэж хатагтайг асуухад, Эжени

- Хажуугийн лоожинд сууж байна шүү дээ гэж хэлээд – Бараг бидний өөдөөс харсан тэр сайхан алтан шаргал үстэй хүүхэн гэлээ.

- Өө харлаа гэж хатагтай хэлээд – Морсер та юу хийхээ мэдэж байна уу? гэж асуулаа.

- Хатагтай та тушаа л даа.

- Та гүн дээр ороод дараа нь түүнийг бидэн дээр авчирмаар байна.

- Авчирч яах юм бэ? гэж Эжени асуулаа.

- Яах вэ түүнтэй ярихгүй юу, чамд ч гэсэн түүнтэй ярихад сонин байх болно.

- Огтхон ч үгүй.

- Хачин хүүхэд шүү гэж хатагтай бувтнав.

- Лав тэр өөрөө хүрээд ирэх байх таныг харчихаад мэндэлж байна гэж Альбер хэлэв.

Хатагтай түүний хариуд нь эелдэгээр инээмсэглэлээ.

- За яах вэ, би золигт гаръя, түүнтэй уулзаж болох эсэхийг асуухаар би та нарыг орхиж гарлаа гэж Альбер хэлэв.

- Лоож уруу нь очихгүй юу. түүнээс амар юм гэж хаана байх вэ.

- Гэвч би танилцаагүй байгаа шүү дээ.

- Хэнтэй?

- Гоо үзэсгэлэнт албани хүүхэнтэй.

- Үгүй та түүнийг шивэгчин нь гэсэн биз дээ.

- Тийм ээ гэвч та түүнийг хааны гүнж гээ биз дээ... за яах вэ, очиж явааг минь харчихаад тэр ч бас гараад ирж магадгүй.

- Магадгүй ээ яв яв.

- За явлаа.

Альбер бөхөсхийн ёслоод гарч одлоо. Нээрээ ч Альберыг гүнгийн үүдээр өнгөрөхөд хаалга нь нээгдэж гүн гарч ирлээ. Гудамд зогсож байсан Алид араб хэлээр хэдэн үг хэлчихээд, Альберыг сугадан авав. Али хаалга хаачхаад өмнө нь очиж зогсоход түүнийг тойрон амьтанг хүн шавлаа.

- Танай Парис үнэхээр хачин хот юм. парисынхан ч гайхалтай хүмүүс юм. негр хүн анх үзэж байгаа юм байх гэж хэлж болмоор. Юу болж байгааг нь ч ойлгохгүй Алиг тойрчихсон байгааг нь хараач. Хэрвээ Парисаас нэг хүн Тунис, Константинополь, Багдад эсвэл Кайрт очвол алинд нь ч гэсэн түүн дээр тэгж бөөгнөрч шавахгүй дээ гэж гүн хэлэв.

- Энэ бол Дорнодын хүмүүс саруул ухаантай чухал хэрэгтэй юмаа лхарж сонирхдог болж байгаа юм гэж Альбер хэлээд – Али таны хүн болохоор Парист их амжилт олж байна. та чинь одоо энд хамгийн анхаарлыг татаж байгаа хүн шүү дээ.

- Нээрээ гэж үү? Би ийм аз завшааны ачийг хэнд хариулбал зохилтой вэ?

- Өөртөө л. Та мянган луйдорын морь бэлэглэсэн, вангийн прокурорын эхнэрийн амийг аварсан. Хошууч Блэкийн нэрээр шилдэг сайн морь ба сармагчингийн хэртэй хүн уралдаанд оруулсан. Тэгээд сүүлд нь алтан цои хожиж түүнийгээ сайхан хүүхэнд бэлэглэж байна.

- Энэ бүх үлгэрийн танд хэн яриа вэ?

- Нэгдүгээрийг нь таныг өөрийнхөө лоожинд ирүүлэх буюу өөрөөр хэлбэл лоожинд тань байж байгааг бусдад харуулахыг үхтлээ хүсэж байгаа хатагтай Данглар, хоёрдугаарыг нь Бошаны сонин, Гуравдугаарыг нь миний зөн билтиг хэлсэн болно. Та нэрээ хүнд мэдэгдэхгүй гэсэн юм бол яагаад морио Вампа гэж нэрлэв?

- Тийм ээ нээрээ болгоомжгүй явдал болсон юм гэж гүн хэлээд - Үгүй ингэхэд Морсер гүн операд ирдэггүй юм уу? Би хэчнээн анхааралтай харсан боловч олж үзсэнгүй гэлээ.

- Тэр өнөөдөр ирнэ.

- Хаана?

- Түшээ гүнгийн хатны лоожинд байх гэж бодож байна.

- Дэргэд нь байгаа тэр сайхан авгай охин нь уу?

- Тийм ээ.

- Танд баяр хүргэхийг зөвшөөрнө үү.

Альбер инээмсэглэж,

- Би энэ тухай дараа тодорхой ярья. Хөгжиа танд ямар санагдаж байна?

- Ямар хөгжим?

- Бидний саяын сонсдог хөгжим.

- Диогений хэлснээр хүн гээч амьтан түүнийг зохиогоод хоёр хөлтэй даль жигүүртэй шувууд дуулж байгаа болохоор ихэд сайхан хөгжим байна.

- Үгүй ер, эрхэм гүн юу? Хэрвээ та хүсвэл диваажингийн тэнгэрлэг охидын хоолойг нийлүүлэн дууоох дуугаар сэтгэлээ баясгаж яаддаг байх нь гэж бодож болох нь ээ?

- Бараг л тийм дээ, бэйс. Үхэх тавилантай хүний чих сонсоогүй тийм уянгалаг хөгжим сонсьё гэхээрээ би зүүрмэглэн унтдаг юм.

- Тэгвэл та яг хэрэгтэй газраа ирж дээ. эрхэм гүн минь ханатлаа нойрс. үүний тулд дуурийг зохиодог юм.

- Үгүй нуулгүй хэлэхэдтанай хөгжим дэндүү их чимээ шуугиантай юм. миний хэлж байгаа тэр нойроор нойрсоход анир чимээгүй, тайван байдал хэрэгтэй...бас тэгээд зарим нэг бэлтгэл.

- Өнөө гайхамшигт гашиш уу?

- Чухам тийм. Бэйс та хөгжим сонсохосн гэж бодохоороо л манайд ирж оройн зоог барьж байгаарай.

- Би танайд өглөөний зоог зооглохдоо тэр хөгжмийг сонссон.

- Ромд уу?

- Тийм ээ.

- TSp чинь Гайдегий пийпай хөгжим байсан юм. хөөрихй хөөгдмөл охин заримдаа надад нутгийнхаа дууг дуулж зугаацдаг юм.

Альбер ч шалгаан асуусангүй, гүн ч дуугүй боллоо.

Энэ минутад хонх дуугарлаа.

- Та намайг уучлаарай гэж гүн лоож уруугаа явлаа.

- Тааллаараа л бол.

- Гүнгий хатан Г-д буг чинь баяр хүгэж байна гэж хэлээрэй.

- Аа түшээ гүнгийн хатанд?

- Хэлвээ зөвшөөрвөл өнөө оройдпоо тэдэн дээр очиж, хүндэтгэж байгаагаа тлэрхийлье гэж дамжуулаарай.

Гуравдугаар үзэгдэл эхэллээ. Энэ үзэгдлийн үед Морсер гүн хэлсэн ёсоороо хатагтай Дагларын лоожинд орж ирэв.

Гүн бол үзэгчдийн танхимыг догдлуулахаар хүн биш болохоор лоожинд сууж байсан хүмүүсээс бусад нь түүний орж ирэхийг мэдсэнгүй.

Харин гүн орж ирхийг нь ажиглаад үл мэдэг мушилзав.

Гайдегийн тухайд гэвэл хөшиг нээмэгц орчин ттойрон юу болэ байгааг анзаарахаа болилоо. Бүх л шууд шулуун хүмүүсийн адил зөвхөн нзд сонорт хүрч байгаа тэр зүйл л анхаарлыг татна.

Гуравдугаар үзэгдэсл гардгаараа гарч жүжигчин Нобль, Жюли, Лера нар ердийнхээ бүжгийг хийж, Роберт-Марио, хаан хүү Гренадын ирүүл тулаанд дуудаж сүүлд нь сүрлэг ван охиныхоо гараас барьж өөрийнхөө урт хилэн нөмрөгийг харуулах гэж тайзан дээгүүр явж өнгөрлөө. Түүний дараа хөшиг хаагдаж үзэгчид завсарлагаанаар амрах байранд гарлаа.

Гүн лоожноосоо гарч хэдэн секундын дараа хатагтай Дангларын лоожинд орж ирлээ.

Хатагтай гайхан баярласан сэтгэлээ гаргахгүй байж чадсангүй.

- Өө гүшн минь таны ирсэнд их баяртай байна гэж дуу алдан хэлээд – Би танд баярлаж талархаснаа илэрхийлсэн зурвас дээрээ амаар нэмж хэлэх юмсан гэж хиад хүсэж байлаа гэв.

- Хатагтай та тэр үл ялих юмыг одоо хүртэл мартаагүй байгаа юм уу? Би бүр мартчихаж.

- Тийм ээ, мартаагүй, түүний маргааш нь миний найз хатагтай Вильфорын мөн л тэрхүү морьдоос болсон явдлаас аварсныг мартаж болохгүй шүү дээ.

- Хатагтай минь энэ бол миний гавъяа биш, миний нуби хүн Али л хатагтай Вильфорт тус хүргэх аз тохиолдсон юм.

- Аа миний хүүн Ромын дээрэмчдийн гараас бас л Али аварсан уу? гэж Морсер гүн асуухад, гүн генералын сунгасан гарыг атгаад,

- Үгүй, энэ удаа талархлыг би хүлээн авна. Гэхдээ та түрүүн надад баярлаж талархаснаа хэлсэн, би ч сонссон. Тэгэхээр одоо дахин сонсоход төдийн л таатай биш байна. хатагтай минь та надад охиноо танилцуулж өгөхгүй юу гэлээ.

- Тэр таныг нэрээр чинь хэдийнээ мэднэ. Бид энэ хэдэн өдөр гацхан таны л тухай ярьцгааж байна гэж хэлээд, - Эжени энэ хүн бол Монте-Кристо гүн гэж охиндоо хандан хэлэв.

Гүн мэхийн ёслоход мадмаузель Данглар толгой дохин ёсоллоо.

- Гүн тантай хамт сууж байгаа гоо бүсгүй таны лохин уу? гэж түүний асуухад ийм дэндүү хүүхэд маягаар мэдэмхийрэн асуухад нь гайхсан гүн,

- Үгүй мадмаузель, энэ бол золгүй албаний хүүхэн. Би асрамжиндаа авсан юм.

- Нэр нь хэн гэдэг вэ?

- Гайде гэж гүн хэлэв.

- албани охин гэнээ гэж Морсер гүн бувтнахад, хатагтай Данглар,

- Тийм ээ гүнтэн таны тэр их алдар гавьяатай алба хааж байсан Али-Тебелений о°донд ийм сайхан хуюцастай хүн байсан уу? гэж асуулаа.

- Та чинь тэгвэл Янинад байсан байх нь ээ гүн гуай гэж Монте-Кристо асуухад Морсер,

- Би пашийн генерал сургагч байсан юм. миний энэ жаахан хөрөнгө хогшил бол албаний эзний хайрласан өгөөмөр хайр хишиг байгаа юм.

- Тэр хүүхнийг хараач гэж хатагтай Данглар үалгаахад Морсер бувтнан

- Хаана гэв.

- Тэр байна гэж гүн заангаа Морсер гүнгийн мөрөн дээгүүр гараа тавин хоёул лоожны хашлага дээгүүр тонгойв.

Энэ үед гүнг хайж ийш тийш харж байсан Гайде Морсерын мөрөөр тэврэн тонгойж байгаа түүний цагаан царайг олж харлаа. үүнийг харсан бүсгүй медузын толгой харсан хүн л тийм байдаг болов уу гэлтэйболж, сайн харж авах гэсэн мэт сулхнаар дуу алдвал ояр байсан хүмүүс ба Али соносж яаран орж ирлээ.

- Хараач таны тэжээвэр охин яачхав аа? Бие нь эвгүй оргих шиг боллоо гэж Эжени хэлэхэд гүн,

- Нээрээ тэглээ шүү. Гэсэн айх хэрэггүй. Гайде их бухимдуу болохоор элдэв үнэр авч чаддаггүй юм. эвгүй үнэр үнэртхээр ухаан нь балартдаг юм гээд гүн хармаанаасаа шилтэй бодисоо гаргаж – Гэхдээ надад түүнийг аргалах юм бий гэлээ.

Тэгээд хатагтай түүний охин хоёрт мэхийн ёслоод гүн, Дебрэ хоёрын гарыг дахин атгаад хатагтай Дангларын лоожноос гарлаа.

Түүнийг лоожиндоо буцаж ирэхэд Гайдегийн барай цонхигор хэвээрээ байлаа. Дөнгөж ормогц нь бүсгүй гараас нь шүүрэн авав. Залуу бүсгүйн гар мөс шиг хүйтэн чийг даасан байхыг гүн мэдэрлээ.

- Ноён минь та хэнтэй ярив ? гэж бүсгүй асуухад

- Морсер гүнтэй. Танай алдарт эцэгт алба хааж хөрөнгө чинээтэй болсныхоо ачийг санаж явдаг гэнэ гэж хариуллаа.

- Бузар амьтан гэж Гайде дуу алдаад – Энэ түүнийг түрэгүүдэд худалдсан юм. түүний хөрөнгө хогшил гэдэг нь урвалтын эд хөрөнгө байгаа юм. миний эрхэм ноён чи үүнийг одоо хүртэл мэдээгүй байгаа юм уу?

- Би Эпирт байхдаа иймэрхүү юм сонссон. Гэхдээ энэ явдлын нарийн ширийнийг мэдэхгүй. Явья охин минь чи энэ бүгдийг надад яриарай, сонирхолтой байж таарна гэлээ.

- Тэгье, тэгье. Одоо дахиад энэ хүний ойр байвал би үхэж мэднэ.

Гайде түргэн босоод шүр сувд шигтгэж оёсон цагаан алчуураа нөмрөөд, тайзны хөшиг нээгдэж байгаа яг тэр үед гарлаа.

Альберыг гүнгийн хатан Г дээр хүрч ирэхэд – Хараач. Энэ хүн хүнтэй адил юм хийхгүй шүү. “Робертын” гуравдугаар үзэгдэл дээр гараад явах юм гэлээ.

XVI. Ханш өсөж буурсан нь

Энэ уулзалтаас хойш хэд хоногийн дараа Альбер де Морсер, гүнгийн Елисейн тал дахь өргөөнд нь айлчлан очлоо. Энэ сууц нь гүн асар их хөрөнгөндөө дулдуйдан түр зуурынхаа сууцыг ч гэсэн янзлан засдагийн адил хэдийн ордны шинжтэй болчихсон байлаа. Альбер түрүүчийн удаа хатагтай Данлар буюу Эрмина де Серьверийн захидлаар илэрхийлсэн баяр талархлыг дахин дамжуулахаар иржээ.

Альберыг Люсье де Дебрэ дагаж ирсэн бөгөөд тэр нөхрийнхөө талархсан үгэн дээр албан ёсны бус хэдэн үг нэмж хэлэхэд, чухам юунаас болж тэгж хэлсэн нь гүнгийн ажигламтгай харцнаас бултаж чадсангүй. Тэрч байтугай Люсьен хоёр талын сонирхлоос болж ирсэн мэт гүнд санагдсан бөгөөд үүний нэг нь Шоссе де Антен гудамжинд суугчдын сонирхлыг төлөөлсөн бололтой. Үнэн хэрэг дээрээ хатагтай Данглар гучин мянган франкийн үнэтэй морьд бэлэглэж, очир эрдэнэсээр дүүрэн чимэглэгдсэн шивэгчин хүүхэн дагуулж театрт очдог тэр хүн яаж суудгийг өөрийнхөө нүдээр үзэх бололцоогүй болохоор өөрийн итгэлт хүнийг нүд болгон явуулж гүнгийн гэрийн байдлыг үзүүлэх гэсэн юм байна гэж айлтгүй бодож болох байлаа.

Гэвч гүн, түшээ гүнгийн хатны сонирхолтой холбогдсон Люьсен ирж байгааг шинж огтхон ч үзүүлсэнгүй.

-Та түшээ гүн Данглартай байнга уулздаг уу? гэж Альбераас асуулаа.

-Тэгэлгүй яах вэ. Гүн та миний ярьсныг санаж байгаа биз дээ.

-Тэгвэл хуучин хэвээрээ байгаа хэрэг үү?

-Бүр ч илүү. Энэ ч шийдчихсэн хэрэг юм шүү дээ гэж Люсьен хэлэв.

Тэгээд ярианд хангалттай оролцсон гэж үзсэн бололтой яст мэлхийн хуяган хүрээтэй өрөөсөн нүдний шилээ зүүж, таягныхаа алтан толгойг хазлан тасалгаан дотуур явж зэвсэг, зургуудыг сонирхож гарав.

-Таны хэлснээр бол эцсийн шийдвэр гарах болоогүй юм шиг санагдах юм гэж Монте-Кристо Альберт хэлэв.

-Яах ч арга алга. Ажил явдал гэдэг чинь харвасан сум шиг л хурдан болж байна. Тэдний тухай бодоогүй байхад л чи тэдний лухай бодоод байх юм. Эргээд л храхад хэчнээн хол явчихсан нь харагдах юм. Манай эцэг эрхэм Данглар хоёр Испанид алба хааж, манай аав армид, Данглар арын албанд байсан юм. Чухам тэнд л хувьсгалын үед хоосорсон эцэг маань улс төр ба цэргийн эрх тушаалаа олж, урьд өмнө халуун дүүрэн байгаагүй Данглар улс төр, санхүүгийн гайхам нэр төр, эрх тушаалыг олж авсан юм.

-Нээрээ, эрхэм Дангларынд очиход тэгж ярьж байсан шүү гэж Монте-Кристо хэлээд альбом үзэж байсан Люсьенийг харж- мадмуазель Эжени гэдэг чинь сайхан охин байна лээ! Эжени гэдэг байх аа гэж нэмж хэлэхэд Альбер,

-Үнэхээр гоо сайхан охин. Гэвч би иймэрхүү гоо сайхныг үнэлдэг хүн биш. Би түүнд тохирохгүй хүн гэж хариулав.

-Тэр бүсгүй бүр таны эхнэр болчихсон юм шиг ярьж байх шив!

-Өө гэж Альбер дуугараад Люсьенийг дуурайн зураг сонирхож эхлэв.

-Та энэ гэрлэлтэд тийм их сэтгэл хөөрөхгүй байх юм шиг санагдах юм гэж Монте-Кристо хэлэв.

-Мадмуазель Данглар дэндүү баян юм. Энэнээс нь л би айх юм.

-Хачин шалтгаан байна даа! Өөрөө баян биш гэж үү? Гэж Монте-Кристо хариу хэлэв.

-Манай эцгийн жилийн орлого нь тавь орчим мянган ливр. Тэгэхээр намайг эхнэр авахаар түүнээсээ лав арав, арван хоёр мянгыг надад тасалж өгөх байх.

-Тийм ээ. Энэ ч зэгсэн том хөрөнгө дөө. Ялангуяа Парист шүү дээ хөрөнгө гэдэг маань гол биш. Нэр алдар нийгмийн яотор эзэлж байгаа байр суурь гэдэг чинь

бас л нэг баялаг шүү дээ. Танд цуутай нэр нийгмийн дотор өндөр байр байна. Түүнээс гадн Морсер гүн бол цэрэг хүн. Байяр шиг хүнд урван худалддаггүй, Дюгескилен¹ шиг ядуу зүдүү байдал хосолсон байхыг харахад таатай байна.Завшихыг мэддэггүй харамгүй сэтгэл гэдэг бол, сайн төрөлт илд хамгаас илүүгээр гялалздаг нарны туяа байгаа юм. Би энэ гэрлэлтийг хамгийн тохирсон гэрлэлт гэж бодоод байгаа юм. Мадмуазель Данглар танд баялгийг өгнө, та түүнд сайн сайхан нэр алдрыг өгнө шүү дээ! гэхэд, Альбер бодлогоширсон байдалтай толгой сэгсрэн,

- Бас нэг явдал байна гэж хэлэв.

- Таны баян чинээлэг гоо сайхан бүсгүйд дургүйцээд байдгийн учрыг ойлгоход хэцүү байна гэдгээ нуулгүй хэлье гэж гүнг хэлэхэд,

- Хэрвээ үүнийг зэвүүрхэх гэж хэлж болдог бол би ганцаараа ч тэгдэг юм биш шүү гэж Морсер хариулав.

- Тэгээд өөр хэн бэ? Та чинь эцгийгээ энэ гэрлэлтэнд дуртай байгаа гэж хэлсэн биз дээ.

- Миний ээж, хурц бөгөөд үнэнийг ологч нүдтэй. Ингээд энэ гэрлэлтэд ээж минь дургүйцээд байгаа юм. Ээж маань Дангларынханд нэг л итгэлгүй байдаг юм.

- За энэ ч мэдээжийн хэрэг гэж гүн бага зэрэг унжруулсхийн хэлээд,-Гоо сайхан, язгууртан шинжийн охь манлай болсон хатагтай Морсер, хүдэр ширүүн дориун гарт хүрэхээсээ бага зэрэг айж байгаа байлгүй. Энэ ч зүйн хэрэг л дээ гэв.

- Тийм эсэхийг үнэндээ мэдэхгүй юм. Харин би тэр охинтой гэрлэчихвэл ээж минь золгүй амьтан болж хувирна гэдгийг мэдэж байна. Одоогоос сар хагасын өмнө энэ асуудлын ашиг тустай талыг хэлэлцэх гэж цугларахаар шийдэж байсан боловч миний толгойн өвчин эхлээд...гэхэд,

- Жинхэнээр үү? гээд гүн инээмсэглэв.

- Жинхэнээр байлгүй яахав, лав айснаас болсон байх...Үүнээс болоод зөвлөлгөөнийг хоёр сараар хойшлуулсан юм. Яараад ч байх юмгүй хэрэг. Би дөнгөж хорин нэгтэй, Эжени арван долоохон настай, одоо хоёр сарын хугацаа маань ирэх долоо хоногт дуусна. Тэгэхээр үүргээ биелүүлэх хэрэг болох нь. Энэ явдал намайг хичээнэ их зовоож байгааг гүн та мэдэхгүй байгаа байх... Та эрх дураараа явдаг ямар азтай хүн бэ?

- Үгүй таныг ч гэсэн эрх дураараа явахад чинь юу саад болоод байна?

- Би Дангларын охинтой суучихвал эцэгт минь их л тустай хэрэг болно.

- Тэгвэл тэрүүнтэйгээ суучихгүй юу гээд гүн мөрөө хөдөлгөв.

- Харин суучихвал ээжид минь харамсалтайгаар барахгүй гунигтай явдал болно.

- Тэгвэл суухгүй л байхгүй юу.

- Би бодъё, оролдъё. Та нада зөвлөгөө сургамж өгөхдөө татгалзахгүй тийм ээ? Та ч намайг энүүнээс аргалж гаргах ч юм бил үү? Би ээжийгээ гомдоохгүйн тулд аавтайгаа зөрөлдөх нь ээ ч яахав.

Гүн буруу харав. Сэтгэл нь түгшсэн янзтай байлаа. Тэгээд зочны өрөөний булангийн зөөлөн сандал дээр суугаад баруун гартаа харандаа, зүүн гартаа дэвтэр барьж суугаа Дебрэд хандан,

- Та юу хийж байгаа юм бэ? Пуссенийг харж зурж байгаа юм уу? гэв.

- Би юу? За тиймэрхүү юм даа. ийм болохоороо л уран зурагт дуртай байдаг юм. гэсэн ч энэ удаа би өөр юм хийж тооцоо гаргаж сууна гэж цаадах нь тайвнаар хариулав.

- Тоо бодож байна гэнэ ээ ?

- Тийм ээ би тооцоо гаргаж байна. энэ бас бэйс танд хамаарна. Гайтигийн сүүлийн өсөлт дээр Дангларын банк хэчнээнийг хожсоныг тооцоолж байна. гурван өдрийн дотор хувь нийлүүлсэн тэмдэгт хоёр зуун зургаагаас дөрвөн зуун есөд хүрч байна. урьдаас харж чаддаг банкны эзэн ихээхэн хэсгийг нь хоёр зуун зургаагаар авсан байна лээ. Миний тооцоогоор тэр гурван мянгыг хожсон байна лээ.

- Энэ түүний хамгийн амжилттай ажиллагаа нь биш. Энэ жил испанийн облигацаас саяыг хожсон шүү дээ гэж Альбер хэлэхэд Люсьен

- Хүндэт нөхөр минь. Монте-Кристо гүн танд Италичууд шиг:

danaro e santia¹

meta della meta гэж хэлэх байна. энэ ч арай их байна аа. надад иймэрхүү юм ярихаар би зөвхөн мөрөө л хавчидаг юм.

- Үгүй та өөрөө Гайтигийн тухай ярьсан шүү дээ гэж гүн хэллээ.

- Гайти бол өөр хэрэг. гайти бол мөнгөний хожооны экарте² юм. бульот, вист, бостон гэх мэтийн хөзрийн тоглоомд дурлаж сэтгэл татагдаж болно. Гэсэн ч эцэстээ түүндээ хөрчихдөг. Харин экарте бол хүнийг татах чадвараа алдаггүй юм. амттан л гэсэн үг. Ингээд Данглар өчигдөр дөрвөн зуун зургаагаар худалдаад хармаандаа гурван зуун мянгыг хийсэн. Харин хоёр зуун тав хүртэл уначихсан өнөөдрийг хүлээсн бол гурван зуун мянган франк хожихын оронд, хорь хорин таван мянгыг алдах байсан юм.

- Яагаад дөрвөн зуун есөөс хоёр зуун тав хүртэл буурдаг билээ гэж гүн асуугаад – Намайг уучлаарай би тэр бирж гээч юмны явуулгыг ёстой мэддэггүй юм.

- Яагаад гэвэл мэдээ баримт гэдэг чинь цуварч ирэх болохоос адилхан байдаггүй д байгаа юм гэж Альбер инээн хариулахад

- Чөтгөр ав эрхэм Данглар нэг өдөр гурван зуун франкаа алдахаас буцахгүй аз үздэг хүн байх нь ээ. тэгэхээр тоолж барашгүй хөрөнгөтэй хүн юм аа гэж гүн дуу алдлаа.

- Үгүй өөрөө тэгж тоглодоггүй юм харин хатагтай Данглар л тоглодог юм гэж Люсьен сэргэж хэлээд – Гайхмаар зоригтой хүүхэн шүү гэж нэмж хэллээ.

- Ингэхэд люсьен та ухаантай, бас тэгээд ирж байгаа мэднүүдийн үнэ цэнийг мэдэх эх булаг дээр нь сууж байгаа хүн болохоор түүнийг зогсоох хэрэгтэй юм даа гэж Альбер хэлэхэд, Люсьен

- Нөхөр нь ч тэгж чадахгүй байхад би яаж чадах вэ? гэж асуугаад – Та хатагтайн занг мэднэ шүү дээ. хэний ч нөлөөнд автдаггүй. Дуртай л юмаа хийдэг хүн гэж хэллээ.

- Гэвч би таны оронд байсан бол гэж Альбер хэлэхэд,

- Тэгвэл яах гэж? гэв.

- Тэгвэл түүнийг эмнэх байсан даа. энэ бол түүний ирээдүйн хүргэнд их л тустай юм болно доо.

- Ямар маягаар?

- Маш амархан. Би л бол тэр авгайд сургамж өгнө дөө.

- Сургамж ий?

- Тийм ээ, сайдын гарын нарийн бичгийн дарга тушаал чинь таныг нэр хүндтэй хүн болгож байгаа болохоор таныг ам л нээвэл биржийн төлөөлөгчид юм болгоныг чинь түргэн бичлэгээр хүлээн авна. Тэгээд та тэр хүүхнийг дараа дарааJaар зуун мянган франк алдахаар хүргэчих. Тэгвэл болгоомжтой хянуур болчихно доо.

- Би таны хэлж байгааг ойлгохгүй байна гэж Люсьен бувтнахад,

- Харин ч их ойлгомжтой байгаа юм биш үү гэж Альбер үнэн цагаан санаанаасаа хариулаад – Та нэг сайхан өглөө л хэний ч санаанд оромгүй танаас өөр хэн ч мэдэхгүй байгаа цахилгаан утасны тухай хэлж орхи. Жишээ нь: Габриэлийнд дөрөвдүгээр Генрих байхыг өчигдөр харжээ. Ингэхээр бирж дээр ханш өснөө дөө. Данглар хатагтай энэ байдлыг ашиглаж хожоо гаргахыг хүсээд маргааш өдөр нь Бошаныг сонин дээрээ “Уржигдар Габриэлийг дөрөвдүгээр Генрихийнд байхыг нь харсан мэтээр учрыг мэдэх хүмүүсийн зарласан нь үнэн байдалд огт нийцэхгүй байна. дөрөвдүгээр Генрих шинэ гүүрнээсээ хэзээ ч гараагүй” гэж зарлахаар хатагтай зайлшгүй алдах болно гэлээ.

Тэгэхэд Люсьен хүйтнээр инээмсэглэв. Энэ ярианы үед огт анзааралгүй сууж байсан гүн нэг ч үг орхилгүй бөгөөд түүний хурц хараанаас гарын нарийн бичгийн даргын эвгүйрхсэн байдал мэдрэгдлээ.

Ингэж зовонгуйрсныг нь Альбер огт анзаараагүй байтал Люсьен явахаар боллоо. үнэхээр сэтгэл нь илтэд эвгүйрхэв бололтой. Гүн түүнийг гаргаж өгөхдөө хажуугийнхаа хүнд хэдэн үг дуулдахааргүй хэлэхэд нь цаадах нь ,

- Дуртайяа тэгье гүн минь, би зөвшөөрч байна гэж хариулав.

Гүн залуу Морсер дээр эргэж ирээд,

- Та эрхэм Деб°эгийн дэргэд хадам эхийнхээ тухай ингэж ярьж болохгүй гэж бодсонгүй юу? гэхэд,

- Гүн танаас энэ хадам гэдэг үгийг болоогүй байх д нь хэрэглэхгүй бахыг гуйя гэж Морсер хэллээ.

- Үнэндээ гүнгийн хатан энэ гэрлэлтийг тийм их эсэргүүцэж байгаа юм гэж үү?

- Тэгэхээр барах уу даа. хатагтай Данглар манайд маш цөөхөн ирдэг. Манай ээж тэднийд амьдралдаа хоёрхон л очсон байх. Ийм л байдаг юм даа.

- Тэгвэл би одоо тантай нуулгүй ярья. Эрхэм Данглар бол миний мөнгө байгаа банкны эзэн, эрхэм Вильфор бол аз тохиолдож тусалсны хариуд их л найрсаг байдаг юм. тийм ч учраас лав өчнөөн төчнөөн урилга зочилго болно гэдэгт найдаж байна. тэгэхээр би энэ бүгдийг тоомсорлохгүй байна гэж харагдахгүйн тулд , тэр ч байтугай би өөрөө санамж болохын тулд Отейль дахь байшиндаа Данглар ба Вильфорынхныг урья. Хэрвээ би таныг ээж аавын чинь адилаар энүүндээ уривал хуримын өмнөх уулзалт мэт болчих юм биш байгаа? Ялангуяа түшээ гүн Данглар охиноо дагуулж ирвэл, хатагтай Морсерт эвгүй санагдах юм биш биз? Тэгвэл намайг танай ээж үзэж чадахгүй болчих юм байна даа. би ингүүлэх тун ч дургүй байна. харин би бол хатагтай миний тухай сайн санаж байдгийг их л хүндэтгэж явдаг хүн гэж хэлэв.

- Гүн таныг ингэж илэн далангүй хэлсэн явдалд чи ихэд талархаж байна. тэгэхээр би таны цайллага дээр ирэхгүй байхыг зөвшөөрнө. Та манай ээжийн бодлыг хүндэтгэж байдаг гэж хэлсэн. Ээж ч танд сайнаар ханддаг юм гэж Морсер хариулахад,

- Та тэгж боддог уу? гэж гүн ихэд сонирхон асуулаа.

- Би үүнд итгэлтэй байна. таныг манайд очсоны дараа бид таны тухай бүтэн цаг ярьсан. Энэ ч яах вэ, ярандаа эргэж оръё. Та ээжийн тухай юу гэж боддогийг ээж мэдвэл их л баярлах байсан даа. харин түүнийг аав мэдвэл галзуурна даа.

Гүн инээд алдлаа, тэгээд Альберт ,

- Одоо та хэрэг байдлыг мэдэх боллоо. Бас ноён хатан Данглар ч намайг онцын хүмүүжилгүй хүн гэж шийтгүүлэх болно. Тэд та бид хоёрыг Парист хамгийн хуучин танил гэж хүмүүс мэддэг болохоор цайллаганд гарсан хүмүүс яагаад таныг уриагүй билээ гэж асуувал яана. Тэгэхээр тэднийг үнэмшэхүйц ямар нэгэн газар уригдан явлаа гэж надад бичгээр мэдэгдээрэй. Банкны эзэд зөвхөн бичиг баримтыг нотолгоо болгодгыг та мэднэ шүү дээ гэв.

- Үгүй гүн минь. Би өөр илүү сайн юм хийе. Манай ээж тэнгисийн агаар амьсгалах юмсан гээд байгаа юм гэж хэлээд – Та хэдийд цайлах юм бэ?

- Бямба гаригт

- Тэгвэл сайн хэрэг. Өнөөдөр чинь мягмар. Бид маргааш нөгөөдөр гэхэд треопорт байна. гүн та хүнд ямар нэг эвгүй байдал төрүүлчихгүйг хичээдэг тань их сайхан хэрэг байна.

- Үгүй та намайг хэтрүүлэж байна. би зүгээр л та нарт аятай байлгах гэсэн юм.

- Та урилгаа хэзээ тараачихсан бэ?

- Өнөөдөр.

- Их сайн хэрэг! би одоохон Дангларынд очиж ээж бид хоёр маргааш Парисаас явна гэж хэлье. Та бид хоёр дайралдаагүй, тэгэхСэр бид таны тэр цайллагын тухай мэдээ ч үгүй, тийм биз.

- Гэвч бодоорой. Таныг манайд байхыг чинь Дебрэ харсан шүү дээ.

- Өө нээрээ тийм л дээ.

- Тэгвэл яах вэ. таныг манайд ирэхэд чинь би урьсан боловч та ээжтэйгээ хамт Треопор орохоор явах учир ирж тун чадахгүй нь гэж нь зүрхнээсээ хариулсан байг л дээ.

- За тэгвэл ингэж шийдье. Харин та ээжийг явахаас өмнө уулзахгүй юу?

- Явахаас нь өмнө уулзана гэдэг нэлээн хэцүү хэрэг. түүнээс гадна би та нарын юмаа төхөөрөхөд чинь саад болно.

- За тэгвэл тааллаараа л бол. Тун гайхалтай хүн, бид таныг хүндэлж байдаг юм.

- Тэгвэл би улам талархагдахын тулд яах вэ?

- Яах вэ гэнээ?

- Тийм ээ би мэдэх юмсан гэж хүсэж байна.

- Та өнөөдөр салхин мэт чөлөөтэй байгаа. Тэгэхээр манайд очиж үдийн хоол зооглоё. Бид хэдүүлхэнээ, өөрөөр хэлцэл та, ээж, бид гурав. Та хатагтайг дөнгөж зэрвэс харсан, одоо түүнтэй ойрхон танилц. Гайхалтай хүн шүү. Ертөнц дээр түүнээс хориод дүү тийм нэг хүүхэн байдаггүйд нь би харамсдаг юм. хэрэв тийм байсан бол би мөдхөн хатагтай Морсероос гадна бэйсийн хатан Морсер гэгч авхай гарч ирэх байсан гэж батлан хэлнэ. Таныг очиход манай эцэг байхгүй байна. тэр өнөөдөр комиссын ажилтай болохоор тэнд үдийн хоол зооглоно. Явж аялал жуулчлалын тухай ярьцгаая. Та энэ орчлон ертөнцийг цөмий нь үзсэн хүн. Тэгэхээр өөртөө тохиолдож байсан учрал явдлын тухай, мөн шивэгчин хүүхэн гэдэг боловч хааны

гүнж шиг харьцдаг, тэр тантай цуг операа байсан, гоо үзэсгэлэнт албани хүүхнийхээ тухай ярьж өгөөч. бид Итали, Испани хэлээр яримз. Зөвшөөр л дөө та. Ээж танд их л тал рхах болно.

- Би танд машид талархаж байна гэж гүн хариулаад – Таны урилга надад таатай сайхан зүйл боловч авч чадахгүйдээ харамсаж байна. та намайг завтай гэж дэмий бодож байна. би нэгэн хүнтэй уулзах маш чухал хэрэгтэй гэв.

- Болгоомжлоорой та саяхан сэтгэлдээ таалагддаггүй цайллаганаас яаж мултран гарахыг зааж сургасан шүү. Надад нотолгоо хэрэгтэй. Харин би аз болоход Данглар шиг банкны эзэн биш боловч түү шигээр юманд итгэдэггүй хүн шүү.

- Тэгвэл би одоо танд нотолгоо өгье гэж гүн хэлээд хонхоо дуугаргав.

- Гэсэн ч гүн та манай ээжийнд үдийн хоол зооглохоос хоёр удаа татгалзаж байна шүү дээ. нэг л шалтгаан байна даа гэж Морсер хэллээ.

Тэгэхэд гүн цочин татвасхийв.

- Таныг арай ингэж бодоогүй байх гэж найдаж байна гэж гүн хэлснээ – Ашгүй миний нотолгоо ирж байна гэв.

Энэ үед Батистен орж ирээд үүдэнд зогслоо.

- Би таныг ирнэ гэж мэдээгүй байсан тийм биз?

- Юу гэх юм билээ. Та тийм ер бишийн хүн болохоор тэгсэн гэж хэлэх арга алга.

- Үгүй ээ л таныг үдийн хоолонд урина гэж мэдээгүй байсан биз дээ?

- Харин ч энэ үнэн шүү.

- За тэгвэл сайн хэрэг. батистен таныг би өглөө өрөөндөө дуудаж аваачаад юу гэж хэлсэн билээ?

- Гэгээн эзэн тан дээр таван цагаас хойш хэн ч ирсэн хүлээж авахгүй бай гэж хэлсэн.

- Тэгээд дараа нь юу гэлээ?

- Үгүй гүн минь...гэж Альбер хэлэн эхэлтэл

- Үгүй үгүй, ямар ч байлаа гэсэн бэйс минь миний тухай яриад байJaа тэр битүүлэг нэр алдраас салахыг хүсч байна. дандаа л Манфредыг дуурайж байх гэж яршигтай ажил. Би хүн бүртэй адил байхыг хүсдэг. За тэгээд дараа нь?...Батистен цааш нь яриарай гэж гүн хэлэв.

- Дараа нь зөвхөн эрхэм хошууч Бартоломео Кавалькантийг хүүтэй нь хат хүлээж ав гэсэн.

- Та дуулав уу? Италийн аль эртний удам судрын нэг хошууч Бартоломео Кавальканти... мөн тантай адил бэйс хэргэмтэй түүний хүү, таны хэр настай маш сайхан залуу ирнэ. Гарал удмы нь Данте өөрөө гаргаж байсан юм. Яагаа вэ, өнөө "Там"-ынх аравдугаар дуунд байдаггүй юу даа. та санаж байж ч болох юм. энэ залуу эцгийнхээ сая сая хөрөнгөөр дулдуйдан Парисын дээдсийн хүрээлэнд орж байгаа юм. хошууч өнөөдөр хүүгээ Италиар боло Континогоо над дээр авч ирнэ. Надад хүүгээ даалгаж өгч байгаа юм. хэрэв болохуйцаар хүн юм бол би түүнийг дэвшүүлэн оруулах юм. та надад тусална биз?

- Мэдээжийн хэрэг. тэгвэл тэр хошууч Кавальканти чинь таны хуучны танил найз уу?

- Огтхон ч үгүй. Энэ бол маш их нэр хүндтэй, даруу зантай юмны учрыг олохдоо сайн хүн байгаа юм. ийм хүн Италид олон л доо. Эртний удам угсааны улс байгаа юм. би хэдэн удаа түүнтэй Флоренц, Булонь, Луккэд дайралдсан юм. тэгээд наашаа ирнэ гэдгээ мэдэгдсэн байна лээ. Замын танилууд гэдэг чинь Ёх л шаардлагатай улс байдаг байна. тэд нэг удаа дайралдаад л боковсон хүний ёсоор аятайхан харьцчихвал хожим дандаа л тэгүүлж байх санаатай улс байдаг юм. эрхэмсэг хошууч Кавальканти эзэнт улсын үед Москвад очиж хөлдөж үхэх гэж явахдаа Парисаар нэг удаа дайрч өнгөрснөө одоо дахин ирж үзэхээр яваа юм. би түүнийг сайн хоолоор зочилно. Эр надад хүүгээ захиж орхиход нь би түүнийг харж , дураар нь дургилж байя гэж ам өгч хоцорно. Тэгээд өглөг авлагагүй олох юм.

- Маш сайн хэрэг. та үнэлж баршгүй халамжлан хүмүүжүүлэгч болно доо. За баяртай бид ням гаригт ирнэ. Ингэхэд би Францаас захидал авсан юм байна шүү гэхэд

- Уухай. Тэр Италид хуучин шигээ таатай сайхан байгаа юм байх даа гэж гүн асуув.

- Тийм л шиг байна._ харин таныг байхгүйд харамсаж байгаа юм байна. тэр таныг Ромын наран байсан. Одоо байхгүй болохоор нь бүдэг мэт болжээ гэсэн байна билээ. энэ лав бороо орж байна гэсэн үг биш байхаа.

- Таны найз миний тухай өөрөөр бодох болжээ гэсэн үг болж байна уу?

- Үгүй, харин таныг гайхамшгийн сонин хүн гэж баталсан хэвээр учир, таныг байхгүйд харамсаж байгаа юм байна.

- Тэр тэн аятайхан хүн билээ гэж гүн хэлээд – Түүнийг оройн хоол идчих санаатай анх дайралдаж манайд очиж хоол идсэн тэр оройноос эхлэн миний сэтгэлд таалагдсан юм. хэрвээ би андуураагүй бол тэр чинь генерал де Эпинегийн хүү байх аа? гэв.

- Яг тийм.

- Өнөөх мянга найман зуун арван таван онд муухайгаар алагдсан хүн сөн биз?

- Тийм ээ, бонапартынхан алчихсан юм.

- Тийм , тийм. Тэр надад ихэд таалагддаг. Харин түүнд эхнэр авч өгөх гээгүй байна уу?

- Тэр чинь Вильфорын охинтой суух гэж байгаа шүү дээ.

- Бүр шийдчихсэн юм уу?

- Миний мадмаузель Данглартай суух гэж байгаатай яг адил гэж Альбер инээ хэллээ.

- Танд инээдтэй байна аа?

- Тийм ээ

- Яагаад тэр билээ?

- Энэ гэрлэлтэд Дангларын охин бид хоёрын бие биедээ талтай байдаг шиг тийм хоёр талын талархал байгаа юм. үгүй, гүн та бид хоёр, хүүхнүүд харчуулын тухай ярьдаг шигээр хүүхнүүдийн тухай чалчиж байна аа даа. энэ ч уучламгүй хэрэг шүү гэж Альбер бослоо.

- Та бүр явах нь уу?

- Асуугаад яах вэ? Би танд яршиг болж бүтэн хоёр цаг суулаа. Тэгээд та явах нь уу? гэж асуудаг чинь надад их л сайхан хэрэг. үнэндээ та энэ хорвоо дээр хамгийн эелдэг хүн юм. бас тэгээд манай зарц нар ямар их сургуультай улс вэ! Ялангуяа Батистен. Би бол хэзээ ч тийм хүнтэй болж чадахгүй дээ. миний зарц нар бол францын театрт гардаг зарц нар шиг ёс болгосон улс байх юм. хэрвээ та Батистенээсээ салмаар санагдвал надад өгөөрэй.

- Тэгэмз.

- Байзаарай, бас болоогүй байна. тэр ирсэн даруу зантай синьор Кавалкантидаа миний мэндийг хүргээрэй. Хэрвээ хүүгээ хүнтэй суулгана гэвэл маш баян эхийнх нь талаас ч байсан хамаагүй маш дээд удамтай хүн олж өгөхийг бодоорой. Би танд энэ талаар тусална.

- Үнэхээр тийм болоод байгаа гэж үү?

- Тийм ээ.

- Тэгж ам өчиг өгч болохгүй. Юмыг яаж мэдэх вэ.

- Ай гүн минь гэж Морсер дуу алдаад- Та насад ямар их тус хүргэв ээ. хэрвээ би таны ачаар үгүйдээ л арван жил эхнэргүй явбал танд маш их баярлахсан гэхэд,

- Юм бүхэн боломжтой гэж гүн ноцтойхон хариуллаа.

Тэгээд Альбертай салах ёс гүйцэтгээд өрөөндөө орж ирж хонхоо гурвантаа дуугаргалаа.

Бертуччо орж ирлээ.

- Бертуччо би бямба гаригт Отейлдоо зочид хүлээж авна гэж хэлэхэд Бертуччо үл мэдэг давхийлээ.

- Сонслоо, гэгээ эзэн минь.

- Юм бүхнийг зохих ёсоор нь хийхэд та нада хэрэгтэй байна. тэр чинь сайхан байшин, үгүйдээ л сайхан болж болох байшин гэж гүн хэллээ.

- Үүний тулд гэгээн эзэн минь цөмийг нь өөрчлөх хэрэгтэй болно. Хань нь өнгө их муудчихсан байна билээ.

- Тэгвэл улаан бүсээр бүсэлсэн унтлагын өрөөнөөс бусдыг бүгдийг нь өөрчил л дөө. Унтлагын өрөөг яг тэр хэвээр нь үлдээгээрэй.

Бертуччо мэхийн ёсоллоо.

- Цэцэрлэгт огт гар бүү хүрээрэй. Харин хашаан доторхыг дуртайгаараа янзалж болно. Ер нь хашаа нь танигдахааргүй болбол надад сайхан л байна.

- Гэгээн эзэн таны сэтгэлд тааруулахын тулд бүхнийг хийе. Хайн гэгээн эзэн та надад хоолны талаар заавар өгвөл улам санаа зоволтгүй болж болох байна.

- Ингэхэд хүндэт Бертуччо та Парист ирснээсээ хойш нэг л биш болоод дав дув хийгээд байдаг болчхож. Та намайг ойлгохоо болчихлоо гэж үү?

- Гэгээн эзэн минь, үгүй ядахдаа хэн ирэхийг хэлж өгч болохсон болов уу?

- Би ч өөрөө мэдэхгүй байна. танд бол бүр мэдэхийн ч хэрэг алга. Луккул Луккулындээ л муол иднэ гэсэн үг. ингээд гүйцэS.

Бертуччо мэхийн ёслоод гарч одов.

XVII. Хошууч Кавальканти

Монте-Кристийг хоолонд урихад татгалзсаны шалтгаан болсон тэр хошуучийн тухай гүн ч Батистен ч худлаа хэлсэнгүй.

Бертуччо гүнгийн тушаалыг биелүүлэхээр Отейль уруу явснаас хоёр цагийн дараа буюу долоон цаг цохиход үүдэнд хөлсний тэрэг ирж зогсоод, Европод заншил болоогүй хар уяатай ногоон сюртук өмссөн тавь орчим насны хүнийг буулгаж орхиод ичсэн юм шиг даруй алга боллоо. Ирсэн хүн бас хөх цэмбэн өргөн шалбуур өмд, зузаан ултай түрийтэй гутал, өнгө нь муудсан боловч нэлээд шинээрээ савхин гутал, илгэн бээлий, цагдаагийн малгайтай адил бүрх малгай өмсөж, хэрвээ эзэн нь дуртайдаа зүүгээгүй бол төмөр хүзүүвч юм уу даа гэж хэлмээр цагаан судалтай хар зах зүүжээ. Ийм сонин янзын тэр хүн хаалганы хонх дуугаргаад, Елисейн талын 30 дугаар байшинд суудаг Монте-Кристо гүнийх мөн эсэхийг асуугаад, хаалгачаас тийм гэсэн баталсан хариу сонсмогц хаалгаар орж шат уруу явлаа.

Чухам ямаршуухан хүн ирхийг урьдчилан хэлүүлээд хүлээж байсан Батистен, түүнийг үүдний өрөөнд орж ирмэгц, жижиг гонзгой толгой, буурал үс, өтгөн цагаан сахлаар нь таньжээ. Ирсэн хүн шаламгай гэрийн даамалд нэр усаа хэлж амжаагүй байтал гүнд ирснийг нь мэдэгдэж амжжээ.

Харь газрын хүнийг хамгийн жирийн засалттай зочны өрөөнд орууллаа.

- Өө найрсаг хошууч морилон ирж ажаам уу. би таныг ирнэ гэж хүлээж байлаа гэж гүн хэлэхэд,

- Нээрээ юу? гэж ЛуккСэс ирсэн хүн асуугаад –Гэгээ эзэн та намайг хүлээж байв уу? гэж асуулаа.

- Тийм ээ, өнөөдөр долоон цагт таныг ирнэ гэж надад мэдэгдсэн юм.

- Миний танайд ирнэ гэдгийг ү? Мэдэгдсэн байсан гэнэ ээ?

- Яг тийм.

- Тэгвэл сайн байна. Үнэндээ би энэ болгоомжлолыг мартчихсан байх гэж айж байсан юм.

- Юуг тэр вэ?

- Танд урьдчилан хэлэхийг.

- Өөө үгүй шүү

- Та андуураагүй гэдэгтээ итгэлтэй байна уу?

- Итгэлтэй байна.

- Гэгээн ноён та өнөөдөр намайг долоон цагт намайг л ирнэ гэж хүлээж байв уу?

- Таныг л хүлээж л байлаа. Гэхдээ бас шалгаж үзэж болно л доо.

- Үгүй дээ, та намайг хүлээж байсан бол тэгэх хэрэггүй гэж Луккээс ирсэн хүн хэлэхэд,

- За яагаад тэр билээ гэж гүн зөрж асуулаа.

Тэгэхэд Луккээс ирсэн хүн бага зэрэг тэвдэх шиг боллоо.

- Үгүй та чинь бэйс Бартоломео Кавальканти мөн биз дээ? гэж гүн асуухад, Луккээс ирсэн хүн баярлан

- Дүрээрээ мөн байна гэж хэлэв.

- Австрийн армийн чөлөөнд гарсан хошууч биз?

- Би хошууч байсан гэж үү? Хэмээн хуучин цэрэг хулчгардуухан асуухад,
- Тийм ээ та хошууч байсан юм гэж гүн хэлээд – Таны Италид хэрэглэж байсан цол чинь францад болохоор хошууч болдог юм.
- За тийм болог. Надад бол аль нь ч хамаагүй л дээ гэхдээ гүн үргэлжлүүлэн,
- Ингэхэд та энд өөрийн дуоаар ирээгүй шүү дээ гэж хэллээ.
- Тэгэлгүй яах вэ.
- Таныг над уруу явуулсан биз дээ?
- Тийм ээ.
- Гэгээн ламтан Бузони явуулсан уу?
- Тийм ээ, тийм гэж хошууч баяртайгаар дуугарлаа.
- Та бас захидал авчирсан биз?
- Энэ байна.
- За харж байна уу тэр. Алив нааш нь өгөөдөх.

Тэгээд гүн захидлыг нь авч дугтуйг нь задлан уншлаа. Тэгэхэд хошууч нүдээ бүлтийлгэн гайхан харлаа. Тэр хүн тасалгаан доторхыг сонирхон харах боловч түүний хараа гэрийн эзэн дээр аргагүй л тусна.

- Тийм байх ёстой..."Хошууч Кавальканти бол флоренцийн Кавальканти удмын, Куккийн нэртэй язгууртан хүн, жилд хагас саяын орлоготой..." гэж гүн захидлыг гүйлгэн уншив.

Гүн захидлаас нүдээ салгаж мэхэсхийн ёсоллоо. Тэгээд,

- Хагас сая гэнэ ээ! Чөтгөр ав, эрхэм хүндэт Кавальканти гэж хэллээ.
- тэнд чинь хагас сая гэж байна уу? хэмээн Луккээс ирсэн өнөө хүн асуув.
- Цагаан дээр хараар бичсэн байна. тийм л байна даа. бузони ламтан европын томоохон хөрөнгөтэй улсыг хэнээс ч илүү мэднэ.
- За яах вэ, хагас сая болог. Харин би тийм их тоо бичнэ гэж санаагүй шүү гэж Луккээс ирсэн хүн хэллээ.
- Таны хэрэг хөтлөгч чинь л танаас хулгайлаад байдаг болохоор тэр байхгүй юу. одоо яая гэх вэ. та бид тийм үйлтэй улс хойно доо.
- Та миний нүдийг нээж өглөө. Тэгэхээр тэр бузар золигийг зайлуулах нь хэрэг болох нь ээ гэж Луккээс ирсэн хүнийг хэлэхэд, Монте-Кристо үргэлжлүүлэн,

“Түүний бүрэн аз жаргалтай байхад ганцхан зүйл дутаад байгаа юм” гэж уншлаа.

- Бурхан минь тийм шүү! Зөвхөн ганцхан юм! гэж Луккээс ирсэн хүн сүүрс алдан хэллээ.

- “Хайртай хүүгээ л олох”

- Хайртай хүүгээ!

- “Бага балчир байхад нь сайн сайхан гэр бүлийн дайсан эсвэл тэнэмэл цыганууд хулгайлан авсан хүүхэд” гэж гүн уншихад, Луккээс ирсэн хүн тэнгэр өөд харан хүндээр санаа алдан

- Эрхэм минь, тавхан настай байхад нь шүү! гэж дуугарлаа.

Тэгэхэд гүн,

- Хөөрхий золгүй эцэг! Гэж хэлээд цааш нь ...

- “Арван таван жилийн турш хий дэмий эрж байгаа хүүг нь олоход гүн таныг тусална гэж хэлснээрээ би түүнд итгэл найдвар, амьдралыг нь буцаан өгч байгаа юм” гэж уншлаа.

Луккээс ирсэн хүн сэтгэл нь зовсон байдалтай гүн өөд харахад,

- Би олж чадна аа гэж гүн хариу хэлэв.

Тэгэхэд хошууч нуруугаа эгцлээд,

- Аа, тэр захидал дотор бичсэн байсан зүйлүүд цөм үнэн үү? Гэж асуув.

- Эрхэм хүндэт Бартоломео та эргэлзэж байна гэж үү?

- Үгүй, үгүй, ганц ч минут үгүй. Яалаа гэж дээ. лам Бузони шиг тийм санваартан хүн тийм тоглоом хийх хүн биш. Гэвч гэгээнтэн та бүгдийг нь уншаагүй байгаа шүү дээ.

- Аа тийм. Бас нэмж бичсэн юм байгаа л даа гэж гүн хэлэхэд,

- Тийм ээ нэмж бичсэн юм бий гэж Луккээс ирсэн хүн давтан хэллээ.

- “Хошууч Кавалькантид төвөг удаж нэг банкнаас нөгөө банкинд мөнгө гуйвуулахгүйн тулд хоёр мянган франкийн чекийг замын зардалд зориулан өгч явууллаа. Бас та надад өгөх ёстой дөчин найман мянган франкийг түүн дээр нь нэмж өгнө биз”.

энэ нэмж бичсэн зүйлийг уншихад хошууч сэтгэл нь түгшсэн нь илт байлаа.

- Ийм байдаг байжээ гэж гүн хэлэхэд, Луккээс ирсэн хүн,

- Надад тэр хэлэхдээ... тэгэхээр гүн минь гэхэд,
- Юу тэгэхээр гэж? хэмээн асуулаа.
- Тэр нэмж бичсэн зүйл...
- Тэгээд яагаа вэ?
- Захидлын бусад зүйлтэй адил бас л сайнаар хүлээн авах болов уу?

- Мэдээжийн хэрэг. Бузони ламтан бид хоёр хоорондоо тооцоотой улс. Би түүнд чухам яг дөчин найман мянган франк өгөхийг сайн санахгүй байна. гэвч бид хоёрын хэн нэгний нь тал уруу хэдэн мянган франк илүү дутуу очих хамаагүй хэрэг. эрхэм Кавальканти та энэ нэмж бичсэн зүйлийг их чухалд бодоод байна аа даа?

- Үнэнээ хэлэхэд би ширээт ламын гарын үсэгт захидалд бүрэн итгээд илүү мөнгө авч гараагүй. Тэгэхээр энэ найдвар маань алдагдвал би гэдэг хүн Парист их л хүнд байдалд орох болоод байна.

- Тан шиг ийм хүн хүнд байдалд ордог юм гэж үү? Гэж гүн хэлэхэд, Луккээс ирсэн хүн,

- Хэрвээ хүн танихгүй бол...гэлээ.
- Харин таныг хүн бүхэн мэднэ шүү дээ.
- Тийм ээ намайг мэдсэн. Тэгэхээр
- За за эрхэм Кавальканти тан хэлэхийг сонсьё.
- Тэгэхээр та надад тэр дөчин найман мянган ливрийг өгөх үү?
- Таныг авъя гэж хэлсэн дор чинь өгнө.

Хошууч гайхсандаа нүдээ анивчив.

- Үгүй та суугаач. Би юу болж байгаагаа мэдсэнгүй. Таныг бүтэн мөч зогсоочихлоо гэж гүн хэлэв.

- Тэр яах вэ?

Тэгээд хошууч зөөлөн сандал ойртуулан суулаа.

- Дарс барихыг зөвшөөрнө үү? Херес, портвейн, аликантегийн алийг нь хүртэхсэн бол?

- хэрэв болох бол аликанте ууя. Энэ бол миний дуртай дарс байгаа юм.
- Надад бүр сайн нь бий. Бас зүсэм зөөлөн боов зооглох уу?

- Та өгөөд байгаа болохоор зүсмийг авъя.

Гүн хонхоо дуугаргахад Баттистен орж ирлээ. Гүн түүн өөд дөхөж,

- За юу болж байна? гэж аяархан асуухад даамал,

- Залуу хүү энд ирчихээд байгаа гэж сэм айлтгалаа.

- За сайн. Та түүнийг хаа оруулсан бэ?

- Гэгээн эзэн таны тушааснаар зочдын цэнхэр өрөөнд.

- Маш сайн нэг шил Аликанте, зөөлөн боов өгөөрэй.

Баттистен гарч одлоо.

- Эрхэмсэг танд ингэж их төвөг удаж байгаадаа би их зовж байна гэж Луккээс ирсэн хүн хэлэхэд,

- Үгүй үгүй яалаа гэж! гэж гүн хариулав.

Баттистен дарс хундага нарийн боов авч ирлээ.

Хүний нүүрний үрчлээ насыг нь тодорхойлдгийн адил дарсны насыг илтэд тодорхойлсон аалзны шүлс зэрэг янз бүрийн шинж тэмдгээр хучигдсан шилтэй дарснаа нэг хундагыг дүүргээд, нөгөөд нь хэдхэн дусал хийлээ.

Хошууч зөв сонгожээ. Тэр дүүрэн хундагатай дарс нарийн боовтой авлаа. Гүн тавиур дээрх зүйлийг зочны дэргэд тавихыг Баттистенд тушаалаа. Хошууч эхлээд дарсанд дүрж үзсэнээ сайшаасан дүр үзүүлээд, зөөлөн боовоо хундагатай дарсанд дүрлээ.

- Тэгэхээр эрхэм та Луккэд элбэг баян олондоо хүндтэй ер нь л жаргалтай хүнд шаардагдах бүх зүйлтэй байсан юм биз дээ?

- Тийм ээ бүх зүйл гэж хошууч хариулаад, зөөлөн боовоо үмхэж – Бүх зүйл бүрдсэн байсан юм гэж хэллээ.

- Харин бүрэн дүүрэн жаргалтай байхад чинь ганцхан л юм дутаад байна уу?

- Зөвхөн ганцхан л юм.

- Хүүгээ л олох л биз дээ? гэж гүнг асуухад, хүндэт хошууч хоёр дахь боовоо авч,

- Ай ганцхан энэ л дутаад байсан юм гэж хэлээд дээшээ тэнгэр өөд харж санаа алдах гэж оролдлоо.

- Эрхэм хүндэт кавальканти та одоо, тэр санаж уйтгарлаад байдаг хүү гэдгийнхээ тухай хэлж өгнө үү? Та чинь эхнэргүй гэж хэлсэн байх аа?

- Энэ бүхнийг хүмүүс зохиосон юм гээд – Би ч өөрөө... гэхэд гүн үргэлжлүүлэн,

- Та ч өөрөө ийм яриаг буруушаан эсэргүүцээгүй биз. хүнээс нуух гэсэн залуу насны нүгэл биз дээ? гэв.

Луккээс ирсэн хүн сандал дээрээ эгцрэн суугаад ихэд тайван намбалаг дүр үзүүлж, улам ч итгэлтэй байхын тулд ч юм уу эсвэл бодолдоо дэм болох гэсэн мэт харцаа буулгалаа. Тэгэхдээ бас уруул дээрх инээмсэглэл нь ердийн л нэг үгэнд дурлаж буйг нь илтгэсэн гүнг сэмхэн хяламхийнэ.

- Тийм ээ эрхэм ээ би нэн алдаагаа нуух гэсэн юм.

- Амиа бодсон юм биш биз дээ. эрчүүд ийм юмыг нэг их тоодоггүй.

- Мэдээж амиа бодсон юм биш гэж хошууч толгойгоо сэгсрэнгээ инээмсэглэн хэлэв.

- Тэр хүүгийн эхийг л бодоо биз дээ.

- Эхийг нь бодсон юм. хөөрхий эх хүнийг бодолгүй яах вэ гэж хэлэнгээ гурав дахь боовоо авлаа.

- Аль вэ эрхэм Кавальканти минь уугаач. Дотор чинь бачуурч байгаа гэж гүн хэлээд хундагыг нь дүүргэж өглөө.

- Хөөрхий эхийг нь бодсон юм гэж Луккээс ирсэн хүн гарахгүй байгаа нулимсыг хүчээр гаргах гэж хий дэмий л анивчина.

- Италийн дээр үеийн нэртэй удмын хүн байсан биз дээ?

- Феодалын удмын хүн дээ гүн минь.

- Нэр нь хэн билээ дээ?

- Та нэрийг нь мэдмээр байна уу?

- Тэнгэр хэлээд яах вэ, би мэдэх гэсэн юм.

- Гэгээнтэн та бүхнийг мэдэх юм даа хэмээн хошууч мэхэсхийн хэлэв.

- Оливе Корсинари, тийм биз?

- Тийм ээ, Олива Корсинари!

- Бэйсийн удамтан биз?

- Бэйс удамтай!

- Гэр бүл нь дургүйцээд байсан ч гэсэн та яаж ийгээд түүнтэй сууж чадсан юм аа.

- Эцэст нь арай гэж амжсан юм.

- Та бүх л шаардагдах баримт бичгүүдийн авчирсан уу? гэж гүн үргэлжлүүлэн асуухад Луккээс ирсэн хүн

- Ямар баримт бичгүүд? гэж асуулаа.

- Таны гэр бүлийн баталгаа, хүүгийн чинь төрсний гэрчилгээ бичиг.

- Хүүгийн гэрчилгээ бичиг ий?

- Таны хүү Андреа Кавалькантийн төрсний гэрчилгээ, Андреа гэдэггүй гэж үү?
Гэж Луккээс асуухад

- Тийм шиг санагдаж байна гэлээ.

- Тийм шиг санагдаж байна гэсэн чинь юу гэсэн үг вэ?

- Тэр хүү маш эрт алга болсон болохоор яг тийм гэж батлахад хэцүү байна.

- Таны хэлдэг зөв гэж гүн хэлээд – харин баримт бичгүүд нь танд байгаа биз дээ? гэж асуулаа.

- Гүн минь би ийм баримт бичиг хэрэг болно гэж мэдээгүй байсан болохоор авч гарсангүй гэдгээ хэлх хэрэгтэй байна.

- Чөтгөр ав! гэж гүн хэллээ.

- Тийм их хэрэгтэй юм гэж үү?

- Зайлшгүй хэрэгтэй!

Луккээс ирсэн хүн духаа маажлаа.

- А per Вассо зайлшгүй хэрэгтэй байдаг гэж хэлэв.

- Тэгэлгүй яах вэ, танай гэр бүл хууль ёсны мөн эсэх, хүү чинь хууль ёсоор төрсөн Ссэхэд гэнэт эргэлзвэл яана?

- Таны хэлдэг зөв. Тийм эргэлзээ гарч болох юм.

- Хэрэв ийм явдал гарвал танай хүүд маш эвгүй юм.

- Түүнд бүр сүрхий цохилт болно доо.

- Энүүнээсээ болоод сайн сайхан хүүхнийг ч алдаж болох юм.

- Харамсалтай яа.

- Францад энэ явдлыг хатуугаар үздэг юм. энд Италид байдаг шиг ламд очоод л “Бид хоёр бие биедээ дуртай, бид хоёрыг гэрлүүлж өгөөч” гэж хэлбэл болдог юм биш. Францад иргэний гэр бүл болох ёсыг тогтоосон, гэр бүл болоход хүмүүсийн хувийн байдлын магадлагаа баримт бичгүүд хэрэгтэй болдог юм.

- Надад ийм баримт бичгүүд байхгүй нь гай байна даа.

- Харин надад байгаа нь сайн хэрэг боллоо гэж гүн хэллээ.

- Танд уу?

- Тийм ээ.

- Одоо танд байна уу?

- Байна.

Баримт бичиг байхгүй нь, ийм хол явж ирсний ямар ч утгагүй болгож дөчин найман мянган франкаа алдчих бий гэж айсан хошууч,

- Энэ ч ёстой үнэхээр аз завшаантай хэрэг байна даа. тийм ээ үнэхээр их азтай хэрэг байна. би энэ тухай огт бодоогүй юм шүү гэлээ.

- Тийм ээ таны хэлдэгт үнэмшиж байна. юм бүхний тухай бодохын аргагүй. Харин таны аз болоход Бузони лам энэ тухай боджээ.

- Ямар их ачтай лам бэ?

- Хашир хүн дээ.

- Гайхалтай сайн хүн юм гэж Луккээс ирсэн хүн хэлээд – Тэр танд тэдгээрийг ирүүлээ юу? гэж асуулаа.

- Энэ байна.

Луккээс ирсэн хүн баясан шагёирсны тэмдэг болгож залбирлаа.

- Та чинь Монте-Каттини дахь гэгээн Павлийн сүмд Олива Корсинаритай гэрлэх ёс гүйцэтгэсэн юм аа. ламын өгсөн баримт энэ байна.

- Нээрээ тийм байна гэж хошууч хэлээд бичиг цаасыг гайхан харлаа.

- Энэ бас Саравеццед байхад чинь Андреа Кавалькантид загалмай зүүлгэсний гэрчилгээ байна.

- Цөм зохих ёсоороо байна гэж хошууч хэлэв.

- Тэгвэл эднийгээ та ав. Надад хэрэггүй. Хүүдээ өг, тэр чинь хадгалж байх болно.

- Үгүй ингэхэд... тэр хаячихвал...
- Нээрээ хаячихвал яана гэж гүн асуухад Луккээс ирсэн хүн,
- Тийш нь л бичих хэрэг болно. Шинэ нь их л удаж ирэх байх даа гэв.
- Тийм ээ их хэцүү юм болно гэж гүн хэлэхэд,
- Бараг бололцоогүй хэрэг гэж Луккээс ирсэн хүн хариуллаа.
- Та энэ баримт бичгүүдийн үнэ цэнийг ойлгож байгаа явдалд би их баярлаж байна.
- Энэ баримт бичгүүд ер нь үнэлж баршгүй гэж би бодож байна.
- Одоо залуу хүүгийн эхийн тухайд гэж гүн хэлэхэд,
- Залуу хүүгийн эхийн тухайд ...гэж хошууч зовсон байдалтай давтан хэлэв.
- Хатагтай Корсинарийн тухайд гэвэл гэж гүнг хэлэхэд, шинэ шинэ саад хөлд нь босож ирсэн хошууч,
- Бурхан минь! Тэр хүүхэн хэрэг болно гэж үү?
- Үгүй, тэгэхдээ тэр хүүхэн чинь...
- Тийм ээ тийм, тэр хүүхэн...
- Бурхан болсон...
- Тийм ээ тэгсэн юм гэж Луккээс ирсэн хүн тосон авч хэлэхэд,
- Би мэднэ ээ үхээд арваад жил болж байгаа гэж гүн хариуллаа.
- Би одоо ч гэсэн харамсаж уйлж суудаг юм гэж Луккээс ирсэн хүн хэлээд хармаанаасаа дөрвөлжин судалтай алчуур гаргаж ирээд эхлээд зүүн нүдээ, дараа нь баруун нүдээ арчлаа.
- Одоо яая гэх вэ. бид цөм үхэх тавилантайгаас хойш. Та одоо хүүтэйгээ арван таван жил уулзаагүй гэж энд Францад ярих хэрэггүй. Энд хүүхэд хулгайлдаг цыгануудын тухай сонирхохоо больчихсон юм. хүү минь хөдөөгийн тосгонд хүмүүжсэн учир одоо түүнийгээ Парист хүмүүжүүлэн сургах гэж авчирсан юм. Үүний тулд л эхнэрээ үхсэнээс хойш сууж байсан Виа-Реджог орхин гарсан гэж хэлбэл болно. Энэ л хүрэлцээтэй болно.
- Та тэгж бодож байна уу?
- Тийм ээ.
- Тэгвэл сайн хэрэг байна.

- Хүүхдийг танаас удаан салгасан тухай яриа хаа нэгэн газраас гарвал...
- Тэгвэл би юу гэж хэлэх вэ?
- Танай гэр бүлийн дайсанд худалдагдсан үл бүтэх хүмүүжүүлэгч...
- Корсинарийн уу?
- Тийм ээ... Таны төрөл удам угсааг таслах гэж хүүхдийг хулгайлж авсан хэрэг болог.
- Тийм ээ, нээрээ ганц хүү минь юмсан.
- Одоо та бид хоёр бүх зүйлийн тухай ярьж тохироод, таны санаанд мартагдсан зүйлүүд чинь ор, гэнэ алдахааргүй болсон хойно, би танд нэг сонин сайхан юм бэлтгэснийг тааварлан мэдэж байгаа биз дээ?
- Сайхан зүйл үү?
- Эцэг хүний нүд зүрхийг хуурч болохгүй гэж би бодож байна.
- Үгүй ер гэж хошууч амандаа бувтналаа.
- Түүнийг энд байгаа гэж хэн нэгэн хүн танд үг алдчихав уу, эсвэл та таав уу?
- Хэн энд байгаа юм бэ?
- Танай хүүхэд, таны хүү, таны Андреа.
- Би таасан юм. тэр энд байгаа юм уу? хэмээн Луккээс ирсэн хүн хээвнэг асуув.
- Энд зэргэлдээ тасалгаанд байгаа. Гэрийн даамал орж ирэхдСэ хэлсэн гэж гүн хэлэхэд,
- Маш сайн, маш сайн! Гэж хошууч хэлэн хөдлөх бүртээ мажар цамцныхаа эснэгийг засна.
- Эрхэм хүндэт Кавальканти гэж гүн хэлээд- Таны сэтгэл хөдөлж байгаа явдал надад ойлгомжтой байна. танд амсхийх цаг өгөх хэрэгтэй. Бас түүнээс гадна мөн л тан шиг тэсвэрлэн ядан хүлээж байгаа залуу хүнийг энэ уулзалтад бэлтгэх хэрэгтэй байна.
- Тийм гэдэгт эргэлзэхгүй байна.
- Нэг мөч хиртэй болоод бид хүрч ирнэ.
- Та түүнийг над уруу авчрах нь уу? Та өөрөө түүнийг надтай танилцуулж өгнө гэдэг чинь ямар сайн хэрэг вэ?

- үгүй, би эцэг хүү хоёрын хооронд орохыг хүсэхгүй байна. гэвч санаа бүү зов. Яс махны тасархай дуу гардаггүй юмаа гэхэд таны сэтгэл зүрх андуурна гэж байхгүй. Тэр энэ хаалгаар орж ирнэ. Тэр бол цайвар, дэндүү цайвар үстэй гэж болохоор аятайхан зантай цэвэрхэн сайхан залуу бий. Та өөрөө харна даа.

- Бм сайн санаат ламаас авсан хоёр мянган франкаас өөр мөнгө авч гараагүй. Хагасы нь бас замдаа зарчихсан. Тэгээд... гэж хошууч хэлтэл,

- Тэгээд танд мөнгө хэрэгтэй. Эрхэм хүндэт Кавальканта, энэ бол зүй ёсны хэрэг. май танд энэ тэгш тоотой болгон найман мянган франкийн дэвсгэрт өгье.

Хошуучийн нүд нь сэргэн гялалзлаа.

- Тэгэхээр бас дөчин мянгыг өгөх үлдэж байгаа биз гэж гүнг хэлэхэд,

- Гэгээнтэн та гарын үсэг авах уу? гэ! хошууч асуугаад мөнгөө дотор талын хармаандаа хийлээ.

- Яах юм бэ? гэж гүн хэллээ.

- Бузони ламтан тооцоо хийхэд баримт болог « доо.

- Та үлдсэн дөчин мянгыгаа аваад надад бөөнд нь гарын үсгээ өгөөрэй. Үнэнч хүмүүсийн дунд ийм болгоомжлол илүү байдаг юм.

- Тийм ээ, үнэнч хүмүүсийн хооронд гэж хошууч хэлэв.

- Бас нэг үг хэлье бэйс.

- Сонсоход бэлэн байна.

- Багахан зөвлөгөө өгөхийг зөвшөөрнө үү?

- Тэгэлгүй яах вэ хэлээч.

- Та энэ сюртукээсээ салбал муугүй л баймаар юм.

- Үнэхээр үү? гэж хошууч асуугаад хангалуун байдлаар хувцас руугаа харлаа.

- Тийм ээ, ийм хувцсыг Виа-Репжоп өмсөхөөс биш хэдий сайхан ч гэсэн Парист сонирхохоо болчихсон юм.

- Энэ чинь л эгдүүтэй хэрэг байна даа гэж Луккээс ирсэн хүн хэллээ.

- Үгүй, энэ хувцсандаа тийм их дуртай юм бол эндээс явахдаа өмсөхгүй юу?

- Тэгээд би юу өмсөх вэ?

- Чемодан дотроо байгаа юмыг л өмс.

- Юун чемодан гэж, би зөвхөн замын хүүдий л авч гарсан.

- Өөрөө ч тийм юм авч явалгүй яах вэ. Илүү юм тээж явах хэрэг юу байна? Тэгээд ч бас хашир цэрэг хөнгөн шингэн явах дуртай.

- Тэгээд л би...

- Гэвч та хашир хүн болохоороо юмаа урьдаар явуулчихсан байх шиг билээ. та өөртөө байр захисан Ришелье гудамжны Жононгууд зочид буудалд өчигдөр ирсэн байна билээ.

- Тэгвэл чемоданд...

- Таны хиа хэрэгтэй юм бүхнийг чинь хийсэн байх гэж бодож байна. энгийн хувцас, цэргийн ёслолын хувцас байгаа байлгүй. Онцлог баярын үеэр цэрэг хувцсаа өмсөөрэй. Их сэтгэлдэл төрүүлнэ дээ. одонгоо зүүхэдS мартавзай. Францад одон тэмдгийг шоолж инээлдсээр байдаг ч зүүсээр байгаа юм.

- За за маш сайхан хэрэг. Маш сайн байна гэж хошууч улам гайхан хэллээ.

- Аа одоо зүрх чинь жаахан чангарсан болохоор эрхэм Кавальканти та, хүү Андреатайгаа уулзахад бэлтгэ гэж гүн хэлэв.

Тэгээд гүн сэтгэл нь хөдөлсөн хошууч өөд ёслоод хөшигний цаагуур явж алга боллоо.

XVIII. Андреа Кавальканти

Батистены цэнхэр гэж нэрлэсэн зочны өрөөнд гүн орж ирлээ. Тэнд түүний нэлээд сайхан хувцастай залуу хүлээж байсан бөгөөд хагас цагийн өмнө хөлсний сүйх тэргээр энд иржээ.

Батистен түүнийг амархан таньжээ. Тэр бол эзний нь хэлж өгснөөр цайвар шар үстэй, эрүүндээ шаравтар сахалтай, хар нүдтэй гялалзсан цагаан царайтай залуу байлаа. Гүнг зочдын өрөөнд орж ирэхэд залуу хүү өргөн зөөлөн сандал дээр хайхрамжгүй янзтай халхайн сууж, алтан бариултай таягаараа гутлаа товшин байлаа.

Залуу гүнг орж ирж явааг харан яаран бослоо.

- Монте-Кристо гүн үү? гэж асуухад,

- Тийм ээ гэж гүн хэлээд- Би бэйс Андреа Кавалкантитай ярих завшаан тохиож байгаа нь энэ үү? гэж хэллээ.

- Бэйс Андреа Кавалькантитай гэж залуу хүү чөлөөтэйгээр мэхийн хэлэхэд,

- Надад хаягласан захидал танд байгаа биз?

- Би гарын үсэгнээс нь болоод тэрүүний тухай танд хэлээгүй юм. гарын үсэг нь надад нэлээн хачин санагдсан.

- Синдбад-Далайчин гэж байна уу?

- Яг тиэм, “Мянга нэгэн шөнийн үлгэр”-т гардаг Синдбад далайчнаас өөр хүн сонсоогүй болохоор...

- Тэр чинь түүний удам угсааны нэг, англи хүн, ёстой өвөрмөц зантай солиотой шахуу хүн байгаа юм. жинхэнэ нэр нь Лорд Уилмор гэдэг.

- Одоо надад цөм ойлгомжтой боллоо.

- Тэгвэл бүх зүйл ёсоор боллоо. Их сайн. Тэр чинь надтай танилцсан нөгөө англи, их сайн гэж Андреа хэлснээ – Гүн танд үйлчилэхэд бэлэн байна гэлээ.

- Хэрвээ танаас сонсох гэж байгаа зүйл үнэн мөнд тохирвол гэж хэлснээ гүн инээмсэглээд – Та өөрийнхөө болоод эцэг хийнхээ тухай зарим нэг зүйлийг тодорхой ярьж өгөх хэрэг болох байх гэж найдаж байна гэхэд, залуу хүү юм мартдаггүй байдлыг нь харуулсан хөнгөн шалмаг байдлаар,

- Дуртайяа хэлье, гүн минь. Би бол таны хэлсэн бэйс Андреа Кавальканти мөн. Флоренцийн алтан дэвтэрт бичигдсэн тэрхүү Кавалькантин удмын хошууч Бертоломео Кавалькантийн хүү. Манай гэр бүл одоо хүртэл баян хэвээр байгаа, эцэг маань жилд хагас саяын орлоготой, гэхдээ олон золгүй явдлыг үзсэн хүн. Намайг тав зургаан настай байхад минь өөдгүй хүмүүжүүлэгч хулгайлан авч, бүтэн арван таван жил эцэг эхтэйгээ уулзаагүй явна. Би насанд хүрч өөрөө өөрийгөө мэдэх болсноос хойш түүнийг эрж байгаа боловч эрэл маань талаар өнгөрч байгаа юм. харин таны найз Синдбадын захидал түүнийг Парист байгааг мэдэгдэж, түүний тухай танаас сураг чимээ сонсохыг зөвшөөрсөн байна билээ.

Гүн цаанаа нэг зэвүүн цэвэрхэн царайтай сайхь залуу хүнийг төдий л таашаахгүй авч сэтгэл ханасан шинжтэй хаагаад,

- Үнэхээр таны хэлж байгаа зүйлүүд маш сонирхолтой юм байна. та миний найз Синдбадын үгэнд ордог чинь сайн болж. Эцэг тань энд таныг хайгаад ирээд байж байгаа.

Гүн орж ирсэн минуутаасаа эхлэн хүүгээс нүд салгалгүй ширтэж түүний итгэлтэй харц шийдмэг дууг сонсоод бахдан байлаа. “Эцэг тань энд таныг хайж ирээд байгаа” гэдэг ердийн үгийг сонсоод Андреа давхийн огло үсэрч,

- Эцэг минь, эцэг минь энд байгаа юм уу? гэж дуу алдлаа.

- Тэгэлгүй яах вэ гэж гүн хэлээд – Таны эцэг хошууч Бартоломео Кавальканти гэж хэлээ.

Залуу хүүгийн царайд тодорсон айсан шинж дорхноо алга боллоо.

- Тийм ээ хошууч Бартоломео Кавальканти. Тэгэхээр гүн та эцгийг минь энд байгаа гэж хэлэв үү?

- Тийм ээ эрхэм минь. Түүгээр ч барахгүй би дөнгөж сая түүнтэй ярьж байгаад ирлээ. Аль хэдийн алдсан хайртай хүүгийнхээ тухай ярьсан нь миний сэтгэлийг их хөдөлгөлөө. Түүний зовлон зүдүүр, найдлага горьдлого нь үнэхээр сэтгэл хөдлөм, бараг бичсэн ч болохоор байлаа. Тэгээд нэг өдөр түүнийг хүүг хулгайлсан хүмүүс хүүг нь нэлээн их мөнгөөр эргүүлж өгөх эсвэл хаана байгааг нь хэлж өгнө гэжээ. Хайртай эцгийг нь юу ч зогсоож чадсангүй. Тэгээд зохих шаардагдсан мөнгийг нь пьомонтын хил рүү Италид очих паспортын хамт явуулжээ. Та тэр үед Францын өмнөд хязгаарт байсан байх аа?

- Тийм ээ, гүн гэж Андреа бага зэрэг зовсон байдалтайгаар хэлээд – Тийм ээ би францын өмнөд хязгаарт байсан гэлээ.

- Таныг Ниццэд ±үйх тэрэг хүлээж байх ёстой байсан биз?

- Яг үнэн. Тэр сүйх тэрэг намайг Ниццээс Гэнуяд, Гэнуягаас Туринд, Туринаас Шамберид, Шамберигаас Пон-де-Бовуизенд, Түүнээс Парист хүхгэж өгсөн юм.

- Маш сайн хэрэг. танд ийм тийм зам тогтоож өгсөн явдал бол тантай дайралдах магадгүй гэж таны замаар өөрөө явсан хэрэг байж.

- Ингэхэд хайрт эцэг минь надтай замд таарлаа ч гэсэн танихгүй байх байсан байлгүй. Бид бие биенээ алдсанаас хойш би нэлээд өөр болсон.

- Яс махны тасархай гэдэг юм байгаа шүү дээ! гэхэд

- Тийм ээ үнэн гэж залуу хүү хариулаад- Би энэ тухай бодсонгүй шүү гэлээ.

- Та түүнээс хол байхдаа чухам юу хийж явсан бол гэдэг ганц зүйл Кавалькантийн санааг зовоож байна гэж гүн хэлээд – Таныг боолчлон байсан хүмүүс тантай яаж харьцаж байв? Таны удамт шаардагдах тэр хүндэтгэлтэй харьцаагаар танд хандаж байв уу? Бие махбодоосоо илүү сэтгэл санаагаар зовсны үр уршгаар, байгалиас заяагдсан ур чадвар чинь өөрчлөгдөөгүй байгаа? Тэрхүү эзэлбэл зохих өндөр байр сууриа эзлэх чадвартай байна гэж үзэж байна уу? гэхэд залуу хүн сандарсан байдалтайгаар,

- Ямар ч худлаа гүтгэлэг ... гэж бувтналаа.

- Хаанаас даа. би таны тухай анх удаа энэрэн тэтгэгч найз Уилмороосоо сонссон юм. тэр таныг их л хүнд байдлаас олсон юм гэнэ лээ. Чухам ямар байдалд байсныг нь би мэдэхгүй. Би тийм их сониуч хүн биш болохоор асуугаагүй юм. тэр

танд анхаарал тавьсан болохоор лав л сайн талтай байж таарна. Тэр тань эзэлбэл зохих байр суурийг чинь эзлүүлж эцгийг тань олж өгнө гэж байсан. Тэгээд эрж эхэлсэн бололтой. Эцэг чинь энд ирсэн байхыг бодоход олж л дээ. харин өчигдөр тэр надад таныг ирсэн тухай мэдэгдээд хөрөнгө хогшлын тань талаар надад заавар өгсөн юм. тэгээд ч миний найз Уилмор их өвөрмөц зантай, үнэнч шударга, хоосрохын зовлонгүйгээр зарцуулах баян тарган хүн учраас би түүний зааврыг дагасан юм. одоо танаас миний асуух юманд бүү гомдоорой гэж гуйя. Би таныг бага зэрэг халамжлах ёстой хүн болохоор нэг зүйлийг асууя. Та өөрийнхөө буруугаас биш орсон тэр золгүй байдал чинь таны эзэлбэл зохих тэр байр суурь бүхий нийгмээс таныг хөндийрүүлчихсэн юм биш биз?

- Энэ талаар та огтхон ч сэтгэл бүү зов. Намайг хулгайлсан хүмүүс хожим нь намайг зохих зиндаанд нь зарах гэж бодож байлаа. Үнэхээр ч тэгсэн юм. тэд надаас илүү их үнэ олох гэж бодоод миний үнийг багас гэхгүй харин улам үнэд хүргэхийг хүсэж байсан юм. Ийм учраас намайг хулгайлж авсан хүмүүс бага азийн боолын эзэд боолуудтайгаа яаж харьцаж, тэднийг үнэ хүргэж зарахын тулд эрдэмтэд, гүн ухаантан, эмч нар болгож байсны адилаар би багагүй боловсрол олж авсан гэж залуу хүү хариулав.

Монте-Кристо сэтгэл хангалуун байдалтай инээмсэглэв. Андреа Кавалькантигаас ийм үг гарна гэж бодоогүй байсан бололтой.

- Хэрвээ миний хүмүүжилд, дээдсийн хүрээлэнгийн заншлын талаар ямар нэг дутагдалтай зүйл гарвал хүүхэд ба идэр насанд минь тохиолдсон зүдүүрийг анхаарч уучлан үзэх байх гэж би найдаж байна гэж Андреа үргэлжүүлэн ярихад гүн хайхрамжгүйгээр,

- За яах вэ, дураараа л бол. Энэ бол таны хувийн хэрэг бөгөөд зөвхөн танд л хамаатай юм. харин би л таны оронд байсан бол энэ мэт явдлуудын тухай ганц ч үг дуугарахгүй байх сан. Таны амьдралд бол роман зохиолтой адил юм. харин шар хавтастай романыг сонирхогч гэдэг чинь, таных шиг алтадсан бүрхүүлтэй байлаа ч, жинхэнэ амьдралын нэхсэн үйл явдалд итгэлгүйгээр ханддаг юм. Бэйс танд энэ төвөгтэй байдлыг сануулж, хэлж өгөх гэсэн юм. та өөрийнхөө сэтгэл хөдлөм түүхийг нэг хүнд ярьж дуусаагүй байхад чинь бүх Парис даяар шал ондоогоор тархан яригдаж амжина. Тэгэхээр та Антони шиг дүр үзүүлэхэд хүрнэ. Гэтэл тийм Антоний үе өнгөрсөн. Та зарим нэг хүмүүжлийн сонирхлыг төрүүлж энэ явдал танд зарим нэг талаар амжилтыг олгох боловч хов ярианы сэдэв болж байх гэдэг тийм таатай биш. Энэ танд залхуутай санагдаж мэднэ.

- Гүн таны хэлдэг зөв гэж би бодож байна гэж Андреа Монте-Кристогийн ширтэх харцанд өөрийн эрхгүй царай нь зэвхийрэн хэлээд – Энэ ч сүрхий эвгүй явдал болно доо гэж хэллээ.

- Гэвч бас хэтүүлж болохгүй. Алдаанаасаа зайлах гээд тэнэг явдал гаргаж болно. Ер нь л биеэ бодолтой авч явах хэрэгтэй. Тан шиг ийм ухаалаг хүнд амархан болох хэрэг. өнгөрсөн үедээ байгаа бүдэг бүрий зүйл бүхнийг баримт нотолгоо, найз нөхдийнхөө гэрчилгээгээр няцаах хэрэгтэй гэж гүн хэллээ.

Андреа илт сэтгэл зовсон бололтой байв.

- Би таныг дуртайяа дааж авах сан, гэвч би сайн найз нартаа ч гэсэн эргэлздэг заншилтай, ер нь ямар нэг юманд эргэлзэх сэтгэл төрөөд байдаг юм. тийм учраас би ямар нэг юманд гоочлогдохгүй явах нь тун ч илүү ажил гэж боддог юм гэж гүн хэлэхэд Андреа,

- Гэлээ ч гэсэн намайг танд явуулсан лорд Уилморыг хүндэтгээд... гэж хэлтэл гүн,

- Тийм ээ, мэдээж хэрэг. гэвч лорд Уилмор таныг залуу насаа нэлээд хөдөлгөөнтэй өнгөрөөсөн гэдгийг надаас нуугаагүй юм шүү гэж хэлээд, Андреагийн хөдөлгөөнийг ажиглан харж - Үгүй, үгүй би таныг нүглээ наманчил гэж шаардахгүй. Харин таныг ямар ч дутагдал гачигдалгүй л байгаасай гэж Луккээс эцгийг чинь дуудаж ирүүлсэн юм. та одоо түүнтэйгээ уулзана. Тэр жаахан хүйтэвтэр хөшүүн байж мэднэ. Энэ бол цэрэг хувцаснаасаа болоод тэгж байгаа хэрэг. тэгэхээр түүнийг австрийн армид арван найман жил алба хааж байгааг нь дуулахаар зэмлэх хэрэггүй болно. Бид ер нь австрийнхнаас элдвийг шаарддаггүй юм. харин эцгийн хувьд гэвэл тохитой байрын хүн шүү гэж хэллээ.

- Гүн та намайг тайтгаруулж байна. би түүнээс хагацаад их удаж байгаа болохоор ямар хүн байсны нь огт санахгүй байна.

- Түүнээс гадна ихээхэн хөрөнгө гэдэг чинь олон юмыг нааштайгаар харахад хүргэдэг юм.

- Тэгвэл миний эцэг үнэхээр тийм баян хүн үү?

- Саятан... Жилд таван зуун мянган ливрийн орлоготой.

- Тэгвэл миний байдал овоо... аятайхан байх нь ээ гэж залуу хүн горьдсон янзтай асуулаа.

- Үлэмж аятайхан болно, хүндэт нөхөр минь. Тэр таныг Парист суух бүх хугацаанд чинь жилд тавин мянган ливр өгнө гэсэн.

- Тэгвэл би энд үргэлж суунаа.

- Үгүй ер! Хүндэт бэйс, хожим юу болохыг хэн мэдэх билээ? Хүн хүсэн бодоход, бурхан түүнийг нь шийдвэрлэж өгнө.

Андреа санаа алдлаа.

- Гэхдээ ямар ч байсан намайг Парист байх хугацаанд ... эндээс нөхцөл байдлаас болоод явтал минь таны хэлсэн тэр мөнгөө надад олдох юм байгаа биз дээ гэж залуу асуулаа.

- Тэгэлгүй яах вэ.

- Миний эцэг өгөх үү? гэж Андреа санаа зовсон байдалтай лавлан асуулаа.

- Тийм ээ, гэхдээ лорд Уилморын баталгаагаар, таны эцгийн хүсэлтээр Парисын баян банкнуудын нэг болох эрхэм Дангларын банканд сар бүр таван мянган франк авах зээллэг нээсэн.

- Миний эцэг Парист удах юм болов уу?

- Хэдхэн хононо. Албаа хоёр гурван долоо хоногоос илүү орхиж болохгүй.

Тэгэхэд удахгүй явах нь гэж баярласан Андреа,

- Ай хайрт эцэг минь! гэж дууга^oлаа.

Гүн яагаад баярласныг нь ойлгоогүй дүр үзүүлэн,

- Тийм ч у-раас та хоёрын уулзах цагийг нэг ч болов минутаар хойшлуулахыг хүсэхгүй байна. та эрхэм хүндэт Кавалькантийг тэврэн уулзахад бэлэн байна уу?

- Та үүнд эргэлзэхгүй байх гэж найдаж байна.

- За тэгвэл энэ зочдын өрөөнд ор. Тэнд таны эцэг чинь хүлээж байгаа.

Андреа гүн өөд мэхийн ёслоод зочдын өрөөнд орлоо.

Гүн түүний хойноос харж байснаа цаашаа явж одохоор нь хананд хадаастай байсан нэгэн зурагны цаана далдлагдсан байсан пүршийг дарахад зураг нь жаазнаасаа хөдлөн цаад талын зочдын өрөөнд юу болж байгааг харах завсар нээгдлээ.

Андрей хаалгаа хаачхаад түүний хөлийн чимээгээр боссон хошууч өөд очиж,

- Ай хайрт эцэг минь гэж Андреа хаалттай байгаа хаалганы цаана дуулдахаар хэлээд – Та мөн үү? гэж асуулаа.

- Сайн байна уу, хонгор хүү минь гэж хошууч хэлэв.

Тэгэхэд Андреа хаалга өөд хараад,

- Ийм удаан уулзаагүй байж дахин уулзана гэдэг ямар аз завшаан бэ?
- Нээрээ удаан уулзсангүй шүү.
- Тэврэлдые гэж Андреа хэлэхэд,
- Тэгье хүү минь гэлээ.

Тэгээд тэр хоёр францын театрт гардаг жүжиг дээр үнсэлддэг шиг хацраа наалдууллаа.

- Одоо бид хоёр ахиад л хамт байх боллоо гэж Андреа хэлэхэд,
- Бид хоёр дахиад л хамт байна гэж хошууч давтан хэлэв.
- Хэзээ ч дахин хагацахгүйн тулд биз, тийм ээ?
- Үгүй хайрт хүү минь, франц нутаг чиний хоёр дахь төрсөн гэр болжээ.
- Үнэнээ хэлэхэд тийм. Парисаас явахад надад үнэхээр гунигтай байх болно.

- Аа би бол Луккээс хол сууж чадахгүй. Тиймээс бололцоо гармагц л Итали руугаа явна.

- Хайрт эцэг минь, явахаасаа өмнө надад гарал үүслийг минь батлах баримт бичгүүдийг өгч чадна биз дээ?

- Тэгэлгүй яах вэ, би тэгэх гэж л ирсэн юм. таныг олох гэж хэчнээн их хүч гаргав аа, дахиж хоёр дахиа ингэж явна гэж бодохын ч хэрэг алга. Хэрэв ингэж явбал амьдралын минь сүүлийн жилүүд барагдаж дуусах болно.

- Тэр баримт бичгүүд тэгээд...

- Энд байна.

Андреа эцгийнхээ гэрлэсэн баталгаа, төрсний гэрчилгээг шүүрэн авч, ихэд тэсэж ядсан байдлаар хоёр бичгийг багагүй туршлагатайг нь гэрчлэх түргэн харцаар гүйлгэн уншлаа.

Уншиж дуусаад царай нь хэлж барашгүй баяртайгаар гэрэлтэж хошууч өөд харан,

- Уухай ийм байдаг байж гэж цэвэр тоскань хэлээр хэлээд – Италид одоо цөллөг байхгүй болоо юу? гэж асуулаа.

Тэгэхэд хошууч нуруугаа гэдийсхийлгээд,

- Яагаад тэр вэ? гэж асуулаа.

- Яагаад гэвэл тэнд чинь ийм бичгийг цээргүй үйлдвэрлэдэг болоо шив. францад бол ийм хэргийн хагасыг л хийчихвэл хайрт эцэг минь, таныг таван жилийн хугацаагаар Тулонид явуулж цэвэр агаар амьсгалуулна даа.

- Яалаа гэнэ ээ? гэж хошууч ихэмсэг дүр гаргах гэж асуулаа.

Тэгэхэд Андреа хошуучийн тохойноос барьж,

- Эрхэм хүндэт Кавальканти таныг миний эцэг болоход хэдий хэрийн мөнгө өгөө вэ? гэж асуулаа.

Хошуучийг хариулах гэтэл,

- Чимээгүй гэж Андреа дуугаа намсган хэлээд,

- Би танд итгэхийн жишээг үзүүлье. Намайг таны хүүгийн дүрийг үзүүл гэж жилд таван мянган франк өгч байна. тэгэхээр би таныг эцгээ биш гэж хэлэхэд хүсэл өчүүхэн ч алга гэлээ.

Хошууч сэтгэл нь зовсон байртай ийш тийшээ харлаа.

- Зовох юмгүй, энд хэн ч алга гэж Андреа хэлээд – Тэгээд ч бид хоёр Итали хэлэх ярьж байгаа гэхэд Луккээс ирсэн хүн,

- Надад нэг мөсөн тавин мянган франк өгч байгаа юм гэлээ.

- Эрхэм Кавальканти та шидэт үлгэрт үнэмшдэг үү?

- Урьд нь бол үгүй, одоо үнэмшээд байгаа.

- Тэгээд үнэн гэх баталгаа гарч байна уу?

Хошууч хармаанаасаа бөөн мөнгө гаргаж ирлээ.

- Гялалзаж байгааг нь харж байгаа биз.

- Тэгвэл надад хэлсэн үгэнд би итгэж болох нь ээ?

- Болно байх аа.

- Энэ найрсаг зантай гүн түүнийг гүйцэтгэх байгаа?

- Яг биелүүлнэ. Харин үүний тулд та бид хоёр өөрсдийн дүрд сайн тоглох ёстой.

- Тэгэлгүй яах вэ!

- Би эевэрхүү эцгийн...

- Аа би бол тэдний хүсэж байгаа эцгээ хүндэтгэгч хүүгийн дүрд тоглоё.

- “Тэд” гэдэг чинь хэн бэ?

- Мэдэхгүй ээ, танд захидал бичсэн хүн. Та захидал хүлээж авсан гэсэн байх аа?

- Хүлээж авсан.

- Хэнээс?

- Бузони гэдэг ламаас.

- Царайгий нь ч хараагүй юм.

- Тэр захидалд чинь юу гэж бичсэн байна?

- Та намайг хэлчихгүй биз?

- Би тэгж яах юм бэ? Та бид хоёрын сонирхол нэг байгаа шүү дээ.

- Тэгвэл үүнийг унш гэж хэлээд Андреад захидал өглөө. Залуу аяархан дуугаар уншсан нь:

“Та бол ядуу хүн. Зовлон зүдүүртэй хөгшрөх гээч таныг хүлээж байна. тэгэхээр таныг баян биш, бусдын гарыг харахааргүй тийм хүн болгохыг хүсэх үү?

Тэгвэл даруйхан Парис руу гарч, Елисейн тал уруу 30 дугаар байшинд суудаг Монте-Кристо гэдэг хүн дээр оч. Тэгээд түүнээс хатагтай Корсаритай байхад чинь гараад таван настайд нь алдчихсан хүүгээ сурагла.

Тэр хүүг Андреа Кавальканти гэдэг юм. дор байгаа үсэг зурсан хүн танд сайн сайхныг хүсэж байгаад эргэлзэхгүй болгохын тулд захианд дараахь зүйлүүдийг хавсаргав.

1. Флоренц дахь Гоццийн банкнаас авах тосканы хоёр мянга дөрвөн зуун ливрийн чек.
2. Миний даалгавраар танд дөчин найман мянган франк өгөх Монте-Кристо гүнд дамжуулах итгэмжлэх бичиг.

Тавдугаар сарын хорин зургааны оройн долоон цагт гүнгийнд очоорой.

Бузони” гэлээ.

- Тийм байх ёстой.
- Тийм байх ёстой гэсэн чинь юу гэсэн үг вэ? гэж хошууч асуулаа.
- Би үүнтэй бараг адил захидал хүлээж авсан юм.
- Та юу?
- Тийм ээ, би.
- Бузони ламаас уу?
- Үгүй.
- Аа тэгээд хэнээс вэ?
- Өөрийгөө Синдбад далайчин гэдэг лорд Уилмор хэмээх англи хүнээс.
- Би лам БУзонийг мэдэхийн адил та түүнийг тийм хэмжээгээр мэднэ байх даа.
- Үгүй би танаас илүү мэднэ.
- Та түүнтэй уулзсан уу?
- Тэгсэн нэг удаа уулзсан.
- Хаана тэр вэ?
- Үүнийг би танд хэлж ядахгүй. Хэрэв танд хэлчихвэл миний зэргийг мэдчих болно. Тэгвэл энэ илүү ажил болно.
- Тэгээд тэр захидалд чинь юу гэж байна?
- Унш л даа.
- “Та бол ядуу хүн Таны өмнө гунигт ирээдүй байна. та нэр алдартай, эрх дураараа баян чинСэлэг болохыг хүсэх үү?”
- Чөтгөр ав гэж Андрей өсгий дээрээ эргэлдэн хэлээд – Энэ тухай асуух хэрэгтэй юм шиг хэсэн хэллээ.
- Генэзийн хаалганы дэргэдэх Ниццээс гарах гарам дээр хүлээж байгаа шуудангийн сүйх тэргэн дээр сууж Турин, Шамбери, Пон-де-Бовуазеныг дайран яваарай. Тавдугаар сарын хорин зургааны өдрийн оройн долоон цагт Елисейн талын

30 дугаар байшинд суудаг Монте-Кримто гүнгийн очиж эцгийгээ сураглаж асуугаарай.

Та бол бэйс Бартоломео Кавальканти ба хатагтай Олива Корсарын хүү бөгөөд танд эцгийн минь өгөх баримт бичгүүд үүнийг баталж, энэ нэрээр та дээдсийн хүрээлэнд орох болно.

Таны байр байдлын тухайд гэвэл жилд таван мянган ливрийн орлого чинь таны бүх сайн сайхан байдлыг тэтгэн дэмжиж чадна.

Энэ захидлын хамт Ницце дэх эрхэм Феррэрагийн банкнаас авах таван мянган ливрийн чек, мөн таны хэрэгцээг хангах үүргийг хүлээсэн Монте-Кристо гүнд явуулах итгэмжлэх бичгийг явууллаа.

Синдбад далайчин

- Багагүй юм аа гэж хошууч хэллээ.
- Үнэн байгаа биз?
- Та гүнтэй уулзсан уу?
- Би дөнгөж түүнтэй уулзаад ирлээ.
- Тэгээд тэр бичсэн зүйлийг зөвшөөрч байна уу?
- Бүрэн зөвшөөрсөн.
- Та ер нь юу болж байгааг ойлгож байна уу?
- Үнэнээ хэлэхэд үгүй шүү.
- Нэг л хүнийг дөнгөж байгаа бололтой.
- Юу ч л гэсэн, та бид хоёрыг л биш юм даг.
- Мэдээж хэрэг, үгүй л дээ.
- Тэгэхээр тэр чий?...
- Бидэнд ямар хамаа байх вэ, тийм ээ?
- Би ч бас тэгж хэлэх гэсэн юм. эцэст нь хүртэл найзархагаар тоглож орхиё.
- Санал нийлж байна. би танд тохирох хань байгаа биз?

- Хайрт эцэг минь, би үүнд нэг ч минут эргэлзээгүй.

- Хайрт хүү минь та надад их ач тус болж байна.

Монте-Кристо зочдын өрөөнд орж ирэхдээ. Энэ минутыг тааруулж орж ирлээ. Түүний хөлийн чимээг сонсоод ярилцаж байсан хоёр бие бие өөдөө ухасхийн тэврэлдлээ. Энэ үед гүн орж ирэв.

- За яав бэйс? Та хүүгээ хараад сэтгэл ханамжтай байна уу?

- Ай гүн минь, баярлаад бахардаж үхэх гэж байна.

- Залуу хүн та?

- Ай гүн минь, би баярлаад өөрөө ч өөрийгөө мэдэхээ байлаа.

- Азтай эцэг, азтай хүү юм даа гэж гүн хэлэв.

- Парист удахгүй, даруй явах гэж байгаа ганц зүйл л намайг эвгүйцүүлж байна гэж хошууч хэлэв.

- Гэхдээ эрхэм хүндэт Кавальканти та зарим нэг найз нөхөдтэйгээ танилцуулахаас өмнө яваад өгөхгүй байх гэж найдаж байна гэж гүн хэллээ.

- Бүхнийг таны хэлснээр гүйцэтгэнэ гэгээнтэн минь гэж хошууч хэллээ.

- За одоо залуу хүү илэн далангүй үнэнээ хэл.

- Хэнд?

- Эцэгтээ. Та мөнгө зоосны талаар ямаршуу байгаагаа нуулгүй хэл.

- Чөтгөр ав, та миний хамгийн хөндүүр юмыг сануулчихлаа гэж Андреа хэлэхэд, гүн,

- Хошууч та сонсож байна уу? гэж асуулаа.

- Сонсолгүй яах вэ, сонсож байна.

- Тэгээд та ойлгож байна уу?

- Маш сайн.

- Тан» хонгор хүү чинь мөнгөний хэрэгтэй юм байна шүү дээ.

- Тэгэхээр би яах ёстой болж байна.

- Мөнгө л өг.

- Би юу?

- Тийм ээ та гэж хэлээд гүн тэдний дунд орж зогсоод боодолтой мөнгөө Андреагийн гарт бариулж,

- Үүнийг ав гэлээ.

- Энэ юу юм бэ?

- Таны эцгийн хариулт.

- Миний эцгийн үү?

- Тийм ээ, та мөнгө хэрэгтэй байгаагаа түүнд санаа төрүүлж хэлсэн биз дээ?

- Тийм ээ, тэгээд яагаа вэ?

- Тэгээд л энэ байхгүй юу. Үүнийг танд дамжуулан өгөхийг тэр надад даалгасан юм.

- Миний орлогод орох уу?

- Үгүй дээ, төвхнөх зардал чинь.

- Ай, хайрт эцэг минь!

- Чишш, эцэг чинь өөрөө өгч байгаа юм гэдгийг танд хэлэх дургүй байгаа юм гэж гүн хэлэхэд Андреа мөнгийг авч хармаандаа хийгээд,

- Түүний ёсорхог харьцааг би маш үнэлж байна гэлээ.

- Их сайн, одоо явцгаа! Гэж гүн хэлэхэд,

- Ай гэгээнтэй тантай ахиад хэзээ уулзахсан бол гэж Кавальканти асуулаа.

- Өө нээрээ хэзээ ийм завшаан тохиолдох бол? Гэж Андреа асуув.

- Хэрвээ хүсвэл бямба гаригт...тийм ээ... бямбад ирвэл сайн байна. фонтен гудамжны Отейль дахь миний ордонд бямба гаригт хэдэн хүн ирж хамт хоол иднэ. Бас тэнд танай банкны эзэн Данглар ирнэ. Би та хоёрыг түүнтэй танилцуулж өгөмз, тэр та нарт мөнгө өгч байх болохоор та нартай танилцах хэрэгтэй байх.

- Ёслолынхоо хувцастай юу? гэж хошууч аяархан асуулаа.

- Ёслолын хувцастай, одонгоо зүүгээд ирээрэй.

- Аа би яах вэ? гэж Андреа асуулаа.

- Та хамгийн энгийн хувцастай хар өмд гялтгар шаахай цагаан хантааз, хар буюу хөх цамц, урт зангиа зүүж ирээрэй. Хувцсаа Блен эсвэл Вероникт захиалж хийлгээрэй. Хэрвээ та хаягийг нь хэлж өгвөл Батистен хэлж өгнө. Аль болохуйц мөнгөний хэмжээндээ тааруулж хувцасбал төдийчинээн сайн. Морь худалдан авахдаа Деведётэй уулзаарай. Сүйхээ бол Батистенээр хийлгэнэ биз.

- Бид хэдэн цагт очих вэ? гэж Андреа асуулаа.

- Зургаан цаг хагасын үед.

- За гэж хэлээд хошууч бүрх малгайгаа авч, хоёр Кавальканти бахийн ёслоод гарч одлоо.

Гүн цонхон дээр очиж тэр хоёрыг хэрхэн гар гараасаа хөтлөлцөн явааг харлаа.

- Ёстой бузар солигнууд! Гэж гүн хэлээд - Үнэхээр эцэг хүү хоёр байгаагүй нь ямар харамсалтай вэ! гэлээ.

Тэгээд хэсэг зуур бодлогшрон зогссоноо,

- Моррелинд очъё. Үзэн ядах сэтгэл төрөхөөс жигших сэтгэл төрөх нь илүү зовлонтой юм гэж хэллээ.

XIX. Царгас тарьсан ногооны газар

Одоо бид эрхэм де Вильфорын гэртэй залгаа байгаа ногооны газар ба туулайн бөөр модонд далдлагдан орсон хаалганы сараалжийн дэргэд эргэж очъё. Тэнд таних нөхөдтэйгээ дахин дайралдав.

Энэ удаа Максимилиан түрүүлж ирлээ. Ногооны газрын хашааны банзанд нүүрээ наачхаад цэцэрлэгийн гүнд танил сүүдэр цухалзаж, модот гудамжны элсэн зам торгон шаахайны уланд шаржигнах эсэхийг хүлээн чагнан зогсож байгаа нь юм санжээ.

Тэгтэл арай гэж хөлийн имээ сонстож нэг сүүдрийн оронд хоёр сүүдэр гарч ирэв. Хатагтай Данглар, Эжени хоёр ирж Валентинагийн болзоонд ирэх цагаас хэтэртэл удаан байсан тул тэр охин хожимджээ. Тэгэхээр нь Валентина хожимдож байгаа нь миний буруугаас биш гэдгийг харуулахын тулд мадмаузель Дангларыг цэцэрлэг дотуур явж зугаалъя гэлээ.

Тэгэхэд л Моррель сэтгэлтэй хүнд байдаг зөнгөөр мэдэрч, сэтгэл нь тайвширлаа. Тэд дуу нь дуулдахаар ойртож ирээгүй боловч Валентина Максимилианд өөрийгөө дандаа харагдаж байхаар алхаагаа тааруулж, хажуугаар нь өнгөрөн

гарах бүрдээ “Найз минь тэсэж байж үз. Миний буруу биш гэдгийг харж ба йгаа биз” гэсэн маягтайгаар хажуу дахь хүндээ үл мэдэгдэн хаалганы зүг харна.

Максимилиан ч хоёр охины нэг нь зүдэрсэн байрын эелдэг зөөлөн харцтай залуухан уд мод мэт уян налирхай, хонгор шар үстэй охин, нөгөөдөх нь бардам янзын нүдтэй хушаангар шиг гуалиг тэгшхэн нуруутай хүрэн үстэй охин байлаа. Моррелийн нүдэнд валентина дор хаяад бүх талаараа давуу харагдах нь мэдээж хэрэг. Охидууд хагас цаг хэртэй зугаалаад, явцгаалаа. Хатагтай Дангларын харих цаг болж гэдгийг Максимилиан мэдэв.

Нээрээ ч нэг минутын дараа валентина ганцаараа хүрч ирлээ. Наашаа ирж яваагийн нь саваагүй хүмүүс харчих бий гэж айн удаахан алхана. Охин хаалга уруу шууд хүрээд ирэхийн оронд замдаа урт сандал дээр сууж, ажиг ч үгүй дүр үзүүлэн бут ба модот гудамжийг ажиглан харлаа. Ингэж болгоомжлон харсны дараа Валентина сая хаалга уруу гүйж ирлээ.

- Валентина гэх дуу хаалганы цаанаас гарлаа.

- Сайн байна уу? Максимилиан. Би таныг хүлээлгэчихлээ. Гэвч яагаад тийм болсныг хараа биз дээ.

- Тэгсээн, би мадмаузель Дангларыг таньсан. Би та хоёрыг тийм сайн найз гэж мэдсэнгүй.

- Бид хоёрыг найз гэж хэн танд хэлээ вэ?

- Хэн ч хэлээгүй. Харин та хоёрыг нууцаа ярилцаж яваа сургуулийн охид юм уу гэмээр сугадалцчихсан юм яриад л явж байхаар чинь тэгж бодсон юм.

- Нээрээ ч бид хоёр нууцаа ярьсан. Тэр надад эрхэм де Морсертой суух дургүй байгаагаа хэлсэн. Би ч бас түүнд эрхэм де Эпинэтэй суух болсон минь их азгүй хэрэг боллоо гэдгээ хэлсэн.

- Хонгор Валентина минь.

- Эжени бид хоёр сайн найзууд шиг харагдсан нь ийм учиртай. Би дургүй хүнийхээ тухай ярихдаа дуртай хүнийхээ тухай бодож байсан шүү.

- Валентина та ямар сайн хүн бэ? Мадмаузель Дангларт хэзээ ч гарч ирэхгүй юм танд олон байна. цэцгийн анхилуун үнэр, жимсний амт шиг тийм сайхан нандин чанар танд байна. цэцэг жимсэнд зөвхөн гаднаас нь харахад сайхан байх нь гол биш.

- Та надад хайртай болохоор л тэгж харагдаж байгаа юм.

- Үгүй, Валентина, тангараглая. Бм сая та хоёрыг хоёуланг чинь харсан. Мадмаузель Дангларын гоо сайхныг хүлээх ёстой боловч түүнд дурлаж яаж болно вэ гэдгийг ойлгосонгүй.

- Намайг тэнд хамт байсан болохоор л танд тэгж санагдсан байх. Би байсан болохоор та алагчилж л дээ.

- Үгүй харЕн та надад хэлээч...мадмаузель Дангларын тухай миний боддог бодлоор тайлбарлагдах тэр сониуч сэтгэлээсээ болоод асууж байгаа юм.
- Чухам юу асууж байгааг чинь би мэдэхгүй боловч, лав л шударга биш бодол байгаа юм. та нар хөөрхий эмэгтэйчүүд бидний тухай хэлцэн ярилцахад биднийг өршөөж байгаа болов уу гэж бодохын нэмэр
- Та нар хоорондоо ярихдаа бие биедээ маш шударга ханддаг гэж бодмоор.
- Энэ бол бидний бодол бараг л дандаа тал тохой татсан юм шиг байдгаас болж байгаа юм. харин та юу асуух гэсэн юм бэ?
- Мадмаузель Данглар эрхэм де Морсертой суух дургүй нь өөр ямар нэгэн хүнд хайртай хэрэг үү?
- Эжени бид хоёр ерөөсөө найз биш гэдгийг танд хэлсэн шүү.
- Охидууд найз биш ч гэсэн бие биендээ нууцаа хэлдэг шүү дээ. та түүнээс энэ тухай асуусан гэдгээ хүлээвэл дээр биш үү. Өө та бараг инээмсэглэж байх шив дээ.
- Энэ модон хаалт танд төдий л их хаалт болдоггүй бололтой.
- Тэгээд тэр охин танд юу гэж хэлэв?
- Хэнд ч дурладаггүй. Хүнтэй сууна гэж бодлохоор айдас хүрдэг гэж байна лээ. Хэнээс ч хараат биш чөлөөт амьдралыг хүсдэг, эцгээ хоосроосой тэгвэл Луиза Армили шигээ жүжигчин болох юм сан гэсэн.
- Харж байна уу тэр.
- Энэ юу харуулж байгаа юм бэ? гэж Валентина асуухад Максимилиан инээмсэглэн,
- Юу ч биш.
- Та тэгвэл яагаад инээмсэглэ байгаа юм бэ?
- Та ч гэсэн харж байгаа шүү дээ.
- Тэгвэл би яваад өгөх үү
- Үгүй, үгүй. Харин таны тухай ярья.
- Тэгье, т ны хэлдэг зөв. Бидэнд зөвхөн аравхан минут үлдлээ.
- Халаг минь гэж Максимилиан дуу алдан хэлэхэд Валентина уйтгартайгаар,
- Ти©м ээ би муу найз юм. таны хэлдэг зөв. Хөөрхий Максимилиан та надаас болж ямар шуу байгаагаа хараач. Гэтэл та бол аз жаргалтай амьдралын төлөө төрсөн хүн шүү дээ. би үүний учир өөрийгөө гашуунаар зэмлэн суудаг юм.
- Валентина минь. энэ надад хамаагүй шүү. Энүүнд л миний аз жаргал байдаг юм. энэ мөнхийн хүлээлт минь, тантай уулзсан таван минут, таны амнаас гарсан хоёр үгнээс л мартагддаг юм. бурхан зөвхөн салган хагацуулах гэсэндээ ийм хоёр ижил

зүрхийг бүтээж, ийм гайхалтайгаар холбож өгөөгүй байх гэж би үнэнээ итгэж байна.

- Баярлалаа Максимилиан. Хоёр биенийхээ төлөө итгэж найдаж яв. Энэ намайг бараг л жаргалтай болгочихдог юм.

- Валентина дахиад л бас юу болов? Юунд ийм хурдан явах ёстой болов?

- Мэдэхгүй. Вильфор авгай намайг орж ирээрэй гэсэн. Миний хөрөнгөний хувь заяа шалтгаалах зүйл надад хэлэх байх. Бурхан минь би дэндүү баян юм. хөрөнгийг минь аваад намайг тайван дураар минь орхиосой. Моррель та намайг яду болчихсон ч дурласан хэвээр байна биз?

- Би хэзээд танд хайртай байна. баян ядуу нь ямар хамаа байна вэ? Зөвхөн л миний Валентина надтайгаа хамт байж, надаас хэн ч булааж авч чадахгүй гэдэгт итгэлтэй байвал болох нь тэр. Харин тэр хэлэх зүйл нь таны гэрлэлттэй холбоотой юм биш байгаа?

- Үгүй байх.

- Валентина би амьд л байхдаа өөр хүнийх болчихгүй. Тэгэхээр бүү ай.

- Та намайг үгээр тайвшруулах гэж оролдож байна уу? Ыахсимилиан.

- Уучлаарай таны хэлдэг зөв. Би эвгүй юм хэлчихлээ. Би сая Морсертой уулзсан гэдгээ хэлэх хэрэгтэй юм.

- Тийм үү?

- Франц түүний найз гэдгийг та мэдэх үү?

- Тэгээд юу гэж?

- Тэр Францаас захидал авсан байна. тэр удахгүй ирэх гэнэ.

Валентинагийн царай зэвхийрч хаалга налж,

- Бурхан минь нээрээ юу? Үгүй энэ тухай хатагтай Вильфор надад хэлмээргүй юмсан даа.

- Яагаад тэр вэ?

- Яагаад ий...би ч өөрөө мэдэхгүй байна... Хатагтай Вильфор энэ гэрлэлтийг илээр эсэргүүцдэггүй ч дотроо талархдаггүй юм шиг санагддаг.

- Валентина тэгвэл би хатагтайг хүндэтгэн үзэж эхлэх нь байна шүү.

- Бүү яар Максимилиан гэж Валетина хэлээд уйтгартайгаар инээмсэглэв.

- Энэ гэрлэлтэд дургүйцдэг юм бол үүнд саад хийхийн тулд энэ хүний гуйлтад талтай хандах юм биш биз?

- Максимилиан үүнд бүү горьд. Хатагтай Вильфор нөхөр болох хүний нь биш, харин ерөөсөө хүнтэй суух явдалд дургүйцээд байгаа юм.

- Яалаа гэж? Хэрвээ хүнтэй суух дургүй юм бол өөрөө яагаад хүнтэй суусан юм бэ?

- Максимилиан та ойлгохгүй байна. Би жилийн өмнө сүмд очиж суух гэж хэлэхэд тэр татгалзах нь зүйтэй гэж үзсэн боловч миний саналыг дуртай хүлээн авсан. Түүний ятгасны хүчээр эцэг маань ч зөвшөөрсөн юм. Харин хөөрхий өвгөн аав минь л явуулаагүй юм даа. Орчлон дээр зөвхөн намайг л хайрладаг зо«гүй болсон өвгөний нүд ямар их тунгалаг ойлгомжтой болохыг та мэдэхгүй байна. Хэрвээ би худлаа гүтгэж байгаа бол бурхан уучлаг! Түүнд ганцхан би л хайртай. Миний шийдвэрийн тухай мэдээд над өөд яаж харсан тэр харцанд нь хэчнээн их зэмлэл, хөдөлгөөнгүй болсон нүүрэн дээгүүр нь урссан нулимсанд нь хэчнээн их гомдол байсныг та мэддэг ч болоосой. Надад ичгэвтэр санагдаж, хөлд нь сөхрөн унаж: “Өршөөгөөрэй! өршөөгөөрэй! өвгөн аав аа! Надад ямар ч явдал тохиолдсон би таниасаа хэзээ ч хагацашгүй” гэж дуу алдан хэлсэн. Тэгэхэд нүдээ тэнгэр өөд өргөсөн... Максимилиан би их зовж зүдэрч мэдэх юм. Гэвч өвгөн аавын минь энэ их зовлон зүдгүүрийн хариу шагнал болно.

- Хайрт Валентина минь та тэнгэрлэг охин юм. Би тэр нүүдэлчин арабуудыг баруун зүүнгүй цавчилж явахдаа буруу номтон болохоор л бурхан анхааралдаа аваагүй юм бол тантай танилцуулчихаар юу хийснээ санахгүй байна. Тэр ч яах вэ, харин хатагтай Вильфор таныг хүнтэй суулгахгүй гэдгийн шалтгаан юу байна?

- Би баян дэндүү баян гэдгийг та дуулаагүй юм гэж үү? Би зөвхөн эхээс хойш жилд тавин мянган ливрийн орлого үе залгамжлан авсан. Миний өвгөн аав, эмгэн ээждээ Сен-Меран бас төдий чинээг надад орхино. Эрхэм Нуарьте ч бас намайг өөрийнхөө ганц үе залгамжлагч болгох бодолтой байгаа. Ийм янзаар миний дүү Эдуар надаас ядуу болж хоцорно. Эдуар хатагтай Вильфорын зүгээс горьдох юм юу ч байхгүй. Харин хатагтай хүүгээ ихэд хайрладаг. Хэрвээ би сүмд явчихвал миний бүх хөрөнгө эцэгт минь ногдож, дараа нь түүний хүүд шилжих юм.

- Хачин юм даа. Ийм залуу сайхан хүүхэн хаанаас ийм шунахай сэтгэлтэй болчихов.

- Тэр өөрийгөө бодож байгаа юм биш. Хүүгийнхээ төлөө л тэгж байгаа юм. Таны буруутгаж байгаа зүйл эхийн хайрын үүднээс авч үзвэл бараг л сайн үйл юм шүү дээ.

- Валентина, та хөрөнгөнийхөө хагасыг хүүд нь өгчихвөл яана?

- Завшаан эрдэггүй гэж дандаа ярьж байдаг тэр хүүхэнд яаж ингэж хэлэх вэ?

- Валентина миний дурлал наддаа хэзээд ариун шүтээн байдаг бөгөөд би түүнийг бүх л гэгээн юмсийн адил зүрхнийхээ гүнд нуун хадгалж явдаг. Энэ орчлонд хэн ч тэр ч байтугай дүү минь ч энэ хайрын тухай сэжиг аваагүй. Би нууцаа хэнд ч итгэн хэлээгүй. Харин нэг найздаа хэлэхийг Валентина минь зөвшөөрөх үү?

Энэ үгийг дуулаад Валентина цочлоо.

- Найзаа гэнэ ээ? Максимилиан надад энэ тухай дуулахад ч хэцүү байна. Тэгээд тэр найз чинь хэн бэ?

-Валентина та хүнийг нэг л хармагц сэтгэлд чинь таатай санагдаж, урьд өмнө ч дайралдаж явсан юм шиг болоод хаана хэзээ үзлээ дээ гэж бодож ядаад олохгүй болохоороо өмнө нь өөр ертөнцөд үзсэн юм байж харин энэ бол зөвхөн сэргэсэн дуртгал байлгүй гэж бодоход хүрч үзсэн үү?

- Үзсэн

- Ер бусын тэр хүнийг анх хараад л надад ийм сэтгэгдэл төрчихсөн юм.

- Ер бусын хүнийг ий?

- Тийм ээ.

- Та танилцаад удаж байгаа юм уу?

- Долоо хоног ч юм уу, арваад л хонож байна.

- Тэгээд танилцаад дөнгөж долоохон хоносон хүнийг найзаа гэж нэрлэж байгаа юм уу? Максимилиан, би таныг найз гэдэг нандин үгийг өгөөмрөөр тарааж явдаг хүн гэж бодоогүй шүү.

- Валентина таны хэлдэг зүйн хэрэг. би таныг юу ч хэллээ гэсэн зөнгөөрөө төрсөн энэ сэтгэгдлээсээ няцаж чадахгүй. Энэ хүн надад ирээдүйд тохиолдох сайн сайхан бүхэнд их үүргийг гүйцэтгэнэ гэдэгт итгэж байна. заримдаа тэр хүн миний ирээдүйд нэвтрэн орж хүчит гараараа залж байх шиг санагддаг юм.

- Тэгвэл тэр чинь зөнч мэргэн хүн үү? гэж Валентина инээмсэглэн асуухад

- Ялангуяа сайн сайхан юмыг урьдаас мэддэг юм билээ... би үүнд нь итгэж байна гэж Максимилиан хэлэв.

- Тэр хүнээ надтай танилцуулаарай. Би энэ зовлон зүдгүүрийнхээ оронд хайр дурлалын шан хүртэж чадах эсэхээ асууя!

- Хөөрхий найз минь! Та түүнийг мэднэ.

- Би юү?

- Тийм ээ. Таны хойд эх, түүний хүү хоёрын амийг аварсан хүн шүү дээ.

- Монте-Кристо гүн үү?

- Тийм ээ тэр.

- Үгүй, тэр хэзээ ч миний найз болохгүй. Хойд эхтэй дэндүү найзархаг байдаг юм гэж Валентина дуу алдлаа.

- Гүн танай хойд эхийн найз байх гэж үү, Валентина ? Үгүй, миний сэрэхүй намайг тэгж хуурах ёсгүй. Таны андуурч байгаад би итгэж байна.

- Максимилиан та мэддэг ч болоосой! Одоо манайд Эдуар зонхилох хүн биш, харин гүн болсон шүү. Хойд эх маань түүний өмнө бөхөлзөн, түүнийг хүн төрөлхтний мэдлэг бүхнийг эзэмшигч гэж үзэж байна. Эцэг маань гахай шагширч байна. Ийм дээд санаа бодлыг хэлдэг хүн урьд өмнө сонсоогүй гэж ирээд л магтдаг юм. Эдуар түүний том хар нүднээс айх боловч ирэх бүрд нь угтан гүйж очиж ямар нэгэн гайхалтай тоглоом авдаг. Монте-Кристо гүн манайд эцэг эхийн маань зочин биш, харин гэртээ байгаа юм шиг байдаг болсон.

- Яая гэх вэ. энэ бүгд таны ярь байгаагаар юм шиг бол та түүний ид шидийн их хүчийг биедээ амсчихсан ч юм уу, эсвэл удахгүй амсах болно оо. Тэр Альбер де Морсертой Италид уулзаад түүнийг дээрэмчдийн гараас аварсан. Хатагтай Данглартай танилцаад хаан хүний өгдөг бэлэг өгсөн. Танай хойд эх ба дүү чинь гэрийн нь гадуур шуугин өнгөрөх үед нуби хүн нь тэдний амийг аварса. Энэ хүн орчин тойрондоо нөлөөтэй билэг ерөөлтэй төрсөн нь илт байна. ийм агуу гайхамшгийг энгийн дур сонирхолтой хослуулж чадсан хүн урьд нь үзээгүй. Тэр над руу тун эелдэг зөөлөн инээдэг болохоор хүмүүс түүний инээдийг гашуун уйтгартай гэж хэлдгийг би ойлгодоггүй юм. валентина, тэр тан өөд ингэж инээмсэглэсэн үү? Хэлээч? Хэрвээ тэгсэн бол та аз жаргалтай болно гэсэн үг.

- Би юу даа? гэж залуу бүсгүй дуу алдаад – Максимилиан тэр хүн над өөд хардаг ч үгүй. Хэрвээ хажуугаар нь өнгөрвөл надаас буруулж эргэдэг. Үгүй тэр тийм энэрэнгүй сэтгэлтэй хүн биш, таны тэр хэлээд байдаг шиг юмыг эвт шувт хардаггүй, хүний зүрхэнд юу байгааг уншиж чаддаггүй хүн. Хэрвээ энэрэнгүй сэтгэлтэй хүн байсан сан бол намайг хараад энэ гэр ганцаардмал уйтгар гунигтай хүн байна гэж мэдээд хамгаалах байсан юм. хэрүүээ тэр хүн таны хэлдэг шиг нар лугаа ялгаагүй юм бол зүрхийг мань туяагаараа бүлээцүүлэх байсан юм. максимилиан та түүнийг өөртөө хайртай гэж байна. та түүнийг яаж мэдэж байгаа юм бэ? Хүмүүс ийм өндөр чилгэр нуруутай, урт сахалтай, сэлэм зүүсэн бяртай офицерт долигонон инээмсэглэх атлаа уйлж байгаа золгүй бүсгүй санаанд ч орохгүй дайрч орхино.

- Валентина та андуурч байна гэдэгт тангараг тавья.

- Максимилиан хэрвээ тиймгүй бол манайд тал олж авах гэж хүн чинь таны тэрхүү магтан шагшраад байдаг тэр инээмсэглэлээ надад нэг удаа боловч бэлэглэх байсан юм. Үгүй тэр намайг золгүй амьтан болохыг хараад надаас ямар ч ашиг гарахгүй гэж мэдээд, намайг хайхарч үздэггүй юм. аягүй бол миний эцэг, хатагтай Вильфор, миний дүүд тал засах гэж намайг мөрдөн мөшгөж эхлэхийг хэн мэдэх вэ? Ер нь илэн далангүй ярья. Би бол ямар ч шалтгаангүйгээр үзэн ядаад байхаар тийм

эмэгтэй биш. Та өөрөө тэгж хэлдэг шүү дээ. уучлаарай намайг гээд бүсгүй түүний үг Максимилианд сэтгэгдэл төрүүлж байгааг ажиглаж хэлээд – Би тэнэг болохоороо өөрийн мэдэлгүй бодсоноо хэлчихлээ. Таны хэлж байгаа тийм хүч тэр хүнд байгаа гэдгийг би үгүйсгэхгүй. Тэр хүч надад ч гэсэн нөлөөлж байна. харин тэгэхдээ муугаар нөлөөлж сайхан сэтгэлийг минь гутааж байна гэлээ.

- За тэгвэл энэ тухай ярихаа больё, би түүнд нэг ч үг хэлэхгүй гэж Моррель санаа алдан хэлэхэд Валентина,

- Найз минь би таныг гомдоочихвоо? Би танаас уучлалт гуйх гэж гараа яагаад өгч болохгүй байна вэ? Харин та намайг итгүүлж чадвал би баяртай байна. тэр гүн чухам танд ямар тус хүргэсэн юу хийсэн хүн бэ?

- Гүн чухам юу хийсэн бэ? гэдэг асуулт чинь намайг хүнд байдалд оруулж байна. Ямар ч тодорхой юм хийгээгүй гэдгийг би өөрөө мэдэж байна. Ямар ч зориудын юм байхгүй, зүгээр тэгж санагдаад байгаа юм. нар миний төлөө чухам ямар юм хийсэн бэ? Юу ч хийгээгүй. Нар намайг гийгүүлж түүний гэрэлд би таныг харж байна. ингээд л гүйцээ. Ямар нэгэн анхилуун үнэр миний төлөө юу хийсэн юм бэ? Юу ч хийгээгүй. Зүгээр л сайхан байдаг. Хэрвээ намайг яагаад анхилуун сайхан үнэрт дуртай байгаа ю бэ гэж асуувал надад хэлэх юм алга. Тэгэхээр гүн надад сайн байдаг шиг би түүнд сайн санах болсон нь ямар нэг тайлбарлашгүй шалтгаан байх шиг. тэр хүн ч бас надад адилхан ханддаг. Энэ харилцан найрсаг бие? Биеэ талархах сэтгэгдэл нь тохиолдлын хэрэг биш гэж надад санагдах юм. түүний хийсэн өчүүхэн боловч зүйл, нандин сэтгэл, миний хийсэн зүйл ба санаа бодлын хооронд ямар нэг холбоо байна гэж надад санагддаг юм. Валентина, та дахиад л намайг шоолох байх даа. гэвч би тэр хүнтэй танилцсанаас хойш надад тохиолдож байгаа сайн сайхан юм бүхэн түүнээс хамаатай гэдэг тэнэг санаа төрөөд байх болов. би тийм асрамжлан хамгаалагчийг хүсэхгүйгээр гучин насыг насалсан хүн, тийм биз дээ? З яах вэ, би танд жишээ хэлье. Тэр намайг бямба гаригт зоог барихыг урьсан. Бидний хоорондын харилцааг бодоход бол энэ ердийн хэрэг биз? Дараа нь би юу мэдсэн бэ гээч? Танай эцэг хойд эх хоёрыг урьсан байна билээ. би тэдэнтэй уулзах болно. Энэ уулзалт юунд хүргэхийг хэн мэдэх вэ? Энэ ердийн тохиолдлын хэрэг боловч ямар нэг гайхмаар юм байгаа юм. надад харин итгэлийг төрүүлээд байх юм. энэ юм бүхнийг мэдэж ойлгодог ер бишийн хүн намайг Вильфорынхонтой уулзуулах гэж бодсон юм болов у? Гэ би өөрөө өөртөө хэлдэг юм. би бас түүнийг хайрын сэтгэлийг минь тааварлан мэдээ юм болов уу гэж нүднээс нь олж харахыг хичээж байна.

- Найз минь, би танаас зөвхөн ийм юм дуулсан бол таныг далдыг харагч гэж үзэж таны энэ бодлоос тоглоомгүй их айх байсан юм. энэ уулзалт танд тохиолдлын биш хэрэг санагдаад байгаа юм уу? Ингэхэд сайн бодоорой. Хаана ч очих дургүй эцэг маань тэр урилгыг очихгүй болгох гэж хатагтай Вильфорыг арваад удаа шалсан боловч, харин хатагтай ер бусын тэр айлд очих хүсэл нь оргилон байв. Тэгээд ямар ч байсан аавыг минь хамт явах болгосон юм. Үгүй дээ, Максимилиан минь, үгүй. Энэ

орчлонд танаас өөр тусламж горьдох хүн надад байхгүй. Хөдөлж чадахаа больсон өвөг эцэг, амьгүй сүүдэр болсон эхээсээ л тусламж горьдоно гэхгүй бол хэнээсээ горьдох билээ?

- Таны хэлдэг зөв, Зүй ёсны таны талд байна гэж Максимилиан хэлээд – Гэхдээ надад дандаа захирангүй нөлөө үзүүлдэг таны Селдэг дуу өнөөдөр намайг итгүүлж чадахгүй байна гэхэд,

- Аа таных ч бас адилхан гэж хэлээд – Гэхдээ танд өөр жишээ авах юм байхгүй бол шүү гэлээ.

- Надад бас байна аа гэж Максимилиан зоримог биш хэлээд, - Энэ бол түрүүчийнхээсээ илүү тэнэг зүйл шүү гэдгийг танд хэлэх ёстой байна гэжээ.

- Тэгвэл ч бүр муу даа гэж хэлээд Валентина инээмсэглэв.

- Гэхдээ надад бол итгэмээр зүйл байгаа юм. би сэтгэлээрээ зөн билгээрээ амьдардаг хүн. Арван жил цэргийн алба хааж явахдаа гэнэт санамсаргүй баруун ч юм уу зүүн тийш хазгай хэмээн дотоод сэтгэл минь тушааж үхлийн сум ирэхэд хажуугаараа өнгөрөөж олон удаа амь гарсан хүн гэж Моррель үргэлжлүүлэн ярилаа.

- Хайрт Максимилиан минь. сум замаасаа хазайн зайлсан нь миний мөргөн залбирснаас гэж яагаад үзэхгүй байна вэ? Би таныг энд байхад, бурхан ба ээж хоёртоо таны төлөө мөргөдөг байсан юм.

- Тийм ээ, та бид хоёрыг танилцсанаас хойш бол тийм гэж Моррель инээмсэглэн хэлээд – Валентина тантай танилцахаас өмнөх явдлыг ярьж байна шүү дээ гэв.

- За яах вэ, муухай аашт минь. та намайг ямар нэг ач тус хүргэсэн гэж бодохгүй байгаа бол таны тэнэг гээд байгаа жишээг тань сонсьё.

- Тэгвэл энэ нүхээр хар даа. тэнд модон доор миний шинээр унаж ирсэн морь уяатай байгааг харж байна уу?

- Ямар сайх н морь вэ? Та яагаад нааш нь авчраагүй юм бэ.

- Үнэн нь хадсан морь гэдгийг та харж байгаа биз. миний хөрөнгө хэмжээ хязгаартайг та мэднэ. Би бол хэрсүү гэгдэхээр хүн шүү дээ. гэтэл энэ сайхан Медеаг (би ингэж нэрлэсэн юм) нэгэн худалдаачинд байхыг хардаг юм байна. тэгээд үнийг нь асуулаа. Тэгсэн дөрвөн мянга таван зуун франк гэж хариулав. Би түүний гайхан шагшрахаа больж, морийг авч чадахгүйдээ гутран буцаж явлаа. Үнэндээ, морь намайг өрөвдмөөр баярлан харж толгойгоороо зөөлөн сөргөөн үүсгэж, мордож үзэхэд ёстой л жороолон гунхалзаж байсан болохоор хий л зүрх шимширч байлаа. Тэр орой манайд танил нөхөд Шато-Рено, Дебрэ бас та азаар нэрий нь ч мэдэхгүй

тав зургаан наргианч хүн ирлээ. Тэгээд хэзэр тоглохоор болцгоолоо. Би хожигдохоор тийм баян биш, хожоо нь гарахаар ч тийм ядуу биш болохоор хэзэр ер тоглодоггүй юм. харин энэ удаа би манайд ингэж байгаа болохоор би хэзэр авчруулахаас өөр аргагүй болсон юм. биднийг тоглох гээд суутал Монте-Кристо гүн орж ирлээ. Тэгээд ширээнд сууж тоглож эхлэхэд, би хожиж гарлаа. Валентина би танд арай гэж зүрх гарган хэлж байна. би таван мянган франк хожив. Зочид шөнө дундын үед тарж явсан юм. би тэссэнгүй хөнгөн сүйх тэрэг хөллөж нөгөө худалдаачин дээр очив. Сэтгэл догдолсноосоо болоод чичрэн байж хонх дарвал хаалга онгойлгож өгсөн хүн лав намайг солиотой хүн гэж бодсон байх. Би морины хашаа руу гүйн очиж уяа руу харав. Бөөн аз! Медеа өвс тайван хазлаж байлаа. Би эмээлийг нь шүүрэн авч өөрөө эмээллээд, хазаарлав. Медеа энэ Үүхэнд дуртай захирагдан зогсож Үайлаа. Дараа нь гайхсан худалдаачинд дөрвөн мянга таван зуун франк атгуулж орхиод гэртээ ирлээ. Үнэндээ гэртээ ирсэн ч биш, Елисейн талаар шөнөжингөө давхилаа. Юу болсон гэж санана! Гүнгийн цонх гэрэлтэй, хөшгөн дээр нь түүний сүүдэр тусах шиг санагдсан. Валентина тэгэхээр гүн намайг морь авах юмсан гэдгийг мэдээд, зориуд хожигдож намайг морио аваг гэсэн байх гэж батлан хэлэхэд бэлэн байна.

- Хонгор Максимилиан минь гээд Валентина – Та дэндүү их хий бодолтой хүн юм. та надад удаан дурлахгүй байх. Тан шиг ийм сайхан бодол мөрөөдөлдөө умбаж байдаг хүн та бид хоёрынх шиг ийм нэгэн хэвийн дурлалд тууштай байж чадахгүй. За бурхан минь... Намайг дуудаж байна. Дуулж байна уу?

- Валентина гэж Максимилиан дуудаад - Чигчий хуруугаа... завсраар нь... надад үнэсэж болохоор өгөөч гэлээ.

- Максимилиан та бид хоёр бие биедээ зөвхөн хоёр дуу, хоёр сүүдэр байна гэж ярилцсан байх аа.

- Өөрөө л мэд дээ, Валентина минь.

- Хэрвээ би таны хүслийг биелүүлбэл та баярлах уу?

- Ай тэгэлгүй яах вэ?

Валентина чигчий хуруугаа завсраараа цухуйлгасангүй. Харин сандал дээр гараад хашаан дээгүүр бүх гараа сунгаж өглөө.

Максимилиан баярлан дуу алдаж, суурь модон дээр үсрэн гараад энэ хүндэтгэн хайрладаг гарыг атган авч, халуун уруулаа наалдуулахад тэрхүү бяцхан гар түүний гараас мултран салж, Моррель зөвхөн Валентинагийн гүйгээд явчихыг сонслоо. Тэр бүсгүй биедээ амсч мэдэрснээс ч айсан байж болох юм даа.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

1. Нуартье де Вильфор

Хатагтай Данглар охин хоёрыг яваад өгснөөс хойш буюу бидний дээр өгүүлсэн яриа болох зуур вангийн гэрт ийм хэрэг болжээ.

Вильфор эхнэрээ дагуулаад эцгийнхээ өрөөнд орж ирлээ. Валентины тухайд гэвэл хаана байсныг нь бид мэднэ.

Тэр хоёр Нуартьетэй мэндэлж гар доор нь хорин таван жил илүү зарагдсан хөгшин зарц Барруаг нь явуулаад сууцгаалаа.

Нуартье өглөө суулгаад үдэш босгож аваачдаг дугуйтай зөөлөн сандал дээрээ сууж байлаа. Өмнө нь тасалгаан доторх бүх юм харагдах том толь тавьсан бөгөөд өвгөн хөдлөлгүйгээр (ерөөсөө ч хөдөлж чаддаггүй байсан юм) хэн орж ирж, гарч байгааг, эргэн тойронд нь юу болж байгааг харж чадна. Үхсэн хүүр мэт хөдөлгөөнгүй тэр хүн ёсорхон мэндлэх байр нь чухал гойдын юм хэлэх гэж байгаа янзтай хүүхдүүдээ ухаалаг сэргэлэн нүдээр харж байлаа.

Дөрөвний гурав нь булшинд очиход бэлэн болсон энэхүү биед амьд оч ганц үлдсэн мэдрэхүй нь хараа сонсгол хоёр л байлаа. Энэ хоёр мэдрэхүйн зөвхөн нэг нь хөдөлгөөнгүй ангид үлдэж хоцорсон дотоод амьдралын нь бүлээн амьсгалыг гэрчлэх ганц зүйл болсон бөгөөд саях дотоод амьдралыг нь илэрхийлсэн нүдний нь харц эзгүй цөлд төөрөн тэнүүчилж яваа хүнд, энэхүү чив чимээгүй, харанхуйн дунд амьт амьтан байгааг зааж, алсад гялсхийн зоригжуулах гэрэл лугаа адЭл ажээ.

Мөрөө хүртэл унжуулсан үс нь цал буурал болсон байхад, өвгөн Нуартъегийн налмайн буусан хар хөмсөгтэй хар нүдэнд нь цагтаа түүний бие цогцос, ухаан санааг амьдруулж байсан бүх хүч чадал, зориг хатуужил тэнхээ тамир, бүх оюун ухаан нь хуран төвлөрчээ. ерөөс ямарваа эрхтнийг төлөөлөн үлдсэн эрхтэн гойд хөгждөг билээ. гар нь хөдлөхгүй, хоолой нь дуугарахгүй, бие нь хөшсөн боловч, энэ бүхнийг захирангуй харц нь орлож чадах ажээ. Тэр харц нь тушаал өгч, баяр талархлыг илэрхийлнэ. Энэ бол зөвхөн нүд нь л амьд үдсэн хүүр байлаа. Дээд хэсэгт нь хорсол хилэн буцалж байгаа ч юм уу, баяр хөөрийг нь илэрхийлэх энэ хөдөлгөөнгүй энэ гөлгөр царайнаас илүү аймшигтай юм гэж үгүй байх. Саад дайрагдсан энэ золгүй өвгөний дохиог зөвхөн Вильфор, Валентина, бас хөгшин зарц нь л ойлгоно. Вильфор хэрэг болохоор л хааяа нэг эцэг дээрээ орж ирж уулздаг байв. Тэгэхэд нь сэтгэлд тааруулахыг хичээхгүйгээр барахгүй, ганц ач охин нь өвгөний сэтгэлийг дэвтээдэг гэдгийг ойлгодоггүй ажээ. Валентина өвгөн аавдаа хайртай зориг тэсвэртэйн ачаар Нуартъегийн бүх санаа бодлыг нь харцаар нь тааж сурчээ. энэ хэнд ч үл ойлгогдом дохио ярианд Валентина охин өөрийн дуу хоолой, царай зүс, бүх л бие сэтгэлээрээ хариулдаг болохоор залуу бүсгүй хүүр болсон хөгшин өвгөнтэй хөгжүүн яриа хөөрөн дэлгэдэг байв. Амьдрал нь бөхөх тийшээ хандсан энэ хүн асар их мэдлэгтэй, юмны учир утгыг хараад андахгүй хянуур, бие цогцос нь мэдрэлгүй болон шаналж байгаа хүнд байж болохын хирээр хатан зориJ, хатуужилтай хэвээр байв.

Валентина ийнхүү өвгөний санаа бодлыг ойлгох ба өөрийн санаа бодлыг ойлгуулах амаргүй хэргийг гүйцэтгэж чаддаг болжээ. Ийм чадварынхаа ачаар өдөр тутмын ердийн юманд энэ амьд оюун сэтгэхүйн хүсэл, тал мэдрэлтэй хүүрийн хэрэгцээг огтхон алдаагүйг тааварлаж, мэдэхгүй байх тохиолдол бараг үгүй байлаа.

Барруагийн тухайд гэвэл, энэ хүн Нуартъед хорин таван жил зарагдсаар эзнийхээ бүх л дадал заншил бүхнийг сайн мэдэх болсон учир өвгөн түүнээс ямар нэг юм хүсэх нь бараг тохиолддоггүй байлаа.

Вильфор ярих гэж ирсэн хачин зүйлээ эцэгтээ хэлэхэд хэний ч туслалцаа хэрэггүй байлаа. Бидний дээр хэлсэнчлэн Вильфор өвгөнтэй маш сайн ойлголцдог байсан боловч зөвхөн хайхрамжгүйгээсээ болоод тэгж цөөхөн орж ирдэг юм сан жээ. Тэгээд л Вильфор Валентинаг цэцэрлэгт зугаал гэж явуулаад, Барруаг мөн гаргаж орхиод өөрөө өвгөний баруун гарт суухад, хатагтай Вильфор зүүн талд нь суулаа.

- Валентина бидэнтэй хамт ирээгүй. Барруаг гадагш гаргасан явдлыг эрхэмсэг та бүү гайхаарай. Бидний энэ ярих гэж байгаа зүйл бол охин ба зарцын дэргэд ярьж болохгүй байгаа юм. танд хэлэх нэг зүйл хатагтай Вильфор бид хоёрт байна гэж Вильфор хэллээ.

Энэ бүхнийг дуугарахад Нуартъегийн царай огт санаанд ч үгүй мэт байхад, харин Вильфоры харц дотроо чухам юу бодож байгааг мэдэх гэж шүлэнгэтэн байлаа.

- Бидний дуулгах зүйл таны таалалд нийцэх байх гэж бид хоёр найдаж байн гэж вангийн прокурор, ердийнхөөрөө хүн өөдөөс нь огтхон ч зөрөхийн аргагүй тулгасан байртай хэлэв.

Өвгөний харц бас л хөдөлгөөнгүй хэвээр бас зүгээр чагнаж суулаа.

- Бид Валентинагаа хүнтэй суулгах гэж байгаа.

Энэ үгийг дуулсан лаан баг ч өвгөний царайнаас илүү хүйтэн байж чадахгүй биз ээ.

- Гурван сарын дараа хуримыг нь хийнэ гэж Вильфор цааш нь хэлэв.

Өвгөний нүд ч бас амьгүй юм шиг хэвээрээ байлаа. Тэгтэл хатагтай ярианд оролцож,

- Таныг энэ мэдээг лав сонирхох байх гэж бодоод бид дуулгаж байгаа юм гэж яаравчлан хэлээд – Тэгээд ч та Валентинад их дассан хүн шүү дээ. тэгэхээр Валентинатай ханилах гэж байгаа залуугийн нэрийг нь хэлэх л дутаад байна. энэ бол Валентинатай суулгаж болох шилдэг залуусын нэг юм. Валентинатай суулгах гэж байгаа тэр хүн, та ч бараг нэрийг нь мэдэх байх даа, удам угсаа сайтай, баян, зөв шулуун явдалтай, зан барил сайта, охиныг минь аз жаргалтай байлгахын баталгаа болно. Франц де Кенель, де Эпинегийн гүнг бид хэлж байна л даа.

Вильфор эхнэрийгээ ярьж байх зуур өвгөний царай өөд урьдынхаасаа улам хянуур харж байлаа. Хатагтай Вильфор Францын нэрийг дөнгөж хэлмэгц хүүгийнх нь сайн мэдэх нүдний харцанд нэг юм хөдлөх шиг болж, юм хэлэх гэж ангайсан уруул мэт дутуу аниастай зовхины нь цаана с цахилгаан цахилах мэт боллоо.

Өөрийн нь эцэг дээр үед Францынөстөн явсныг вангийн прокурор мэдэх учир ийнхүү өвгөний сэтгэл д@гдлон үймэрснийг мэдэс ажээ. Гэвч хараагүй вч шиг дүр үзүүлж эхнэрийнхээ яриаг залган авч,

- Одоо удахгүй хорь хүрэх шахаж байгаа Валентинагаа төвхнүүлж тохижуулах явдал ямар чухал байгааг ат сайн ойлгож байгаа. Бид энэ асуудлыг ярилцахдаа таныг бас мартаагүй. Валентинагийн нөхөр залуу хосод эвгүй санагндаад бидэнтэй хамт суухыг зөвшөөрдөггүй юм аа гэхэд таныг тэдэнтэй хамт суухаар урьдчилан зөвшөөрөн ярьж тохиролцсон. Валентина танд хайртай, та ч бас түүнд сайн шүү дээ. ингэхлээр таны дасаж сурсан амьдрал юугаар ч өөрчлөгдөхгүй. Харин ялгаа нь зөвхөн нэг хүүхэд таны асардаг байсан бол одоо хоёр болох юм гэв.

Нуартъегийн гялалзсан хоёр нүд цусаар бүрхлээ. Өвгөний сэтгэл зүрхэн дотор ямар нэг аямшигтай зүйл болж байгаа бололтой. Царай нь хүрэгтэй, уруул нь хөхөрсөн байхыг харвал, хорсол занала гаргаад хашгирчихаж чадахгүй болохоор дотроо бачимдан багтарч байгаа бололтой.

Вильфор тайван байдлаар цонх онгойлгож,

- Энд их бүгчим байгаа болохоор Нуартъе гуайн амьсгаа давхцаж байх шиг байна гэж хэлээд эргэж байрандаа ирсэн боловч суусангүй зогслоо.

Тэгэхэд хатагтай түрүүчийн ярьсан дээр нэмж,

- Энэ гэрлэлт де Эпине гуай болон түүний төрөл садангуудын сэтгэлд нийцэж байгаа юм. төрөл садансаад байх юмгүй. Зөвхөн л авга ах эгч хоёр нь байдаг юм. эх нь түүнийг төрүүлэхдээ нас барсан, эцэг нь хүүгээ хоёрхон настай байхад буюу мянга найман зуун арван таван онд алагдсан. Тэгэхээр д Эпине өрөө өөрийгөө л мэдэх хүн гэж ярихад, Вильфор,

- Сэжигтэй алагдсан юм. алсан хүн нь олдоогүй өнгөрсөн. Олон хүнийг сэжиглэсэн боловч хэнийг нь ч мэдэж чадаагүй билээ гэж хэлэв.

Нуартъе инээмсэглэх дүр үзүүлэх гэж байга мэт их л хүчлэн, уруула мурийлгав.

- Үнэхээр гэмт хэрэг үйлдсэнээ өөрсдөө мэдэж байгаа, амьд насандаа хүн төрөлхтөний шдарга үнэний шүүхээр цээрлүүлэгдэж болох хүн бол бидэн шиг ингэж охиноо Франц де Эпинед өгч ямар нэг сэжиглэлийг үгүй хийх бололцоо олдож байгад баярлахсан даа гэж Вильфор хэлэв.

Нуартъе саагийн гэмт дайрагдаж арчаагүй болсон хүнээс гарна гэж санамгүй их зориг чадлаар биеэ барьж байлаа.

- Тийм ээ би таны хэлж байгааг ойлгож байна гэсэн маягтайгаар өтгөн Вильфорын өөд харсан бөгөөд энэ харцанд нь гүн жигшил хорсол илэрнэ.

Вильфор энэ харцыг сайн ойлгож хариуд нь мөрөө хавчисхийв.

Тэгээд эхнэртээ бос гэсэн дохио өглөө.

- Одоо бид явахыг зөвшөөрнө үү? гэж хатагтай хэлээд – Эдуарыг дуудаж тантай мэндчилүүлбэл яана? гэж асуулаа.

Өвгөн нүдээ анивал зөвшөөрч байгаагийн, анивчиж байвал үгүй гэсний тэмдэг байлаа. Ямар нэг зүйлийг хүсвэл дээшээ тэнгэр өөд харна.

Хэрвээ Валентинаг дуудвар зөвхөн баруун нүдээ анина. Барруаг дуудах гэвэл зүүн нүдээ анина.

Өвгөн хатагтайн үгийг сонсоод нүдээ түргэн анивчлаа.

Хатагтай Вильфор илтэд татгалзаж байгааг мараад илтэд хөмхийгөө зуулаа.

- Тэгвэл Валентинаг нааш нь ирүүлэх үү? Гэж хатагтайг асуухад

- Тэг гэж өвгөн даруй нүдээ анилаа.

Тэгээд тэр хоёр бөхийн ёслоод гарангаа Валентинаг дууд гэж тушаав. Үдийн хирд өвгөн ав дээрэ ирээрэй гэж охинд урьд нь хэлчихсэн байжээ.

Валентина сандарснаас болж царай нь ягаан хэвээр орж ирлээ. Охин орж ирээд өвгөн ааваа хармагц түүний яаж зовж байгаа, өөртэй нь ярихыг хир их хүсэж байгааг даруй ойлгов.

- Өвгөн аав та юу болов? Таны дургүйг хүргээ юу? Та уурлаж байна уу? гэж Валентина дуу алдан асуухад өвгөн нүдээ аньж

- Тийм гэж хариуллаа.

- Хэнд уурлаа вэ? Манай эцэгт үү? үгүй юу? Хатагтай Вильфорт уу? Үгүй юү? Надад уу?

Өвгөн тийм гэдэг дохио өглөө.

- Би ямар буруу юм хийчихээв гэж Валентина дуу алдахад өвгө хариу дуугарсангүй тул бүсгүй цааш нь

- Би өнөөдөр тантай уулзаагүй байсан. Хүн миний тухай ямар нэгэн юм танд хэлээ юу? гэж асуулаа.

- Тийм гэж өвгөний харц яаран хариулав.

- Чухам юу болсныг таах гэж оролдоод үзье. Бурхан минь, үгүй шүү өвгөн аав аа...Аа мэдлээ... Вильфор гуай хатангтайгаа хамт саяхан орж ирээд гарсан уу?

- Тийм ээ.

- Таныг цухалдуулсан тэр зүйлийг хэлээ юу? Тэд юу гэж хэлсэн байж таарах вэ? Би танаас юуны учир уучлалт гуйх болсныг би тэднээс асуух уу?

- Үгүй, үгүй гэж өвгөний харц хариуллаа.

- Та намайг айлгачихлаа. Тэд ву гэж хэлсэн бол гээд залуу бүсгүй бодлогшров. Тэгээд өвгөнд ойртож ирээд намуухан дуугаар

- Би одоо л ойлголоо. Намайг хүнтэй суулгах гэж тэд ярьсан уу?

- Тийм гэж харц нь хорсоон маягтай хариуллаа.

- Ойлголоо. Та намайг хэлсэнгүй гэж уурлаж байх шиг байна. тэд намайг энэ тухай танд огт хэлж болохгүй гэж хатуу хориглосон юм. тэд надад юу ч хэлээгүй. Би санамсаргүй явж байгаад л тэр нууцыг мэдчихсэн юм. иймээс л би танд хэлээгүй байсан. Өвгөн аав минь уучлаарай.

Харц нь дахин хөдөлгөөнгүй хайхрамжгүй болж “Зөвхөн чиний хэлээгүй чинь намайг гомдоогоогүй” гэж хэлэх шиг боллоо.

- Чухам юу болоо вэ? Би тхүнтэй суугаад таныг орхичихно, таныг мартчихна гэж та бодоо юу?

- Үгүй гэж хариуллаа.

- Де Эпине гуай бидэнтэй хамт суухыг зөвшөөрч байгаа гэжтэд танд хэлсэн үү?

- Тийм.

- Тэгвэл та юунд уурлаад байгаа юм бэ? гэхэд өвгөний нүдэнд хязгааргүй их хайр энхрийллийн шинж илэрлээ. Тэгэхэд Валентина

- Та нада хайртай болоод тэр шүү дээ? гэхэд өвгөн тийм гэдэг дохио өглөө.

- Та надаас аз жаргалгүй хүн болчихно гэж бодоо юу?

- Тийм.

- Та Францад дургүй юу?

Өвгөний нүд хэдэн удаа дараалан

- Дургүй, дургүй дургүй гэж хариулав.

- Өвөө та их зовиуртай байх шиг байна?

- Тийм.

Өвгөн ааыгаа ингэж хэлэхээр Валентина түүний дэргэд ирж сөхрөн суугаад хүзүүгээр нь тэвэрч,

- Тэгвэл надад ч гэсэн их хэцүү байна. би Франц де Эпинед сэтгэлгүй гэлээ.

Өвгөний нүдэдн баярласны тэмдэг илэрлээ.

- Намайг сүмд очиж сууна гэж байхад та ямар их уйрласнаа санаж байна уу?

Өвгөний хатсан зовхин дотор нулимс гүйлгэнэж харагдав.

- Намайг аргагүй абйдалд оруулсан энэ гэрлэлтээс л зайлах гэсэндээ тэгсэн юм гэж хэлэхэд өвгөний амьсгаа давхцаж ирлээ.

- Тэгвэл өвгөн аав та гэрлэлтэд тун их дуогүйцэж байна уу? Аа харла та надад тус болж чаддаг ч болоосой. Бид хоёр тэдний энэ төлөвлөсөн юманд саад хийж чаддаг ч болоосой. Та хэдийгээр ийм саруул ухаантай,сэтгэл зориг чинь хүчтэй ч гэсэн тэдний өмнө хүч чадалгүй л дээ. Тэмцэх болоход та надаасаа ч дорой юм. Та хүч чадалтай, эрүүл энх байсан болнамайг хамгаалж чадах байсан, харин одоо бол миний байдлыг мэдэж надтай хамт баярлах буюу гунихарч суухаас өөр юмгүй болжээ. Энэ бол бурхан надаас булааж авахаа мартсан сүүлчийн аз завшаан юм.

Валентинаг ингэж хэлэхэд Нуартъегийн нүдэнд залирхаг байдал илэрч,

- Чи андуурч байна, би бас ч чиний төлөө их юм хийж чадна гэж хэлэх шиг жаал бүсгүйд санагджээ.

- Өвгөн аав та надад тус болж чадах уу? гэж Валентина түүний бодлыг үгээр илрүүлэн гаргалаа.

- Тийм.

Нуартъе дээшээ харлаа. Энэ бол ямар нэг хүсэлтэй байгаагаа илэрхийлсэн тэр хоёрын хоорондын дохио байлаа.

- Та юу гэх гээ вэ?. Би таны хэлэх гэсэн зүйлийг чинь ойлгох гэж оролдоод үзье гэж Валентина хэлээд санаандаа орсон зүйлийг хэлж эхэллээ. Гэвч өвгөн бүгдэд нь “ Үгүй” гэж хариулна.

- За тэгэхээр би нэгэнт л тааж чадахгүй байгаа болохоор шийдвэртэй арга хэрэглэе гэж охин хэлээд цагаан толгойн үсгийг А-гаас эхлээд Н хүртэл дуудлаа. Ингэж дуудах зуураа охин саагийн гэмд дайрагдсан өвгөний нүдийг инээмсэглэн ажиглаж байлаа. Охин уншсаар Н үсэгт хүрэхэд өвгөн мөн гэсэн дохио үзүүллээ.

- Тэгвэл таны хүсэж байгаа зүйл чинь Н үсгээр эхэлсэн үг үү? Н үсгэнд л хамаг учир байх нь ээ? На,Ни,Но...гэж уншлаа.

- Тийм,тийм гэж өвгөн хариулав.

- Тэгвэл Но юм уу?

- Тийм.

Валентина толь бичиг авчирч түүний өмнө тавиур дээр дэлгэж тавилаа. Өвгөн хуудас руу харж байгааг мэдмэгц охин хуруугаараа дээрээс нь доош түргэн заалаа.

Зургаан жилийн өмнө Нуартъег одоогийнхоо энэ байдалд орсноос эхлээд Валентина түүний санаа бодлыг толь бичгээс түргэн олж, тааварлан мэдэж сурчээ.

Нотариат гэдэг үгэнд хүрэхэд өвгөн зогс гэж дохилоо.

- Нотариат уу, та нотариатын хүнтэй уулзах гээ юү? гэж бүсгүйн асуухад өвгөн үнэхээр нотариатын хүнтэй уулзах хүсэлтэй байгаагаа харууллаа.

- Тэгвэл нотариатын хүн ирүүлэх үү гэж Валентина асуухад өвгөн толгой дохилоо.

- Энэ тухай аав мэдэх хэрэгтэй юм уу?

- Тийм.

- Нотариатын хүн танд яаруу хэрэгтэй байна уу?

- Тийм.

- Одоо хүн явуулъя. Хэрэгтэй юм чинь ердөө л энэ үү?

- Тийм.

Вильфорыг хатантай нь урьж ирүүлэхийг зарцад хэлэх гэж Валентина босч хонх өөд очлоо.

- Санаа тань амрав уу? Таахад бас хэцүү байлаа шүү гэж Валентина асуугаад өвгөн аав өөдөө хүүхдэд инээмсэглэх адил инээмсэглэв.

Баруа Вильфорыг өвгөний тасалгаанд авчирахад, саагийн гэмд дайрагдсан өвгөнөөс

- Эрхэмсэг та юу гэх гээ юм бол? Гэж асуулаа.

- Ааваа, өвгөн аав нотариатын хүнтэй уулзах гэсэн юм гэж Валентина хэллээ.

Вильфор энэ хачин, гол нь санаанд оромгүй юмыг сонсоод саагийн гэмт дайрагдсан өвгөн өөд харлаа.

- Тийм гэж өвгөн долхио өгөх нь түүний хүслийг мэдэж байгаа өвгөн зарц, Юалентина хоёрын тусламжтайгаар тэмцэхэд бэлэн байгаагаа харуулав.

- Та нотариатын хүнтэй уулзах гээ юү? гэж Вильфор давтан асуулаа.

- Тийм.

- Яах нь вэ?

Нуартъе юу ч хариулсангүй.

- Нотариатын хүн танд ямар хэрэг болоо вэ? хэмээн Вильфорыг асуухад өвгөний харц хөдөлгөөнгүй боллоо. Энэ нь “Би үүнийг шаардаж байна” гэсэн үг ажээ.

- Ямар нэг юмаар бидний хорыг маажих гэж үү? Энэ юунд хэрэгтэй юм бэ? гэж Вильфор асуухад Барруа санасандаа хүрэх гэдэг хөгшин зарц нарын заншлаар,

- Миний эзэн нотариатын хүнтэй уулзах гэж байгаа бол хрэгтэй болоод л тэр. Би одоо түүнийг олж ирэхээр явлаа гэв.

Барруа Нуартъегээс өөр хэнийг ч эзнээ гэж боддоггүй бөгөөд хэн ч санаснаас нь буцааж чаддаггүй ажээ.

- Тийм би нотариатын хүнтэй уулзах гэсэн юм гэсний тэмдэг болгон өвгөн нүдээ аньсан нь “Миний хүслийг биелүүлэхгүй байж зүрхлэхийг нь үзэмз” гэж хэлж байх адил байлаа.

- За яах вэ, та тэгж шаардаад байгаа бол нотариатын хүн авч ирэг. Харин энэ явдал их л инээдэмтэй явдал болох учраас би тэдний өмнө өөрийнхөө болоод таны өмнөөс уучлалт гуйх хэрэг болох ь.

- Хамаагүй, би очиж авчирна гэж Барруа хэллээ.

Тэгээд хөгшин зарц дийлж гарч одлоо.

2. Гэрээслэл

Барруа тасалгаанаас гарч одоход Нуартъе, ач охин өөдөө их залирхаг маягаар учиртайхан харлаа. Валентиан энэ харцыг ойлголоо. Вильфорын царай барайж хөмсөг нь хөдөлснийг харвал тэр ч бас ойлгосон бололтой.

Тэрээр сандал авч саад дайрагдсан өвгөний өөдөөс харан сууж, юу болохыг хүлээлээ. Нуартъе түүний өөдөөс харж огтхон ч хайхрамжгүй суух боловч, нүднийхээ булангаар Валентинад санаа зовох юмгүй, эндээ байж бай гэж хэллээ.

Барру дөчин таван минут хиртэй болсны дара нотариатын хүн дагуулж ирлээ.

Вильфор ирсэн хүнд мэндлээд,

- Эрхэм таныг энд сууж байгаа Нуартъет де Вильфор дуудсан юм. саа өвчин энэ хүнийг хөдлөх ба дуу авианаас нь хагацаасан учир зөвхөн бид хэдхэн л түүний санааг ойлгох гэж тун их оролдож байж хагас заримыг нь тааж мэддэг юм гэлээ.

Нуартъе Ювалентина өөд сүрхий захирангуй харцаар харахад Валентина тэдний дундуур орж,

- Эрхэм ээ, би өвгөн аавынхаа юу хэлэ гэж байгааг бүхнийг ойлгодог юм гэлээ.

- Энэ үнэн. Бүр бүгдийг нь мэддэг юм. би танд замдаа хэлсэн шүү дээ гэж Барруа хэлэв.

- Эрхэмүүд ээ гэж нотариат Вильфор Валентина хоёрт хандаж,

- Энэ бол албаний хүн болгоомжгүй хөнгөн хийсвэр ажиллачихаад өөрийгөө хүнд хариуцлагад унагаж мэдэх тийм хүнд хэргүүдийн нэг байна. Энэ баримтыг хууль ёсны болгохын тулд нотариусын хүн өөрөө цаад хүний хүтэл зорилгыг үнэн зөв дамжуулсан гэдэгтээ итгэлтэй байх хэрэгтэй юм. Юм ярьж чадахгүй болсон хүнийг зөвшөөрч байгаа юм уу эсвэл хүсээгүф байгаа юмыг нь би мэдэж чадахгүй болохоор миний оролцоо огт ашиггүй, хуулийн эсрэг хэрэг болно гэж хэлэв.

Тэгээд нотариус явах гэлээ. Вангийн прокурорын уруул дээр дийлсний тэмдэг болсон үл мэдэг инээмсэглэл үзэгдлээ. Нуартье Валентина өөд их л гунигтай байдлаал харахад бүсгүй нотариатын гарах замыг хөндөлдөн зогсоод,

- Би өвгөн аавтайгаа ярилцдаг тэр хэл бол сурахад маш амархан. Хэдхэн минутын дотор таныг өөр шигээ сайн ойлгодог болтол сургаж чадна. Харин таны сэтгэл бүрэн тайван байхад юу хэрэгтэйг хэлж өгнө үү?

- Манай баримт бичиг хууль ёсны болоход гагцхүү уг хүн зөвшөөрсөн буюу зөвшөөрөөгүйд нь итгэлтэй байх явдал юм. Гэрээслэгч хүн бол бие нь өвчтэй байлаа ч ухаан санаа нь эрүүл байх ёстой.

- Өвгөн аавын ухаан одоо хэзээ хэзээнийхээсээ илүү саруулхан байгааг хоёр л дохио танд итгүүлэх болно. Дуугарах авиа, хөдлөх хөдөлгөөн нь үгүй болсон Нуартье гуай “Тийм” гэж хэлэхээрээ нүдээ аньдаг, “Үгүй” гэхээрээ нүдээ хэдэн удаа анивчдаг юм. Та одоо түүнтэй ярихад хангалттай зүйлийг мэдэж авлаа. Өөрөө оролдоод үз.

Валентина өөд харсан өвгөний харц хайр талархлаар дүүрсэн байлаа. Үүнийг нотариус ч ойлгожээ.

- Эрхэм та ач охиныхоо хэлсэн бүхнийг сонсож ойлгов уу? гэж нотариус асуухад, Нухртье нүдээ аажуухан аниад алгуурхан нээлээ.

- Тэгвэл та ач охиныхоо хэлсэн бүгдийг баталж байна уу? Өөрөөр хэлбэл, та хүсэл санаагаа бусдад дамжуулдаг зүйл тань эдгээр дохионууд мөн үү?

- Тийм гэж өвгөн дохилоо.

- Та намайг урьсан юм уу?

- Тийм.

- Гэрээслэлээ хийлгэх гэж үү?

- Тийм.

- Та намайг энэ гэрээслэлийг хийлгүй битгий яваасай гэж хүсч байна уу?

Саад дайрагдсан өвгөн нүдээ түргэн, түргэн анивчлаа.

За одоо та түүнийг ойлгож байгаа биз дээ гэж Валентина асуугаад,- Таны сэтгэл тайван байж болно биз гэлээ.

Гэвч нотариус хариу хэлэхээс өмнө Вильфор түүнийг хажуу тийш нь аваачиж,

- Нуартье де Вильфор гуайн биеийн энэ аймшигт гэмтэл ухаан санааны нь чадварт их хэмжээгээр нөлөөлөөгүй гэж та үзэж байна гэж үү? хэмээн хэллээ.

- Зөвхөн энэ ч биш, харин түүний санаа бодлыг яаж гаргаж мэдэх вэ? гэдэг явдал миний сэтгэлийг зовоож байна гэж цаад хүн хариулахад Вильфор,

- Тийм бололцоо байхгүй байгааг та харж байгаа биз дээ гэлээ.

Валентина өвгөн хоёр энэ яриаг дуулав. Нуартье Валентина өөд их л шийдэмгий байдлаар ширтэн харлаа. Энэ харц нь бүсгүйг үгээ хэлээч гэсэн нь илэрхий байлаа.

- Эрхэми та энэ тухай бүү санаа зов. Миний өвгөн аавын санаа бодлыг ойлгоход хэцүү ч гэсэн үнэнийг хэлэхэд танд тэгж санагдаж байвал, би танд ямар ч эргэлзээ төрүүлэхгүйгээр нСэн хэлж өгч чадна. Би Нуартье гуайн дэргэд байх болсноос хойш зургаан жил болж Уайна. энэ завсартүүний ямар нэг хүслэ михий ойлгохгүйгээс болоод зүрх сэтгэлд нь хадгалагдан үлдсэн явдал ганц ч гэсэн удаа тохиолдсон эсэхийг өөрөө хэлж өгөг гэж охиынг хэлэхэд өвгөн,

- Үгүй хэмээн дохилоо.

- Тэгвэл туршаад үзье л дээ. та мадмаузель де Вильфорыг өөрийнхөө хэлмэрч болгохыг зөвшөөрч байна уу? гэж нотариус асуухад, саад дайрагдсан өвгөн,

- Тийм гэж дохилоо.

- Их сайн байна. тэгвэл эрхэмсэг та надаас юу хүсэж, ямар баримт хийлгэж гэж хүсэхсэн бол?

Валентина цагаан толгойг эхнээс нь уншиж Г үсэгт хүрэхэд Нуартьегийн харц зогс гдэг дохио өглөө.

- Нуартье гуайд Г үсэг хэрэгтэй байга юм байна. энэ ч яахав тодорхой байна гэж нотариатын хүн хэлэхэд, Валентина

- Байзаарай хэмээн өвөө өөдөө харж – Гэ үсэг үү? Гэж хэлтэл өвгөн охиныг тэр дор нь зогсоолоо.

Тэгэхэд Валентина толь бичиг авчирч анхааралтай ажиглан харж байгаа нотариусын нүдний өмнө хуудсыг нь эргүүлж гарлаа. Тэгээд гэрээслэл гэдэг үгэн дээр очиход өвгөний харц түүнийг зогсоолоо.

- Гэрээслэл ий? Энэ тогдорхой боллоо. Эрхэм Нуартье гэрээслэлээ хийлгэх гэж байгаа юм байна гэж нотариатын хүн дуу алдлаа. Тэгэхэд Нуартье хэдэн удаа,

- Тийм гэж дохио өглөө.

- Энэ үнэхээр гайхалтай хэрэг болж байгааг та ч өөрөө зөвшөөрөх биз гэж нотариатын хүн гайхсан Вильфорт хэлэхэд цаадах нь,

- Илүү их гайхалтай нь тэр гэрээслэл гээч нь болох байх даа. миний охины уран чадмаг хэллэггүйгээр, тэр гэрээслэлийн зүйл нгиуд бүрэн дүүрэн гарч, цаасан дээр бичигдэнэ гэдэгт би ямар ч л байсан эргэлзэж байна. аа, Валентина маань эрхэмсэг Нуартье де Вильфорын энэхүү хэнд ч мэдэгдэхгүй байгаа битүү далд хүслийг тайлбарлах гэж дэндүү их сонирхож байж болох юм.

- Үгүй, үгүй гэж өвгөн дохилоо.

- Яалаа гэнэ э, Валентина таны гэрээслэлд сонирхолгүй байх нь ээ? гэж Вильфор хэлэхэд,

- Үгүй гэлээ.

Тэгэхэд энэ хийсэн туршлагандаа сэтгэл нь хөөрч энэ сонирхолтой тохиолдыг олонд ярина гэж бодож байсан нотариат,

- Эрхэм минь, тун саяхан огт бололцоогүй гэж миний бодож байсан зүйл харин одоо маш амархан юм шиг санагдаж байна. энэ бол ердөө л нууц гэрээслэл. Өөрөөр хэлбэл долоон гэрчийн этгээдийн дэргэд хийгдэж, гэрээслэгч хүн тэдний дэргэд баталж, бас энэ гэрээслэлийг нотариатын хүн тэдний дэргэд битүүмжилсэн бол хүчинтэйд үзнэ гэж хуулиар зөвшөөрөгдсөн гэрээслэл юм байна. энэ бол ердийн гэрээслэл бичихээс илүү хугацаа бараг шаардахгүй. Юуны өмнө хуулиар тогтоосон өөрчлөшгүй жаягт байдаг юм. харин тодорхой зүйлүүдийн тухайд гэвэл гол нь гэрээслэгчийн хэргийн байдал ба уг хэргийг хөтөлж байгаа та нараар дамжуулан хэлүүлж болно. Энэ баримтыг маргашгүй болгохын тулд би үүнийг үнэн зөвөөр хийнэмз. Тэгэхээр найз нөхдийн маань нэг, миний туслагч болж, ердийн заншлаас өөр гэрээслэл бичих болно. Энэ таны сэтгэлд нийцэх үү? гэж өвгөнөөс асуулаа. Өвгөн өөрийнх нь санаа бодлыг ойлгосонд нь баярлан,

- Нийцнэ гэлээ.

Тэгэхэд эцгийнхээ яах гэж байгааг мэдэж чадахгүй, бас тэгээд өндөр тушаалаас болоод биеэ барьж сурсан Вильфор “Юу бодоо юм бол?” хэмээн бодож учрыг нь олохгүй гайхан суулаа.

Тэгээд нотариатын хүн хоёр дахь хүнийг ирүүлэхээр хүн явуулах гэж эргэн хартал харин энэ яриаг дуулж эзнийхээ хүслийгтааварлан мэдсэн Барруа аль хэдийн гараад явчихсан байлаа.

Тэгэхээр нь вангийн прокурор эхнэрээ дуудууллаа.

Арван таван минутын дараа бүх хүн цугларахад нотариатын хоёр дахь хүн ч ирлээ. Тэгээд дараа нь түүний ухаан санаа сарууд эсэхийг шалгаж үзэх гэсэн мэт түрүүчийн хүн нь өвгөнд хандаж,

- Гэрээслэлийг чинь ямар нэг хүний ашиг тусын тулд хийдэг шүү дээ гэхэд өвгөн,

- Тийм гэлээ.

- Та өөрийнхөө хөрөнгөний хэр хэмжээг мэддэг үү?

- Мэднэ.

- Би танд аажмаар нэмэгдэх хэдэн тоо хэлье. Тэгэхээр та өөрийнхөө хэрэгтэй тоонд хэрэхээр намайг зогсоогоорой.

- За.

Болж байгаа хэрэг явдал ихэд ёсорхог байртайгийн дээр хүний ухаан санаа, сульдаж доройтсон бие махбодоо санаанд багтамгүйгээр шаргуу хүчлэн дийлж бидний золтой л хэлчихсэнгүйгээр ихэд гэгээн үзэгдэл биш юм аа гэхэд лав л сонирхолтой зүйл байлаа.

Хүмүүс цөм өвгөний дэргэд шавлаа. Нотариатын хоёр дахь хүн ширээнд суугаад бичихэд бэлдэв.

- Таны хөрөнгө гурван зуун мянган франкаас илүү биз, тийм үү? Гэхэд өвгөн зөвшөөрсөн дохио өглөө.

- Тэр хөрөнгө дөрвөн зуун мянгаас илүү байх аа? гэхэд өвгөн бас л хөдөлгөөнгүй хэвээр байлаа.

- Таван зуун мянга уу?

Бас л хөдөлсөнгүй.

- Зургаан зуу, долоон зуу, намйан зуу, есөн дун мянга уу? гэхэд өвгөн зогс гэсэн дохио өглөө.

- Та тэгвэл есөн зуун мянган франкийн хөрөнгөтэй юм уу?

- Тийм.

- Үл хөдлөх үү? Гэж нотариат асуухад өвгөн үгүй гэлээ.

- Улсын хүүтэй тэмдэгтээр үү? Гэхэд тийм гэлээ.

- Тэр тэмдэгтүүд таны гар дээ байгаа юу?

Нуартье Баруа өөд харахад зарц тасалгаанаас гарч минутыг дараа жижигхэн хайрцаг барьсаар орж ирлээ.

-Та энэ хайрцгийг онгойлгохыг зөвшөөрөх үү? Гэж асуухад Нуартье зөвшөөрсөн дохио өглөө.

Хайрцгийг онгойлгоход дотор нь есөн зуун мянган франкийн улсын сангийн мөнгөн тэмдэгт байлаа. Тэд тэмдэгтүүдийг тоолж үзэхэд Нуартъегийн хэлсэн хэмжээ яг мөн байв. Тэгээд тэд,

- Цөм зөв байна. Ухаан нь саруул тунгалаг байна гэж хэлээд өвгөн өөд харж,
- Тэгэхээр та есөн зуун мянган франкийн хөрөнгөтэй, түүнийхээ тэмдэгт цаасны ачаар жилд дөчин мянган франкийн орлоготой байдаг юм уу? гэж асуув.
- Тийм гэж Нуартъе дохилоо.
- Та энэ хөрөнгөө хэнд үлдээх гэж байгаа юм бэ?
- Энд эргэлзэх юмгүй. Нуартъе гуай ач охин Мадмуазель Валентина де Вильфорт л хайртай. Валентина зургаан жил өвгөнийг сувилж байгаа юм. Валентина эцэж цуцалгүй харж асарч байсан учир түүний хайрыг хүлээсэн юм. Ийм учраас Валентина өөрийн үнэнч шудхргын хариу шанг хүртэх нь шударга хэрэг болно гэж Вильфор авгай хэллээ.

Вильфор авгай ийнхүү хуурмагаар өөрийн нь санаанд тааруулсан болж чадаагүйн гэрч гэмээр Нуартъегийн харц дүрсхийв.

- Тэгвэл та энэ есөн зуун мянган франкийг Валентина охинд үлдээх гэж байгаа юм шив дээ? гэж нотариус асуув.

Тэгэхэд Валентина ялихгүй хажуу тийшээ болоод толгойгоо унжуулан уйлав. Өвгөн түүнийг их л энхрийлсэн байдлаар харлаа. Дараа нь нотариус өөд харж нүдээ анивчив.

- Үгүй гэнэ. Таны өв залгамжлагч болох ганц хүн Валентинад хөрөнгөө үлдээхгүй гэж үү?, гэхэд , өвгөн үгүй гэдгээ батлан дохилоо.
- - Та андуураагүй биз? Та үнэхээр үгүй гэж хэлж байна уу? хэмээн өнөө нотариус хүн гайхан асуухад,
- Үгүй, үгүй гэж Нуартъе давтан хариуллаа.

Валентина толгойгоо өндийлгөв. Бүсгүй өв хөрөнгөгүй хоцорсондоо тэгсэн биш харин өвгөнд тийм сэтгэл төрүүлсэндээ тэгж их гайхан дээш харсан ажээ.

Нуартъе охин өөд тун энхрийлсэн харцаар харлаа. Тэгэхэд Валентина хариуд нь,

- Өвгөн аав та надад өмч хөрөнгөө өгөхөө больсноос биш хайртай хэвээр байгаа, тийм ээ. Ви зөв ойлгож байна уу? гэхэд,
- Тийм, мэдээж хэрэг гэж өвгөний нүд дохиод Валентина түүнийг эргэлзэлгүй ойлгож,

- Баярлалаа, баярлалаа гэж аман дотроо шивэглэв.

Өвгөний ийнхүү татгалзахыг Вильфор авгай үзээд нэгэн горьдлого гэнэт төрж өвгөнд ойртон очоод,

- Та өөрийнхөө хөрөнгийг ач хүү Эдуар де Вильфорт үлдээх нь үү? гэж асуув. Тэгэхэд өвгөн нүдээ анивчсан нь аймаар бөгөөд бар г үзэн ядаж байгааг илтгэнэ.
- Үгүй байж, тэгвэл энд байгаа хүүдээ өгөх юм уу? гэж нотариатын хүн асуухад,
- Үгүй гэж өвгөн татгалзан хариулав.

Тэгэхэд нотариатын хоёр хүн бие биеээ харцгаав.

Вильфор түүний эхнэр хоёрын царай улайлаа. Нэг нь ичиж, нөгөөх нь хорссондоо тэгж улайжээ.

- Өвгөн аав аа, бид таны өмнө ямар буруу хэрэг хийчхэв ээ? Та өнөөгөөс аваад бидэнд хайртай байгаа больчихов уу? гэж асуухад өвгөн эхлээд Вильфор, дараа нь түүний эхнэрийг гүлгэн хараад, сүүлд нь Валентинаг их л энхрийлэн харлаа.
- Өвгөн аав аа, та надад хайртай юм бол таны одоогийн хийж байгаа зүйлийг чинь таны хайр сэтгэлтэй яаж авцалдуулж ойлговол зохих юм бэ? Би таны хөрөнгө хогшлын тухай хэзээ ч бодож байгаагүй гэдгийг та мэднэ шүү дээ. Тэгээд ч би бас эхээсээ их, дэндүү их хөрөнгө өвлөж авсан гэдэг шүү дээ. Тэгээд ер нь ямар учиртай болохыг хэлж өгөөч?

Тэгэхэд Нуартье Валентинагийн гар өөд цоргих мэт харав.

- Миний гар уу? гэж охиныг асуухад,
- Тийм ээ гэж хариулав.

Гэтэл тэнд байсан хүмүүс,

- Гар гэнэ ээ! гэж давтан хэлэв.
- Эрхэм үү дээ, энэ бүхэн ашиггүй, хөөрхий эцэг минь өөрийн ухаангүй байгааг та минь харж байгаа биз дээ гэж Вильфор хэлэхэд Валентина гэнэт,
- Би мэдлээ. Намайг хүнтэй суулгах тухай, тийм ээ гэж асуулаа.
- Тийм, тийм гэж саагийн гэмд дайрагдсан өвгөн хариулахад нүд нь хорслоор гялалзаж байв.
- Намайг хүнтэй сууна гэхэд та дургүй байна уу?

- Тийм ээ.
- Энэ чинь дэмий хэрэг байна гэж Вильфор хэлэхэд,
- Эрхэм минь уучлаарай, миний бодоход өвгөний хэлдэг их л учир зүйтэ©, нэг нь нөгөөгөөсөө уялдан гарч байгаа зүйл байна гэж нотариус хариулав.
- Намайг франц д' Эпинетэй суухад та дургүй байна уу? гэж охин асуухад,
- Үгүй, хүсэхгүй байна гэж өвгөний харц хариулав.
- Ач охин чинь таны хүсэл санаанаас зөрж өөр хүнтэй суух гэж байгаа болохоор нь түүнд хөрөнгөө өгөхгүй гэж байгаа юм уу? гэж нотариатын хүн асуухад,
- Тийм ээ гэж Нуартье хариулав.
- Хэрвээ тэр хүнтэй суухгүй бол, энэ охин таны өв залгамжлагч болох уу?
- Тийм.

Өвгөний дэргэдэх хүмүүс цөм нам гүм боллоо. Нотариатын хоёр хүн хоорондоо зөвшин ярилцав.

Валентина өвгөн аав өөдөө ихэд баярласан байдалтай харав. Вильфор нимгэхэн уруулаа хазаж суув. Эхнэр нь өөрийн эрхгүй нүүрэн дээрээ илрэн гарч ирсэн баяр хөөрөө дарж чадахгүй байв. Тэгтэл нам гүмийг Вильфор түрүүлэн эвдэж,

Франц д' Эпине манай охинд хэр тохирсон хань болохыг мэдэж шийдэх ганц хүн бол би юм шиг санагдана. Охиноо хэнтэй суулгахыг би ганцаараа мэднэ. Би түүнийг франц д' Эпинетэй суулгах хүсэлтэй байна. Валентина түүний эхнэр болно гэв.

Валентина нулимсаа цувруулан зөөлөн сандал дээр суучихлаа. Тэгэхэд нотариатын хүн өвгөн рүү хандаж,

- Хэрвээ Валентина охин эрхэм д; Эпинетэй суувал та өөрийнхөө хөрөнгийг яая гэж бодож байна гэж асуулаа.

Өвгөн хөдөлсөнгүй.

- Гэвч та хөрөнгөө нэг тийш нь болгоно биз дээ?
- Тийм гэж Нуартье дохилоо.
- Гэрийнхнийхээ хэн нэгний ашиг тусад зориулж өгөх үү?
- Үгүй.

- Тэгвэл ядуучуудад зориулах уу?
- Тийм.
- Хүүгээ огт хоосон хоцроохыг хууль зөвшөөрөхгүй гэдгийг та мэднэ шүү дээ.
- Мэднэ.
- Тэгвэл та хуулиар зөвшөөрөгдсөн тэр хэсгийгээ л өөрөө мэдэж шийдвэрлэх үү?

Нуартые хөдөлсөнгүй.

- Тэгвэл та бүх хөрөнгөө өөрөө мэдэж шийдвэрлэх гээд байгаа юм уу?
- Тийм.
- Таныг нас барснаас хойш гэрээслэлийг чинь залруулахаар заалдах болно шүү дээ.
- Үгүй.
- Эрхэм минь, манай эцэг миний занг мэднэ. Түүний хүсэл санаа надад гэгээн нандин зүйл гэдгийг тэр өөрөө мэднэ. Түүнээс гадна миний одоогийн байдал намайг чдуучуудтай хөрөнгө булаацалдахад хүргэхгүй гэдгийг бас ойлгож байгаа гэж Вильфорыг хэлэхэд өвгөний харцанд дийлсэн шинж тодорлоо.

Тэгээд нотариатын хүн Вильфороос,

- Эрхэмсэг та юу гэж шийдэх гэж байна? хэмээн асуув.
- Юу ч гэж шийдэхгүй. Эцэг минь нэг л шийдвэл тэр шийдвэрээ өөрчлөхгүй. Надад зөвхөн дагаж хүлээхээс өөр юмгүй. Энэ есөн зуун мянган франк бидний гараас алдагдаж, асрамжийн газрын санг баяжуулах нь байна. Гэвч би өвгөний зөрүүд занг дагахгүй, өөрийнхөө л сэтгэл оюунаар болно.

Вильфор ингэж хэлээд эхнэрээ дагуулан гарч, эцэгтээ дур зоргоороо аашлах бололцоо тавьж өглөө.

Тэр өдөртөө гэрээслэлийг бичиж гүйцэтгэжээ. Тэгээд гэрчийн этгээдүүдийг дуудан ирүүлж, уншиж өгөөд, өвгөнөөр зөвшөөрүүлэн, хүмүүсийн нүдний өмнө лацдан битүүмжилж, Вильфорын гэр бүлийн нотариус эрхэм Дешанд өгч хадгалуулав. .

3.Цахилгаан мэдээ

Вильфор эхнэртэйгээ хамт өрөөнд хүрч ирээд зочдын өрөөнд Монте-Кристо гүн хүлээж байгааг мэджээ. Вильфор авгай сэтгэл нь дэндүү их хөдөлчихсөн байсан учир шууд гүн дээр очсонгүй, унтлагынхаа өрөө рүү явлаа. Вангийн прокурор биеэ барьж чаддаг хүн тул зочдын өрөө рүү очлоо. Гэвч хэдийгээр биеэ барьж, царайгаа хэвийн байлгахыг хичээвч эвгүй байдлаа нууж чадсангүй, их л таалалтайгаар инээмсэглэж байсан гүн түүний бодлогоширч санааширсан байдлыг анзаарчээ. Тэгээд мэнд усаа мэдэлцсэний дараа,

- Эрхэм де Вильфор та яагаа вэ? гэж асуугаад,

- Таныг ямар нэг амаргүй ялын төлөвлөгөө бичиж байхад чинь би хүрч ирэв үү? гэхэд Вильфор инээмсэглэхийг оролдон,

- Үгүй гүнтэн, энэ удаа би өөрөө хохирогч болов. Би энэ удаа хожигдлоо. Харин ялын төлөвлөгөөг учрал тохиолдол, гэжүүд зөрүүд, ухаангүй тэнэг явдал удирдан боловсрууллаа гэж хэлэв.

Тэгэхэд Монте-Кристо гүн түүний төлөө их л зовсон дүр үзүүлж,

- Яалаа гэнээ? Танд үнэхээр ноцтой эвгүй явдал тохиолдов уу? гэвэл Вильфор тайван боловч гунигтай байдлаар,

- Гүнтэн, яриад ч байх юм алга. Дэмий шахуу юм. Мөнгөний алдагдал гарлаа гэж хэллээ.

- Тийм ээ, тан шиг ийм их хөрөнгөтэй, гүн ухаантан хүнд мөнгөний алдагдал гэдэг сухан байх вэ гэж Монте-Кристо хэлэхэд,

- Тийм учраас би хэдийгээр есөн зуун мянган франк алдсандаа харамсах буюу үгүй ядахдаа хор хөдөлж болох байсан боловч мөнгөний тухай санаашраагүй. Зөнөглөж хүүхэд шиг болчихсон өвгөний зангаас болж баялаг хөрөнгө олох найдлага минь алдагдаж, охины минь сайн сайхан ирээдүйг эвдэж, надад цохилт өгсөн тэр хүч, хувь заяаны эргэлт хувиралт л намаыг илүү их гомдоож байна гэж Вильфор хариулав.

- Юу гэнэ ээ! Яагаад тэр билээ? Есөн зуун мянган франк гэв үү, та? Энэ чинь гүн ухаантан хүн ч харамсахаар их мөнгө байна. Харин таныг хэн ингэж гомдоож хорсгов?

- Миний эцэг, би түүний тухай танд ярьж байсан даа.

- Нуартье гуай юу? Тэр тэглээ гэж үү? Та түүнийг саа өвчинд дайрагдаж бүх чадвараа алдчихсан гэж ярьсан шиг надад санагдаж байна.

- Тийм ээ, бие махбодынхоо чадварыг алдсан учир хөдөлж, ярьж чаддаггүй юм. Гэсэн ч ухааран бодож, хүсэж мөрөөдөж, ухаан санаа нь ажиллаж байна. Би тавхан минутын өмнө тэндээс түүнийг орхиж гарлаа. Тэр одоо нотариатын хоёр хүнд гэрээслэлээ хэлж өгч бичүүлж байна.

- Тэгээд тэр хүн юм ярьж чаддаг болчихоо юу?

- Үгүй, өөрийнхөө бодлыг хүчээр ойлгуулж байна.

- Яаж тэр вэ?

- Харцаараа, нүд нь амьд хэвээрээ, тэр ч байтугай алаад орхиж байгааг нь үзэхгүй юу гэв.

- Найз минь, гэж Вильфор авгай орж ирэнгүүт хэлээд,- Та арай дэндүүлж байх шиг байна гэлээ.

- Эрхэмсэг хатагтай... гээд гүн бөхийн ёслов.

Вильфор авгай хариуд нь хамгийн эелдгээр инээмсэглэлээ.

- Де Вильфор гуай юу ярьж байна аа? Яасан ойлгогдохгүй хатуу сэтгэл вэ? гэж Монте-Кристо асуухад вангийн прокурор мөрөө хавчаад,

- Чухам л ийм юм боллоо. Хөгшин хүний зөрүүд зан! Гэж хэллээ.

- Түүний шийдвэрийг өөрчлүүлэх арга байхгүй юм уу?

- Байгаа нь ч байгаа юм гэж Вильфор авгай хэлээд- Гэрээслэлийг Валентинад хохиролгүй, харин түүнд ашигтайгаар шийдвэрлэх явдал ганцхан манай нөхрөөс шалтгаалж байна гэлээ.

Тэр хоёр бие биеэ егөн ярьж байгааг хараад,гүн анзаараагүй царай гаргаж шувууныхаа идүүрт бэх асгаж байсан Эдуарыг их л анхаарч, сайшаасан байдалтай сууж байв.

- Хайрт минь гээд Вильфор эхнэртээ- Би гэртээ эцгийн ноёрхлыг тогтоох эрмэлзэлгүй бөгөөд ертөнцийн хувь заяа миний илбэ шидээс хамаарагдах мэт дүр үзүүлж чадахгүй гэдгийг та мэднэ. Гэсэн ч миний гэр бүл, миний шийдвэрийг юманд бодолцон, өвгөний тэнэг явдал, хүүхдийн зөрүүд зангаас болж, миний эртнээс бодсон төлөвлөгөө эвдрэхгүй байх нь чухал. Түшээ гүн д' Эпине бол миний сайн нөхөр байсан юм. Үүнийг та мэднэ. Тэгэхээр түүний хүү нь манай охинд тохирох хамгийн сайн нөхөр байх ёстой гэж хэллээ.

Тэгэхэд Вильфор авгай:

- Тэгвэл та тэр хоёрыг хоорондоо тохиролцчихсон гэж бодож байна уу? Үнэндээ ч Валентина тэр хүнтэй суухаас үргэлж дургүйцэж байсан шүү. Бидний саяын үзэж, сонссон зүйл, тэдний урьдаас төлөвлөсөн төлөвлөгөөний биелэлт болж таарлаа гэхэд би л гайхахгүй гэхэд,

- Есөн зуун мянган франкийн хөрөнгөнөөс тэгж татгалздаггүй юм гэж Вильфор хэллээ.

- Валентина ертөнцөөс ч татгалзахаасаа буцахгүй байх аа. Тэр чинь ноднин сүмд очиж сууна гээд байсан шүү дээ.

- Хамаагүй, юу ч гэсэн түүнтэй гэрлүүлнэ! гэж Вильфор зөрж хэллээ.

- Эцгээсээ зөрж үү? Тэр ч тийм амар хэрэг биш байх аа! гэж авгай хэлэв.

Монте-Кристо дуулаагүй юм шиг дүр үзүүлж суусан боловч энэ ярианаас нэг ч үг гээлгүй чагнаж байлаа.

- Авгайтан, түүний зан суртахууны давууг ухамсарлах миний ухамсар, эцэг үрийн холбоо хоёр нийлж эцгийг минь хүндэтгүүлдэг юм. Бас эцэг минь биднийг төрүүлсэн, бидний ах зах болох хүн учир хоёр давхар хүндтэй байдаг гэдгийг танд хэлэх ёстой. Гэвч одоо эцгийн нь төлөө хүүг нь үзэн яддаг өвгөнийг яаж бүрэн ухаантай гэх билээ. Би өөрийнхөө бодлыг түүний зөрүүд зантай зохицуулах гэвэл миний талаас их л инээдтэй хэрэг болно. Би эрхэм Нуартъег гүн их хүндэтгэдгээ ч болихгүй, надад ногдуулсан мөнгөн шийтгэлийг үг дуугүй хүлээх боловч миний шийдвэр хэвээр үлдэх бөгөөд хэний нь зөв болохыг олон түмэн ялган салгана. Би охиноо түшээ гүн франц д'Эпинетэй суулгана. Энэ бол хүндтэй сайхан гэр бүл болно. Тэгээд ч би санаандаа таарсан хүнтэй охиноо суулгана.

- Өө, таны хэ«ж байгаагаар бол эрхэм Нуартъе мадмуазель Валентинаг түшээ гүн франц д'Эпинетэй суулгах гэлээ гэж өв хөрөнгөө үлдээхийг татгалзаж байгаа юм уу? гэж гүн асуув.

Вангийн прокурор түүнээс дэмжлэг олох гэж үе үе өөдөөс нь харж байсан юм. Вильфор мөрөө хавчаад,

- Чухам үүнд л хамаг учир байгаа юм гэлээ.

- Ямар ч гэсэн нүдэнд харагдах шалтгаан нь энэ гэж Вильфор авгай нэмж хэлэв.

- Гол шалтгаан нь тэр. Хатагтай минь, би эцгийнхээ занг мэдэлгүй яах вэ.

- Эрхэм д'Эпине юугаараа бусдаас доор юм бэ? Та үүнийг мэдэж байна уу? гэж залуу бүсгүй асуухад,

- Нээрээ тийм дээ, би эрхэм франц д'Эпинетэй дайралдсан гэж гүн хэлээд, - Тэр чинь хожим түшээ гүн болсон генерал Кенель д'Эпинегийн хүү юү? хэмээн асуухад

- Яг үнэн гэж Вильфор хариуллаа.

- Тэр чинь надад их л аятайхан залуу шиг санагдсан.

- Тийм учраас л үүгээр шалтаг хийгээд байна гэж би бодоод байгаа юм гэж Вильфор авгай хэлээд, - Өвгөчүүл хайртай хүндээ хэрцгий ханддаг юм. Нуартъе гуай зүгээр л ач охиноо хүнтэй суухад дургүй байгаа нь тэр гэлээ.

- Үгүй ээ, тэгж үзэн ядаад байгаа нь ямар нэг үндэстэй юм биш байгаа гэж монте-Кристо гүн асуулаа.

- Бурхан минь, хаанаас түүнийг мэдэх билээ?

- Улс төрийн зөрчил байж болох юм.

- Тийм ээ, манай эцэг, д'Эпинегийн эцэг хоёр ширүүн үед амьдарч байсан улс. Би зөвхөн сүүлийн үеийг нь мэднэ гэж Вильфор хэлэхэд, Монте-Кристо гүн,

- Танай эцэг чинь Бонапартын талын хүн байсан байх аа гэж асуугаад- Та надад тиймэрхүү л юм ярьсан санагдаж байна гэлээ.

Тэгэхэд Вильфор хамаг сэтгэл нь хөдөлсөн учир болгоомжлохоо мартчихаад,

- Миний аав якобинчуудын талын хүн байсан юм гэж хэлснээ,- Наполеоны өмсүүлсэн сенатчийн хувцас зөвхөн түүний зүсийг хувиргаснаас биш, түүнийг өөрийг нь өөрчлөөгүй юм. Манай аав тэр үед хуйвалдаахд оролцохдоо эзэн хаанд хайртайдаа биш, харин Бурбончуудыг үзэн яддагтаа л тэгсэн юм. Хамгийн аймшигтай нь тэр хэзээ ч бүтэхгүй юмны төлөө тэмцэж байгаагүй_ үнэхээр биелэгдэх боломжтой зүйлийн төлөө тэмцэж байсан юм. Тэгэхдээ зорьсондоо хүрэхээс нааш юуны ч өмнө зогсохгүй гэдэг монтаньяруудын аймшигтай онолыг мөрдлөгө болгож байлаа гэв.

- Харж байна уу, үүнд чинь л хамаг учир байгаа юм байна гэж Монте-Кристо гүн хэлээд - Нуартье д'Эпине хоёр улс төрийн тавцан дээр мөргөлдөж байсан улс юм. Генерал хэдийгээр Наполеонд алба хааж байсан боловч сэтгэл нь роялист хэвээр үлдсэн, тийм ээ? Нэг шөнө, эвсэх болов уу гэсэндээ бонапартын клубт аваачаад тэндээсээ гарч яваад алагддаг тэр хүн биз дээ? гэж асуулаа.

Тэгэхэд Вильфор, гүн өөд айсан юм шиг харлаа.

- Би андуурч байна уу? гэж Монте-Кристо асуухад, Вильфор авгай,

- Үгүй, тэр хүн мөн. Чухам тийм учраас л миний нөхөр урьдын дайсагналаа мартагын тулд энэ хоёр хүүхдийг хайраар холбох гээд байгаа юм гэж хариу хэлэв.

- Сайхан л санаа байна гэж гүн хэлээд

- Энэрэнгүй сэтгэлийн биелэл болсон санаа байна. Олон түмэн үүнд баяр хүргэх ёстой. Нээрээ ч мадмуазель Нуартье де Вильфор Франц д'Эпине авгай гэж нэрлэгдэх болбол сайхан байна даа гэлээ.

Вильфор цочин, яагаад ийм үг хэлж байгаагийн нь учрыг олох гэсэн мэт гүн өөд харлаа.

Гэвч гүн өнөө л найрсаг байдлаараа инээмсэглэж байгаа харагдав. Вангийн прокурор хэдийгээр нэвт шувт харах чадвартай боловч энэ удаа өнгөнөөс нь өөр юм олж харж бас л чадсангүй.

Тэгээд Вильфор цааш нь үргэлжлүүлж,

- Өвгөн аавинхаа хөрөнгийг алдаж байгаа нь Валентинад их л золгүй явдал болж байгаа боловч энэ нь Валентинагийн хүнтэй суух явдлыг саатуулж чадахгүй гэж бодож байна. Д'Эпине гуай энэхүү мөнгөний алдагдлыг юманд бодохгүй байх. Хэлсэн үгэндээ хүрэх гэж хохирол үзэж байгаа намайг энэ мөнгөнөөс илүү үзэх байлгүй дээ. Валентина эхээсээ ихээхэн хөрөнгө өвлөн үлдсэн гэдгийг тэр бодолцох ёстой. Энэ хөрөнгө түүний нагац өвөг, эмэг Сен-Мераныд хадгалагдаж байгаа юм. Энэ хоёр хөгшин Валентинаг их л энхрийлэн хайрладаг хэмээн ярилаа.

- Валентина эрхэм Нуартъег хэрхэн асарч байгаа шиг тэгж тэр хоёр асруулахаар сайн улс. Тэр хоёр одоо сар бололгүй Парист хүрч ирнэ. Тэгэхэд ингэж гомдсон Валентина юу хийж одоо хүртэл Нуартъег сахиж суусан шигээ үүрд сууж байх билээ гэж Вильфор хатагтай хэлэв.

Доромжлогдсон, хууртсан шунаг сэтгэлийн дууг гүн амгалан сууж чагнан байлаа.

- Би уучлаарай гэж хүсэж байгаад нэгэн зүйлийг хэлье гэж гүн хэлээд хэсэгхэн зуур дуугүй байснаа – Эцэг нь үзэн ядаж байсан хүнтэй суух гэлээ гээд Валентина хөрөнгө хогшил өвлөн авах эрхгүй хоцорч байгаа юм бол, манай хонгор жаахан Эдуарыг ингэж зэмлэмээргүй юм даа гэв.

- Тийм л баймаар юм гэж Вильфор авгай бичиж тодорхойлохын аргагүй хэлээд, - Нээрээ аймшигтай шударга биш хэрэг ээ? Хөөрхий Эдуар бас л Валентина шиг Нуартъе гуайн ач хүү шүү дээ. гэхдээ Валентина Франц де Эпинетнй суухгүй бол Нуартъе өв хөрөнгөө түүнд үлдээнэ. Валентинад өвгөн аав нь өмч хөрөнгө залгамжлан үлдээхгүй ч гэсэн, гал голомтыг үргэлжлүүлэгч хүн болох Эдуараас гурав дахин баян байгаа хүн шүү дээ.

Гүн нэг ч үг дуугаралгүй гагцхүү анхааралтай чагнан сууж байлаа. Тэгэхэд Вильфор,

- Гүн минь, гэр бүлийн энэ будлианы тухай дахин ярихаа больё. Харин миний хөрөнгө ядуучуудын орлогыг нэмэгдүүлэх хэрэгт зарцуулагдах нь байна. ер нь одоо үед чинь ядуучууд л ёстой баячууд болсон юм шив дээ. эцэг минь намайг буруугүй байсаар байтал миний хууль ёсны найдварыг үгүй хийж байна. гэвч би зөв бодолтой сайхан санаатай хүний ёсоор байх болно. Бид Эдинед энэ хөрөнгөнөөс орлогы нь өгнө гэж хэлсэн. Тэгэхээр надад ямар ч хүнд хохирол учирлаа ч гэсэн тэр, тэрхүү орлогыг авах болно гэж хэлэхэд Вильфор авгай сэтгэлийг нь шаналгаж байгаа зүйлийг тэсэлгүй гаргаж,

- Ер нь энэ эвгүй явдлыг эрхэм де Эпинед хэлж үзэл яасан юм бэ? Тэр өөрөө энэ талаар хэлсэн үгээ буцааж авбал аяаг гэгчхлээ.

- Тэгвэл ч их золгүй явдал болно доо гэж Вилфор хэлэхэд,

- Их золгүй явдал ий? гэж гүн өөдөөс нь асуулаа. Вильфор бага зэрэг тайвширсан байдлаар,

- Тэгэлгүй яах вэ. хэдийгээр мөнгөний асуудлаар болоод ч гэсэн сүй буцвал бүсгүйн нэрэнд л сүүдэр буудаг шүү дээ. түүнээс гадна миний төгсгөл болгох гэж хүсэж байгаа хуучны элдэв үг яриа дахин босож бий болно. Үгүй шүү, үүнийг гаргуулахгүй. Хэрвээ де Эпине гуай шударга хүн бол Валентина өв хөрөнгөө алдаж байгаагаар эрх биш суулгүй бол эвгүй юм болж байгааг ойлгох учиртай. Үгүй гэдэг юм бол зөвхөн шунаг сэтгэлээсээ суух юм болно. Үгүй, тийм байх ёсгүй гэж хэлэхэд, гүн Вильфор авгай руу ширтэн харж,

- Би ч бас тэгж бодож байна. би эрхэм де Вильфорын найзын хувьд зөвлөгөө өгөх хэрэгтэй гэж бодвол Франц де Эпине удахгүй ирэх гэж байгаа болохоор энэ гэр бүл болох төлөвлөгөөг нураахгүйн тулд зохих зүйлийг хийх хэрэгтэй. Би л бол эрхэм де Вильфорын нэр төрөөр төгсгөх тийм тэмцэл хийнэ дээ гэхэд Вильфор их л сэтгэл хангалуун болж боссон бөгөөд харин эхнэрийн нь царай бага зэрэг зэвхийрлээ.

- Маш сайн. Би чухамхүү ийм үг сонсох гэж хүссэн юм. таны зөвлөгөөг даган гэж хэлээд Вильфор гүнд гараа өгч - Өнөөдөр энд болсон явдал ямар ч ач холбогдолгүй гэж үзэхийг эндбайгаа бүх хүмүүсээс хүсье. Манай төлөвлөгөө хэвээрээ үлдэнэ гэлээ.

- Эрхэм ээ олон түмэн хэдийн шударга биш байлаа ч гэсэн таны энэ зоримог явдлыг үнэлэн үзэх болно. Таны нөхөд чинь танаар бахархаж, мадмаузель Вильфор инжгүй ч гэсэн де Эпине гуай авч суухад хүрдэг юм гэхэд хэлсэн үгэндээ хүрч, үүргээ гүйцэтгэхийн тулд хохирол ч хүлээж чаддаг гэр бүлд багтан орохдоо баяртай байх болно гэж гүн хэлэв.

Гүн энэ үгийг хэлээд босож явахаар завдав.

- Та биднийг орхиод явах нь уу? гэж хатагтай асуулаа.

- Хатагтай минь би явалгүй болохгүй. Зөвхөн та нарын бямба гаригт манайд айлчлахаар соёрхсоныг тань сануулахаар ороод гаръя гэж бодсон билээ.

- Та биднийг мартчихна гэж үнэхээр бодлоо гэж үү?

- Авхайтан та их сайхан санаатай хүн юм. вильфор гуай чухал, хойшлуулашгүй ажил хтэй байдаг шүү дээ.

- Манай нөхөр очно гэж хэлсэн. Тэр нэгэнт л тэгж хэлсэн бол өөрт нь ихээхэн хохирол учрах байсан ч хэлсэн үгэндээ хүрдгийг та үнэмшлээ шүү дээ. тэгхэд энэ бол аятай таатай зүйл шүү дээ гэж Вильфор авгай хэлэхэд,

- Танай Елисейн тал дахь өргөөнд очиж дайлуулах хэрэг үү? Гэж Вильфор асуулаа.

- Үгүй, хотын захад болно. Тэр тусмаа та бүхний биесээ чилээн очсоны гавья төдийн их болно гэж гүн хариуллаа.

- Хотын захад гэнэ ээ?

- Тийм ээ.

- Хаахна вэ? Парисын захад уу?

- Хаалганы яг дэргэд. Харуулаас хагас цаг яваад хүрнэ. Отейлд.

- Отейлд гэв үү? Гэж Вильфор дуу алдаад – Нээрээ тийм, манай эхнэр таныг Отейлд суудаг гэж хэлсэн юм байна. тэнд таны гэрт эхнэрт минь тус болсон гэсэн л дээ. отейлын хаахнатай вэ?

- Фонтен гудамжинд.

- Фонтен гудамж аа? гэж Вильфор бачимдсан дуугаар асуугаад – Хэддүгээр байшин бэ? гэлээ.

- Хорин найм.

- Сен-Меран бэйлийнхэн танд энэ байшиг худалдсан байх нь ээ? гэж Вильфор асуухад гүн,

- Бэйл де Сен-Меран гэнэ ээ? Сен-Мераныхан тэнд сууж байсан юм гэж үү? Гэж өөдөөс нь асуулаа.

- Тийм ээ гэж хатагтай хариу өгүүлээд – Их хачин юм шүү... гэхэд нь гүн,

- Чухам юу тэр вэ? гэж асуулаа.

- Энэ сайхан байшин гэдгийг та зөвшөөрч байгаа биз дээ?

- Бахадмаар байшин даа.

- Тэгэхэд миний нөхөр тийшээ очиж суухыг огт зөвшөөрдөггүй юм.

- Нээрээ эрхэм ээ үүнийг чинь би ойлгож чадахгүй юм байна гэж гүн хэлэхэд,

Вангийн прокуророр хүч гарган,

- Би Отейлд нэг л дургүй хүрээд байдг юм гэж өгүүллээ.

- Үүнээс болоод би таныг гэртээ урин зочлох хувьгүй хүн арай болчихгүй байгаа хэмээн гүн сандарсанд,

- Үгүй гүнтэн,...би...би очих гэж бололцоотой бүхнийг л хийнэ гэж найдаж байна хэмээн аман дотроо бувтнахад,

- Би ямар нэг шалтгаан заахыг хүлээж авахгүй шүү гэж хэлээд – Би та нарыг бямба гаригийн орой, зургаан цагт ирнэ гэж хүлээнэ. Хэрвээ ирэхгүй бол энэ хориод жил хүн суухгүй байгаа байшинд ямар нэг цуст явдал болжээ гэж бодох болно шүү гэлээ. Тэгэхэд Вильфор,

- Би очно, гүн минь үчно гэж яаран хариуллаа.

- Баярлалаа танд. Одоо явахыг зөвшөөрнө үү? Гэж гүнг хэлэхэд Вильфор авгай,

- Гүн та явах хэрэгтэй гэж нээрээ хэлсэн, тэр ч байтугай яагаад гэдгээ хэлэхээ завдсанаа өөр юмны тухай яриад явчихлаа гэв.

- Авхайтан, би хаашаа явахаа танд хэлэхийг нэг л зүрхшээж байна гэж гүн хэлэхэд,

- Хамаагүй ээ, хэлээч дээ гэв.

- Би цөөн биш удаа бүтэн цагаар хүсэн мөрөөддөг нэгэн зүйлээ очиж үзэх гэсэн юм.

- Тэр чинь юу билээ?

- Цахилгаан мэдээний газар.

- Цахилгаан мэдээний газар гэнэ ээ? гэж Вильфор авгай давтан хэлэв.

- Тийм ээ, цахилгаан мэдээний газар. Тэнгэр сайхан өдөр замын хажуу талын довцог дээр байдаг аварга том шавж хорхойн савар шиг хэлбэртэй, агаарт сүндэрлэсэн үет гар мэт шонгууд харагддаг юм. харах бүрдлээ сэтгэл хөдлөн гайхдаг гээч. Агаарыг ингэж нарийн огтлон гарч, ширээний цаана сууж байгаа хүний хүсэл зоригийг гурван зуун бээрийн хол газар утасны нөгөө үзүүрт, бас нэг өөр ширээн дээр сууж байгаа хүнд дамжуулан хүргэдэг энэ тэмтрүүл нь бараан үүл ба хөх тэнгэрийн дунд тэрхүү бүхнийг чадагчийн хүслийн хүч болон тодрон харагддаг юм байх гэж боддог байлаа. Тэгээд бас ид шид, буг чөтгөрийн тухай ч боддог байв. Гэвч би энэ том цагаа гэдэстэй, нарийхан хар савартай аварга том шавжинд түүний шулуун далавчны доор эрдэм ухаан, ид шидийг эзэмшсэн хямсгар нь аргагүй жижгэн хүн байж байх магадгүй гэж айгаад дэргэд нь ойрхон очиж харахыг хүсдэггүй байв. Тэгээд нэг сайхан өдөр би жилд мянга хоёр зуун франк авч одон орны шинжээч шиг тэнгэрийг ширтэлгүй, загасчин шиг ус руу харж суудаггүй, зугаацан яваа хүн байгаль шиг дэлхийг харж ажигладаггүй, харин өөрөөсөө дөрөв, таван бээр орших, мөн л тий цагаан гэдэстэй, хар савартай хорхойг хүлээж нүдээ цөхөртөл ширтэн суудаг золгүй ядуу албан хаагч нар цахилгаан мэдээний газрыг хөдөлгөн байдаг юм гэдгийг дуулж мэдлээ. Тэгээд л би энэ амьд хүүхэлдэй, нөгөө хүүхэлдэйтэйгээ яаж олс татаж үзүүрээс нь чангаан тоглож байдгийг үзмээр санагдсан юм.

- Тэгээд та тэр уруугаа явах нь уу?

- Би тийшээ явна.

- Аль цахилгаан мэдээний газар очих гээ вэ? Дотоод явдлын яамныхад уу? эсвэл одон орныход уу?

- Хэрхэвч үгүй. Хэрвээ тэнд очвол миниймэдэх хүсээгүй байгаа юмыг надад тайлбарлаж, өөрсдөө ч ойлгохгүй байгаа нууцаа надад хүчээр хэлж өгөх гэгцгээнэ. чөтгөр ав, би шавжны тухай хий бодлыг өөртөө хадгалж үлдэхийг хүсч байна. хүмүүсийн тухай дээгүүр санаж яваад талаар болсон минь боллоо. Тэгээд дотоод

явдлын яамныхад ч очихгүй, одон орхныход ч очихгй. Би өөрийнхөө байшинд суусаар хөшиж чулуу болчих шахсан хөөрхий амьтныг ямар ч гоёл чимэглэлгүйгээр, чөлөөт агаар дотор байгаагаар нь харах хэрэгтэй байна.

- Та чинь алдар нэртэй хүндтэй хүн боловч маш хачин хүн юм гэж Вильфор хэллээ.

- Та намайг аль шугамыг нь үз гэж зөвлөхсөөн бол?

- Одоо хамгийн их ажилтай байгааг нь л үзвэл дээр дээ.

- За тэгвэл Испанийхыг үзэх хэрэг үү?

- Тэгэлгүй яах вэ, сайдаар бичиг хийлгэж танд...

- Үгүй, үгүй. Би ер нь юу ч ойлгож мэдэхийг хүсэхгүй байна гэж хэлсэн шүү дээ. би түүнийтухай мэдчихвэл цахилгаан мэдээ гэдэг юм байхгүй, харин Дюшатель гуай юм уу, де Монталивегийн явуулсан тэмдэг болж нада санагдар болно. Харин би бол түүнийг хар савруудтай, хорхой мэт бодож хүндэтгэсэн хэвээрээ байхыг хүсэж байна гэлээ.

- Та тэгвэл яв даа.одоо хоёрхон цаг болоод харанхуй болчихно. Та тэгэхээр тэд нарын алийг нь ч үзэж чадахгүй болчихно.

- Та нар намайг айлгачихлаа. Тэд нарын аль нь илүү ойр бол?

- Байонн орох зам дээр нь ойрхон.

- Тийм ээ, Байонн орох зам дээр байгааг ч үзэж болох юм.

- Шатильоных.

- Шатильоны цаадах уу?

- Монлерийн цамхаг дээр үиг санагдаж байна.

- Баярлалаа танд, баяртай. Би бямба гаригт та нарт сэтгэгдлээ яримз.

Валентинаг өв хөрөнгөнөөс нь хагацаагаад өөрсдөдөө бол овоо ярвигтай чухал баримт хийсэндээ их л хангалуун яваа нотариатын хоёр хүнтэй гүн үүдэн дээр дайралдав.

4.Цэцэрлэгчийг тоорыг нь идэгч унтаахайгаас ангижруулах арга

Монте-Кристо гүн тэр оройгоо биш маргааш өглөө нь Ахьфер харуулаар дайран гарч, Орлеоны замаар явж, гүнг түүгээр өнгөрөхө үед урт нарийн гараа хөдөлгөж байсан цахилгаан мэдээний газрын хажуугаар гарч нэр нэгт хөндийн хамгийн өндөрлөг хэсэгт нь байдаг Монлерийн цамхагт хүрлээ.

Толгойн бэлд хүрч ирээд гүн сүйх тэрэгнээсээ гарч, бүтэн хагас фут өргөн тойруу зөргөөр өөдөө өгслөө. Тэгээд толгойн оройд хүрэхэд өмнө нь ягаан цагаан цэцэгний нь оронд үр жимс гарсан хонин хашаанд хүрлээ.

Гүн хаалгыг нь эрж төдхөн олов. Хаалга нь бургасаар хийсэн гогцоонд өлгөсөн, хадаас олсны тусламжтайгаар хаагддаг модон сараалж байлаа. Гүн энэ оньсны учрыг тэр дор нь олж хаалга нээгдлээ.

Гүн уртаараа хорин алхам, өргөнөөрөө арван хоёр алхамын хэмжээтэй жижигхэн цэцэрлэгт орж ирлээ. Энэ цэцэрлэг нэг талаасаа бидний дээр ярьсан нарийн аргаар хийсэн хонин хашаа, нөгөө талаасаа ороонго ба өнгө, өнгийн лиш, башир цэцэг эргэн тойрон тарьсан хуучин цамхагтай зах нийлжээ.

Үр хүүхдүүд нь ирж уулзаад баяр хөөр болсон эмгэн хүний үрчлээт царай шиг болчихсон, өнгийн цэцгээр хүрээлэгдсэн энэ цамхаг эртний үгэнд гардагчлан юм дуулах чихтэйн дээр хэлтэй байсан бол олон аймшигт явдлуудын тухай өгүүлнэ гэж хэний ч санаанд оромгүй.

Нарийн замаар явж цэцэрлэг дундуур өнгөрч болох байв. Энэ зам дээр улаан элс асгаж, олон наст бүдүүн хуайс суулган эмжсэн нь өнгө хосолж, манай үеийн Рубенс болсон Делакурагийн нүдийг ч аргагүй татмаар ажээ. Энэ зам нь тахирласан наймын тоо хэлбэртэй болохоор хориодхон алхамын талбайтай энэ цэцэрлэг дотор бүтэн жаран алхам явж болох ажээ. Цэцгийн хүрээлэн болсон хорин ширхэг ягаан бутан дээр нь хорхой идсэн нэг ч навч, ялзарсан ганц ч судал харагдахгүй байв. Гэтэл цэцэрлэг дотор чийг хангалттай байлаа. Энэ нь хөө шиг тас хар шороо, өтлөн навчнаас нь илэрхий. Харин байгалийн чийгийг цэцэрлэгийн буланд ухаж суулгасан ган хувин доторх тогтмол усаар түргэн зуур сохьж болно. Хэдий ийм ус чийг элбэгтэй боловч зам дээр нэг ч өвс ургаагүй, цэцгийн хүрээлэнд ч хог өвсгүй ажээ.

Монте-Кристо гүн хаалгыг хааж, олсон гогцоог хадаасанд нь өлгөж түгжээд энэ бүхнийг ажиглан харлаа.

- Цахилгаан мэдээний хүн эсвэл цэцэрлэгчтэй байх, эсвэл өөрөө цэцэрлэгийн ажилд их дуртай бололтой гэж дотроо бодож явжээ.

Тэгтэл дүүрэн навч овоолсон түрдэг тэрэгний цаад талд нэг юмтай гэнэт мөргөлдөв. Тэрхүү юм нь гайхсан дуу гарган босч ирэхэд Монте-Кристо тавь орчим насны бяцхан хүнтэй нүүр тулгарав. Харин тэр бяцхан хүн нь гүзээлзгэнэ түүж, усан үзмийн навчин дээр дэлгэн тавьж байжээ. Усан үзмийн арван хоёр ширхэг навч байх бөгөөд мөн төдийчинээ гүзээлзгэнэ байлаа.

Өвгөн босохдоо жимс, цэцэг, навч, тавгаа арай л унагачихсангүй. - Ургацаа хурааж байна уу? гэж гүн инээвхийлэн асуухад

- Уучлаарай эрхэм минь гэж өвгөн хариулаад, гараа малгай руугаа өргөн – Би дээр байгаагүй нь үнэн боловч дөнгөж сая тэндээс бууж ирээд байна гэлээ.

- Найз минь, намайг ирлээ гэж бүү сандср. Түүж гүйцээгүй бол жимсээ түү гэж гүн хэлэхэд,

- Одоо арав дутуу байна гэж өвгөн хариулаад, бүгд хорин нэг байгаа юм. Ноднин жилийнхээс таваар илүү ургажээ. Энэ хавар дулаахан байсан, гүзээлзгэнэд хэрэгтэй юм гэж байдаг бол энэ нь нар байх. Ингээд л ноднин жил арван зургаа байсны оронд энэ жил хорин нэг болсон юм. Одоо зулгааж аваад байга арван нэг байна. Арван хоёр, арван гурав, арван дөрөв... -- Бурхан минь, хоёр нь алга! Өчигдөрхөн бүр энд байсан юм. Би хэд дахин тоолсон. Лав Симон авгайн хүү идчихэж шүү. Өнөө өглөө тэр үүгээр өнгөлзөж явсан юм.! Хүний цэцэрлэгээс юм хулгай хийдэг үл бүтэх жаал, энэ юунд хүргэж болохыг та мэдэхгүй байгаа бололтой гэлээ.

- Тийм ээ, энэ ч тоглоом биш шүү гэж Монте-Кристо хэлээд,-- гэвч гэмтэн хүний бага нас, амттай юм идэх гэсэн хүсэл хоёрыг нь харгалзан үзэж болох юм биш үү гэхэд, цэцэрлэгч өвгөн,

- Тийм нь ч тиймээ, үүнээс болоод тайвшрах юмгүй байна гэж хэлснээ – Эрхэм ээ, уучлахыг дахин гуйя. Дарга тушаалтан хүнийг хүлээлгээд байгаа юм биш биз? гэж асуугаад гүнгийн цэнхэр фракийг айсан маягтай харлаа.

- Тайвшир, найз минь гэж гүн хэлээд инээвхийлэв. Түүний инээмсэглэл нь гүнгийн хүслээр заримдаа аймшигтай, заримдаа эелдэг зөөлөн болдог бөгөөд энэ удаа зөвхөн эелдэг зөөлнийг илэрхийлж байлаа.

- Би таныг шалган байцаах гэж ирсэн дарга огтхон ч биш. Ердийн л нэг жуулчин хүн. Зүгээр л сонирхохоор ирсэн юм. Харин одоо таны цагийг гарздуулж байгаадаа харамсаж хэрэггүй ирлээ гэж бодож байна гэв.

Тэгэхэд өвгөн өөдөөс нь уйтгартайгаар инээмсэглэн, -- Миний цаг үнэтэй биш ээ. Үнэндээ энэ цаг бол албаны цаг болохоор ингэж үрж болохгүй. Гэвч намайг өдөрт нэг цаг амарч болно Жэсэн.(Тэгээд тэр нарны цагаа харлаа. Монлерийн цамхгийн дэргэдэх цэцэрлэгт хэ°эгтэй юм бүхэн, тэр ч байтугай нарны цаг ч байл а) Одоо аравхан минут дутуу байна. Гүзээлзгэнүүд маань болчихсон. Харин одоо нэг л өдөр өнгөрвөл... Эрхэм минь, үүнийг маань унтаахай идчихнэ гэв.

- Үүнийг чинь би хэзээ ч бодоогүй юм байна гэж Монте-Кристо хариулаад – Бид түүнийг ромчууд шиг балтай холиод идчихдэггүй. Ер нь л зэвүүн хөршүүд шүү гэж хэлэхэд цэцэрлэгч өвгөн,

- Уухай! Ромчууд иддэг гэнэ ээ? гэж асуулаа.

- Би энэ тухай Петронийн номоос уншсан юм гэж гүн хариу өгүүлэв.

- Нээрэн гэж үү? Хэдийгээр унтаахай шиг тарган гэж ярьдаг боловч тийм амттай гэж бодохгүй байна. Тарган байх нь аргагүй, тэд бүхэл шөнийн турш, гэгээн цагаан өдрийн турш унтдаг юм чинь. Ноднин жил надад дөрвөн гүйлс байсан юм. Нэгийг нь тэд гэмтээчихсэн. Бас ганухан ширхэг гялгар хальстай тоор ургаж гүйцсэн байсан юм. Тэгтэл тэр муусайн хогнууд хана руу харсан талыг нь идчихсэн байхгүй юу. Гайхам амттай, сайхан тоор байсан юм. Би тийм амттай тоор хэзээ ч идэж үзээгүй.

- Та тэгээд түүнээ идсэн үү? гэж Монте-Кристо асуухад цэцэрлэгч өвгөн,

- Үлдсэн хагасыг нь идсэн. Бас сайхан эд билээ. Харин тэр эрхмүүд амттай хэсгийг нь анддаггүй амьтад юм. Яг л Симон авгайн хүү гэсэн үг. Тэр хүү бүр хамгийн мууг нь аваагүй байдаг шүү! Гэж хэлснээ цааш нь,-- Энэ жил тийм явдал тохиолдохгүй гэж итгэж бокно. Би жимсээ болж эхлэхээр нь шөнөжин манана гэлээ.

Монте-Кристо ханатлаа сонслоо. Жимс бүр өөрийгөө иддэг хорхойтой байдаг ший хүн бүрд өөр өөрийн шунан дурладаг юм байдаг. Цахилгаан мэдээний өвгөн, цэцэрлэгийн ажилд дуртай ажээ.

Монте-Кристо наран халхалж байсан усан үзмийн навчсыг зулгаан авснаар цэцэрлэгчийн сэтгэлд ихэд таалагдав.

- Эрхэмсэг та цахилгаан мэдээний газар үзэх гэж ирсэн гэв үү? Хэмээн цэцэрлэгч асуухад,

- Тийм ээ, тэгэхдээ танай дүрмээр хориглоогүй бол шүү пээ гэж гүн хэлэв.

- Үгүй, хориглоогүй, үзүүлэхэд ямар ч аюул байхгүй. Бидний дамжуулан нэвтрүүлж байгаа юмыг хэн ч мэдэхгүй, мэдэж ч чадахгүй гэж цэцэрлэгч хэлэхэд гүн,

- Үнэндээ ч та нарын мэдэхгүй дохио тэмдгийг дамжуулан нэвтрүүлж байдаг юм гэж надад хэлсэн юм гэв.

- Тийм ээ, би үүнд нь сэтгэл хангалуун байдаг юм гээд цахилгаан мэдээч инээлээ.

- Яагаад тэр билээ?

- Яагаад гэвэл надад ямар ч хариуцлага ногдохгүй шүү дээ. Би зөвхөн машин, би л ажиллаж байвал надаас юу ч асуухгүй.

“Чөтгөр ав. Ямар ч эрмэлзэл, сонирхолгүй хүнтэй учирчихлаа гэж үү? Тэгвэл надад ашиг болохгүй дээ “ гэж гүн бодлоо.

Тэр үед цэцэрлэгч өвгөн нарныхаа цагийг харж,

- Эрхэм минь, миний арван минут дуусах ойртож, би байрандаа очих ёстой боллоо. Та надтай хамт өөдөө гарахгүй юу? гэлээ.

- Би таныг дагахад бэлэн байна.

Монте-Кристо цайзанд орж очлоо. Гурван давхар, доод д вхарт нь газар шорооны ажлын багаж зэвсгүүд, зээтүү, малтуур, г@ожуур ханын дэргэд байх бөгөөд эдгээр нь эндхийн ганц төхөөрөмж нь ажээ.

Хоёрдугаар давхар нь тэрхүү албан хаагчийн ердийн буюу, үнэндээ унтлагын нь байр байлаа. Энд гэрийн ядуулаг хэрэгсэл ор, ширээ, хоёр сандал, гар нүүрийн чулуун угаалтуур, бас таазнаас дүүжилсэн хуурай өвс төдий байлаа. Тэнд бас үнэт вандуй, испанийн шош байхыг гүн таньсан бөгөөд тэдгээрт ургамлын шинжээч эрдэмтэн шиг шошго хийж хаджээ.

- Эрхэм ээ, цахилгаан мэдээний ажлыг сурахад их цаг шаардагдах уу? гэж Монте-Кристо асуулаа.

- Сурах нь биш, илүү хугацаагаар алба хаах нь удаан үргэлжлэх юм.

- Та хичнээн хөлс авдаг юм бэ дээ?

- Мянган франк эрхэм ээ.

- Бага л байна даа.

- Тийм ээ, гэсэн ч байр өгч байгаа юм.

Гүн тасалгааг нь эргэцүүлэн хараад

- Энэ муу байраа их юманд боддог байх нь ээ гэж аман дотроо өгүүлэв.

Тэд гуравдугаар давхарт гарахад тэнд цахилгаан мэдээний нь газар байлаа. Цахилгаан мэдээний түшмэл машинаа хөдөлгөдөг хоёр төмөр бариулыг нь Монте-Кристо гүн ажиглан харлаа. Тэгээд,

- Их сонин юм аа, гэхдээ л эцсийн эцэст ийм амьдрал танд уйтгартай санагддаг байх даа гэж асуулаа.

- Анхандаа тийм шүү, үргэлж хараад байхаар хүзүү чилчихдэг байсан. Гэвч нэг хоёр жил болоход дасчих юм даа. Бас ч чөлөөтэй өдрүүд, амралтын цаг байдаг юм.

-Чөлөөтэй өдөр гэнэ ээ?

- Тийм ээ.

- Ямар?

- Манантай өдрүүдэд

- Аа, тийм Үайх.

- Тийм өдрүүд бол миний баярын өдрүүд байдаг. Ийм үед би цэцэрлэгтээ бууж, тарих, суулгах, хайчлах, хорхой шавьжнаас хамгаалах ажил хийдэг. Ер нь цаг хугацаа мэдэгдэхгүй түргэн өнгөрдөг юм.

- Та энд ирээд удаж байна уу?

- Арван жил, бас нэмэгдэл албаны таван жил, бүгд арван таван жил болж байна.

- Та одоо хэдтэй вэ?

- Тавин тавтай.

- Тэтгэвэр авахын тулд хэдэн жил алба хаах ёстой вэ?

- Ай, эрхэм минь, хорин таван жил.

- Тэгээд тэтгэвэр нь их үү?

- Зуун эки.

- Хөөрхий хүн төрөлхтөн гэж Монте-Кристо амандаа бувтнахад,

- Эрхэм, та юу гэв ээ? гэж түшмэл асуулаа.

- Үгүй, би энэ бүхнийг их сонин юмаа гэж ярьж байна.

- Чухам юу нь сонин байна?

- Таны энэ үзүүлж байгаа юм бүхэн... Та тэгээд энэ дохионуудаа юу гэж байгааг нь огт мэддэггүй юм уу?

- Юу ч мэддэггүй.

- Мэдэх гэж хэзээ ч оролдоогүй юу?

- Хэзээ ч үгүй. Би үүнийг мэдэж яах юм бэ?

- Үгүй, танд холбогдолтой дохионууд байдаг биз дээ?

- Мэдээж хэрэг. Та тэднийгээ ойлгодог уу?

- Нэг л хэвийн адилхан юм байдаг.

- Юу гэж байдаг юм бэ?

-“Сонин юмгүй байна”,-Та одоо амрах цаг чинь болсон” гэх буюу эсвэл “Маргааш болтол баяртай”...гэдэг.

- Тийм ээ, энэ ч ердийн дохионууд байна гэж гүн хэлснээ – Хараач, таны машин чинь хөдөлж эхэлж байх шиг байна уу даа? гэлээ.

- Тийм байна. Баярлалаа, эрхэм минь.

- Тэр танд юу гэж байна? Та ямар нэг юм ойлгож байна уу?

- Ойлгож байна, тэр намайг бэлэн үү? гэж асууж байна.

- Аа, та хариуд нь...

- Баруун талын нь дохиогоор би бэлэн байгаагаа хэлнэ. Зүүн талынхаар нь нөгөө нэгт нь бэ«эн байгаарай гэж мэдэгдлээ.

- Ураантай хийсэн эд юм аа гэж гүн хэлэхэд,

- Та одоо харж бай. Таван минутын дараа ярьж эхэлнэ дээ гэж өвгөн бахархан ярив.

- Тэгвэл миний мэдэлд бүхэл бүтэн таван минут байх нь ээ. Надад үүнээс илүү цаг хэрэггүй гээд Монте-Кристо гүн,-- Найз минь нэг юм асуухыг зөвшөөрөх үү? Гэлээ.

- Болно оо.

- Та цэцэрлэгт дуртай юу?

- Хачин дуртай.

- Хориодхон алхам газрынхаа оронд хорин фут газартай байвал танд сайхан уу?

- Ай тэгвэл эрхэм минь би түүнийг орчлон дээрх диваажингийн орон болгоно доо.

- Та мянгахан франкаар олигтой амьдрахгүй байгаа биз дээ?

- Нилээд муу байна. Гэсэн ч аргалаад л болгож байна.

- Таны цэцэрлэг чинь даанч жаахан юм аа.

- Нээрээ тийм ч ихгүй шүү.

- Бас тэгээд хамаг юм идэж гүйцдэг унтаахайтай болчихож.

- Тийм ээ, энэ л ёстой гамшиг болоод байна.

- Баруун талынхаа машиныг хөдөлж эхлэхэд та гай болж буруу хараад суучихсан байвал яах вэ?

- Тэгвэл би дохиог нь харахгүй л болно.

- Тэгвэл юу болох вэ?

- Би цааш нь дамжуулж чадахгүй л болно.

- Тэгэхээр яах вэ?

- Салан задгайдаа болоод цааш дамжуулсангүй гэж торгоно.

- Хэдээр?

- Зуун франкаар.

- Жилийн хөлсний чинь арван хувиар уу? Багагүй хэрэг байна даа.
- Одоо яая гэх вэ гэж түшмэл хэлэхэд, гүн,
- Танд ийм явдал тохиорлдсон уу?
- Шар сарнай цэцгээ тарьж яваад ийм явдалд нэг орсон.
- Харин та дохионыхоо ямар нэг зүйлийг өөрчлөх буюу өөр зүйл дамжуулбал яах вэ?
- Тэгвэл өөр хэрэг. намайг эндээс зайлуулж би тэтгэвэргүй хоцорно.
- Гурван зуун франкийн уу?
- Тийм ээ зуун эки. Тэгэхээр би хэзээ ч тийм юм хийхгүй л дээ.
- Арван таван жилийн хөлстэй чинь тэнцэх мөнгө өгсөн ч хийхгүй юу? Энэ тухай бодоход зүгээр л байна шүү дээ. та юу бодож байна?
- Арван таван мянган франкаар уу?
- Тийм ээ.
- Эрхэм ээ та миний айдсыг хүргэж байна.
- Үгүй ер өө!
- Та намайг мөнгөөр татах гэж байна уу даа?
- Чухамдаа яг тийм. Арван таван мянган франк шүү дээ.
- Эрхэм минь баруун талынхаа ашиныг сайн харах боломж олгоно уу?
- Үгүй харин та үүнийг хар л даа.
- Энэ юу юм бэ?
- Юу? Та энэ цаасыг танихгүй гэж үү?
- Мөнгөн тэмдэгт л байна.
- Ёстой жинхэнэ шүү. Энд арван тав байгаа юм.
- Хэний юм бэ?
- Хэрвээ хүсвэл таны юм.
- Миний гээд түшмэд амьсгаа нь давхцан дуу алдлаа.

- Тийм ээ таны бүрэн өмч болно .
 - Эрхэм ээ баруун талын машин хөдөлж эхэллээ.
 - Яах вэ хөдөлж байг.
 - Эрхэм ээ та миний анхаарлыг хөндийрүүлчихлээ. Намайг торгоно шүү дээ.
 - Энэ ч яах вэ, нэг зуун франк л төлнө. Энэ арван таван мянгыг авбал танд л хэрэгтэй юм даа.
 - Эрхэм ээ миний баруун талын хүн иэсэхээ байлаа. Дохиогоо давтаад байна.
 - Аа түүнийг бүү анзаар. Энүүнийг ав гэж гүн хэлээд, боодолтой мөнгийг түшмэлийн гарт атгуулав.
 - Бас гүйцээгүй шүү. Та арван тавхан мянган франкаар амьдарч чадахгүй гэлээ.
 - Миний ажил хэвээрСэ үлдэнэ шүү дээ.
 - Үгүй, та үүийгээ алдана. Яагаад гэвэл та оооо энэ ирсэн дохиог биш өөр зүйлийг дамжуулж өгнө.
 - Ай эрхэмсэг та нада юу гээчийг хэлж байна аа?
 - Хүүхдийн зүггүйтэл.
 - Эрхэм ээ намайг албадах л юм бол...
 - Харин албадах л гэд байна.
- Тэгээд гүн хармаанаас хоёр дахь боодолтой мөнгийг гаргаж ирж,
- Энд арван мянга байгаа юм. таны хармаанд байгаа тэр мөнгөтэй нийлээд хорин тав болно. Таван мянгаар нь та аятайхан байшин, хорин фут газар худалдан авч болно. Үлдсэн хорин мянга нь жилд мянган франкийн орлого оруулна гэж хэллээ.
 - Хорин фут газартай цэцэрлэг гэнэ ээ?
 - Бас жилд мянган франкийн орлого.
 - Бурхан минь, бурхан минь.
 - Май ав ав.
- Тэгээд гүн арван мянган франкаа түшмэлийн гарт хүчээр атгуулав.
- Тэгэхээр би юу хийх болж байна?

- Онц юм биш.

- гэсэн ч?

- Энэ дохиог л дамжуулчих гэж хэлээд гүн хамаанаасаа цаас гаргаж ирэхэд дээр нь гурван дохио ба тэдгээрийн дамжуулах дэс дарааг нь заасан дугаарууд бичигдсэн байлаа.

- Энэ тийм их цаг эзлэхгүй юм шүү дээ.

- Тийм ээ, тэгэхдээ л...

- Одоо танд гөлгөр хальстай тоор, ер нь л юу хүссэн бүхэн чинь бий болно гэснээр гүн шагайсан байгаа оножээ. Сэтгэл нь хөдлөн царай нь улайж хөлс нь гоожсон өвгөн байруун талынхаа дамжуулагчийг ухаан жолоогүй дуудсаар байтал нь гүнгийн өгсөн бүх гурван дохиог дэс дараалан дамжуулав. Болж байгаа явдлыг үл ойлгосон баруун талын хүн тоор жимсний хэнээтэй өвгөн галзуурчээ гэж бодсоноос өөр юмгүй.

Зүүн талынх нь хүний иухайд гэвэл, цаадах нь өвгөний дамжуулсан мэдээг санаанд ч үгүй дамжуулж орхисон бөгөөд эцэст нь энэ мэдээг дотоод явдлын яам хүлээн авчээ.

- Одоо та баян боллоо гэж гүн хэлэхэд, түшмэл,

- Тийм ээ харин ямар үнээр бол доо? Гэхэд гүн,

- Найз минь, би таны сэтгэлийг зовиуртай орхихыг хүсэхгүй байна. танд хэн ч муу юм хийгээгүй, гагцхүү бурхны тааллыг биелүүлэхэд тус болсон гэлээ.

Түшмэд гар дахь мөнгөө барилж үзээд тооллоо. Тэр энгэн үе царай нь зэвхийрч, нэгэн үе улайж байснаа сүүлд нь аяга ус уух гэж тасалгаа руугаа гүйлээ. Гэвч гарын угаартууртаа хүрэлгүй ухаан алдаж хуурай шошгонуудынхаа дунд ойчлоо.

Цахилгаан мэдээ дотоод явдлын яаманд хүрснээс хойш таван минутын дараа Дебрэ сүйх тэргээ хөллөхийг тушааж, Дангларынд очихоор давхилаа.

- Танай нөхөрт Испанийн зээллэгийн облигаци бий юу? гэж хатагтай Данглаараас асуухад,

- Байх байхдаа зургаан саяынх бий.

- Тэр түүнийгээ ямар ч хамаагүй үнээр худалдаг.

- Яахаараа тэр билээ?

- Яагаад гэвэл, Дон Карлос Буржаас оргож, Испанидаа буцаж иржээ.

- Та үүнийг яаж мэдээ вэ?

- Миний мэддэг тэр бүх газраас гээд Дебрэ мөрөө хавчлаа.

Хатагтай дахин хэлүүлэх гэсэнгүй тэр дороо нөхөртөө очиж хэлжээ. Цаадах нь өөрийн төлөөлөгчдөө очиж ямар ч хамаагүй үнээр облигацийг худалдахыг тушаав.

Данглар худалдаж байгааг хараад испанийн зээллэгийн тэмдэгтийн ханш дохроо буулаа. Данглар энүүнээс таван зуун мянган франк алдсан боловч тэмдэгт цааснаасаа салж чаджээ. Орой нь “мэдээнд”

“Цахилгаан мэдээ

Дон Карлос ван хэдийгээр харгалзагч тавьсан боловч Буржаас сэт зайлж Каталаны хилээх дамжин, Испанид эргэн иржээ. Барселон бослого гаргаж түүний талд оржээ” гэсэн мэдээ нийтлэв.

Оройн туршид л тэмдэгт цаасаа зарж амжсан Дагларын болгоомжтойн тухай, энэ аюул дундаас дөнгөж тавхан зуун мянган франк алдаж гарсан энэ их хөлийн наймаачны амжилтын тухай ярьцгаалаа.

Тэмдэгт цаасаа хадгалж хоцорсон буюу Дангларынхыг худалдан авсан хүмүүс өөрсдийгөө хоосорсонд тооцож маш тавгүй хонолоо.

Маргааш нь албан ёсны мэдээнд:

“Дон Карлос оргосон ба Барселонд бослого болсон тухай “Мэдээний” мэдээ нь ямар ч үндэсгүй зүйл боллоо.

Дон Карлос ван Буржаа орхиж яваагүй хагас арал дээр тайван байна.

Энэ алдааны шалтгаан бол манагаас болж буруу ойлгогдсон цахилгаан мэдээ болжээ” гэсэн мэдээ нийтлэгдлээ.

Тэмдэгт цаасны үнэ унаснаасаа хоёр дахин нэмэгдлээ. Алдагдал буюу хожиж борлох байсан орлогыг нь оролцуулбал Дангларт нэг сая франкийн хохирол учирчээ.

Данглар хохирч хоцорсон тэрхүү бирж дээрх гайхалтай эргэлтийн тухай мэдээ ирэх үед гүнгийн байсан Моррельд,

- Харин би таван зуун мянган франкийн үнэ хүрэх нээлтэйг хорин таван мянган франкаар хийлээ гэж Монте-Кристо гүн хэлэв.

- Таны нээлт чухам юу юм бэ? гэж Максимилиан асуухад,

- Би нэгэн цэцэрлэгчийг жимсийг нь иддэг унтаахайгаас ангижруулах арга олсон юм гэж гүн хэллээ.

5.Хий үзэгдэл

Отель дахь тэр байшинд баян хээнцэр Монте-Кристо гүнгийнх гэхэд гойд гоц чимэг гадна талдаа үгүй ажээ. Гэвч энэ байдал эзний өөрийн нь хүслээс шалтгаалжээ.

Гадна талд нь юу ч өөрчилж болохгүй хэмээн гүн хатуу тушаажээ. үүнийг илтгэхэд гагцхүү дотоод төхөөрөмжийг нь харвал боллоо. Нээрээ ч босго алхан ормогц байдал шал өөр болно.

Тасалгаануудыг гоёж чимэглэсэн болон энэ ажлуудыг хурдан түргэн амжуулсан нь Бертуччогийн хэмжээнээс хэтрэн гарчээ гэмээр. Урьд нэгэн цагт XIV Людовикийг юм харахад саад болж байна гээд Антенийнхаас бүхэл бүтэн модот гудамжийг ганцхан шөнийн дотор огтолж байсан шиг огт нүцгэн байсан хашаан мод тарь ногооруулан, үзэсгэлэнт сайхан улиангар, агч моддыг эндэстэй нь авчирч тарьсан нь байшингийн гол урьд талыг сүүдэрлэнэ. Байшингийн өмнө талын өвс ногоо завсраар нь ургачихсан шигтгэмэл бөөрөнхий чулуун замын оронд сайхан ногоон зүлэг өглөөхөн нь суулгасан нь өргөн хивс адил харагдана. Засаж янзалсан энэ өргөн ногоон хивсийг усалсан усны дуслууд гялтганана.

Энэ бүх тушаал шийдвэрүүдийг гүн өөрөө өгчээ. хаана ямар газар хэдэн мод яаж байрлаж байх, чуоун замын оронд ногоон зүлэг дэвссэн талбай ямар хэмжээ хэлбэртэй байх төлөвлөгөөг Бертуччод гаргаж өгчээ.

Ийнхүү байшин танигдашгүй болж, Бертуччо өөрөө ч нээ ногоон хүрээтэй байшинг танихааргүй болсон гэж итгэлтэй хэлж болно.

Бертуччо цэцэрлэг дотор ч мөн юухан хээхэн өөрчлөхөөс буцахгүй байсан боловч тэдгээрт гар хүрэхийг гүн хатуу хоригложээ. Бертуччо үүдний өрөөн, шат, задгай зуухнуудыг цэцгээр арвин гоёжээ.

Үнэнийг хэдлэхэд гэийн даамал бол тушаалыг биелүүлэх ер бишийн авьяастай хүн бөгөөд эзэн нь ч өөртөө үйлчлүүлж чадах чадвартай хүн ажээ. Ингэж хорин жилийн турш хэн ч сууж байгаагүй, он удсаны үнэр гэж нэрлэж болох чийгний үнэр ханхалж, уйтгар гунигтай харагдаж байсан байшин ганцхан өдрийн дотор өөр болж, эзний нь дуртай анхилуун үэнр сэнгэнэн, гэрэл гэгээтэй саруул сайхан болжээ. Гүн байшиндаа ормогц өөрийн ном, зэвсэг, үүдний нь өрөөнд дуртай зургууд, үнэнч ноход, уран дуутай шувуудаа олж харав. Нойрсон байгаа гоо гүнжийн шилтгээн шиг удаан жилийн нойрноос сэрсэн энэ байшин аль эртнээс эхлэн бидэнд хонгор сайхан санагдах болсон бөгөөд гай болж орхиж явахад хүрвэл сэтгэл зүрхнийхээ хагасыг өөрийн эрхгүй үлдээдэг тийм орон гэр мэт амь орж, сэргэн цэцэглэв.

Хашаан дотуур зарц нар хөгжилтэйеэ холхилдоно. Зарим нь гал тогоонд ажиллаж энэ байшинд хэзээний амьдарч байсан юм шиг засаж дууссан шатаар гүйлдэнэ. Зарим нь сүйх тэргийг дэс дугаараар нь зэрэгцүүлэн зогсоосон саравчны дэргэд хагас зуун жил энд байсан мэт зогсох бөгөөд, бас зарим нь адууны хашаанд овъёос идэж, эзэндээ янцгаан хариулж байгаа морьдтойгоо, зарим эзний зарц нар эзэдтэйгээ ярьдгаас илүү хүндэтгэлтэйгээр ярьж байна. номын сан нь хоёр ханын дагуу номын шүүгээнд байх бөгөөд хоёр мянга орчим номтой ажээ. Шинэхэн гарсан романуудад нэгэн хэсгийг бүрэн зориулсан бөгөөд хамгийн сүүлд хэвлэгдсэн алтадсан хавтастай романууд ч харагдана.

Байшингийн нөгөө тал д номын сангийн өөдөөс харсан хэсгийг том том япон ваартай ховор цэцэг навч бүхий ургамлын хүлэмж болгожээ. Нүд хужирлаи энэ сайхан цэцэрлэгт хүлэмжийн гол дунд цагийн өмнө тоглож байгаад шаарийгууды нь амраах гэсэн мэт ногоон цэмбэн дээр нь орхисон бильярдын ширээ байлаа.

Шидэт Бертуччо нэг л тасалгаанд гар хүрсэнгүй. Энэ тасалгаа хоёрлугаар давхрын зүүн буланд байх бөгөөд, тэр тасалгаа руу гол шатаар явж орох ба нууц хаалгаар нь гарч болох ажээ.

Энэ тасалгааны хажуугаар гарахдаа зарц нар сонирхож байхад Бертуччогийн айдас хүрнэ.

Гүн яг таван цагт Алийг дагуулан Отейль дахь байшинд ирлээ. Бертуччо түүний ирэхийг сэтгэл түгшүүртэйгээр хүлээж байжээ. Тэр магтах үг сонсох байх гэж найдаж байсан боловч бас хөмсөг зангидах бий гэж айж байв.

Гүнг сүйх тэрэгнээсээ бууж, байшин дундуур бүгдээр нь явж, цэцэрлэгийг тойрон үзэх зуураа магтсан, дургүйцсэн нэг ч үг дуугарсангүй.

Зөвхөн нөгөө талын түгжээтэй өрөөний эсрэг байх унтлагын тасалгаандаа орж ирээд түүг ирэхдээ анхааран харсан, ягаан модоор хийсэн жижигхэн шүүгээ рүү зааж,

- Зөвхөн бээлийн хийхэд л тохирох юм байна гэлээ.

- Яг тийм шүү гэгээн эзэн минь гэж баярласан Бертуччо хариулаад – Онгойлговол дотор нь бээлий тань байгаа гэж хэллээ.

Бусад шүүгээнүүдэд гүнгийн байлгах гэсэн юм бүхэн, сүрчиг ороомол навчин тамхи эрдэнэс зэрэг нь байлаа.

- Сайн болж гэж гүн сүүлд нь дуугарав.

Сэтгэлийнхээ гүнд хүртэл баярласан Бертуччо гарч одлоо. Энэ хүн орчин тойрныхоо хүмүүст хэчнээн их нөлөөтэй, байдгийг хэлэх юун.

Яг зургаан цагт морин төвөргөөн хаалган дээр сонстлоо. Энэ бол залуу ахмад Медеагаа унаж ирсэн нь энэ ажээ.

Гүн баяртайгаар инээмсэглэн түүнийг үүдэндээ хүлээж зогсов.

- Би түрүүлж ирсэн гэдэгтээ итгэлтэй байна гэж Моррель хашхираад – Цаадуулыг чинь цуглаж иртэл тантай хоёулханаа ганц минут ч болсон хамт байх гэж зориуд яарсан юм. Жюли, Эммануэль хоёр танд мэнд хүргээрэй гэсэн шүү. Танай энд яасан сайхан юм бэ? Гүнтэн танай хүмүүс морийг минь сайн арчилах байгаа даа гэлээ.

- Хүндэт Максимилиан та бүү зов, тэд юу хийхээ мэднэ.

- Энүүнийг сайн шиг хусуурдаж арчих хэрэгтэй юмсан. Яаж давхисаныг нь та харсан бол доо. Ёстой л хуй салхи гэсэн үг.

- Таван мянган франкийн үнэтэй морь чинь тэгэлгүй яах вэ гэж гүн хүүтэйгээ ярьж байгаа эцэг хүний дуугаар хэлэхэд, Моррель сайхан сэтгэлээр инээвхийлж,

- Та түүндээ харамсаж байна уу? гэлээ.

- Би юу? Бурхны аврал! Үгүй. Харин морь л муу байвал миний харамсах юм тэр гэж гүн өгүүллээ.

- Эрхэм гүнтэн минь, морь танихдаа францдаа тэргүүн Шало-Рено, яамныхаа араб морьдыг унадаг Дебрэ хоёр миний хойноос хөөсөн боловч хоцорсныг та харж байгаа биз дээ. тэдний ар талд хатагтай Дангларын морьд гээг даран давхиж явна. Цагт зургаан бээрээс илүү ч үгүй, дутуу ч үгүй давхиж чаддаг морьд доо.

- Тэгвэл тэд одоо энд хүрч иэрэх нь ээ? гэж гүн асуулаа.

- Тийм ээ. За, тэр гараад ирлээ.

Үнэхээр ч тэр даруй аажуухан нээгдсэн хаалгаар хөөс цахруулсан хос морьтой сүйх, араас нь хоёр морьтон давхилдан орж ирлээ. Сүйх тэрэг нэг тойроод хоёр морьтой хүнийхээ хамт үүдэнд ирж зогслоо.

Дебрэ эгшийн зуур мориноосоо үсэрч сүйх тэрэгний хаалгыг онгойлголоо. Тэгээд гарч ирэнгүүтээ гүнээс өөр хэнд ч ажиглагдамгүй хөдөлсөн хатагтай Дангларт гараа өглөө. Гэвч энэ нь гүнгийн нүднээс зайлж чадсангүй. Энэ хөдөлгөөний үед, энэхүү хөдөлгөөн шигээ үл ажиглагдам цагаан зурвас гялсхийн хатагтай Дангларын гараас нарийн бичгийн даргын гарт их л сурмаг дамжсаныг гүн харж амжлаа.

Банкны эзэн эхнэрийнхээ хойноос гарч ирэхдээ царай нь сүйх тэргэн дотроос биш, авсан дотроос гарч ирэх мэт зөвхий дааж харагдав.

Данглар авгай гагцхүү Монте-Кристорд л ойлгогдох тийм ажигч түргэн харцаар хашаа, байшингийн нүүр, тал зэргийг гүйлгэн харснаа сэтгэлийнхээ хөнгөн хөдөлгөөнийг дарж, шатаар өгсөх зуураа Моррельд,

- Эрхэм та хэрвээ миний найз байсан бол морио худалдчихгүй юу гэж гуймаар байна гэлээ.

Тэгэхэд Моррель ярвайснаас ялгаагүй инээмсэглэх аядан Монте-Кристо өөд хүнд байдлаас минь гаргаж өгөөч гэсэн байртай харлаа.

Гүн түүнийг нь ойлгож,

- Ай хатагтай минь, та надаас иймэрхүү юм хүсдэг ч болоосой гэхэд,

- Танаас хүсвэл, даруй хүссэндээ хүрэх болно гэдгийг мэдэх учраас юм хүсэхийн аргагүй санагдах юм. Тийм учраас би Моррель гуайгаас хүссэн юм гэлээ.

- Моррель гуай танд морио өгч чадахгүй нь харамсалтай гэдгийг танд дуулгая. Морио өөрөө авч байна гэдэг бол нэр төрийн хэрэг байгаа юм гэж гүн хэллээ.

- Яагаад тэр билээ?

- Тэр Медеагаа хагас жилийн дотор сургуультай болгоно гэж мөрий тавьсан юм. Хэрвээ мөрийний нь хугацаа дуусахаас өмнө мориноосоо хагацвал мөрийгөө алдахаар барахгүй, түүнийг хулчийлаа гэж ярих болно. Тийм учраас миний бодлоор сайхан хүүхэн гэдэг манай ертөнцийн гэгээн сайхны нэг хэдий боловч, морин цэргийн ахмад сайхан хүүхний адармаатай занг хангахын тулд өөрийнхөө тухай тэгж муухайгаар яриулахыг хүсэхгүй л дээ гэхэд Моррель,

- Хатагтай та харж байгаа биз дээ гэж хэлээд гүнд талархан инээмсэглэв.

- Тэгээд ч бас гээд Данглар эвгүй дуугарснаа засахыг хичээж, хүчээр инээмсэглэн – Танд хэрэлцээтэй морьд бий шүү дээ гэлээ.

Ийм эвгүй үгийг зүгээр өнгөрүүлэх нь хатагтайн зан биш боловч энэ удаа дуулаагүй зүр үзүүлэн юм дуугаралгүй өнгөөрсөнд залуу хүмүүс багагүй гахйлаа.

Гүн энэ хачин эвлэрлийг хараад инээмсэглэн, хатагтайд хоёр аварга хүтад шаазан ваар үзүүллээ. Энэ хоёр дээр зөвхөн байгаль өөрөө л ийм хүчирхэг, шимтэй, нарийн сүлжээсээр бүтээж чадах далайн ёроолын ургамал амтны дүр мушгиралдан харагдана.

Хатагтай ихэд гайхан шагширч,

- Энүүн дотор Тюлирьрийн туулайн бөөр мод тарьж болохоор юм. энэ том юмыг яаж шатааж чадаа юм бол? Гэхэд, гүн,

- Хатагтай минь, зөвхөн панснаас нимгэн шил, бас баримал дүрс төдийнхнийг хийж чаддаг бид энүүнд хариулж чадна гэж үү? Энэ бол өөр эрин үеийн ажил, нэг үгээр хэлбэл газар усны суут ухаантны бүтээл юм гэж хариулав.

- Үгүй ер! Тэгээд жишээлбэл ямар эринд хамаарагдах юм бэ?

- Үүнийг би мэдэхгүй. Зөвхөн хятадын нэгэн эзэн хаан тусгай шатаадаг зуух барихыг тушааж, энүүн дотроо арван хоёр ийм баар шатаахыг тушаасан юм гэнэ билээ. Тэдгээрийн хоёр нь зуухан дотроо хагарчихсан юм гэдэг. Үлдсэн арвыг нь далайн ёроолд гурван зуун сажингийн гүнд хаясан юм гэнэ билээ. тэнгис өөрөөс нь юу шаардаж байгааг мэдэж, тэдгээрийг усны ургамал, шүр, хясаагаараа бүрхжээ. Тэгээд эдгээр ваар тэхнүү асар гүн ёроолд хоёр зуун жил хэвтжээ. Яагаад гэвэл энэ туршлага хийж үзэх гэсэн хятадын хаан хувьсгалаар унагагдаж, түүний оронд зөвхөн ваар шатааж, далайн ёроолд хаясан гэдэг бичиг баримт л үлджээ. Тэгээд хоёр зуун жилийн дараа энэхүү баримт бичгүүдийг олж вааруудыг гаргахаар шийджээ. Тусгай захиалгаар хийлгэсэн хэрэглэлтэй усанд шумбагчид ваар анх хаясан далайн буланд эрэл хийжээ. Гэвч арван ваарын гуравхныг нь олжээ. Бусад нь далайн долгионоор урсан үгүй болсон буюу хагарч үрэгдсэн байна. би энэ ваарнууддаа хайртай байдаг юм. далайн гүнд байхад нь зөвхөн усанд шумбагчид л үзэж чадах тэдгээр аймаар муухай амьтад хүйтэн харцаараа харж байсан ба дайснаас айсан загаснууд дотор нь орж амь зулбаж абйсан нь миний нүдэнд харагдах шиг болдог юм.

Энэ завсар ховор зүйлсийг үл хайхрагч Данглар үлэмжийн сайхан алтан жүрж модын цэцгийг санаандгүй зулгааж байв. Үүнээ дуусаад аршийн нударгад шилжсэн боловч, аршийн мод тийм ч гөлгөр эд биш тул хатуу өргөсөөрөө хатгажээ.

Тэгэхэд Данглар цочиж сая сэрсэн юм шиг нүдээ арчлаа. Гүн инээмсэглэж,

- Уран зурагт дуртай, тийм сайхан зургуудыг цушлуулсан таны дэргэд өөрийнхөө зургуудыг магтаж чадахгүй ч гэсэн яах вэ, Гоббемын хоёр зураг Пауль, Поттер, Мирисийн зургууд, Герад Доугийн хоёр зураг, Рафаэль, Ван-Дейк, Сурбаран ба танд үзүүлж болохуйц Мурильгогийн хоёр гурван зураг байна гэлээ.

- Алив! Би энэ Гоббемын зургуудыг таньж байна гэж Дебрэ хэлэв.

- Нээрээ юү?

- Тийм ээ, үүнийг музейд авахгүй юу гэж байсан юм.

- Тэнд Гоббемын зургаас нэг ч байхгүй байх аа? гэж гүн хажуунаас нь асуув.

- Байхгүй, хэдийн тийм боловч музейд авахгүй гэж татгалзсан юм.

- Яагаад тэр вэ? гэж Шато-Рено асуулаа.

- Та мөн юм мэддэггүй хүн юм даа. засгийн газарт үүний тулд зарах мөнгө байгаагүй юм.

- Уучлахыг хүсье! Би түүнийг найман жилийн турш өдөр бүр сонсож байгаа боловч дасаж чадахгүй л байна гэж Шато-Реног хэлэхэд,

- Аажимдаа дасна аа гэж Дебрэ хэллээ.

- Үгүй л байгаа хэмээн Шато-Рено өөдөөс нь өгүүллээ.

- Хошууч Бартоломео Кавальканти, бэйс Андре Кавальканти хоёр ирлээ гэж Батистен айлтгалаа.

Бидний хуучин таних эервүү эцэг буурал сахалтай хошууч Бартоломео Кавальканти дөнгөж саяхан дэлгүүрээс авсан хар пүүсүү зангиа зүүж, хууз сахлаа гөлийтөл хусаж, гурван одон, таван хирээс тэмдэг зүүж гоёсон хошуучийн ёслолын хувцас өмсөж, итгэлтэйгээр харах нь өө хэлэхийн аргагүй хуучин цэргийн хүний шинжтэй. Дэргэд нь бидний бас таних гял цял болсон дэгжин хувцастай хүндэт хүү бэйс Андреа Кавальканти инээмсэглэн явж байлаа.

Моррель, Дебрэ, Шато-Рено гурав хоорондоо ярьж нэгэн үе эцэг өөд нь, нэгэн үе хүү өөд нь харж байснаа зүй ёсоор сүүлчийнх дээр нь тэдний хараа тогтож бүх талаар нь судаллаа.

- Кавальканти! гэж Дебрэ дуугарахад,

- Сайхан нэр байна шүү, чөтгөр ав! гэж Моррель хэллээ.

- Тийм ээ энэ үнэн гэж Шато-Рено хэлээд – Италийнхан сайхан нэро өгдөг боловч муухан хувцасладаг улс гэлээ.

- Та битгий тохуурх гэж Дебрэ зөрж хэлээд – Түүний хувцас нь сайхан хийцтэй, цоо шинэ юм байна шүү дээ гэлээ.

- Харин энэ чинь л надад таалагдахгүй байгаа юм. энэ эрхэмсэг хүн, дөнгөж өнөөдөр хувцас өмсөж үзэж байгаа хүн шиг харагдаж байна.

- Энэ эрхмүүд чинь хэн гээч улс вэ? гэж Данглар гүнээс асуулаа.

- Кавальканти гэдгийг та дуулсан шүү дээ.

- Зөвхөн нэр нь тийм байж. Цааш нь юу ч мэдэхгүй байна.

- Өө тийм, та чинь манай Италийн ихэс дээдсийг мэдэхгүй л дээ. “Кавальканти” гэдэг чинь сурвалжит баян гэсэн үг.

- Их хөрөнгөтэй юу? гэж банкны эзэн асуулаа.

- Үлгэрт гардаг шиг л баян.

- Эд юу хийдэг улс вэ?

- Хөрөнгөө үрж дуусгах гэж дэмий хичээж байгаа юм. далимд нь хэлэхэд, энэ хоёр таны банкинд мөнгөө гуйвуулсан гэнэ лээ. Уржигдар манайд ирэхдээ ярьж байна билээ. би таныг мөн тэднийг урьсандаа баяртай байна. тэднийг тантай танилцуулья.

- Тэр хоёр францаар их цэвэрхэн ярьж байх шиг санагдлаа гэж Данглар хэлэв.

- Хүү нь францын өмнөд хэсэгт, Марсель юм уу түүний ойролцоо газарт коллеж сургуульд сурсан юм байх. Одоо бүр сэтгэл нь хөөрчхөөд явна.

- Юунаас тэр вэ? гэж хатагтай Данглар асуулаа.

- Франц бүсгүйчүүлээ хатагтай минь. бүр Парисын охинтой сууна гээд байгаа юм.

- Хэлэх юм алга, ухаантай л бодож дээ! гэж Данглар мөрөө хавчин хэлэв.

Хатагтай Данглар нөхөр өөдөө харахад түүний харц нь өөр цагт бол шуурга болохын тэмдэг байсан бол, энэ удаа дуугүй өнгөрлөө.

- Түшээ гүн өнөөдөр нэг л сэтгэл тавгүй байгаа бололтой гэж гүн хатагтай Дангларт хэлээд – Түүнийг сайд болгох гэж байгаа юм биш биз дээ? гэж асуулаа.

- Миний л мэдэж байгаагаар бол одоохондоо үгүй байх. Харин би бол түүнийг бирж дээр азаа үзээд алдаж орхиод, түүндээ хорссоноо хэнд гаргах гээд байгаа юм бол Жэ бодмоор байна.

- Эрхэм Вильфор, хатагтайгаа морилон ирлээ гэж Батистен хэлэв.

Вангийн прокурор гэргийн хамт тасалгаанд орж ирлээ. Вильфор хэдийгээр сэтгэлээ барьж чаддаг боловч сэтгэл нь хэд хөдөлсөн нь илт байлаа. Гүн түүнтэй гар барихдаа гар нь чичирч байхыг мэдэрлээ.

“Хүүхнүүд л гэмгүй царайлж чадах юм даа” гэж гүн өөр зуураа бодонгоо вангийн прокурортой мэнпдлэн инээмсэглээд, эхнэртэй нь үнсэлцэж байгаа хатагтай Дангларыг харж зогсов.

Гүн тэдэнтэй мэндэлсний дараа галын өрөөдн юм хйиж байсан Бертуччо, улс цугларсан өрөөтэй залгаа зочдын жижиг өрөөний үүдээр цухалзахыг харж, түүн руу гарч одлоо.

- Бертуччо танд ямар хэгэ гарав?
- Гэгээн эзэнтэн та надад хэдэн зочин ирэхийг хэлээгүй билээ.
- Нээрэн тийм л дээ.
- Хэдэн хэрэгсэл тавих вэ?
- Өөрөө тоол.
- Гэгээнтэн минь, цөм цугларсан байгаа нь энэ үү?
- Тийм.

Бертуччо дутуухан онгойсон хаалгаар шагайв. Гүн түүнийг ширтэн харав.

- Ээ тэнгэр минь! гэж Бертуччо дуу алдахад гүн,
- Юу болов? гэж асуулаа.
- Тэр хүүхэн!.. Тэр хүүхэн!..
- Аль нь вэ?
- Тэр очир эрдэнэ зүүсэн цагаан даашинзтай... хонгор шар үстэй хүүхэн...
- Хатагтай Данглар уу?
- Би нэрийг нь мэдэхгүй. Гэвч тэр хүүхэн мөн байна. эрхэмсэг эзэн минь мөн байна.
- Хэн “мөн” гэж?
- Цэцэрлэгт байсан хүүхэн. Бие шалтгаанлай байсан тэр хүүхэн. Хүн хүлээж цэцэрлэгт явсан хүүхэн... гэлээ. Бертуччо амаа ангайсан хэвээр дуугүй болж, царай нь зэвхийрэн зөгслоо. Үс нь босох шиг боллоо.
- Хэнийг хүлээж?

Тэгэхэд Бертуччо, Макбет, Банко өөд заадаг шиг тийм хөдөлгөөнөөр Вильфор өөд зөөлөө.

- Тэнгэр минь, та харж байна уу? гэж шивгэнэв.

- Юу вэ? Хэнийг?

- Түүнийг!

- Түүнийг ий? Вангийн прокурор эрхэм де Вильфорыг уу? Мэдээжийн хэрэг харж байна.

- Би түүнийг алчихаж чадаагүй юм байжээ.

- Хонгор Бертуччо минь, та солиорчих шиг боллоо гэж гүн хэлэв.

- Үхээгүй юм байжээ!

- Тийм ээ, үгүй л байна шүү дээ. Үхээгүйг нь та харж байгаа биз дээ. танай нутгийнхны заншлаар зургаа долоо дахь хавирганы завсраар хутга шааж чадалгүй, жаахан дээгүүр юм уу, доогуурдуулчихсан юм байлгүй. Энэ шүүхийн хүмүүс чинь амь бөхтэй улс байдаг юм. эсвэл таны надад ярьсан зүйлд үнэний хувьтай нэг ч үг байхгүй, зөвхөн хий дүрслэл, дэмийрэл байсан хэрэг үү? Та өшөө авах санаагаа зохих ёсоор шингээлгүй унтчихаж тэгээд тэр чинь таны ходоодыг дарж аймшигт зүүд зүүдэлсэн байж л дээ. тэгээд л гүйцээ. За одоохон ухаан орж тоолж үз. Эрхэм Вильфор хатагтайн хамт хоёр, Данлар хатагтай хамт дөрөв, Шато-Рено, Дебрэ Моррель-долоо, хошууч Бартоломео Кавальканти –найм.

- Найм гэж Бертуччо давтан хэлэхэд гүн,

- Байзаарай, байзаарай. чөтгөр ав. та хаашааг тэгж яарав? Та бас нэг зочныг орхичихож, тийшээгээ зинтээгээ хар..тэр тэнд...Андреа Кавальканти, Мурильонигийн дагиныг харж абгяаа хар хувцастай залуу, за тэр наашаа эргэлээ гэж хэлэв.

Энэ удаа Бертуччо арай л хашхирчихсангүй. Гүнгийн харцнаас болж дуу нь аман дээрээ гарч ирээд зогсов.

- Бенедетто! гэж тэр дуулдах төдий дуугараад – Хувь тавилан ийм л байдаг байжээ гэлээ.

- Зургаан цаг хагас боллоо. Эрхэм Бертуччо гэж гүн хэлээд – Энэ үед зоог байрихыг тушаасан биш бил үү. Би хүлээх дургүй гэгийг та мэднэ шүү дээ гэлээ.

Тэгээд гүн зочид дээрээ эргэж очиход, Бертуччо хана түшиж хоолын өрөө рүү явлаа. Таван минутын дараа зочдын өрөөний хоёр хаалга онгойж Бертуччо, Шантилид гардаг Вателю шиг сүүлчийн удаа баатарлаг хүч гаргаж,

- Зоог тавьсан, гэгээн эзэн минь! гэж айлтгалаа.

Гүн хатагтай Вильфорт гараа өгч,

- Эрхэм де Вильфор та хатагтай Дангларт хань болохыг хүсье гэлээ.

Вильфор тэр хүслийг даган биелүүлэхэд цөм хоолын өрөөнд оров.

6.3оог

Бүх зочин хоолны өрөөнд орж явахдаа цөм нэгэн адил зүйлийг сэтгэлдээ бодож явсан нь харваас илт байлаа. Тэд ямар аймшигт хүч тэднийг энэ байшинд цуглуулсны учрыг ойлгохгүй байсан ч зарим нь энд байгаадаа гайхаж, сэтгэл нь зовж байсан боловч бас энд байхгүй байхыг хүссэнгүй ажээ.

Түүнчлэн гүнтэй танилцаад удаагүй, түүний ер бусын хачин зожиг амьдрал, хэнд ч үл мэдэгдэх, бараг үлгэрт гардаг шиг тоймгүй их баялаг нь эрэгтэйчүүдийг бол болгоомжтой байхад, хүүхнүүдийг бол тэднийг хүлээн авах эмэгтэй хүн байхгүй энэ байшинд орж гарч явах замыг нь хаахад хүргэлтэй. Гэвч эрэгтэйчүүд нь болгоомжлолын хуулийг дэвж, хүүхнүүд нь ёс журмын хэмжээг давжээ. Тэдний сэтгэлээс үл салах сониуч зан нь бүгдийг дийлжээ.

Тэр ч байтугай эцэг Кавальканти нь хэв ёсыг хэтэрхий баримталдаг, хүү нь хэтэрхий зайдан задгай ч байлаа гэсэн хоёулаа зорилгыг нь үл мэдэх энэ хүний гэрт анх нүүр учирч байгаа хүмүүстэй нь л тохитой байхын төлөө санаа тавьж байх мэт харагдана.

Гүнгийн хүсэлтээр Вильфор гараа өгөхөд хатагтай Данглар өөрийн эрхгүй цочлоо. Хатагтайн гар Вильфорын гарт хүрэхэд алтан хүрээтэй шилний нь цаадах нүдний нь хараа бүрхэх шиг болжээ.

Сэтгэл түгшсэн энэ хөдөлгөөний нэг нь ч гүнгийн харцнаас зайлсангүй. Энд цугларсан хүмүүс зөвхөн бие биедээ хүрч шүргэх төдийхөн ч гэлээ ажиглаж байгаа хүнд туйлын сонирхолтой ажээ.

Вильфорын баруун гар талд хатагтай Данглар, зүүн гар талд Моррель суулаа.

Гүн өөрөө хатагтай Вильфор ба Дангларын голд суулаа. Бусад суудлуудыг нь эцэг хүү хоёр Кавалькантийн дунд суусан Дебрэ, хатагтай Вильфор, Моррель хоёрын дунд суусан Шато-Рено нар эзэлжээ.

Үлэмжийн сайхан зоог байлаа. Гүн Парисын заншлаас шал өөр хийж, зочдын гэдсийг цатгахаасаа тэдний сониуч занг цатгах зорилго твьжээ. Гүн тэдэнд дорнодын найр, тэгэхдээ арабын шидтэнгүүдийн л хийж чадах тийм найрыг үзүүлжээ.

Ертөнцийн дөрвөн зүгээс, европын элбэг дэлбэгт орж чадах бүх л амттан жимсийг арвинаар хятад ваар, япон тавагнуудтай багсайтал овоолон засжээ. Үзэсгэлэнт сайхан өд сөдтэйгээ ховор шувууд, мөнгөн тавагт өрсөн аварга том загаснууд, Далайн арал, Бага Ази, Өмнөд Африкийн янз янзын үнэт саванд хийсэн болохоор улам ч амттай санагдах төрөл бүрийн дарс дараа дараагаараа Аниций өөрийн биеэр дайлж байна уу гэлтэй зочдын нүд харааг булаана. Энд байгаа парисынхан аравхан хүнд зориулсан хоол мянган луйдороор үтээж бололгүй яах вэ гэж үзэх боловч, үүний тулд Клеопатра шиг сувд залгих ч юм уу, Лоренцо Медич шиг хайлуулсан алт ухаар баян байх хэрэгтэй гэж бодно.

Хүмүүс гайхан шагширч байхыг гүн харлаа. Тэрээр инээж, өөрөө өөрийгөө тохуурхан,

- Эрхмүүд ээ, амьдралын сайн сайхан байпал, нэгдэн тодорхой хэмжээнд хүрч ирэхэд, илүү мэт санагддаг байсан зүйлүүдийг хамгийн чухалд үзэж эхэлдгийг та нар зөвшөөрнө биз. онгод орон хөөрсөн үед хүслэнгийн туйл жинхэнэ бодит зүйл болдог гэдгийг авгайчуул зөвшөөрөх байх. Энэ санааг цааш үзргэлжлүүлье. Гайхамшиг гэж юу вэ? Тэр бол бидний ойлгож мэдэхгүй зүйлийг хэлнэ. Юуг илүү хүсдэг вэ? Олж чадахгүй юмаа л их хүсдэг. Ингээд харагдашгүй юмыг харж, олдошгүй юмыг олох гэдэг бол миний амьдралаа зориулсан гол зүйл мөн. Би үүнийгээ хоёр аргаар: мөнгө, хүсэл зорилгоор олдог. Хачин хүсэл, цагаан зангаа хангахын тулд би Данглар төмөр зам тавихдаа эрхэм де Вильфор та хүнд цаазаар аваачих ял ноогдуулахдаа , эрхэм Дебрэ та ямар нэгэн улсыг төвшин дөлгөөн байлгахдаа, эрхэм Шато-Рено та хүүхнүүдэд аятайхан хаагдахыг хичээхдээ, бас Моррель, та хэн ч унаж чаддаггүй морийг унааны болгон сургахдаа гаргадаг шиг тийм шаргуу зан, цөхрөлтгүй оролдлогыг гаргадаг хүн. Жишээ нь энэ байна. энэ хоёр загасыг хар л даа. нэг нь Санкт-Петербурггаас тавьхан бээрийн газар төрсөн, нөгөөх нь Неаполиас тавхан бээрийн газар төрсөн юм. энэ хоёрыг нэг ширээн дээр зэрэгцүүлэн тавина гэдэг зугаатай хэрэг биш үү? гэв.

- Ямар гэвч загаснууд юм бэ? гэж Данглар асуухад, гүн,

- Шато-Рено Орос улсад байсан болохоор энэ хоёрын нэгийг юу гэж нэрлэдгийг юу гэж нэрлэдгийг нь танд хэлж өгөг, нөгөөгийг нь хошууч Кавальканти итали хүн учир хэлж өгөг гэв.

- Энэ чинь стерляд хэмээх хилим шиг байна гэж Шато-Рено хэлэв.

- Маш зөв.

- Аа, энэ нь хэрвээ би андуураагүй бол нүд загас байна гэж Кавальканти хэллээ.

- Яг тийм шүү. Одоо түшээ гүн та энэ загаснууд хаанаас баригддаг юм бэ гэж асуу л даа.

- Энэ хилим зөвхөн Ижил мөрөнд л байдаг юм гэж Шато-Рено хариулахад, Кавальканти,

- Ийм хэмжээний нүд загас Фузаро нуураас өөр газар байдаг гэдгийг би л дуулаагүй юм байна гэж хариу өгүүллээ.

- Яг тэгсэн юм. нэг нь Ижил мөрнөөс, нөгөө нь Фузаро нуураас ирсэн юм гэж гүн хэлэхэд зочид цөм нэгэн дуугаар,

- Ээ, үгүй байх аа! гэж дуу алдлаа.

- Энэ л надад тааламжтай санагдаж байна гэж гүн хэлээд – Би бол бүтэшгүйг бүтээх гэж хөөцөлддөг, Нерон шиг хүн. Та нарт ч гэсэн аятайхан л байгаа болов уу. Үнэн хэрэг дээрээ алгана, хулд зэргээс доор ч байж болох боловч та нар гайхан

шагширч байна. Яагаад гэвэл эдгээрийг олж авчирч болохгүй шиг санагдсан болохоор тэр. Харин тэгтэл энэ хоёр энд байж байдаг гэлээ.

- Энэ загаснуудыг яаж Парист авчирч чадав аа?

- Энүүнээс амархан юм гэж байхгүй. Эдний нэгийг нь голын өвс, зэгс дэвссэн ган торхонд хийж авчирсан юм. Эднийг тусгай төхөөрөмжилсэн тэргэнд ачи ж ирсэн. Стерлядь нь арван хоёр хоног, нүд загас нь найман хоног тэгж явж ирсэн боловч манай тогоочийн гарт орж нэгийг нь сүүнд, нөгөөг нь дарсанд дарах хүртэл хоёул амьд байж байсан юм. Данглар та итгэхгүй байна уу?

- Юу ч л гэсэн эргэлзмээр байна гэж Данглар зориуд инээмсэглэн өгүүлэхэд гүн,

- Батистен, тэнд байгаа нэг стерлядь, нүд загас хоёрыг аваад ир гэж хэллээ. Өөр торхонд ирсэн, одоо амьд байгаагийг нь шүү гэж тушаав.

Тэгэхэд Данглар нүдээ бүлтийлгэж, бусад бүх хүмүүс алга ташив.

Дөрвөн зарц хоёр ган хувин оруулж ирэхэд дотор нь ширээн дээр тавьсан шиг хоёр загас байлаа.

- Тус бүрээс нь хоёрыг авахын хэрэг юун бэ? гэж Данглар асуухад,

- Эдний аль нэг нь нүд аньчихаж магадгүй шүү дээ гэж Монте-Кристо энгийнээр хариулав.

- Та нээрээ гайхам хүн юм гэж Данглар хэлээд,

- Гүн ухаантнууд юу ч гэж ярьдаг байсан баян чинээлэг байх нь сайхан хэрэг юм гэлээ. Хат гтай Данглар дээрээс нь нэмж,

- Ялангуяа янз янзын юм бодож олж, зохиодог байх зайхан гэж хэллээ.

- Хатагтай минь, энэ санаачлага бол минийх биш, ромчууд ингэдэг байсан юм. Плиний бичсэнээр бол, Остигоос Ромд хэд хэдэн боол сольж *mulus* гэдэг загасыг толгой дээрээ өргөн авчирч байсан гэдэг. Тэр нь дорада гэдэг загас байсан бололтой. Түүний үхэх нь хачин сонирхолтой учир амьдаар нь авчрахыг гойд тансагт тооцож байжээ. Тэр загас үхэхдээ өнгө нь хэд дахин өөрчлөгдөж, солонгорсон олон янзын өнгөтэй болдог ажээ. Үүний дараа загасыг гал тогооны өрөө рүү явуулна.

- Амь давчдах нь алдартай болгож л дээ. харин амьдаар нь үзээгүй хүн бол үхсэн хойно нь тоохгүй.

- Тийм байж, тэгэхдээ Остигоос Ром хүртэл наймаас илүүгүй бээр газар шүү дээ гэж Дебрэ хэлэхэд, Монте-Кристо,

- Тэр үнээн. Лукуллаас илүү гарахгүй юм бол түүнээс мянга найман зуун жилийн хойно төрөхийн хэрэг юу билээ гэж хариу өгүүлэв.

Хоёр Кавальканти хоёулаа гайхан нүдээ бүлтийлгэн харах боловч дуугүй суух нь дээр гэж үзжээ.

- Энэ бүхэн надад их л сонирхолтой байна гэж Шато-Рено хэлээд—Харин хамгийн их сонирхож байгаа юм бол таны тушаалыг ингэж түргэн биелүүлдэг явдал байна. Гүн та энэ байшинг тав, зургаахан хоногийн өмнө худалдаж авсан гэдэг үнэн үү? Гэж асуухад,

- Тийм ээ, түүнээс илүүгүй гэж гүн хариуллаа.

- Энэ долоо хоногт энэ байшин огт өөр болжээ. Хэрвээ би андуураагүй бол энэ байшингийн хаалга нь өөр, хашаа нь дэвсмэл талбайтай, бас хоосон байсан. Харин одоо зүлэг ногоо суулгаж, эргэн тойрон мод тарьс н нь , зуун жил ийм байсан юм шиг харагдаж байна.

- Одоо яая гэх вэ. Би ногоон мод сүүдэр хоёрт дуртай хэмээн Монте-Кристо хариу хэлэв.

- Нээрээ орохдоо зам руу харсан хаалгаар ордог байсан л даа. Намайг ид шидээр аврагдахад гудаижаад харсан хаалгаар оруулж байсныг санаж байна гэж хатагтай Вильфор хэлэхэд,

- Тийм ээ, хатагтай минь. Гэхдээ би Булоны ойг хашаан завсраар харж болох талдаа хаалгатай болох гэж бодсон юм гэв.

- Дөрөвхөн өдрийн дотор гэдэг чинь ёстой гайхамшиг аа! гэж Моррель хэлэхэд, Шато-Рено,

- Үнэндээ хуучирсан муу байшинг цоо шинэ болгоно гэдэг чинь ёстой гайхамшиг! Энэ бол их хуучирсан, тэр ч байтугай доожоогүй царайтай байшин байсан юм. Хоёр гурван жилийн өмнө Бэйл де Сен-Меран худалдах гэж байгааг дуулаад манай ээж намайг очиж үзээд ир гэж явуулж байсныг санаж байна гэж ярилаа.

- Бэйл де Сен-Меран гэнэ үү? Энэ чинь тэдний байсан байшин юм уу? гэж хатагтай Вильфор асуухад,

- Тийм байх аа гэж Монте-Кристо хариуллаа.

- Юу тийм байх аа гэж? Та хэнээс худалдаж авснаа мэдэхгүй гэж үү?

- Үнэнээ хэлэхэд, үгүй. Энэ бүхнийг миний гэрийн даамал хариуцан эрхэлдэг юм.

- Энд лав арваад жил хүн сууж байгаагүй байх аа. Хаалттай цонх, түгжээтэй хаалга, өвс ургачихсан хашааг харахад уйтгартай байсан юм. Хэрвээ энэ байшин вангийн прокурорын хадмынх биш байсан бол дотор нь асар муухай гэмт хэрэг хийгдсэн нүгэлт байёин гэж бодож болох сон билээ гэж Шато-Рено хэллээ.

Үүний өмнө урдаа байсан гайхамшгийн дарс хийсэн хундагануудын алинд нь ч гар хүрээгүй байсан Вильфор одоо гартаа аль дайралдсан хундагыг авч нэг амиар хоосолчихов.

Монте-Кристо хэсэгхэн зуур дуугүй байснаа Шато-Реногийн хэлсэн үгийн дараах чимээ аниргүй байдлын дунд өгүүлсэн нь,

- Намайг анх энэ байшинд орж ирэхэд таны саяны хэлдэг шиг санаа төрсөн нь хачин юм шүү. Энэ байшин надад нэг л зэвүүн санагддаг бөгөөд даамал маань миний өмнөөс худалдаад авчхаагүй бол би энэ байшинг яавч авахгүй байсан юм. Өөдгүй золиг, нотариатын хүнээс жаал зугаа юм авсан юм байлгүй гэлээ.

Тэгэхэд Вильфор инээмсэглэхийг оролдон,

- Тун ч магадгүй дээ, харин энэ хээл хахуул авч, өгсөнд би буруугүй шүү гэж амандаа бувтнаад—Энэ байшин одоо ахиад гурав дөрвөн жил хүн суухгүй байвал бүр нурж гүйцэх байсан учир де Сен-Меран бэйл ач охиныхоо инжийн хагас болох энэ байшинг худалдах гэсэн юм гэлээ.

Энэ удаа Моррелийн царай зэвхийрлээ.

- Ялангуяа нэг тасалгаа гээд гүн цааш үргэлжлүүлэн,— Харахад ердийн л нэг улаан бөсөөр доторлосон тасалгаа, яагаад ч юм, бүү мэд, хачин эмгэнэлтэй санагддаг юм даа гэхэд,

- Яагаад тийм эмгэнэлтэй санагддаг юм бол? Гэж Дебрэ асуулаа.

- Аяндаа зөнгөөрөө төрсөн бодолд яаж дүгнэлт хийх вэ ээ? Танд уйтгартай санагддаг газар байхгүй гэж үү? Яагаад тийм санагддагийг нь хүн өөрөө ч мэддэггүй. Биднийг өөр цаг үе, өөр орон газарт, магадгүй, бидний байгаагаас огт өөр газарт аваачиж болох дуртгал, санаа бодол, хүслэнгийн үрээр ч гэх үү дээ... Энэ тасалгаа надад де Ганж ноёгтой [1](#)эсвэл Дездемоны тасалгаатай тун адилхан санагдсан шүү. Бид одоо хоолоо идэж дууссан болохоор цэцэрлэгт орж кофе уухаасаа өмнө, хэрэв та нарыг хүсвэл би тэр тасалгааг үзүүлье. Хоолны дараа юм үзэхэд зүгээр байдаг.

Ингэж хэлээд Монте-Кристо зочид өөдөө асуусан байртай харахад хатагтай Вильфор бослоо. Монте-Кристо бас босоход бусад хүмүүс тэр хоёрыг дагалаа.

Вильфор, хатагтай Данглар хоёр байрандаа хадагдчихсан юм шиг хэсэг сууж, айснаасаа болж бие нь хөрч, дуу чимээгүй өөд өөдөөсөө харлаа.

- Та дуулав уу? гэж хатагтай Данглар хэлэхэд Вильфор босч түүнд гараа өгөөд,

- Явах хэрэгтэй гэж хэлэв.

Сонирхол нь ихэд хөдөлсөн зочид зөвхөн нэг тасалгааг үзээд зогсохгүй, түүний далимаар Монте-Кристингийн харш болгож босгосон эвдэрхий байшингийн бусад хэсгийг нь үзэхээр тархан явав. Ийм учраас цөм л охгорхой байгаа хаалга руу явахад гүн сүүлдсэн хоёрыг хүлээж байгаад тэднийг ирэхээр нь инээмсэглэн даган

явлаа. Хэрэв зочид түүний инээмсэглэлийн учир холбогдлыг ойлгосон бол үзүүлэх гэж байгаа тасалгаанаас ч илүү их айдас төрүүлэх байсан биз ээ.

Үнэхээр ч бүх байшинг эхнээс нь үзэж о^оны оронд зөөлөн сандал ба вэр тавилсан модон хэрэглэлийн оронд Жаанс тамхи, зэвсэг тавьсан тасалгаанууд, хуучин сайхан мастеруудын зурсан шилдэг сайхан зургууд хадсан олон өнгийн хээ хуартай гайхам сайхан зочдын өрөө, нэхмэл эдээр дотрлосон эмэгтэй хүний өрөө зэргийг үзсээр яваад өнөөх тасалгаандаа хүрч ирлээ. Хэдий бүрэнхий болсон боловч гэрэл асаагаагүй байсныг эс тоцвол тасалгаан дотор ямар ч гойд гоцын юм байсангүй, доторх бүх юм нь хуучирч муудсан байхад бусад тасалгаа нь цоо шинээр засагдсан байв.

- Нээрээ энд эгдүү хүрмээр эвгүй байна шүү гэж хатагтай Вильфор дуугарлаа.

Хатагтай Данглар аман дотроо үглэсэн боловч түүнийг хэн ч сонссонгүй.

Улаан тасалгаанд үнэхээр ямар нэг аймшигтай юм байх шиг санагдаж байгаа тухай зочид үг хаялцаад авав.

- Үнэндээ эвгүй шүү, хараач! Энэ ор ямар эвгүй харагдана вэ? цус мэт ямар муухай өнгөөр энэ өрөөг доторлоо вэ? бас энэ чийгнээс болж бүдгэрсэн хоёр зургийг хараач. Энэ хоёр зурагны цусгүй уруул айсан нүд нь “Бид харсан” гэж байгаа юм шиг та нарт санагдахгүй байна уу? гэж гүн хэллээ.

Вильфорын царай үнэхээрийн цонхигор болж, хатагтай Данглар тэсэж чадахаа болиод задгай зуухны дэргэд очиж суулаа.

Тэгэхэд хатагтай Вильфор инээмсэглэн,

- Эрмина, чи яах гэж энүүн дээр суучихав. Наад дээр чинь гэмт хэрэг хийгдсэн байж ч мэдэх юм биш үү? Гэхэд хатагтай Данглар яаран бослоо.

- Үүгээр ч зогсохгүй гэж гүн хэлэхэд хатагтай Данглар тэгж тэвдэж байхыг харсан Дебрэ,

- Бас юу байх нь вэ? гэж асуулаа.

- Нээрэн өөр юу байна? гэж Данглар асуугаад - Үнэнээ хэлэхэд би одоогоор төдий л гойд юм олж хараагүй байна. харин эрхэм Кавальканти та ямар бодолтой байна? гэхэд цаадах нь,

- Яах вэ, манай Пизед Уголиногийн цамхаг, Ферраред Тассогийн гяндан, Риминид, Фраческо ба Паологийн тасалгаагэж байдаг юм гэв.

- Тийм ээ харин та тэнд ийм шат байхгүй шүү дээ гэж гүн хэлээд далд хаалгыг онгойлгож - Үүнийг хараад ямар бодол төрж байгаагаа хэлж өгнө үү? гэлээ.

- Ямар муухай мушгиралдсан шат вэ? гэж хэлээд Шато-Рено инээлээ.

- Ингэхэд Хиоссны дарс ингэж уитгар төрүүлээд байгаа юм уу мэдэхгүй, ер нь л энэ байшин надад баахан эвгүй бодол төрүүлээд байна гэж Дебрэ хэллээ.

Моррелийн тухайд гэвэл Валентинагийн инжийн тухай үг дуулснаас хойш уйтгартай болж, нэг ч үг дуугарсангүй.

- Нэгэн түгшүүртэй харанхуй шөнө, хүний нүднээс нуувч, бурхны хараанаас зайлж үл чадах ямар нэгэн гэмт хэргийн баримт болох зүйлийг аваад энэ шатаар Отелло эсвэл Ганж ламтан бууж явжээ гэж бодоод үз л дээ гэж гүн хэлэв.

Хатагтай Данглар, хана түшихээс өөр аргагүй болоод байгаа Вильфорын гар дээр арай л ухаан алдан унасангүй.

- Хатагтай та яаж байна? гэж Дебрэ асуугаад – Царай чинь ямар их цонхигор болчихоо вэ! гэж хэлэхэд хатагтаа Вильфор тосож аваад,

- Юу болж байгаа нь маш ойлголмжтой байна. биднийг цөмийг нь айж үхэхэд хүргэх гэж гүн аймшигтай юм ярьж байна гэлээ.

- Нээрэн та хүүхнүүдийг айлгаж байна шүү гэж Вильфор хэлэхэд,

- Та яаж байна гэж Дебрэ хатагтай Дангларт шивгэнэн хэлэв.

Тэгэхэд хатагтай биеэ барьж, хүч гарган,

- Зүгээр, зүгээр, зөвхөн дотроо л бүгчимдээд ингэж байна гэж хэллээ.

- Цэцэрлэгт очихгүй юу гэж Дебрэ хатагтайд хэлээд гараа өгч нууц шат уруу зүглэхэд хатагтай,

- Үгүй, үгүй, би эндээ хоцорье гэлээ.

- Хатагтай та үнэхээр айчихлаа гэж үү? хэмээн гүн хэлэхэд хатагтай Данглар,

- Үгүй, гүнтэн та чинь хий зөгнөлт зүйлийг жинхэнэ бодитойгоор болж байгаа мэт санагдахаар ярьж чадахаар хүн юм гэлээ.

- Тийм ээ, зүгээр л санаанд орсон зүйлээ дүрслэн ярьж байгаа нь энэ. Нээрээ энэ өрөөг өрх гэрийн эх эмэгтэйн тайван нойрсох өрөө гэж бодож яагаад болохгүй байх вэ. энэ улаан бүтээлэгтэй орыг Люцина дагина ирж баярлуулсан ор, бас энэ шатыг саяхан төрсөн хүүхнийг сэрээхгүйн тулд эмч буюу сахиул сэи орж гардаг хаалга, эсвэл хүүхдийн эцэг өөрөөнөйрсож байгаа жаалаа тэвэрч салхинд гардаг хаалга гэж яагаад бодож болохгүй билээ дээ.

Гэтэл хатагтай Данглар энэ намуун дөлгөөн ярианд тайвшрах нь байтугай харин гиншин дуугараад ухаа алдан уналаа.

- Хатагтай Дангларын бие эвгүйрхэж байх шиг байна. түүнийг сүйх тэргэнд аваачих юм биш үү? Гэж Вильфорыг хэлэхэд гүн,

- Бурхан минь, би дусаалгаа авчтрсангүй! Гэж хэлэв.

- Миний өөрийнх байна гэж хатагтай Вильфор хэллээ.

Тэгээд хатагтай, Эдуар хүүгийн хэрэглэсэн тэрхүү ачтай дусаалгын адил улаан өнгөтэй шингэн зүйлийг хийсэн савыг гүнд өглөө. Гүн түүнийг хатагтайн гараас авч,

- Үгүй ер!... гэж хэлэхэд хүүхэн

- Тийм ээ, би таны зааж өгсөнийг дагасан юм гэж шивгэнэв.

- Тэгээд амжилттай юу?

- Тийм шиг л надад санагдсан.

Тэр үед хатагтай Дангларыг зэргэлдээ тасалгаанд аваачжээ. Монте-Кристо түүний уруулыг нэгэн дуслар норгоод хатагтай таруй сэргэж ,

- Ямар аймшигтай зүүд вэ? гэж дуугарлаа.

Тэгэхэд энэ бол зүүдэлсэн биш гэдгийг иэдэгдэхийн тулд түүний гарыг чанга атгалаа.

Дангларыг хайж гарав. Сэтгэл нь бараг уярна гэж байдаггүй тэр хүн аль хэдийн цэцэрлэгт очиж, эцэг Кавалькантитай Ливорно Флоренцийн хоорондох төмөр замын зураг төслийн тухай ярилцаж байлаа.

Гүн их л сандарч тэвдсэн хүний байдалтайгаар, хатагтай Дангларыг сугадан, эцэг хүү хоёр Кавалькантийн дунд сууга Данглар дээр очлоо.

- Хатагтай таныг би тэгж их айлгачихлаа гэж үү? Хэмээн гүн хэлэхэд,

- Үгүй, гүнтэн бид чинь зан ааш ямар байснаасаа болоод элдэв сэтгэгдэлд автдаг улс шүү дээ гэв.

Вильфор инээмсэглэхийг оролдож,

- Зүгээр л ямар нэг аймшигт юм зохиогоод ярьчихвал болох нь шүү дээ... гэж хэлэхэд,

- Үнэмшинэ үү байна уу өөрсдөө л мэд гэж гүн хэлээд – Харин энэ байшин дотор ямар нэгэн гэмт хэрэг үйлдэгдсэн гэдгийг би хувьдаа хаьтуу итгэж байна гэв.

- Болгоомжлоорой, байгаарай, энд чинь вангийн прокурор байна шүү гэж хатагтай Вильфорын хэлэхэд, гүн,

- За яах вэ, тэгвэл энэ тохиолдлыг ашиглаад нэг юм аэдэгдээд орхиё гэв.

- Мэдэгдэх ий? Гэж Вильфор асуулаа.

- Тийм ээ харин гэрчийн этгээдийн дэргэд шүү.

- Энэ бүхэн онцын сонирхолтой байна гэж Дебрэ хэлээд – Хэрвээ энд үнэхээр гэмт хэрэг болсон юм бол бидний хоол шингэхэд тус болог гэж хэлэв.

- Энд гэмт хэрэг хийгдсэн байна билээ гэж Монте-Кристо гүн хэлээд – Эрхэмүүд ээ, наашаа ирцгээ, эрхэм де Вильфор таныг бас наашаа ирэхийг хүсье. Би энэ мэдэгдэх зйлээ хүчин төгөлдөр, хууль ёсны болгохын тулд засаг төрийн зохих төлөөлөгчийн дэргэд хэлэх ёстой гэж үзэж байна гэв.

Гүн Вильфорыг сугадан аваад бас хатагтай Дангларын гараас барьж илүү их өтгөн сүүдэр туссан чанар модны зүг вангийн прокурорыг аваачлаа.

Бусад гийчид тэднийг даган явлаа.

- Харцгаа таминь, яг энд гэж хэлээд хөлөөрөө дэвсэлж, - Хуучин моддод шинэ шим тэжээл өгөхийн тулд хари шороо хий гэж би тушаасан юм. тэгээд миний ажилчид газар ухаж байгаад хайрцаг өөрөөр хэлбэл хайрцагны төмөр хэсэгт тулжээ. Тэр хайрцаг дотро нь дөнгөж төрөхөд нь булчихсан хүүхдийн араг яс байжээ. Энэ бол зохиомол дэмий яриа биш шүү гэв.

Тэгэхэд хатагтай Дангларын тохой нь хүндэрч, Вильфорын гар чичрэхийг гүн мэдэрлээ.

- Дөнгөж төрсөн хүүхэд ий? Гэж ДеУрэ давтан асуугаад - Чөтгөр ав, энэ хэрэг их ноцтой хэрэг болж байна аа гэв.

- Заа тээр, байшин саванд хүртэл хүнтэй адил түүний дотоод чанар нь илрэн харагддаг өөрийн нь сэтгэл оюун, зүс царай байдаг гэж миний хэлсэн үг буруугүйг харж байгаа биз. энэ байшин уйтгар гунигтай харагдаж байж, гэмт хэргийг нуун дарагдуулж байснаас сэтгэл тарчилж байсан байна гэж Шато-Рено хэлэхэд, Вильфор сүүлчийн удаа хүч гарган,

- Чухам яагаад гэмт хэрэг байх ёстой юм бэ? гэж татгалзан асуулаа.

- Яалаа гэж! Сая төрсөн хүүхдийг амьдаар нь цэцэрлэгт булчихна гэдэг гэмт хэрэг биш гэ та бодож байна уу? Имй явдлыг вангийн прокурор та юу гэж нэрлэх вэ? гэж гүн дуу алдлаа.

- Амьдаар нь булчихсан гэдгийг хаанаас мэдээ вэ?

- Тэгээгүй юм бол түүнийг яах гэж энд булсан байх вэ? Энэ цэцэрлэг чинь хэзээ ч хүүр оршуулах газар болж байгаагүй юм билээ.

- Танай францад хүүхэд алдаг хүмүүсийг яадаг вэ? гэж хошууч Кавальканти асуухад,

- Шууд л толгойг нь авчихдаг юм гэж Данглар хариулав.

- Өө, толгойгийг нь авчихдаг гэнэ ээ! гэж хошууч давтан өгүүлэв.

- Тэгдэг байх аа. Тийм биз, эрхэм де Вильфор? Гэж гүн асуулаа.

- Тийм ээ гүн гэж цадах нь хүний дуу гэхийн тэмдэггүй дуугаар хариулав.

Энэ жүжгийг зориулж зохиосон тэр хоёр хүн нь цаашид тэсвэрлэхээ больж байгааг гүн ойлголоо. Тэгээд дэндүү хэтрүүлэхийг хүссэнгүй.

- Эрхэмүүд ээ, кофе уух аа яав? Бид ыүр мартчихаж гэж гүн хэлэв.

Тэгээд ногоон зүлгийн дунд зассан ширээ лүү зочдоо дагуул н явлаа.

- Гүн минь, би ийм сул доройгоо мэдэгдсэнээ ичиж байна. гэвч энэ аймшигт түүх намайг бүр сульдаачихлаа. Намайг суухыг зөвшөөрнө үү гэж хатагтай Данглар хэлээд сандал дээр тэр чигтээ уначихлаа.

Гүн түүнд бөхийн ёслоод хатагтай Вильфор дээр очоод,

- Хатагтай Данглар таны дусаалга хэрэг болж байх шиг байна гэв.

Гэвч хатагтай Вильфор өөрийн найз хүүхэн дээрээ хүрч очихоос өмнө вангийн прокурор хатагтай Дангларт шивгэнэж амжжээ.

- Бид хоёр ярилцах хэрэгтэй байна.

- Хэзээ?

- Маргааш.

- Хаана?

- Миний албан тасалгаанд... Хэрвээ та тагалзахгүй бол шүүх хурлын өрөөнд. Энэ бол хамгийн аюулгүй газар гэж бодож байна.

- Би очимз.

Энэ үед хатагтай Вильфор хүрч ирэв.

Тэгэхэд хатагтай Данглар инээмсэглэхийг оролдоод,

- Баярлалаа, найз минь. одоо овоо зүгээр болчихлоо гэж хэлэв

7.Гуйлгачин

Үдэш орой боллоо. Хатагтай Вильфор парис руугаа буцах тухай үг цухуйлгав. Харин хатагтай Данглар өөрт нь эвгүй байсан боловч буцах тухай ярьж зүрхлэхгүй байжээ.

Тэгэхэд Вильфор эхнэрийнхээ хүсэлтээр хамгийн түрүүнд явах дохио өглөө. Вильфор эхнэрийгээ, хатагтай Дангларт үйлчилж болох боломж олгох гэж өөрийнхөө тэргэнд түүнийг хамт суухыг урилаа. Кавалькантитай ихэд ажил хэргийн яриа дэлгэж суусан Данглар болж байгаа явдлыг анзаарсангүй.

Гүн хатагтай Вильфороос шилтэй шингэнийг нь гуйнгаа эрхэм Вильфор, хатагтай Дангларт дөхөж очихыг ажиглан харжээ. Гүн түүний байдлыг ойлгох тул хэдийгээр Вильфор хатагтай Дангларт өөрт нь ч арай гэж дуулдах төдийн аяархан хэдлсэн боловч чухам юуны тухай хэлснийг нь тааварлажээ.

Гүн ирсэн зочидыг Вильфорын сүйхэд сууж явахад нь ямар ч саад болсонгүй. Кавальканти Дангларын сэтгэлд улам улам таашаагдсан тул түүнийг өөрийнхөө сүйх тэргэнд сууж явахыг урьжээ.

Андреа Кавалькантийн тухайд гэвэл, өөрийг нь үүдний дэргэд хүлээж байгаа том бор морь хөллөсөн тэрэгний зүг явав. Хэтэрхий тэгжин хөтөч өлмий дээрээ зогсож, морины хазаараас барьж байв.

Хоол идэж байх үед Андреа бага ярилаа. Тэр ухаалаг хүн байсан учир ийм баян, нөлөөтэй хүмүүсийн дунд ямар нэг илүү дутуу юм ярчих вий гэж өөрийн эрхгүй болгоомжилжээ. Түүнээс гадна түүни дүрлэгэр нүд нь вангийн прокурор дээр түгшүүртэй янзаар тусна.

Хэтэрхий ёсорхог хошууч ба түүни йнэлээд хулчгар байрын хүүг Данглар зэрвэсхэн хараад энэ бүхнийг гүнгийн найрсаг байдалтай зэрэгцүүлэн үзэж, үе залгамжлагчийгаа дээдсийн хүрээлэнгийн хүмүүжлээр төгс хүмүүжүүлэхийн тулд Парис хотод хүрэлцэн ирсэн учиргүй байн хүнтэй учирчээ гэж боджээ.

Тийм учраас Данглар түүний чигчий хуруунд гялалзан байгаа том доржпалам чулууг хэлж барашгүй бахдан харж байв. Хошууч хашир болгоомжтой хүн болохоор мөнгөн тэмдэгтэд нь ямар нэг явдал тохиолдохоос болгоомжлон тэр дор нь үнэт зүйл болгон хувиргаж аьсан нь энэ байв. Хоолны дараа тэр, үйдвэ° ба аялал жуулчлалын тухай ярих далимаар эцэг хүү хоёрын амьдралын байдлыг асууж сонирхов. Эцэг хүү хоёр Дангларын банкинд нэгэнд нь нэг удаа дөчин найман мянган франк, нөгөөд нь жил бүр тавин мянган ливрийн данс нээхийг мэдэж байгаа болохоор Данглартай их л элэгсэг дотно талархалтай айсан бөгөөд, түүнийгээ илэрхийлж л байвал зарц нарын нь ч гарг атгахад бэлэн байлаа.

Данглах тэднийг тоомсорлон үзэж тэр бүү хэл хүнднтгэх болсонд бас учир бий. Юуг ч үл гайхах Горацийн зарчимд үнэнч хошууч шилдэг сайн нүдэн загасыг аль нуураас барьдгийг хэлснээрээ юм мэддэгээ харуулж чаджээ. Дараа нь загаснаас өөрт ногдсон хувийг дуугуй сууж байгаад идэж орхив. Энэ байдлыг Данглар хараад, энэ бол тэдний ердийн хэрэг, эд лав өөрийн Луккдээ гүн Фузаро нуураас нүдэн загас, Ижил мөрнөөс хилэм авчирдаг аргаар Швецараас захиж авчирсан хулд, Бретанаас авчруулсан аварга хавчаар хооллож суудаг байх гэдэг дүгнэлт хийжээ.

Тийм учраас Кавалькантийг,

- Эрхэм минь, би маргааш тан дээр ажил хэргээр очиж болох нь ээ гэж хэлэхэд их л элэгсгээр,

- Би таныг хүлээн авч уулзахдаа баяртай байна гэж хариулав.

Үүний дараа Данглар, Кавалькантид хэрвээ хүүгээсээ тусдаа явахыг зөвшөөрвөл жононгуудын зочид буудалд хүргээд өгье гэв.

Тэгэхэд Кавальканти, хүүгээ аль эртнээс биеэ даасан залуу хүн ёсоор мьдарч байгаа, иймээс өөрийн морь тэрэгтэй, тэгээд ч бас ийшээ тус тусдаа ирсэн болохоор ганц ганцаараа буцахад болохгүй юм алг гэж хариу өгүүлэв.

Тэгээд хошууч Дангларын сүйх тэргэнд орж суулаа. Банкны эзэн дэргэд нь сууж, нямбай хямгатай байхын тухай зөв зүйтэй яриаг сайшаан шагшрах боловч, энэ нь хүүдээ жилд тавин мянган франк өгөхөд нь саад болдоггүй юм байна. ийм хэмжээний мөнгө өгөхийн тулд дор хаяж жилдээ тав буюу зургаан зуун мянган франкийн орлоготой байх хэрэгтэй дээ гэж бодож явлаа.

Тэр үед Андреа ихэмсэг дүр үзүүлэхийн тулд хөтчөө морио үүдэнд аваачсангүй, хаалганы дэргэд хүлээж, бүхэл бүтэн гучин алхам явуулахад хүргэлээ гэж зэмлэж байв.

Хөтөч нь зэмлэлийг хүлцэнгүй номхон хүлээн зогслоо. Тэрээр зогсож ядан туурайгаараа цавчлан байгаа мориныхоо хазаараас зүүн гараараа барьж, баруун гараараа жолоог нь Андреад өгвөл цаадах нь хөлөө гишгүүр дээр тавихаар өргөлөө.

Энэ үед нэг хүн түүний мөрөн дээр гараа тавилаа. Тэгэхэд Данглар, Монте-Кристо хоёрын аль нэг нь түүнд ямар нэг юм хэлэх гэж бодож байснаа гэнэт санаад ирж байгаа байх гэж бодоод эргэн харав.

Гэтэл үс сахал нь ургачихсан наранд түлэгдсэн нүүр, нүүрс шиг гялтганасан хар нүдтэй хачин царайтай хүн цөөвөр чонынх шиг хурц ховдог гучин хоёр цагаан шүдээ яралзуулан доогтойхон инээмсэглэн зогсож байв.

Буурал орсон, өнгөгүй өтгөн үстэй толгойдоо дөрвөлжин судалтай улаан алчуур зангиджээ. Ясархаг чөргөр өндөр биендээ тийм гэхийн тэмдэггүй уранхай хувцас өмссөн бөгөөд хөдлөх үе мөч нь хэлхээтэй араJ яс мэт санагдах ажээ. Андреа эргэхдээ мөрөн дээр дарсан гарыг нь түрүүлж харвал, энэ гар түүнд аварга том юм шиг санагджээ.

Андреа тэрэгнийхээ бүдэг дэнгийн гэрэлд тэр хүний царайг таньсан ч юм уу, эсвэл энэ хүний аймаар байдлаас зэвүүрхсэн ч юм уу цочин дайвалзлаа.

- Танд юу хэрэгтэй вэ? гэж хэлэхэд ирсэн хүн гараа улаан алчуур дээрээ тавиад,

- Хүндэт хүн гуай, уучлаарай, би танд садаа болсон байж магадгүй. Гэвч би танд юм хэлэх хэрэгтэй байна гэв.

Тэгэхэд тэнүүлчин шалгаахаас эзнээ зайлуулах гэж хөтөч нь,

- Шөнийн цагаар хишиг гуйдаггүй юм гэхэд,

- Хөөрхий хүү минь, би юм гуйх гээгүй гээд үл таних хүн ёжилсон байртай инээмсэглэх нь нэг л аймаар тул зарц өөрийн эрхгүй ухрав,-- Таны эзэн хоёр долоо хоногийн өмнө надад даалгавар өгсөн учир түүнд хоёрхон үг хэлэх гэсэн юм.

- Танд юу хэрэгтэй вэ? гэж Андреа өөрийн түгшсэн сэтгэлийг зарцдаа мэдэгдэхгүйн тулд нилээд ширүүн дуугараад,-- Найз минь түргэн хэлээрэй гэхэд нөгөө хүн дөнгөж дуулдах төдийгөөр,

- Та намайг Парис руу явган буцахгүй болгож өгнө үү? Би чам шиг сайн хоол идээгүй болохоор ядарч, хөл дээрээ дөнгөж зогсож байна гэв.

Андреа энэ хаёин яриаг сонсоод цочин давхийж,

- Та чинь яах гээд байгаа хүн бэ? гэлээ.

- Та намайг сайхан тэргэндээ суулгаж явахыг л хүсэж байна.

Ингэж хэлэхэд Андреагийн царай зэвхийрсэн боловч юм хэлсэнгүй.

Тэгэхэд улаан алчуурт хармаандаа гараа хийгээд, өдсөн байдалтайгаар залуу хүн өөд харж,

- Надад ингэх хэрэгтэй байна. Дуулж байна уу?, миний жаахан Бенедетто? Гэж хэлэв.

Андреа энэ үгийг сонсоод даруй номхорч, хөтөч дээрээ очоод,

- Би энэ хүнд үнэхээр нэг юм даалгасан юм. Одо түүнийхээ дүнг дуулах хэрэгтэй байна. Та харуул хүртэл явгаар очоод, их .хожимдохгүйн тулд хөлсний тэргэнд суугаарай гэв.

Гайхсан зарц зайлан явлаа.

- Харанхуй газар очъё гэж Андреа хэлэхэд улаан алчуурт,

- Өө, би харин чамайг тохиромжтой газар хүргээд өгье, алий вэ гээд, нөгөө хүн морины цулбуураас барьж, нээрээ хэн ч харахааргүй харанхуй газар аваачлаа.

- Би сайхан тэргэнд сууж явах гэсэндээ тэгсэн юм биш. Зүгээр л ядраад, бас далимд нь ажил төрлийн яриа байна гэж тэр хэллээ.

- За, суу гэж Андреа дуугарлаа.

Тэргээ жолоодож яваа гоёмсог залуу, торгон суудал дээр хээв нэг суусан ноорхой амьтан хоёрыг шөнийн харанхуйд хэн ч харахгүй нь харамсалтай.

Андреа бүх л сууринг өнгөрөн гартал нэг ч үг дуугарсангүй. Харин хамт яваа хүн нь хөл залгах ийм сайхан арга олсондоо их л сэтгэл хангалуун инээмсэглэх боловч дуугүй явна.

Тэр хоёр Отелийг өнгөрөн гармагц Андреа тэднийг хүн харж, яриаг нь сонсохгүй гэдгийг магадлан харав. Дараа нь морио зогсоогоод хоёр гараа цээжиндээ зөрүүлэн барьж улаан алчууртай хүн өөд эргэн харж,

- Та надаар яах гэсэн юм бэ? Та яагаад намайг тайван байхад минь үймүүлээд байна? гэв.

- Үгүй©, хүү минь, чи яагаад надад итгэхгүй байгаагаа хэл.

- Би танд юуг нь итгэхгүй байгаа юм бэ?

- Юуг нь гэнэ шүү? Чи бас асууна гэнээ? Чи бид хоёр Гаарийн гүүр дээр салахад чи надад Пьемонт, эсвэл Тосканд очно гэж хэлсэн, гэтэл чи энд, Парист байж байх юм.

- Энэ танд ямар саад болоод байна?

- Үгүй, ямар ч саад болоогүй. Харин ч надад ашиг болно гэж итгэж байна.

- Уухай! Та надаар ашиг олох санаатай байна уу?

- За, ийм сүржин үгээр яах вэ?

- Кадрусс гуай минь, энэ чинь дэмий байх гэдгийг танд хэлчихье.

- За, хүү минь, чи битгий уурла. Зол заяагүй явах гэдгийг чи өөрөө ч мэдэх ёстой. Зол заяагүй явдал хүнийг атаархуу болгодог юм. Би чамайг Пьемонт буюу Тосканаар тэнүүчилж газарч эсвэл гар тээш зөөгчийн хүнд бэрх ажил хийж яваа гэж бодож явсан юм. Би чамайг төрсөн хүү шигээ хайрлаж явдаг шүү. Чамайг дандаа л хүү минь гэж дууддаг байсныг санаж байгаа биз.

- За, тэгээд цааш нь? Юу гэх гээ вэ?

- Дарь шиг амьтан юмаа. Жаахан тэвчиж үз.

- Би тэртэй тэргүй тэсвэртэй хүн. За, болиорой.

- Тэгтэл чи чинь зарц дагуулчихсан, хөнгөн тэргэнд суучихсан, дэгжин сайхан хувцас өмсчихсөн явж байх шив. Чи чинь алтаар баадаг шидэт илжиг олоод авчихав уу, эсвэл худалдааны зуучлагчийн эрх худалдаад авчихав уу?

- Тэгэхээр та атаархаад байгаа байх нь ээ?

- Үгүй, би чамд баяр хүргэмээр тийм сэтгэл дүүрэн байна, хүү минь. Би олигтой хувцас өмсөөгүй болохоор чамайг эвгүй байдалд оруулахгүйн тулд болгоомжлох арга хэмжээ авсан юм.

- Тийм ээ, зарцын дэргэд надтай ярина гэдэг чинь болгоомжлох сайхан арга даа гэж Андреа хэлэв.

- Одоо яая гэх вэ хүү минь. Дайралдсан дээрээ л ярьчихсан минь тэр. Морь чинь хурдан, тэрэг чинь хөнгөн, чи өөрөө могой загас шиг гулгамтгай. Би чамайг өнөөдөр л алдчихвал дараа нь дахиад олж уулзахгүй шүү дээ.

- Би огт нуугдаагүй байгааг та харж байгаа биз дээ?

- Энэ ч чиний аз. Би өөрийнхөө тухай чиний энүүн шиг л юм хэлмээр байна. Гэтэл би бол нуугдаж явна. Тэгээд бас чамайг, намайг танихгүй байх вий гэж айж явлаа. Харин чи намайг таньчихлаа гэж ёжтойхон хэлээд-- Чиний зүгээс энэ бол хонгор сайхан сэтгэлийн илрэл юм гэлээ.

- За тэр ч яах вэ? та надаас юу хүсээ вэ? гэж Андреа хэлэв.

- Чи намайг “ Та” гэнээ? энэ чинь тусгүй байна. Бенедетто, би чиний хуучин найз нөхөр биш билүү. Мэдээрэй, би илүү шаардлагатай болж болох юм шүү.

Энэ сүрдүүлэг нь Андреагийн хилэнг намтгаад, бууж. өгөх хэрэгтэй болсноо мэдрэв. Тэгээд дахин морио хатирууллаа.

- Кадрусс, чи надтай ингэж харьцах чинь сайн хэрэг биш дээ. Чи марсель хүн, би... гэж хэлэхэд, Кадрусс,

- Чи одоо хэн болохоо мэдэж байна уу? гэж асуулаа.

- Үгүй, гэсэн ч би Корсикт өссөн хүн. Чи хөгшин болохоор зөрүүд, би залуу болохоор чигээрээ. Чи бид хоёр бие биеийгээ сүрдүүлж айлгах гэж @ролдвол муу хэрэг. Бид бүх зүйлийг найрсгаар шийдэх хэрэгтэй. Надад хувь заяа инээмсэглэж, чамд хуучин хэвээрээ бүтэлгүй байгааг би ямар буруутай байгаа юм бэ?

- Үнэндээ чиний аз дайрсан байх нь ээ? Энэ хөтөч, хөнгөн тэрэг, хувцсыг хөлсөөр авсан биш байх нь ээ? Тэгвэл бүр ч сайн! Гэж Кадрусс хэлэхэд нүд нь хомхойрон гялалзаж байлаа.

- Чи өөрөө эхэлж надтай ярьсан хойно, сайн мэдэж байгаа байлгүй гэж хэлээд Андреа улам сэтгэл нь хөдөлж—Хэрвээ намайг, толгой дээрээ чинийх шиг улаан алчуур зангидаж, мөрөндөө хиртэй цамц эгэлдэргэлж, хөлдөө цоорхой шаахай өмсөж явбал чи лав намайг танихгүй байсан байх гэлээ.

- За хүү минь, чи намайг хир зэрэг жигшин ярьж байгаагаа харж байна уу? Муу хэрэг дээ! Одоо би чамайг олсон болохоор ямар ч сайн цэмбэн хувцас өмсөхөд юу ч саад болохгүй. Би чиний сайн санаатайг мэднэ шүү дээ. хэрвээ амд хоёр хувцас байвал нэгийг нь надад өгнө. Би чамайг өлсөж явахад чинь өөрийн идэх гэж байснн шөл шошоо өгч байсан шүү дээ.

- Тэр ч үнээн гэж Андреа хэлэв.

- Чи тэгэхэд хоолонд мөн ч сайн байсан сан! Одоо ч бас тийм байлгүй.

- Тэгэлгүй яах вэ гэж Андреа инээн хэлэв.

- Энэ ноёныд яаж идэж байсан чинь нүдэнд харагдах шиг боллоо.

- Тэр чинь ноён биш зөвхөн гүн хүн.

- Гүн ий? Баян юм уу?

- Тийм ээ, гэсэн ч түүнээс горьдох хэрэггүй. Тэр эрхэмтэй ажил хэрэг явуулахад тий ч амаргүй.

- За чи битгий зов. Чиний гүнг хэн ч хөндөхгүй, өөрөө л авч бай. Харин гээд Кадруссын уруул дээр өнөөх муухай инээмсэглэл тодорч - Иймийн тулд чи түрийвчээ хоослох хэрэгтэй болно доо.

- За чамд хэчнээн хэрэгтэй юм бэ?

- Сард зуун франк л болох байх гж бодож байна...

- За тэгээд?

- Тэгвэл амьдраад л байх юм.

- Зуун франкаар уу?

- Муу нь ч муу л байх биз, чи өөрөө мэдэж байгаа шүү дээ... Гэхдээ...

- Юу гэхдээ гэж?

- Гэхдээ зуун тавьин франкаар бол би маш сайн тохижно.

- Май чамд хоёр зууг өгчихье гэж Андреа хэлээд, Кадруссын гар дээр арван луидор тавихад,

- Энэ ч болно гэж Кадрусс хэлэв.

- Чи сар бүрийн эхний өдөр манай хаалгач дээр ирж бай, өдий чинээ мөнгө авах болно.

- За тэр чи намайг бас доорд үзэж гарлаа шүү.

- Яаж тэр вэ?

- Чи намайг заавал зарц нар дээрээ очуулах гээд байх юм. Үгүй, би зөвхөн чамтай л холбоотой байхыг хүсэж байна.

- За яах вэ, чи над дээр сар бүрийн эхний өдөр ирж, надад орлогыг минь өгч байх хугацаанд өөрийнхөө хувийг авч бай.

- За за, би чамайг тэгнэ гэж мэдсэн юм аа. чи сайн хүү. Имй улсад аз тохиолдох сайн хэрэг. чамд яаж ингэж азтай явдал тохиолдсоноо ярьж өгөхгүй юу?

- Чамд түүнийг мэдэх ямар хэрэг байна? гэж Кавальканти асуулаа.

- Бас л итгэхгүй нь!

- Огтхон ч үгүй. Би эцгийгээ эрж олсон.
- Жинхэнэ эцгээ юу?
- Надад мөнгө өгч байгаа болохоор л...
- Чиний үнэмшиж итгэж байгаа чинь зөв байж таарна. Харин эцгийг чинь хэн гэдэг юм бэ?
- Хошууч Кавальканти.
- Тэгээд тэр чамайг хараад сэтгэл ханамжтай байна уу?
- Одоогоор тийм л бололтой байх шиг байна.
- Түүнийг эрж олоход чамд хэн тусалсан бэ?
- Монте-Кристо гүн.
- Чиний саяын байж байгаад ирдэг үү?
- Тийм ээ.
- Тэгвэл тийм юм эрхэлдэг юм бол намайгш тэднийд өвгөн ааваар оруулж өгөхгүй юу?
- Чиний тухай ярихнаан ч болох юм. харин чи одоогоор юу хийж байна?
- Би юу?
- Тийм ээ, чи?
- Чи энэ тухай санаа зовж байгаа чинь тун хонгор сайхан сэтгэл байна гэж Кадрусс хэлэхэд,
- Чи намайг сонирхож байгаа болохоор би бас чиний тухай юухан хээхэн асуух эрхтэй байх гэж бодож байна гэж Андреа зөрж хэлэв.
- Үнэн.. Би тохитойхон байшинд нэг өрөө хөлөөлж аваад, зохих ёсоор хувцаслаж, өдөр бүр сахлаа хусаж, кафед сонин уншина. Оройд нь аль нэг хөлсөөр алга ташигч хүмүүстэй театрт очино. Ер нь тайван суухаар шийдсэн талхны мухлагийн эзэн гэмээр болно. Би ийм л хүн болох юмсан гэж дандаа хүсэж байсан юм.
- За яах вэ, энэ ч сайхан хэрэг. чи өөрийн бодлыг биелүүлж ухаалаг байвал, бүх юм гайхамшигтай сайхан болно.
- Энэ Боссюэг хараач!...Харин чи юу болох вэ? Францын тайж болох уу?
- Юмыг яаж мэдэх вэ? гэж Андреа хэлэв.

- Хошууч Кавальканти чи тайж байж болох юм. гэвч үе залгамжилдаг нь утсан л даа.

- Кадрусс минь! Улс төргүй шиг л явж үз. За чи хүссэн зүйлээ авсан. Бид хэрэн газраа хүрч ирлээ, тийм учраас тэрэгнээс бууж далд ор.

- Хонгор найз минь хэрхэвч үгүй!

- Юу гэсэн үг вэ?

- Хүү минь өөрөө бодоо үз л дээ. толгойн дээрээ улаан алчууртай, өсгийгүй гуталтай, ямар ч баримт бичиг алга. Хармаанд хуучин байсныг нь оруулахгүйгээр арван луидортой, ер нь бүхэлдээ хоёр зуун франктай байгаа хүн шүү дээ. намайг харуул дээр зайлшгүй барьж авна. Би биеэ үнэмшүүлэхийн тулд арван луидорыг чамайг өгсөн гэ хэлэх болно. Тэгээд л мөрдлөг мэдүүлэг болоод намайг Тулонаас оргосн учир хэнээс ч асуулгүй Газрын дундад тэнгис хүртэл дамжуулан хөөж явна. Би дахиад л зуун зургаан дугаартай болж, тайван жаргахыг хүссэн талхны мухлагийн эзэн болох хүслээсэ хагацах болно. Хэрхэвч үгүй, хүү минь, би нийслэлдээ тохитой суухыг илүү дээрд үзэж байна.

Андреа хөмсгөө зангидлаа. Хошууч Кавалькантийн хуурай хүү өөрөө хэлсэнчлэн маш зөрүүд хүү байлаа. Тэгээд морио зогсоож эргэн тойрныг түргэн зуур харангаа, гар нь санамсаргүй хармаандаа орж гар бууныхаа гохыг тэмтрэв.

Энэ завсар хамт яваа нөхрөөсөө нүд слгалгүй харж байсан Кадрусс гараа нуруу уруугаа явуулж, хэрэг болж магадгүй гэж үргэлж авч явдаг байсан испани хутгаа тэнийлгэв.

Хоёр найз бие биедээ тэнцэх хүмүүс байсан бөгөөд үүнийгээ ч ойлгосон бололтой. Андреа хармаанаасаа гараа тайвнаар аваад шар сахлаа илбэж эхлэв.

- Кадрусс минь чи одоо л нэг аятайхан амьрах юм шиг байна гэж хэлэхэд Гаарын гүүрийн буудлын эзэн хутгаа эвхэнгээ,

- Ингэхийн төлөө чадах бүхнээ хийнэ шүү гэлээ.

- За яах вэ, Парис өөд явъя. Харин чи сэжиг төрүүлэхгүйгээр яаж харуулыг өнөгрүүлэх юм бэ? Чи ийм хувцастай явган явснаас илүү сүйх тэргэнд сууж явах нь аюултай юм биш үү?

- Байз харж бай гэж Кадрусс, Андреагийн бүрхийг толгойдоо углаад хөтчийн орхисон том захтай цувыг нь мөрөн дээрээ хаяж баян гэрийн зарц эзнээ тэргээ жолоодож явахад нв хажууд нь харж явдаг дүртэй боллоо.

- Би тэгээд толгой нүцгэн явах болж байна уу? гэж Андреаг асуухад,

- Гайгүй дээ, өнөөдөр ийм ширүүн салхитай байхад чинь малгай чинь хийсээд уначихаж гэж бодно биз гэлээ.

- За яах вэ энэ яриаг дуусгая гэж Андреаг хэлэхэд Кадрусс,

- Хэн чамд саад болоод байгаа юм бэ? Би л лав биш байх гэж бодож байна гэв.

- Чишш гэж Андреа шийгэнэлээ.

Тэд харуулыг эсэн мэнд өнгөрлөө.

Хамгийн түрүүнд дайралдсан гудамжинд хүрээд Андреа морио зогсооход Кадрусс газарт үсрэн буулаа.

- Цув малгай хоёрыг минь өгнө үү? Андреаг хэлэхэд Кадрусс,

- Чи намайг салхи цохиулчих вий гэж зовохгүй байна уу гэж хариу хэлэв.

- Би яах юм бэ?

- Чи бол залуу хүн, харин би бол хөгширч байна. баяртай Бенедетто! гэж хэлээд булан тойрч алга боллоо.

- Ай хөөрхий, энэ орчлонд бүрэн бүтэн аз жаргал байж болдоггүй юм байх даа? гэж Андреа санаа алдан өгүүлэв.

8.Гэр бүлийн явдал

Залуу хүмүүс XV Людрвикийн талбай хүрээд салж, Моррел цэцэрлэгийн зүг, Шато-Рено хувьсгалийн гүүрийн өөд, Дебрэ голын эргийг даган явлаа.

Моррель, Шато-Рено хоёр одоо хүртэл, танхимын индэр дээрээ гоо сайхнаар ярьдагчлан, Ришельегийн гудамжин дахь театрын тайзан дээр тоглодог сайхан бичдэг жүжгүүдэд үзүүлдэгчлэн гал голомт@ндоо буцсан нь гарцаагүй. Харин Дебрэ өөр тийш явжээ. Залуу эр Луврын хаалганд хүрээд зүүн тийш эргэж Каруселийн талбайг шогшин өнгөрөөд, Сен Рокийн гудамжаар явж байснаа Мишодьерын гудамж уруу эргэжВильфорын сүйх тэрэг, түүний эхнэрийн нь хамт Сент-Оноред буулгачхаад хатагтай Дангларыг гэрт чоиж байхад нь Дангларын үүдэнд хүрч очжээ.

Тэднийд бараг өөрийн нь хүн байдаг Дебрэ түрүүлж хашаанд нь ороод, зарцад нь мориныхоо цулбуурыг өгч, өөрөө эргэн ирж хатагтай Дангларыг сүйх тэрэгнээс нь буухад нь туслаад тасалгаанд оруулж өгөхөөр сугадан явлаа.

Хаалга хаагдмагч хатагтай Дебрэ хоёр хашаанд хоёулханаа хоцорлоо. Тэгэхэд Дебрэ хатагтайд,

- Эрмина та яагаад байна! Гүн тэрхүү түүх, чухамдаа тэрхүү үлгэрийг ярихад танд яагаад эвгүй оргив оо? гэж асуухад,

- Миний бие өнөөдөр муухан байснаас тэгсэн биз, найз минь гэж хатагтай хариуллаа.

- Үгүй дээ, Эрмина, би энүүнд чинь хэзээ ч итгэхгүй. Харин та гүнгийн ирэхдээ тун сайхан байдалтай байсан шүү дээ. харин эрхэм Дангларын лагшин

төдий л тунгалаггүй байсан байх. Гэвч та түүнийг ямар байгааг хайхрах биш дээ. таны сэтгэлийг нэг л хүн эвдчихлээ. Юу болсноо надад хэлээч, таныг хүн гомдооход би тэсвэрлэж чаддаггүй гэдгийг та мэднэ шүү дээ.

- Люсьен та ташаарч байна. таны хэлснээр биеийн минь байдлаас, бас тэгээд таны ажигласанчлан танд учрыг нь хэлээд яах вэ гэж бодсон тэрхүү сэтгэл тавгүй б йдлаас тэгсэн байх гэж хатагтай хэлэв.

Эмэгтэйчүүд өөрсдөө ч мэддэггүй байх нь олон тохиоддог тийм сэтгэлийн хөдөлгөөнд учирсан буюу эсвэл Дебрэгийн тааварласнаар хэнд ч хэлэхийг үл хүсэх тийм ямар нэг нууц догдлолд орсон нь илтэд байв. Шалтгаангйгээр зан ааш нь эвгүйтэр явдлыг эмэгтэй хүний шинж чанарын нэг гээд үзэж сурчихсан Дебрэ түүнээс шалж шаардахаа больж энэ асуултыг дахин асууж болох аятайхан боломж гартал ч юм уу, эсвэл өөрөө хэлэхийг нь хүлээхээр шийджээ.

Хатагтай унтлагынхаа өрөөний үүдэнд итгэмжлэгдсэн шивэгчин мадмаузель Корнцлитай дайралдав.

- Охин маань юу хийж байна гэж хатагтай Дангларыг асуухад, мадмаузель Корнели,

- Оройн турш хичээллэж байгаад дараа нь хэвтсэн гэж хариулаа.

- Төгөлдөр баян хуураар нэг хүн тоглож байх шиг.

- Энэ бол мадмаузель Армильи тоглож байгаа нь тэр, харин мадмаузель Эжени хөнжилдөө орсон.

- За сайн, намайг тайчихаад тулаж өгнө үү гэж хатагтай Данглар хэлэв.

Тэд унтлагынхаа өрөөнд орлоо. Дебрэ өргөн диван дээр тэрийн унахад хатагтай Данглар мадмаузель Корнелигийн хамт хувцас сольдог өрөөнд орлоо. Хатагтай Данглар хаадганы цаанаас,

- Люсьен, Эженийг өөртэйгээ ярихыг ч хүсэхгүй юм гэж гомдо гаргасан хэвээр байна уу? гэхэд,

- Энэ талаар ганцхан би ч гомдол гаргаад байгаа юм биш шүү, хатагтай минь, саяхан Морсер хүртэл өөрийн болзоот хүүхнээс ганц ч үг дуулж чадахгүй нь гэж танд сүйд болоод байсан шиг санагдаж байна гэж Люсьен хатагтайн хав нохойтой тоглох зуураа өгүүлжээ. Хатагтайн хав түүнийг гэрийн дотно хүн гэж түүнд эрхэлдэг аж.

- Тэр ч үнээн, харин удахгүй энэ бүхэн хувиран өөрчлөгдөж, Эжени таны албан өрөөнд хүрч очих байх гэж хатагтай хэллээ.

- Миний албан өрөөнд ий?

- Үгүй би сайдын өрөөнд гэж хэлэх гэсэн юм.

- Яах нь вэ?

- Дуурийн жүжигт тоглуулж өгөөч гэж гуйх гэж очно байх. Хөгжимд ийм их дуртай болсныг би мэдэхгүй юм байна. дээдсийн хүрээлэнгийн охинд инээдэмтэй л хэрэг байгаа юм.

Дебрэ инээмсэглэж,

- За яах вэ, түшээ гүн та хоёр зөвшөөрсөн юм бол очиг л дээ. би бүтээхийг бодъё. Бид түүнийх шиг авьяа чадварын үнийг төлөхөд дэндүү ядуу ч гэсэн тэр нь түүнд зохицохоор байлгахыг хичээе л дээ.

- Корнели та явж болно оо одоо надад хэрэггүй гэж хатагтай хэлэхэд Корнели явж нэг минутын дараа хатагтай хувцас өмсөх өрөөнөөсөө гэрийн гоё сайхан хөнгөн даашинзай гарч ирлээ.

Тэгээд Люсьений дэргэд суугаад бяцхан сэгсгэр хаваа бодлогширсон байдалтай илж байв.

Люсьен түүнийг харж дуугүй сууна.

- Эрмина, та өнөөдөр ямар нэг юманд сэтгэл чинь зовжээ дээ, үнэнээ хэлчих л дээ гэхэд,

- Үгүй, юунд ч зовоогүй гэж хатагтай зөрөв.

Бүгчим оргиж байсан учир босож цээж дүүрэн амьсгаа аваад толь руу очиж,

- Би өнөөдөр мануухайтай л адилхан байх шив дээ гэлээ.

Дебрэ инээмсэглэн босож, энэ та«аар хатагтайг тайвшруулахаар дэргэд нь очих гэтэл, гэнэт хаалга нээгдэж, Данглар орж ирсэн тул буцаж диван дээрээ суулаа.

Хатагтай хаалга онгойхын чимээгээр эргэж нөхрөө хараад гайхаж буйгаа нуусан ч үгүй. Банкны эзэн,

- Сайн байна уу хатагтай, сайн байна уу эрхэм Дебрэ гэж хэллээ.

Түшээ гүн ингэж орж ирсэн явдал нь тэрээр өдөр хэд хэдэн удаа хэгжүүрхэж эгдүүтэй үг хэлчихсэндээ тал засах гэж байгаа хэрэг байх гэж хатагтай өөр зуураа боджээ.

Тэгээд бардам дүр үзүүлэн нөхөр өөдөө харсангүй, харин Люсьен өөд эргэж,

- Эрхэм Дебрэ та надад ямар нэг юм уншиж өгөөч гэж хэллээ.

Түшээ гүнг орж ирсэн явдалд Дебрэанхандаа баахан зовж байсан боловч хатагтайг аижг ч үгүй байгааг хараад алтан чимэгтэй танан хутга хавчуулсан ном өөд гараа сарвайв. Гэтэл түшээ гүн,

- Уучлаарай, хатагтай та өнөөдөр ядарсан болоххо хэвтэж амрах хэрэгтэй. Одоо арван нэгэн цаг болчихсон байна, тэгээд ч эрхэм Дебрэ хол суудаг хүн гэлээ.

Люсьен хөшсөн мэт зогслоо. Тэгэхдээ Дангларын хэлэх үгийн аялгуу эелдэг зөөлөн, тайван биш байснаас тэгсэн биш, харин энэ эелдэг зөөлөн, тайван байдлын цаана энэ удаа эхнэрийнхээ хүслийг үл хайхрах дасал болоогүй зөрүүд байдал цухалзсанд тэгжээ.

Хатагтай ч бас гайхсан бөгөөд түүнийгээ харцаараа илэрхийлсэн боловч нөхөр нь сонин дээрх биржийн мэдээлэл харж байсан уяир хатагтайн тэр харцыг анзаарсангүй. Хэрвээ анзаарсан ол юу ч билээ гэж бодохоо° байсан биз.

Ийнхүү бардам харц дэмий өнгөрч зорилгодоо эс хүрлээ.

- Эрхэм Дебрэ гэж хатагтйа хэлээд – Надад унтах өчүүхэн ч хүсэл алга, танд ярих юм их байгаа учраас та хэдийгээр нойр чинь хүрлээ ч гэсэн миний ярихыг бүхэл шөнийн турш чагнах болно гэдгийг мэдээрэй гэв.

- Таны хүслээр болог гэж Дебрэ хайхрамжгүй тайван өгүүлэхэд банкны эзэн хажуугаас нь,

- Эрхэм хүндэт Дебрэ та өнөөдөр хатагтайн энэ чалчаа ярианаас өөрийгөө чөлөөлж үзэхийг хүсье. Хатагтайн яриаг маргааш ч гэсэн тийм амжилттай чагнаж болно. Харин өнөө орой бол нада ногдож байгаа бөгөөд таны зөвшөөрөлтэйгээр эхнэртэйгээ маш чухал зүйлийг ярилцахад зориула гэж хэлэв.

Энэ удаа црхилт нь шууд бөгөөд мэргэн туссан тул Люсьен хатагтайхоёрын гайхшийг нь барагдуулж орхилоо. Тэр хоёр довтолгооны эсрэг бие биенээсээ түшиг дэмжлэг олох гэсэн мэт өөд өөдөөсөө харлаа. Гэвч гэрийн эзэн дийлж, ялалт нөхрийн нь талд үлдлээ.

- Эрхэм Дебрэ та намайг хөөж байна гэж бүү бодоорой гэж Данглар хэлээд – Огтхон ч үгүй, хэрхэвч тэгэхгүй шүү. Харин гэнэтийн чухал явдлаас болоод өнөөдөр хатагтайтай ярилцах хэрэгтэй болчихлоо. Ийм явдалд надад уурлахаар хүн олон тохиолддоггүй шүү дээ гэв.

Дебрэ хэдэн үг аман дотроо бувтнаад мэхийн ёсолж “Аталийд” гардан Натан шиг сандал ширээнд тээглэсээр гарч одлоо.

- Ёстой гайхалтай юм. бидний энэ элг д@ог болгодог нөхрүүд бидний дээр амархан гарчих юм! гэж Дебрэ хаалга хаагдсаны д раа бодсоор цааш явлаа.

Люсьенийг гарахаар Данглар түүний байранд суугаад нээлттэй байсан номыг гараагаа хааж орхиод их л тайван дүр гарган, нохойгоор тоглох гэтэл Дебрэ шиг сайн дасаагүй нохой түүнийг ураг гэлээ. Тэгэхээр нь Данглар түүний сэрвээн дээрээс нь барьж аваад тасалгааны булан рүү шидчихлээ.

Нохой шидэлт дунд гасалж явсан боловч буйдан дээр унамагц дэрэн доогуур шургаж, ийм ер бишийн аашилж байгаа хараад хөдлөх ч үгүй чимээ аниргүй хэвтлээ.

- Эрхэм та их ахиж байна гэж хатагтайн нүд цавчилгүй хэлээд – Уг ь та их хөдхө бүдүүлэг эр сэн, өнөөдөр бүр ч адгуус мал шиг загнаж байна гэв.

- Энэ бол өнөөдөр миний зан урьдынхаасаа муу байгаа болохоор тэгж байгаа хэрэг гэж Данглар хариулав.

Эримна банкны эзэн өөд имх л жигшсэн янзтай хяламхийн харав. Ингэж жигшсэн харцаар харахад хор шартай Данглар урьд нь тэсэж яаддаггүй байсан бол харин өнөөдөр түүнийг огтхон ч анзаарсан шинжгүй байв.

- Таны зан ааш муу байгаа явдал надад ямар хамаа байгаа юм бэ? Надад огтохон ч хамаагүй, муу зан чинь хөдлөөд байгаа юм бол өрөөндөө л сууж байхгүй юу. эсвэл тэрнийгээ албан тасалгаандаа гаргахгүй юу? Танд чинь хөлс хүчээр ажилладаг албан хаагчид бий шүү дээ. тэдэндээ л муу зангаа гаргаж байхгүй юу! гэж хатагтай нөхрийнхөө тхайван байдалд бачимдан өгүүлээ.

- Үгүй хатагтай минь, таны зөвлөгөө зохимжгүй байна. Би түүнийг чин сонсмооргүй байна. Миний контор гэдэг чинь эрхэм Демутьегийн хэлснээр миний алтаар урсдаг гол байгаа юм. түүнхй учраас түүний урсгалыг саатуулж усыг нь булингартуулахыг хүсэхгүй. Миний албан хаагчид бол цөм надад хөрөнгө зорь хураахад минь үнэнч хүмүүс. Би тэдэнд хийсэн ажилтай нь зэрэгцүүлбэл хэмжээлшгүй бага хөлс шан өгдөг юм. эдэнд уурлах юм надад алга. Гэтэл миний хоолыг идэж, миний морьдоор зугаалж, миний касыг хоослогч хүмүүс байгаа болохоор тэдэнд уур хүрэх юм.

- Таны кассыг хоосолж байгаа тэр улсууд чинь хэн бэ? Тодорхой хэлэхийг танаас хүсэж байна.

- Бүү зов, хэрвээ би тааварлагдахгүй ярьж байгаа бол тайлах түлхүүр нь танд удахгүй олдох болно. Миний кассыг хосолж байгаа улс бол, ганцхан цагийн дотро л таван зуун мянган франк тэднээс авчхаж байгаа хүмүүсийг хэлж байгаа юм гэж Данглар хэлэв.

Тэгэхэд хатагтай хоолойгоо чиирч, нүүрээ урайж байхыг нуухыг хичээн байж,

- Би таны хэлж байгааг ойлгохгүй байна гэж хэлэхэд Данглар,

- Үгүй та сайн ойлгож байх ёстой. Гэвч таныг ингэж гөжөөд байвал би испанийн зээллэгээр долоон зуун мянган франк алдчихсанаа хэлчихье.

- Үгүй ер өө гэж хатагтай дооглосон маягтай хэлээд – Та чинь энүүнд намайг буруутан болгож байгаа хэрэг үү? Гэлээ.

- Яагаад тэгж болохгүй байх вэ?

- Та долоон зуун мянган франк алдахад би буруутай болох гэж үү?

- Юи ч л гэсэн би л өөрөө биш дээ.

- Эрхэмсэг минь , би таныг мөнгөний тухай надтай ярихыг үүрд хориглосон шүү дээ. би ийм мөнгөний тухай эцэг эхийнхээ дэргэд ч, түрүүчийнхээ нөхөртэй сууж байхдаа ч ярьж сураагүй юм гэж хатагтай эрс зөрлөө.

- Түүнээс гадна өглөөнөөс үдэш хүртэл энд чихэнд минь чийр болж байдаг мөнгөний тухай этгээд хэлтэй танилцаж чадаагүй юм. тоолчихоод л дахиад тоолдог зооснуудын дууг сонсож чаддаггүй юм. тэгээд ч ер нь таны дууг л гэхгүй бол түүнээс муухай дуу гэж юу байж болохыг мэдэхгүй юм байна.

- Үгүй ер, хачин хэрэг байна даа. би таныг миний мөнгө янчааны явдлыг их л сонирхдог гэж боддог юм гэж Данглар хэлэв.

- Би юу? Ямар тэнэг юм бэ. хэн танд ингэж хэлж байна?

- Та өөрөө.

- Боль доо!

- Тэгэлгүй яах вэ.

- Хэзээ тэгсэн юм бол. Дуулбал сонин байна.

- Одоохон хэлээд өгч болно. Хоёрдугаар срд та надад гайтигийн зээллэгийн тухай үг эхэлж дуугарсан шүү дээ. та гаврын усан буудалд онгоц ирж, хойшлуулсан гэж тооцож байсан өрийг төлөх болсон тухай мэдээ авчирсан мэт зүүдэллээ гэсэн. Таны зүүд мэргэн гэж би санадаг байсан болохоор үх л олдож болох гайтигийн зээллэгийг цөмийг ь сэм худалдаж авахыг тушаасан юм. тэгээд дөрвөн зуун мянган франк хожсон. Үүний зуун мянгыг нь танд тооо ёсоор нь шилжүүлэн өгсөн. Та түүний гөөрийн дурар зарцуулсан, би үүнд тань оролцоогүй.

Гуравдугаар сард төмөр замд газар түрээслэн олгох тухай яриа дэгдсэн. Энд адилхан баталгаа өгсөн гурвал нэгдэл өрсөлдсөн байсан. Тэгэхэд та Өмнөдийн гэгддэг ногдол илүүтэй шиг бодогдоод байна гэж хэлж байсан билээ.

Миний мөнгө төгрөгний явдал танд хааагүй гэж та батлан хэлэх боловч, таны дотоод сэтгэхүй чинь зари асуудалд сонор ч юм шиг надад санагддаг юм. тэгээд би Өмнөдийн гэгдлийн хувь нийлүүлсэн тэмдэгтийн гуравны хоёр хувийг өөртөө авсан. Тэднийх үнэхээр таны хэлснээр дийлж гарсан. Тэгээд таны урьдчилан харснаар хувь нийлүүлсэн тэмдэгтийн үнэ гурав дахин өсөж би түүнээс нэг саяыг хожсоны хоёр зуун тавин мянгыг таны хармааны мөнгө болгож өгсөн. Харин та хоёр зуун тавин мянган франкийг юунд зарцуулсан бэ?

- Үгүй та ер нь юу гэх гээд байгаа юм бэ? гэж хорсож зэвүүцсэнээс бие нь чичирсэн хаагтай хэллээ.

- Хатагтай минь тэсвэрлэж байж үз, би одоо дууслаа.

- Бурхан минь!

- Та дөрөвдүгээр сард сайдын зоогонд уригдсан. Тэнд байхад чинь испанийн тухай яриа болж та Дон Карлосыг хөөгдөх нь гэсэн нууц яриа сонсож ирсэн. Тэгэхэд би Испанийн зээллэг худалдаж авсан. Тэгтэл Дон Карлос хөгдөж тавдугаар Карл Бидассоуд шилжиж ирсэн тэр өдөр би зургаа зуун мянган франк хожсон. Энэ зургаан зуун мянган франкаас та тавин мянган эккюг нь авсан. Энэ мөнгө таных байсан учир

та түүнийг дураараа зарцуулсан. Тэгэхээр та энэ онд юу ч л гэсэн таван зуун мянган ливр авсан.

- Тэгээд цааш нь?

- Цааш нь уу? цааш нь ажил явдал муугаар эргэсэнд хамаг учир байгаа юм.

- Та нэг л хачин байдалтай ярих юм.

- Миний яриа миний санааг дамжуулж байгаа юм. надад хэрэгтэй юм энэ байгаа юм. цааш нь гэвэл энэ явдал гурав хоногийн өмнө болсон билээ. та гурав хоногийн улс төрийн бодлогын тухай Дебрэтэй ярилцахад Дон Карлос Испанид эргэж ирсэн юм шиг санагдлаа гэж хэлсэн. Тэгэхээр чинь би өөрийнхөө авсан зээллэгийг худалдахаар шийдсэн. Энэ үинэ сонин мэдээ бүхэнд тархаж хмүүс сандарч эхлэхэд би зээллэгүүдээ зарах биш, зүгээр тарааж өгч байсан. Гэтэл маргааш нь нөгөө мэдээ худал болж би тэр худлаа мэдээнээс долоон зуун мянган франк алдсан шүү дээ.

- Тэгээд яагаа вэ?

- Би танд хожооныхоо дөрөвний нэг хувийг өгдөг байсан учир та одоо миний адсан мөнгөний дөрөвний нэгэн хувийг буцааж өгөх ёстой юм биш үү. Долоон зуун мянган франкийн дөрөвний нэг хувь нь зуун далан таван мянган франк байна.

- Та ёстой дэмий юм ярьж байна. Энэ явдалд та Дебрэгийн нэрийг холбогдуулж байгаагийн учрыг ерөөсөө ойлгохгүй байна.

- Яагаад гэвэл, хэрвээ танд зуун далан таван мянган франк байхгүй бол найз нөхдөөсөө аваад өгнө биз. Таны найз нөхөр бол Дебрэ шүү дээ.

- Ямар булай юм бэ? гэж хатагтай дуу алдлаа.

- Хатагтай минь, ширүүн дориун биш, загнаж зүхэлгүй ярьж үзээрэй. Тэгэхгүй бол би таны өгсөн таван зуун мянган ливрийг Дебрэ тоолонгоо тоглоод хожигдсон ч гарзгүй мөнгө олж байдаг шидэт хайрцагтай болсондоо баярлан биднийг шоолон инээж байгааг эндээс харж байна. Үэдгээ хэлэх хэрэгтэй болох нь.

Хатагтай тэсвэрлэж чадахаа болилоо.

- Бузар амьтан гэж хүүхэн дуу алдаад-- Өнөөдөр намайг зэмлэх гэж зүрхэлсэн тэр зүйлээ урьд нь мэдээгүй байсан гэж хэлж зүрхэл л дээ!

- Би мэдсэн ч гэж хэлэхгүй, мэдээгүй ч гэж хэлэхгүй. Бид хоёр эхнэр нөхөр байхаа больсон дөрвөн жилийн турш дахь миний байдлыг бодоод үз л дээ. Та бид хоёрын холбоо тасрахаас өмнөхөн та Италийн театрт их амжилттай тоглож байсан нэрт дуучинтай хамт хөгжмийн хичээл хийж, би Лондонд тэгж их алдаршсан бүжигчнээр бүжиг заалгаж сурахаар шийдэж билээ. Хоёр биенийхээ өмнөөс би зуун мянган франк төлсөн. Гэр бүлийн амьдралд эв зүй хэрэгтэй байсан учир би юу ч хэлээгүй. Эхнэр нөхөр хоёр хөгжим, бүжиг үндэстэйхэн заалгахад зуун мянган франк зарцуулах нь тийм ч үнэтэй хэрэг биш. Удалгүй та хөгжимдөө дургүй хүрч, сайдын нарийн бичгийн даргын удирдлагын дор дипломатын уран чадварт суралцах

хүсэлтэй болсон. Би тэгэхэд танд түүнийг судлах боломж олгосон шүү дээ. Та өөрөө өөрийнхөө хичээлийн хөлсийг төлчихдөг байсан болохоор энэ ажилд би хамаагүй байсан. Гэтэл та одоо миний касс руу орж, таны хичээл надад сард долоон зуун мянган франкийн үнэтэй болж байна. Хатагтай гуай, зогсолгүй болохгүй. Цааш тэгж үргэлжилж болохгүй. Эсвэл дипломатч танд үнэгүй хмчээл зааг, би яах вэ, тэвчье. Эсвэл түүний хөл миний гэрт бүү орж ирэг. Ойлгов уу? хатагтай минь?

- Эрхэм минь, энэ ч дэндэж байна! гэж хатагтай амьсгаадан өгүүлээд—Бузар хэрэг! Та бүх л ёс журмаас хэтэрч байна гэв.

- Надаас хоцрохгүй байгааг тань би хараад их л сэтгэл ханамжтай байна. Та “эхнэр нь нөхрөө дуурайдаг” гэсэн сургаалыг сайн дураараа биелүүлж байна гэж Данглар хэлэв.

- Та намайг доромжилж байна!

- Таны хэлдэг үнэн. Үүнийг орхиод тайван ярьцгаая. Таныг сайн сайхан байлгахтай холбогдохоос өөр хэрэгт чинь оролцдоггүй. Тэгэхээр та ч бас намайг дуурайх хэрэгтэй. Миний хөрөнгө танд хамаагүй гэж та хэлсэн. Тэгвэл их сайн хэрэг. Та өөрийнхөө хөрөнгийг л захирч бай. Минийхийг бүү арвижуул, бүү хоосруулж үз. Тэр явдал хорт ажиллагаа байсан байж болох юм. Сайд намайг сөрөг намд байдаг болохоор хилэгнэж, нэр алдарт минь хордож, намайг хоосруулахаар Дебрэтэй хуйвалдсан байж болох юм.

- Энэ чинь үнэний хувьтай юм шиг!

- Яг л тийм мэт. Цахилгаан утасны хуурамч мэдээ байдгийг би дуулаагүй юм байна. Энэ бол бараг л боломжгүй хэрэг. Сүүлчийн хоёр утасны хорооны хүн бусдаасаа огт өөр мэдээ дамжуулсан байсан. Бодвол надад зориулж санаатайгаар хийсэн биз.

- Тэр түшмэлийг хөөж зайлуулах, тэр ч бүү хэл шийтгэх гэж байсныг та мэдсэн шүү дээ. Түүнийг баривчлах тушаал өгсөн боловч өнөөх түшмэл алга болчихсон гэнэ лээ. Түүнийг зугатаж алга болсныг бодвол тэр хүн эсвэл солиотой, эсвэл гэмтэн хүн байсан биз... Үгүй, тэр бол алдаа л байсан юм.

- Тийм ээ, энэ алдааг чинь дуулаад тэнэгүүд шоолон инээлдэж, сайд нойргүй хонож, улсын эрхэм нарийн бичгийн дарга нар цаас бузарлаж хохироход, харин би долон зуун мянган франкаар хохироод байна.

- Үгүй, энэ явдал Дебрэгээс гараад байгаа юм бол та үүнийгээ Дебрэд өөрт нь хэлэхгүй яасан юм бэ? Та эр хүнийг зэмлэхийг хариуг нь яагаад эмэгтэй хүнээс асуугаад байгаа юм бэ? гэж Эрмина гэнэт хэлэв.

- Би тэр Дебрэг чинь мэдэх юм гэж үү? Би түүнтэй танилцах гэж хүсэх юм гэж үү? Би чухам түүнийг тэдгээр зөвөлгөөг өгдөг гэж мэдэх ёстой юм гэж үү? Би бирж дээр тоглож байна гэж үү? Энэ бүхэн танд хамаарагдахаас надад хамаагүй гэж Данглар хэлэв.

- Үгүй, танд ашигтай бол...

- Эмэгтэйчүүд гэдэг ямар тэнэг улс вэ? Бүх Парис даяар ярьчхааргүй дурлалын нэг ч юм уу, арван явдал хийчихэж чадвал өөрсдийгөө суут хүмүүс гээд бодчих юм. Та ч гэсэн нөхрөөсөө өөрийн явдлыг нууж чадвал .(нуух ч гэж дээ, нөхрүүд нь тэр явдлыг мэдээгүй юм шиг өнгөрөх нь олон байдаг) дээдсийн хүрээлэнгийн найзуудынхаа хөөрхий хуулбар нь болох байсан юм. Гэвч ийм юм болоогүй. Би бүгдийг мэдэж байсан. Та энэ арван зургаан жилийн дотор надаас ямар нэг бодлоо нууж чадаж байсан байж магадгүй. Харин ганц ч хөдөлгөөн, нэг ч ажил явдлаа нууж чадаагүй. Та самбаатайгаа гайхан шогширч, намайг хуурч чаддаг гэж хатуу итгэж байсан. Тэгээд юу болов? Би мэдээгүй юм шиг дүр үзүүлж байсны ачаар, Вильфороос эхлээд Дебрэ хүртэл надаас айдаггүй нэг ч хүн байгаагүй юм. Намайг гэрийн эзэн гэж үздэггүй хүн нэг ч байгаагүй. Би үүнийг л зөвхөн танаас л шаарддаг шүү дээ. Эцэст нь тэдний хэн нь ч тантай над шиг ярьж зүрхлэхгүй. Намайг бузар булай гэж хэлж болно. Харин амьтны элэг доог болгохгүй шүү. Хамгийн гол нь намайг хоослохыг чинь хатуу хориглож байна.

Вильфорын нэрийг дурдах хүртэл хатагтай яаж ийгээд тэсч байлаа. Гэвч энэ нэрийг дуулаад царай нь зөвхийрч, ямар нэг оньсны хүчээр хөдлөх мэт гараа өргөн нөхрийнхөө хэлж гүйцээгүй нууц санааг амнаас нь булааж авах гэсэн мэт түүн өөд алхав. Данглар бол цаанаа заавал нэг өөдгүй юм санаж өөрийн бодол санаагаа бүрэн хэлдэггүй заншилтай хүн билээ.

- Вильфор ий? Юу гэсэн үг вэ? Та юу гэх гээ вэ?

- Хатагтай, таны анхны нөхөр де Наргон вангийн прокуророос ямар ч ашиг олж чадахгүйгээ мэдээд, таныг есөн сар алга болж яваад ирэхдээ зургаан сар болсон хүүхэдтэй байсныг чинь үзмэгц уйтгар гунигаас болж үхсэн гэж хэлэх гэсэн юм. би бүдүүлэг хүн, үүнийгээ зөвхөн мэдээд зогсохгүй түүгээрээ бахархдаг юм. энэ бол миний худалдааныхаа ажилд амжилт олдог хэрэглэлийн нэг байгаа юм. тэр яагаад өөрөө алахын оронд өөрийгөө алагдахад хүрэв? Яагаад гэвэл түүнд өөрийгөө хамгаалах хөрөнгө байсангүй. Аа харин надад бол өөрийн гэх хөрөнгө байна. би хамсаатан Дебрэгийн буруугаар долоон зуун мянган франк алдлаа. Тэгэхээр хөрөнгөнөөсөө өөртөө ногдох хувийг надад төлж өгвөл бид хаоёр хамтран ажиллаж болно. Эсвэл энэхүү зуун далан таван мянган франкийг төлөх хөрөнгөгүй бол дамдуурсан хүмүүсийн хийдгийг хийгээд алга болог. Түүний хэлсэн мэдээ нь үнэн зөв байгаа үед гайхам сайхан хүн юм. харин түүнээс хэлж байгаа мэдээ нь үнэн зөв биш бол түүнээс илүү залуус дээдсийн хүрээлэнгээс өдий төдий олдоно гэв.

Хатагтай Данглар бүрэн цохигдлоо. Гэсэн хэдий боловч довтолгоонд хариулахын тулд эцсийн хүчээ шавхан гаргажээ. Тэгээд гэр бүлийн тайван амтдралыг эвгүй муухай хэрүүл маргаан болгож хувиргасан сүүлчийн хэдэн өдрүүдийн золгүй явдлын тухай, Вильфорын тухай бодож зөөлөн сандал дээр суун туслаа.

Хүүхэн хэдийгээр ухаан алдаж унах гэж бүх хүчээрээ хичээсэн боловч Данглар хүний урманд хяламхийж ч харсангүй. Тэгээд нэг ч үг хэлсэнгүй унтлагын өрөөний үүдийг хааж орхиод өөрийнхөө өрөнд орчихов. Энэ нь хагас муралтын байдлаасаа сэргэсэн хатагтайд муухай зүүд зүүдлэгдээд өнгөрсөн мэт санагдуулжээ.

9.Гэрлүүлэх төлөвлөгөө

Энэ явдал болсны маргааш нь Дебрэ яам уруугаа явах замдаа хатагтай Дангларынд дайрч ордог тэр цагт нарийн бичгийн даргын сүйх тэрэг хашаанд орж ирсэнгүй.

Яг энэ үеэр буюу арван хоёр цаг хагаст хатагтай Данглар сүй тэрэг өгөхийг тушаагаад, гэрээсээ гарч явлаа.

Данглар хөшигний хойно нуугдаж зогсоод болно гэж бодож байсан зүйлээ болохыг нь ажиглан харж байв. Тэрээр хатагтай Дангларыг ирмэгц өөртөө хэлээрэй гэж тушаасан боловч хатагтай хоёр цаг болтол ирсэнгүй.

Данглар хоёр цагт морьд авчруулж, Тахим уруу явсан бөгөөд тэнд төсвийн эсрэг үг хэлэх хүмүүсийн тоонд нэрээ бичүүлжээ.

Данглар арван хоёр цагаас хоёр цаг хүртэл тасалгаанаасаа гаралгүй сууж, эцэс төгсгөлгүй олон тоо бодож, хүмүүс хүлээн авав. Эдгээр хүмүүсийн дотор банкны эзэнтэй ажлаа дуусгах гэж урьд нь тохиролцсон цагтаа ирсэн, ёсорхог байдалтай улаанхүрэн царайтай хошууч Кавальканти байлаа.

Хурлын үед сэтгэл нь хөдлөсөндөө яам өөд урьд урьдынхаасаа улам ширүүн довтолсон Данглар Танхимаас гарч сүйх тэргэндээ суугаад Елисейн тал дахь 30 дугаар байшин өөд явахыг тушаалаа.

Монте-Кристо гэртээ байсан боловч тэднийд нэг хүн ирсэн байсан учир Дангларыг хэдэн минут хүлээнэ үү гэлээ.

Банкны эзэн хүлээж суухад хаалга нээгдэж ширээт ламын хувцастай нэгэн хүн орж ирлээ. Тэр хүн гэрийн эзэнтэй ойрхны танил бололтой. Данглар шиг хүлээсэнгүй, түүнтэй мэндэлчхээд шууд дотор талын тасалгаа уруу орж алга болов.

Мөн тэр доор шахам өнөөх ламын орсон хаалга онгойж гүнтэн гарч ирлээ.

- Хүндэт түшээ гүн танаас уучлал хүсье. Миний сайн нөхдийн нэгэн болох лам Бузони тун саяхан Парист хүрч ирчээ. тэр үүгэр өнгөрснийг та лав хрсан байх. Бид хоёр уулзаагүй удсан болохоор уулзсан дороо түүнийг орхиж зүрхэлсэнгүй. Та миний энэ учрыг ойлгож хүлээснийг минь уучлана биз гэж гүн хэлэхэд Данглар,

- Энэ бол зүйн хэрэJ. Би цагаа олж ирсэнгүй тул би явья гэв.

- Тэгж болохгүй, та суу л даа. Үгүй бурхан минь, та чинь яачхаа вэ? Таны царай ихэд сааширсан байдалтай байна. та намайг бүр айлгаж орхилоо. Гуньж гутарсан хөрөнгөтөн хүн гэдэг сүүлт одтой адил ертөнцөд зодлгүй явдал тохиолдохыг зөгнөдөг юм.

- Хүндэт гүн минь, хэдэн өдрийн турш миний ажил явдал бүтдэггүй, үргэлж л муу мэдээнүүд сонстоод байх боллоо.

- Муу хэрэг гэж гүн хэлээд – Та бирж дээр бас л хожигдоо юу? гэв.

- Үгүй би үүнийг үгүйдээ л хэсэг хугацаагаар орхисон. Харин энэ удаад зүгээр л Триестэд дампуурал болов.

- Өө тийм үү! Та чи Жакопо Манфредийн дампуурлын тухай ярьж байна аа даа?
- Яг тийм. Надтай жил бүр найм есөн зуун мянган франкийн харилцаатай байдаг бөгөөд огт сааталгүй, тоо ёсоор нь ноён хүн шиг төлдөг хүн байлаа. Би саяын урьдчилгаа өгчихсөн юм л даа. Гэтэл энэ чөтгөрийн Жакопо Манфредид төлбөрөө зогсоочихлоо.
- Тэглээ гэж үү?
- Дуулдаагүй муухай золгүй явдал боллоо. Би түүнд зургаан зуун мянган ливрийн өр төлөх гуйвуулгын баталгаа явуулсан юм. тэгтэл тэр маань төлөгдөлгүй буцаж ирлээ. Түүнээс гадна бас энэ сарын эцсээр хугацаа нь дуусах Парисын төлөөлөгч нь төлөх ёстой дөрвөн зуун мянган франкийн өрийн баталгаа надад байна. Өнөөдөр гучны өдөр болохоор би мөнгөө авахаар хүн явууллаа. Гэтэл тэдний төлөөлөгч алга болчихлоо. Испанийн явдлыг оролцуулаад энэ сар би ёстой балраад байна.
- Та тэр испанийн явдлаар их юм алдсан гэж үү?
- Мэдээж хэрэг. надаас илүү ч үгүй, дутуу ч үгүй долоон зуун мянган франкийн алдагдал гарсан.
- Чөтгөр ав, яаж тийм явдал учрах нь тэр вэ? Та чин хашир чоно шүү дээ.
- Энэ явдал эхнэрээс л болж байгаа юм. дон Карлос Испанидаа буцаж ирлээ гэж зүүдэлж гэнэ. Тэр, зүүдэндээ итгэдэг юм. Зүүдээ тун мэргэн гээд нэг юм зүүдэлбэл уг явдал заавал тэр ёсоор болно гэж зүтгэдэг хүн. Би түүний дураар аашлахыг зөвшөөрдөг хүн. Тэрүүнд өөрт нь хувийн хөрөнгө, өөрийн хэрэг хөтлөгч байдаг. Хожоод л, хожигдоод л байдаг л даа. Үнэндээ миний мөнгөөр бус өөрийнхөөрөө л тоглодог юм. эхнэр нь долоон зуун мянган франк алдаж орхихлоор нөхөрт нь бага зэрэг нөлөөлж орхих юм. та үүнийг дуулаагүй гэж үү? Энэ тухай бөөн шуугиан болсон шүү дээ.
- Би энэ тухай дуулсан. Харин тодорхой мэдээгүй байсан юм. тэгээд ч би биржийн ажил явдал огт мэддэггүй амьтан байгаа юм.
- Та бирж дээр ер азаа туршдаггүй хүн үү?
- Би юу? Хэдийд нь би ашиг хонжоо хөөцөлдөх вэ? Орлогоо л дөнгөж тоолж амжиж байх юм. би даамлаасаа гадна нэг дэмч мөнгөний няравтай болох хэрэгтэй юм шиг байна. ингэхэд Испанийхаа тухай ярья. Хатагтай зөвхөн Дон Карлосыг буцаж ирлээ гэж зүүдлээд зогсоогүй баймаар юм аа? Энэ тухай сонин дээр бичсэн биш бил үү?
- Та сонинуудад итгэдэг гэж үү?
- Огтхон ч үгүй. Гэвч тэр шударга “Мэдээ” сонинд зөвхөн цахилгаан мэдээгээр ирсэн баримттай зүйлүүдийг нийтэлдэг биш билүү?
- Чухамхүү энэ л ойлгогдохгүй байгаа юм. Дон Карлосын буцаж ирсэн тухай мэдээ үнэхээр цахилгаанаар ирсэн байгаа юм.

- Тэгэхээр та энэ сард барагцаалбал сая долоон зуун мянган франк алдаа юу? гэж гүн хэлэхэд Данглар,

- Барагцаалах ч биш, яг л төчнөөнийг алдаад байна гэв.

- Чөтгөр ав, гуравдугаар зэргийн хөрөнгөтэй хүнд бол хатуу цохилт байна даа гэж гүн санаа зовсон мэт өгүүлжээ.

Тэгэхэд Данглар бага зэрэг гомдсон янзтай,

- Гуравдугаар зэргийнх гэдэг чинь юу гэсэн үг вэ? гэж асуулаа.

- Тийм ээ минийхээр бол хөрөнгө чинээ гурван зэрэгтэй байх ёстой. Нэгдүгээр, хоёрдугаар, гуравдугаар зэргийн хөрөнгө гэж байдаг. Нэгдүгээр зэргийн хөрөнгөтэй хүн бол гар доороо газар, уурхай, Франц, Австри, Англи мэтийн гүрнүүдийн цаасан дэвсгэрт зэргийн зуун сая франкийн хэмжээнд хүрэх хөрөнгө бүхий хүмүүсийг хэлнэ. Хорёдугаар зэргийн хөрөнгө гэдэг жилд сая хгасаас доошгүй хөрөнгө өгдөг, үйлдвэрүүдийн газар, хувь нийлүүлсэн хоршоо, эдлэн газар бүхий нийтдээ тавин саяас доошгүй хөрөнгөтэй хүнийг хэлнэ. Эцсийн буюу гуравдугаар зэргийн хөрөнгө гэж эргэлтэд оруулсан хөрөнгөний нь орлого хэн нэгэн хүн дампуурахаас шалтгаалах бусдын дур зориг ч юм уу цахилгаан мэдээ, санамсаргүй наймаа зэрэг дээдсийн хүчнээс бус, байгаль хэмээгдэгч доод хүчнээс алдаж, хожиж байдаг хөрөнгийг хэлнэ. Энд бол үндсэндээ арван таваас илүүгүй саяын хөрөнгө байна. та бол гуравдугаар зэрэгт нь орох хүн, тийм биз?

- Үнэн гэж Далар хариулахад гүн огтхон ч ажиггүй цаау үргэлжлүүлэн,

- Үүнээс үзэхэд энүүн шиг л зургаан сар үргэлжилбэл энэ гуравдугаар зэргийн хөрөнгө балрахын даваан дээр очоно оо доо? гэв.

- Өө, та мөн явуулж байна аа даа гэж Данглар төдий л хөгжилтэй бусаар инээмсэглэн алгуурханаар хэлэхэд, гүн өнөө л байдлаараа,

- За яах вэ, долоон сар ч болог. Долоо дахин нэг сая долоон зуун мянган франк гэдэг чинь бараг арван хоёр сая франк болдог гэж та ер нь бодож үзсэн үү? Тэгж бодоогүй чинь сайн. Хэрэв тэгж бодсон бол соёлт хүнд нүүрний арьс нь хэрэгтэй шиг, санхүүгийн хүнд тийм чухал хэрэгтэй хөрөнгөөрөө тоглохгүй байсан юм. бид их ч бага ч гэсэн тансаг хувцас өмсдөг болохоор тэд маань биднийг бага ч гэсэн жинтэй болгодог. Харин хүн үхэхэд түүнд зөвхөн арьс л үлддэг. Та ч гэсэн ажил хэргээ орхиход хүрэхэд ихдээ л тав зургаан саяын хөрөнгөтэй хоцорно шүү дээ. гуравдугаар зэргийн хөрөнгө бол утаа униар дундаа томрон харагддаг хүч чадал нь их бага байх нь хамаагүй, харагддаг шиг бух тэрэг шиг юм. ийм хөрөнгөний гуравны нэг юм уу дөрөвний нэг нь л бодитой байдаг юм. тэгэхээр таны бодитой хөрөнгө таван саяас саяхан бараг хоёр саяыг нь алдчихаж. Ингэхээр таны үндсэн хөрөнгөний хэмжээ буурчээ. эрхэм Данглар минь өөрөөр хэлбэл таны цусыг ханачхаж гэж бодвол одоо дахин дөрвөн удаа ингэж ханавал үхэлд хүрч болох болжээ. крхэм найз минь болгоомжтой байгаарай. Танд мөнгө хэрэгтэй юм биш биз? Би танд зээлдүүлэх үү? Гэв.

- Гэсэн хэдий боловч та муу тооцож байна гэж Данглар өөрийн бүх л тэсвэр хатуужлыг дайчлан хэлээд – Энэ үеэр миний касс өөр амжилттай ажиллагааны үрээр алдсанаа олсон. Алдсан цусаа тэжээлээр нөхөж авсан. Би Испанийн тулаанд хожигдож, Триестэд цохигдсон боловч, миний энэтхэгийн флот хэдэн онгоц барьж авсан байж магадгүй. Миний хайгуулчид Мексикээс ямар нэгэн хүдрийн уурхай олсон байж магадгүй гэв.

- Сайхан хэрэг! сайхан хэрэг! Гэвч шарх үлдсэн болохоор анхны алдагдал гармагц л цус гоожиж эхлэх болно.

- Үгүй, би яг таг ажиллах учраас тэгэхгүй гэж Данглар өөрийгөө өндөрт бодож сурчихсан хүний заншлаар биеэ магтаад – Намайг унагах гэвэл гурван улсын засгийн газрыг унагаах хэрэгтэй болно гэв.

- Тэр яах вэ! Ийм явдал тохиолдож л байсан.

- Тариа жимс хаана ч ургахгүй үед л магадгүй.

- Долоон тарган, долоон туранхай үнээний 1 тухай санаарай.

- Эсвэл фараоны үед тэнгисийн ус эргээсээ буцсан шиг болох гэж үү. Тэнгис ч олон доо. Гэвч хөлөг онгоцуудыг жингийн цуваагаар сольчихгүй юу. тэгээд л болох нь тэр.

- Тэгвэл ч бүр сайн хэрэг. эрхэм хүндэт Данглар би андуу бодож, та чинь хоёрдугаар зэргийн хөрөнгөтнүүдэд хамаарагдах хүн байна.

- Ийм нэр төрийг хүртэж болох байх гэж бодож байна гэж Дангларыг хэлэхэд гүнгийн боддогоор муухай зураачид эвдэрхий балгас зурахдаа оруулан зурдаг тосорхог өнгөтСй сарны дүрсийг санагдуулам эвгүй инээмсэглэж, - Бид нэгэнт ажил хэргийн яриа ярьж байгаа болохоор би эрхэм Кавалькантийн тулд су хийвэл зохих вэ? гэж яриагаа өөрчлөх завшаан олдсонд баярлан асуув.

- Хэрвээ таны банкинд данс нээгээд та түүнд нь итгэж байгаа бол мөнгө өг.

- Яалаа гэж, итгэлгүй яах вэ. тэр өнөө өглөө Бузони гэж хүн гарын үсэг зурж танд хаягласан, ар тал дээр нь таны хуудас хавсаргасан дөчин мянган франкийн чек авч ирсэн. Би түүнд тэр ддор нь дөчин ширхэг дэвсгэрт тоолж өгөв.

Гүн бүрэн сайшаасан янзтай толгойгоо дохилоо.

- Ингээд ч зогссонгүй. Тэр бас майнад өөрийн хүүд зориулж данс нээсэн.

- Уучлаарай, даруу биш нэг зүйлийг асуучихъя. Тэр хүүдээ хичнээнийг өгч байна?

- Сард таван мянган франк.

- Жилд жаран мянга. Би тэгэх л байх гэж одоод байсан юм гэж гүн хэлснээ мөрөө хавчаад – Кавалькантийнхан цөмөөрөө жигтэйхэн харамч улс байгаа юм. залуу хүнд сард тавхан мянган франк гэдэг юу болох билээ? гэв.

- Залуу хүүд илүү хэдэн мянга хэрэгтэй юм бол...
- Өгч болохгүй. Эцэг нь танд төлж өгөхгүй. Та Италийн саятан хөрөнгөтнүүдийг мэдэхгүй байна. Тэд чинь ёстой л харамчууд гэсэн үг. Тэр дансыг хэн нээв?
- Флоренцийн шилдэг пүүсийн нэг болох Фенцийн банк.
- Танд хохирол учирчих байх би л хэлж чадахгүй. Гэвч нээсэн данстай мөнгөний нь хэмжээнээс бүү хэтрээрэй.
- Та чинь Кавалькантийнд тийм ч их итгэдэггүй хүн юм аа даа?
- Би юу? Би бол түүгээр гарын үсэг зуруулаад л арван саяыг ч өгчихнө. Энэ хүний хөрөнгө миний хуваарилдагаар хоёрдугаар зэргийн хөрөнгөд орох юм.
- Тэгээд ямар энгийн байдалтай хүн бэ! Би л бол түүнийг жирийн хошууч л байна гэж хэлмээр байна.
- Тийм ээ таны хэлдэг үнэн. Гаднаас нь харахад тийм ч их итгэмээргүй хүн. Би түүнтэй анх уулзаад л ёслолын хувцас дотроо хөгширчихсэн бага дарга л байна гэж бодсон. Италичууд цөмөөрөө л тий улс. Дорнодын ид шидтэн шиг гялалзаагүй үедээ ердөө л хөгшин жүүд шиг улс байгаа юм.
- Хүү нь илүү дээр харагдаж байдаг шүү дээ гэж Данглар хэлэв.
- Бага зэрэг бүрэг боловч нүдэнд дулаахан хүн билээ. Гэвч би түүний төлөө бага зэрэг сэтгэл зовж байсан.
- Яагаад?
- Та манайд түүнийг анх харахад тэр барбг л анх удаа дээдсийн хүрээлэнд орж ббайсан юм. Надад л хэлснээрээ бол тийм юм. Тэр маш их хатуу багштай жуулчлан явж байсан бөгөөд Парист ердөө ирж байгаагүй юм.
- Тэр ямбатай итали хүмүүс зиндааныхаа хүнтэй ханилан суудаг гэсэн байх аа? гэж Данглар санаандгүй асуугаад—Тэд хөрөнгөө нийлүүлэх дуртай байдаг байх даа гэв.
- Ер нь тийм. Гэвч Кавалькантийнхан юухныг ч өөрсдийнхөө дураар хийх дуртай онцлог зантай байдаг улс. Тэр лав хүүгээ гэрлүүлэх гэж энд авчирсан байх.
- Та тэгж бодож байна уу?
- Бүр итгэлтэй байна.
- Түүний хөрөнгөний тухай юу гэж хэлэлцдэгийг сонсов уу?
- Энэ тухай их ярьцгааж байгаа юм. Зарим нь сая хөрөнгөтэй гэлцэнэ. Зарим нь сохор зоос ч байхгүй гэж баталцгааж байгаа юм.
- Аа, та юу гэж боддог вэ?

- Энэ бол миний хувийн бодол, түүнийг юманд бодох хэрэггүй.
- Үгүй, гэлээ ч гэсэн...
- Энэ Кавалькантууд нэг үе арми командалж, муж захирч байсан хүмүүс. Эдгээр хуучуулд энд тэнд булсан, хаана нуусныг нь үеэс үедээ зааж өгдөг сая сая хөрөнгө бий гэж бодож байна.Тийм ч учраас тэд цөмөөрөө, алтны нь гялтганасан өнгө нь нүүрэнд нь шингээ юү гэлтэй Бүгд Найрамдах Улсын үеийн алтан зоос шиг хатуу, шарлангуй улс байдаг юм.
- Тэгэхээр тэдний хэнд ч алгын чинээ газар байхгүй гэдэг үнэн байх нь ээ гэж Данглар хэлэв.
- Үгүй дээ л тун бага байх. Би зөвхөн Луккэд байдаг Кавалькантийн шилтгээнийг үзсэн.
- Өө, шилтгээний хүн үү?гэж Данглар асуугаад, инээмсэглэн—Тэр чинь бас нэг хэрэг дээ! гэв.
- Тийм ээ, түүнийгээ Сангийн яамны сайдад хөлслүүлчихээд өөрөө нэг жижигхэн байшинд суудаг юм. Түүнийг нарийн хүн гэж би танд хэлсэн шүү дээ.
- Та түүнийг арай дэндүүлж байгаа юм биш биз.
- Үгүй, би түүнийг бараг танихгүй шүү дээ. Түүнтэй гурван удаа л уулзсан. Түүний тухай миний мэдэж байгаа зүйл бол Бузони ламтнаас өөрөөс нь дуулсан зүйл байгаа юм. Тэр өнөөдөр надад хүүгийнхээ тухай бодож байгаагаа яриад сая сая хөрөнгөө Итали шиг улсад барьж байхын оронд Франц эсвэл Английн аль нэгэнд шилжүүлэн эргэлтэд оруулахаас буцахгүй байгаа тухайгаа цухуйлгаж байна лээ. Гэхдээ би Бузони ламд асар их итгэдэг хэдий ч ямар ч зүйлийг хариуцахгүй шүү гэдгийг хэлчихье.
- Хамаагүй, манай банктэй харилцах хүн олж өгсөнд баярлалаа. Тийм нэр миний дэвтрийг чимэглэж, Кавальканти гэж хэн болохыг тайлбарлаж өгсөн мөнгөний нярав минь үүнд бахархаж байгаа юм. Үгийн далимд асуухад, тэр эрхмүүд чинь хүүхдээ хүнтэй суулгахдаа инж өгдөг юм уу?
- Байдлаас л болдог юм. Алтан урсгалтай гол шиг баян Италийн Тоскани удмын нэг ноёнг би таньдаг юм. Тэр хүн хүүхдүүдээ өөрийн нь санаанд тохирсон эхнэр авбал хэдэн саяар ч хамаагүй шагнадаг бөгөөд, хэрвээ дур зоригоос нь зөрж эхнэр авбал сард гучхан эки өгөөд болдог байсан. Андреа эцгийнхээ хүсэл зоригоор эхнэр авлаа гэж бодоход хошууч түүнд хоёр гурван саяыг өгч мэднэ. Жишээ нь тэр эхнэр нь банкны эзний охин бол лав хүүгийнхээ хадмын ажил явдалд оролцоно доо. Тэгтэл хүүгийн нь эхнэр санаанд нь таарахгүй бол өнгөрөх нь тэр дээ. Аав нь мөнгөнийхөө авдарны түлхүүрийг цоожинд нь шургуулж хоёр эргүүлээд хармаандаа хийж орхивол манай Андреа хүү Парисын ёозгүй залуусын адил хөзөр мөзөрхөн эргүүлж явах болно доо.
- Энэ залуу баварын эсвэл перугийн гүнжийг олж авна.Тэгээд эхнэр авсныхаа шөнө ноёны титмийг дээр нь Эльдорадог¹ Петоситай нь хамт авахыг хүсэх байлгүй.

- Та ташаарч байна. Тэр алдартан италичууд чинь ердийн үхэх үйлтнүүдтэй суух нь олон байдаг юм. Тэд Юпитер шиг төрөл холихыг дурладаг улс байгаа юм. Ингэхэд хүндэт түшээ гүн та надаас чухам юу асуугаад байна вэ? Андреад эхнэр авч өгөх гээд байгаа юм биш биз?

- Энэ чинь муугүй л наймаа л даа. Би чинь наймаачин хүн шүү дээ гэж Данглар хэлэв.

- Мадмуазель Данглартай суулгах гээгүй байгаа гэж найдаж байна. Альбер хөөрхий Андреагийн хоолойг огтлог гэж та бодоогүй биз дээ?

- Альбер ий? Гэж хэлээд Данглар мөрөө хавчин,

- Тэр энд ямар ч хамаагүй л дээ гэв.

- Тэр таны охинтой сүй тавиагүй юм гэж үү?

- Морсер бид хоёр энэ гэрлэлтийн тухай ярьж байсан. Гэвч хатагтай Морсер, Альбер хоёр...

- Түүнийг тохиромжгүй хань гэж бодож байна гэж үү?

- Гэхдээ мадмуазель Данглар, бэйс де Морсероос дордоод байх юм алга.

- Мадмуазель Дангларын инж үнэхээр муугүй байх биз. Ялангуяа цахилгаан мэдээ тэнэглэхээ зогсвол бүр ч сайн гэдэгт би эргэлзэхгүй байна.

- Учир нь зөвхөн инжинд биш. Харин далимд нь асуухад...

- За тэгээд?

- Та тэр будаалган дээр Морсер, түүний эцэг эхийг яагаад уриагүй юм бэ?

- Би түүнийг урьсан боловч, залуу, ээжтэйгээ хамт Дьепп руу явах ёстой байсан. Хатагтайг тэнгисийн агаар амьсгал гэж зөвлөсөн юм байх.

- Тийм бий, тэр агаар хатагтайд хэрэгтэй байх ёстой гэж Данглар инээнгээ хэлэв.

- Яагаад тэр билээ?

- Яагаад гэвэл, хатагтай залуудаа тэр агаараар амьсгалж байсан юм.

Монте-Кристо энэ ёжтой үгийг чихнийхээ хажуугаар өнгөрүүлчихлээ.

- Альбер хэдийгээр мадмуазель Данглар шиг баян биш ч гэсэн сайхан нэртэй хүн гэдгийг зөвшөөрнө биз дээ.

- Тэгээд яах вэ, минийх ч гэсэн муугүй байх гэж би бодож байна.

- Мэдээж мэрэг. Таны нэр олонд алдаршиж, имэглэх гэсэн хэргэмийг тань чимж байгаа юм. Гэвч зарим хуучны үлдэгдэл үлэмж бат бөх учраас устгачихаж болдоггүй. Тэгэхээр хорин жил болсон язгууртнаас таван зуун жил болсон язгууртнуудыг илүү үздэг гэдгийг та ойлгохгүй байхааргүй ухаантай хүн билээ гэж гүнг хэлэхэд Данглар ёжтойхон инээмсэглэхийг оролдоод,
- Чухам ийм учраас л би Андреа Кавалькантийг Альбер де Морсероос илүүд үзээд байгаа юм шүү дээ гэв.
- Гэхдээ Морсерынхон юугаараа ч Кавалькантийнхнаас дордохгүй юм шиг надад санагддаг гэж Монте-Кристо хэлэв.
- Морсерынхон уу?... Эрхэм гүн та чинь боловсролтой хүн биш билүү? гэж Данглар хэлэхэд, гүн
- Тийм байх гэж бодож байна.
- Тэгээд ч бас сүлдүүдийн учрыг сайн мэддэг хүн байх аа?
- Бага зэрэг мэднэ.
- Тэгвэл минийх Морсерынхоос илүү найдвартай.
- Яагаад тэр вэ?
- Би хэдийгээр түшээ гүн биш боловч ямар ч гэсэн Данглар л даа.
- Тэгээд юу гэж?
- Харин тэр бол Морсер биш байгаа юм.
- Яагаад Морсер биш гэж?
- Огтхон ч биш.
- Хараач хөөе!
- Намайг бол түшээ гүн болгож өргөмжилсөн болохоор би яах аргагүй гүн хүн. Харин тэр өөрөө өөрийгөө гүнд өргөмжилсөн болохоор ерөөсөө ч гүн биш.
- Байж боломгүй юм.
- Та сонсож бай, Морсер, бол миний найз, үнэнээр нь хэлбэл гучин жилийн танил хүн. Би өөрөө ямар байж, юугаар эхэлснээ сайн мэдэх учир сүлжээрээ төдий л сонирхдоггүй юм гэж Данглар үргэлжлүүлэн ярихад Монте-Кристо,
- Энэ бол асар их даруу, эсвэл асар их бардмыг гэрчлж байгаа хэрэг гэв.
- За тэгэхээр, намайг бяцхан албан хаагч байхад Морсер жирийн нэг загасчин байсан юм.

- Тэгэхэд хэн гэдэг нэртэй байсан юм бэ?
- Фернан.
- Зүгээр л Фернан гэж үү?
- Фернан Мондего гэдэг байсан.
- Та хэлж байгаадаа итгэлтэй байна уу?
- Тэгэлгүй яах вэ? Би түүнээс цөөнгүй загас худалдан авч байсан юм чинь
- Тэгээд түүний хүүд яагаад охиноо өгөх гэсэн юм бэ?
- Яагаад гэвэл Фернан бид хоёр хоёулаа азаар өөдөлж баяжаад язгууртны зэрэгт хүрсэн учир бие биедээ тэнцдэг юм. Гэвч түүний тухай улс амьтан жиг жуг ярилцаж байхад миний тухайд бол тийм юм байхгүй.
- Чухам юуг тэр вэ?
- Шалихгүй юм даа
- Өө, одоо ойлголоо. Таныг нэрийг нь хэлмэгц Фернан Мондегогийн нэртэй холбогдсон юм санаанд орлоо. Би тэр нэрийг Грегт байхдаа дуулсан юм байна.
- Али-пашийн түүхтэй холбогдуулж уу?
- Яг тийм.
- Энд л нэг битүүлэг юм байгаа юм даа. Би түүнийг олж мэдэхийн тулд багагүй юм өгнө дөө гэж Данглар хэлэв.
- Ихэд хүсвэл ч түүнийг илрүүлэхэд хэцүү биш дээ.
- Яаж?
- Танд мэдээжээр, Грегт холбоотой хүн байдаг биз дээ?
- Байлгүй яах вэ?
- Янинад бий юу?
- Хаана л бол хаана бий.
- Тэгээд Янинад байгаа хүнээсээ, Али-Табелинэд учирсан гай зовлонд Фернан гэдэг нэртэй франц хүн ямар үүрэг гүйцэтгэсэн бэ? гэж асуугаарай.
- Таны хэлдэг туйлын зөв! Би өнөөдөр л бичнэ гэж хэлээд Данглар эрсхэн босов.
- Бичээрэй.

-Заавал бичнэ.

- Хэрвээ ямар нэг буулиантай юм мэдвэл...

- Би танд хэлэмз.

- Би танд баярлах болно.

Данглар өрөөнөөс гүйхээрээ гарч, сүйх тэрэг өөдөө явлаа.

10. Вангийн прокурорын албан тасалгаа

Банкны эзнийг гэр өөдөө давхиж явах зуур хатагтай дангларын өглөөний зугаалгыг дагаад үзье.

Хатагтай данглар арван хоёр цаг хагаст морьд өгөхийг тушаагаад гэрээсээ гарч явсан гэдгийг дээр өгүүлсэн.

Тэр хүүхэн Сен-Жермен рүү чиглэн явснаа Мазарины гудамж өөд эргэж Шинэ гүүрний цуваа дэлгүүрийн хажууд зогсохыг тушаалаа.

Хатагтай сүйх тэрэгнээс гарч мухлагуудын дагуу явлаа. Өглөө гэрээс гарч байгаа дэгжин хүүхний хувцасладагаар тун жирийн байдлаар хувцаслажээ.

Генего гудамжинд очоод тэрэг хөлслөн авч Арле гудамжруу явахыг тушаалаа.

Тэрээр тэргэнд ормогцоо хармаанаасаа маш шигүү хар гивлүүр гаргаж сүрэл малгайндаа бэхлэв. Тэгээд малгайгаа дахин өмсөөд, хармааныхий жижиг толинд харж, зөвхөн түүний цагаан арьс, гялалзсан нүдийг л харж болох төдий болсонд баярлажээ.

Хөлсний тэрэг шинэ гүүрийг өнгөрөн Дофиний талбайгаас Арлегийн орд уруу эргэв. Хөтөч үүд дөнгөж онгойлгомогц Хатагтай данглар хөлсийг нь төлчихөөд шат өөд гүйж дээш өгсөн сэмхэн Алхааны танхимд орлоо.

Өглөөгүүр шүүх таслах газарт ажил хэрэг ихтэй, хүн олонтой, зав зайгүй байдаг. Зав зайгүй хүмүүс хүүхэн анзаарч хардаггүй. Тиймийн учир хатагтай данглар өмгөөлөгчдөө хүлээж байгаа бусад хүүхнүүдээс илүү хүний анхаарал таталгүй Сэмхэн Алрааны танхим дундуур явж өнгөрөв.

Вильфорын хүлээн авах өрөө дүүрэн хүнтэй байлаа. Гэвч хатагтай Данглар нэрээ хэлэх ч хэрэг болсонгүй. Түүнийг орж ирмэгц үйлчлэгч эрхэм вангийн прокурорын ирээрэй гэсэн хүүхэн мөн эсэхийг асуугаад тийм тийм гэсэн хариултыг авсны дараа тусгай гудмаар дагуулан Вильфорын тасалгаанд оруулав.

Вангийн прокурор зөөлөн сандал дээр цаашаа харж суугаад юм бичиж суув. Хаалаг онгойж “Хатагтай орж ажаам уу” гэж хэлээд хаалга хаагдахыг сонссон боловч өчүүхэн ч хөдөлсөнгүй. Гэвч үйлчлэгчийн хөлийн чимээ дуулдахаа болимогц босоод хаалгаа түгжээд хөшгийг нь буулган тасалгааныхаа булан бүрийг тойруулан харав.

Тэгээд хэн ч харч, хэн ч дуулдахгүй болсныг үзээд санаа нь амарч,

- Хатагтай ингэж яг цаг баримталдагт чинь баярлалаа гэж хэлээд зөөлөн сандал ойртуулж өгөв.

Хатагтай Данглар суухад нь зүрх нь хүчтэй цохилж арай гэж амьсгалж байв.

- Тантай нүүр учран хоёулханаа ярих завшаан тохиолдоогүй болсоор удлаа гэж вангийн прокурор хэлээд бас зөөлөн сандал дээр хатагтайн өөдөөс харж суугаад – Харин маш хүнд яриа ярих гэж байгаа нь даанч харамсалтай байна гэв.

- Энэ яриа танаас илүү надад хүнд байгаа боловч таныг ир гэсэн даруйд чинь ирж байгааг харж байгаа биз.

Вильфор гашуунаар инээмсэглэв. Тэгээд хатагтай Дангларын үгэнд хариу өгөхөөсөө өөрийнхөө санасанд хариу болов уу, гэлтэй

- Тэгэхээр та бид хоёрын хийж байсан бүх явдал бидний өнгөрсөн үеийн байдалд заримдаа баргар бараан, заримдаа гэгээн гэрэлтэй ул мөр үлдээсэн нь үнэн шив дээ. үнэндээ та бид хоёрын амьдралын зам дээрх алхаа маань элсэн дээгүүр мөлхөж урагшилсантай адил бөгөөд судал татсан ул мөр үлджээ! Ай хөөрхий энэ ул мөрийг олон хүн нулимсаараа усалжээ! гэв.

- Эрхэм минь, миний сэтгэл ямар их догдолсон байгааг ойлгож байгаа биз! Намайг хаярлаач гуйя танаас. Энэ тасалгаанд, энэ сандал дээр, бэмбэгнэн ичиж зовсон хэрэгтнүүд хичнээн сууж байсан бол... өнөөдр чичирч догдлон, ичиж зовсон би ч бас сууж байна!... Би өөрийгөө хэрэгтэн, таныг аймшигт шүүгч гэж бодохгүй байхын тулд бүх ухаан санаагаа зарцуулах хэрэгтэй байгааг та ойлгож үзээч.

Вильфор толгойгоо сэгсрээд хүндээр санаа алдлаа.

- Аа би бол өөрийн байрыг шүүгчийн зөөлөн сандал биш харин яллагдагчийн сандал байх ёстой хэмээн өодож сууна хэмээн Вильфор зөрж эхлэв.

Тэгэхэд хатагтай гайхаж,

- Таных уу? гэж асуулаа.

- Тийм ээ, минийх.

- та өөрийн хатуу үзлээр арай дэндүүлж байх шиг байна гэж хатагтай хэлэхэд түүний сайхан нүдэнд оч гялалзан – Таны ярьж байгаа тэр ул мөрийг үлдээгээгүй залуу нас гэж байх уу? Бүх л шунал тачаалын ёроолд, бүх л зугаа цэнгэлийн цаад талд харамсан гашуудах явдал байдаг юм. тийм учраас эрт урдаас д аван зовлонтны өмөг, түшиг тулгуур болж, нүгэлт эм ба нөхөртөө үнэнч шударгыг алдсан эхнэрүүдийн тухай Хөлгөн сударт гайхамшигт сургаалийг заасан билээ. залуу насныхаа зугаа цэгэлийг санахдаа би заримдаа нүглээ наманчилснаараа ч биш, зовж зүдэрснээрээ бурхан тэнгэрт өршөөгдөх байх гэж боддог юм. танд бол айгаад байх юм юу байна? Эрэгтэйчүүд та нарыг орчин тойрон чинь дандаа зөвтгөдөг, яриа будлиан гарвал нэр сүр чинь улам ихэсдэг шүү дээ:

- Хатагтай та намайг мэднэ. Би бол хуурмаг зангүй засдаг хүн биш. Юу ч л гэсэн үндэсгүйгээр бяланчилгадаггүй хүн. Хэрвээ миний царай ширүүн догшин байгаа бол зовлон эдэлснээс тэр. Зүрх минь чулуу шиг болоогүйсэн бол үзэж амссан тэр цохилтуудыг яаж даван гарах вэ? Би залуудаа ийм байгаагүй Марсель хотын Гран Кур гэдэг гудамжинд гэрлэх өдрөө тантай нэг ширээнд сууж байхдаа тийм хүн байгаагүй. Тэр цагаас хойш надад ч тэр, орчин тойронд минь ч тэр их юм өөрчлөгджээ. Бүх амьдралаа миний зам дээр дур зоргоороо буюу эсвэл хүний эрхээр санаатай буюу санамсаргүй зогссон хэн бүхнийг бут цохих хэрэгт зарцуулж энэ саад тотгоруудыг зайлуулж байсан юм. учиргүй халуунаар хүссэн юмыг бусад хүмүүс мөн тиймээр үгүй хийчих нь цөөн байдаг юм. тэднийг хүссэн юмаа авах гэвэл гараас нь булаагаад үз. Олонх хүмүүст тохиолдож байгаа муу явдал бол өөрийн нь хэрэгцээнээс гардаг юм. сэтгэлийн хөдөлгөөн айх ичихийн үед хийж орхисон муу явдлыг эргээд харахад, зайлаад гарч цөхөхөөргүй юм байдаг. Бидний ажиллавал зохих сандарсан үедээ олж хараагүй аргууд сүүлд нь харахад ердийн л хялбархан зүйл байдаг. Тэгээд би яагаад үүнийг нь хийхгүй, тэрнийг нь хийж орхив оо гэж өөрөөсөө асуухад хүрдэг. Харин хүүхнүүд та нарыг наманчлал бага түгшүүлдэг. Яагаад гэвэл та нар өөрсдөө шийдэх нь ховор байдаг. Та нарын золгүй явдал бол бараг хэзээ ч та нараас шалтгаалдаггүй. Та нар бараг шахам бусдын гэмт хэрэгт буруутан болж холбогддог.

- Юу ч л гэсэн, би буруутай бөгөөд тэр бүхний хариуцлагыг хүлээх ёстой бол өчигдөр хатуун ширүүн шийтгэл хүлээлээ гэдгийг минь та хүлээн зөвшөрөх ёстой гэж хатагтай хэлэхэд Вильфор түүний гарыг атгаж,

- Золгүй хүүхэн, шийтгэл дэндүү хатуу учир та хоёр ч удаа ухаан алдахад ойчиход хүрсэн, гэвч... гэв.

- Юу гэвч гэж?

- Би танд нэг зүйлийг хэлэх ёстой... Энэ явдлаар төгсгөл болоогүй юм шүү, биеэ сайн барих хэрэгтэй.

- Бурхан минь! гэж айж сандарсан хатагтай дуу алдаад

- Бас юу байх нь вэ? гэж асуулаа.

- Та зөвхөн өнгөрсөн явдлын тухай бодож байна. тэр явдал бараан гунигтайн тухай хэлэхүг алга. Гэвч түүнээс илүү их муухай ирээдүй болно гэж бодоод үз... эргэлзэх юмгүй... аймшигтай болно... Магадгүй цусаар будагдан хүрэнтсэн байж ч болно.

Вильфорын зориг самбааг хатагтай мэдэх учир ийнхүү сэтгэл хөдөлсөн байдлыг нь хараад хашхирах гэсэн боловч дуу нь зангираад гарч өгсөнгүй.

- Тэр өнгөрсөн аймшигт явдал яагаад сэргэн босоод ирэв? Тэр хий үзэгдэл биднийг айлгаж зэвхийрүүлэн, ичээж улайлгах гэж бидний зүрхний дотроос, булүны гүн доороос яаж гараад ирэв? гэж Вильфор хашхирах шахам дуугарлаа.

- Энэ бол санамсаргүй болсон хэрэг.

- Санамсаргүй гэнэ үү? Үгүй, үгүй, хатагтай минь санамсаргүй юм гэж байдаггүй юм! хэмээн Вильфор зөрлөө.

- За үгүй дээ. энэ бүгд хэдийгээр гайтай боловч санамсаргүй тохиолдсон юм биш гэж үү? Монте-Кристо энэ байшинг санамсаргүй худалдан аваад л бас л санамсаргүйгээр газар ухахыг тушаагаа биз. тэр золгүй хүүхдийг модон доороос ухаж гаргасан нь санамсаргүй тохиолдсон хэрэг биш гэж үү? Хөөрхий хүүхэд минь, би түүнийг нэг ч удаа үнэсээгүй, гэвч түүний төлөө хэчнээн нулимс асгарсан гэж санана. Гүн тэрхүү цэцэгний дотроос олсон нандин үлдэгдлийн тухай ярьж байхад зүрх минь шимширч байв.

- Үгүй хатагтай минь. танд хэлэх гэж байгаа энэ зүйл бол бүр аймшигтай байх болно. Цэцгэн дотроос ямар ч юм ухаж олоогүй, уйлж унжиж гинших хэрэггүй. Харин дагжин чичрэх хэрэгтэй.

- Та юу хэлэх гээ вэ? хэмээн хатагтай бүх бие нь чичрэн асуулаа.

- Монте-Кристо тэрхүү модон дотроос хүүхдийн ясыг нь төмөр хэсгийг ч олж өсгүй байсан юм. Яагаад гэвэл тэнд тэдгээрийн аль нь ч байгаагүй юм.

- Аль нь ч байгаагүй гэнэ ээ? гэж хатагтай айсандаа боож нүдээ бүлтийлгэн вангийн прокурор өөд харж асуугаад – Аль нь ч байгаагүй гэнэ ээ? гэж бас дахин өөрийн үгээр, өөрийн дуугаар зайлан алга болчих гээд байгаа бодлоо тогтоон барих гэсэн мэт асуулаа.

Тэгэхэд Вильфор хоёр гараараа нүүрээ дарж,

- Үгүй, үгүй, үгүй гэж дуугарлаа.

- Тэгвэл тэр золгүй хүүхдийг тэнд оршуулаагүй байх нь ээ? Та намайг юунд хуурав аа? Хэлээч дээ, юунд тэр вэ?

- Тэнд л дээ. гэвч та миний хэлэх үгийг сонссоч. Үүнийг минь сонсоод та намайг өрөвдөх болно. Би энэхүү хүнд дарамтыг тантай хуваалцалгүй хорин жил хуурч явлаа. Одоо би танд бүгдийг хэлье.

- Бурхан минь! Та намайг бүр айлгачихлаа. За хамаагүй ээ, ярь. Би чагнаж байя.

- Та тэр улаан дотортой өрөөнд орон пээр амьсгаадан хэвтэж, би ч бас тан шиг амьсгаадан сандарч, юву болохыг хүлээж суусан тэр золгүй шөнө яаж өнгөрснийг санаж байгаа байх. Хүүхэд төрж, амьсгал ч үгүй, хөдөлгөөн ч үгүй, дуу чимээ ч үгүй хүүхдийг надад өгсөн. Би түүнийг үхсэн хүүхэд гэж бодсон.

Хатагтай Данглар ухасхийн босох нь гэлтэй татвалзан хөдлөв.

Гэвч Вильфор түүнийг зогсоогоод цааш нь сонсохыг гуйсан мэт гараа элгэндээ зөрүүлэн барив.

- Би түүнийг үхсэн хүүхэд гэж бодсон. Тэгээд авсыг орлосон хайрцагт хийгээд, цэцэрлэг рүү очиж газраа ухаад яаран булсан. Дөнгөж нүхээ шороогоор бултал над уруу нэг корсик хүн дайрсан. Миний өмнө хүний сүүдэр сүүтэгнээд цахилгаан цахих адил Үолсон. Бие минь хөндүүрлэн өвдөж хашхирах гэтэл бие минь дагжиж хоолой минь боогдлоо... Би газар унаж өөрийгөө үхчихлээ гэж бодсон билээ. Намайг хагас ухаантай юм мөлхөөд шатанд хүрч ирэхэд та ч бас хагас ухаантай байсан ч гэсэн над руу бууж ирсэн тэр өгүүлшгүй их зоригийг чинь би хэзээ ч мартажгүй. Тэр аймшигт явдлыг нуух хэрэгтэй байсан юм. та өөрийн асрагчтай хамт гэртээ орж чадсан. Би өөрийн шархыг ирүүл тулааны шарх гэж хэлээд өнгөрсөн. Бидний нууц ингэж санаснаас илүү хадгалагдаж чадсан юм. намайг Версальд авчирсан. Гурван сарын турш үхэлтэй тэмцсэн. Тэгээд сүүлд нь алгуурхан эдгэрч эхлэхэд намайг өмнө зүг өөд нар салхид яв гэсэн. Парисаас Шалон хүргэхээр дөрвөн хүн өргөж явсан. Дамнуургын араас хатагтай Вильфор сүйх тэргэнд сууж дагаж явсан. Би Шаланоос цааш Соноор хөвж, тэндээсээ Роноор дамжин арль хүрсэн. Арлид намайг дахин дамнуурган дээр тавьж Марсель хот хүргэсэн. Би хагас жил болж байж эдгэрсэн. Би таны тухай юу ч дуулаагүй. Асууж ч зүрхлээгүй. Тэгээд Парист буцаж ирээд таныг бэлэвсрээд Данглартай суужээ гэдгийг мэдсэн.

Би тэгэхэд ухаан орсноосоо хойш юу бодож явсан гээч? Ганцхан л хүүхдийн хүүрийн тухай л бодож байлаа. Шөнө бүр л булшнаасаа гарч ирээд намайг гараараа занаж байна гээд л зүүдэлдэг байлаа. Би Парист ирмэгцээ л бүх зүйлийг сураглаж мэдсэн. Биднийг явснаас хойш тэр байшинд хэн ч сууж байгаагүй байснаа дөнгөж саяхан есөн жилийн хугацаагаар хүнд хөлслүүлсэнийг мэдэж авлаа. Тэгэхээр нь хөлсөлж авсан хүн дээр очиж талийгаач эхнэрийн маань эцэг эхийн байшин өөр хүнд шилжихийг хүсэхгүй байгаагаа хэлж гэрээ цуцалсны төлбөрийг төлж өгье гэв. Надаас зургаан мянган франк авна гэсэн. Харин би бол арав, хорин мянган франк өгөхөд ч бэлэн байсан. Би мөнгөтэй байсан болохоор гэрээг тэр доор нь цуцалж орхилоо. Ингэж амжуулаад Отейль өөд явав. Намайг тэндээс гарснаас хойш тэр байшинд хэн ч ороогүй байсан юм.

Өдрийн таван цаг болж байлаа. Би шатаар гарч улаан тасалгаанд орж шөнө болохыг хүлээлээ.

Тэнд хүлээж байх зуур жилийн турш сэтгэлд зовж байсан тэр зүйл улам ч аймшигтай санагдаж байлаа.

Тэр корсик хүн надаас цусаар өшөө авна гэж тангарагласан юм. тэгээд Нимаас Парис хүртэл намайг дагаж мөрдөж байгаад хутгалжээ. Энэ корсик хүн намайг газар ухаж хүүхэд булахыг харсан байх. Тэгэхээр тэр таны хэн болохыг бас мэдэж болно. Мэдчихсэн ч байж магадгүй. Тэр хүн тэрхүү аймшигт нууцыг хадгалахын төлөө танаас төлбөр нэхвэл яах вэ? Тэр намайг хутгалж алж чадаагүйгээ мэдвэл энэ нь түүнд сайхан өшөө авалт болох юм. тийм учраас өнгөрсний ул мөр, эд мөрийн баримтыг устгах нь чухал гэж үзсэн юм. миний санаанд үлдэж хадгалагдсан тэр зүйлүүд хангалттай хойно доо.

Ийм учраас гэрээг хүчингүй болгож, тийшээ давхин очиж, шөнө болохыг хүлээж суусан минь тэр.

Шөнө б@ллоо. Би бүр харанхуй болохыг хүлээж байв. Би х ранхуйд сууж байсан бөгөөд салхи сэвэлзэхэд хөшиг хөдөлж, цаана нь тандуул туршуулууд

хөдлөөд байгаа юм шиг санагдаад байв. Би байн байн цочиж татвасхийж байв. Ар талд маань ор байсан бөгөөд та түүн дээр гиншиж байх шиг санагдаад эргэж харахаа ч айж байв. Энэ чимээ аниргүйн дунд зүрх минь яаж цохилж байгаа хүртэл дуулдлаа. Шарх маань дахин задарсан юм шиг, зүрх маань тийм хүчтэй цохилж байлаа. Суурин дахь чимээ анир ашгүй нэг намхарч билээ. тэгээд би юунаас ч айх хэрэггүй, хэн ч намайг харж, сонсохгүй гэж мэдээд цэцэрлэг рүү буулаа.

Эрмина, би аймхай хүн биш шүү. Гэвч та бид хоёр хичнээн хайрлаж, та алтан цагиргаар оосорлож явдаг байсан зүүлттэй түлхүүрээ энгэрээсээ авч цэцэрлэгийн хаалаг онгойлгоход сарны цагаан гэрэл цонхонд тусаад шатан дээгүүр хий юм шиг сүүтэгнэхэд би хана түшин авч арай л хашхирчихсангүй. Галзуурах шиг л санагдаж билээ.

Тэгээд би арай гэж биеэ барьж алгуурхан бууж эхлэв. Гэвч өвдөг чичрэхээ барьж чадсангүй. Би шатны бариулаас зуурч байгаагүй бол унах байлаа.

Тэгээд би доод хаалга хүрлээ. Надад нууц дэнлүү байсан юм. тэгээд ногоон зүлгийн дунд зогсож гэрлээ асаагаад цааш явлаа.

Арван нэгдүгээр сарын сүүлч үе болж байсан учир нүцгэрсэн мод араг яс мэт сарьайн хөлийн дор унасан навч, элс шажигнана.

Имй аймшигт байдал зүрхийг минь базах тул шугуйд ойртоод хармаанаасаа буугаа гаргаад замгийг нь татан бэлдэв. Мөчрийн цаанаас өнөөх корсик хүн хараад байгаа юм шиг санагдаад байлаа.

Би нууц дэнлүүгээр бутнуудыг гэрэлтүүлэн харахад юу ч харагдахгүй байлаа. Бас эргэн тойрон харахад гав ганцаараа байв. чимээ аниргүй байдлыг нэг ч дуу чимээ эвдсэнгүй, харин шар шувуу шөнийн буг дуугарах мэт чанга хашхирна.

Би дэнлүүгээ ноднин жил нь булшны нүх ухаж байхдаа ажиглан харсан хоёр салаат мөчир дээр өлгөв.

Зун нь энд өтгөн өвс ургасан боловч, намар нь хэн ч түүнийг хадаж авсангүй. Гэсэн ч төдий л их өвс ургаагүй хэсэг газар нүдэнд тусч, би чухам л тэнд нүх ухаж байснаа санах. Тэгээд тэр дороо ажиллаж эхлэв.

Жил илүү хүлээсэн мөч боллоо.

Тэгээд хүрээ мар нэг юм хүрэг шиг болох бүрт атга шороо бүрийг нарийвчлан үзэж, хичээнгүйлэн ухаж найдаж горьдож байсн боловч, юу ч байсангүй. Харин би түрүүчийнхээсээ хоёр дахин том нүх ухсан билээ. тэгээд андуураад өөр газар ухчихаж гэж бодов. Эргэн тойрныг харж мод бүхнийг ширтэн бүх зүйлийг сэргээн бодох гэж хичээнэ. Хүйтэн салхи шуугин нүцгэн мөчрүүд исгэрэн байсан боловчхөлс борооны дусал мэт гоожино. Намайгш булшны шороо тэгшлэн гишгэлж байха хутгалсныг саналаа. Тэгэхэд би цагаан бургас түшсэн юм. ар талд маань зугаацан явагчдад зорудлсан сандалд болох хиймэл цохио байв. Би унахдаа иэр хүйтэн чулууг гараараа дарж авсан билээ. харин одоо цагаа бургас баоуун талд хад чулуу ар талд минь байв. Би тэр үед унасан шигээ гагар ойчоод дараа нь босож нүхээ өргөтгөн ухаж гарлаа. Бас л юу олсонгүй! Хайрцаг алга байлаа.

- Алга байсан гэнэ ээ? гэж хатагтай Данглар айснаасаа болж амьсгаа нь давхцан шивгэнэхэд Вильфор үргэлжлүүлэн,

- Намайг энэ оролдлогоор хязгаарласан гэж бүү бодоорой. Үгүй шүү. Би бүх л төглийг нэгжсэн. Өнөө алуурч хайрцгийг ухан гаргаж аваад дотор нь алт мөнгө байгаа байх гээд авч явснаа андуурсан болохоо мэдэж буцаагаад булчихсан байж магадгүй гэж бодсон юм. Гэвч би юу ч олсонгүй. Тэгээд сүүлд нь зүгээр л нэг газар хаячихсан байж магадгүй гэдэг санаа надад төрөв. Ингээд эрье гэж бодлоо. Ингэж эрэхэд гэгээ орохыг хүлээх хэрэгтэй байв. Тэгээд би тасалгаандаа буцаж очоод, хүлээв гэж ярив.

- Ай бурхан минь!

- Дөнгөж л гэгээ ормогц дахиад л цэцэрлэг рүү орлоо. Юуны өмнө төглийн эргэн тойрон сайн харав. Шөнийн харанхуйд ажиглагдаагүй ямар нэгэн ул мөр байж магадгүй гэж горьдсон юм. Би дахиад л хорь гаруй алхам газрыг алхам хяраатай гүн ухлаа. Хөлсний ажилчин ч гэсэн миний нэг цагийн дотор хийсний чинээ ажлыг бүтэн өдөр ч хийж чадахгүй байх. Гэвч би юу ч олсонгүй.

Тэгээд би хайрцгийг ямар нэг газар хаячихсан байж магадгүй гээд эрж гарлаа. Тэр хүн хаалга руу явсан замын хажууд хаячихсан байж болох байсан юм. Гэвч энэ оролдлого маань талаар болж, зүрх минь шимшрэн, горьдлого тасран төлөлдөө буцаж ирсэн билээ.

- Галзуурч болмоор юм байж дээ! гэж хатагтай Данглар дуу алдахад Вильфор,

- Галзуурах байх гэж нэг үе горьдсон боловч тийм аз завшаан тохиолдсонгүй. Би бүх хүчээ хуримтлуулан, эрүүл ухаанаа зарцуулж, тэр хүн хүүр авч явдгийн учир юу билээ? гэж эргэцүүлэн бодлоо гэв.

- Гартаа баримт нотолгоотой байх гэж бодсон байх гэж та хэлсэн шүү дээ гэж хатагтай Данглар өөдөөс нь хэлэв.

- Үгүй, хатагтай минь ийм юм байх ёсгүй. Хүүрийг бүтэн жилээр хадгалж болохгүй тул зүгээр л засаг захиргааны газар аваачиж үзүүлэхэд, мэдэгдэл гаргаж өгөх байсан. Гэвч ийм явдал болоогүй юм.

- Тэгвэл яасан байж таарах вэ? гэж Эрмина чичрэн асуулаа.

- Тэгвэл бидэнд илүү аюултай, илүү их гайтай явдал болно доо. Хүүхэд лав амьд байгаад алуурч түүнийг аварсан байх.

Ингэж хэлэхэд хатагтай Данглар орилоод Вильфорын гараас шүүрэн авав.

- Миний хүүхэд амьд байсан гэж үү? Та миний хүүхдийг амьдаар нь оршуулчихсан хэрэг үү? Та түүнийг үхсэн гэж бүтэн итгээгүй хэрнээ амьдаар нь оршуулчихсан юм гэж үү? гэж хэлээд вангийн прокурорын өмнө нуруугаа эгцлэн зогсож бараг заналхийлсэн байдлаар түүний гарыг бяцхан гараараа чанга атгаж байв.

- Чи яаж мэдэх билээ? Би зөвхөн тэгж л тааварлаж байгаа юм гэж Вильфор хариу өгүүлэхэд түүний гөлөрсөн харц нь энэ зоригтой хүн ганихарч, ухаан тавихын даваан дээр байгааг илтгэнэ.

- Миний хүү, хөөрхий хүү чинь гэж хатагтай дахин дуу алдаад сандал дээр сууж цурхиран уйлах чимээгээ намтгах гэж алчуураараа амаа дарав.

Вильфор ухаан орж эх хүний хорсол заналыг өөрөөсөө зайлуулахад өөрт тохиолдсонд аймшгийг түүнд итгүүлэх нь чухал гэж үзжээ.

- Хэрвээ тийм бол бид өнгөрлөө гэдгийг та ойлгож байгаа биз дээ гэж хэлээд Вильфор дуугаа намасгахын тулд хатагтай руу очоод – Тэр хүүхэд амьд бөгөөд энэ тухай хэн нэгэн хүн мэдэж, бидний нууцыг эзэмдэж байна. хүүхэд тэнд байгаагүй байтал хүүхдийн хүүрийг ухаж олсон мэтээр ярьж байгаа болохоор тэр нууцыг Монте-Кристо гүн л мэдэж байна гэв.

- Үнэнч шударга бурхан минь! Энэ бол таны өшөө хорсол мөн гэж хатагтай шивнэлээ.

Вильфор үүнийх нь хариуд нэг жигтэйхэн хүнгэнэн дуугарлаа.

- Харин хүүхэд хаа байна? гэж эх нь шалгаалаа.

- Өө би хичнээн их эрсэн гэж санана гэж хэлээд Вильфор халаг хоохой болон – Нойр үл хүрэх шөнийн уртад би түүнийг яахан дуудаж байсан гэж санана. Би ван шиг их хөрөнгөтэй болж хүн бүхний нууцыг худалдан авч түүний дундаас өөрийнхөө нууцыг олж авахсан гэж хэчнээн их бодож байсан гэхэв. Би зуун удаа хүрз барин газар ухаж байхдаа тэр корсик хүн хүүхдийг яагаа бол хэмээн өөрөөсөө асууж байв. Оргож зугтаж явсан хүнд хүүхэд гэдг тээр болно. Хүүхдийг амьд байгааг мэдээд гол руу хаячихсан байж магадгүй юм аа гэж бодсон юм.

- Тийм байж болохгүй гэж хатагтай дуугараад - Өшөшш хорсолос болж хүнийг алж болно, харин хүүхдийг хайхралгүй усанд хаяж болохгүй гэхэд Вильфор үгэлжлүүлэн,

- Түүнийг асрамжийн газар аваачиж өгсөн байж магадгүй яа? Гэж хэлэв.

- Тийм ээ, тийм хүүхэд тэнд байж таарна.

- Тэгэхдээ би асрамжийн газар уруу гүйн очиж, яг тэр шөнө буюу есдүгээр сарын хоринд хаалганы нь дэргэд хүүхэд авчирч тавьсан эсэхийг сураглан мэдэв. хүүхдийг зөөлөн даавуунд ороосон байсан бөгөөд даавууг түшээ гүн хэргэмийн сүлд болгон Н үсгтйн талыг үлдээж талыг нь зориуд урж авсан байжээ.

- Тийм байх ёстой гэж хатагтай дуу алдан хэлээд – Миний бүх цагаан даавуу хэрэглэл тийм тэмдэгтэй байсан юм. миний нэрийн эхний үсгийн де Наргон түшээ гүн байсан. Бурхан минь! Хүүхэд минь үхээгүй байжээ.

- Үгүй, үхээгүй.

- Та үүнийг надад хэлж байдаг. Та намайг баярлаад үхчихвий гэж айхгүй байна уу? тэр одоо хаана байна? миний хүү хаана байна?

Вильфор мөрөө хавчлаа.

- Би мэднэ гэж үү? Хэрвээ би мэдэж байсан бол таныг ший жүжиг роман зохиолд гардаг шиг ингэж удаан зовоох байсан гэж үү? Халаг минь би огт мэдэхгүй. Наайг очихоос зургаан сарын өмнө нэг хүүхэн авахаар өнөөх даавууны хагасыг авчирчээ. тэр эмэгтэй хуулиар шаардагдах бүх баримтыг авч ирсэн болохоор түүнд хүүхдийг өгөөд явуулжээ.

- Тэр бүсгүй хэн байсныг мэдэж эрж олох ёстой байсан юм.

- Та намайг юу хийсэн гэж бодож байна? Шүүхийн мөрдлөг гэдэг нэрийн доор хамгийн шалмаг эрүүлч, хамгийн хашир цагдаагийн төлөөлөгч нарыг эмэгтэйн мөрөөр явуулсан юм. түүнийг Шалон хүртэл мөшгөөд тэнд иөрийг нь алджээ.

- Алдах ий?

- ТЭйм ээ үүрд.

Хатагтай Данглар Вильфорын яриаг чагнаж суухдаа заримдаа санаа алдаж, заримдаа нулимсаа дусааж, заримдаа дуу алдан байв.

- Тэгээд л энэ үү? Та үүгээр хязгаарлаж орхив уу? гэхэд Вильфор,

- Үгүй би эрж сураглаж, мэдээ материал цуглуулахаа хэзээ ч болиогүй юм. Үнэнээ хэлэхэд сүүлийн хоёр гурван жил би өөртөө амсхийх зав зай өгсөн л дөө. Харин одоо би хэзээ хэзээнийхээс шаргуу ажиллах болно. Та дуулж бай, би заавал амжилт олно. Яагаад гэвэл одоо намайг энэ ажилд зөвхөн дотоод сэтгэл төдийгүй бас айх явдал түлхэж байна.

- Монте-Кристо юу ч мэдэхгүй байх гэж би бодож байна хэмээн хатагтай зөрж хэлээд – Тиймгүй бол бидэнтэй тэгж ойртох гээд байхгүй байсан байлгүй гэв.

- Хүмүүсийн хорон хэмжээ хязгаар байхгүй. Тэр бол бурхны энэрэл хязгаар хайраас ч илүү хэмжээ хязгааргүй байдаг юм. та тэр хүнийг бидэнтэй ярилцаж байхад нүдийг нь анзаарч харав уу? гэж Вильфор асуулаа.

- Үгүй шүү.

- Харин та тэрүүн өөд анхааралтай харж байсан удаа бий юү?

- Байлгүй яах вэ. тэр маш хачин хүн. Тэгээд л гүйцээ. Харин би нэгэн зүйлийг ажигласан. Тийм сайхан хоолоор биднийг зочилж байхдаа юунд нь ч гар хүрээгүй шүү.

- Тийм ээ би бас ажигласан. Би тэр үед одоогийн мэдэж байгаа зүйлийг мэдэж байсан бол сан бол биднийг хорлох гэж байна гэж бодоод бас л юунд нь ч гар хүрэхгүй байсан юм.

- Тэгсэн бол ташаарах байжээ, тийм байгаа биз?
 - Тийм нь ч тиймээ. Энэ хүнд өөр төлөвлөгөө байх шиг байна. чухам энэ учраас тантай ярилцан юм бүхнээс, ялангуяа тэр хүнээс болгоомжилж байхыг захих гэсэн юм гээд Вильфор хатагтайг улам ширтэн харж – Та бидний холбооны тухай хэнд ч хэлээгүй биз? хэмээн асуулаа.
 - Хэзээ ч хэнд ч хэлээгүй.
 - Шалгааж байгааг минь уучлаарай гэж Вильфор зөөлнөөр үргэлжлүүлэн – Би хэнд ч үгүй биз гэж байгаа маань энэ ертөнц дээр хэнд ч хэлээгүй биз гэж асууж байгаа юм шүү, та ойлгож байгаа биз? гэхэд хатагтайн царай улаж,
 - Тийм ээ сайн ойлгож байна. хэзээ ч хэлээгүй гэдгээ танд тангараглая.
 - Өдрийнхөө хийсэн юмыг үдэш нь тэмдэглэдэг заншил байхгүй биз? Та өдрийн тэмдэглэл хөтөлдөг үү?
 - Үгүй, миний амьдрал үймээн шуугиан дунд өнгөрдөг. би юу болсныг өөрөө ч мартчихдаг юм.
 - Та шөнө зүүдэлж ярьдаг уу?
 - Би хүүхэд шиг л бөх унтдаг. Та мартчихлаа гэж үү? гээд хатагтайн царай улайж, Вильфорын царай үхээрийн мэт зэвхийрлээ.
 - Нээрээ тийм дээ гэж Вильфор зөнгөж дуулдах төдийн хэлэв.
 - Тэгээд цааш нь гэж хатагтайн асуухад Вильфор,
 - Цааш нт ий? Би юу хийвэл зохихыг мэдлээ. Монте-Кристо гэж чухам хэн болох, хаанаас ирсэн, хаашаа явж байгаа ба цэцэрлэг дотроос хүүхэд олдсон тухай тэр ямар санаата йбидэнд ярьсан учрыг нэг долоо хонуулгүй мэдэх болно.
- Хэрвээ гүн энэ үгийг дуулсан сан бол цочин давхийхээр тийм өнгөөр Вильфор үүнийг элэв.
- Дараа нь хат гтайн дурамжхан өгсөн гарыг атгаад, түүнийг ихэд хүндэтгэсэн маягтай үүд хүртэл гаргаж өгөв.
- Хатагтай өөр тэрэг хөлслөн аваад гүүр гарч цаана талд нь түүнийг хүлээнгээ үүрэглэн байгаа хөтөч, сүйх тэрэг хоёроо олж авав.

11.Урилга

Тэр өдөр хатагтай Дангларыг вангийн прокурорын тасалгаанд байхад Эльер гудамжаар аяны сүйх тэрэг гарч ирэн 27 дугаар байшингийн дааман хаалгаар орж хашаан дотор зогслоо.

Тэрэгний хаалга онгойж түүн дотроос хатагтай Морсер хүүгийнхээ гарыг түшин гарч ирлээ.

Альбер ээжийгээ тасалгаанд нь оруулж өгөөд, тэр дороо өөртөө халуун ус, морь хоёр захиалж орхиод дараа нь гэрийн үйлчлэгчээрээ туслуулан хувцсаа солиод Елисейн тал руу Монте-Кристогийнд хүргэж өг гэж тушаав.

Гүн түүнийг ердийнхөөрөө инээмсэглэн угтав. Энэ хүний зүрх сэтгэл оюун ухаанд нь жаахан ч атугай нэвтрэн орж болохгүй нь хачин хэрэг байлаа. Түүний сэтгэл оюунд хүчээр нэвтрэх гэж оролдсон хүн бүр ингэж хэлж болдогсон бол давшгүй хана хэрэмтэй тулгардаг байлаа.

Гараа алдлан тэврэхээхр очсон Морсер түүнийг хараад өөрийн эрхгүй гараа буулган, гүн хичнээн эелдэгхэн инээмсэглэн байсан боловч зөвхөн гар барив.

Харин гүн ердийнхөө заншлаар түүний гарыг атгасангүй, зөвхөн гарт нь хуруу хүрэх төдийн боллоо.

- Эрхэм гүнтэн би хүрээд ирлээ гэж Альбер хэлэв.

- Морилон орохыг хүсье.

- Би дөнгөж цагийн өмнө ирсэн.

- Дьеппаас уу?

- Трепораас ирлээ.

- Өө, тийм л дээ.

- Хамгийн түрүүнд тан дээр ирлээ шүү дээ.

- Энэ чинь тун сайхан хэрэг байна гэж өөр ямар ч үги©г хариу хэлэх байсан хайхрамжгүй өнгөөр гүн хариу барив.

- За сонин юу байна?

- Сонин юу байна ий? Та гаднаас ирсэн хүн ийм юм асуугаад яах нь вэ?

- Та миний хэлснийг ойлгосонгүй. Та миний өлөө ямар нэг юм хийв үү? гэж асуух гэсэн юм.

- Та надад ямар нэг юм даалгасан гэж үү? Гэж гүн сэтгэл зовсон дүр үзүүлж асуухад, Альбер

- Та битгий хайхрамжгүй байдал үзүүлэх гээд байгаач. Зайнаас ч гэсэн бие биедээ талтай байдаг холбоо байдаг гэж ярьцгаадаг. Тэгэхээр би Трепорт байхдаа ийм цахилгаан нөлөөг мэдэрч байсан. Та миний төлөө юу ч хийгээгүй байж болно, гэхдээ миний тухай бодож байсан шүү дээ.

- Энэ магадгүй. Үнэндээ таны тухай бодсон шүү. Таны хэлж байгаа миний бие дамжуулагч болсон цахилгаан бол миний хүсэл зоригоос гадуур танд нөлөөлсөн байх гэж гүн хэлэв.

- Тийм гэж үү? Яагаад гэдгийг хэлж өгөөч?

- Маш амархан. Данглар танай зоогонд уригдсан юм.

- Үүнийг би мэднэ. Ээж бид хоёр түүнтэй уулзахаас зайлсхийнхийн тулд тэгж явсан шүү дээ.

- Харин тэр Андреа Кавалькантитай хамт танай хол идсэн.

- Таны итали ноёнтон юу?

- Тэгж хэтрүүлэх хэрэггүй. Андреа өөрийгөө зөвхөн бэйс л гэдэг юм.

- Өөрөө тэгдэг гэж үү?

- Тийм ээ.

- Тэгвэл тэр чинь бэйс биш юм уу?

- Би хаанаас мэдэх вэ? Тэр өөрийгөө тэгж нэрлэдэг болохоор би тэгж нэрлэдэг, бусад хүмүүс ч бас тэгж нэрлэдэг. Тэр үнэхээр бэйс байлаа ч гэсэн ямар хамаа байх билээ, тийм үү?

- Гойдын санаа хэллээ шүү, тэгээд?

- Юу гэж тэгээд?

- Данглар танайд хоол идсэн биз дээ?

- Тийм ээ.

- Бас таны Андреа Кавальканти?

- Андреа кавальканти, бэйс, түүнийг эцэг бэйл хатагтай Данглар, Вильфор эхнэртэйгээ, бас гайхам залуус Дебрэ, Максимилиан Моррель бас...өөр хэн билээ? Байз, байз...аа тийм, Шато-Рено байсан.

- Миний тухай ярив уу?

- Нэг ч үг яриагүй.

- Тэр тусмаа муу даа.

- Яагаад? Та чинь өөрийнхөө тухай мартаарай гэсэн шиг надад санагдаж байна. тэгээд л таны хүслийг биелүүлсэн юм.

- Хүндэт гүн минь, хэрвээ миний тухай яриагүй бол лав миний тухай их бодсон байх ёстой. Энэ нь миний сэтгэлийг эвгүйцүүлж байна.

- Мадмаузель Данглар таны тухай бодсон хүмүүсийн тоонд л байгаагүй бол танд хамаагүй юм биш үү? Гэхдээ тэр бүсгүй гэртээ таны тухай бодож болох юм байна шүү дээ.

- Өө, тэр талаар бол санаа зовох хэрэггүй. Тэр хүүхэн миний тухай бодсон байлаа гэхэд би түүний тухай боддогоос өөрцгүй юм боддог байх ёстой.

- Мөн талтай байна аа? Ингэхэд та холёр бие биенээ үзэн яддаг юм шив дээ? гэхэд Морсер,

- Хэрэв мадмаузель Данглар өөрийнх нь төлөө мини йзовохгүй байгаа тэр зовлонг болгоон үзэж чаддагсан бол, тэгээд үүний минь төлөө манай хоёр айлын тохиролцсон гэр бүл бололцох нөхцлийг хайхралгүй намайг шагнадаг сан бол би гялайхсан даа. өөрөөр хэлбэл тэр бүсгүй сайхан явдаг хүүхэн байж чадна, харин эхнэр болно гэвэл ч ёстой чөтгөр ав... гэж Морсер хэлэхэд,

- Та ирээдүйнхээ эхнэрийн тухай муугүй л бодолтой байгаа юм байна гэж гүн хэлээд инээв.

- Тийм ээ, энэ маань мэдээж жаахан бүдүүлэгдүү хэлсэн хэдий ч үнэн юм шүү. Энэхүү хүслийг амьдралд хэрэгжүүлэх аргагүй. Тодорхой зорилгод хүрэхийн тулд мадмаузель Данглар миний эхнэр болж, өөрөө хэлбэл надтай хамт сууж, надтай хамт бодож санаж, надтай хамт дуулж, хөгжмөөр хичээллэн, шүлэг бичиж, амьдрал туршдаа хамт байх хэрэгтэй болж байна. энэ бүгд миний айдсыг хүргэх юм. Явдаг хүүхнээс бол салж болно. Харин эхнэр бол өөр хэрэг. түүнтэй нэг л нэр холбосон бол хол ч байсан ойр ч байсан ялгаагүй үүрд холбоотой болно. Мадмаузель Данглартай хол ч басан холбоотой байна гэдгийг бодохоос ч аймшигтай санагдах юм.

- Таны таалалд нийцүүлэх амаргүй дэг ээ.

- Тийм ээ, би байнга бүтэшгүй юм мөрөөддөг хүн.

- Юу тэр вэ?

- Аавынхаа олсон шмг тийм эхнэр олох гэсэн юм.

Гүнгийн царай зэвхийрч хоёр сайхан гар буугаар тоглон замгийг нь хурдан хурдан тачигнуулангаа Альбер өөд хараад,

- Тэгвэл таны эцэг их аз жаргалтай хүн юм аа? гэж асуулаа.

- Гүн та, намайг ээжийнхээ тухай юу бодож байдгийг мэдэх байх аа? Манай ээж бол ёстой тэнгэрийн дагина. Түүнийг хараарай л даа. гоо сайхан, ухаантай хэвээрээ, хэзээ хэзээнээс ч илүү сайхан саатай яваа хүн. Бид Трепорт байлаа. Ер нь хүү эхийгээ дагаж явна гэдэг бол эелдэгээр үйлчлэх буюу ёсыг даган аргацаах гэсэн үг шүү дээ. би ээжтэйгээ хоёулханаа дөрвөн хоног хамт байлаа. Тэгээд би Трепорт

хатан хаан Маб буюу Титанийг дагалдан явснаас илүү аятай, сэргэлэн цовоо, яруу сайхан байлаа.

- Ийм бүрэн төгс яруу сайхан байна гэдэг ховор. Таны яриаг сонсоод эхнэргүй хэвээрээ явмаар санагдаж байна шүү.

- Энүүнд хамаг учир байгаа. Орчлон ертөнц дээр өөгүй сайхан бүсгүй байдаг юм гэдгийг мэдэх болсноос мадмаузель Данглартай суухыг даанч хүсэхгүй байна. бидний амин хувиа хичээх хүсэл өөрийн маань юм бүхнийг гойд содон сайхан харагдуулдгийг та ер ажигласан уу? Марле буюу Фоссены үзмэрийн цонхонд байдаг очир эрдэнийн чулуу манайх болохоороо улам ч сайхан болсон шиг санагддаг. Өөр илүү тунгалаг сайхан чулуу байдгийг олж мэдсэн атлаа арга буюу муухан чулуу зүүхэд хүрвэл сэтгэл нэг л дундуур гэсэн үг шүү дээ! гэв.

- Хоосон хорвоогийн жам аа гэж! гэж гүн аман дотроо шивэгнэв.

- Ийм учраас ч Эжени намайг өчүүхэн хумхийн тоос гэдгийг мэдэж надад өөр шиг нь сая сая франк байхгүй дөнгөж л зургаадхан мянган франктай гэдгийг үнэмшин итгэсэн тэр өдөр би баярлан цовхчино доо.

Гүн инээмсэглэнгээ,

- Надад бас нэг санаа төрсөн юм. францыг ер бусын хачин юм бүхэнд дуртай хүн болохоор нь мадмаузель Дангларт хүчээр дурлуулах гэж оролдод үзэв. Тэгээд Эженийг хамгийн сэтгэл татахаар бичиж дүрслэн дөрвөн ч удаа захидал явууллаа. Гэвч Франц “Би үнэхээр ер бишийн хачин юманд дуртай хүн. Гэсэн хэдий ч үгнээсээ буцахаар тийм хүн биш” гэж ажиггүй хариулсан шүү гэв.

- Өөрөө бол зөвхөн явдаг хүүхнээ болгемоор байгаа бүсгүйг нөгөө хүнд эхнэр болгож ав гэдэг чинь ёстой л хармгүй найз байна даа.

Альбер инээмсэглэв.

- Дахиад хэлэхэд манай хонгор Франц ирж яваа. Та түүнд дургүй байх аа.

- Би юу даа? гэж гүн хэлээд – Эрхэм бэйс уучлаарай, юунаас болоод намайг түүнд дургүй гэх болов? Би бүгдээрэнд нь хайртай.

- Надад ч бас тэр биз дээ...Баярлалаа танд.

- Юмыг хольж хутгахаа больё гэж гүн хэлээд – Бурхны лүндэгнэсээр бол ойр дотныхоо христус шашинтны ёсоор хайрлаж байх учиртай. Харин би зарим нэгийг нь үнэн голоосоо үзэн яддаг. За энэ ч яах вэ, Франц де Эпинегийнхээ тухай эргэж ярья. Та түүнийг удахгүй ирнэ гэв үү? Гэж асуулаа.

- Тийм ээ, түүнийг Втьлфор дуудсан байна билээ. данглар охиноо хүнтэй суулгах гэж байж ядаж байгаагийн адил Вильфор ч бас Валентинаг хүнтэй суулгах гэж байж ядаж байгаа юм байлгүй. Насанд хүрсэн охинтой байна гэдэг амаргүй хэрэг бололтой. Эцэгт нь чичрээ өвчин тусаж, охиноо хүнд өгч салахаас нааш судас нь минутад ерэн удаа цохилж байдаг юм байхаа.

- Гэвч эрхэм де Эпине тантай адилгүй, байдлаа тэвчээртэйгээр даван өнгөрөх хүн.
- Түүгээр ч зогсохгүй. Франц энэ явдлыг бүр чухалд тооцоод байгаа. Цагаан зангиа зүүж, гэр бүл болох нь олон болсон. Түүнээс гадна Вильфорынхныг их л хүндэтгэдэг юм.
- Тэгэх нэ зүйн хэрэг гэж бодож байна, тийм биш үү?
- Вильфор хатуу ширүүн хүн боловч маш шударга хүн бололтой.
- Бурхны аврал. Хөөрхий Дангларын тухай ярьдгаасаа өөрөөр ярьдаг нэг хүн гарч ирж байх чинь гэж гүн хэлэв.
- Би түүний охинтой суух ёсгүй болохоороо тэгж байгаа байж ч магадгүй гэж Альбер инээн хариулахад гүн,
- Эрхэм минь, та ер нь сонин хүн байна шүү гэлээ.
- Би юу даа?
- Тийм ээ, алий вэ, ороомол навчин тамхи аваач.
- Дуртайяа авья. Та намайг яагаад сонин хүн гэж байна?
- Мадмаузел Данглартай суухгүй гэж байдгаараа зүтгэн эсэргүүцэж байгаа болохоор чинь тэгж байгаа юм. та бүх зүйлийг болдгоороо болог гээд л орхичих. Та ч түрүүлж үгнээсээ буцсан хүн болохгүй байж магадгүй шүү дээ.
- Уухайс! гэж Альбер нүдээ бүлтийлгэн хэлэхэд, гүн өөр өнгөөр үргэлжлүүлэн,
- Таны хүчээр аваачаад суулгачихгүй шүү дээ чөтгөр ав. бэйс та ингэхэд Дангларын охинтой суухгүй гэж үнэхээр хүсээд байгаа юм уу? гэж өгүүллээ.
- Үүний тулд би зуун мянган франк ч өгнө.
- Тэгвэл одоо баярлаж явж болно. Данглар мөн таны адил зорилгод хүрэхийн тулд хоёр дахин ихийг төлөхөд бэлэн байгаа.
- Нээрээ юү? Ёстой аз байна даа гэж Альбер хэлсэн боловч царай нь нэг л аягүйрхсэн байртай болоод
- Гэхдээ Данглар шалтгаан байгаа болоод л тэр байх даа? гэв.
- Хувиа бодсон, бардам зан гэдэг энэ дээ! Нэгнийхээ сэтгэлтийг яаж ч хөргөхөөс буцахгүй мөртлөө өөрийн нь хувьд өчүүхэн л эвгүй болоход үг дуу тавиад гардаг.
- За үгүй дээ, зүгээр л Дагларыг...
- Таныг л гэдэг байх ёстой гэж үү? Данглар юмны сайн мууг ялгаж чаддаггүй хүн юм. одоо өөр хүнийг илүүд үзэж хөөргөж байгаа...

- Хэнийг тэр вэ?
- Би мэдэхгүй. Харин та ажиглаж байгаад олж мэдээд өөрийнхөө эрх ашигт зориулаарай.
- За тийм бай. Манай ээж... чухамдаа гэвэл манай аав бүжигт наадам зохиох гэж байгаа.
- Өдийд, зунаар бүжиг наадам зохиох гэж үү?
- Одоо, зунаар бүжигт наадам хийдэг заншилтай болсон юм.
- Тийм заншилтай болоогүй ч байлаа гэсэн, хатагтай хүсвэл л тийм заншилтай болчих байлгүй.
- Муугүй хэллээ. Энэ бол ёстой цэвэр Парисын бүжигт наадам болно. Долдугаар сард Парист үлддэг хүмүүс бол жинхэнэ Парисынхан байдаг юм. та эрхэм Кавалькантид урилга дамжуулж өгөхгүй юү?
- Тэр бүжигт найр чинь хэзээ болох юм бэ?
- Бямба гаригт.
- Тэр үед эцэг кавальканти нь яваад өгсөн байна.
- Гэвч хүү Кавальканти нь үлдэнэ шүү дээ. та түүнийг дагуулж ирэх юм биш үү?
- Бэйс минь би түүнийг огт танихгүй.
- Танихгүй гэнэ ээ?
- Үгүй шүү. Амьдралдаа түүнийг дөрөвхөн хоногийн урьд үзсэн болохоор түүний төлөө би хариуцаж чадахгүй.
- Үгүй та чинь түүнийг хүлээн авдаг шүү дээ.
- Миний хүлээж авах өөр хэрэг. түүнийг өөрөө ч төөрөлдчихсөн байж мэдэх нэгэн хүндтэй лам надтай танилцуулсан юм. харин та нар өөрсдөө түүнийг уривал сайн байна. нада эвгүй байна. тэр хүн гэнэт мадмаузель Данглартай суучихвал та намайг буруутгаж надтай тулалдах гэх байх. Бас тгээд би өөрөө тэр үед байх байхгүйгээ мэдэхгүй байна.
- Хаана?
- Танай бүжигт найран дээр.
- Яагаад тэр вэ?
- Нэгдүгээрт, та намайг одоогоор уриагүй байна.

- Би таныг өөрийн биеэр урих гэж зориуд ирсэн юм шүү дээ..
- Өө энэ бол таны талаас тун найрсаг хэрэг байна. харин би завгүй байж магадгүй.
- Би танд нэгэн зүйлийг хэлэхэд та өөрийн завгүй гэдгийг орхих байх гэж найдаж байна.
- Тэгвэл хэл л дээ.
- Ээж таныг ирээч гэж гуйж байна лээ.
- Хатагтай де Морсер уу? гэж гүн асуугаад цочих шиг болов.
- Ээж надтай илэн далангүй ярьдаг гэдгийг танд хэлчихье. Хэрвээ би танд ярьж байсан сэтгэлийн утас тань хөндөгдөөгүй бол танд тийм нандин сэтгэл гэж байхгүй юм байна гэж бодмоор юм байна. Яагаад гэвэл бид бүтэн дөрвөн өдрийн туршид ганцхан таны л тухай ярьсан.
- Миний тухай юу? Үнэндээ та намайг зовоочихлоо.
- Үүнээс өөр арга алга. Та чий амьд таавар болоод байна шүү дээ.
- Танай ээж намайг үнэхээр таавар болж байгаа хүн гэж байна уу? би түүнийг ингэж бодохооргүй их ухаалаг хүн гэж хэлсэн.
- Тийм ээ гүнтэн, та бүх хүнд, манай ээжид ч гэсэн таавар болоод байна. энэ бол бүхний хүлээн зөвшөөрсөн боловч хэнмч олоогүй байгаа таавар юм. гэхдээ санаа бүү зов, та шийдвэрлэгдээгүй асуудал хэвээрээ үлдэж байна. ээж таныг яагаад ийм залуу байж болох билээ гээд л асуугаад байдаг юм. ээжтаныг хатагтай Г.Лорд Рутвен гэж боддог шиг л Калиостро, эсвэл Сен Жермен гүн бодоод байгаа юм. та хатагтай Морсерта уулзмагцаа л өөрийгөө эдгээрийн аль нэгээр итгүүлэх хэрэгтэй. Та нэгний нь гүн ухааны суурь, нөгөөгийн нь оюун билгийг эзэмшсэн хүн болохоор энэ бол амархан хэрэг.
- Урьчилан хэлж өгсөнд чинь баярлалаа. Би итгүүлэхийг л оролдож үзье гэж гүн инээмсэглэн хэлэв.
- Тэгэхээр та бямба гаригт очих юм шив дээ?
- Хатагтай Морсер ингэж хүсэж байгаа хойно тэгэлгүй яах вэ.
- Энэ бол таны зүгээс их л найрсаг хэрэг.
- Данглар очих уу?
- Өө! Түүнд давхар урилга явуулсан. Энэ үүргийг аав хариуцаж авсан. Бид бас агуу де Агессо¹ болох эрхэм де Вильфорыг байлгахыг хичээнэ. Гэвч найдлага багатай байна.
- Санаж явбал бүтдэг гэсэн зүйр үг бий.

- Гүн та бүжиг хийдэг үү?
- Би юу?
- Тийм ээ, та. Та бүжиг хийдэг байхад гайхалтай нь юу байгаа юм бэ?
- Тийм ээ, нээрээ дөч хүрлээ. Үгүй би бүжиг хийдэггүй. Харин бүжиглэж байгааг харах дуртай. Хатагтай Морсер бүжиг хийдэг үү?
- Бас үгүй. Та хоёр ярьж сууна биз. ээж тантай ярих гээд хүсээд байгаа юм.
- Нээрээ тэглээ гэж үү?
- Нээрээ! Тэгээд бас та бол манай ээжийн ярих гээд хүсээд байгаа ганц хүн нь мөн.

Альбер малгайгаа аваад бослоо. Гүн түүнийг гаргаж өгөхөөр явав.

- Би өөрийгөө зэмлэж байна гэ гүн Альберыг шатан дээр зогсоогоод хэлэв.
 - Юунд тэр билээ?
 - Өөрийн даруу бишид. Би танд Данглары тухай ярих ёсгүй байсан юм.
 - Үгүй түүний тухай улам их, улам олон дандаа ярьж байгаарай. харин энэ л санаагаар ярьж байгаарай.
 - Маш сайн. Та намайг тайвшрууллаа. Далимд нь асуухад де Эпинье хэзээ ирэх вэ?
 - Тав зургаан хоногоос хэтрэхгүй байх гэсэн.
 - Аа хурим нь хэзээ болох вэ?
 - Эрхэм Сен-Меран хатагтайнхаа хамт ирсэн цагт хийнэ гэнэ билээ.
 - Түүнийг ирэхээр манайд дагуулаад ирээрэй. Та намайг хэдийгээр түүнд дургүй гэж хэлэх боловч би түүнтэй уулзахдаа баяртай байна.
 - Эзэнтэн минь! Таны хүсэл биелэгдэх болно.
 - Баяртай.
 - Бямба гаригт заавал шүү дээ, тийм ээ?
 - Тэгэлгүй яах вэ. нэгэнт танд ам өгсөн хойно.
- Гүн Альберыг нүдээрээ дагууоан хараад гараараа даллав. Дараа нь түүнийг тэргэндээ суумагц эргэж Бертуччотой уулзав.
- За яав? Гэж гүн асуув.

- Тэр эмэгтэй шүүх тээр очсон гэж даамал хариу айлтгалаа.
- Тэнд удав уу?
- Цаг хагас байсан.
- Тэгээд дараа нь гэртээ ирээ юү?
- Шууд ирсэн.
- За тэгвэд одоо эрхэм Бертуччо та Норманди уруу явж миний хэлж байсан тэр жижигхэн эдлэн газрыг эрж олохыг зөвлөө гэж гүн хэлэв.

Бертуччо мэхийн ёслоод өөрийн нь хүсэл авсан тушаалтай нь бүрэн нийцэж байсан тул тэр үдэшдээ замд гарчээ.

12.Эрэл

Вильфор хатагтай Дангларт хэлсэн үгэндээ чухамдаа гэвэл өөртөө ам гарсандаа хүрч Монте-Кристо гүн Отейлд болсон явдлыг яаж мэдсэн болохыг хайж эрэхийг оролдлоо.

Вильфор тэр өдөртөө шоронгийн байцаагч байгаад мөрдөгч цагдаагийн тушаалд дэвшсэн Бовил гэгч хүнд захидал бичжээ. Тэр нь хэнээс үнэн магадтай мэдээ авч болохыг мэдэхийн тулд хоёр хоногийн хугацаа өгөхийг хүсчээ.

Хоёр хоногийн дараа Вильфор дараахь захидлыг хүлээн авав.

“Монте-Кристо гүн гэдэг нэртэй тэр хүн, заримдаа Парист ирдэг бөгөөд яг одоо энд сууж байгаа гадаадын нэгэн баян хүн лорд Үилмортой ойрхон танил хүн юм. бас дорно зүгт өөрийн буянай өглөгч явдлаараа алдаршсан сицилийн лам Бузони мөн түүнийг санй мэдэх юм байна” гэжээ.

Вильфор хариуд нь эдгээр гадаад пүүсүүдийн тухай хамгийн үнэн мэдээ цуглуулахыг тушаажээ. Маргааш үдэш нь түүний хүсэл биелэгдэж ийм зүйлийг мэдэв.

Дөнгөж сарын хугацаагаар Парис хотод хүрч ирсэн лам Сен-Сюльпис сүмийн ар талд хоёр давхар байшинд сууж байна. тэр башин бүгд дөрвөн тасалгаатай, хоёр нь дээрээ, хоёр нь доороо байдаг. Лам тэнд ганцаараа суудаг, доод давхар нь самрын модоор хийсэн ширээ сандал, шүүгээтэй хоолны газар, модоор эмжиж цагаан өнгөөр будсан, элдэв янзын чимэглэл хивс ханын цаг байхгүй зочдын өрөө байна. тэгэхээр лам зөвхөн шаардлагатай юмаа хэрэглэдэг нь илэрхий.

Лам хоёрдугаар давхар дахь зочдынхоо өрөөнд цагийг ганцаараа өнгөрөөхийг илүүд үздэг хүн юм. энэ зочдын өрөө буюу номын сан нь шашны ном ба гар бичмэлээр дүүрэн бөгөөд зарим бандийн үгээр бол лам тэндээ бүтэн сараар суучихдаг байна.

Банди нь ирсэн хүнийг хаалганд гаргасан жижиг нүхээр хараад хэрвээ тэр хүн үл таних буюу сэтгэлд нь тавгүй санагдвал эрхэм ламтан Парист байхгүй гэж хариулна. Олонх хүн ламыг үргэлж ийш тийшээ явдгийг заримдаа удаан хугацаагаар байхгүй

байдгийг мэддэг болохоор энэ хариултад сэтгэл ханана. Лам гэртээ байсан ч үгүй ч Парист юм уу Каирт байлаа ч адилхан ядууст заавал туслах агаад, хаалганыхаа нүхээр зарц нь эзнийхээ өмнөөс өглөг буян тасралтгүй тараана.

Номын сангийн дэргэдэх тасалгаа унтлагын өрөө болдог. Хөшиггүй ор, дөрвөн сандал, хилэн бүрээстэй буйдан энэ тасалгааны хэрэглэл болно.

Лорд Уилморын тухайд гэвэл тэр хүн Фонтен Сен Жоржид суудаг юм байна. энэ бол аялал жуулчлалд хамаг мөнгөө үрж дуусгадаг тойрон аялагч англи хүмүүсийн нэг юм. гэрийн тавилгатай байр хөлслөн авч тэндээ өдөрт хоёр гурван цагаас илүү байдаггүй, хааяа нэг хонодог юм байна. түүнийг францаар маш сайхан бичдэг гэж ярилцах боловч франц хэлээр ярихыг эрс татгалздаг хачин зантай хүн юм байна.

Энэ үнэт мэдээнүүдийг вангийн прокурорт өгсөний маргааш нь нэг хүн Феру гудамжны буланд сүйх тэрэгнээс бууж ногоовтор будгаар будсан хаалга цохиж Бузони ламыг сураглав.

- Эрхэм ламтан өглөө гараад ирээгүй байна гэж банди нь хариулав.

- Би, ирэхэд нь хүн бүхэн гэртээ байх ёстой тийм хүний өмнөөс яваа учир ийм хариултад сэтгэл ханахгүй байж болох юм. за яах вэ, та Бузони ламд нэг юм дамжуулж...

- Би түүнийг гэртээ байхгүй гСж хэлсэн шүү дээ гэж зарц давтан хэлэв.

- Тэгвэл түүнийг эргэж Ёрэхээр нь энэ танилцуулах хуудас, дугтуйтай бичшгийг дамжуулж өгөөрэй. Эрхэм ламтай өнөө орой найман цагт уулзаж болох уу?

- Хэрвээ юм хийгээд л суучихгүй бол мэдээжийн хэрэг болно. Харин тэгээд суучихвал гэртээ байхгүйтэй адил гэсэн үг.

- За тэгвэл би орой тогтоосон цагтаа эргэж ирье гэж ирсэн хүн хэлээд яваад өглөө.

Орой нь тэр хүн хэлсэн цагтаа өнөөх сүйх тэргээрээ ирсэн бөгөөд харин энэ удаа Феру гудамжны буланд зогссонгүй, шууд явж ногоон хаалган дээр ирж зогслоо. Тэр хүн хаалга цохиход хаалга нээгдэж орууллаа.

Банди нь их л хүндэтгэсэн шинжтэй байхыг хараад бичиж орхисон захидал зохих сэтгэгдэл төрүүлжээ гэж боджээ.

- Эрхэм лам гэртээ бий юү?

- Бий номын сандаа юм хийж байна. гэхдээ таныг хүлээж байгаа гэж хэлэв.

Үл таних хүн нэлээд эгц шатаар өгсөж гарахад том бүрхүүлтэй дэнгийн хурц гэрэл ширээн дээр тусаж, бусад тал нь сүүдэрт хоцорсон өрөөн дотор дундад зууны үеийн эрдэмтдийн өмсдөг хүзүүгээ бүрхсэн юүдэнтэй ламын хувцас өмссөн хүн ширээний цаана сууж байлаа.

- Эрхэм Бузонитой ярьж байна уу? гэж ирсэн хүн асуув.

Тэгэхэд лам,

- Тийм ээ эрхэм гүн, та цагдаагийн газрын нэрийн өмнөөс хуучин шоронгийн байцаагч байсан эрхэм де Биволийн явуулсан хүн үү? Гэж өөдөөс нь асуув.

- Би мөн эрхэм ээ.

- Парисын цагдаагийн газрын эргүүлчдийн нэг үү?

- Тийм ээ эрхэм ээ гэж ирсэн хүн бага зэрэг тээнэгэлзсэн байдалтай хариулаад царай нь жаахан улайв.

Ла- зөвхөн нүдийг нь биш ба чамархайг нь далдалсан том шилээ засаад дахин сууж орж ирсэн хүнийг суухыг урив.

- За таны хэлэхийг сонсьё гэж ширээт лам маш их итали аялгуутайгаар хэлэхэд ирсэн хүн хэлэхэд нь хэцүү байгаа юм шиг үгээ цэгнэн байж,

- Миний биелүүлэхээр хүлээн авсан үүрэг бол хүлээн авсан хүн ба мөн хандаж байгаа нөгөө хүний аль аль нь цааш задраахгүй гэдэг итгэлтэй байх ёстой зүйл юм гэж хэлэв.

Лам дуугаралгүй мэхэсхийв.

- Эрхэм лам таны гүндүүгүйг манай цагдаагийн газрын дарга сайн мэдэх тул цагдаагийн газраас сонирхож байгаа нэгэн зүйлийг мэдэж авахаар намайг явуулсан юм. тиймээс эрхэм лам та найз тал буюу хувийн ямар нэгэн бодолгүйгээр шударга үнэний шүүхээс нуулгүй бидний сонирхсон зүйлд хариу өгөх байх гэж найдаж байна гэж үл таних хүн хэлэв.

- Хэрвээ та нарын мэдэх гэж байгаа зүйл миний дотоод сэтгэлийг хөндөхөөргүй бол хэлж бололгүй яах вэ. гэвч би лам болохоор ямар нэгэн хүний нүглээ наманчилсан зүйл бол зөвхөн надад ба бурхны үнэн шударга шүүхэд мэдэгдээд зогсохоос биш хүн төрөлхтөний шүүхэд мэдэгдэггүй байдаг юм.

- Өө эрхэм ламтан та санаа бүү зов. Бид ямар боловч таны дотоод сэтгэлийг хөндөхгүй.

Лам энэ үгийг хэлмэгц дэнлүүний бүрхүүлийн хажуу тал дээр дарахад нөгөө тал нь дээш өргөгдөж гэрэл нь ирсэн хүн дээр тусахад ламын нүүр сүүдэрт хоцорлоо.

- Эрхэм та уучлаарай. Энэ хурц гэрэлд нүд гялбаад байна гэж цагдаагийн газраас ирсэн хүн хэлэхэд лам ногоон бүрхүүлийг доош болголоо.

- Эрхэм минь одоо би таны хэлэх үгийг сонсьё. Ирсэн хэргээ хэлнэ үү?

- Би одоо ирсэн хэрэгтээ шилжин оръё. Та Монте-Кристо гүнг таних уу?

- Та Закконе гуайг хэлж байна уу?

- Закконе!.. Түүнийг Монте-Кристо гэдэггүй юм уу?
- Монте-Кристо гэдэг чинь газрын нэр, өөрөөр хэлбэл цохионы нэр болохоос овог нэр биш.
- За яах вэ, ямар нь ч яах вэ. Үг хөөцөлдөхөө больё. Монте-Кристо Закконе хоёр нэг хүн юм бол...
- Яриагүй нэг хүн.
- Закконе гуайн тухай ярилцъя.
- Ярь ярь.
- Би танаас түүнийг таних уу? гэж асуусан.
- Таних танихдаа бүр их сайн танина.
- Тэр чинь юун хүн бэ?
- Мальтийн усан онгоцны баян эзний хүү.
- Тийм ээ, би тэгж дуулсан юм байна. тэгж ярьцгаадаг юм. харин цагдаагийн газар бол “ярьцгаадаг юм” гэдэг үгээр ханагагдахгүйг та мэднэ биз дээ.
- Гэвч “ярьцгаадаг юм” гэдэг маань үнэн юм байвал цагдаагийн газар ч гэсэн бүхний адил хангагдах хэрэгтэй болно доо гэж лам зөөлнөөр инээмсэглэн зөрж хэлэв.
- Та хэлж байгаадаа итгэлтэй байна уу?
- Итгэлтэй байх гэсэн чинь юу гэсэн үг вэ?
- Одоо би таныг үнэн голоосоо ярьж байгаад эргэлзэхгүй. Би зүгээр л таныг үүндээ итгэдэг үү? Гэж асуусан юм.
- Би эцэг Закконег нь таньдаг байсан юм.
- Уухай!
- Би хүүхэд байхдаа онгоцны үйлдвэрийн газар хүүтэй нь нэг биш удаа тоглож байсан юм...
- Түүний гүн хэргэм нь ямар учиртай юм бол?
- Үүнийг худалдаж авч болно шүү дээ.
- Италид ч уу?
- Хаана ч болно шүү дээ.

- Бас түүнийг тун баян гэж ярьцгаах юм...
- Энэ чинь үнэн л дээ. Үнэхээр баян хүн дээ гэж лам хариулав.
- Та хэдий хэрийн бодож байна.
- Жилд зуун тавь, хоёр зуун мянган ливрийн орлоготой гэхэд ирсэн хүн,
- Энэ ч үнэмшмээр юм байна. харин гурав дөрвөн саятай гэж ярих юм билээ.
- Жилд хоёр зуун мянган ливрийн орлого гэдэг чинь яг л дөрвөн саяын хөрөнгө гэсэн үн дээ.
- Үгүй жилд дөрвөн саяын орлоготой гэдэг юм.
- Аа, энэ ч үгүй байх аа.
- Та түүний Монте-Кристо арлыг нь мэдэх үү?
- Мэдэлгүй яах вэ. Палермо, Зом эсвэл Неополиос Франц орохоор тэнгисээр явсан хэн боловч мэднэ. Хөлөг онгоцууд дэргэдүүр нь өнгөрдөг юм.
- Сайхан газар гэж ярьдаг биз?
- Үгүй хадан цохио байдаг юм.
- Гүн яагаад хадан цохио худалдаж авсан юм бол?
- Гүн болох гээд тэр байхгүй юу. италид гүн болохын тулд гүнлэгтэй байх хэрэгтэй байдаг юм.
- Эрхэм Закконегийн залуу үеийн тухай ямар нэг юм сонсоогүй биз?
- Эцгийнх нь үү?
- Үгүй, хүүгийнх нь.
- Чухам энэ талаар итгэлтэй хэлэх юм алга. Яагаад гэвэл би түүнийг залуу байхад нь уулзаж байгаагүй юм.
- Тэр байлдаж байсан уу?
- Цэргийн алба хааж байсан шиг санагдаж байна.
- Ямар цэрэгт?
- Усан цэрэгт.
- Та түүний лам багш нь биш биз?

- Үгүй, эрхэм минь тэр чинь лютерийн шажинтан байх.
- Лютерийн гэнэ ээ?
- Би тийм “байх” гэж хэлж байна. би үүнийг б талж чадахгүй. Францад шашин шүтэх явдал чөлөөтэй гэж бодож явдаг юмсан.
- Тэгэлгүй яах вэ. Бид түүний шашин шүтлэгийг сонирхоолгүй, харин ажил явдлы нь сонирхож байгаа юм. Би цагдаагийн газрын нэрийн өмнөөс түүний тухай юу мэдэж айгаа бүхнээ хэлж өгөхийг хүсэж байна.
- Түүнийг сайн үйл үйлдэгч гэж үздэг юм. Түүнийг дорнодын христосын шашинтангуудад онцгой тус хүргэсэн хэмээн манай гэгээн эцэгш хутагт хамба лам Христийн одонгоор шагнасан юм. Энэ шагналыг зөвхөн өндөр дээд хүмүүст өгдөг юм. Янз бүрийн орны төрийн эзэд ба төрд тус хүргэсэн учир тав зургаан дээд зэргийн одон түүнд бий.
- Тэдгээр одонгоо зүүдэг үү?
- Үгүй, гэвч үүгээрээ бахархаж байдаг юм. Хүн төрөлхтөнд тус хүргэсэн хүмүүст шагнадаг одонгууд нь хүн амьтныг сүйтгэгчдэд өгдөг одонгоос илүү хүндтэй зүйл гэж ярьдаг хүн дээ.
- Тэгвэл энэ эрхэм хүн Кавакер¹ шашны хүн байх нь ээ.
- Чухамхүү тийм. Энэ хүн кавакер боловч өргөн хүрээтэй бүрх хүрэн сюртук өмсдөггүй юм.
- Түүний найз нөхөд гэж бий юу?
- Таних хүн бүгд нь түүний найз нөхөд.
- Тэгвэл түүнд дайсан бий юу?
- Цорын ганц хүн бий.
- Хэн гэдэг хүн бол?
- Лорд Уилмор.
- Тэр хаана байдаг хүн бэ?
- Одоо Парист байгаа.
- Тэр хүн надад түүний тухай мэдээлэл өгч чадах болов уу?
- Маш үнэтэй мэдээ өгнө дөө. Тэр хүн Закконег энэтхэгт байхад бас тэнд байсан юм.
- Хаана суудаг вэ?

- Шоссе де Антенд юм гэнэ лээ. Харин гудамж байшингийн дугаарыг мэдэхгүй.
 - Та энэ англи хүнд дургүй юм аа даа?
 - Закконе бид хоёр сайн явдаг улс. Гэтэл тэр түүнийг тэсвэрлэж яаддаггүй юм. Тимй болохоор жаахан хүйтэн харьцаатай байдаг юм даа.
 - Монте-Кристо гүн өмнө нь Францад ирж байсан болов уу? Эрхэм лам та юу гэж бодож байна?
 - Үгүй, ирж байгаагүй. Үүнийг би сайн мэдэж байна. Францад хэзээ ч ирж байгаагүй учир хагас жилийн өмнө хэрэгтэй баримт мэдээ өгөөч гэж надаас хүссэн юм. Би өөрөө хэзээ Парист очихоо мэдэхгүй байсан учир түүн рүү эрхэм Кавалькантийг явуулсан юм.
 - Андреа юу?
 - Үгүй, Бартоломео, эцгийг нь.
 - Маш сайн хэрэг! Одоо нада ганц юм ас уух үлдээд байна. Харин та нэр төр, шашнаа бодож надад үнэн зөвөөр хариулахыг шаардаж байна.
 - Би таны хэлэхийг сонсьё.
 - Монте-Кристо гүн Отейль дахь байшинг ямар учиртай худалда авсныг нь мэдэх үү?
 - Мэдэлгүй яах вэ, тэр өөрөө надад хэлсэн юм.
 - Яах гэж авсан юм бол?
 - Түшээ гүн Пизани Палермод байгуулсантай адил тийм солирсон хүмүүст зориулсан эинэлгийг байгуулах гэсэн юм гэнэ лээ. Та тэр эмнэлгийг мэдэх үү?
 - Дуулсан л юм байна.
 - Маш сайн байгууллага шүү.
- Лам ингэж хэлээд тасалдсан ажилдаа эргэж ороход, дургүйцэхгүй байгаагаа мэдэгдэх гэсэн хүний ёсоор мэхийн ёслов.
- Ирсэн хүн ламын хүслийг ойлгосон ч юм уу, ауух юмаа дууссан ч юм уу алин боловч бослоо.
- Лам түүнийг хаалаг хүртэл гаргаж өгөв.
- Та өглөг их тараах юм. Та хэдийгээр баян хүн гэгддэг боловч би ядуучуудад зориулж бяцхан зүйл өгөх гэсэн юм. Миний хандивыг хүлээн авн уу? гэж ирсэн хүн хэлэв.

- Эрхэм танд их баярлалаа. Энэ орчлонд чухалчлан Үоддог ганцхан зүйл минь ядуучуудад үзүүлж байгаа тус маань зөвхөн л надаас гарч байгаасай гэдэг хүсэл байгаа юм.

- Гэлээ гэхдээ...

- Энэ болл нугарч өөрчлөгдөшгүй шийдвэр юм. эрхэм та эрвэл олно доо. Баян хүн бүрийн замд өчнөөн ядуус дайралддаг юм.

Лам хаалга онгойлгож дахин ёслов. Ирсэн хүн хариу ёслоод гарч одлоо.

Сүйх тэрэг тэр хүнийг шууд Вильфорын дэргэд аваачив.

Нэг цагийн дараа өнөөх сүйх тэрэг дахин хашаанаас гарч Фонтен Сен Жорж гэдэг гудамжийг чиглэн явж тавдугаар байшингийн дэргэд очлоо. Энд Лорд Уилмор суудаг ажээ.

Үл таних хүн Лорд Уилмортой уулзья гэж бичсэн бөгөөд цаадах нь үдшийн арван цагт ир гэжээ. Цагдаагийн газрын төлөөлөгч арван цагт арван минут дутуу байхад хүрч ирлээ. Тэгэхэд түүнд Лорд цагийг яг баримталдаг болохоор одоогоор иэрээгүй байна. харин яг арван цаг болоход заавал ирнэ гэж хэлжээ.

Ирсэн хүн зочдын өрөөнд хүлээж суув.

Энэ зочдын өрөө хогшилтой тавилгатай байшингийн ердийн зочдын өрөөнөөс ялгагдах юмгүй. Задгай зуухан дээр нь севрийн шинээр үйлдвэрлэсэн хоёр ваар байлаа. Нум барьсан чигаа тэнгэртэй цаг толь, хоёр талд нь нэгэн дээр нь хүнд хөтлүүлсэн Гомер, нөгөдөх дээр нь гуйлга гуйсан Велизарий хоёрыг дүрсэлсэн сийлбэр зураг өлгөжээ. Хар хээтэй улаан цэмбээр бүрхсэн тавилгатай ийм л зочдын өрөө байв.

Энэ өрөө нь цагдаагийн газрын төлөөлөгчид ядарсан нүдэнд зориуд тааруул х гэсэн юм шиг цэнхэр бөмбөлгөө цацарсан зөөлөн гэрлээр гэрэлтүүлжээ.

Арван минут хүлээсний дараа арван цаг болсны мэдэгдэж цаг цохилоо. Цаг таван удаа цохилж байтал хаалга нээгдэж Лорд Уилмор орж ирлээ.

Тэрээр зэгсэн өндөр нуруутай зэгсэн шар сахалтай, маш цагаа царайтай хүн бөгөөд буурал орсон шаргал үстэй байлаа. Цэвэр англи маягаар хувцасласан байв. 1811 онд өмсөж байсан алтан товчтой өндөр захтай хөх цамц, казимир хэмээх хагас ноосон даавуугаар хийсэн цагаан хантааз, бүдүүн ширхэгтэй хөвөн цаасан даавуу өмд өмссөн нь түүнд богиндсон мэт боловч мөн тимий материалаар хийсэн эмжээрийн ачаар өвдгөөс нь дээш үл татна.

Тэр уулзаад хамгийн түрүүнд,

- Эрхэм та намайг Франц хэлээр ярьдаггүй гэдгийг дуулсан уу? гэхэд төлөөлөгч,

- Таныг ямар ч л гэсэн манай хэлээр ярих дургүйг чинь мэднэ гэв.

- Гэхдээ та францаар ярьж болно. Би ярьдаггүй ч гэсэн оялгоно гэж Лорд хэлэв.
- Би ч гэсэн ярилцаад байхуйцаар англи хэл мэднэ. Эрхэм та зоволтгүй ярьж болно гэж ирсэн хүн өөр хэлээр хэллээ.
- Өө, гэж лорд зөвхөн цэвэр англи хүмүүст байдаг аялгуугаар дуугарлаа.

Цагдаагийн төлөөлөгч өөрийн итгэмжлэх захидлыг лордод өгөв. Цаадах нь энэ захидлыг үнэнхүү английн хайхрамжгүй байдлаар уншаад англиар,

- Би ойлгож байна. сайн ойлгож банья гэлээ.

Тэгэхэд ирсэн хүн асуултаа асууж гарлаа.

Тэдгээр асуулт нь лам Бузониос асуусан асуулттай бараг адил байв. Харин лорд Уилмор Монте-Кристо гүнд дургүй болохоор лам шиг болгоомжлолгүй илүү тодорхой хариулав. Тэр түүнд гүнгийн залуу насны тухай арван настай байхдаа английн эсэрг байлдаж байсан энэтхэгийн нэгэн бага шиг ноён албанд орсныг ярив. тэнд лорд тэр хоёр дайралдаж бие биеийн эсрэг байлдсан ажээ. Энэ тулалдааны үед Закконе олзлогдож англид хүргэгдсэн боловч тэндээсээ усаар зугтаж алга болсон байна. Үүнээс хойш түүний жуулчлал, халз тулалдаан, янаг амрагийн явдлууд эхэлсэн ажээ. Грегт бослого гарахад грегийн талд оржээ. Энд албан хааж байхдаа Фессалийн уулнаас мөнгөний уурхай олж энэ нээлтийнхээ тухай хэнд ч хэлсэнгүй. Наварины дараа, грегийн засгийг батжин бэхжих үед Оттон вангаас уурхай гаргах зөвшөөрөл гуйж эрхээ олж авчээ. тэгж хэмжээлшгүй их хөрөнгөтэй болсон гэнэ. Лордын үгээр бол түүний баялаг жилдээ нэгээс хоёр саяын орлого оруулдаг бөгөөд тэгэхдээ уурхай нь шавхагдаж дуусвал бас баялаг нь дуусчихаж мэдэх ажээ.

- Тэр францад яах гэж ирснийг та мэдэх үү? Гэж ирсэн хүн асуухад лорд,
- Тэр төмөр замын барилгаас ашиг хонжоо олох, түүнээс гадна туршлагатай химич, физикч хүн болохоор шинэ маягийн цахилгаан мэдээний хэрэгсэл зохион түүнийгээ ашиглалтанд оруулахыг хүсэж байгаа юм гэв.
- Тэр барагцаалбал жилд хичнээн мөнгө зарцуулдаг бол?
- Тав зургаан зуун мянгаас илүүгүй. Нарийн хүн байгаа юм гэж лорд хэлэв.

Англи хүн түүнийг үзэн яддаг болохоор гүнг зэмлэх юмаа олж чадахгүй ядахдаа харамч, нарийнд нь хүрлээ.

- Отейль дахь байшингийн нь тухай ямар нэгэн юм дуулаагүй биз?
- Мэдэлгүй яах вэ.
- Та юу мэддэг юм бэ?
- Яах гэж тэр байшинг худалдан авсан юм бол гэж асуусан байх аа?
- Тийм ээ.

- Гүн бол дамын наймаачин хүн. Тэгэхээр өөрийнхөө туршлага ба хоосон төлөвлөгөөн дээр хоосрох нь гарцаагүй. Худалдаж авсан байшингийнхаа ойролцоо Баньер де Люзон ба Котрийн рашаантай өрсөлдөж чадахуйц тийм рашаан ус бий гэдэг юм. тэгээд энэ байшингаа германуудын хэлдгээр Ba de Haus байгуулах юм гэнэ билээ. тийм учраас тэр өөрийн цэцэрлэгийг гурван удаа ухаж үзсэн боловч юу ч олоогүй. Аягүй бол удахгүй тэр хавийнхаа бүх байшинг худалдан авна даа. би түүнд дургүй болохоор түүнийг төмөр зам, цахилгаан мэдээний газар, эсвэл тэр уснаасаа болж хоосорно гэж бодож байна. би түүнийг эрт орой алин боловч тохиолдох уналтыг нь үзэж сэтгэл тэнийх гэж газар бүр дагаж явдаг юм.

- Та яагаад түүнд дургүй болсон юм бэ?

- Тэр англичид байхдаа миний нэгэн эхнэрийн найзыг үймүүлсэн болохоор тэгж дургүйцдэг юм.

- Та түүнд дургүй юм бол өшөө авах гэж яагаад оролдоггүй юм бэ?

- Би гурван удаа гүнтэй үзэлцсэн, эхлээд гар буугаар, дараа нь сэлмээр, сүүлд нь туялзуур жадаар үзэлцсэн.

- Тулалдааны үр дүн нь юу болсон бэ?

- Эхний удаад өрөөсөн гарыг минь шархдуулсан, дааа нь уушги руу минь хатгасан, сүүлд нь намайг ингэж шархдуулсан гээд англи хүн чихээ хүрсэн өндөр цамцныхаа захыг эргүүлэн соруй үзүүлэв. Тэр нь төдий л удаагүй шархны шинжтэй байлаа.

- Иймээс би түүнд маш их хорсож явдаг юм гэж англи хүн хэлээд – Миний гараас өөр хүний гарт үхэхгүй дээ гэж нэмж хэлэхэд төлөөлөгч,

- Тэр болтол хол ч байх даа гэв.

- Өө, би өдөр бүр буудлагын газар очиж сургууль хийдэг. Гризье бас нэг өнжөөд над дээр ирдэг гэж хэлэв.

Ирсэн хүн энийг л дуулах хэрэгтэй байлаа. Тэгээд бас англи хүний мэдэж байгаа бүх зүйл нв ч байсан аж. Тэгээд төлөөлөгч босож лордод мэхийн ёслоход цаадах нь цэвэр англичуудын хүйтэн ёсоор хариу барив. Тэгээд төлөөлөгч гарч одлоо.

Харин лорд түүнийг гарсны дараа хаалга хаагдахыг сонсомогц, унтлагын өрөөнд орж нүд ирмэхийн зуур цайвар үс, шаргал хууз сахал, хиймэл эрүү ба шархны сорвио авч хаян, хуучин хар үс зөөлөн цагаан царайтай сувд мэт шүдтэй Монте-Кристо гүн болж хувирав.

Үнэндээ эрхэм деВилфорын гэрь цагдаагийн газрын төлөөлөгч биш Вильфор биеэрээ буцаж иржээ.

Эрхэм де Вильфор хэдийгээр тайвширмаар гойд юм дуулаагүй боловч, бас сэтгэл түгшиж сандармаар юм дуулаагүй тул энэ уулзалт вангийн прокурорыг нэлээд тайвшруулаа.

Үүнийхээ ачаар Отейльд хоол зооглосноос хойш анх удаа их бага ямар ч гэсэн энэ шөнийг тайван нойрсож өнгөрүүлжээ.

13. Зуны бүжигт наадам

Зургадугаар сарын хамгийн халуун өдрүүд болж байлаа. Морсерын бүжигт наадам хийхээр тогтоосон буямба гариг цагийн урсгалаар хүрч ирлээ.

Үдшийн арван цаг бол! байв. Саяхан арилсан аадар бор@оны эцсийн үүл хөвөн хөөрч, олон мичид гялалзаж байгаа хөх тэнгэрийн өнгөн дээр гүнгийн цэцэрлэгийн том моддын дүр тодхон харагдана.

Хос хосоороо вальс бүжиг эргэлдэн байгаа хүмүүсийн дуу, хөгжмийн аялгуу доод двхрын тасалгаанаас сонстож, цонхны хаалтын завсраар хурц гэрэл зурайн тусна.

Тэнгэр цэлмэж байгаад сэтгэл нь амарсан гэрийн эзэгтэйн тушаал авсан арваад зарц оройн хоолны ширээг цэцэрлэг дотор засах гэж чармайн байв.

Оройн хоолыг хоолны өрөөнд өгөх үү эсвэл цэцэрлэг дотор ногоон зүлгэн дээр сүүдрэвч доор зассан ширээн дээр өгөх үү гэдэг нь хүртэл тодорхойгүй байсан ажээ. Одон мичид улам улам түргэн яралзаж байсан хөх тэнгэр уг асуудлыг цэцэрлэгийн талд ашигтайгаар шйдвэрлэжээ.

Цэцэрлэгийн моддын хоорондох замын дагуу италийн заншлаар өнгө бүрийн дэнлүү асааж, ширээ замсах урлагийг бага боловч ойлгодог улс орны заншлаар оройн хоолонд зориулж зассан ширээгээ янз бүрийн цэцэг ба лаагаар гоёж чимжээ. Гүйцэд сайхан засаж бэлтгэсэн ширээ, бусад зүйлээс цөөн тохиолддог юм.

Хатагтай Морсер тушаал шйдвэрээ өгчихөөд зочбдынхоо өрөөнд эргэж ирэх үед зочид улам олширсон байлаа. Тэднийг гүнгийн өндөр цол хэргэмийн адил хатагтайн гайхамшигтайгаар зочлох явдал дуудан авчирчээ. Мерседес юмыг явал сайхан болдгийг мэддэгийн ачаар бүжиг наадмын тухай дараа нь ярих юмтай тэр ч байтугай дуурайх юм олон гарна Жэдэгт итгэлтэй байлаа.

Бидний дээр өгүүлсэн хэрSг явдлаас болж сэтгэл түгшсэн хатагтай Данглар хатагтай Морсерынд очих эсэхээ шйдэж ядан тээнэгэлзэж байв. Гэтэл өглөө нь түүний сүйх тэрэг Вильфорын сүйх тэрэгтэй дайралджээ. Вильфор дохио өгөхөд сүйх тэрэгнүүд бие биедээ дөхөн ирж вангийн прокурор цон уруугаа бөхийн,

- Та хатагтай Морсерынд очих уу? гэхэд,

- Үгүй, миний бие муу байна гэж хариуллаа.

- Тусгүй л хэрэг байна даа гэж Вильфор дуугарахдаа их л жоготойхон харж – Таныг тэнд байхыг улс амьтан харвал маш чухал байсан юм сан гэж хэлэхэд,

- Та тэгж бодож байна уу? гэж хатагтай асуулаа.

- Би бүр түүнийг зүйтэй гэж үзэж байна.

- Тэгвэл би очъё л доо.

Тэгээд сүйх тэрэгнүүд хоёр тийшээ салж явлаа. Хатагтай Данглар зөвхөн өөрийн төрөлхийн сайхан царайгаа биш, бас үзэсгэлэн гоо хувцсаа гялалзуулсаар бүжиг наадамд орж ирлээ. Мерседесийг нөгөө хаалгаар орж ирэхэд хатагтай Данглар орж ирлээ.

Гүнгийн авгай хатагтай Данглар уруу хүүгээ угтуулан явуулав. Альбер хатагтайд дөхөн очоод түүний засал чимгийг сайшаасан хэдэн үг хэлж тал засаад, очих гэсэн газарт нь хүргэж өгөхөөр гараа өглөө.

Энэ үед Альбер хэн нэгнийг эрсэн мэт харлаа.

Тэгэхэд хатагтай Данглар инээмсэглэн,

- Та манай охиныг хайгаа юу? гэж асуув.

- Нэрэлхээд ч яах вэ, тийм шүү. Та түүнийг дагуулаад ирэхээргүй хатуу сэтгэл гаргалаа гэж үү? хэмээхээ,

- Бүү зов. Охин маань Вильфор»н охинтой дайралдаад түүнтэй явсан. Бидний араасирж яваа, хоёулаа цагаан дашинзтай, нэг нь уулын цайн цэцэг, нөгөө нь дурсгал цэцэг барьж ваа. Харин ингэхэд...

- Та ч гэсэн ямар нэг юм эрээд байх шиг? гэж Альбер инээмсэглэн асуулаа.

- Монте-Кристо гүн ирэхгүй юм гэж үү?

- Арван долоо.

- Энэ чинь юу гэсэн үг вэ?

- Та ийм асуулт асуусан арван долоо дахь хүн нь болж байна. гүн азтай хүн юм. түүнд баяр хүргэж болно... гэж бэйс хэлэв.

- Та хүн бүхэнд л надад хэлж байгаа шиг ээ хариулдаг уу?

- Өө нээрээ би танд хариулаагүй юм байна шүү. Тэр чухаг хүн манайд ирж хайрлана.

- Та санаа зоволтгүй.

- Өчигдөр та дуурийн театрт очсон уу?

- Үгүй шүү.

- Тэр тэнд байсан.

- Уухай бас л нэг гоц гойд сэтгэл төрүүлээ биз дээ?

- Тэр тийм сэтгэгдэл төрүүлж явж чаддаг юм гэж үү? Эльслер “Долоон чөтгөр” бүжиглэсэн. Өнөө албани гүнж бүр баярлачихсан байна билээ. тэгээд испани бүжгийн дараа гүн тэр гайхам бүжигчинд цэцгийн цоморлиг маш сайхан бөгж шигтгээд шидэж өгсөн. Бүжигчин бүсгүй баярласны тэмдэг болгож тэр бөгжийг гуравдугаар үзэгдэл дээр зүүгээд гарч ирсэн. Тнгэхэд түүний Албани гүнж хамт ирэх үү?

- Үгүй, өнөөдөр танд түүнийг харах аз дутжээ. Гүнгийн гэрт тэр бүсгүй ямар байдалтай байдаг нь төдий л тодорхой биш байна.

- Намайг эндээ орхиод хатагтай Вильфортой мэндэлчхээд ир. Цадах чинь тантай ярих гэхээс байж сууж чадахгүй байна гэж хатагтай хэлэв.

Альбер хатагтай Дангларт мэхийн ёслоод тэртээ холоос ярих гэж бэлтгэж байгаа хатаглай Втльфор өөд явлаа.

- Та юу хэлэх гэж байгааг чинь би мэдэж байна. Хоёулаа мөрийцэх үү?

- Нээрээ юү?

- Хэрвээ намайг таачихвал та үнэнээр нь зөвшөөрөх үү?

- Тэгнэ.

- Бүр үнэн үү?

- Бүр үнэн.

- Та Монте-Кристо гүнг энд ирсэн үү эсвэл ирэх үү гэж асуух гэж байгаа.

- Огт үгүй. Одоо би түүнээс өөр юм сонирхож байна. харин би Францаас сураг чимээ байна уу? гэж танаас асуух гэсэн юм.

- Байна. Өчигдөр түүнээс захидал авсан.

- Танд юу гэж бичээ бол?

- Захидалтайгаа зэрэг гарна гэж бичсэн байна лээ.

- Маш сайн байна. харин одоо гүнгийн тухай ярья.

- Бүү зов. Гүн ирнэ.

- Та түүнийг Монте-Кристо гэдгээс өөр нэртэйг нь мэдэх үү?

- Үгүй, би мэдэхгүй.

- Монте-Кристо гэдэг чинь арлын нэр. Түүнээс гадна түүний овог бас байна.

- Би овгийг нь огт дуулаагүй.

- Тэгвэл би танаас илүү юм мэдэж байгааё юм байна. түүнийг Закконе гэдэг юм.
 - Магадгүй.
 - Мальт хүн гэнэ.
 - Тийм ч байж магадгүй дээ.
 - Хөлөг онгоцны эзний хүү гэнэ.
 - Та үүнийгээ олонд дуулдахаар хэлбэо танд их л амжилт олно доо.
 - Тэр энэтхэгт албан хааж байгаад Фелласид мөнгөний уурхай олж гаргаад, одоо Парист ирж, Отейльд рашаан усны газар байгуулах гэж байгаа юм.
 - Үнэхэрийн шинэ сонин зүйл байна. харин хүн амьтанд хэлбэл зөвшөөрөх үү? Гэж Морсер асуув.
 - Бүгди©г нь зэрэг хэлчихгүй, бага багаар нь хэлээрэй. Харин намйаг ярьсан гэж хэлж болохгүй шүү.
 - Яагаад?
 - Яагаад гэвэл би бараг хулгайгаар чагнаж дуулсан зүйл байгаа юм.
 - Хэний нууц юм бэ?
 - Цагдаагийн газрын.
 - Тэгвэл энэ тухай яриа болсон юм байх нь ээ...
 - Өчигдөр орой цагдаагинхан тэгж ярьж байна билээ. энэ ер бишийн гоо сайхныг Парисынхан хараад сэтгэл нь хөдөлснийг та мэдэж байгаа шүү дээ. тэгээд л цагдаагийн газар мэдэж авсан хэрэг.
 - Тэгэлгүй яах вэ! Ийм хэтэрхий баян хүн тэнүүчилж явна гээд бариад авах нь дутаад байх шив.
 - Ийм гэм халгүй мэдээ биш байсан бол ч бариад авчихаж болох л байсан юм.
 - Хөөрхий гүн! Тэр өөрөө энэхүү заналхийлж байгаа аюулыг мэдсэн болов уу?
 - Үгүй байх гэж бодож байна.
 - Тэгвэл түүнд хэлж болгоомжлуулах хэрэгтэй юм байна. чи ирмэгц нь заавал хэлнэ.
- Энэ үед хар үстэй сэргэлэн нүдтэй сайхан залуу тэдэн дээр ирж, хатагтай Вильфорыг хүндэтгэн мэхэсхийн ёслов.

Альбер түүнтэй гар барьж,

- Хатагтай минь манай алдарт офицеруудын гол нь баатар офицеруудын нэгэн болох морин цэргийн ахмад Максимилиан Моррелийг тантай танилцуулахыг зөвшөөрнө үү гэв.

- Отейльд, гүнгийн эрхэм Моррельтай танилцсан гэж хатагтай хэлээд, илтэд хүйтэн байдлаар эргэв.

Энэ хариу, ялангуяа хэлсэн өнгө нь хөөрхий Моррелийн зүрхийг шишрүүлэв. Гэвч шагнад хүртэх аз түүнд байжээ. Түүнийг эргэтэл цагаан даашинзтай залуу бүсгүй үүдэнд зогсож байв. Бүсгүйн том боловч юу ч үл илэрхийлэх нүд нь Моррель өөд чиглэжээ. Тэгээд бүсгүй барьж явсан цэцгээ уруулдаа алгуурхан хүргэв.

Моррель энэ мэдчилгээг ойлгож мөн тийм байдлаар алчуурдаа уруулаа хүргэв. Тасалгааны уудам зайгаар таслагдсан энэ гантиг чулуу мэт хүйтэн царайтай хоёр амьд баримлын зүрхний нь цохилт түргэсэж, энэхүү нам гүмийн дунд орчин тойрны бүх зүйлийг эгшин зуурын дотор мартжээ.

Тэр хоёр бие биеэ ширтэн удаан зогсох байсан боловч тэр үед Монте-Кристо гүн орж ирлээ.

Хиймэл төрөлхийн алин боловч сэтгэлийг татан нөлөөлөх байдлаараа бүхний анхаарлыг татдаг байсныг бид дээр өгүүлсэн билээ. одон тэмдэггүй энгийн боловч өөгүй сайхан хийцтэй хувцас нь элдэв хатгамалгүй цагаан хантааз нь тэгш шулуун хөлд нь тохирсон өмд нь хүний анхаарлыг татдаг юм биш ээ. түүний царайн цайвар өнгө, долгиотсон хар үс, тайван нүдэнд дулан царай, ухаалаг боловч уйтгартай харц, бас түүний дургүйцсэнээ гарган хялбархан мөшийдөг уруул ам нь олны харцыг татах ажээ.

Түүнээс гоо сайхан эрэгтэйчүүд байх боловч, хэрвээ тэгж хэлж болох бол тэдний хэн ч ийм үлэмжийн төгөлдөр харагдахгүй байв. Байгаа байдал нь оюун ухаан гүн бодлыг нь илэрхийлэн харуулж, үргэлж ухаан бодлоо цэгцэлж явдаг нь харцанд нь, үл ялих хөдөлгөө нь ч болов зүйрлэшгүй тод томруун ирдэр ажээ.

Хэрвээ хэмжээ хязгааргүй баялгийн нь өнгөнд далдлагдсан ямар нэг битүүлэг нууц байгаагүйсэн бол манай Парисынхан энэ Үүхнийг олж харахгүй байлаа.

Хэдий тийм боловч гүн сонирхсон олон хүний харцанд ба түргэн дуурын мэндчилэлийн доор хатагтай МорсГрыг чиглэн очив. Хатагтай дээр нь цэцэг овоолон задгай зуухны өмнө зогсож байхдаа үүдний өөдөөс харуулан тавьсан толинд түүний орж ирэхийг хараад тосож уулзахаар бэлтгэв.

Тийм учраас өмнөө ирж хүндэтгэн ёслоход түүн өөд эргэн харж биеэ барьсан янзтай инээмсэглэв.

Хатагтай гүнг өөртэйгээ эхэлж дуугарна гэж бодсон бололтой. Гэтэл гүн бас түүнийг өөртөө ямар нэгэн юм хэлэх байх гэж боджээ. Хоёулаа тийм үед ямар нэг ёс болсон илүү үг бие биедээ хэлэх нь зохимжгүй гэж үзсэн бололтой дуугүй өнгөрлөө. Монте-Кристо хатагтайтай мэндэлчихээд гараа сунган ирсэн Альбер өөд очлоо.

- Та хатагтай Морсертай уулзав уу? гэж Альбер асуухад,

- Би дөнгөж сая түүнтэй мэндэллээ. Харин аавтай чинь дайралдсангүй гэж хэлэв.
- Аав тэр байна, харж байна уу? Нэрт хүмүүсийн цомхон хэсэг дунд улс төрийн бодлогын тухай ярилцаж байна.
- Эдгээр эрхмүүд цөмөөрөө нэрт хүмүүс юм гэж үү? Би мэдсэнгүй шүү! Юугаараа нэр төрийг улс юм бэ? Төрөл бүрийн салбарт алдар хүнд байдаг шүү дээ.
- Тэр өндөр туранхай нь эрдэмтэн. Тэр хүн Ром хотын ойролцоогоос бусдаасаа нэг нурууны үе илүү хонин гүрвэл олжээ. Тэгээд энэ нээлтийнхээ тухай шинжлэх уханы академид илтгэл тавьсан юм. энэ мэндэгдлийн тухай удаан хугацаагаар маргалдсан боловч эцэст нь энэ хүн дийлсэн юм. тэр нээлт нь эрдэмтийн дотроо их л шуугиан дэгдээсэн. Энэ өндөр туранхай хүн зөвхөн л Хүндэт легионы одон тэмдэгтэй басан бол одоо офицерын хирээстэй болсон.
- Аргагүй, зүй ёсны шагнал байна. харин дахиад нэг нуруу олчихвол түүнийг жанжин ч болгочхож магадгүй юм аа? гэхэд, Альбер,
- Тун ч боломжтой хэрэг шүү.
- Аа, тэр хачин ногоон эмжээртэй хөх хувцас өмссөн хүн чинь хэн гэгч билээ?
- Тэр өөрөө гоёх гэж ийм хувцас хийлгэж өмссөн юм биш. Улсын л буруу байгаа юм. Бүгд Найрамдах Улс гоё сайхны учрыг мэддэг болохоороо академич эрдэмтдэд ямбаны хувцас хийлгэж өгөх гэж Давидаар загвар зуруулсан нь тэр.
- Уухай, тэгвэл энэ хүн чинь академич хүн байх нь уу?
- Эрдэмтэн эрчүүдийн тоонд ороод бүтэн долоо хоноод байна.
- Түүний гавьяа нь мэргэжил нь юу юм бэ?
- Мэргэжил ий? Тэр чандагануудын толгойд зүү хатгаж тахиануудыг улаан будгийн цэцгээр хооллож халимын сахлаар нохойн нугасыг суга татдаг гэсэн байх аа.
- Тэгээд л академийн гишүүн болсон хэрэг үү?
- Францын академийн гишүүн.
- Францын академи ямар хамаатай юм бэ?
- Би танд одоохон тайлбээрлаад өгье. Улсын ярих нь...
- Энэ хүний хийсэн туршлага шинжлэх ухааныг урагш нь хүчтэй хөгжүүлсэн байх.
- Үгүй, их сайхан бичдэг л юм гэнэ лээ.
- Тэр лав толгойд нь зүү шаадаг чандага, ясыг нь улаанаар будаж байгаа тахиа ба нугасыг нь сугалдаг нохойнууддаа их тал засдаг байлгүй.

Альбер инээд алдлаа.

- Аа тэр нь? Гэж гүн асуув.

- Аль вэ?

- Наад талаасаа гурав дахь нь.

- Тэр мөх цэнхэр хувцастай нь уу?

- Тийм ээ.

- манай аавын түнш байгаа юм. тэр саяхан тайж нарын танхимын гишүүдэд ямбаны хувцас олгохын эсрэг их л ширүүн шүүмжилсэн. Энэ асуудлын талаар хэлсэн үг нт их амжилт олсон. Энэ хүн либерал хэвэлэлүүдтэй харьцаа муутай байсан боловч, ордныхны бодлогын эсрэг түүний сайн санааны эсэргүүцэл нь тэдэнтэй эвлэрүүлсэн юм. одоо түүнийг элчин сайдаар томилох байх гэж ярьцгааж байна лээ.

- Тайж болохоор юу хийсэн юм бэ?

- Хоёр гурван инээдмитйн дуурь бичсэн, “Эрин зууны” сонины хэдэн мөнгөн тэмдэгтэй бөгөөд яамны төлөө тав, зургаан жил саналаа өгсөн юм.

- Бэйс! Догь хэрэг байна даа! гээд гүн инээснээ – Та тун гайхам сайхан тайлбарлагч хүн юм даа. харин би одоо танаас нэг зүйлийг хүсье гэв.

- Ямар зүйл тэр вэ?

- Та намайг энэ эрхмүүдтэй битгий танилцуулаарай. Хэрвээ өөрсдөө танилцах гэвэл урьтаад надад мэдэгдэж үзээрэй.

Энэ үеп гүнгийн гарт нэг хүн хүрэх шиг болоход эргээд харвал Данглар байлаа.

- Та яагаад намайг түшээ гүн гэж байнаа юм бэ? Би өөрийнхөө хэгэмийг юманд боддоггүйг та мэднэ шүү дээ. харин бэйс та бол өөр хэрэг, та энэ хэргэмээ хайрлан хүндэтгэж явдаг, тийм биз дээ? гэхэд нь Альбер,

- Мэдээж хэрэг. би бэйс байхаа л больчихвол юу ч биш амьтан болж хувирна. Харин та бол түшээ гүн хэргэмгүй боллоо гэхэд саятан хэвээр үлдэнэ шүү дэ гэхэд Данглар,

- Энэ бол долоон саырн хэмжээгүй эрхт засгийн үеийн хамгийн шилдэг цол нь байх гэж би боддог гэв.

Тэгэхэд Монте-Кристо,

- Сая хөрөнгөтэй гэдэг бол түшээ гүн, францын тайж, академич гэдэг шиг бүх амьдралын цол биш нь харамсалтай. Баримт нотолгоо нь гэвэл тун саяхан франкфуртын саятан Франк, Пульман хоёр дампуурсан шүү дээ гэлээ.

- Тэгсэн үү? Гэж Данглар хэлээд царай нь зэвхийрлээ.

- Тийм ээ, орой нада энэ мэдээг элч хүргэж ирсэн. Тэдний банкинд миний сая шахам франк байсан боловч, цаг алдалгүй мэдэж сарын урьд нэхэж авсан юм.

- Ай чөтгөр гэж. тэд надад хоёр зуун мянган франкийн баримт гуйвуулж ирүүлсэн байна билээ гэж Данглар хэлэв.

- Та одоо мэдчихлээ шүү дээ. тэдний гарын үсэг таван хувийн үнэтэй.

- Тийм ээ, мэдсэн ч гэсэн дэндүү оройтож, би тэдний баримтаар мөнгө төлчихсөн гэж Дангларын хэлэхэд гүн,

- За тэгэхээр дахиад хоёр зуун мянган франк гэтэл Данглар түүний яриаг тасалж,

- Чишш! Энэ тухай бүү ярь... ялангуяа Кавалькантийн дэргэд бүү яриарай гэж гүнд хэлээд, холгүй зогсож байсан залуу хүү өөд эргэж харав.

Альбер ээжтэйгээ ярилцах гээд гүнг орхин явав.

Данглар хүү Кавалькантитай мэндлэхээр түүний бас орхин явав. Гүн нэгэн зуур ганцаараа хоцорлоо.

Энэ завсар тэсвэрлэхийн аргагүй улам бүгчим боллоо.

Зарц нар тавиур дээр жимс, мөхөөлдөс тавьж тараан өгнө.

Гүн хөлөрч чийг даасан нүүрээ алчуураараа арчаад, тавиуртай сэрүүцүүлэх ундааг дэргэд нь авч ирэхэд авахгүй ухасхийн зайлж байв.

Хатагтай Морсер гүнг нэг ч минут хараанаасаа алдсангүй. Түүний хажуугаар тавиуртай юм барьж өнгөрөхөд юу ч авахгүй байгааг нь харжээ. Тэр ч байтугай хойшоо ухарч байгааг нь ажиглав.

- Альбер, чи нэг юм анхааран ажиглав уу? гэж хатагтай хүүгээсээ асуув.

- Юу тэр вэ?

- Эцгийг чинь зоогонд урихад гүн нэг ч удаа ризээгүй шүү дээ.

- Тийм л дээ. тэгэхдээ над дээр ирж өглөөний зоог зооглосон шүү дээ. Үүгээр гүн дээдсийн хүрээлэнд орсон юм.

- Чиний тэр чинь Морсер гүнгийнх биш шүү дээ. Би түүнийг энд орж ирснээс нь хойш хараад л байгаа юм гэж хатагтай шивгэнэв.

- Тэгээд яав?

- Тэр одоо хүртэл юунд ч хүрсэнгүй.

- Гүн хоол ундны талд их хямсгар хүн байгаа юм.

Мерседес гунигтай байдлаар инээмсэглэв.

- Чи түүний дэргэд очоод тавиуртай юмнаас ямар нэг юм авахуулаач

- Ээж ээ, тэгж яах юм бэ?

- Альбер хүү минь, миний хүссэнийг гүйцэтгэ гэж Мерседес хэлэхэд Альбер, ээжийнхээ гарыг үнэсээд, гүн дээр очлоо.

Тэдний дэргэдүүр тавиуртай юм авч өнгөрөхд Альбер гүнг их л шаргуу зочилж, тэр ч байтугай дийтэй мөхөлдөс хүртэл авчирч өгөхөд цаадах нь эрс татгалзаж байхыг хатагтай Морсер харжээ.

Альбер ээж дээрээ эргэж ирэхэд хатагтай царай маш цонхигор байв.

- За чи, татгалзаж байгааг нь харав уу гэж хатагтай хэлэв.

- Тийм байна. Харин та эннүнд юунд нь зовсон юм бэ?

- Альбер хүү минь, эмэгтэй улс гэдэг чинь хачин амьтад байдаг юм шүү дээ. миний гэр анар жимсний ганц үр ч болсон идвэл надад сайхан санагдах болно. Ингэхэд франц зууш сэтгэлд нь тохирохгүй ямар нэгэн өөр зуушанд дуртай байж болох юм даа.

- Үгүй дээ, Италид байхдаа юу ч хамаагүй иддэг байсан юм. харин өнөөдөр бие нь л муу байгаа юм байлгүй.

- Эсвэл бүх л амьдралынхаа туршид халуун дулаан оронд байсан болохоор бидэн шиг халууцаж зовохгүй байгаа юм болов уу даа? гэж хатагтай хэлэв.

- Үгүй байх. Тэр түрүүн бүгчиа байна, цонхоо онгойлгож болсон юм чинь, цонхныхоо хаалгыг онгойлгож болохгүй яасан юм бэ гэж байна билээ.

- Үнэндээ түүний зориуд татгалзаж байгаа эсэхийг шалгах нэг арга байгаа юм байна шүү гэж Мерседес хэлээд зочдын өрөөнөөс гарч одлоо

Минутын дараа цонхны хаалтууд нээгдэж цонхныхоо өмнө ургасан моддын завсраар дэнгийн гэрэлд гийгүүлэгдсэн цэцэрлэг дэх саравчин доор зассан ширээг харж болох болов.

Бүжиглэж байсан эрэгтэй эмэгтэй хүмүүс, тоглуж ярьж байсан хүмүүс тасалгаанд орж ирсэн сэрүүн цэвэр агаарыг цээж дүүрэн амьсгалж баярлалдан хашхиралдав.

Энэ үед Мерседес урьдынхаасаа улам ч цонхигор царайтай боловч эрс шийдмэг байдалтай болчихсон орж ирлээ. Тэгээд хатагтай нөхрийнхөө хүрээлэн байгаа хүмүүс рүү шууд очиж,

- Гүн та зочдоо битгий энд бариад байгаарай. Хэрвээ хөзөр тоглоогүй бол тасалгаанд ыүгчим байснаас цэцэрлэгт орж цэвэр агаар амьсгалб л дээр баймаар юм.

Тэгэхэд 1809 онд “Сири уруу явцгаая” гэж дуулж явсан гоёмсог хөгшин генерал,

- Хатагтай минь, бид дангаараа цэцэрлэгт очихгүй шүү дээ гэж хэлэв.

- За яах вэ тэгвэл би та нарт үлгэр жишээ үзүүлье гээд эргэн харж Монте-Кристо гүнд,

- Та надад түшиг болж хамт гарахгүйсэн болов уу? гэв.

Гүн энгийн энэ үгийг дуулаад хөл нь гуйвах дөхлөө. Тэгээд Мерседесийг ширтэн харав. Энэ явдал эгшин зуурын дотор болсон авч, хатагтайд өчнөөн удсан мэт санагдаж, гүн ч харцандаа өчнөөн их санаа бодол, учир утгыг гаргажээ.

Гүн хатагтайд гараа өгч түшүүлээд үнэндээ түшсэн биш түүний бяцхан гарт гараа дөнгөж хүрээний төдий явж алтан тэрэлж, уулын цай эцгээр эмжээрлэсэн чулуун шатаар буув.

14.Дайлсан нь

Хатагтай Морсер гүнтэй хамт цэцэг жимс тарьдаг дулаан байрын зүг гудамжлан ургасан далдуу модон дундуур орж явлаа.

- Зочдын өрөөнд дэндүү халуун байна тийм ээ гэж хатагтай хэлэхэд,

- Тийм байна, бүх хаалга цонх онгойлгоно гэдэг таны санаа тун зөв сайхан санаа бана гэснээ гүн, Мерседесийн гар чичирч байгаг ажиглаад – Ийм хөнгөн даашинзтай ганц нимгэн алчуур мөрөн дээрээ тохчихоод таннд хүйтэн биш байна уу? гэж асууд.

Тэгэхэд хатагтай хариулалгүй,

- Таныг хааш нь дагуулж явааг мэдэж байна уу? гэж өөдөөс нь асуулаа.

- Мэдэхгүй хатагтай минь, гэхдээ би зөрөхгүй дагаж явааг та харж байгаа биз дээ гэж гүн хэлэв.

- Энэ модот гудамжны адагт байгаа жимсний хүлэмж рүү авч явна.

Гүн Мерседес өөд асуусан царайтай харахад, хатагтай юу ч дуугаралгүй цааш явлаа. Гүн ч бас л дуугүй явав.

Манайд ховор тохиолдох нарны илчийг орлуулж чадахаар тохируулан дулаалсан байранд ургаж, долдугаар сарын эхэн болоход боловсорч гүйцсэн сайхан жимс дүүрэн байгаа байранд тэд хүрч очлоо.

Хатагтай гүнгийн гарыг тавиад усан үзмийн хэсэгт очиж бөөнийг таслан авч, нүднээс нь нулимс уначих нь уу гэмээр гунигтай инээмсэглэж,

- Гүн та үүнийг авна уу. манай францын усан үзэм Сицил, Киприйн усан үзэмтэй тэнцэхгүй ч гэсэн эндхийн элч муутай хөөрхий нарыг уучлан үзэх байх гэхэд гүн мэхийн ёслоод, алхам ухрав.

- Та идэхгүй гэж байгаа юм уу? гэж Мерседес чичирсэн хоолойгоор асуув.
- Хатагтай минь би танаас уучлахыг гуйя. Усан үзэм ердөө иддэггүй гэж гүн хариулав.

Тэгэхэд Мерседес санаа алдаад жимсээ газар унагачихлаа.

Зэргэлдээх эгнээнд нь тоо хэмээх сайхан жимс усан үзмийн хонгорцог адил зохиомол дулаанд бөнжигнөн байлаа. Хилэн мэт хальстай жимсэнд Мерседес ойртон очоод таслан авлаа.

- Тэгвэл энэ тоорыг ав л даа гэж хатагтай хэлэхэд гүн бас л татгалзав.
- Бас уу! гэж хатагтай цурхиран уйлчихгүйг хичээж арга нь барагдаж байгаа янзаар дуугараад - Үнэндээ, би заяагүй хүн юм гэж хэлэв.

Тэгээх тэр хоёр удаан дуугарсангүй. Тоор жимс усан үзмийн адил элсэн дээр унав.

Тэгж байснаа Мерседес гүн өөд царайчилсан янзтай хараад,

- Нэгэн дээврийн доор талх давс худааж идсэн хүмүүс үүрд найз нөхөд болон үлддэг гэж арабчуудын сэтгэл хөдлөм заншил байдгийг та мэднэ шүү дээ гэхэд,

- Хатагтай минь, би мэднэ. Харин бид, Арабад биш Францад байна. Бас тэгээд Францад талх давс хувааж иддэг заншил байхгүйн адил мөнхийн найз нөхөрлөл гэж байдаггүй шүү дээ гэж гүн хариулав.

- Тэглээ ч гэсэн гээд хатагтайн гар нь чичрэн гүнгийн нүд өөд ширтэн харснаа гарыг нь хоёр гараараа атган авч - Гэсэн ч та бид хоёр найз нөхөд мөн тийм биз дээ? гэв.

Гүнгийн бүх цус нт зүрхэндээ цугларч, царай нь үхдэл мэт зэвхийрснээ дараа нь нүүр уруу нь шахагдаж толгой нь эргэсэн хүн шиг нүд нэ хэдэн хором эрээлжлэв.

- Мэдээжийн хэрэг хатагтай минь, яалаа гэж бид найз нөхөд биш байж болох билээ? гэж тэр хариулав.

Гүнгийн хэлсэн үгний аялгуу нь Мерседесийн хүлээж байснаас тэс өөр байсан тул гинших мэт санаа алдаад,

- Танд баярлалаа гэж хэлэв.

Тэгээд бүсгүй түрүүлэн явав.

Тэр хоёр нэг ч үг дуугаралгүй бүх л цэцэрлэгийг тойрон явав. Тэгээд арваад минут дуугүй байснаа гэнэт Мерседес эхлэн дуугарч,

- Гүн та их юм үзэж олон газар жуулчлан явж зовж зүдэрсэн гэдэг үнэн үү? гэж асуув.

- Тийм ээ, хатагтай минь, би их зовж зүдэрсэн гэж хариулав.

- Харин одоо та жаргалтай байна уу?

- Тэгэлгүй яах вэ. Ямар нэгэ талаар намайг гомдоллож байхыг хэн ч хараагүй байх.
- Одоогийн аз жаргалтай байгаа тань таны сэтгэлийг зөөлрүүлж байна уу?
- МЭний одоогийн аз жаргал өнгөрсөн золгүй явдалтай тэнцүү юм.
- Та эхнэргүй юу?
- Эхнэр ий? гэж гүн цочиж – Хэн танд үүнийг хэлсэн байдаг билээ? гэв.
- Хэн ч хэлээгүй. Харин таныг залуу сайхан хүүхэнтэй хамт дуурь үзэж явахыг хэдэн удаа харсан юм.
- Тэр бол Константинопольд байхдаа худалдаж авсан боол хүүхэн байгаа юм. урьд ноёны охин байсан, одоо энэ орчлонд ойр дотны хүн байхгүй надад охин минь болсон юм.
- Тэгхээр та ганц бие амьдарч байгаа байх нь ээ.?
- Ганц бие.
- Танд эгч дүү...хүү...эцэг бий юү?
- Юу ч байхгүй.
- Амьд яван насанд сэтгэл дэвтээх ойр дотны хүн байхгүйгээр та яаж амьдарч байгаа юм бэ?
- Хатагтай минь, энэ бол миний буруугаар болсон хэрэг биш. Би Мальтад байхдаа нэгэн бүсгүйд сэтгэлтэй болж түүнтэйгээ суух ёстой байсан боловч дайн олж намайг түүнээс салхин мэт холдууллаа. Би түүнийг үнэхээр надад хайртай үхсэн ч надад сэтгэлтэй байна гэж бодож байсан юм. тэгээд намайг эргэж ирэхэд хүнтэй суучихсан байв. Энэ бол хориос дээү насны эрэгтэй хүн бүрд тохиолддог явдал. Харин миний зүрх бусдынхаас илүү эмзэг байсан юм уу, бүү мэд, илүү их зовж зүдэрсэн дээ.

Хатагтай амьсгал нь давхацсан мэт түр зогсоод,

- Тэр дурлал чинь таны зүрхэнд шарх болон хоцорчээ... Хүн амьдралдаа нэг л удаа жинхэнээр дурладаг... Та тэр хүүхэнтэйгээ дахиад уулзаагүй юу? гэж асуув.
- Хэзээ ч үгүй.
- Хэзээ ч үгүй гэнэ ээ?
- Би түүний байсан Жазар уруу ер очоогүй.
- Мальтад уу?
- Тийм ээ, Мальтад.

- Одоо тэр бүсгүй Мальтадаа байгаа юу?
- Тийм байх аа.
- Тэгээд та түүнээс болж зовж зүдэрснээ уучлаа юу?
- Тэр хүүхний хувьд уучилсан.
- Зөвхөн түүнийг үү? Таныг түүнээс салгасан хүмүүсийг үзэн ядсаар байгаа юм уу?
- Огтхон ч үгүй шүү. Би түүнийг яалаа гэж үзэн ядах юм бэ?

Хатагтай гүнгийн өмнө зогсоход гарт нь усан үзмийн хонгорцгийн хагас нь бас бариатай байв.

- Энүүнийг ав л даа гэж хатагтайг хэлэхэд гүн тэдний хооронд энэ тухай огтхон ч яриа бологүй юм шигээр
- Би үзэм ер идэггүй гэв.

Хатагтай цөхөрсөн байдалтай усан үзмээ ойрын бут уруу хаячихлаа.

- Чигээрээ хүн юм аа гэж хатагтай шивнэхэд гүн энэ зэмлэл өөрт нь огтхон ч хамаагүй юм шиг ажиг ч үгүй байв.

Энэ үед Альбер тэдэн дээр гүйн ирж,

- Ээж ээ, их зогүй явдал болжээ гэв.
- Юу гэнэ ээ юу болчихоов? Гэж хатан нойрноосоо сэрсэн мэт эгцлэн зогсоод – Золгүй явдал гэнэ ээ? Нээрээ ч одоо золгүй явдал болж эхлэх ёстой доо гэв.
- Вильфор гуйа ирсэн гэв.
- Тэгээд яагаа вэ?
- Эхнэр охин хоёроо аваачих гэж иржээ.
- Яах гэж?
- Де Сен-Меран бэйлийн авгай Парист иржээ. Өвгөн бэйл Марселиас гараад замдаа эхний буудал дээр нас барчихсан гэнэ. Хатагтай Вильфор их л хөгжилтэй байсан учир үнэмшиж чадалгүй удлаа. Харин Валентина охин эцгээ хичнээн болгоомжтой хэлсэн ч гэсэн дуугармагц нь тааварлан мэдсэн. Тэгээд энэ цохилт охиныг аянга мэт ниргэж ухаан алдаж унасан шүү.
- Ингэхэд Ва«ентина де Сен-Меран бэйлийн юу нь юм бэ? гэж гүн асуув.
- Эхийнх нь талын өвөг эцэг байгаа юм. охиноо Францтай гэрлэхийг нь түргэтгэх гэж ирж явсан юм.

- Өө, тийм учиртай юм бий.

- Одоо Франц хүлээх хэрэгтэй боллоо. Де Сен-Меран бэйт мадмаузель Дангларын өвгөн аав байгаагүй нь харамсалтай.

- Альбер, Альбер чи юу гэж байгаа чинь энэ вэ? гэж хатагтай хүүгээ зөөлнөөр зэмлээд – Гүн таныг энэ ихэд хүндэтгэдэг учир тэгж ярьж болдоггүй гэдгийг хэлж өгөөч гэв.

Хатагтай дахин хэдэн алхам холдов.

Гүн хатагтайг тийм их хачин, бодлогширсон байдалтай боловч эелдэг зөөлнөөр харахад хатагтай буцаж ойртлоо.

Хатагтай түүний гарыг барьж тэр дороо бас хүүгийнхээ гарыг барьж нийлүүлээд,

- Бид найз нөхөд тийм биз дээ? гэхэд гүн,

- Хатагтай тантай найз нөхөр гэж хэлж зүрхлэхгүй байна. харин юу ч болсон таны дуулгаварт зарц мөн гэдгээ хэлж чадах байна гэв.

Хатагтайн зүрх пал хийх шиг болон холдлоо. Арав ч алхаагүй байтла нусныхаа алчуурыг нүд уруугаа аваачихыг гүн харав.

- Ээж та хоёр зөрөлдөө юу? гэж Альбер гайхан асуухад,

- Үгүй, харин саяхан таны дэргэд бид найз нөхөд гэж байлсныг дуулаа биз дээ гэж хариулав.

Тэгээд саяхан Валентина Вильфор хатагтайн хамт гарч одсон зочдын өрөөнд орж ирлээ.

Моррель тэдний хойноос гарсан нь мэдээж хэрэг.

15.Хатагтай де Сен-Меран

Үнэндээ ч Вильфорын гэрт гунигт үйл явдал болох нь болжээ.

Хатагтай Вильфор нөхрөө бүжигт наадамд дагуулж явах гэж хичнээн ятгасан боловч чадсангүй. Хоёр авхайг явсны дараа вангийн прокурор сурсан зангаараа өрөөндөө орж хаалгаа түгжээд бөөн бичиг цаасны дундаа орж авав. Бичиг цаасны нь хэмжээ өөр хүн бол сүрдмээр их боловч ердийн цагт Вильфорын ажиллах хүслиг нь дөнгөн данган хангаж байв.

Энэ удаад Вильфорын ажил хэрэг гэдэг нв зөвхөн шалтаг төдийн хэрэг байлаа. Ганцаараа байж чөлөөтэйхэн шиг ултай бодох гэсэндээ гэртээ хоцорчээ. албан тасалгаандаа орж, хэрвээ ямар нэгэн онцын гойд хэрэг гарахгүй бол бүү яршиг төвөг болоорой гэж тушаагаад зөөлөн сандал дээр шигдэн сууж, сүүлчийн долоо хоногийн дотор уйтгар гунигт дурьдатгалыг нь сэргээсэн бүх л үйл явдлаа ухаандаа эргэцүүлэн бодож гарлаа.

Ингээд өмнөө овоолоотой байгаа хэргүүдийг сөхөж үзэхийн оронд бичгийн ширээнийхээ нүдийг нээж далд пүрш дарж, хувийнхаа нууц тэмдэглэлийг гаргаж ирэв. энэхүү үнэт гар бичмэлүүдийн дотор түүний улс төрийн ажлын таталбар, мөнгөний хэрэг явдлууд, шүүхийн болон хайр сэтгэлийнх нт зам дээр дайсан болсон хүмүүсийн нэрсийг зөвхөн өөрөө гаргах нууц түлхүүрээр маш нарийн дэс дараатай тэмдэглэн бичсэн ажээ.

Сэтгэл түгшин айсан үед тэдгээр нь тоолж байршгүй олон ч юм шиг санагдав. Гэхдээ тэр нэрсийн дотрос хамгийн хүчирхэг, хамигийн аймшигтай нь ч гэсэн уулын оргил өөж авиран гарчхаад хөл доороо байгаа өөрийн зовж зкүдэрч туулж өнгөрүүлсэн нэвтэршгүй урт зам, хурц үзүүртэй хад цохио, гуу жалгын амсрыг эргэн хараад жуулчин хүн инээмсэглэхтэй адил үл тоомсорлон инээмсэглэх хүн ч байж билээ.

Тэрээр нэрсийг дахин санаандаа ургуулан бодож, дахин дахин уншиж, тэмдэглэлээрээ шалгаж үзээд, эцэст нь толгойгоо сэгсэрч,

- Үгүй, эдгээр хүмүүсийн аль ч төдийн болгож байж энэ нууцаар намайг унагах гэж ийм удаан тэвчээртэйгээр хүлээхгүй. Гамлетын хэлдгээр заримдаа газрын хөрсөнд гүн булагдсан хүний хүнгэнэх дуу гарч ирж, ссүмгийн гэрэл мэть агаараар хөвж явдаг юм. гэвч ийм гэрэл дүрсхийн асаад л алга болчихно. Нөгөө Корсик хүн юу болсныг нэг ламд ярьсан байх. Лам тэр тухай мөн цааш нь яриад, Монте-Кристо үүнийг дуулчхаад шалгах гэж байж болох юм даа... хэмээн амандаа шивгэнэв. Вильфоор минутын хир бодолхийлснээ цааш үргэлжлүүлэн,

- Түүнд шалгах хэрэг юун билээ? Фессалийн мөнгөний уурхайн эзэн, мальтийн хөлөг онгоцны эзний хүү анх удаа Францад ирж байгаа эрхэм Монте-Кристо гуай эрхэм Какконе гуайд ийм бүдэг бадаг нууц, ашиггүй баримтыг шалгах хэрэг юу байна даа? Гүнгийн найз хоёр хүн болох Бузони ламтан, лорд Уилмор хоёрын ярьсан бүх зүйлээс үзэхэд ямар ч цаг үе, нөхцөл байдлын дунд надад түүнтэй холбогдох ямар ч юм байхгүй гэдэг ганц зүйл эргэлзээгүй тодорхой байна гэж үглэв.

Вильфор өөрийнхөө үгэнд итгэхгүй хир нь энэ бүхнийг давтан хэлж суув. Хамгийн аймшигтай юм нь илчлэгдэхэд биш, яагаад гэвэл үүнийг үгүйсгэж, эсвэл хариулсан ч болно. Энэ “Мене, Текел, Фарес” гэж цуст үсгээр үг ханан дээр гэнэт гарч ирсэн явдал түүний санааг бага зовооно. Харин эдгээр үгийг бичсэн гар чухам хэнийх болохыг мэдэх сэн гэсэн сэтгэл нь зовиурлана.

Тэгээд өөрийгөө тайвшруулах гэж оролдон, хүсэл мөрөөдөлд нь зарим үед зурагдан харагддаг улс төрийн ирээдүйнхээ оронд, тэр олон жил нойрссон дайснаа сэрээхгүйн тулд гэр зуурын баяр жаргалаар хязгаарлагдсан ирээдүйн сайн сайхныг бодож суутал хашаан дотор тэрэгний дугуйн чимээ гарлаа. Дараа нь шатан дээр хөгшин хүний хөлийн чимээ гарч, дараа нь цурхиран уйлах дуу ба зарц нар эздийнхээ төлөө сэтгэл зовж байгаагийн тэмдэг болгож сайхан чаддаг гунигтайгаар халаг хоохой болох чимээ гарлаа.

Тэрээр тасалгааныхаа түгжээг яаран тайлбал бараг тэр доор нь гартаа том алчуур, бүрх малгай барьсан настай авгай зөвшөөрөл ч үгүй шууд орж ирэв. Түүний зааны шарласан яс шиг зөөлөн шар өнгөтэй духыг нь буурал үс нь эмжин хүрээлж, он жилийн эрхэнд гүнзгий үрчлээс суусан нүд нь уйлснаас болж хавджээ.

- Ай ямар их золгүй явдал вэ! Ямар заяа нь хаясан юм бэ? Би үүгийг тэсвэрлэж чадашгүй нь. Үгүй, би ч гэсэн үхмээр байна гэж орь дуу болов.

Тэгээд үүдний дэргэдэх зөөлөн сандал дээр унаад цурхиран уйллаа.

Зарц нар босгон дээр бөөгнөрөлдөн, орж зүрхлэхгүй зогсох бөгөөд мөн чимээнээр эзнийхээ өрөөнөөс гүйн гарч бусдынхаа ард зогссон Нуартъегийн хөгшин зарцыг хийл харцгаана.

Вильфор хадмаа таниад, ухасхийн босоод угтан очив.

- Бурхан минь, юу болчхов? Та юунд ингэж гутарч гунихарч орхив? Де Сен-Меран бэйл тантай ирээгүй юм уу? хэмээхэд хөгшин авгай,

- Де Сэн-Меран бэйл үхчихлээ гэж сэтгэлин ямар ч илэрхийлэлгүй хөшчихсөн мэт байдлаар шууд хэлэв.

Вильфор алхам ухран халаг хоохой болж,

- Үхчисэн гэнэ ээ!...Гэнэт үхчихээ юү? гэж асуув.

- Долоо хоногийн өмнө бид үдийн хоолны дараа замд гарлаа. Бэйл хэдэн өдөр өвчтэй байсан юм. гэвч удахгүй хайрт Валентинагаа үзнэ гэсэндээ хүч орж биеэ муу байгаа хайхралгүй замд гарсан юм. тэгээд бид Марселиас зургаан мод газар явж амжаагүй байхад тэр ердийнхөөрөө эмээ уучихаад дараа нь маш бөх унтчихлаа. Нэгл биш дээ гэж санагдсан боловч сэрээж зүрхлээгүй юм. гэтэл царай нь хөхөрч хүрэнтэн чамархайны судас нь учиргүй их бүдүүрч байхыг гэнэт харав. Гэсэн ч түүнийг сэрээгээгүй л дээ. тэгтэл ч шөнө болж юу ч харагдахаа больчихлоо. Удалгүй нойрон дундаа бие нь өвдөөд байгаа юм шиг бүдэгхэн дуу тавиад толгойгоо ар тийш нь гэдийлгэв. Би хиагаа дуудаад, хөтөчдөө зогсохыг тушааж, бэйлийг сэрээх гэж оролдон, шилтэй дарс үгэртүүлэв. Гэвч бүх юм өнгөрч хэдийнээ амьсгал хураачихсан байлаа. Би Экс хүртэл амьгүй болсон биеийн нь хажууд сууж явлаа.

Вильфор энэ ярианд цочирдон чагнаж зогслоо.

- Та нар дороо л эмч дуудаа биз дээ?

- Тэр дороо дуудсан гэсэн ч хэдийнээ хожимдсон байсан гэж танд хэлсэн шүү дээ.

- Тэр ч тийм л дээ. Гэхдээ эмч ядахдаа хөөрхий чухам ямар өвчнөөр үхсэнийг нь тодорхойлж өгнө шүү дээ.

- Ээ бурхан минь. надад хэлэлгүй яах вэ. тархинд нь цус харвах дайрлага байсан бололтой.

- Тэгээд та яав?

- Де Сен-Меран гуай өөрийгөө Парисаас өөр газар үхвэл хүүрийг гэр бүлийн булшинд заавал аваачаарай гэж захидаг байсан юм. би түүнийг тугалган авсанд хийж ирэхийг тушаагаад өөрөө хэд хоногоор түрүүлээд ирлээ.

- Хөөрхий ээж минь! Ийм насан дээрээ, ингэж сэтгэлээ шимшрүүлсний дараа, ийм их ажил хийх гэж! хэмээн Вильфор хэлэв.

- Бурхан надад энэ бүхнийг давах хүч чадал өгсөн. Хэрвээ намайг үхвэл миний нөхөр, мини йхийсэн бүхнийг хийх байсан. Би түүнийг тэнд орхисоноосоо хойш ухаан солиотой юм шиг болчихлоо. Одоо уйлах ч тэнхээгүй боллоо. Миний насанд хүрэхэд хүн нулимсгүй болдог гэж улс ярьдаг боловч, зовж зүдэрч байгаа цагт нулимс байсаар байдаг юм шиг байна. Валентина хаана байна? Бид ганцхан түүний л төлөө наашаа явсан юм. би Валентинатай уулзахсыг хүсч байна гэв.

Валентина бүжигт наадамд байгаа гэх нь ямар хатуу эвгүй зүйл болохыг Вильфор ойлгож байсан учир зүгээр л түүнийг гэртээ байхгүй хойд эхтэйгээ хамт гарсан, одоохон дуудуульчихья гэж хэлэв.

- Одоохон, одоохон дуудаарай гуйя гэж хатагтай хэлэв.

Вильфор хөгшнийг сугадан өрөөнд оруулаад,

- Амарч бай ээж минь гэв.

Хойноос нь уй гашуу болсоор байг а хайрт охиныг нь санагдуулсан энэ хүнийг хараад “ээж” гэсэн үгийг нь дуулахдаа хөгшний сэтгэл хямран зөөлөн сандлын өмнө сөхрөн унаж буурал толгойгоороо түшив. валентина томрох тусмаа талийгаач ач охин нь дүрээрээ мэт болж байгаа билээ.

Вильфор түүнийг хүүхнүүдийн асрамжинд үлдээгээд явахад сэтгэл гүнээ хөдөлсөн Барруа эзэн уруугаа очихоор дээш гарлаа. Үхэл өөр нэг өвгөнийг аваачаар, өөрсдөөс нь минутын төдий холдоход хөгшчүүд хамгийн ихээр айдаг билээ. бэйлиний хатан өнөө л өвдөг дээрээ сөхөрсөн хэвээр залбирч байх зуур Вильфор хүн явуулж, хөлсний сүйх тэрэг дуудуулаад өөрөө хатагтай Морсерынд очиж эхнэр охин хоёроо авчрахаар явав.

Зочдын өрөөний үүдэн дээр ирэхдээ царай нь хачин цонхигор байсан тул Валентина харангуутаа хашихиран гүйж очиж,

- Аав аа юу болов, гай тохиолдов уу? гэж асуухад,

- Валентина, эмээ чинь ирсэн гэж хэлэв.

- Аа өвгөн аав гэж бүсгүй хамаг бие нь чичрэн асуув.

Вильфор хариу хэлэхийн оронд охиноо сугадан авлаа.

Ингэж барьсан нь ч сайн болж, Валентинад эвгүй оргиж гуйвалзан байхад нь түшин авав. Хатагтай Вильфор түүнийг түшиж сүйх тэргэнд суулгахад нөхөртөө туслах зуур,

- Ямар аймшигтай юм бэ? Хэн тэгнэ гэж бодож байх билээ? нээрээ аймшигтай хачин явдал аа гэж байв.

Гунихрал учирсан гэр бүл үдэшлэгт ирсэн бүх хүмүүст уйтгарын хар хүрээ татуулж орхиод, даруй орхин явлаа.

Валентина шатны доор хүлээж байсан Барруатай дайралдав.

- Нуартье гауй өнөөдөр тантай уулзахыг хүсэж Үайнагэж тэр аяархан хэлэв.

- Эмээ ээжтэйгээ уулчихмагцаа очно гэж байна гэж хэлээрэй гэв.

Валентинагийн сонор зүрх хатагтай Сен-Меранд энэ мөчид өөрөөс нь илүү хэрэгтэй хүн байхгүйг ойлгожээ.

Валентинаг ороход эмээ нь орондоо орчихсон байв. Үг дуугүй энхрийлсэн харц, зүрх сэтгэл дүүрэн уйтгар гашуу, уйтгарлан санаа алдах ба халуун нулимс эд бүгд л уулзаж учирсны шинж болж байлаа. Хатагтай Вильфор нөхөртэйгээ хамт сугадалцан хөөрхий бэлэвсэрсэн авгайг лав л өнгөндөө өрөвдөн хайрласан шинжтэй зогсож байв.

Жаахан зогсож байснаа нөхрийнхөө чихэнд,

- Хэрвээ зөвшөөрвөл би гарья. Мини йбайдал таны хадмын дургүйг улам ч их хүргэж байгаа бололтой гэв.

Хатагтай Сен-Меран түүний ингэж хэлэхийг дуулчихжээ.

- Тийм ээ, тийм тэр яваг. Харин чи үлдээрэй, заавал үлдээрэй гэж Валентинагийн чихэнд шивэгнэв.

Вангийн прокурор гэнэтийн үхэлд сэтгэл үймэрч эхнэрийнхээ хамт гарч одсон учир эмгэний дэргэд Валентина ганцаараа хоцров.

Тэр зуураа Барруа эрхэм Нуартье дээр эргэж ирлээ.

Нуартье гэртээ шуугиан болохыг сонсоод юу болж байна вэ үзээд ир гэж зарцаа явуулсан гэдгийг бид дээр өгүүлсэн билээ.

Түүнийг эргэж ирэхэд өвгөний золбоотой амьд хүдний харц зарцаа асуусан байдалтай харав.

- Их золгүй явдал болжээ, эрхэм минь. хатагтай Сен-Меран гацаараа ирсэн байна. нөхөр нь нас барчихсан гэнэ гэж Барруа айлтгалаа.

Нуартье Сен-Меран хочр хэзээ ч төдийлөн сайн найз нөхөд байсангүй. Гэхдээ үе тэнгийн насны хүн үхэх явдал өвгөчүүлд ямаршухан сэтгэгдэл төрүүлдэг болох нь ойлгомжтой билээ. нуартье уй гашууд үймэрсэн бодолд автсан хүн шиг дуу чимээгүй байснаа дараа нь нэг нүдээ анив.

- Мадмаузель Валентина юу? гэж Барруаг асуухад Нуартье тийм гэж дохилоо.

- Тэр одоо бүжигт наадам дээр байгаа. Явахынхаа өмнө тан дээр гоёлынхоо хувцастай ирээд явсан шүү дээ.

Нуартье дахин зүүн нүдээ анив.

- Та түүнтэй уулзах гээ юү?

Нуартье тийм гэж дохилоо.

- Одоо түүнийг олж ирэхээр хатагтай Морсерын руу хүн явах байх. Би түүнийг ирэхийг хүлээж байгаад тан дээр оруулах уу? Мөн үү?

- Тийм гэж саагийн гэмд дайруулсан өвгөн дохилоо.

Тэгээд Барруа Валентинаг тосож байгаад өвгөн аав нь уулзах гэснийг нь хэлснийг бид мэдэх билээ.

Валентина ядарч зүдрэн нойронд дарагдан унтсан Сен-Меран авгай дээрээс гармагцаа Нуартье дээр очихоор шатаар өгсөв.

Эмгэний толгойн тэнд түний уух дуртай ус тавьсан ширээ тавид хажууд нь шилэн аяга орхив.

Дараа нь Валентина бидний түрүүний хэлснээр өвөө дээрээ очлоо.

Валентина өвгөн аавыгаа үнсэхэд өвгөн аав нь маш их энхрийлсэн харцаар харсан тул бүсгүйн нулимс нь татарчихсан гэж бодож байсан нүднээс нь нулимс урслаа.

Өвгө түүн өөд ширтэн харав.

- Ойлголоо, бас сайн санаат өвгөн аав үлдсэн гэж та хэлэх гээ юү? гэж Валентина асуухад чухам тэгэх гэсэн юм гэж өвгөн дохиогоор мэдэгдлээ.

- Тийм ээ, энэ бол надад их аз. үгүй бол би яах байсан бол бурхан минь гэж Валентина үргэлжлэн хэлэв.

Шөнийн нэг цаг болж байв. Нойр нь хүрсэн Барруа, ийм гунигтай явдал болсны дараа тайван амрах явдал бүгэдэд нь хэрэгтэй гэж хэллээ. Өвгөн ачаа л хажр байвал тайвшрах нь тэр гэж хэлэхийг хүссэнгүй. Тэгээд уй гашуу ба ядралаасаа болоод арай гэж хөл дээрээ зогсож байсан Валентинатай салах ёс хийв.

Маргааш өглөө нь Валентинаг орж ирэхэд эмээ нь орноосоо босоогүй байв. чичиргээ нь намдсангүй. Харин ч хатагтайн нүд намартан гялалзаж, мэдрэлийн их донслолд учирсан нь илт байлаа.

Валентин энэ байдлыг хараад,

- Эмээ ээж минь ямар байна? Бие чинь муу байна уу? гэж асуув.

- Үгүй дээ хүү минь! харин би чамайг орж ирэхийг хүлээж байлаа. Аавыг чинь авчруулах хэрэг байна гэхэд сэтгэл нь зовсон Валентина,

- Аавыг ий? гэж давтан асуулаа.

- Тийм ээ, түүнтэй ярих хэрэг байна.

Валентина эмээгийнхээ хүслээс зөрөх гэж зориглосон ч үгүй, тэгээд ч бас ямар учиртайг нь мэдэхгүй байлаа. Минутын дараа Вильфор тасалгаанд орж ирлээ.

- Эрхэм та манай охиныг хүнтэй суулгах гэж байгаа гэж бичсэн байсан гэл үү? гэж асуув.

- Тийм ээ хатагтай минь, энэ бол санаа биш, шийдчихсэн юм шүү дээ гэж Вильфор хэлэв.

- Танай хүргэн болох хүнийг Франц де Эпине гэдэг юм уу?

- Тийм ээ, хатагтай минь.

- Түүний эцэг нь бидний нэгэн санаатай генерал де Эпинье мөн биз? Засгийн эрх булаагчийг кльбээс эргэж ирэхээс хэдхэн хоногийн өмнө түүнийг алчихсан байх аа?

- Яг тийм.

- Якобинчуудын талыг баримтлагч хүний ач охинтой суухдаа дургүйцэхгүй юм биз?

- Аз болоход бидний улс төрийн зөрөлдөөн арилсан. Эцгийнхээ үхэхэд Франц де Эпине бараг нялх хүүхэд байсан юм. тэр эрхэм Нуартъег тун муу танина. Түүнтэй нэг их дуртай биш ч гэхнээ ямар ч байсан санаанд орохгүй л уулзах байх гэж Вильфор хэлэв.

- Тэнцүү хоёр уу?

- Бүх талаараа тэнцүү.

- Тэр залуу хүү чинь...

- Олны хүндэтгэлийг хүлээсэн хүн.

- Сайн хүмүүжилтэй хүн үү?

- Миний л мэдэх хүмүүсийн дотроос хамгийн сайн хүний нэг.

Энэ яриаын үеэр Валентина нэг ч үг дуугарсангүй. Хатагтай Сен-Меран багахан бодолхийлснээ,

- Тийм юм бол яаравчлах хэрэгтэй байна. миний амьдрах хугацаа жаахан үлдсэн шүү гэв.

- Таны юу? Эмээ ээж минь гэж Вильфор Валентина хоёр зэрэг дуу алдлаа.
 - Би юу ярьж байгаагаа мэлдж байна. эх нь байхгү ч гэлээ, эмээ нь болохноо Валентинагаа хүнд очихонд нь адислах хэрэгтэй байна. эрхэм таны тийм амархан мартаж орхисон муу Ренегийн талаас ганцхан би л үлдсэн юм гэж хатагтай үргэлжлэн ярив.
 - Энэ хөөрхий охинд минь эх хэрэгтэй басйан гэдгийг та мартаж орхижээ гэж Вильфор хэлээ.
 - Эрхэм минь, хойд эх гэдэг хэзээ ч эхийг орлож чаддаггүй юм. за энэ ч яах вэ, ажил хэрэгт холбогдохгүй юм. Валентинагийн тухай ярьж байгаа болохоор талийгаачийн ясыг өндөлзүүлээд яах вэ.
- Эмгэн үгээ их хурдан, дэмийрч байна уу гэх өнгөөр ярьж байв.
- Таны хүсэл минийхтэй нийлж байга болохоор эрхэм де Эпинег ирмэгц л биелэгдэнэ гэж Вильфор хэлэв.
 - Ингэхэд эмээ минь тэгж таарахгүй, манайд чяинь эмгэнэл болж байгаа үе шүү дээ... Та намайг ийм уйтгар гунигтай үед хүнтэй суулгах гэж байгаа юм гэж үү? Гэж Валентина хэлэхэд эмгэн үгийг нь таслан,
 - Хүү минь энэ тухай бүү ярь. Энэ бол ирээдүйгээ бат бөх болгоход саад болно. Намайг ч бас ээжийг минь амьсгал хураах гэж: байхад хүнтэй суулгасан юм. Үүнээс болоод би муудаагүй гэж хэлэв.
 - Хатагтай та бас л үхлийн тухай ярьж байна уу? гэж Вильфор хэллээ.
 - Бас гэнэ үү! Ямагт шүү. Би удахгүй үхнэ гэж хэлж байгааг минь сонсооч. Гэвч үхэхээсээ өмнө хүргэнээ үзэх гэсэн юм. би түүнээс ач охиныг минь аз жаргалтай байлгах амыг нь авах гэсэн юм. миний шаардлагыг биелүүлэх эсэхийг харцаар нь мэдэх гэсэн юм. хэрвээ зөв зүйтэй явахгүй бол, булшны ёроолоос гарч түүн дээр ирэхийн тул түүнийг сайн таниж авах гэсэн юм гэхдээ хөгшний царай аймаар болж ирлээ.
 - Хатагтай та энэ бодлоо орхи. Энэ чинь бараг солиорол байна. Үхсэн хүмүүс булшиндаа үүрд хэвтэхээс биш, хэзээ ч босч ирдэггүй юм гэж Вильфор зөрж хэлэхэд, Валентина,
 - Тийм тийм эмэг ээж минь тайвшир гэж хэлэв.
 - Энэ бүхэн та нарйн бодож байгаагаар биш юм шүү гэдгийг хэлэх гэсэн юм. урьд шөнийг би их аймшигтайгаар өнгөрүүлээ. Би сүнсээ нисээд явчхаж, өөрөө бол унтаж байна гэж зүүдэллээ. Би нүдээ харах гэж оролдсон боловч аяндаа анилдаад байв. Та нарт ялангуяа Вильфорт миний хэлэх зүйл байж боломгүй юм шиг санагдах байх. Гэвч хатагтай Вильфорын гоёл заслын өрөөнөөс нэгэн цагаан дүрс орж ирэхийг би нүдээ аниж байгаад расан шүү гэв.

Валентина дуу алдлаа. Тэгэхэд Вильфор,

- Та халуурч байсан байлгүй гэв.
 - За яах вэ, надад итгэхгүй байж болно. Харин би юу ярьж байгаагаа мэдэж байна. би цагаан дүрс үзсэн. Харсандаа итгэхгүй байж магад гэж бурхан болгоомжилсон юм шиг ширээн дээр байгаа шилэн аяга дуугарахыг сонссон.
 - Эмээ ээж минь, та зүүдэлсэн байлгүй дээ.
 - Үгүй зүүдлээгүй. Намайг хоно руу гараа сунгахад тэр сүүдэр дорхноо алга болчихсон. Тэгтэл шивэгчин хүүхэн лаа барьж орж ирсэн.
 - Тэгэхэд хэн ч байсангүй юу?
 - Буг бол зөвхөн харагдах гэсэн хүндээл харагддаг юм. тэр бол нөхрийн минь сүнс байсан. Тэгэхээр миний хойноос нөхрийн мнь сүнс ирж болсон байхад, миний сүнс хүүхдүүдээ хамгаалах гэж ирж яагаад болдоггүй байх билээ? Бидний холбоо улам ч хүчтэй юм шиг надад санагдсан шүү.
 - Хатагтай минь, ийм гунигт санаа бодлоо бүү сул тавиач гэж гуйя. Та бидэнтэй хамт удаан сууж хүндлэгдэн хайрлагдаж жаргана гэж Вильфор сэтгэл нь гүнээ хөдлөн хэлэхэд хатан түүний үгийг таслан,
 - Үгүй, үгүй, хэзээ ч үгүй гэснээ – Эрхэм де Эпине хэзээ ирэх вэ? гэлээ.
 - Бид түүнийг хэзээ хэзээгүй ирнэ гэж хүлээж байна.
 - Сайн байна. түүнийг ирмэгц л надад хэлээрэй. Түргэлэх хэрэгтэй шүү. Манай бүх хөрөнгө Валентинад шилжин очно гэдэгт итгэлтэй байхыг хүсэж байна.
 - Ээ, эмээ минь гэж Валентина эмгэний халуу буцалж байгаа духан дээр уруулаа хүргээд – Би үүнийг тэсвэрлэж чадашгүй нь ээ. таны бие шаьаж байгаа вь шиг халуун байна. нотариатын хүнийг биш харин эмч дуудах хэрэгтэй юм гэж хэлэв.
 - Эмч ий? Би өвдөөгүй, би зөвхөн л юм уухыг хүсч байна гэж эмгэн мөрөө хавчин хэллээ.
 - Эмээ та юу уух вэ?
 - Чи мэднэ шүү дээ. Тоорны шүүстэй ус ууя.Ширээн дээр аяга байгаа. Алив надад аваад аль.
- Валентина ус аяганд хийгээд эмгэнд авч өгөхдөөхатагтай хэлсэн өчигдөр шөнийн буг энэ аяганд хүрсэн гэж бодоод айдас нь хүрлээ.
- Хатагтай усыг цөмийг нь уучихлаа. Тэгээд дараа нь дэрээ налж,
- Нотариатын хүн, нотариатын хүн гэж үглэв.

Вильфор гадагшаа гарлаа. Валентина эмэг ээжийнхээ дэргэд сууж хоцорлоо. Хатанг эмч дуудуул гэж зөвлөж байсан хүн маань өөрөө эмч дуудуулмаар болчихжээ. Хацар нь улайж, амьсгаа нь давхцан, судас нь хүчтэй цохилно.

Хөөрхий охин ингэж суухдаа, Максимилиан хатагтай Сен-Мераныг өөрийн холбоотон болж туслахын оронд атаат дайсан нь болж байгааг мэдвэл ямар их гомдох бол гэж бодож байлаа.

Валентина бүх зүйлээ эмэг ээждээ ярина гэж олон удаа боджээ. Хэрвээ Максимилиан Моррель бус Альбер де Морсер эсвэл Рауль де Шато-Рено гэдэг нэртэй байсан сан бол Валентина хэлэхээсээ нэг ч минут эргэлзэхгүй байсан биз ээ. харин Моррель бол ердийн гаралтай хүн байсан бөгөөд хатагтай Сен-Меран язгуургүй хүмүүсийг үзэн яддаг болохыг Валентина мэднэ. Нууц нь аман дээр нь гарч ирэх болгонд нууцаа дэмийн илрүүлчхээд эцэг ба хойд эх нь мэдчихвэл бүх зүйл өнгөрнө гэдгийг мэдэж байлаа.

Ингэж хоёр цаг хиртэй өнгөрлөө. Хатагтай тайван биш нойронд дарагдан байхад нотариатын хүн ирснийг мэдэгдэв. Хэдийбээр дуулдахааргүй гахам хэлсэн ч хатагтай толгой өргөж,

- Нотариатын хүн үү? Орог, орог гэв.

Нотариатын хүн үүдэнд байсан учир даруй орж ирлээ.

- Валентина гар, намайг энэ эрхэм хүнтэй хоёулангий минь орхиодох гэхэд Валентина,

- Гэхдээ эмээ ээж ээ... гэхэд,

- Яв, яв гэв.

Валентина эмгэний духыг үнэсээд алчуураа нүдэндээ барьсаар гарав.

Гартал үүдэн дээр хиатай дайралдаж, эмч ирээд зочдын өрөөнд хүлээж байгааг мэдэв.

Валентина даруйхан доошоо буув. Ирсэн эмч нь тэр үеийн хамгийн нэртэй эмч нарын нэг бөгөөд тэдний гэр бүлийн найз нөхөр, Валентинаг өлгийтэй байхаас нь эхлэн таньдаг учир охинд хайртай хүн байлаа. Валентинатай бараг нас чацуу охин нь эхээс төрөхийн уушиг муутай болохоор эцэг нь үргэлж охиныхоо төлөө санаа зовдог байжээ.

- Ай, эрхэм хүндэт Авринья гуай, бид таныг их хүлээж байна. Мадлен, Антуанета хоёр сайн биз дээ гэдгийг эхлээд асуучихья гэж Валентина хэлэв.

Мадлен бол эмчийн охи бөгөөд Антуанета нь түүний хамаатан ажээ. Д' Авринья гуай уйтгартайгаар инээмсэглэж,

- Антуанета маш сайн, Мадлен гайгүйхэн шиJ л байна. Та намайг дуудуулаа юу? Танайхны хэн өвдөө вэ? Аав, хатагтай Вильфор хоёр лав биш биз дээ? Бидний

мэдрэл гэдэг тайван байлгахгүй л дээ. Бидний санаа бодлыг дэндүү дураар нь тавихгүй байхыг зөвлөх л гэж дуудсан байх гэж бодохгүй байна шүү гэж хэлэв.

Валентина улайгаад явчихав. Д' Авринья бол юм бүхнийг тааварлан мэдэх бараг ид шидийн чадалтай эмч хүн байв. Тэр бол биеийн өвчнийг сэтгэл санаагаар эмчилж чаддаг эмчийн нэг ажээ.

- Үгүй дээ, хөөрхий эмээ маань өвдсөн. Манайд ямар гай тохиолдоод байгааг та мэдсэн үү? гэж охиныг асуухад,

- Юу ч мэдээгүй шүү дээ гэж эмч хэлэв.

- Аймшигтай юм болсон. Өвгөн аав нас барчихсан гэж Валентина нулимсаа барьж ядан хэлэв.

- Де Сен-Меран бэйл үү?

- Тийм ээ.

- Гэнэт үү?

- Тархинд нь цус харвасан.

- Цус харвасан гэнэ ээ?

- Тийм. Тэгээд хэзээ ч хагацаж үзээгүй нөхөр нь дуудаад байна гэдэг санаа эмээг эзэмдэж, хөөрхий маань хойноос нь очих ёстой гээд байгаа юм. Эмээд минь туслаач!

- Хаана байна?

- Өрөөндөө байгаа. Бас тэнд нотариус байгаа.

- Эрхэм Нуартье ямаршуухан байна?

- Хуучин хэвээрээ саруул ухаантай, хөдөлгөөнгүй, дуугүй суусаар байгаа.

- Таныг энхрийлсэн хэвээрээ юү, тийм үү?

- Тийм ээ гэж Валентина санаа алдан хэлээд—Надад маш их хайртай шүү гэв.

- Таныг яаж хайрлахгүй байж болох билээ дээ?

Валентина уйтгартайгаар инээмсэглэв.

- Танай эмээ чухам яагаад байна?

- Сэтгэл мэдрэл нь ер бишээр хөдлөн, хачин жигтэй зүүд зүүдлээд байх юм. Урьд шөнө, түүний сүнс биеэс нь зайлж, өөрийгөө унтаж байгаагаар үзжээ. Мэдээж дэмийрэл л дээ. Өрөөнд нь хий үзэгдэл орж ирээд, аяганд нь хүрснийг дуулсан гэж ярив.

- Хачин юм даа. Хатагтай Сен-Мераныг хий юм үздэг өвчтэй гэж би л дуулаагүй юм байна гэж эмч хэлэхэд, Валентина,

- Би түүний тийм байхыг анх үзэж байна. Өнөө өглөө намайг их айлгалаа. Солиорчхож гэж бодлоо шүү. Та манай аавыг тун тайван хүн гэдгийг мэдэх байх, гэтэл аав их сандарч байх шиг байна лээ гэв.

- Одоо үзье. Их л хачин юм байна даа гэж эмч хэлэв.

Нотариус доошоо буулаа. Бэйлийн хатанг ганцаараа байна гэж хэлэхээр хүн ирэхэд, Валентина, эмчид

- Дээшээ оч л доо гэв.

- Та өөрөө яах вэ?

- Үгүй, би айж байна. Намайг тан руу хүн явуулахыг хориглосон юм. Тэгээд ч бас та намайг, сэтгэл хөдөлчихсөн, бие муу байгааг хэлсэн шүү дээ. Би бага зэрэг тайвшрахын тулд цэцэрлэг дотуур жаахан явъя.

Эмч, Валентинатай гар бариад хатагтай өөд очиход залуу бүсгүй цэцэрлэг рүү явлаа.

Валентина цэцэрлэгийн альхан хэсэгт зугаалах дуртайг ярих ч хэрэггүй биз. Байшин тойруулан тарьсан цэцэрлэгийн хүрээлэнгийн дэргэдүүр нааш цааш явангаа үсэндээ хавчуулах саргай тастаж аваад, сүүдэртэй модот гудамжаар улам цаашлан сандал хүрээд тэндээсээ хаалга өөр очдог билээ. Харин энэ удаа Валентина цэцгүүдийн дундуур хэдэн удаа явсан боловч зүрхэндээ байгаа уй гашуудлаас болж нэг ч цэцэг тастан авч гоёсонгүй. Дараа нь модот гудамж өөд явав. Цаашаа явах тусам нэг хүн өөрийн нь нэрээр дуудаж байхыг сонсоод гайхан зогслоо. Тэгээд залуу бүсгүй Максимилианы дуу болохыг танив.

16. Амлалт

Энэ бол үнэндээ өчигдрөөс хойш өөрөө өөрийгөө ч мэдэхээ больчихсон Моррель мөн байлаа. Тэрээр дурласан хүн ба эх хүнд байдаг төрөлх авьяасаар хатагтай Сен-Меран ирсэн, бэйл нас барсан явдлаас болж Вильфорын гэрт Моррелийн хайр сэтгэлтэй холбоотой чухал явдал болно гэдгийг тааварлан мэджээ.

Совин нь худал байсангүй. Ердийн түгших сэтгэл алмайрч догдолсон эрийг туулайн бөөр модны дэргэдэх хаалганд авяирсангүй гэдгийг бид үзнэ. Харин Валентина Моррелийг хүлээж байгаа гэж бодсонгүй. Энэ бол түүний ирдэг цаг биш байв. Ёстой л санамсаргүй буюу азтай тохиолдол охиныг цэцэрлэгт авчирчээ.

Охиныг замаар явж байгааг хараад Иоррель дуудахад бүсгүй хаалга өөд гүйж очив.

- Та өдийд энд байгаа юм уу? гэж охин асуув.

- Тийм ээ, хөөрхий найз минь, би гунигтай мэдээ мэдэж авах гэж ирлээ хэмээн Моррель хариулав.

- Бүх л гай зовлон манай гэрийг дайрлаа! Максимилиан ярь л даа. Золгүй явдал бишгүй нэг л тохиолдож байна.

- Хайрт минь, сонсооч, миний хэлэх зүйл онц чухал шүү. Та хоёрын хурим хэзээ болох вэ? гэж Моррель түгшсэн сэтгэлээ дарахыг хичээн хэлэв.

Тэгэхэд Валентина,

- Максимилиан, би танаас юу ч нуухыг хүсэхгүй. Өнөө өглөө намайг хүнтэй суулгах тухай ярьсан. Дэмжлэг тусламж авах байх гэж найдаж байсан эмээ маань тэр хүнтэй суухыг зөвшөөрөөд зогсохгүй, харин ч бүр түргэлүүлэх гэж хүсэж, зөвхөн д'Эпинийг ирэхийг хүлээж байна. Түүний ирсний маргааш л гэрлэлтийн баталгаанд гарын үсэг зурна гэж хэлэв.

Моррелийн цээжнээс хүндээр санаа алдах дуун гарч, Валентина өөд гунигтай удаанаар харлаа.

- Тийм байжээ. Сэтгэлтэй бүсгүй маань тайвнаар:" Таны цаазлагдах цаг тогтоогдсон, хэдхэн цагийн дараа болно. Одоо яая гэх вэ, ийм л ёстой хойно, үүнийг би эсэргүүцэж чадахгүй" гэж хэлэхийг сонсоход аймшигтай л юм. Гэрээнд гарын үсэг зурахын тулд зөвхөн д'Эпинийг хүлээж, түүнийг ирсний маргааш та түүнийх болчих гэж байгаа юм бол тэр хүн өнөө өглөө ирсэн гэж хэлэв.

Валентина дуу алдлаа.

- Цагийн өмнө би Монте-Кристо гүнгийн дотор очиж, гүн надад танай гэр бүлд тохиолдсон гай зовлонгийн тухай, би түүнд таны зовлонтой байгаа тухай ярьж байтал хашаан дотор нь сүйх тэрэг орж ирлээ. Миний хэлэхийг сайн сонс. Би тэр минутыг хүртэл өөрийн совинд итгэхгүй байсан юм. Одоо итгэхээс өөр арга алга. Сүйх тэрэгний дугуйн чимээг сонсоод би чичрэн догдолсон юм. Удалгүй шатан дээр хүний хөлийн чимээ гарахыг сонслоо. Нөгөө амилсан хөшөөний нүргээнтэй алхах чимээ Дон Жуаныг миний айснаас арай л бага хэлмэгдүүлсэн болов уу. Тэгтэл хаалга нээгдэж Альбер де Морсер түрүүлэн орж ирлээ. Тэгэхэд би миний совин буруутах нь юм болов уу гэж бодтол хойноос нь бас нэг хүн орж ирлээ. Түүнийг хараад гүн"Өө, түшээ гүн Франц д'Эпине..." гэсээр угтлаа. Би биеэ барих гэж бүх хүч чадлаа гаргалаа. Миний царай зэвхийрч, бие чичирч байсан байж магадгүй! Гэсэн ч би инээмсэглэсээр байсан. Тэгээд таван минут болоод гарсан. Би тэр таван минутын дотор ярьсан ярианаас юу ч сонсоогүй. Ёстой элий балай болчихоод байсан гэв.

- Хөөрхий Максимилиан! гэж Валентина шивгэнэв.

- Тэгээд би энд хүрч ирлээ, Валентина минь. Одоо надад хариу хэл. Таны хариунаас л миний үхэх, сэхэх шалтгаална. Та юу хийе гэж бодож байна?

Валентина уй гашууд бүрэн автсан учир толгойгоо унжуулан зогсоно.

- Бид ямар байдалд ороод байгааг та нэг биш удаа бодоо биз дээ. цөхөрмөөр зовиуртай хүнд байдалд шүү. Одоо бол үр ашиггүй гунихрах цаг биш. Энэ бол ямар ч эсэргүүцэлгүй зовж, шаналан нус нулимсаа гоожуулан байдаг хүнд л тохирно. Ийм хүмүүс байдаг, газар дэлхий дээр нигүүлсэнгүй номхон байсныг нь тэнгэрт очсон

хойно нь бурхан харгалзан ивгээл хайраа хүртээх байх л даа. тэмцэх зоригтой гэдгээ мэдэрч байгаа хүн үнэт цагаа алдахгүй хувь заяаны цохилтыг цохилтоор хариулах ёстой. Валентина та энэ өөдгүй тавилангийн эсрэг тэмцэхийг хүсэж байна уу? Би үүнийг л асуух гэж ирсэн юм.

Валентина цочин давхийж Морсер өөд айсан байдалтай харав. Эцэг, эмээ ер нь бүх л гэр бүлийнхээ эсрэг зогсоно гэдэг санаа түүний толгойд ч орсонгүй.

- Максимилиан та юу гэж мэлэх гээд байна даа? Тэмцэл гэж та юуг хэлж байна? Үүнийгээ шүтээнээ долромжлох гэж нэрлэвэл дээр биш үү? Эцэг ба үхэж байгаа эмэг эхийнхээ хүсэлтээс зорих гэж үү? Үгүй энэ бол боллоцоогүй хэрэг! гэж хэлэв.

Моррель цочин давхийлээ.

- Та миний хэлж байгааг ойлгохгүй байхааргүй дэндүү сайн санаатай хүн юм. та дуугүй байхыг бодоход хонгор Максимилиан та сайн ойлгож байх шиг байна. би тэмцэх юм гэнэ ээ! Бурхан авраг. Үгүй, үгүй. Таны хэлснээр би өөрөө өөртэйгээ тэмцэн, нулимсаа гоожуулан байхын тулд хамаг хүчээ гаргах хэрэгтэй болно. Харин эцгээ гомдоож, хөгшин эмээгийнхээ сүүлчийн мөчийг хэзээ ч гутааж чадахгүй.

- Таны хэлдэг маш зөв гэж Моррель хайнгадуухан хэлэхэд, үүнд нь гомдсон Валентина,

- Бурхан минь, та яаж ингэж ярьж байгаа юм гэж хэллээ.

- Мадмаузель таныг бахархдаг хүнхий ёсоор ярьж байна гэж Максимилиан зөрж хэлэв.

- Мадмаузель ий? Мадмаузель гэнэ ээ? Ямар хувиа бодсон хүн бэ? Намайг цөхрөнгөө бараад байгааг харж байгаа мөртлөө миний байдлыг ойлгохгүй дүр үзүүлж байх юм гэв.

- Үгүй та ташаарч байна. Би таныг дэндүү сайн ойлгож байна. Та эрхэм де Вильфортой зөрөхгүй, бэйлийн хатны үгийг дуулахгүй байж чадахгүй, тэгээд бас маргааш таныг нөхөртэй чинь холбох гэрлэлтийн баталгаанд гарын үсэг зурах гэж байгааг мэдэж байна.

- Би түүнSэс өөр яаж чадах юм бэ?

- Мадмаузель та энэ тухай надаас асуух хэрэггүй. Ыби ийч хэрэгт муу шүүгч болох учир, миний хувиа боддоJ маань намайг харалган болгочхож магадгүй гэж Моррель хариулав.

Хоолой нь зангирч, гараа зангидсаныг нь харвал улам бүр хорсон уурлаж байгаа болотой.

- Моррель, хэрвээ би таны хэлснийг хүлээн авдаг юм аа гэхэд та надад юу гэж хэлэх вэ? Хариулаач, "Та муу юм хийж байна" гэж хэлэхэд амархан. Харин чухам яавал зохих тухай зөвлөгөө өгөхөд хамаг учир оршино.

- Валентина та үнэнээ хэлж байна уу? Миний зөвлөгөөг үнэхээр дуулахсан гэж байна уу?

- Хүсэлгүй яах вэ, Максимилиан, хэрвээ сайн зөвлөгөө бол хүлээж авна. Өөрөө надад ямар үнэтэй болохоо мэднэ шүү дээ.

- Валентина, та миний энэ дүрсхийсэнд уурлахгүй гэсний баталгаа болгож гараа аль хэмээн Моррель хашааны банзыг хажуу тийш нь болгож хэлээд

- Хачин тэнэг бодол төрж, тархи толгой минь үймэрсээр бүтэн цаг болж байна. хэрэв та миний зөвлөгөөг эс дагавал... гэхэд нь Валентина,

- Тэр чинь ямар зөвлөгөө юм бэ? гэж асуув.

- За Валентина дуулж бай.

Валентина тэнгэр өөд харж санаа алдав.

- Би эрх чөлөөтэй хүн. Бид хоёрт хүрэлцэхээр баян хүн. Таныг миний эхнэр болохоос өмнө миний уруул таны магнайд ч хүрэхгүй гэж Максимилиан үргэлжлэн ярихад, Валентина,

- Надад аймшигтай байна гэж өгүүллээ.

- Надтай хамт орго. Би таныг дүү дээрээ аваачья. Таны дүү болоход тохиром сайхан бүсгүй. Дараа ь бид Алжир, Англи, эсвэл Америкт явья. Эсвэл манай танай гэр бүлийнхнийг зөөлрүүлж чадах хүртэл хөдөө нутагт нуугдаж байя гэж Моррель хэлэв.

Тэгэхэд Валентина толгойгоо сэгсэрч,

- Би тэгж хэлнэ байх гэж бодож байсан юм. энэ бол ухаан нь булингартсан хүний үг байна. тэгэхээр би таны үгийг болгоомжгүй гэдэг ганц үгээр хариулж зогсоохгүй бол би өөрөө ч бүр солиорсон хэрэг болно гэлээ.

Тэгэхэд Морсерийн царай дахин барайж,

- Та өөрийнхөө хувийг хүртээд, хувь тавиландаа захирагдан, тэмцэх гэж ч оролдохгүй нь үү?

- Тийм ээ, энэ нь намайг алах байлаа ч гэсэн тэгнэ.

- За яах вэ, Валентина таны хэлдэг маш зөв. Нээрээ ч би солиотой юм. Тачаадал гэдэг хамгийн төвшин төлөв оюун ухааныг ч гэсэн харалган болгочихдог юм гэдгийг та надад баталж өглөө. Таны имй тайван, тохитой ухааран бодож байгаад баярлалаа. За яах вэ, тэгвэл та маргааш Фроанц де Эпинегийн болзоот хүүхэн эргэлт буцалтгүйгээр болно. Тэгэхдээ энэ бол хошин жүжгийн тайлалд зориулсан гэрлэлтийн баталгаанд зохиомлоор ёс болгож үсэг зурж байгаа хэрэг биш, харин таны өөрийн тань хүсэл зоригоор болж байгаа хэрэг болно.

- Максимилиан та миний шарханд зоосон хутгыг дахин эргүүлж зовоож эхэллээ. таны дүү бүсгүй таны надад өгч байгаа шиг тийм зөвлөгөө дагавал та яах вэ?

- Мадмаузель, би таны хэлснээр хувиа хичээсэн хүн болохоор өөр хүн миний оронд байвал яах байсан бол гэж боддоггүй, харин өөрийнхөө хийх гэж байгаагаар л боддог. Би танийг таних болоод бүтэн жил болж байна. тантай танилцсан тэр өдрөөс эхлээд аз жаргалтай байх найдвар минь таний хайрын сэтгэлд дулдуйдаж байлаа. Тэгтэл ч та надад сэтгэлтэй гэдгээ хэлсэн билээ. энэ өдрөөс эхлээд ирээдүйнхээ тухай хүсэн мөрөөдөхдөө таны өөрийнхөө болно хэмээн итгэж явсан. Энд л миний бүх амьдралын утга учир байсан юм. би одоо өөр юу ч бодохгүй байна. аз жаргал минь надаас нүүр буруулжээ гэж өөртөө хэлж зогсоно. Сайн сайхан зол жаргалд хүрнэ гэж найдаж байсан минь алга болчихлоо. Тоглож байгаа хүн зөвхөн байгаа юманд алдаад зогсохгүй, харин байхгүй ч алдчихдаг нь өдөр бүр тохиолддог шүү дээ.

Моррель энэ бүхнийг их л тайван хэллээ. Валентина дэлбэрчих шахан тонгочиж буй зүрхэнд Моррелын харцыг нэвтрүүлэхгүй юм шүү гэсэн мэт дүрлийлгэн түүнийг ширтэн харна.

- Ингэхэд ер нь та яая гэж бодож байна вэ? гэж Валентина асуулаа.

- Мадмафзель тантай салах ёс гүйцэтгэх гэж байна. миний үгийг дуулж зүрхний минь гүн доторхыг уншиж байгаа дээд тэнгэр, таны намайг дурсах ч зангүй төвшин сайхан амьдарч аз жаргалтай явахыг хүсэн ерөөсний минь гэрч болог.

- Ай бурхан минь гэж Валентина шивгэнэв.

- Баяртай, Валентина баяртай гэж хэлээд Моррель гүнээ мэхийн ёслов.

Тэгэхэд бүсгүй сараалжны завсраар гараа шургуулж, Максимилианы ханцуйнаас шүүрэн авч,

- Хаачих нь вэ? гэж хашхирлаа.

Дурласан хүний нь гадна талын тайван байдал үнэнээсээ биш байхыг, өөрийн сэтгэлийн хөдөлгөөнөөр ойлгожээ.

- Одоо явж дахин танийг гэр бүлд эвгүй юм болохоос болгоомжлье. Ийм байдалд орсон үнэнч шударга хүн яах ёстойг үзүүлье.

- Салахаасаа өмнө яах гэж байгаагаар хэлээч дээ.

Моррель уйтгартайгаар инээмсэглэв.

- Хэлээч дээ, хэлээч гуйж байна гэж залуу бүсгүй шанална.

- Та санаагаа өөрчлөв үү, Валентина?

- Юугаа ч өөрчилж чадахгүй болсон захяагүй амьтан гэдгийг та мэднэ шүү дээ.

- Тэгвэл хагацъя даа.

Тэгэхэд Валентина хаалганы сараалжийг өөрөөс нь гарахын аргагүй хүчээр сэгсчив. Моррель цааш явсаар байтал бүсгүй хойноос нь гар сунган дуу алдан,

- Та яах гэж хүсэж байна? Би мэдмээр байна. Та хаачих нь вэ? гэв.

- Бүү санаа зов гэж Максимилиан зогсож – Би золгүй хувь заяаныхаа төлөө өөр хүнийг хариуцлаганд унагахыг хүсэхгүй. Надаас өөр хүн бол де Эпине дээр очно, хэрүүл өдөж ирүүл тулаанд дуудна гэж таныг айлгах байсан биз... Энэ бол тэнэг явдал. Де Эпине энд ямар хамаатай юм бэ? тэр өнөө өглөө л анх намайг харсан, одоо бол намайг харснаа мартчихсан яваа. Тэр ч байтугай танай хоёр гэр бүл та хоёрыг сүй тавилцуулахаар шийдвэрлэж байх үед ийм хүн хорвоод байдаг гэж мэдээ ч үгүй явсан. Тийм учраас тэр нада огтхон я хамаагүй, би түүнтэй тооцоо бодохгүй гэдгээ танд тангараглая.

- Тэгээд хэнтэй хийх гэж? Надтай юу?

- Валентина тантай юу? Бурхан минь! эмэгтэй хүн гэдэг ариун зүйл. Дурласан хүүхэн гэдэг бол ариунаар зогсохгүй гэгээн шүтээн.

- Тэгвэл солиотой амьтан минь өөрөө өөртэйгээ т@оцоо хийх нь үү?

- Би л бүх юманд буруутай юм чинь дээ гж Моррелийг хэлэхэд Валентина,

- Максимилиан нааш ир би шаардаж байна гэв.

Максимилиан зөөлнөөр инэмсэглээд ойртон ирлээ. Хэрвээ царай нь цонхигор биш байсан сан бол түүнд ямар ч явдал тохиолдоогүй юм байна гэж болохоор байв.

- Хайрт хонгор Валентина минь миний хэлэх үгийг сонсож бай гэж уянгалаг зөөлөн дуугаар хэлээд – хүмүүсийн өмнө эцэг эхийнхээ өмнө, бурхны өмнө царай улайх нэг ч бодол дотроо агуулж яваагүй. Та бип хоёр шиг ийм улс бие биенийхээ зүрхэн доторхыг дэлгэсэн ном шиг уншиж чадна. Би ромэны хөөргөн баатар ч биш, доожоогүй баатар ч биш, өөрийгөө Манфред Антони болгож боддоггүй хүн. Гэвч би танд итгүүлэх гэж илүү дутуу тангараг өгөлгүйгээр зүгээр л амьдралаа танд өгссөн. Одоо та надаас хөндийрч явлаа. Ийм ч эрхтэй. Би түүнийг танд түрүүн хэлсэн одоо ч хэлчихье. Та надаас нэгэнт зайлж яваа болохоор би энэ ертөнц дээр ганцаараа үлдлээ. Дүү минь хүнтэй суугаад их л баяр жаргалтай байдаг. Түүний нөхөр нь нөдтөй нийгмин ёс заншлаар холбогдсон хүргэн дүү юм. тэгэхээр одоо миний энэ ашиггүй амьдрал одоо хэнд ч хэрэггүй, би ингэх санаатай байна. таныг гэрлэх ёслолоо хийх мөч хүртэл чинь хүлээж баях болно. Заримдаа азтай учралд хүргэж болдог тохиолдлын сүүдрийг ч алдаж өнгөрүүлэхгүйг хичээе. Үэн хэрэг дээрээ энэ завсар Франц де Эпине үхчихэж болно. Эсвэл сүмийн шүтээнд мөргөх гээд ойртон очтол чинь сүмийн шүтээнийг тэгэр ниргэчихэж болох юм. хороох ял шйтгүүлсэн хүнд бүх юм гордлоготой, тэр бүү хэл аврагдах боломжтой ч юм шиг санагддаг. Тэгэхээр би сүүлчийн минутыг хүртэл хүлээх болно. Тэгээд байдал засаж сэргээхээр найдваргүй болж өнгөөрчихвөл хүргэн ба цагдаагийн газрын дарга хоёрт нууц захиа бичиж, өөрийнхөө бодлын тухай мэдэгдээд ойд ямар нэг гуу жалга, голын эрэг дээр очиж өөрийгөө буудна. Хэзээ нэгэн цагт Францад амьдарч байсан хүү би мөн гэдэг шиг, миний энэ хэлж байгаа зүйл үнэн шүү.

Валентинагийн хамаг бие чичрэн доглов. Тэгээд барьж байсан сараалжаа тавиад амьгүй юм шиг гараа унжуулахад том том дусал нулимс хацрыг нь даган урслаа.

- Өрөвдөөч, өрөвдөөч, өөртөө бүү хүрээч, үгүй биз дээ? гэж Валентина үглэнэ.

- Нэр төртэй үхнэ гэдгээ тангараглая. Гэхээд энэ маань танд ямар хамаа байна? Та өөрийнхөө үүргийг гүйцэтгэсэн болооор танд санаа зовох юмгүй, сэтгэл чинь ариун байна шүү дээ гэж Максимилиан хэлэв.

Валентина элгээ тэврэн сөхрөн суухад зүрх нь дэлбэрэх шахаж байв.

- Максимилиан найз минь, газар дээрх ганц ах минь. Тэнгэрт очиход үнэнч хань минь, над шиг л зовж шаналаад амьд явж үзээч, бид хоёр нийлэх цаг ирж магадгүй шүү дээ гэж Валентинаг хэлэхэд Моррель,

- Баяртай, Валентина! Гэв.

Валентина хэлэхийн аргагүй тийм царай гаргаж, гараа дээш өргөн,

- Бурхан минь, би чадах бүхнээ л хийж, гуйж гувшиж, харааж зүхэж элдвээр оролдсон боловч миний гуйж, гувших, нулимс гаргахын алийг ч аав минь тоосонгүй. Би нүглээ наманчилж үхэхийн оронд ичиж үхсэн минь дээр гэж үзэж байна. Максимилиан, чи минь амьдарч үз. Би зөвхөн чинийхээс өөр хэнийх ч болохгүй. Хэзээ вэ? Одоо юу? Хэлээч, тушаагаач, би бэлхэн байна гэв.

Хэдийнэ хэдэн алхам холдсон Моррель баярласандаа болж царай нь цайран, харц нь тунгалаг болж буцаж ирээд сараалжны завсраар Валентинад гараа өгч,

- Хайрт найз минь, надтай тэгж ярих хэрэггүй. Хэрвээ тийм бол би үхсэн нь дээр. Би танд дурладаг шиг та надад дурладаг бол би таныг хүчээр аваачихын хэрэг юу байх вэ? Эсвэл та намайг зөвхөн өрөвдөөд л амьд байлгах гэж байна уу? Хэрвээ тийм бол би үхэхийг илүүд үзнэ шүү гэв.

- Үнэндээ энэ орчлонд ганц хэн надад дурлаж байна вэ? Зовж зүдэрч явахад минь хэн тайвшруулж байв? Энэ л хүн. Миний бүх итгэл найдвар хэнд байж, самгардсан харц минь хэн дээр тусаж, ядарч зүдэрсэн зүрх минь хэн дээр ирэхээр тайвширдаг билээ? Түүн дээр, ганцхан түүн дээр гэж Валентина аман дотроо шивэгнээд-- Чиний хэлдэг бас зөв. Би чамайг дагаж явъя, төрсөн гэрээ орхино, бүгдийг нь орхино...Бүгдийг! Би яасан хүний ачийг санадаггүй мөсгүй амьтан бэ? Өвгөн ааваа бүр мартчхаж! Гэж Валентина ухилан хэллээ.

- Үгүй шүү, чи тэр хүнийг орхихгүй. Эрхэм Нуартье надад талтай байдаг гэж Ia ярьсан шүү дээ. Тэгэхээр чи зугтахаасаа өмнө бүхнийг түүнд яриарай. Түүний зөвшөөрөл нь бурхны өмнө чамд хамгаалалт болно. Та бид хоёрыг суусны дараа тэр манайд хүрч ирнэ. Хоёр ачтай болно. Тэр чамтай яаж харилцан ярилцдаг тухай чи надад ярьсан. Би тэр сэтгэл хөдлөм дохиог амархан сурна. Валентина минь, гай зовлонгийн оронд аз жаргалтай амьдарна гэдгийг би чамд амлая!

- Максимилиан чи надад ямар их нөлөөтэйгөө харж байнау? Би чиний хэлж байгаад итгэхэд бэлэн байна, гэхдээ л бодлогогүй явдал болно доо. Эцэг минь намайг харааж

зүхнэ. Би түүнийг сайн мэднэ. Түүний зөөлрөшгүй зүрх хэзээ ч намайг уучлахгүй. Максимилиан миний хэлэхийг сонс. Би залилж мэхлээд ч юм уу, гуйж гувшаад, эсвэл аз завшаан тохиолдоод, ер нь ямар нэг аргаар хурим хийх хугацааг хойшлуулж чадвал чи намайг хүлээх үү?

- Би тангараглая, харин таныг хүчээр хотын даргад, ламд аваачдаг байлаа ч гэлээ тэр аймшигт гэрлэлт болохгүй гэдгийг, чадахгүй гэж хэлнэ гэдгээ надад амлаач.

- Ингэж тангараглая, Максимилиан. Энэ орчлон дээрх хамгийн ариун гэгээн зүйл болох ээжийнхээ нэрийг барьж тангараглая.

- Тэгвэл хүлээнэ гэж Моррель хэлэв.

- Тэгье, хүлээе. Бидэн шиг хөөрхий болсон амьтдыг аврах юм олон байгаа л даа, гэхдээ зүрх нь жаал тайвшрав.

- Валентина, би танд найдаж байна. Таны хийх гэж байгаа бүхэн чинь сайн юм болно. Харин таны гуйлт хүсэлтийг ойшоож үзэхгүй дүлий юм шиг Үайвал, хэрвээ танай эцэг, хатагтай Сен-Меран хоёр д'Эпинег маргааш ирүүлж гарын үсэг зуруулахаар шаардвал... гэхэд нь

- Тэгвэл Моррель... би танд ам өгсөн шүү дээ гэв.

- Гарын үсэг зурахын оронд...

- Би тан дээр хүрч ирээд хоёулаа хамт оргоно. Тэр болтол уулзахаа больё. Биднийг олж харчхаагүй нь бурхны аврал. Та бид хоёрын яаж уулздагийг мэдчихсэн бол ч ямар ч найдваргүй болох байсан шүү.

- Валентина таны хэлдэг зөв. Харин би яаж мэдэх вэ?...

- Нотариус Дешанаар дамжуулж мэдээрэй.

- Би түүнийг танина.

- Надаас ч бас мэдэж аваарай. Би танд бичнэ, заавал бичнэ. Бурхан минь, би тэр хүнтэй суухыг тан шиг л үзэн ядаж байна!

- Баярлалаа, хонгор Валентина минь. Тэгвэл бүхнийг шийдчих шив дээ. Таныг хугацаа хэлмэгц л би наашаа давхиад л ирнэ. Танийг хашаа давангуут л, энэ амархан л даа, би таныг гар дээрээ тосоод авамз, ногооны хашааны үүдэнд сүйх тэрэг хүлээж байх болно. Хоёул суугаад би таныг охин дүү дээрээ аваачна. Тэнд бид нэг бол нүднээс далд байж, эсвэл нуугдахгүй байсан ч болно. Таны хүслээр л болох хэрэг. Тэнд бид өөрсдийн эрхийг аз жаргалд хүрэх хүсэл зориг төгс байгаагаа үзүүлж, санаа алдахаас өөр хамгаалах юмгүй хурга шиг бөөрөө гаргуулахгүй шүү.

- Хэлснээр чинь болог, Максимилиан минь, таны хийх гэж байгаа бүх зүйл бүтэмжтэй сайн болно гэж би бас хэлчихье хэмээн Валентина өгүүлэв.

- Хонгор минь!

- За эхнэр чинь таны сэтгэлд таалагдав уу? гэж бүсгүй гунигтай хэлэв.

- Хайрт Валентина минь, тийм гэж хэлэхэд ч багадаж байна.

- Гэсэн ч хэлж байх шив дээ.

Валентина уруулаа сараалжинд ойртуулахад түүний үг, зөөлөн амьсгалын нь хамт сараалжийн нөгөө талаас хүйтэн төмөрт уруулаа наалдуулсан Моррелийн хошуунд хүрлээ. Валентина энэ аз жаргалаас арай гэж салж,

- Баяртай! Баяртай! гэж хэллээ.

- Танаас захидал хүлээж байх уу?

- Тэгээрэй.

- Хайрт эхнэр минь, баярлалаа, баяртай!

Агаарт хий үнэсэх чимээ гарч, Валентина далдуу модот гудамжаар гүйн одлоо.

Моррель дашинзны нь бутанд нь шүргэхийг, хөлийн нь доор элс чийхарахыг намдтал чагнан зогслоо. Дараа нь үгээр гаргахын аргагүй сэтгэл тэнийсэн байдалтай инээмсэглэн тэнгэр өөд харж, ийм дурлал заяасанд нь баярласнаа илэрхийлээд мөн гэр уруугаа явав.

Гэртээ ирээд бүх л оройгоо маргааш өдөр нь бүтэн хүлээсэн боловч ямар ч мэдээ авсангүй. Зөвхөн нөгөөдлөр өглөө нь арван цагт Дашеныд очихоор гарах гэж шуудангаар бичиг ирснийг хүлээн авч хэдийгээр Валентинагийн бичгийг танихгүй боловч түүнээс ирснийг андахгүй мэджээ.

Зурвас дотор ийн бичжээ.

“Гуйж, гувшиж, уйлж, унжсан минь огт тус болсонгүй. Би өчигдөр гэгээн Филипп Рулийн сүмд хоёр цаг байж, бүтэн хоёр цагийн турш бурханд гуйж мөргөлөө. Гэтэр бурхан ч бас хүмүүсийн адил гуйвшгүй байна. Өнөө орой есөн цагт баталгаанд гарын үсэг зурна.

Моррель би зүрхнийхээ үнэнчийн адил хэлсэн үгэндээ үнэнч шүү. Энэ үгийг би танд хэлсэн, энэ зүрх ч бас таных!

За орой болтол баяртай. Есөн цагт арван таван минут дутуу байх д сараалжны дэргэд уульзья.

Таны эхнэр

Валентина де Вильфор

Жич: Хөөрхий хөгшин эхийн бие улам муудаж байна. өчигдөр хөөрснөөсөө болоод бүр дэмийрч, ухаан санаа нь элий балай болж байна.

Би түүнийг ийм байдалтай орхиж гарснаа мартахаар та надад хайр сэтгэлтэй байна биз?

Өнөө орой гарын үсэг зурна гэдгийг өвгөн аав Нуартъезд хэлэлгүй нууж байх шиг байна.” гэжээ.

Моррель Валентинагаас авсан мэдээгээр хязгаарласангүй, нотариус дээр очвол цаадах нь түүнд өнөө орой есөн цагт баталгаанд гарын үсэг зурна гэдгийг хэлжээ.

Дараа нь Монте-Кристогийнд очиж тэндээс улам ч тодорхой зүйлийг мэдэж авав. Франц баяртай явдлаа хэлэх гэж гүн дээр иржээ. Хатагтай Вильфор ирүүлсэн зурвасандаа гүнгээс урихгүйг байгааг уучлахыг хүсээд, өвгө Сен-Меран нас барж бэлэвсэн эхнэр нь өвчтэй байгаа явдал баяр хөөрийг уйтгар гунигаар бүрхүлж байгаа болохоор үргэлж сайн сайхныг хүсэж явдаг гүнгээ ийм юман дээр оруулахыг хүсэхгүй байна гэжээ.

Өмнөхөн нь Францыг хатагтай Сен-Меран дээр оруулж танилцуулахад хатагтай орноосоо боссон боловч дараа нь дахин хэвтжээ.

Моррелийн сэтгэл маш их хөдөлсөн байгааг гүгийн хурц нүд яаж ажиглахгүй байж чадах билээ. тиймээс ч гүн түүнтэй урьдынхаас илүү эелдэг зөөлөн байсан агаад тэр ч байтугай Максимилиан бүх юм аа илчилчихдэг юм билүү гэтэл нь эелдэг байв. Гэвч Валентинад ам өгснөө санаж нууцаа зүрхнийхээ угт хадгалаад үлдэв.

Максимилиан Валентинагийн захидлыг өдөртөө хориод удаа угшжээ. Түүнд Валентинагийн бичсэн анхны захидал, тэгээд ямар юмны тухай гэж санана. Максимилиан унших бүрдээ Валентинаг зол жаргалтай байлгана гэж өөртөө танараглаж байв. Үнэндээ ч ийм зоригтой юм хийж байгаа бүсгүй сэтгэлтэй залуудаа ямаршуухан эрх мэдэлтэй байх нь мэдээж хэрэг. дурлалт хүүн сэтгэлт бүсгүйдээ маш халуунаар мэхийн ёслох ёстой. Тэр бүсгүй бол түүний эзэн хаан, эхнэр нь бөгөөд ач тусыг нь хариулж, дурлаж хайрлахад орчлонгийн нэг нас багадаа ажээ.

Валентина хүрч ирээд “За би ирлээ. Максимилиан би таных болсон” гэж хэлэх тэр минутын тухай сэтгэл хөдлөн бодно.

Тэрээр орлуулах бүх зүйлийг бэлтгэж ногооны газар царгасны дунд хоёр шат нууж, Максимилиан өөрөө жолоодох хөнгөн тэрэг бэлхэн зогсоно. Зарц авахгүй, гэрэл асаахгүй. Дэндүү болгоомжилж байгаад цагдаагийн газарт орчихгүйн тулд булан тойроод дэнгээ асаахаар бэлтгэжээ.

Моррелийн зүрх байн байна чичирнэ. Моррель Валентинад хашаа давахад нь тусалж, урьд зөвхөн хурууны нь үзүүрийг үнэсэж гарыг нь барихаас хэтрээгүй, одоо бол чичрэн догдолсон эмзэг биеийг тэврэх тэр минутын тухай бодож байв.

Өдөр дунд өнгөрөөгөөд болзсон цаг ойртмогц ганцаараа баймаар санагджээ. Зүрх нь хөөрч, ямар ч асуулт, найз нөхдөйн тухай дуу ч зэвүүг нь хүргэж байв. Ном унших гэж оролдон өрөөндөө ороод түшжиж авчээ. гэвч номын мөрөнг дээгүүр хий дэмий л нүд гүйлгэнэ. Тэгэхээр нь номоо шидчихээд орлуулах ажлаа нарийвчлан бодож гарав.

Болзсон цаг ойртсоор байв.

Сэтгэлтэй болчихсон хүн цагийн зүүг тайван явуулж байсан удаа хэзээ ч байхгүй. Моррель цагаа хайр найргүй шамдуулж, орой зургаан цаг болж байхад цаг нь найман цаг хагасыг зааж байв. Тэгэнгүүт Моррель явах боллоо гэж өөртөө хэлэв. Гарын үсэг есөн цагт зурах боловч Валентина тэр дэмийн юмыг хүлээжсуухгүй байлгүй гэж боджээ. Тэгээд өөрийн цагаар найм хагаст Меле гудамжнаас гарч ногоонылоо газарт хүрч ирлээ. Тэр үед нь Филипп Рулийн сүмийн цаг найм цохилоо.

Морь тэргээ өөрийнхөө нуугддаг эвдэрхий оромжныхоо цаана нууж орхив.

Бага багаар бүрэнхй болж цэцэрлэгийн өтгөн навчит модод бөөн бараан дүрс болж харагдана.

Тэгэнгүүт Моррель нуугдсангазраасаа гарч зүрх нь цохилон салаалжны завсраар харлаа. Цэцэрлэг дотор улам харанхуй боллоо. Найман цаг хагас цохилоо.

Дахин хагас цаг хүлээлээ. Моррель хашааны завсраар байна байна харж хойш урагшаа алхална. Цэцэрлэг дотор улам харанхуй боллоо. Харанхуй дунд цагаан дашинз харагдаж, чимээ аниргүйн хөлийн чимээ гарахыг дэмий л хүлээнэ.

Моддын цаагуур харагдаж байга байшин ч мөн гэрэлгүй байгаа нь энд гэр бүл болохын баталгаадн гарын үсэг зурах чухал хэрэг явдал болох гэж байгаагийн шинж тэмдэг огтхон ч үгүй байлаа.

Моррель цагаа гаргаж харав. Арван цагт арван таван минут дутуу байлаа. Гэтэл сүмийн цаг есөн цаг хагас болсныг зарлан Морелын цаг буруу байгааг мэдэгдлээ.

Валентинагийн тогтоосон цагаас хагасцаг өнгөрчээ. валентина түүнийг есөн цагт, тэр ч байтугай жаахан урьд ирээрэй гэж хэлсэн билээ.

Энэ бол Моррельд хамгийн хэцүү мөч байлаа. Секунд бүр түүний зүрхийг тугалга алхаар цохих мэт санагдана.

Навчис өчүүхэн төдий хөдлөх, салхи сэвс хийх нь түүнийг цочоож, духанд нь хүйтэн хөлс чийхарна. Хамаг бие нь чичрэн салганасан амьтан нэг ч минут алдахгүй тулд шатаа түшүүлэн тавиад доод талын хөндөл дээр хөлөө тавьж бэлэн зогслоо.

Ийнхүү айж тэвдэн найдаж горьдон ацан шалаанд байтал сүмийн цаг арван цаг болсныг мэдэгдэв.

- Хачин юм. гарын үсэг зурах ёслол тийм удах ёсгүй. Өөр юм болсон юм биш байгаа даа. би бүхнийг цэгнэн үзэж хичнээн минут эзлэхийг ч бодож үзсэн юмсан. Нэг жиг ургалаа шүү гэж Максимилиан айж сандран шивгэнэв.

Сэтгэл нь хөдлөн нааш цааш хөлхөхдөө заримдаа шатах гэж байгаа духаа хүйтэн төмөрт нааж зогсоно. Валентина гарын үсэг зурчихаад ухаан алдаад уначихаа юм болов уу? Оргохоор завдаж байхад нь бариад авсан юм биш байгаа даа. моррелийн таамаглах нь энэ хоёрхон л байлаа. Гэхдээ л түүнийг цөхрүүлнэ.

Эцэст нь Валентинаг оргож явахад нь тамир нь б рагдаж цэцэрлэг дотор хэвтэж байгаа юм биш биз? гэдэг бодол төрлөө. Тэгэнгүүт шатан дээш авирангаа,

- Хэрвээ тэгсэн байвал би өөрийнхөө муугаас болж би түүнийгээ алдах болох нь ээ? гэж бодлоо.

Энэ бодлыг түүнд шивнэж өгсөн шулам чихэнд нь улам шаргуу шивнэсээр хэдэн минутын дараа нөгөө тааж ядаж байсан зүйлийг нь үнэн бодит зүйл мэт санагдуулж чаджээ. Улам өтгөрч байгаа харанхуй өөд ширтэх тутам харанхуй модон доторх замын элсэн дээр нэгэн цагаан юм хэвтэж байх шиг харагдав. Тэр ч байтугай Моррель зүрх гаргаж дуу өгвөл гинших мэт дуу салхинд дуулдах шиг болов.

Арван цаг хагас цохив. Одоо үүнээс цааш хүлээхийн аргагүй. Энэ завсар юу ч болсон байж болно. чамархай нь дүнгэнэж нүд нь бүрэлзэнэ. Тэгээд хашаан дээгүүр давж газарт үсэрлээ.

Тэрээр Вильфорын сэй орчих нь тэр. Энэ вдал юунд хүргэж болохыг урьдаас төсөөлж байсан хэдий ч буцаж ухарья гэсэндээ ийм юм хийсэнгүй.

Хана дагаж нэлээд явснаа модот гудамжаар жаар гүйж өтгөн мод уруу орлоо. Нүд ирмэхийн зуур дундуур нь гарснаа байшин харагдаж байгаа газарт хүрч очив.

Сэжиглэн байсан зүйлээ одоо бүрэн итгэж, цэцэрлэгийн шугуй дундуур нэвт харахыг оролдоно. Баярын өдөр байвал зохих хурц гэрэтэй цонхнууд сарны гэрлийг халхалсан том гэрэлд дайрагдсан бөөн бүдэг саарал юм харагдана.

Зөвхөн хоёрдугаар давхрын гурван цонхонд бүдэг гэрэл гялбалзах нь хатагтай Сен-Мераны өрөөний цонх байлаа.

Улаан хөшийгний цаана жигдхэн гэрэл асаатай байгаа нь хатагтай Вильфорын унтлагын өрөө ажээ.

Моррель энэ бүхнийг таасан байлаа. Валентинагийн хаана юу хийж буйг санасандаа дүрсэн бодоох гэж байшингийн дотоод зохион байгуулалтыг нь нарийвчлан асууж мэдсэн учир хэзээ ч орж байгаагүй ч гэсэн сайн мэдж байв.

Энэ чимээ аниргүй харанхуй нь Валентина ирээгүйгээс илүү Моррелийг айлгаж байлаа.

Уйтгар гунигаасаа болж ухаан нь балартсан амьтан Валентинаг харж чухам ямар болохыг тухайлан мэдэхгүй ч тааварлаж байгаа зол завшаангүй явдалд итгэхээс нааш эндээс явахгүй гэж шийдэв. Тэгээд төглийн захад хүрч, тал бүрээс ил, цэцгийн хүрээлэнг өнгөрөн гарах гэж завдал хүн ярилцах нь сонстлоо.

Тэгэхээр нь дахин бут уруу ухраад харанхуйд нуугдан чимээгүй зогсов.

Валентина бол хажуугаар өнгөрөхөөр нь дуудья гэж шийдэв. Хэрвээ хүнтэй хамт байвал ямар ч байсан муу явдал тохиолдоогүйг нь мэднэ. Огт өөр хүн байвал тэдний ярианаас ямар нэгэн зүлийг мэдэн авч үл ойлгогдох нууцыг тааварлаж болно.

Энэ завсар үлэн чөлөөгөөр сар цухуйж шатан дээр Вильфор хар хувцастай хүнтэй хамт гарч ирэх нь харагдав. Тэр хоёр шатаар буугаад модот гудамжны зүг явав. Моррель хар хувцастай хүнийг эмч де Авриьни байна гэж танив.

Өөрийн нь чиглэн ирж явааг хараад Моррель өөрийн эрхгүй ухарч бутан дунд ургасан агч модонд тулж зогсохоос өөр аргагүй боллоо.

Удалгүй эмч Вильфор хоёрын хөл доор элс шаржигнахаа болив.

- Тийм ээ, эмч минь. бурхан бидэнд хилэгнэчихжээ. Ямар аймшигтай үхэл вэ. Ямар айхтар юм болов? Намайг тайтгаруулж тайвруулах гэж бүү оролд, шарх дэндүү шинэ, дэндүү гүн байна. Үхчихлээ шүү дээ үхчихлээ гэж вангийн рокурор хэлэхэд Максимилианы духанд хүйтэн хөлс чийхарч шүд нь тачигналаа. Вильфор өөрөө ч нүгэлтэй гээд байгаа энэ байшинд хэн үхчихээ юм бол?

- Эрхэм де Вильфор би таныг тайтгаруулах гэж энд авчраагүй гэж эмчийн хэлэхэд Моррель улам ч ихээр айв.

- Та юу гэх гээ вэ? гэж Вильфор айн асуухад,

- Та нарт тохиолдсон золгүй явдлын араас улам ч илүү золгүй явдал тохиолдож болох юм гэж хэлмээр байна.

- Бурхан минь, та өөр юу хэлэх гээд байна? гэж прокурорыг гараа базлан шивнэхэд эмч,

- Биднээс өөр хүн энд айхгүй биз? гэж эмч асуув.

- Байхгүй ээ, юунд ийм бролгоомжлол хэрэгтэй болов?

- Танд нэгэн аямшигтай юм хэлэх гэсэн учраас тэр. Алив сууя.

Вильфор сандал дээр суух ч дээ бүр унаад өгөв. Эмч суусангүй өмнө нь зогсоод мөрөн дээр нь гараа тавьлаа.

Моррель айснаасаа болоод бие нь хүйт оргиж зүрхийх нь цохилтыг дуучих вий хэмээн нэг гараа духан дээрээ тавьж нөгөө гараараа зүрхэн дээрээ дарав.

“Үхчихлээ! Үхчихлээ!” гэдэг үг толгойд нь орж ирнэ. Моррель өөрөө л үхэж байгаа юм шиг санагджээ.

- Эмч минь, ярь ярь. Би ямар ч муухай юм дуулсан дааж өнгөрөөхөд бэлэн айна гэж Вильфор хэлэхэд,

- Хатагтай Сен-Меран тмй залуу хүн байгаагүй нь мэдээж хэрэг. гэвч их сайн биетэй хүн байсан юм.

Энэ арван минутын дотор Моррель анх удаа чөлөөтэй амьсгаа авав.

- у© гашуу түүнийг алчихав аа, эмч ээ... Тэр өвгөнтэйгээ дөчин жил хамт амьдарсан... гэж Вильфор хэлэхэд эмч,

- Эрхэм нөхөр минь. уй гашууд учир нь байгаа юм биш. Уй гашуу хүнийг алах нь байдаг боловч тун ховор. Уй гашуу бол хүнийг нэг өдрийн дотор арван минутын дотор алчихдаг юм биш ээ гэв.

Вильфор юу ч хэлсэнгүй харин анх удаа толгойгоо өндийлгөн эмч өөд асуух мэт харлаа.

- Таталдаж амьсгаа хурааж байх үед нь та дэргэд нь байсан уу? гэж дде Арвинь асуухад Вильфор,

- Тэгэлгүй яах вэ, та намайг битгий гараарай гэж шивгэнэсэн шүү дээ гэв.

- Та хатагтай Сен-Мераны үхэлд хүрсэн өвчний гадаад шинж тэмдгийг ажиглав уу?

- Тэгэлгүй яах вэ. хатагтай хэд хэдэн минутын завсарлагатайгаар гурван удаа ухаан алдаж унасан. Унах бүр хоорондох зай нь багасаж улам хүнд болж байсан. Таныг ирэхэд амьсгаа нь давхцаж эхэлсэн. Дараа нь ухаан алдахад би зүгээр л мэдрэлийнх байх гэж бодсон. Тэгээд ер бусын хүч гаргаж хүзүү мөч нь татан орон дээр өндийхөд би үнэхээр санаа зовсон. Таны царайг хараад миний бодож байснаас илүү ноцтой юм болж багшааг мэдсэн л дээ. энэ дайрлага өнгөрсний дараа тань руу харвал, та над өөд харж өгсөнгүй. Та судасны нь цохилтыг тоолж байтал, хоёр дахь дайрлага дайрч та над өөд харатай манатай байсан энэ ч их аймаг байсан. Өнөө л янзаараа давчдан сарвалзаж, уруул нь хөхөрч татваганан эхэлж, гурав дахь дайрлагын үед нас барсан. Нэгдүгээр дайрлагын дараа л би татран өвчин гэж бодсон. Та ч тэгж хэлээ биз дээ.

- Тийм ээ, бусад хүмүүсийн дэргэд тэгж хэллж байсан юм. харин одоо бол та чид хоёр хоёулханаа байна гэж эмч хэлэв.

- Та надад юу хэлэх гээд байна?

- Татран өвчин ба ургамалын хорны хордлого хоёрын гадаад шинж нь тун адил байдаг юм.

Ингэж хэлэхэд Вильфор ухасхийн босоод минут хир хөдөлгөөнгүй зогссоноо дахин сандал дээр уналаа.

- Бурхан минь, эмч та юу ярьж байгаагаа ойлгож байна уу? гэж Вильфор хэллээ.

Энэ бүхэн зүүд үү, эсвэл үнэн үү гэдгийг мэдэхгүй байв.

- Миний хэлж байгаа зүйл хичнээн ноцтойг мөн хэнд хэлж байгаа би мэдэж байна гэж эмч хэлэв.

- Та одоо албаны хүнтэй ярьж байна уу? эсвэл найз нөхөртэйгээ ярьж байна уу? Хэнтэй нь ярьж байна? гэж Вильфор асуув.

- Найзтайгаа, одоо зөвхөн найзтайгаа ярьж байна. хөших өвчин ба ургамлын хорны хордлогын гадаад шинж тийм их адил байдг учраас би хэлж байгаадаа гарын үсэг зурна гэвэл эргэлзэх юм алга байна. би одоо албани хүнд биш найздаа хэлж байгаа

юм гэдгийг давтан хэлье.би дөчин таван минутын турш өвчний байдлыг амь тавин варчлах хатагтайн нас барахыг ажиглан харлаа. Тэгэхээл хатагтай хорлогдож үхсэнд итгээд зогсохгүй ямар хороор хорлогдсоныг нь хэлж чадах байна.

- Эмч ээ? эмч ээ?

- Бүх байдал нь илэрхий харагдаж байв. Дайрлагын хоорондох нойрмог байдал, тархины хэтэрхий их хөөрөл, сэдрэлийн төвүүд нь хөшсөн зэргээс тодорхой байна. хатагтай өөрт нь санамсаргүйгээр андуурч өгсөн ч байж мэдэх гожил ч юм уу хүнцлээр хорджээ.

Вильфор эмсчийн гарыг шүүрэн барив.

- Ай энэ бол байж болохгүй! Бурхан минь энэ чинь зүүд байна! Зүүд байна. тан шиг хүн ийм юм ярьж байх нь ээ! эмч та андуурч ташаарч болох биз дээ?

- Тэгж болох л юм гэвч...

- Гэвч, тэгээд?

- Гэвч би тэгж бодохгүй байна.

- Эмч ээ, намайг өрөвдөөч. Сүүлийн өдрүүдэд дуулдаагүй хачин явдлууд болж ухаан солиорчих бий ч гэж айж байна.

- Надаас өөр ямар нэг хүн хатагтай Сен-Мерантай уулзсан уу?

- Хэн ч үгүй.

- Надад жорыг нь үзүүлэхгүйгээр эм авахуулахаар эмийн санд хүн явуулсан уу?

- Үгүй.

- Хатагтай Сен-Меранд дайсан байсан уу?

- Би л мэдэхгүй юм байна.

- Үхээсэй гэж хүсэх хүн байсан уу?

- Бурхан минь. Үгүй дээ, үгүй. Миний охин түүний ганц өв залгамжлагч нь байгаа юм. валентина ганцаараа... Үгүй би тийм бодол эгшин зуурын дотор ч гэсэн дотроо агуулж гэмээнэ өөрийн зүрхэнд хутга шаана.

- Найз минь, бурхны аврал. Би хэнийг ч сэжиглэх гээгүй байна. би зөвхөн андуу ташаагаас болж тохиолдсон золгүй явдлын тухай ярьж байна. санамсаргүй тохиолдол байсан ч үгүй ч баримт нь илхэн байна. тэр баримт минЕй хүнч сэтгэлийг хөндөж, энэ ма нь намайг энэ тухай танд сайн хэлж өгөхийг шаардаж байна. санй лавлаарай та.

- Хэнээс, яаж? Юун тухай?

- Жишээлбэл хөгшин зарц Барруа эзэнд нь өгсөн ямар нэг эмнээс хатагтайд өгчихсөн юм биш биз?
- Миний аавд бэлтгэсэн эмнээс үү?
- Тийм ээ.
- Гэхдээ эрхэм Нуартъед бэлтгэж өгсөн эмнээс уугаад хатагтай яахаараа хорддог билээ?
- Маш амархан. Зарим өчнийг эмнэхэд, хор эм болдгийг та мэднэ дээ. Саа өвчин ийм өвчний нэг юм. Би гурван сарын өмнө эрхэм Нуартъе хөдөлж, ярих чадвар олгохын тулд сүүлчийнхээ аргыг хэрэглэж, гурван сарын турш бруцин хэмээх гожилоор эмнэж байгаа юм. Ингэхээр сүүчийн удаа бичиж өгсөн эмэнд зургаан центгармм гожмил орж байгаа юм. энэ бол саа өвчинд дайрагдаж эмэндээ дасал болсон өвчтөний биенд хор болохгүй бөгөөд, харин өөр хүнийг бол дор нь алчихна.
- Хатагтай Сен-Меран эрхэм Нуартъе хоёрын тасалгаанд ямар ч харьцаа байхгүй. Хадмын өрөөнд Барруа нэг ч удаа ороогүй. Би таныг хамгийн их юм мэддэг гол нь энэ дэлхий дээр хамгийн сайхан сэтгэлтэй гэж боддог. Амьдралд тохиолдсон бүх явдалд таны хэлсэн үг надад нар мэт гийгүүлж ирсэн. Би танд хэдийгээр итгэх боловч “Хүг ташаарч болно” гэдэг үгийг хэлчихмээр санагдаад байх юм.
- Вильфор та миний нөхдөөс хэнд нь над шиг итгэдэг вэ? гэж эмч асуув.
- Та юунд асууж байна? Та юу Jэх гээ вэ?
- Түүнийгээ дуудуул. Би үзсэн харсан бүгдийг хэлж хамт задлан шинжилJээ хийе.
- Хорын ул мөр олдох уу?
- Үгүй, хор о«дохгүй л дээ. гэхдээ мэдрэлийн систем нь цухалдан багтарч үхсэн байдлыг нь зайлшгүй илрүүлнэ. Тэгээд танд “Эрхэм Вильфор хэрвээ энэ ядал салан задгайаас болсон бол зарц нараа ажиглан харж бай. Хэрвээ үзэн ядахаас ийм байдалд хүрсэн бол дайснуудаа сайн мөрдөж мөшгиж бай” гэж хэлэх болно доо.
- Авринь та ярьж байгаа юм аа бодооч? Нууцыг танаас өөр хүн мэдэхэд хүрч, мөрдөн мөшгих хэрэг болоход би өөрөө мөрдөнө гэдэг нь санашгүй зүйл. Гэвч гээд вангийн прокурор тавгүй байдлаар түгдчин эмч өөд харж – Хэрвэ та тэгж их хүсээд байвал би санаснаар чинь болгож өгье. Нээрээ ч би үүнийг хийгээд үзэж болох юм. байдал үүнийг шаардаж байна. эмч минь бүр туйлдаж гүйцлээ. Имй уй гашууны дараа ийм будлиан хийх гэдэг хэцүү еэ! Эхнэр охин хоёр минь тэсвэрлэн давж чадахгүй. Миний тухайд гэвэл одоогийг ийм байдалд хүрч вангийн прокурорын ажлыг хорин таван жил тасралтгүй хийхэд бишгүй олон өштөнтэй бологүй яах вэ. гомдолгүй олон байгаа энэ явдлыг олонд тараах юм бол тэд баяр хөөр болж би гутамшиг болно. Дэмийн олон юм хэлсэнд уучлаарай. Хэрэв таныг лам хүн байсан бол ингэж хэлэхгүй байсан. Харин та бол хүмүүсийн байдлыг мэддэг хар хүн. Эмч ээ, эмч ээ та надад юу ч яриагүй гэж үзье тэгэх үү?

- Эрхэм хүндэт Вильфор миний хамгийн анхны үүрэг бол мүнгийг хайрлах явдал юм. хэрвээ шинжлэх ухаан хүч чадалгүй байсан бол, би хатагтй Сен-Мераныг аварчихсан байх ёстой. Гэтэл хатагтай өнгөрчихлөө. Тэгэхээр одоо амьд хүмүүсийнх нь тухай санаас зовох ёстой. Энэ аймшигт нууцыг бүр зүрхнийхээ гүнгээ нууж орхиё. Харин та эцэж цуцалгүй, зогсоо зайгүй эрж үзээрэй. Ганц үүгээр зогсохгүй байж мэднэ шүү. Гэмтлийг олохоор тань хэрвээ олж чадвал шүү. Би танд – Та шүүгч хүн хэрэгтэй гэж үзсэнээрээ болоорой гэж хэлнэ.

- Баярлалаа эмч ээ, баярлалаа. Надад танаас илү сайн нөхөр хэзээ ч байгаагүй гэж Вильфор хэлэхийн аргагүй ихээр баярлан өгүүлээ.

Тэгээд эмчийг санаагаа өөрчлөх бий гэж болгоомжилсон юм шиг гэрийнхээ зүг дагуулан явлаа.

Моррель амьсгаа нь давхацсан юм шиг мөчрийг хоёр тийш нь ярахад үхээрийн юм шиг зэвхийрсэн царайд нь сарны гэрэл туслаа.

- Тэнгэр надад таалатай байх шиг байна. гэхдээ ямар аймшигтай юм бэ? Хөөрхий Валентина минь! Яаж ийм уй гашууг давж гарна даа гэж өөр зуураа хэлэв.

Ингэж ярьж байх зуураа улаан хөшигтэй цонх, цагаан хөшигтэй гурван цонхыг ээлжлэн харна.

Улаан хөшигтэй цонхны гэрэл бараг унтарчихлаа. Хатагтай Вильфор гэрлээ унтраа зөвхөн унтлагын гэрэл нь асаалттай байгаа болотой.

Харин байшингийн нөгөө талд цагаан хөшигтэй цонхнуудын нэг нь онгойж, задгай зуухан дээр байгаа лааны гэрэл сүүдэгнэн гадаа тагтан дээр нэгэн сүүдэр гарч ирлээ. Хүн мэгшин улах шиг сонсогдож Моррель давхийн цочив.

Хүний хамгийн хүчирхэг хоёр тачаал болох дурлал ба айхаас болж сСтгэл нь догдлон түгшсэн энэ хүч чадалтай зоримтог хүн сульдэн доройтож элдвийн хий юманд автах болж байгаа нь гайхаад байх хэрэг биш болотой.

Тэр хэдийгээр Валентинад харагдахгүйгээр нууц газар байгаа ч гэсэн цонхон дээрх сүүдэр өөрийг нь дуудаж байх шиг санагдана. Энэ санааг түүнд түгшсэн оюун нь хэлж өгч, түргэн цохилох зүрх нь батлан байв. Саях сэтгэлийн хуурмаг үзэгдэл бодит юм шиг болж, залуу халуундаа автан нуугдаж байсан газраасаа ухасхийн гарлаа. Өөрийг нь хүн харчхаж магадгүй, Валентина цочин өөрийн эрхгүй хашхирч, хөл үймээн болох бий гэдгийг ч бодолгүйгээр хоёрхон харайгаад ссрны гэрэлд нуур шиг цэлийн харагдайж байсан цэцгийн хүрээлэнг өнгөрөн гарч, байшингийн өмнүүр тавилсан алтан жүржтэй торхнуудад хүрч, тэндээсээ шатаар түргэн өгсөж, амархан онгойсон хаалгаар орж явчихлаа.

Валентина түүнийг харсангүй. Түүний өөдөө чиглэсэн нүд нь хөх тэнгэрийн дунд хөвөх яваа үүлсийг ширтжээ. Үүлний дүрс сэтгэл зүрх нь түгшсэн охинд эмэг ээжийн нь сүнс тэнд яваа юм шиг санагджээ.

Тэр завсар Моррель үүдний өрөөг өнгөрч, шатны бариулыг тэмтрэн олов. Шатан дээр дэвссэн хивс түүний хөлийн чимээг намтгана. Түүнээс гадна Моррель

Вильфортой дайралдсан ч гэсэн айхааргүйгээр сэтгэл нь догдолсон байлаа. Өөдөөс нь Вильфор гарч ирвэл яахаа мэдэж байжээ. Тэр түүнд бүх үнэнээ хэлж, Валентина тэр хоёрыг холбож байгаа дурлалыг ойлгон сайшааж үзээч гэж гуйх ажээ. Нэг үгээр хэлэхэд Моррель солиорчихсоноос ялгаагүй байлаа.

Аз болоход хэнтэй ч дайралдсангүй. Одоо ч байшингийн дотоод зохион байгуулалтын тухай Валентинагийн хэлж өгсөн зүйлүүд түүнд онц хэрэг болжээ. Саадгүй явсаар шатны дээд тавцан дээр гарч, ийш тийш харвал мэгшин уйлах дуу түүний хаашаа явах ёстой замыг зааж өглөө. Моррель эргэж харвал дутуу хаалттай хаалганаас гэрэл тусаж, уйлах дуу сонстлоо. Тэгээд хаалгыг нь түлхэн орлоо.

Тасалгааны гүнд нас барсан хатагтай цагаан даавуугаар бүтээлэгтэй хэвтэж байх нь харагдав. Моррелийн сонссон өнөөх нууцаас болоод бүр ч аймшигтай санагджээ.

Валентина орны дэргэд өргөн сандлын түшлэгт толгойгоороо шигдэн өвдөг дээрээ сөхрөн, толгой дээгүүрээ гараа салаавчлан мэгшин уйлж байв.

Бүсгүй цонхноос холдож, ямар ч хатуу зүрхийг уяруулахаар залбиран мөргөнө. Үг нь үл ойлгогдох бөгөөд хоолой нь гуньж гутсанаасаа болоод боочих гээд байна уу гэлтэй байлаа.

Цонхны сараалжин хаалтны завсраар орсон сарны туяа лааны гарлийг сүүтэгнүүлэн энэ гунигт үзэгдлийг улам ч уйтгартай болгон харагдуулна.

Моррель тэссэнгүй. Төдийлэн сүсэгтэй биш, сэтгэлийн хөдөлгөөнд амархан автдаггүй боловч, уйлан унжиж байгаа Валентинаг хараад дуугүй байж чадсангүй, санаа алдаад түүнийг нэрээр нь дуудахад, нулимсандаа норж, сандлын хилэн бүрээсний ор нүүрэнд нь орчихсон Магдалина Коррежогийн царай түүн өөд харав.

Валентина түүнийг хараад гайхсангүй. Хэмжээ хязгааргүй уйтгар гунигаар дүүрсэн зүрх, түүнээсээ илүү догдолдоггүй юм.

Моррель дцрлалт бүсгүйдээ гараа өглөө.

Валентина гарч очоогүй шалтгаанаа тайлбарлахын оронд бүтээлэгтэй байгаа хүүрийг заагаад дахин уйллаа.

Тэр хоёр тасалгаанд юм ярилцаж зүрхэлсэнгүй. Байшингийн аль нэг буланд эрлэгийн элч өөрөө зогсоод дуугүй гэж хуруугаа уруул дээрээ тавьчхаад байгаа мэт, энэ чимээ аниргүйг эвдэхээсээ айцжээ.

Валентина эхлэн дуугарч,

- Найз минь, яаж ороод ирчхэв? Хэрвээ үхэл байшингийн хаалгыг танд урьтаж нээчхээгүй сэн бол би таныг морилон орно уу? гэж хэлэх байсан юм гэлээ.

Тэгэхэд Моррель гарыг нь атгангаа чичирсэн хоолойгоор,

- Валентина, би найм хагасаас хойш хүлээсэн. Ирэхгүй болохоор чинь хашаа даваад цэцэрлэгт орлоо. Тэгээд энэ золгүй явдлын тухай яриа... гэж хэлтэл бүсгүй,

- Ямар яриа? гэж асуув.

Моррель цочлоо. Эмч, Вильфор хоёрын ярьсан бүх зүйлийг санаж, бүтээлгэн доорх тэлсэн гар, хөшсөн хүзүү, хөхөрсөн уруулыг харж байх шиг санагджээ.

- Танай зарц нарын ярианаас мэдлээ гэж Моррелийг хэлэхэд,

- Наашаа ирнэ гэдэг чинь бидний хэргийг баллаж мэдэх юм шүү дээ гэж Валентина айсан, зовсон янзтай хэлэв.

Тэгэхэд Моррель мөн тэр янзаар,

- Уучлаарай, би одоо явъя гэв.

- Болохгүй, хүнтэй дайралдчихаж мэднэ. Эндээ бай.

- Наашаа хүн ирвэ« яах вэ?

Валентина толгой сэгсэрч,

- Хэн ч ирэхгүй. Бүү зов. Энд л бидний хамгаалалт гэж хэлээд бүтээлэгтэй хүүр өөд заалаа.

- Ингэхэд д'Эпине яасан бэ, хэлээч, гуйя? Гэж Моррель хэлэв.

- Эмээг амьсгаа хурааж байх яг тэр үед гарын үсэг зурахаар ирсэн.

- Аймшигтай хэрэг! гэж Моррель энэ үхлээс шалтгаалж хурим ямар нэг хугацаагаар хойшлогдох болсон учир баярласандаа хэлчхэв. Гэвч тэр доороо энэ үгнийхээ шанг авчээ.

- Эмэг ээж нас барахдаа, хуримыг аль болох түргэн хийж үзээрэй гэж тушаасан. Бурхан минь, тэр намайг хамгаалах гэж бодоод наддаа дайсан болж байх юм даа гэж Валентина хэлэхэд Моррель,

- Дуулав уу? гэж хэлэв.

Тэр хоёр дуугүй боллоо.

Хаалга онгойж гудмын шал, шатны гишгүүр дээр хүний хөдийн чимээ гарав.

- Аав өрөөнөөс гарч байгаа нь энэ гэж Валентина хэлэхэд, Моррель

- Эмчийг гаргаж өгч байх шиг байна гэв.

- Эмч гэдгийг нь та яаж мэдэв? Гэж Валентина гайхан асуухад,

- Зүгээр л тааж байгаа юм гэж хэлэв.

Валентина түү өөд харлаа.

Энэ үед гол хаалга хаагдах шиг сонстлоо. Дараа нь Вильфор цэцэрлэгийн хаалгыг цоожлохоор яваад дахин орж ирж шатаар өгсөв.

Үүдний өрөөнд орж ирээд өрөөндөө орох уу эсвэл хатагтай Сен-Мераны өрөөнд орох уу гэж тээнэглэсэн бололтой хэдэн секунд зогсов. Моррель хөшигний цаана яаран нуугдав. Валентина их уйтгар гуниг нь ердийн айх сэтгэлээс нь давж гарсан мэд огтхон ч хөдлөлгүй злгслоо.

Вильфор өрөө рүүгээ явлаа.

- Одоо та гол хаалгаар ч тэр, цэцэрлэг рүү ордог хаалгаар ч тэр гарч чадахгүй болсон гэж Валентина хэлэхэд Моррель яах учраа мэдэхээ байж Валентина өөд харлаа.

- Одоо өвгөн аавын өрөөгөөр дамжих ганц бололцоо найдвартай хаалга байна гэж хэлснээ Валентина босоод – Явья гэлээ.

- Хаашаа?

- Өвгөн аав дээр очье.

- Би эрхэм Нуартье дээр очих гэж үү?

- Тийм ээ.

- Валентина бодооч дээ!

- Би энэ тухай аль хэдийн бодсон. Надад одоо энэ дэлхий дээр ганц хань болох хүн, бид хоёр хоёуланд минь хэрэг болно.

- Валентина болгоомжлоорой гэж Моррель дагаж зүрхлэхгүй хэлээд – Би одоо л нааш ирж ямар явдал хийснээ ойлголоо. Хайрт минь, зөв зүйтэй юм хийж байна гэж үзэж байна уу? гэж асуув.

- Үзэхээр барах уу. гагцхүү хөөрихй эмээгээ ганцааранг нь үлээх л эвгүй байна. би харж хамгаалж байна гэсэн юм.

- Үхнэ гэдэг ариун тунгалдаг байдаг юм шүү дээ гэж Моррелийг хэлэхэд Валентина,

- Тийм ээ ямар удах юм биш дээ явья гэж хариулав.

Валентина гудмаар явж Нуартьегийн өрөө рүү буусан жижиг шатаар буулаа. Моррель өлмий дээрээ гишгэлэн хойноос нь дагана.тасалгааны нь үүдэнд хөгшин зарцтай нь дайралдав.

- Барруа биднийг орсны хойно хаалгаа хаагаад хэнийг ч бүү оруулаарай гэж Валентина хэлээд түрүлэн орлоо.

Нуартье өчүүхэн ч атугай чимээг чагнан сандал дээрээ сусаар байв. Барруагаас болсон явдлыг дуулсан болохоор хаалга өөд анхааралтай харна. Валентинаг харчхаад нүд нь гялалзав.

Бүсгүй алхаа түүний биеэ авч яваа байдал түүний ноцтой баяртай буйг харуулна. Өвгөн үүнийг хараад гайхаж нүдэнд нь асуусан шинж илрэв.

- Хайрт өвгөн аав минь, миний хэлэхийг анхааралтай сонс. Сен-Меран эмээ цагийн өмнө талийгаач болсныг та мэднэ. Тэгэхлээр танаас өөр намайг хайрлах хүн энэ орчлонд байхгүй боллоо гэж Валентина таслалдуулан хэлэв.

Хязгааргүй ихээр энхрйлсэн нүд өвгөний нүдэнд илрэв.

- Би ганцхан танд л итгэл найдвар гаслан зовлонгоо итгэн хэлж болно тийм ээ?

Саагийн гэмд дайрагдсан өвгөн тийм гэж дохилоо.

Валентина Максимилианы гараас барьж,

- Тийм бол энэ хүнийг сайн харж ав гэж хэлэв.

Өвгөн залууг шинжсэн шинжтэй бага зэрэг гайхсан байдалтай харлаа.

- Энэ бол марселийн хөлөг онгоцны хүндэт эзний хүү Максимилиан Моррель шүү дээ. та түүний тухай лав дуулсан байх.

- Тийм ээ гэж өвгөн дохиогоор хариулав.

- Энэ бол хиргүй тунгалаг нэр. Максимилиан энэ нэрээ алдар гавьяагаар чимж явна. Одоо гучхан настай ч гэсэн, морин цэргийн ахмад цолтой. Хүндэт легионы одонгоор шагнуулсан хүн.

Өвгөн үүнийгээ санаж байгаагаа дохиж хэлэв.

- Тэгэхээр өвгө аав аа гэж хэлээд Валентина түүний өмнө өвдөг сөгдөөд, Максимилиан өөд зааж – Би энэ хүнд сайн. Гагцхүү энэ хүнийх болно. Хэрвээ намайг өөр хүнтэй суулгах гэвэл би үхнэ. Эсвэл өөртөө гар хүрнэ гэв.

Өвгөний нүдэнд өчнөөн төчнөөн санаа төрж байгаа бололтой.

- Өвгөн аав аа, таны сэтгэлд Максимилиан Моррель таалагдаж байга тийм биз дээ? гэхэд хөдөлгөөнгүй өвгөн,

- Тийм гэж дохив.

- Та биднийг, хүүхдүүдээ ааваас хамгаалж чадах уу?

Нуартье бодлогшир±он харцаар Моррель өөд харах нь “байдлаас л болно” гэсэн мэт харагдана.

Максимилиан ойлгожээ.

- Мадмаузель таныг эмээгийн чинь өрөөнд ариун үүрэг хүлээж байгаа. Эрхэм Нуартьетэй хэдэн минут ярилцахыг зөвшөөрнө үү? гэж хэлэв.

- Тийм ээ тийм чухам үүнийг л хүсэж байна гэх шиг өвгөн харлаа.

Дараа нь нэг юманд санаа зовсон болотой Валентина өөд харлаа.

- Өвөө ав та өөрийгөө яаж ойлгох юм бол гэж асуумаар байна уу?

- Тэгж байна.

- Бүү зов. Бид хоёр таны тухай дандаа ярьдаг болохоор тэр бид хоёрын яаж ярьдгийг сайн мэднэ ээ гэж хэлээд Валентина хачин уйтгартай боловч Максимилиан өөд эргээд эелдэг сайхнаар инээмсэглээд – Миний мэдэх бүхнийг энэ хүн мэднэ гэж нэмж хэлэв.

Валентина ингэж хэлээд өвдөг дээрээсээ босож, Моррельд сандал дөхүүлж өгөөд хэнийг ч бүү оруул гэж Барруад тушаагаад, өвгөн ааваа үнэсэн Моррельтэй салах ёс уйтгартайгаар гүйцэтгэн гарч одлоо.

Моррель Валентинагийн итгэлийг хүлээж, тэдний нууцыг мэддэгээ батлан харуулахын тулд толь бичиг, үзэг, цаас аваад шитрээн дээр дэнлүүний хажууд тавив.

- Юуны өмнө би хэн болохоо мадмаузель Вильфорт хэр сайн байдгаа цаашдаа яах санаатай байгаага танд ярихыг зөвшөөрнө үү? Гэж Моррель хэлэхэд Нуартье,

- Би сонсож байна гэж дохилоо.

Орчныхоо хүмүүст тээртэй танагдах энэ хүн дөнгөж сая амьдралд орж байгаа сэтгэлтэй сайхан залуусын цорын ганц хамгаалагч, түшиг тулгуур нь болж байгаа нь зэгсэн сүртэй харагдав.

Ер бусын сүрлэг намбатай ширүүн дүртэй энэ хүн Моррельд гүнээ нөлөөлж хоолой чичрүүлэн ярьж эхлэв.

Валентинатай яаж танилцсанаа яаж хайртай болсноо, ганцаардмал хөөрхий бүсгүйн үнэн сэтгэлийг нь хэрхэн хүлээж авсан зэргийг тоочин ярив. моррелийг асуусан янзтай харах бүрд өвгөн харцаараа

- За сайн, цааш нь ярь хэмээн хариулж байлаа.

Моррель ярианыхаа эхний хэсгийг ярьж дуусаад,

- Би танд хайр сэтгэл, итгэл найдварынхаа тухай ярилаа. Одоо бидний төлөвлөгөөний тухай ярих уу? гэж асуув.

- Тэг гэж өвгөн зөвшөөрлөө.

- Бид ингэж шийдсэн юм.

Тэгээд Нуартьед ногооны газар сүйх тэрэг хүлээж байсныг Валентинаг дүү охиныдоо аваачиж тэндээ гэрлэх ёс хийгээд дараа нь эрхэм Вильфорыг уучлах хүртэл хүүлээх гэж байснаа ярив.

- Үгүй гэж Нуартье дохив.

- Үгүй ий? Ингэж хийж болохгүй байв уу?

- Үгүй.

- Та энэ төлөвлөгөөг сайшаахгүй байна уу?

- Үгүй.

- Тэгвэл бас өөр арга байна гэж Моррель хэлэв.

Өвгөний харц ямар арга гэж асуув.

- Би Франц де Эпине дээр очиж ёс журам мэддэг хүг бол учир ойлгохоор ярина. Валентинаг байхгүйд энэ тухай тантай ярилцах болсон завшаан тохиосонд би баяртай байна гэв.

Нуартье бас л асуусан янзаар харав.

- Миний чухам юу хийхийг мэдэх гээ юү?

- Тийм.

- Тэгвэл ийм байна. би хлснээрээ түүн дээр очиж Валентина бид хоёрыг холбож байгаа холбооны тухай хэлнэ. Хэрэв учир мэддэг хүн бол Валентинаг эхнэр болгохоосоо өөрөө татгалзана л даа. би үхтлээ түүнд үнэнч нөхөр нь болж явна. Хэрвээ ашиг хонжоо харагч юм уу эсвэл бардам зан гаргагч бөгөөд зөвшөөрөхгүй бол Валентинаг надаас өөр хүнд сэтигэлгүй байдгийг хэлээд хүчээр булааж авах гэвэл түүнд бүх давуу талыг нь өгч байгаад тулалдана. Эсвэл би түүнийг ална. Эсвэл тэр намайг ална. Хэрвээ би түүнийг алчихвал тэр Валентинатай сууж чадахгүй. Хэрвээ тэр намайг алчихдаг юм гэхэд Валентина түүнтэй суухгүй гэвэгт би итгэж байна.

Нуартье энэ илэн далангүй нүдэнд дулаан царай өөд их л баяртай харна. Энэ царай Моррелийн ярьсан бүхнийг илчлэн харуулж нүүрний нь өнгө ярьсан бүхнийг нь батална.

Гэвч Моррелийг ярьж дуусахад Нуартье хэдэн удаа нүдээ аньсан нь зөвшөөрөхгүй байгаагийн шинж ажээ.

-Та энэ төлөвлөгөөг бас л түрүүчийн адил зөвшөөрөхгүй байна уу?

-Үгүй зөвшөөрөхгүй гэж дохив.

-Тэгвэл би яах ёстой юм бэ? хатагтай Сен-Меран ач охиноо даруй гэрлүүл гэж хэлээд амьсгал хураасан байна билээ. би энэ хуримыг хийлгэчих ёстой юм гэж үү?

Нуартье хөдөлсөнгүй.

-Ойлголоо би үүнийг хүлээх ёстой юм шив.

-Тийм.

-Хойшлуулах нь биднийг баллана. Валентина гав ганцаараа юу ч хийж чадахгүй. Түүнийг хүүхэд шиг тулгачихна шүү дээ. би бараг ид шидээр энд орж ирж юу болж байгааг мэдлээ. Бас тан дээр азаар орж ирлээ. Одоо дахиад ийм аз тохиолдоно гэж үзэх аргагүй байна. миний хэлсэн хоёр аргын аль нэг нь бололцоотой. Ингэж итгэлтэй байгааг минь өршөөгөөрэй. Та алийг нь дээр гэж үзэж байна? та миний нэр төрд итгэхийг валентинад зөвшөөрөх үү?

-Үгүй.

-эрхэм де Эпине дээр очихыг дээр гэж үзэж байна уу?

-Үгүй.

-Бурхан минь. Тэгвэл бидний тэнгэрээс гуйгаад байгаа тусламжийг хэн бидэнд үзүүлэх болж байна?

Тэнгэрийн тухай үг дуугарах бүрд царайд нь тодордог инээмсэглэл өвгөний нүүрэнд гарлаа. Якобич өвгөн бурхангүй үзэлтэн хэвээр байв.

-Азтай тохиолдол уу? гэж Моррель асуухад,

-Үгүй гэв.

-Та юу?

-Тийм.

-Та юу даа?

-Тийм гэж өвгөн давтан дохив.

-Эрхэм та миний асууж байгаа юмыг сайн ойлгож байгаа биз? Шалгаагаад байгааг минь уучлаарай. Гэвч таны хариултаас л миний амьдрал шалтгаална. Биднийг та аврах уу?

-Тэгнэ.

-Та үүндээ итгэж байна уу?

-Тийм.

-Бүр баталж байна уу?

-Тийм.

Үүнийг батлан хэлж байгаа харцанд эрх мэдэл биш юмаа гэхэд эргэлзэхийн аргагүй шийдмэг зориг илрэн байлаа.

-Өө, би танд түмэнтээ баярлалаа. Гэхдээ эрхэм минь бурхан л танд ид шидээр хэл ам, хөдөлгөөн оруулахгүй юм бол хэл амьгүй хөдөлж чадахгүй сандалтай барьцалдсан ийм хүн тэр гэрлэлтийг яаж эсэргүүцэх юм бэ?

Хөдөлгөөнгүй нүүрэн дээр нүдээрээ инээмсэглэх хачин инээмсэглэл тодорно.

- Тэгвэл би хүлээж байх ёстой юм уу? гэж Моррель асуув.

-Тийм.

-Аа, гэрээ баталгаа?

Нүд нь дахин инээмсэглэв.

-Түүнд гарын үсэг зурахгүй гэж хэлэх гээд байгаа юм уу?

-Тийм.

-Тэгэхээр гарын үсэг ч зурахгүй байх нь ээ! гэж Моррель дуу алдаад - Өө уучлаарай. Их жарга«ын тухай хэлэхээр хүн эргэлздэг ёс байдаг шүү дээ. гарын үсэг зурагдахгүй нь ээ? гэхэд өвгөн,

-Үгүй гэж хариулав.

Хэдий тийм боловч Моррель итгэхгүй хэвээр байв. Арчаагүй өвгөний энэ амлалтыг зориг чадлын амлалт гэж үзэхээсээ арга нь барагдсандаа ингэж байна гэж бодохоор ажээ. Ухаан нь солиорсон хүн өөрийн солиорсноо мэдэлгүй хүчнээсээ хэтэрсэн юмыг хийнэ гээд байдаг нь зүйн хэрэг биз дээ? Бяргүй хүн хүнд ачаа өргөсөн тухай, зүрхгүй, аймхай хүн аваргуудыг ялсан тухай, ядуу хүн эрдэнэ баялаг эзэмшсэн тухай ярьдаг шүү дээ.

Нуартье Моррелийн эргэлзэхийг ойлгосон ч юм уу, эсвэл номхон даруугаар хүлээн дагасанд нь итгээгүй алин боловч түүн өөд зөвхөн ширтэн харав.

- Эрхэмсэг та юу гэх гээ вэ? Ямар ч юм хийхгүй гэж танд дахин амлах хэрэг байна уу? гэж Моррель асуув.

Нуартьегийн харц эрс, хөдөлгөөнгүй болж зөвхөн ингэх нь хангалттай биш гэсэн янзтай хараад, дараа нь харц нь нүүрнээс гар руу шилжин ирлээ.

- Та намайг тангараглахыг хүсч байна уу? гэж Максимилиан асуухад өвгөн,

- Тийм. Би үүнийг хүсэж байна гэсэн янзтай дохив.

Өвгөн тангаргийг их ач холбогдолтой гэж үзэж байгааг Моррель ойлгов. Тэр гараа өргөж,

- Нэр төрөө барьж тангараглая. Эрхэм д'Эпинегийн эсрэг ямар нэг юм хийхээс өмнө таны шийдвэрийг хүлээнэ гэж хэлэв.

- Сайн байна гэж өвгөн нүдээрээ хэлэв.

- Аа, одоо намайг яваг гэж бодож байна уу? хэмээн Моррель асуув.

- Тийм.

- Мадмуазель Валентинатай уулзалгүй юу?

- Тийм.

Моррель үгэнд нь орсны тэмдэг болгож мэхийн ёслоод,--Харин одоо хүү чинь, охин шиг чинь таныг үнэсэхийг зөвшөөрнө үү? Гэв.

Нуартъегийн илтэд энхрийлсэн харцыг Моррель үзээд түүний өмнөхөн Валентинагийн уруул хүрсэн газар духан дээр нь уруулаа хүргэв.

Дараа нь өвгөнд дахин ёслоод гарав.

Үүдэн дээр Валентинагийн захиж орхисон хөгшин зарц дайралдав. Моррелийг гарч ирэхэд хүлээж байгаад мухиралдсан гудмаар дагуулан явж цэцэрлэг рүү гарсан жижиг хаалганд хүргэж өгөв.

Моррель цэцэрлэгт ороод хаалга хүрлээ. Модны мөчрөөс зүүгдэн эгшин зуурын дотор хашаан дээр үсрэн гараад секундын дараа сүйх тэрэг хүлээж байсан ногооныхоо газарт шатаар буулаа.

Моррель тэргэндээ суугаад, сэтгэл нь хөдөлсөндөө болж ядарсан боловч, зүрх нь тайван явж шөнө дундын үед Меле гудамжиндаа хүрч хөнжилдөө орж нам унтлаа.

17. Вильфорын гэр бүлийн бунхан

Хоёр хоногийн дараа өглөөний арван цагийн үед, эрхэм де Вильфорын үүдэнд олон хүн цугларч, Сент-Оноре ба де-ла Пепиньер гудамж дагуу гашуудлын болон хувийн сүйх тэрэг цуван зогсжээ.

Эдгээр сүйх тэрэгнүүдийн дотроос хол замыг туулсан бололтой нэгэн сүйх тэрэг байдлаараа ялгарч байв. Энэ бол хар өнгөөр будсан нэг ёсны ачааны бүхээгтэй тэрэг байв. Энэ тэрэг цугларах газар хамгийн түрүүнд шахам иржээ.

Энэ тэргээр Сен-Меран бэйлийн хүүр ирсэн нь хачин тохиолдол бөгөөд энд цугларсан хүмүүс нэг хүн оршуулахын оронд хоёр талийгаачийг үдсж мордуулах болжээ.

Үдэж мордуулах хүн олон цугларчээ. Сен-Меран бэйл бол ХVIII Людовик ба Х Карлын үеийн хамгийн зүтгэлтэй, үнэнч шударга, өндөр тушаалтны нэг байсан учир найз нөхөд олонтойн дээр нийгмийн ёсыг бодож Вильфортой талтай байдаг хүмүүстэй нийлж бүр ч олон болжээ.

Засаг захиргааны хүмүүст даруй мэдэгдэж, хоёр ёслолыг нэг дор гүйцэтгэх зөвшөөрөл авчээ. Гашуудлын янзаар сүржин засаж чимэглэсэн хоёр дахь сүйх тэрэг вангийн прокурорын үүдэнд ирж зогсоход, авсыг шуудангийн тэрэгнээс гаргаж гашуудлын тэргэнд шилжүүлэн тавив.

Хоёр цогцсыг Пер-Лашезын хүүр оршуулах газар авчирч оршуулах бөгөөд Вильфор энд гэр бүлийнхээ хүмүүсийг оршуулах бунхан хэдийнэ хийлгэсэн байв. Бунхны дотор хөөрхий Ренегийн шарил байх агаад арван жилийн дараа эцэг эх хоёр нь ирж нийлж байгаа нь энэ ажгуу.

Сүр бараатай оршуулгын хөлтэй явдал болоход ямагт догдлон хөдөлж, сонирхдог парисынхаа зан заншлаа даган дээдсийнхээ хүрээлэнд хязгааргүй үнэнч асан хуучны язгууртны хоёр төлөөлөгчийг тайван нойрсох сүүлчийн байранд нь үдэх энэ сүртэй ёслолыг харж чимээ аниргүй зогсоно.

Бошан, Шато-Рено, Альбер гурав гашуудлын нэг сүйх тэргэнд суугаад, энэ гэнэтийн үхлийн тухай ярилцаж байв.

- Би хатагтай Сен-Мераныг өнгөрсөн жил Марсельд харсан. Би тэр үед Алжираас буцаж явсан юм. Зуун нас наслахаар л хүн харагдаж байсан даа. Гайхам ажи«саг, цэцэглэж байгаа эрүүл бие, саруул ухаантай хүн байсан юм. Хэдэн настай билээ дээ? гэж Шато-Рено ярив.

- Жаран зургаатай. Франц л надад тэгж хэлсэн шүү дээ. Түүнийг хөгшин нас нь биш, бэйлийн үхэл л донсолгож, уй гашуунаас болж үхлээ. Өвгөнийнээ үхсэнээс хойш ухаан нь орж гарах болсон гэж улс ярилцаж байна билээ хэмээн Альберыг хэлэхэд, Бошан,

- Чухам юунаас болоод үхчихэв? Хэмээн асуув.

- Тархинд нь цус харваснаас юм уу эсвэл саа дайрнаас болсон бололтой. Эсвэл энэ хоёр чинь адилхан юм уу?

- Бараг тийм байх аа.

- Саа дайрсан ий? гэж Бошан давтан асуугаад--Үнэмшихэд ч бэрх байна. Би хатагтай Сен-Мераныг хоёр ч удаа харсан. Туранхай жижигхэн биетэй, ууртай байрын хүн байснаас биш, тийм их тарган цатгалан авгай байгаагүй юм. Уй гашуудлаас болж дайрлага дайрна гэдэг бол ийм биетэй хүмүүст маш ховор тохиолдох зүйл гэв.

- Ямар ч байсан өвчнөөр ч юм уу эсвэл эмч нь алчихсан байлаа ч гэсэн эрхэм Вильфор чухамдаа хэлбэл мадмуазель Валентина, бүр үнэнээр нь хэлбэл миний найз Франц одоо гомдолгүй их хөрөнгөний үе залгамжлагч боллоо. Жилд наян мянган ливрийн орлоготой гэж бодож байна гэж Альбер хэлэв.

- Энэ хөрөнгө тэр хөгшин якобич Нуартьег үхэхээр бараг л хоёр дахин ихэснэ дээ.

- Нөр өвгөн юм аа.Теласет propostil virum¹ гэж Бошан хэлээд--ӨөрЕйн бүх үе залгамжлагчийг оршуулж дуусгана гэж үхэлтэй лав мөрий тавьсан байх аа. Санасандаа хүрнэ дэг шүү. Мянга найман зуун арван дөрвөн онд Наполеонд:

“Таны эзэнт улс өсөлтөндөө ядарсан залуу мод шиг болохоор та доошилж байна. Бүгд Найрамдах Улсдаа түшиглэж сайн шиг үндсэн хууль гаргачхаад, тулалдааны талбайд гарч ир. Тэгвэл би танд таван зуун мянган цэрэг, хоёрдугаар Маренго, хоёрдугаар Аустерлицыг олж өгнө гэж амлая. Үзэл санаа зүүрмэглэн үүрэглэхээс биш харин үхдэггүй юм шүү, эрхэм дээд эзэнтэн минь. Харин сэргэхээрээ унтахын өмнө байснаасаа улам хүчирхэг болдог” гэж хэлж байсан ерэн гурван оны эвслийн гишүүн болж таарлаа гэв.

- Харваас хүмүүс түүнд үзэл санаа шиг санагддаг байх аа. Ингэхэд Валентинагүйгээр байж чадахгүй өвгөнтэй Франц яаж шуухан амьдрах юм бол мэдэх юм сан. Үгүй, Франц хаана байна вэ? гэж Альбер хэлэв.

- Түрүүчийн сүйх тэргэнд Вильфортой хамт яваа. Цаадах нь түүнийг гэр бүлийнхээ гишүүн гэж үзэх болжээ.

Тэнд явсан сүйх тэрэг бүрд шахам ийм яриа болж байв. Хүн бүхэн ингэж нэг нэгнийхээ араас цуварсан хоёр үхлийн тухай гайхан ярилцах боловч, шөнийн зугаалгын үеэр д' Авринья Вильфорт хэлсэн аймшигт нууцыг хэн ч сэжиглэсэнгүй.

Нэг цаг явсны дараа оршуулгын газарт хүрлээ. Энэ өдөр намуухан боловч бүрхэг байсан нь уйтгарт ёслолд их л тохирч байв. Гэр бүлийн бунхан руу явж байгаа хүмүүсийн дунд өөрийн тэргээр ирсэн Моррель явж байхыг Шато-Рено харав. Улаан мод суулгасан зөргөөр ганцаархнаа явж байгаа харагдав.

Ш то-Рено залуу ахмадыг сугадан аҵч,

- Та яаж энд хүрээд ирээ вэ? Вильфорыг таньдаг юм уу? Таныг тэднийд байхыг ер хараагүй юм байна гэж хэлэхэд,

- Би эрхэм Вильфортой танил биш, харин хатагтай Сен-Мераныг таньдаг байсан юм гэж Моррель хариулав.

Тэр үед Альбер, Франц хоёр тэднийг гүйцэж ирлээ.

- Танилцахад төдий л тохиромжтой газар биш юм гэж Альбер хэлээд,- Гэхдээ яах вэ, бид ямар сүсэгтэй улс биш. Эрхэм Моррель танд, Италиар хамт явсан сайн нөхөр Франц де Эпинег танилцуулъя. Хүндэт Франц, энэ бол Максимилиан Моррель гэдэг хүн. Чамайг байхгүй үед олж танилцсан сайн найз. Сайн сэтгэлтэй, сайхан ухаантай хүмүүсийн тухай ярих бүрдээ энэ хүний нэрийг танд олон удаа дурдах байх гэлээ.

Моррель хэсэг зуур эргэлзэв. Өөрийнх нь эсрэг нууцаар тэмцэж байгаа хирнээ нөхөрсгөөр мэндлэх гэдэг дэндүү нүүр тал харсан хэрэг болох юм биш байгаа гэж дотроо бодов. Гэвч өгсөн тангаргаа санах. Тэгээд царайндаа ямар ч шинж тэмдэг илрүүлэхгүй биеэ барин байж Францад мэхийн ёслох.

- Мадмуазель де Вильфор их гашуудаж байна уу? гэж Дебрэ Францаас асуув.

- Хязгааргүй их гашуудаж байна лээ. Өнөө өглөө царай нь хачин жигтэйхэн байсан, би арай гэж таньсан гэж Франц хариулав.

Энэ ердийн юм шиг үг Моррелийн зүрхийг хатгах шиг боллоо. Энэ хүн Валентинатай уулзаж, түүнтэй ярилцсан байх нь ээ?

Энэ үед залуу, зоримог офицер тангаргаа зөрчихгүйн тулд биеэ барих гэж хамаг хүчээ дайчлах хэрэгтэй болжээ.

Тэгээд Шато-Реног сугадаж оршуулгын ажлыг эрхлэх товчооны үйлчлэгч хүмүүс хоёр авс аваачиж тавьчхаад байгаа бунхны тийш явав. Бошан бунхныг хараад,

- Сайхан сууц байна шүү. Өвлийн ч, зуны ч ордон юм аа. Удахгүй энэ гэр бүлийн гишүүн болох гэж байгаа хүндэт Франц де Эпине таны энд шилжиж ирэх ээлж ирнэ дээ. Би бол гүн ухаантан хүн болохоор тэр модон доорх шиг даруухан оромжинд сууж, хөөрхий биеэн дээр минь багахан шиг чулуу дараасай гэж бодож байна. Би үхэхдээ, Вольтер Перонд” Тосгон руу явлаа” гэж бичсэн шиг ойр орчныхоо улсад бичээд л гүйцэх нь тэр... Ай чөтгөр гэж, Франц зоригтойхон бай. Таны эхнэр бүхнийг өвлөн авна гэж хэлэв.

- Бошан та үнэхээр тэсвэрлэшгүй хүн байна шүү. Улс төрийн зүтгэлтэн хүн болохоор, тэр улс төр чинь таныг юм бүхнийг дооглож, юунд ч итгэхгүй болгож сургажээ. Гэсэн ч та ердийн үхэх үйлтнүүдийн дунд ирэхдээ улс төрийн бодлогоосоо минут ч болов ангижрах азтай хүн юм. Харин буцахдаа л, Депутатуудын танхим, тайж нарын танхимын үүдний өрөөнд орхиод ирсэн тэр сүнсээ дахин эзэмдэн авч байхыг хичээж баймаар юм гэж Франц хэлэв.

- Ай бурхан минь, ер нь амьдрал гэдэг чинь үнэн хэрэг дээрээ юу юм бэ? Үхлийн үүдний өрөөн дэх хүлээлт гэсэн үг хэмээн Бошан хэлэхэд Альбер,

- Би Бошаныг үзэн ядаж эхэлж байна гэж хэлээд Францтай хамт хэдэн алхам холдож, Бошаныг Дебрэтэй гүн ухаанаа үргэлжлүүлэн ярилцах боломж гаргаж өглөө.

Вильфорын гэр бүлийн бунхан нь өндрөөрөө хорин фут дөрвөлжин бу«антай цагаан чулуун хана байв. Дотор талд нь Сен-Меран ба Вильфорынхны тал гэж хоёр хуваагдах бөгөөд тал бүр нь өөртөө орох хаалгатай ажгуу.

Бусад бунхнуудаас ялгагдах юм нь гэвэл, зай хэмнэн талийгч нарыг дотор нь хийгээд гадна талд нь шошго шиг элдвийг бичсэн давхар давхар хайрцгууд байхгүй байв. Хүрэл хаалганы цаана булшнаас ханаар тусгаарлагдсан энгийн хийцтэй тасалгаархуу юм харагдана.

Энэ хананд Вильфор ба Сен-Меранынхныг тайван нойрсох газарт нь оруулах хоёр хаалга байлаа.

Хоёр авсыг Сен-Мераны тал болох баруун хэсэгт оруулав. Тэгээд урьдаас бэлтгэж зассан суурин дээр тавив. Ийшээ Вильфор, Франц ба ойр төрлийн нь хүмүүс дангаараа оров.

Шашны үйл ёслолыг гадна талд нь хийж гүйцэтгэчихсэн, чрих хэлэх үг байхгүй болохоор хүмүүс даруй тарж одов. Шато-Рено, Альбер, Моррель гурав нэг зүгт явж, Дебрэ, Бошан хоёр өөр тийшээ явлаа.

Франц Вильфортой үлдлээ. Оршуулгын газрын үүдэнд Моррель шалтаг гарган зогслоо. Тэгээд тэр хоёрыг гашуудлын сүйх тэргэнд сууж явахыг хараад муу ёр гэж боджээ. Моррель хотод буцаж ирэв. Хэдийгээр Альбер, Шато-Рено хоёртой нэг тэргэнд суусан боловч юу ч сонссонгүй.

Үнэндээ ч Франц Вильфортой салах ёс гүйцэтгэх гэхэд цаадах нь:

- Түшээ гүн! Тантай хэзээ уулзах бол? Гэж асуужээ.
- Таны дуртай цагт уулзъя гэж Франц мариулав.
- Аль болох түргэн л бол сайн байна.
- Би таны мэдэлд байна. Хүсвэл одоо хамт явах уу?
- Хэрвээ танд төвөг болохгүй бо« тэлье.
- Огтхон ч үгүй.

Ирээдүйн хадам, хүргэн хоёр сүйх тэргэнд сууж, дэргэдүүр нь өнгөрөхөд Моррель санаа зовсны учир энэ ажээ.

Вильфор, Франц хоёр Сент-Оноред хүрч ирлээ.

Вангийн прокурор хэн дээр ч оролгүй, эхнэртэйгээ, охинтойгоо ч ярилгүй зочноо өрөөндөө оруулаад суухыг урив.

- Эрхэм д'Эпине би танд нэг зүйлийг сануулан хэлэх хэрэгтэй байна. Энэ зүйл зохимжгүй мэт санагдаж болох боловч, талийгаачийн гэрээсийг биелүүлэх нь түүний араас өргөж буй үйлдэл юм. Тэгэхээр уржигдар хатагтай нас барахынхаа өмнө захисан зүйл, тухайлбал Валентинагийн хуримыг хэрхэвч хойшлуулж болохгүй гэсэн гэрээсийг танд сануулах гэсэн юм. Талийгаачийн үлдээсэн бичиг сэлт бүрэн цэгцтэй байгаа. Түүний гэрээс ёсоор Сен-Мераны бүх хөрөнгө Валентинад шилжсэн. Өчигдөр нотариус гэрлэлтийн гэрээг бүрэн дуусгах баримтуудыг надад өгсөн. Та нотариус дээр очиж миний нэрийн өмнөөс эдгээр баримтуудыг авч үзэж болно. Манай нотариус Дешан гуай Сент-Онорегийн Баве талбайд суудаг.

- Валентина одоо ийм их уй гашууд дарагдаж байгаа болохоор хүнтэй суух тухай бодох ч дургүй байгаа даа. Би үнэндээ жаахан халгаад байна шүү гэж Францыг хэлэхэд Вильфор түүний үгийг таслан,

- Эмээгийнхээ сүүлчийн гэрээсийг биелүүлэх нь Валентинагийн хамгийн халуун хүсэл байх болно. Үүний талаас ямар ч саад тотгор байхгүй гэж танд бүрэн хэлж болно гэв.

- Тэгвэл миний талаас мөн саад байхгүй болохоор та дурааа бол л доо. Би хэлсэн үгэндээ хүрэхээр барахгүй, их баяртай байна.

- Тэгвэл хойшлуулаад байх юм алга. Уржигдар гарын үсэг зурах ёстой байсан. Одоо бол бэлэн байгаа. Өнөөдөр ч гарын үсэг зурж болно гэж Вильфор хэлэхэд, Франц:

- Гашуудлыг яах вэ? гэж хулчгардуухан хэлэв.

- Бүү зовоорой. Манай гэрт ёс журам эвдэгдэхгүй. Мадмуазель де Вильфор тогтоосон гурван сарын хугацаагаар өөрийн Сен-Мераны эдлэнд очно. Одоо түүнийх болчихсон болохоор өөрийнх нь гэж ярьж байгаа юм. Долоо хоногийн дараа хэрвээ таныг зөвшөөрвөл тэнд чимээ анир багатай, даруухан шиг гэр бүл болох ёс гүйцэтгэнэ. Хатагтай Сен-Меран ач охиныхоо хуримыг чухамхүү энэ эдлэнд хийгээрэй гэж хүссэн юм. Хуримын дараа та нар Паристаа буцаж ирж болно, таны эхнэр хойд эхтэйгээ хамт гашуудлынхаа хугацааг өнгөрөөнө биз.

- Эрхэм таны дураар болог гэж Франц хэлэхэд Вильфор цааш нь:

- Тэгвэл би танаас хагас цаг хүлээхийг хүсье. Тэр хугацаанд Валентина зочдын өрөөнд бууж ирнэ. Би Дешаны хойноос хүн явуулж авчруулаад гарын үсэг зурж, өнөө оройдоо хатагтай Валентинаг эдлэн рүү нь аваачиг. Долоо хоногийн дараа бид тийшээ очъё гэв.

- Надад ганцхан хүсэх зүйл байна гэж Франц хэлэв.

- Юу билээ?

- Гарын үсэг зурах үед Альбер де Морсер, Рауль де Шато-Рено хоёрыг байлгахыг хүсэж бацна. Тэд миний гэрч болно гэдгийг та мэдэж байгаа шүү дээ.

- Тэдэнд хагас цагийн дотор мэдэгдэж болно. Харин та өөрөө тэднийг аврахаар явах уу, эсвэл хүн явуулах уу?

- Өөрөө явсан нь дээр гэж бодож байна.

- Түшээ гүн таныг би хагас цагийн дараа хүлээж байя. Энэ завсар Валентина ч бэлэн болно.

Франц Вильфорт мэхийн ёслоод гарч одлоо.

Түүнийг гараад хаалга хаагдаж амжаагүй байхад, Вильфор нотариус ба д'Эпинегийн гэрч нар ирэх учир хагас цагийн дараа зочдын өрөөнд орж ир гэж Валентинад хүн явуулж хэлүүлэв.

Энэ гэнэтийн мэдээ гэр бүлийн бүх хүнийг догдлуулав. Хатагтай Вильфор үнэмшээгүй боловч Валентинад тэнгэр ниргэх адил боллоо.

Залуу бүсгүй хамгаалалт эрэх мэт тасалгаага эргэн тойрон харав. Тэгээд өвгөн аав дээрээ очих гээд гартал, шатан дээр Вильфор дайралдаж, гараас нь хөтлөн зочдын өрөөнд орууллаа.

Үүдний өрөөнд Барруатай дайралдаж, бүрэн цөхөрсөн харцаар харав.

Валентинагийн дараа хатагтай Вильфор бяцхан Эдуарыг дагуулан орж ирэв. Залуу хүүхэнд гэр бүлийн уй гашуу их л хүчтэй нөлөөлсөн бололтой, царай нь хачин цонхигор, учиргүй сульдсан харагдана.

Хатагтай хүүгээ өвдөг дээрээ суулгаад байн байн чанга тэврэн элгэндээ наах нь хамаг амьдралаа энэ хүүхдэд зориулсан юм уу гэлтэй санагдана.

Удалгүй хоёр сүйх тэрэг хашаанд орж ирэх нь сонстлоо. Нэгд нь нотариус, нөгөөд нь Франц найз нөхдийнхээ хамт сууж иржээ.

Минутын дараа бүгд цугларсан байв.

Валентинагийн царай ихэд цонхийж, чамархай, зовхин дСэгүүр нь хөх судас гүрийн гарчэС.

Францын сэтгэл ихэд догдолжээ.

Альбер, Шато-Рено хоёр гайхсан янзтай бие бие өөдөө харлаа. Дөнгөж түрүүхэн дууссан гашуудлын ёслол одоо энэ болох гэж байгаа ёслолоос ч илүү уйтгар гунигтай юм шиг санагдсангүй.

Хатагтай Вильфор хилэн хөшигний хажууд сүүдэрт сууж,хүү рүүгээ байн байн тонгойх учир түүний сэтгэлд юу болж байгааг тааварлан мэдэхэд хэцүү байв.

Вильфор л хэзээ язааныхаараа огт хэнэггүй байв.

Нотариус хуулийн үйлчлэгчийн ёсоор баримт бичгүүдийг ширээн дээр дэлгэж тавиад сандал дээр сууж буй Францад хандаж, хэдийгээр түүнийг сайн таньдаг боловч,

- Та, эрхэм Франц де Кенель д' Эпине түшээ гүн мөн үү? гэж асуухад Франц,

- Тийм ээ, эрхэм минь гэж хариулав.

Нотариус мэхийн ёслоод,

- Би танд эрхэм де Вильфорын нэрийн өмнөөс нэгэн зүйлийг урьдчилан мэдэгдэх ёстой байна. Эрхэм Нуартье мадмуазель де Вильфорыг тантай суулгах гэж байгааг дуулаад ач охиныхоо талаар бодлоо өөрчилж, түүнд шилжүүлэх ёстой байсан хөрөнгөө өвлүүлэхгүй болгосон. Харин нэг зүйлийг яаран нэмж хэлэхэд гэрээслэгч хөрөнгөнийхөө хагасыг мэдэх эрхтэй байсан боловч бүгдийг нь мэдэж байгаа нь заргалдах боломж нээж өгч байна. Иймээс гэрээг хүчингүй гэж үзэж болно гэв.

- Харин би амьд ахуй цагтаа л эцгийнхээ гэрээслэлтэй заргалдахгүй. Миний одоогийн албаны байдал тийм боломж өгөхгүй байгаа гэдгийг д' Эпинед урьдчилан хэлье гэж Вильфор хэлэв.

- Эрхмүүд ээ,Валентинаг энд байхад ийм үриа болж байгаад би ихэд зовж б йна. Валентинагийн хөрөнгө хичнээн багаслаа ч гэсэн минийхээс их байх юм. Би түүний хогшил хөрөнгөний хэмжээг хэзээ ч сонирхохгүй. Миний гэр бүл эрхэм де Вильфортой холбоо тогтоохдоо гагцхүү нэр төрөө бодсоноос тэгсэн юм. Би зөвхөн аз жаргалыг л эрж байгаа хүн гэж Франц хэлэхэд Валентина талархлын тэмдэг болгож үл мэдэг толгой дохиод хацар дээгүүр нь хоёр нулимс чимээгүй бөмбөрөв.

Вильфор хүргэн болох хүндээ хандан,

- Таны найдлагын хэсэгхэн хувь алдагдсаныг эс тооцвол энэхүү гэнэтийн гэрээслэлд таныг доромжилсон өчүүхэн ч зүйл үгүй болохыг дашрамд нь хэлчихье. Энэ бол эрхэм Нуартъегийн ухаан сулаас болж байгаа хэрэг. Миний эцэг мадмуазель де Вильфорыг тантай суухад дургүйцэж байгаа биш, ерөөсөө хүнтэй суухад ньдургүйцэж байгаа юм. Мадмуазель эрхэм Нуартъед бүх л цагаа зориулж байсан бол, одоо түшээ гүнгийн хатан болчихвол тэгж чадахгүй. Эцгийн минь одоогийн байдал түүнтэй онцгой чухал юм ярих боломжгүй бөгөөд ухаан муутай болохоороо хэлсэн зүйлийг ойлгож чаддаггүй юм. Одоо энэ үед ач охиноо хүнтэй сууж байгаа гэдгийг мэдэж байвч хүргэн болох хүнийхээ нэрийг нь ч мартчихсан байж байгаа.

Вильфор үгээ дөнгөж хэлж дуусаад, Франц хариуд нь мэхийн ёсолтол үүд онгойж Барруа орж ирлээ. Тэгээд баяр ёслолын үед эзэндээ хандаж байгаа зарц хүн гэхэд, ер бишийн ширүүн өнгөөр,

- Эрхмүүд ээ, эрхэм Нуартъе де Вильфор эрхэмсэг Фр нц де Кенель д' Эпине түшээ гүнтэй даруй ярилцах хүсэлтэй байна гэж хэлэв..

Самуурахгүйн тулд нотариус шиг л нөхөр болох хүнийг бүрэн овог, нэр, хэргэм зэргээр нь дууджээ.

Вильфор цочиж, хатагтай Вильфор өвдөш дээрээсээ хүүгээ буулган, Валентина суудлаасаа босож, хөшөө мэт дуугүй цонхийн зогсов.

Альбер Шато-Рено хоёр түрүүчийнхээсээ бүр ч илүү гайхсан янүзтай өөдөөсөө харлаа.

Нотариус Вильфор өөд харахад, вангийн полкурор,

- Энэ бололцоогүй хэрэг. тэгээд ч эрхэм де Эпинье зочдын өрөөнөөс гарч чадахгүй гэв.

- Миний эзэн Нуартъе гуйа чухам одоо л энэ эрхэм Франц де Эпиньетэй маш чухал зүйл ярилцах гэсэн юм гэнэ гэж Барруа өнөөх л зуунги байдлаараа хэллээ.

- Өвгөн аав Нуартъе ярьдаг болоо юу? гэж Эдуар ердийн зүггүй байдлаараа асуулаа.

Гэвч хүн бүхэн бодлогширсон байсан тул энэ нь хэний ч тэр ч байтугай хатагтай Вильфорын ч инээдийг хүргэсэнгүй.

- Эрхэм Нуартъед хүсэл тань биелэгдэж чадахгүй нь гэж хэлээрэй гэж Вильфор хэлэхэд Барруа зөрж,

- Тэгвэл эрхэм Нуартъе өөрийгөө зочдын өрөөнд оруулаараа гэж тушаасан юм гэв.

Хүмүүс хязгааргүй их гайхав.

Хатагтай Вильфорын царайд инээмсэглэл тодроод өнгөрөв.

Валентина баярласнаа тэнгэрт илэрхийлэх гэсэн мэт өөрийн эрхгүй тааз өөд харав.

- Валентина чи очоод өвгөн аав чинь бас ямар адайр зан нь хөдөлчхөө вэ мэдээд и° гэж Вильфор хэлэхэд Валентина яаран үүд рүү явтал Вильфор хэлснээ өөрчлөн – Хүлээж бай. Хоёулаа явья гэлээ.

Франц бас хажуугаар нь орж,

- Эрхэм та уучлаарай. Нуартье гуай миний хойноос хүн ирсэн болохоор хүслийг нь хүндэтгэж байгаага илтгэх аз тохиолдоогүй байга болохоор энэ завшааныг ашиглавал их баярлаж байна гэв.

- Аа бурхан минь гэж Вильфор сэтгэл нь зовсон байдалтайгаар – Танд зовоод байх юм байхгүй гэж хэлэв.

Тэгэхэд Франц бодсоноо өөрчилдөггүй хүний байдлаар

- Уучлаараай эрхэм минь, Нуартье намайг тэгж боддог нь буруу болохыг харуулах бололцоог алдмааргүй байна. Ямар ч байсан буруугүй гэдгээ харуулмаар байна гэв.

Тэгээд Франц Вильфорт баригдсангүй шатаар бууж явсан Валентинагийн хойноос явлаа. Валентина живдгийн даваан дээр хаднаас барьж авсан хүн шиг баяртай явлаа.

Вильфор тэдний хойноос явав.

Шато-Рено Морсер хоёр түрүүчийн хоёр удаагийнхаасаа бүр ч илүүгээр гайхан харав

18.Хуралдааны тогтоол

Нуартье өвч хар хувцастай сандал дээрээ суугаад хүлээж байв.

Түүний ирэх байх гэж бодож байсан гурван хүн нь орж ирмэгц, хаалга өдөө харахад зарц нь тэр дороо хаалга түгжив.

Баярласнаа нууж чадахгүй байгаа Валентинад Вильфор аярханаар – Хэрвээ эрхэм Нуартье чиний хүнтэй суухад ямар нэг саад болох юм бол ойлгож болохгүй шүү гэв.

Валентинагийн царай улайсан боловч юу ч хариулсангүй.

Вильфор Нуартьед дөхөж очоод,

- Эрхэм Франц де Эпине энд байна. таны дуудсан ёсоор ирлээ. Бид ингэж уулзуулахыг хэдий нь хүссэн бөгөөд энэ уулзалт ач охиноо хүнтэй суухад нь саад хийж, зөрсөн явдал үндэсгүй байсан гэдгийг танд нотлон харуулбал би маш их баярлах болно гэв.

Нуартье зөвхөн харцаар хариулахад Вильфорын өвдөг чичрэв.

Дараа нь өвгөн Валентинаг нүдээрээ дуудлаа.

Валентина өвгөн аавтайгаа өдөр бүр ярилцдаг арганыхаа ачаар “Түлхүүр” гэдэг үгийг эгшин зуурын дотор оллоо.

Дараа нь бүсгүй өвгөний харцыг даган харав. Өвгөний харц цонхын хооронд байгаа шүүгээний хооронд тогтлоо.

Бүсгүй нүдийг нээвэл дотор нь үнэт түлхүүр байв.

Бүсгүй түлхүүрийг гаргаж авахад өвгөний харц мөн гэж батлав. Дараа нь өвгөний харц хуучин хэрэггүй муу сайн бичиг цас хадгалдаг болов уу гэмээр аль хэдийн хаягдсан хуучин цагийн бичгийн ширээ рүү чиглэв.

- Би онгойлгох юм уу? гэж Валентина асуув.

- Тийм.

- Нүдийг нь онгойлгох уу?

- Тийм.

-Хажуугийнх нь уу?

-Үгүй.

-Дундах нь уу?

- Тийм.

Валентина түүнийг онгойлгож дотроос боодолтой бичиг гаргаж ирэв.

- Энэ танд хэрэгтэй юу, өвгөн ааваа? Гэж Валентина асуув.

- Үгүй.

Валентина бүх бичиг цаасыг дэс дараалан гаргахад цаана нь юу ч үлдсэнгүй.

- Хайрцаг хоосон болчихлоо шүү дээ гэж охин хэлэв.

Тэгэхэд Нуартье толь бичиг өөд нүдээрээ харав.

Ойлголоо, өвгөн аав аа гэж Валентина хэлээд цагаан толгойн үсгүдийг дэс дараалан хэлэхэд “Н” гэдэг үгэн дээр огсоов. Валентина “Нууц” гэдэг үгийг хүртэл толь бичиг эргүүлэв.

- Нууц оньстой юм уу? гэж бүсгүй асуув.

- Тийм ээ.

- Энэ нууцыг хэн мэдэх вэ?

Нуарте зарцынхаа гарсан хаалгаа өөд харав.

- Барруа юу?

- Тийм.

- Түүнийг дуудах уу?

- Тэг.

Валентина үүдэнд очоод зарцыг дуудлаа.

Тэр завсар Вилдьфорын духан дэгүүр байж ядсанаас болж хөлс чийхрах бөгөөд Франц гайхахдаа хөшсөн мэт зогсоно.

Хөгшин зарц тасалгаанд орж ирлээ.

- Барруа өвгөн аав намайг энэ шүүгээнээс түлхүүр авч, ширээ онгойлгоод энэ нүдийг тат гэж тушаав. Энэ нүд нь нууц оньстой юм байна. та л сэдэх болотой. үүнийг онгойлгооч гэж Валентина хэлэхэд Барруа өвгөн өөд харлаа.

Нуартъегийн ойлгомжтой харц онгойлгож өг гэж харав.

Барруа үгэнд нь орж нууц оньстой нүдний давхар ёроолыг онгойлговол дотор нь хар туузаар багласан бөөн бичиг байв.

- Эрхэмсэг та үүнийг шаардсан юм уу? гэж Барруа асуув.

- Тийм.

- Би үүнийг хэнд өгөх вэ? Эрхэм де Вильфорт өгөх үү?

- Үгүй.

- Мадмаузель Валентинад уу?

- Үгүй.

- Франц де Эпине гуайд уу?

- Тийм.

- Надад уу? гэж гайхсан Франц дөхөж очоод хэлэв.

- Тийм ээ.

Франц Барруагийн бичгийг авч боолтыг аваад уншсан нь:

“Намайг үхсэний дараа миний найз генерал Дюринд дамжуулж өгөх бөгөөд тэр үхэхдээ үүнийг маш чухал баримт бичгийнх нь хувьд хадгалахыг хүүдээ захиж шилжүүлж өгөх ёстой” гэв.

- Эрхэм ээ, би энэ бичгийг яах ёстой болж байна?

- Бас л энэ битүүмжилсэн байдлаар нь хадгалах юм байлгүй гэж вангийн прокурор хэлэв. Нуартъегийн нүд нь үгүй үгүй гэж яаран хэлэв.

- Эрхэм де Эпинег уншихыг хүсч байгаа юм биш биз? гэж Валентина хэлэв.

- Тийм.

- Харж байгаа биз, түшээ гүн өвгөн ааю таныг уншаасай гэж хүсч байна.

Тийм бол суухаас л биш дээ, бас л хэсэг хугацаа орно гэж хор нь хөдөлсөн байртай Вильфор хэлэв.

- Сууцгаа гэж өвгөний нүд хэлэв.

Вильфор сууж Валентина өвгөн аавынхаа сандлыг түшихэд Франц тэдний өмнө зогсож хоцорлоо.

Франц дугтуйтай бичгийг гартаа байрь зогссоор байв.

- Уншаач гэж өвгөн нүдээрээ хэлэв.

Франц боолтыг задлахад тасалгаан дотор чимээгүй нам гүм байв. Тэрээ анир чимээгүйн дунд ийнхүү уншлаа:

“Мянга найман зуун арван таван оны хоёрдугаар сарын тавны өдөр. Сенжак гудамжин дахь Бонапартын талынхны клубийн хуралдааны тогтолын хэсэг” гэж уншиж ззогслоо.

- Мянга найман зуун арван таван оны хоёрдугаар сарын таванд гэнээ. Энэ өдөр миний эцэг алагдсан юм.

Валентина Вильфор хоёр дуугүй байсан бөгөөд зөвхөн өвгөний нүд л цааш унш гэж дохив.

- Аав маань энэ клубээс гарсны дараа алга болчихсон юм гэж Франц хэлэхэд, Нуартъегийн харц хуучин хэвээр унш гэж хэлсээр байв.

Франц цааш уншсан нь:

“Бид доор гарын үсэг зурсан их бууны дэд хурандаа Луй Жак Боррепер бригадын генерал Этьен Пюшампи, газар тарилангийн захиргааны дарга Клод Лешарпаль нар мянга найман зуун арван таван оны хоёрдугаар сарын дөрвөнд, одоо хэдийгээр арван наймдугаар Людовикоос эдлэн газрынаа нэрээр де Эпинг түшээ гүн гэдэг хэргэм шагнагдсан боловч мянга найман зуун дөрвөөс мянга найман зуун арван он

хүртэл эзэн хааны армид алба хаагч, Наполеоны төрд эргэлзээгүй үнэнч байсан генерал Флавнен де Канелийг анхааран үзэж, итгэж болхыг тушаасан захидал бонапартын клубын гишүүдэд Элвба арлаас ирсэн болохыг тэмдэглэе.

Үүний дагуу маргааш нь хоёрдугаар сарын таванд болох хуралдаанд ирэхийг урьж генерал де Кенельд бие хүнээр бичиг хүргүүлэв. Хурал болх гудамжны нэр байшингийн дугаарыг дурьдаагүй гарын үсэг ч байсангүй. Харин генералыг зөвшөөрвөл оройн есөн цагт түүнийг авахаар хүн очно гэж мэдэгдсэн байсан юм.

хуралдаан энгүүндээ оройн есөн цагаас шөнө болтол үргэлжилдэг байв.

Оройн есөн цагт клубийн ерөнхийлөгч генерал дээр хүрч ирэв. генерал бэлхэн байв. Ерөнхийлөгч генералд гагцхүү хурал хийсэн газар түүнд мэдэгдэлгүй хоцорч, очих газартаа нүдээ боолгон очихыг зөвшөөрч, боолтоо өргөж завсраар нь хараг гэж оролдлхгүй бол тийш нь аваачна гэж мэдэгджээ.

Генерал де Кенель тэр болзлыг нь хүлээн авч хааш нь авч явааг харах гэж оролдохгүй хэмээн тангараг өгчээ.

Генерал өөрийн сүйх тэргийг урьдаас бэлтгүүлсэн байв. Тэгэхэд ерөнхийлөгч түүнд хөтчийн нь нүдийг боогоогүй байж эзний нь нүдийг боогоод яваг гэж утгагүй хэрэг хөтөч хаагуур явснаа мэдэж байх тул ингэж болохгүй гэлээ.

“Тэгээд яах вэ?” генерал асуув.

“Би өөрөө сүйх тэрэгтэй ирсэн” гэж ерөнхийлөгч хэлжээ.

“Та миний хөтчид итгэхгүй байж, өөрийнхөө хөтчид тийм итгэлтэй байгаа юм уу?”

“М най хөтөч бол клубийн гишүүн хүн. Хариуцлагатай нарийн бичгийн дарга байгаа юм”

“Тэгвэл бас л өөр нэг аюул байна. тэр чинь биднийг онхолдуулчих байх.”

Энэ шог үг нь генералыг бид хуралдаанд хүчээр аваачагүй харин тэр өөрөө сайн дураар оролцсоны баталгаа гэж тэмдэглэж байв.

Тэд сүйхэнд суумагц ерөнхийлөгч генералд нүдээ боолгохыг зөвшөөрснөө санулав. Генерал энэ ёсыг гүйцэтгэхэд огтхон ч таталзсангүй. Энэ зорилгод урьдаас бэлтгэж сүйх тэргэнд тавьсан боолтыг хэрэглэв.

Замд явж байхдаа генералд боотынхоо гадуур харах гэж оролдож байх шиг харагдахаар нь ерөнхийлөгч түүнд тангаргийн тухай сануулахад,

- Тийм тийм таны зөв гэж генерал хэлэв.

Сүйх тэрэг Сен-Жак гудамжны нэгэн модот хэсэгт зогслоо. Генерал нэрийг нь мэдэхгүй клубийн ерийн нэгэн гишүүн гэж бодож байсан ерөнхийлөгчийн гарыг түшиж сүйх тэрэгнээс буув. Тэд модот гудамжийг өнгөрөөд хоёрдугаар давхарт гарч хуралдааны өрөөнд орлоо.

Хурал эхэлчихсэн байв. Өнөө орой шинэ гишүүн ирнэ гэж дуулсан байсан гишүүд бүрэн байв. Генералыг танхимын төв дунд авчирч боолтоо тайлахыг зөвшөөрлөө.

Тэр даруй боолтоо тайлж байхыг нь ч мэдээгүй байсан саях нийгэмлэгт таних хүн олон байгааг хараад маш их гайхав бололтой.

Түүний үзлийн тухай асуухад, Эльбаас ирсэн захидалд тодорхой байх ёстой гэж хариулав...”

Франц уншихаа зогсож,

- Миний эцэг роялист хүн байсан. Үзлийг нь асуугаад байх хэрэг юу байхау дээ бүхэнд илэрхий юм чинь гэв.

- Тимй болохоор л танай эцэг бидэнтэй холбоотой болсон юм даа эрхэм түшээ гүн минь. Үзэл санаа нэгтэй хүнтэй хэлэлцэхэд амархан гэж Вильфор хэлэхэд өвгөн унш гэж байгаа харагдав.

“Тэгэхэд ерөнхийлөгч үг хэлэх зөвшөөрөл авч, генералыг оновчтойхон ярихыг хүсэхэд эрхэм де Кенель өөрөөс нь юу хүсээд байгааг эхлээд мэдэх хүсэлтэй байна гэлээ.

Тэгэхэд түүнд найдаж болох хүн гэж Эльбын ирүүлсэн захидлыг уншиж өгөв. Энэ захидын нэг хэсэг нь Эльба арлаас эргэн ирж болох бололцооны тухай байсан бөгөөд илүү тодорхой захидыг Марселийн хөлөг онгоцны эзэн хөлөг онгоцны эзэн Моррелийн “Фараон хөлгийн ахмад, эзэн хаанэд үнэнч хүнээр хүргүүлнэ гэжээ.

Энэ захидлыг уншиж байх үед ах дүүгээ жигшиж бодож байсан генерал маань дургүйцэж илтэд жигшиж байгаагаа харуулсан билээ.

Захидал уншиж дуусахаад хөмсөг зангидан дуугүй зогссоор байв.

“За генерал та энэ захидлын тухай юу хэлмээр байна?” гэж ерөнхийлөгч асуухад

“Арван наймдугаар Людовик үнэнчээр зүтгэнэ гэж саяхан ам тангаргаа өргөчихсөн болохоор одоо хуучин эзэн хааны ашиг тусын төлөө түүнээсээ няцах нь дэндүү юм гэж хэлмээр байна!” гэж хариулав.

Энэ хариулт генералын үзлийг хэнд ч эргэлзээ төрүүлэмгүй маш тодорхой болголоо.

“Генерал бидэнд хуучин эзэн хаан гэж байгүйн адил арван наймдугаар Людовик ван гэж байхгүй. Харин арван сарын өмнө хүчирхийлэл урвалтаар өөрийн гүрэн Францаасаа холдуулагдсан, эрхэм дэд эзэн хаан л гэж байдаг юм” гэж ерөнхийлөгч хэлэв.

“Уучлаарай эрхмүүдээ, та нарт арван наймдугаар Людовик ван гэж байхгүй байж болно. Хаин надад байдаг юм шүү. Тэр надад түшээ гүн хэргэм хайржлаж, фельдмаршал болгосон болохоор би түүнийг Францад эргэж ирсэн явдалд баяртай байдаг юм” гэж генерал хариулав.

Тэгэхэд ерөнхийлөгч босож их л ноцтой байдлаар,

“Эрхэм ээ та ярь байгаа зүйлээ эгэцүүлэн бодоорой. Таны тухай Эльба арал дээр андуу ташаа бодож биднийг ьтөөрөлдүүлсэн нь таны ярьж байгаагаас тодорхой байна. бид танд тал өгч итгэж байсан тул дээрх зүйлийг мэдэгдсэн билээ. гэтэл бид ташаарчээ. цол хэргэм, өндөр тушаал ьаныг бидний унагах гэж байгаа шинэ засгийн газартай эвсэн нийлэхэд хүргэжээ. Бидэнтэй хамтран ажиллаач гэж таныг хүчээр шахахгүй. Бид хэнийг ч зориг хүслийнхээ эсрэг манай талд ор гэж дуудахгүй. Харин бид таныг өөрийн тань бодлоо зөрөх ч байлаа ч гэсэн, хүчээр шударга хүний ёсоор байлгах болно” гэлээ.

“Та нарын хуйвадлдааныг мэдчихээд илрүүлэхгүй байвал шударга санй хүн болно гэж та нар бодож байна уу? Харин би бол энийг та нартай эвсэн хуйвалдсан хэрэг гэж үзнэ. Би та нараас илүү илэн далангүй байгааг харж байгаа биз”.

- Аав аав минь гэж Франц уншихаа зогсож – Таны яагаад алсны учрыг одоо мэдлээ гэв.

Валентина өөрийн эрхгүй Франц өөд харав. Залуу хүү хүүгийн ёсоор ингэж байх нь сайхан байв.

Вильфор тасалгаан дотуур хойш урагш лхална.

Нуартье тэнд байгаа хүмүсийн царайг ажиглан сүртэй ихэмсэг байдалтай хэвээр сууна.

Франц үргэлжүүлэн уншсан нь:

“Эрхэм таныг энэ хуралдд ирэхийг урьсан болохоос хүчээр авчраагүй. Би таныг нүдээ боохыг хүссэ, та зөвшөөрсөн. Та энэ хоёр зүйлийг зөвшөөрч байхдаа биднийг лав л арван наймдугаар Людовикийн төрийг бэхжүүлэх гэж ингээгүй гэдгийг санй мэдэж байсан. Хэрвээ тийм бол бид цагдаагийн газраас нуугдахгүй байсан шүү дээ. хүний нууцад нэвтэрч орох боломжийг олгосон баг өмсөж нууцыг нь мэдчихээд дараа нь энэ багаа хаяад өөртөө итгэсэн хүмүүсийг барьж өгөх гэдэг маш амархан хэрэг болох байсныг та мэдэж байгаа шүү дээ. Үгүй, үгүй, одоо та эхлээд хэний төлөө байгаагаа бидэнд илэн далангүй хэлээрэй. Одоохондоо хаанчилж байгаа тохиолдлын вангийн төлөө юу, эсвэл эрхэм дээд эзэн хааны төлөө юу? гэхэд

“Би вангийн талын хүн. Арван наймдугаар Людовикт үнэнчээр зүтгэх ам тангаргаа өгсөн болохоор түүндээ үнэнч байна” гэж генерал хариулав.

Энэ үг олны дургүйцлийг хүргэж, эрхэм де Эпинегийн бодлогогүй хэлсэн үгний нь бурууг хүлээлгэхийг хүссэн шинж хүмүүсийн царайд харагдаж байв.

Ерөнхийлөгч дахин босгож чимээгүй болгов.

“Эрхэм та одоо болж буй бадлын үр уршгийг тооцон бодохгүй байж чадахгүйгээр ухаантай хүн шүү дээ. таны илэн валангүй байгаа явдал вань биднээс танд нэгэн болзол тавихад хүргэж байна. та энэ сонссон зүйлээ хэнд ч юу ч хэлэхгүй гэж ам өг” гэж хэлэв..

Генерал сэлэмнийхээ бариулаас атга,

“Хэрвээ нэр төрийн тухай ярьж байгаа бол юуны өмнө хууль зүйгээс бүү хэтэрч, бүү хүчээр тулгах гээл байгаарай!” гэв.

Тэгэхэд ерөнхийлөгч генералын уур хилэнгээс дутуугүй нухацтай байдлаар

“Сэлмээ бүү шүүр эрхэм танд зөвлөө” гэв.

Генерал тэнд байсан хүмүүсийг эргэн тойрон харахад, энэ харцанд нь баахан түгшсэн байдал илэрхий байв. Гэвч бууж өгсөнгүй харин ч зүрх зоригоо чангалан,

“Би та нарт тийм тангараг өгөхгүй” гэж хэлэв.

“Хэрвээ тийм бол та үхэх л болж дээ” гэж ерөнхийлөгч тайвнаар хэлэв.

Эрхэм де Эпинегийн царай цонхийв. Тэр дахин эргэн тойрон сууж байгаа хүмүүсийг харав. Клубийн зарим гишүүн хорондоо шивнэлдэн, цуван доогуурааа зэвсгээ тэмтэрч байгаа харагдав.

“генерал та бүү зов. Та бол эцситйн аргыг хэрэглэхийн өмнө итгүүлэх бүх арга хэмжээг авах гэж оролдох нэр төртэй шударга хүмүүсийн дунд байгаа. Бас нөгөө талаас нь хэлбэл таны хэлснээр хуйвладгчдын дунд байгаа шүү. Таны гарт минийнууц байгаа болохоор та түүнийг минь бидэнд эргүүлэн өгөх ёстой” гэв.

Үүний дараа чимээ аниргүй олох нь быөгөөд генерал юу ч хариулсангүй.

“Хаалгаа түгж” гэж ерөнхийлөгч хэлэв.

Энэ үгийн дараа бас л чимээ аниргүй нам гүм байна.

Тэгэхэд генерал урагшаа гарч аймшигтай их хүч гарган

“Надад хүү бий. Би алуурчдын дунд байхдаа түүнийхээ тухай бодох үүрэгтэй” гэв.

Тэгэхэд хурлын дарга намбайтайгаар

“Генерал, нэг хүн тавин хүнийг айх зовох юмгүйгээр долромжилж байна. энэ бол сул дорой эрх ямба л юм л даа. гэвч үүнийг дэмий л хэрэгдэж байна. генерал та тангараглаж үз, биднийг бүү доромжлоорой” гэв.

Хурлын даргйн давуутайд автсан генерал минут хиртэ эргэлзсэнээ ерөнхийлөгчийн ширээнд дөхөж,

“Ямар тангараг тавих юм бэ?” гэж асуув.

“Энэ байна:

Би мянга найман зуун арван таван оны хоёрдугаар сарын тавны ес арван цагийн хооронд үзэж дуулсан зүйлээ хэзээ ч хэнд ч хэлэхгүй гэж тангараглья. Хэрвээ тангаргаа зөрчвөл намайг дээд зэргээр залхаах нь зүй гэж үзнэ”.

Генерал мэдрэл цочирдон дотор нь аягүй болсон учир хэдэн хомын турш юу ч хэлж чадахгүй байв. Тэр илтэд дургүйцсэн боловч шаардсан тангаргийг нь хэлэв. Тэгэхдээ дөнгөж дуулдах төдий хэлэв. Тиймээс зарим гишүүд дуулдахаар чанга хэлэхийг хүсэхэд хүслийг нь биелүүллээ.

“Би чөлөөтэй юу, үгүй юу? Одоо явмаар байна” гэж генерал хэлэв.

Ерөнхийлөгч босож дагаж явах хурлын гурван гишүүнийг сонгоод сүйх тэргэнд хамт сууж генералын нүдийг нь боов. Энэ гурван хүний дотро хөтчийн үүрэг гүйцэтгэсэн өнөө хүн байв.

Клубын бусад гишүүд чимээгүй тарцгаалаа.

“Бид таныг хааш нь хүргэж өгөх вэ?” гэж ерөнхийлөгч асуув.

“Та нараас л салбал хаашаа ч хамаагүй” гэж эрхэм д’Эпине хариулав.

“Эрхэм та одоо болгоомжлоорой. Хурал дээр байгаа биш, хэдхэн хүний дунд Үайна шүү. Тэднийг бүү доромжлоорой. Доромжилсныхоо хариуг тэднээр авахуулах гэж хүсээгүй л бол бүү тэгээрэй” гэж ерөнхийлөгч хэлэв.

Гэдэл д’Эпине энэ үгийн утгыг ойлгохын оронд:

“Дөрвөн хүн нэг хүнээс илүү хүчтэй байдаг болохоор та нар хурал дээр байсан шигээ сүйх тэргэн дотроо зоригтой байна.”

Ерөнхийлөгч сүйх тэрэг зогсоохыг тушаав. Тэд яг гол руу буусан шаттай эрэг дээр зогсчээ.

“Та нар яах гэж энд зогсов?” гэж эрхэм д’Эпине асуув.

“Яагаад гэвэл та хүн доромжилж гомдоосон. Тэгэхээр энэ хүн танаас хууль ёсныхоо хүслийг хангахаас нааш нэг ч алхам урагш явахгүй гэнэ” гэж ерөнхийлөгч хэлэв.

“Хүн алах бас нэг арга “гэж генерал мөрөө хавчин хэллээ.

“Эрхэм минь, таны саяын хэлсэн сул доройгоор бамбай хийж явдаг аймхай хулчгар хүн гэж өөрийгөө надад үзэгдэхгүй гэж хүсвэл дуугаа аядаарай. Та ганцаараа, би бас ганцаараа тантай үзэлцэх болно. Та сэлэмтэй, надад ч бас таяган дотор минь нэг юм бий. Танд өөрийн гэрч байхгүй, тэгэхээр энэ эрхмүүдийн нэг нь таны гэрч болно. Одоо та хүсвэл боолтоо авч болно” гэж ерөнхийлөгч хариу өгүүлжээ.

Генерал нүдээ боосон алчуурыг даруй авч хаялаа.

“Ямар хүнтэй учирснаа одоо л мэдлээ” гэж тэр хэлэв.

Сүйх тэрэгний хаалга онгойж дөрвүүлээ гарлаа...

Франц уншихаа дахин зогсож хүйтэн хөлс гарсан духаа арчлаа.хүү нь эцгийнхээ үхсэн тухай одоо хүртэл мэдэхгүй байсан зүйлийг дуулдахаар унших нь аймшигтай байв.

Валентина залбирах адил гараа зөрүүлэн зогсоно.

Нуартье, Вильфор өөд гаргаж хэлэхийн аргагүй бардам, жигшсэн байдлаар харж байв.

Франц цааш нь үргэлжлүүлэн уншсан нь:

- Энэ бол бидний дээр хэлснээр хоёрдугаар сарын тавны өдөр байлаа. Сүүлийн өдрүүдэд тав зургаан градус хүйтэрсэн учир шатан дээгүүр мөс хөлдсөн байв. Генерал өндөр том хүн байв. Ерөнхийлөгч шатаар гол руу буухдаа түүнийг шатны бариултай талаар явуулав.

Гэрчийн хоёр хүн тэдний хойноос дагав.

Харанхуй болсон байв. Шат ба голын хоорондох зай цас ба хяруунаас болж нойтон байсан бөгөөд зарим газраар нь хөлдсөн мөс хөвсөн гүнзгий гол харлан харагдлаа.

Гэрчийн нэг нь нүүрсний онгоцноос дэнлүү авчирч, дэнлүүнийхээ гэрэлд зэвсгүүдээ шалган үзэв.

Ерөнхийлөгчийн сэлэм ердийн хулсан таяган дотор авч явдаг энгийн сэлэм бөгөөд нөгөө этгээдийнхээ сэлэмнээс таван хуруу богино, гарын хамгаалалтгүй байв.

Генерал д'Эпине сэлмийг сугалаагаар өгөх санал гаргав. Тэгэхэд ерөнхийлөгч, энэ хүнийг ирүүл тулаанд дуудахдаа хүн бүр өөрийн сэлмээр тулалдана гэж бодсон юм гэв.

Гэрчүүд үүнийг зөвшөөрөх дургүй байсан боловч ерөнхийлөгч тэднийг дуугүй байхыг шаардав.

Дэнлүүг газар тавьж, тулалдагчид түүний хоёр талд зогсож, тулалдаан эхлэв.

Дэнлүүний гэрэлд хоёр сэлэм цахилгаан цахих адил харагдана. Харанхуй байсан учир хүмүүс бараг үл үзэгдэнэ.

Генерал бол арми даяар хамгийн шилдэг сэлэмчний нэгд тооцогдож байсан юм. гэвч асар ширүүн дайралттай тулгарч ухрахдаа газар уначихав.

Хүмүүс түүнийг алагдчихлаа гэж боджээ. Харин ерөнхийлөгч түүнийг шархдуулаагүйгээ мэдэх болохоор босгох гэж гараа өгөв. Энэ байдал генералын уурыг улам хүргэж, генерал давшлан оров.

Гэвч түүний дайсан нь алхам ч ухарсангүй дайралтыг нь хариулж байв. Генерал гурван удаа ухарч, гурван удаа довтлон дайрав.

Гурав дахь удаагаа генерал дахин унав.

Цөмөөрөө түүнийг халтирч уналаа гэж бодсон боловч босохгүй болохоор нь гэрчүүд нь очиж хөл дээр нь босгох гэж оролдов. Гэвч түүнийг өргөх гэж барьж авсан хүний гарт нойтон бүлээн юм баригдав.

Энэ бол цус байлаа.

Хагас ухаан алдсан генерал сэргэв.

“Миний өөдөөс хөлсний алуурчин, цэргийн хорооны сэлэмний багшийг тавьсан байна” гэж хэлэв.

Ерөнхийлөгч юу ч дуугарсангүй, дэнлүү барьж байсан гэрчүүд дээр очиж, ханцуйгаа шамлаад гар дээрх нэвт гарсан хоёр шархаа үзүүлэв. Дараа нь цамцаа тайлж, хантаазаа дэлгээд хажуу талаа харуулахад бас нэг шарх харлаж байв. Тэгэхэд тэр ганц ч ёолоогүй билээ.

Генерал татаж эхлэн таван минутын дараа үхлээ...

Франц энэ сүүлчийн мөрүүдийг арай гэж дуулдахаар аяархан уншив. Дараа нь бүрэлзээд байх шиг санагдсан нүдээ арчаад дуугүй болов.

Тэгээд минутын дараа дахин уншсан нь:--“Ерөнхийлөгч сэлмээ хулсан таягандаа хийгээд дахин шат өөд гарав. Түүний ард цусан мөр цасан дээр үлдэж байв. Түүнийг шатны дээд гишгүүрт хүрээгүй явахад нь ус пүл палхийн нуугарах чимээ сонстлоо. Энэ бол гэрчүүд генералын үхсэнийг магадлан мэдээд гол уу хаясан нь энэ байжээ.

Ингэж генерал, дараа нь элдвээр баталж мэдэх занганд биш үнэнч тулалдаанд нас барсан билээ.

Хэзээ нэгэн цагт энэ явдалд оролцсон хүмүүсийг нэр төрөө таягдан санаатайгаар хүн алсан гэж зэмлэвэл үнэн зөвийг нь тогтоохын тулд энэ протоколд гарын үсэг зурцгаасан нь энэ билээ.

Гарын үсэг зурсан: “Борепер, Дюшамни, Лешарпаль” гэжээ.

Хүүд нь хичнээн төвөгтэй байсан энэ зүйлийг Франц уншиж дуусахад Валентина сэтгэл хөдлөн нулимсаа арчив. Вильфор буланд шигдэн одоо болох аймшигтай юмыг зайлуулах гэсэндээ өвгөнийг гуйж царайчилсан байдалтай харна.

- Эрхэм та, гээд д'Эпине Нуартье өөд хөндөж—Энэ аймшигт явдлын нарийн шириийнийг тодорхой мэдэж, хүндэт хүмүүсээр гарын үсэг зуруулжээ. Та намайг сонирхож байгаа болохоор энэ сонирхол тань надад одоохондоо зөвхөн зовлон учруулж байгаа ч гэлээ надад сүүлчийн удаа тус хүргэхийг танаас гуйя. Надад клубын ерөнхийлөгчийн нэрийг хэлж өгөөч. Би эцгээ алсан хүнийг мэдэж авъя даа гэв.

Вильфор бүр тэвдэж, хаалганы бариул эрэв.

Валентина, өвгөний гар дээр сэлмээр хатгасан хоёр сорви байдгийг нэг биш удаа үзсэн учир, хариулт ямар болохыг урьдаас тааварлан мэдээд алхам ухарлаа.

Тэгэхэд Франц эхнэр болох гэж байгаа бүсгүйгээс,

- Мадмуазель та тэнгэрийг бодож, эцгийг минь алж, хоёр настай байхад минь өнчин хоцроосон тэр хүний нэрийг мэдэхэд туслаач! гэж хэлэв.

Валентина хөдлөхгүй дуугүй зогсоно.

- Хүүш ингэхэд, энэ айхавтар үзэгдлийг үргэлжлүүлэхээ больё. Тэгээд ч бас нэрийг нь зориуд далдалсан байгаа байх. Миний эцэг тэр ерөнхийлөгч хэн байсныг мэдэхгүй л дээ, мэдсэн ч байсан гэсэн танд дамжуулан хэлж чадахгүй. Толь бичиг дотор хүний нэр байхгүй шүү дээ гэж Вильфор хэлэхэд, Франц дуу алдаж,

- Ямар золгүй хэрэг вэ? Эцгийгээ алсан хүний нэрийг мэдэх гэсэн ганц найдлага л намайг энэ захидлыг дуустал нь унших хүч өгсөн юм! гэж хэлээд Нуартъед хандаж— Эрхэм минь бурхныг бодож, тэр хүний нэрийг хэлж өгөхийг чадах ядахаараа оролдож үзээч... гэж гуйв.

- Тэгье гэж өвгөн нүдээрээ хариулав.

- Мадмуазель! Өвгөн аав чинь тэр нэрийг хэлж өгч чадна гэж дохиж байна...Надад туслаач...Та түүний хэлэхийг мэднэ шүү дээ... гэж Франц дуу алдав.

Нуартъе толь бичиг өөд харав.

Франц сэтгэл нь догдлон толь бичгийг гартаа авч цагаан толгойн үсгийг А,Б хэмээн чичигнэн уншив.

Б үсгэн дээр өвгөн тийм гэж дохив.

- Б юм биз дээ гэж Франц давтан хэлэв.

Залуу хүн үгнүүд дээгүүр хуруугаараа заах боловч өвгөн тухайн бүр биш хэмээн дохиж байв.

Валентина гараараа нүүрээ таглав.

Эцэст нь Франц биеийн төлөөний үг “би” гэсэн дээр заалаа. Тэгэхэд өвгөн

- Тийм гэж дохив.

- Та юу? гэж Франц дуу алдаад, үс нь босч--Та эрхэм Нуартъе та юу? Та миний эцгийг алсан юм уу? гэв.

- Тийм гэж ихэмсэJ дүрээр түүний нүүр өөд харан дохилоо.

Франц тамир нь алдран садал дээр унав.

Вильфор өвгөний номхотгошгүй зүрхэнд үлдээд байгаа амьдралын өчүүхэн очийг нь дарж унтраах юм сан гэж тэсэлгүй хүсэх учир хаалга онгойлгож тасалгаанаас гүйн гарлаа.

19.ХҮҮ КАВАЛЬКАНТИЙН АМЖИЛТ

Тэр завсар эцэг Кавальканти Парисаас албан тушаалдаа эргэн орохоор явахдаа Австрийн дээд эзэн хааны цэрэгт бус харин, луккийн рашаан усны [roulette](#)¹ хэмээх мөрийтэй тоглоомын газар руу явав. Энэ тоглоомын газрын хамгийн идэвхтэй тоглогчдын нэг байсан ажээ.

Өөрийн аялал ба эцгийн дүрд сүртэй сайхан тоглосныхоо хөлс шанг нэг ч зоос дутаалгүй авч явсныг хэлэх юун.

Түүнийг явахад нь Андреа, бэйл Бартоломео, түүний гэргий Олива Корсинарын хүү мөн гэсэн баримт бичгүүдийг өвлөн авчээ.

Тэрээр ийнхүү гадаадын хүнийг хэн болох нь хамаагүй, харин хэн болох хүсэлтэнд нь тохируулан харьцдаг Парисын дээдсийн хүрээлэнд их бага ямар нэг хэмжээгээр бат орж авав.

Парист залуу хүнээс юуг шаарддаг вэ? Юухан хээхэн ярьчхаж чаддаг, аятайхан хувцаслачихдаг, зоригтойхон тоглоод алтаар төлчихдөг л байвал болох нь тэр.

Парисынхныг бодвол гадаадын хүнээс бүр ч бага зүйл шаарддаг нь мэдээж хэрэг.

Ингээд хоёр долоо хоногийн дараа Андреа муугүй байдалтай болж авлаа. Хүмүүс түүнийг гүн хэмээн нэрлэж, жилд тавин мянган ливрийн орлоготой гэгцгээж, эцэг нь Саравецкийн чулуу авдаг газар булсан хэмжээ хязгааргүй их хөрөнгөтэй гэж ярилцах болов.

Бас нэг эрдэмтэн тэр газрыг үзсэн мэт ярьсан нь бүрэн үндэстэй болж батлгдаагүй байсан яриаг бүр ч баттай болгов.

Бидний уншигчдаа дагуулан очсон Парисын дээдсийн хүрээлэн Монте-Кристог нэг орой эрхэм Дангларынд очиход иймэрхүү байдалтай байв. Данглар гэртээ байсангүй. Харин хатагтай Данглар байсан болохоор гүнг ирсэн тухай түүнд хэлэх эсэхийг асуухад гүн зөвшөөрчээ.

Отейлийн цайллага, түүнээс хойш болсон үйл явдлын дараа хатагтай Данглар Монте-Кристо гүнгийн нэрийг чичрэн догдлохгүй сонсож чадахаа байжээ. Нэр нь дуулдаад араас нь гүн өөрөө хүрч ирээгүй бол хатагтай улам ч аймаар байдалд орох байв. Тэгтэл гүнг өөрөө үзэгдэхэд нь хатагтай түүний цайлган царай, гялалзсан харц, ээвэргүү дотно байдлыг нь хараад түгшсэн сэтгэлийн нь сүүдэр амархан арилжээ. Гадна талдаа ийм сайхан хүн, ямар нэг муу юм санаж явах гэдэг боломжгүй мэт хатагтайд санагдана. Ер нь зан байдал нь эвдэрсэн хүн ч гэсэн ашиг хонжоо л хараагүй бол хүнд муу юм хийдэггүй билээ. Ямар ч зорилго шалтгаангүй хор хүргэнэ гэдэг бол гутамшигтай хэрэг.

Бид дээр нэг удаа уншигчдаа дагуулан орсон хүлээн авах өрөөнд Монте-Кристог ороход, охин нь хүү Кавальканти хамт үзээд ээждээ өгсөн зургийг цаанаа л нэг тайван биш харцаар гүйлгэн харж байв.

Гүнгийн ирсэн явдал ердийнхөө нөлөөг үзүүлж түүний нэрийг дуулаад тэвдсэн хатагтай инээмсэглэн угтав.

Гүн ганц хараад л бүх байдлыг ойлгожээ.

Зөөлөн бандан дээр налж суусан хатагтайн хажууд Эжени сууж, түүний өмнө Кавальканти зогсож байв.

Кавальканти, Гётегийн зохиолын баатар шиг тас хар хувцас, гялгар хар шаахай өмсөж, зэгсэн цагаан танхилхан гараараа шар үсээ илбэж, биеэ тоох дуртай залуу хүн, Монте-Кристогийн зөвөлгөөг хайхралгүй чигчий хуруундаа зүүсэн очир алмас бөгжийг гялалзуулан байв.

Энэ хөдөлгөөнийг мадмуазель Дангларын зүг унаж гүйцсэн байдлаар харж, санаа алдах явдал дагалдана.

Мадмуазель Данглар биедээ итгэлтэй, өөрөөр хэлбэл гоо сайхан боловч хүйтэн, зэвүүн доогтой байв. Андреагийн нэг ч харц, нэг ч санаа алдах нь бүсгүйд мэдэгдэхгүй өнгөрсөнгүй. Андреагийн байдал нь зарим гүн ухаантны нотолдгоор, Сафогийн ¹ цээжийг хамгаалж байсан хуяг буюу Минервийн хуягийг мөргөх адил талаар өнгөрч байв.

Эжени гүнд хүйтнээр мэхий ёслоод, яриаг далмдуулан хичээл хийхэд зориулагдсан өрөө уруугаа явав. Удалгүй тэндээс төгөлдөр хуур хөгжмийн эгшиг доор хөгжилтэй хоёр чанга дуу дуулдана. Гүн түүнийг сонсоод мадмуазель Данглар эрхэм Кавальканти тэр хоёр хамт байхаасаа өөрийн дууны багш Луиза де Армилитэй хамт байхыг илүүд үзжээ гэж мэдэв.

Тэр завсар хатагтай Дангларын ярианд бахдан шагшсан мэт байсан гүн Андреа Кавальканти санааширсан байдалтай байхыг нь ажиглав. Тэр байна байн хаалга уруу очиж хөгжмийг чагнан хаалга уруу очоод орчхож учир бахадсанаа хөдөлгөөнөөр илэрхийлнэ.

Удалгүй банкны эзэн гэртээ хүрч ирлээ. Тэр эхлээд гүн өөд харсан боловч дараа нь харцаа Андреа өөд тусгав.

Эхнэрий тухайд гэвэл олонх нөхрүүд эхнэртэйгээ эхлээд мэнэдэлдэг ёсоор мэндлэв.

- Манай авгайчууд таныг хөгжмийн хичээлээ хамт хийе гэж урихгүй байна уу? гэж банкны эзэн Андреагаас асуухад тэр улам ихээр санаа алдаж,

- Үгүй л байна шүү дээ гэж хариулав.

Данглар даруй үүдэнд очоод онгойлгов.

Төгөлдөр хуурын өмнө ганц дөрвөлжин сандал дээр хуваан суусан хоёр бүсгүй харагдана. Нэг нэг гараараа даран хослон тоглож байгаа ая нь ихэд амжилт олсон өөрсдийнх нь зохиол байжээ.

Онгорхой хаалгаар, Германд ихэд дурладаг жаазанд байгаа амьд зураг мэт Эженитэй хамт сууж харагдах мадмаузель де Армили гоо сайхантай чухам нүдэнд дулаан бүсгүй байв. Намхан нуруутай жижиг нарийхан биетэй, хүзүүгээ бүрхсэн алтан шаргал үстэй, ядарсан байрын нүдтэй хүн байв. Сул биетэй, уушги муу болохоор “Кремоны хилийн” Антон шиг, нэг л өдөр дуулж байгаад ойччих байх гэж хүмүүс ярьдаг байв.

Гүн тэр хоёрыг түргэн зуур сонирхон харав. Эднийд ирэхдээ олон удаа нэрийг нь дуулсан мадмаузель де Армилиг анх удаа үзэж байгаа нь ажээ.

- Ингэхэд бид яах болж байна? Биднийг хайхрахгүй хэрэг үү? Гэж банкны эзэн охиноосоо асуув.

Дараа нь Андреаг зочдын өрөөнд оруулаад санаатай санаагүй алин боловч гүн хатагтай хоёрын сууж байсан газраас харагдахааргүйгээр хаалгаа дутуу хаав. Түшээ гүн Андреагийн хойноос дагаж гарсан болохоор хатагтай Данглар үүнийг анзаарсан ч үгүй.

Удалгүй Андреа төгөлдөр хуурын эгшгэнд корсик дуу дуулахыг гүн сонсов.

Гүн дууг чагнан Андреаг мартаж, Бенедеттог санаж суух завсар хатагтай Данглар түүнд нөхрийгөө өнөө өглөө Миланы нэгэн пүүс дампуурснаас болж дөрвөн зуун мянган франк алдчихаад байгаа боловч биеэ барьж чаддаг хүн юм гэж бахдан ярьж байлаа.

Нээрээ ч түшээ гүн бахадмаар байлаа. Хэрэв гүн энэ тухай хатагтайн амнас мөн бүхнийг мэдэж чаддаг тэр аргуудынхаа нэгээр мэдсэн байгаагүйсэн бол түшээ гүнгийн царайгаар юу ч мэдэхгүй байв.

“Тийм бий! Хэдийнээ алдагдлаа нуух болж байх шив. сарын өмнө үүгээрээ бардамнаж байсан биш бил үү?” гэж гүн бодлоо.

Дотроо ингэж бодсон боловч,

-Хатагтай минь, эрхэм Данглар зах зээл сайн мэддэг болохоор нэг газар алдлаа ч гэсэн түүнийгээ нөгөө газраас нөхөөд авчихна гэж хэлэхэд хатагтай,

-Та бас л олны адил төөрөлдөж байна гэв.

-Ямар төөрөгдөл? гэж гүн асуув

-Бүгд л эрхэм Дангларыг мөнгөний худалдаа хийлдэг хүн гэж ярьдаг. Гэвч энэ бол худлаа.

-Өө нээрээ тийм... эрхэм Дебрэ надад ярьсан юм байна...Үгүй ингэхэд эрхэм Дебрэ яагаад үзэгдэхээ больчихов? Түүнийг гурав дөрвөн өдөр харсангүй.

- Би ч бас гэж хатагтай гайхам итгэлтэйгээр хэлээд – Та нэг юм ярих гэснээ дутуу орхичихлоо гэж хэлэв.

- Юуны тухай ярьж байлаа?

- Дебрэ танд нэг юм ярьсан гэж...

- Өө тийм таныг мөрийцөхдөө дуртай хүн гэж тэр хэлж байсан.

- Тийм ээ, үнэн. Нэг үе тийм байсан юм. харин одоо аз туршихаа байсан гэж хатагтай өгүүлэв.

- Тэр чинь дэмий болж дээ хатагтай минь. хувь заяа гуйвамтгай, тэгээд ч бас наймаа арилжаанд азтай азгүй явдал гэж байдаг. Би эмэгтэй хүн, бүр тэгээд банкны эзний эхнэр байсан бол нөхрийнхөө азтайд хэдий итгэдэг байлаа ч гэсэн, өөрийн тусгай хөрөнгөтэй байна да. Өөрийн эрх ашгийг танихгүй хүнд ч гэсэн итгэж гардуулж байгаад ийм хөрөнгөтэй болно.

Хатагтай Данглар өөрийн эрхгүй дүрс хийлээ. Тэгэхэд гүн түүнийг нь ажиглаагүй дүр үзүүлэн,

-Жишээлбэл та өчигдөр Неополитаны мөнгөн тэмдэгтийн амжилтын тухай дуулсан уу? гэв.

-Надад тэр тэмдэгтээс байхгүй. Хэзээ ч байгаагүй. үгүй гүн минь ингэхэд та бид хоёр худалдааны төлөөлөгчид шиг зах зээлийн тухай бишгүйдээ ярилаа. Одоо гай зовлон мөрдөн дагаад байх болсон золгүй Вильфорын тухай ярилья гэж хатагтай хариулав.

-Тэднийд юу болчихоов? Гэж гүн огтын цагагнаар асуув.

-Эрхэм Сен-Меран гэрээсээ гарснаас хойш гурав дөрөв хоноод нас барчихсан. Одоо авгай нь бас энд ирээд талийгаач болчихлоо.

-Өө тийм, би энэ тухай дуулсан. Харин энэ чинь Клавдий Гамлетад хэлдэг шиг байгалийн хууль юм биш үү. Тэдний эцэг түрүүлж үхсэн, тэд гашуудсан. 'эд өөрсдийн хүүхдүүдээс өмнө үхсэхэд, хүүхдүүд нь гашуудан оршуулна шүү дээ гэж гүн хэлэв.

-Гэхдээ бас үүгээр дуусаагүй шүү.

-Яагаад дуусаагүй гэж?

-Үгүй, тэд охиноо хүнтэй суулгах гэж байсан...

-Тийм ээ, эрхэм Франц де Эпинетэй. Хурим нь хойшлогдчихлоо гэж үү?

-Өчигдөр өглөө Франц тэдэнд хэлсэн үгээ буцааж авсан гэж ярьцгаа байна.

-Нээрээ юү? Эв тасрах ямар шалтгаан байсан юм бол?

-Мэдэгдэхгүй байна.

-Өршөөлт бурхан минь! Та юу ярина вэ? Вильфор энэ гай зовлонгоо яаж тэсвэрлэн өнгөрүүлж байгаа юм бол?

-Бахь байдгаараа л гүн ухаантны ёсоор тэвчиж байна.

Энэ үед Данлар орж ирлээ.

-Та Кавальканти охинг ганцааранг нь охинтой орхиж ирж байгаа юм уу? гэж хатагтайг асуухад,

-Аа мадмаузель Армилийг та юу гэж бодож байна? гэж хариу асуув.

Дараа нь гүн үрүү эргэн,

-Энэ Кавальканти ноён хонгор сайхан ноён байна шүү тийм ээ? Тэгэхдээ үнэхээр ноён юм уу? үгүй юм уу?

-Би баталж чадахгүй байна. түүний эцгийг надад бэйл л гэж танилцуулсан юм. тэгэхээр гүн л байх даа. гэхдээ өөрөө ноён хэргэмтэй гээд зүтгээд байдаггүй юм шиг санагдсан.

-Яагаад тэр вэ? Хэрэв ноён л юм бол нуугаад байх хэрэг юу байна? Хүн бүр өөрийнхөөрөө байх эрхтэй. Өөрийн гарал үүслийг үгүйсгээд байхад дургүй гэж банкны эзнийг хэлэхэд, гүн инээмсэглэж,

-Та ч цэвэр ардчилсан үзэлтэн юм аа? гэв.

-Хүүш ингэхэд Морсер гэнэт хүрээд ирвэл та өөрийгөө ямар байдалд оруулж байна даа. Эженийн болзоот хүн түүнийг орохыг зөвшөөрдөггүй өрөөнд Кавальканти байхыг харвал тэр хүн юу гэх вэ? гэж хатагтай хэлэхэд,

-“Гэнэт” гэж хэлдэг маш зөв. Үнэндээ ч манайд цөөн ирдэг хүн, хэрэв ирвэл тэгж гэнэт гэмээр ирэх л юм даа.

-Хүрч ирээд энэ залууг охины тань дэргэд байвал дургүйцэж мэдэх юм.

-Дургүйцэх ий? Та ташаарч байна! Эрхэм бэйс та болзоот хүүхэндээ төдий л сайнгүй учир харддаггүй юм. тэгээд ч ер дургүйцнэ үү? Байна уу? надад ямар хамаа байна вэ?

-Бидний хоорондын харьцаа...

-Өө бидний харьцаа юу? Бидний ямар харьцаатайг хэлээд өгөх үү? Эхийнхээ хийсэн бүжигт наадам дээр, тэр болзоот хүүхэнтэйгээ дөнгөж ганц удаа бүжиглэсэн, тэгэхэд эрхэм Кавальканти гурван удаа бүжиг хийсэн. Гэтэл хүний урманд ажиглаа ч үгүй.

-Эрхэм Альбер де Морсер ирлээ гэж зарц нь айлтгав.

Хатагтай яаран бослоо. Тэр зочдын бага өрөөнд орж охиндоо мэдэгдэх гэтэл Данглар гараас нь бариад – Боль боль гэхэд түүн өөд гайхан харав.

Гүн үүнийг хараагүй юм шиг сууж байлаа.

Альбер орж ирлээ. Их сайхан хөгжилтэй харагдлаа. Альбер хатагтайд нүүрэмгий мэхийн ёслоод Данглартай хээгүйхнээр, гүнтэй нөхөрсгөөр мэхийн ёслов.

-Мадмаузель Дангларын бие сайн уу гэж хатагтай танаас асууж болохсон болов уу? гэхэд Данглар түргэн босож аваад,

-Маш сайн байгаа. Эрхэм Кавалькантитай хамт зочдын өрөөнд хөгжмийн хичээл хийж байгаа гэж хэлэв.

Альбер тайва, хайхрамжгүй байдалтай байв. Жаахан хор нь хөдөлсөн баймаар янзтай байсан боловч гүн өөрийг нь харж байгаа мэдэрчээ.

-Эрхэм Кавальканти сайхан баргил хоолойтой, Эжени төгөлдөр хуураар Тальберг шиг тоглодгийг нь хэлэлгүйгээр сайхан тунгалаг хоолойтой болохоор гайхалтай сайхан концерт байх ёстой доо.

- Ямар ч л гэсэн энэ хоёрын хоолой нийлж байна аа гэж Данглар хэлэхэд Альбер энэ бүдүүлгээр хэлсэн хоёр утгатай үгийн учрыг мэдээгүй юм шиг өнгөрч, хатагтай Дангларын царай улайв.

-Би ч бас хөгжимчин хүн. Лав л багш нар тэгж хэлдэг юм. харин хэзээ ч хэнтэй ч хоолой нийлдэггүй нь харамсалтай. Тунгалаг цээл хоолойто бусдыгаа бодвол бүр ч муу нийлдэг юм гэж Альберын ярихад данглар хүйтнээр инээмсэглэж "Алив уурлаадхаач" гэсэн байдалтай харав. Данглар ямар ч байсан санасандаа хүрэх гэж

-Өчигдөр манай охин ноён хоёр олны бахархлыг татсан. Өчигдөр та манайд байгаагүй бил үү? гэж асуухад

- Ямар ноён?

-Кавальканти ноён гэж Андреаг байнга энэ хэргэмээр нь дууддаг Данглар хэлэхэд Альбер,

-Уучлаарай би түүнийг ноён хүн гэж мэдсэнгүй. Тэгээд өчигдөр ноён Кавальканти мадмаузель Эженитэй хамт дуулсан юм уу? Лав их сайхан болсон байх ёстой. Би сонсож чадаагүй нь харамсалтай. Гэвч би таны урилгыг хүлээн авах аз тохиолдоогүй болохоорээжийг дагаж хөгшин хатагтай Шато-Реногийнд очсон. Тэнд Германууд дуулсан гэж хэлэв.

Дараа нь Альбер хэсэг зуур байснаа юу ч болоогүй юм шиг,

-Би мадмаузель Дангларыг хүнээтгэж байгаагаа илэрхийлж болох сон болов уу? гэхэд Данглар түүнийг зогсоож,

-Үгүй шүү жаахан хүлээж бай. Би танаас гуйя. Сайха дуулж байна шүү, гайхам сайхан байна, та, та, та, ти, ти, ти. За одоо дууслаа жаахан хүлээ. Бахдалтай байна. Сайхан, сайхан гэснээ банкны эзэн учир зүггүй алгаа ташив.

- Нээрээ сайхан байна. Кавальканти ноёны ойлгож байгаагаас илүүгээр төрсөн орныхоо хөгжлийг ойлгох боломжгүй юм шиг байна. та түүнийг “ноён” гэсэн байх аа. ноён биш ч байлаа гэсэн түүнийг ноён болгочихно. Энэ бол Италид амархан хэрэг. за тэр яах вэ. Гайхалтай дуучныхаа тухай ярья. Та мадмазель Даглар Кавальканти ноён хоёрт гадны хүн байгаа гэж хэлэлгүйгээр дахин нэг дуулахыг хүсэж, биднийг зугаацуулахгүй юу? Ингэж тоглож байгаа хүнээ ч харахгүй, тоглож байгаа хүнлээ ч харагдахгүй алсхан байж байгаад хөгжим сонсох сайхан байдаг юм. тэгэхэд л тоглогч хүн өөрийнхөө авьяас чадлыг гаргаж, зүрхнийхээ догдлолыг үзүүлдэг юм.

Энэ удаа Данглар Альберын хайхрамжгүй байдалд арга нь тасарчээ.

Тэгээд гүнг хажуу тийш нь аваачиж,

-За манай сэтгэлт залуугийн тухай юу гэж хэлмээр байна? гэж асуув.

-Нэлээд хүйтэн янзтай нь ч маргаангүй байна л даа. одоо яая гэх вэ, та ам өгчихсөн биз дээ!

-Тийм ээ, ам өгсөн, гэхдээ юун тухай гээч. Охиноо сайн хүнд өгнө гэж амласнаас биш сэтгэлгүй хүнд өгнө гээгүй. Энүүнийг хар л даа. гантиг чулуу шиг хүйтэн эцэг шигээ ихэмсэг амьтан. Баян байгаад кавальканти шиг хөрөнгөтэй байсан бол үүнийг анзаарахгүй байж болох сон. Нуулгүй хэлдэхэд би охиныхоо саналыг асуугаагүй байгаа юм л даа. хэрэв охин маань сайхан муухайг ялгаж мэддэг хүн сэн бол...

-Мэдэхгүй юм даа. би түүнд талтай байдаг маань намайг харалган болгож байгаа ч юм уу бүү мэд. Ямар ч л гэсэн Морсер бэйс таны охиныг аз жаргалтай байлгаж, эрт орой алин боловч нэг юманд хүрэн хүн шиг санагддаг юм. эцэг нь ч гэсэн өндөр тушаалтай хүн шүү дээ гэж гүн хэлэв.

-Үгүй ер гэж Данглар бувтнав.

-Та эргэлзэж байна уу?

-Өнгөрсөн үе нь нэг л биш...Хар бараан юм байгаа даа.

-Гэвч эцгийн нь өнгөрсөн үе хүүд нь хамаагүй шүү дээ.

-Огт тийм биш.

-Та ингэж өөртөө бүү итгүүл. Та ганцхан сарын өмнө Морсерыг дээд зэргийн тохирох хүн гээд л байсан шүү дээ. Би цөхрөхөд хүрч байна. Яагаад гэвэл та манайд л энэ Кавальканти гэдэг залуутай танилцсан шүү дээ. би тэр хүнийг огт мэдэхгүй гэдгээ дахин хэлье.

-Харин би түүнийг мэднэ. Энэ л боллоо гэж Данглар хэлэхэд гүн,

-Та түүнийг мэднэ гэнэ ээ? Та түүний тухай судалгаа хийгээ юу? гэж асуув.

-Энэ тийм хэрэгтэй юм гэж үү? Хараад л хэн болохыг нь мэдэж болохгүй гэж үү? Юуны өмнө их баян хүн юм.

-Би үүнд итгэхгүй байна.

-үгүй, та түүний төлөө хариуцдаг шүү дээ?

-Энэ бол өчүүхэн юм. тавьхан мянган франк.

-Сайхан боловсролтой хүн юм.

-Үгүй ер гэж гүн хэлэв.

-Тэр чинь хөгжимчин хүн.

-Италичууд цөмөөрөө хөгжимчин байдаг юм.

-Гүн та түүнд шударга биш байна шүү.

-МорсГрт таны ам өгснийг мэддэг болох®ор итали залуу баянаараа түрээ Үарин урдуур нь дайрч байгааг харахад гомдмоор байна.

Данглар инээд алдаад,

-Та дэндүү хатуу байна шүү! Хорвоо ер нь л имй байдаг юм шүү дээ гэв.

-Гэвч та ингэж тасарч болохгүй шүү. Морсерийхан энэ гэрлэтийг хүлээж байгаа.

-Тийм гэж үү?

-Мадаггүй юм.

-Тэгвэл учраа ололцог. Эрхэм гүн та тэднийд хүндлэгддэг болохоор энэ тухай үг цухуйлгахгүй юу.

-Би юу? Та үүнийг хаа хараа вэ?

-Бүжигт наадам дээр яаж байгааг л харья л даа. хуучин танилуудтайгаа хүртэл арай гэж дуугарсаар болдог, бардам ихэмсэг испани хүүхэн Мерседес таныг сугадан цэцэрлэг рүү хөтлөн явж, хамгийн харанхуй буланг сонгон авч хагас цаг болсны дараа эргэж ирсэн шүү дээ.

-Ай түшээ гүн минь. та биднийг хөгжим сонсоход саад болж байна. танд шиг ийм хөгжимд дуртай хүнд бүдүүлэг хэрэг гэж Альбер хэлэхэд Дагнгллар,

-Эрхэм доогтой гүн минь, зүгээр, зүгээр гэж хэлэв.

Дараа нь гүн өөд дахин эргэж,

-Та миний хэлдгийг эцэст нь дуулгаж өгөх үү? Гэж асуув.

-Та тэгж хүсээд байгаа юм бол яая гэх вэ.

-Энэ тухай бол бүх зүйл тодорхой болох ёстой. Юуны өмнө охиныг минь гуйж хугацаагаа тогтоогоод мөнгөнийхөө тоог хэлэг. Ер нь энэ удаа бол нэг бүрэн тохирно, нэг бол бүр салж одно, харин хойшлуулах юм гэж байхгүй шүү.

-За яах вэ, хэлэлцээр хийг л дээ.

-Би онц дуртай байна гэж хэлж чадахгүй ч гэсэн хүлээж л байна. банзны эзэн хүн бол хэлсэн үгийнхээ боол байх ёстой гэж Данглар хэлээд хагас цагийн өмнө хүү Кавальканти санаа алдаж байсан шиг санаа алдлаа.

Альбер банкны эзнийг дуурайж дөнгөж сая дууссан аялгууг магтан,

-Сайхан байна, сайхан байна гэж алга ташив.

Данглар нэгэн юмны тухай зарц нь мэдэгдэхэд Альбер өөд хялайн харж байв. Тэгээд гүнд,

-Би одоолхон ороод ирнэ. Хүлээж байгаарай. Танд нэг юм дуулгах хэрэг ч болж магадгүй гэж хэлээд гарч одлоо.

Хатагтай нөхрийнхөө байхгүйг ашиглаж охиныхоо зочдын өрөөний хаалгыг онгойлговол, мадмаузель Эженитэй төгөлдөр хуурын өмнө зэрэгцэн сууж байсан Андреа оньстой юм шиг ухасхийн босов.

Альбер инээмсэглэн мэхэсхийвэл мадмаузель огтохонч зовсон шинжгүйердинь хүйтэн байдлаараа хариу мэндлэв.

Кавалькантинд илэрхий байсан нь илэрхий. Тэр Морсерт мэхийн ёслоход цаадах нь ихэмсэг байдлаар хариу мэндлэв.

Дараа нь Альбер мадмаузель Дангларын хоологй магтан сайшааж, олноороо тийм их амжилттай болсон гэж үзэж байгаа өчигдрийн тэр үдэшлэг дээр байгаагүйдээ харамсаж байгаагаа хэлэв.

Чөлөөтэй болсон Кавальканти гүнг хажуу тийш нь аваачив.

-Алив та минь хөгжимдөж дуулж бие биедээ манж үг хэлэхэ больё. Явж цай ууцгаая гэж хатагтай Данглар хэлэв.

Мадмаузель Данглар найз бүсгүйдээ,

-Явья гэж хэлэв.

Цөмөөрөө цай уухад бэлтгэж зассан зочдын хажуу өрөөнд орлоо.хүмүүс цайгаа уугаад англи ёсыг баримтлан халбагаа яаган дотроо орхитол хаалга нээгдэж Данглар сэтгэл нь хөдөлсөн байртай орж ирэв.

Гүн энэ б идлыг нь бүхнээс түрүүн ажиглааа Данглараас асуусан байдалтай харав.

-Би сая Грегээс захидал авлаа гэж Данглар хэлэхэд,

- Тийм учраас л таныг дуудаа юу? гэж гүн асуув.

- Тийм ээ.

- Хаан Оттаны бие сайн байна уу? гэж Альбер хөгжилтэй дуугаар асуув.

Данглар түүн өөд хялайн хараад юу ч хариулсангүй. Харин Монте-Кристо царайн дээрээ гарч ирээд алга болчихсон өрөвдсөн байдлаа нуухын тулд буруу харав.

- Хоёулаа хамт гарах уу? гэж Альбер гүнд хэлэхэд,

- Тэгвэл тэгье л дээ гэж цаадах нь хариулав.

Альбер банкны эзнийг яагаад ингэж харж байгааг мэдэхгүй учир түүний шалтгааныг сайн мэдэж байсан Монте-Кристо гүнээс,

- Намайг яаж харсныг та ажиглав уу? гэж асуув.

- Ажигласан, тэгэхдээ түүний харцанд ер бусын юм байлаа гэж үү?

- Байхаар барах уу, тэр грегээс ирсэн захидлаар юу хэлэх гээ юм бол?

- Би яаж мэдэх вэ дээ.

- Би таныг тэр оронтой зарим талаар холбоотой гэж санасан юм.

Монте-Кристо хариу хэлэхдээ зайлсхийх гэхээрээ инээмсэглэдэг байдлаараа мушилзав.

- Хараач, тэр тан руу ирж явна. Би мадмуазель Данглар дээр очиж гээгний нь танан даруулгыг магтаад ирье. Энэ завсар аав нь тантай ярилцаж амжих байх гэж Альбер хэлэхэд Монте-Кристо,

- Та түүнийг магтъя гэж байгаа бол ердөө хоолойг нь магтаж үзээрэй гэв.

- Үгүй, өөр хэн ч тэгж магтаж чадна.

- ЭрхСм бэйс, та бардам байдлаараа гайхуулж байна шүү гэж Монте-Крист® хэлэв.

Альбер инээмсэглэсээр Эжени руу очив. Тэр завсар Данглар гүнгийн чихэнд хошуу ойртуулан,

- Та надад маш сайхан зөвөлгөө өгчээ."Фернан", "Янина" гэдэг хоёр үгэнд аймшигтай явдал агуулагдаж байжээ гэж шивэглэв.

- За боль доо

- Би танд бүгдийг хэлнэ. Харин энэ залууг эндээс гаргаач. Үүний энд байх нь надад их тээртэй байна.

- Би цуг явъя гэж бодож байсан юм. Бид хоёр хамт гарна. Та бас л түүний эцэгтэй уулзах гэсэн хэрэг үү?

- Хэзээ хэзээнийхээс ч илүү хүсч байна.

- За сайн.

Гүн Альбер өөд дохив.

Хоёул авгайчуулд мэхийн ёслоод гарч одлоо. Альбер нь мадмуазель Дангларын ихэмсэг байдлыг огт хайхраагүй юм шиг, харин Монте-Кристо нь хатагтай Дангларт банкны эзний эхнэр хүн бол урьдаас болгоомжтой байж, ирээдүйгээ хангаж авсан байх хэрэгтэй гэдэг өнөө зөвлөгөөг дахин хэлээд гарчээ.

Тулалдааны талбай эрхэм Кавалькантид үлдэв.

20.ГАЙДЕ

Гүнгийн сүйх модот гудамжны булан дөнгөж тойртол Альбер тачигнатал хөхрөх нь үнэнээсээ инээж байгаад итгэхээс өөр аргагүй байв.

Есдүгээр Карл ван Варфоломейн шөнийн дараа би өөрийн өчүүхэн дүрд сайн тоглов уу, яав? гэж Екатерина Медичаас асууж байсан шиг би одоо танаас асуухыг хүсч байна гэж хэлэв.

- Ямар утгаар тэр вэ? гэж гүн асуув.

-Өрсөлдөгчөө эрхэм Дангларын гэрт өөриймшүүлэх талаар...

- Ямар өрсөлдөгч?

- Юу ямар гэж? Таны инээж асрамжилдаг Андреа Кава«ьканти!

- Тэнэг тоглоомоо болиорой, бэйс. Би андреаг огтхон ч иүүээсэн юм алга. Дангларынд бол бүр ч үгүй.

- Залуу хүнд ивээл хэрэгтэй болоод байгаа үедсэн бол ч таны ингэж хэлж байгааг зэмлэмээр байна. харин аз болоход надад ийм хэрэг болсонгүй.

- Тэр сэтгэлтэй болчихсон юм шиг танд санагдаж байна уу?

- Баталж байна. Нүд нь талимаарч санаа алдан сэтгэлтэй хүний ёсоор дуу дуулж байх болжээ. Ихэмсэг Эженитэй гэрлэх тухай санааширч суугаа хүн байна. Харж байна уу, би шүлэглэж байна шүү! Энд миний буруу алга. ЯМар ч л гэсэн ихэмсэг Эженитэй гэрлэх тухай санааширч байна гэж Альбер хэлэв.

- Таны тухай л бодож байдаг бол хамаагүй юм биш үү?
- Эрхэм гүн та тэгж бүү ярь.Хоёулаа надад их ширүүн байна лээ.
- Хоёулаа гэсэн чинь юу гэсэн үг вэ?
- Мадмуазель Эжени надтай арай гэж хариу мэндэлсэн. Дотнын найз д' Армильи нь надад хариу дуугарсан ч үгүй.
- Үгүй эцэг нь таныг хүндэтгэж байдаг биз дээ гэж Монте-Кристо асуухад,
- Тэр үү? Үгүй, миний зүрхэнд мянгантаа хутга шаасан хүн. Тэгэхдээ театрын тайзан дээр хэрэглэдэг ир нь бариул руугаа орчихдог хутга. Түүнийгээ ёстой хутга гэж бодож байгаа байх
- Хардах явдал бол хайртайн тэмдэг мөн.
- Тийм ээ, гэхдээ би хардаагүй
- Тэгвэл тэр хүн хардаад байна.
- Хэнтэй, Дебрэтэй юү?
- Үгүй, тантай.
- Надтай юү? Долоо хоног ч өнгөрөөгүй байхад тэр намайг бүү хүлээж ав гэж тушаана гэж мөрий тавья.
- Эрхэм бэйс та ташаарч байна.
- Та юугаар нотлох юм бэ?
- Т нд нотолгоо хэрэгтэй юм уу?
- Тийм.
- Морсер гүнг, Данглар дээр ирж эцсийнхээ шийдвэрийг ярилцахгүй юу гэж хэлэх онц эрхтэй төлөөлөгч нь би байна.
- Хэн танд тийм эрх олгосон юм бэ?
- Түшээ гүн өөрөө.
- Эрхэм гүн та үүнийг биелүүлэхгүй юм байгаа биз дээ? гэж Альбер чадах чинээгээрээ тал засаж эхлэв.

- Та ташаарч байна. Би амлачихсан болохоор хэлэлгүй болохгүй гэж гүн хэлэхэд Альбер санаа алдаж,

- Та намайг заавал гэрлүүлэх гээд байна аа даа гэв.

- Би бүгдтэй нь сайхан харьцаатай байх хүсэлтэй. Мартсанаас өнөө Дебрэ яасан бэ? Хатагтай Дангларынд харагдахгүй юм.

- Тэд муудалцсан.

- Хатагтайтай юу?

- Үгүй дээ, нөхөртэй нь

- Тэр нь мэдчихээ юу?

- Тоглож байх шив дээ!

- Цаадах нь сэжиглэчихсэн гэж бодож байна уу? гэж Монте-Кристо ихэд гэнэ бадлаар асуув.

- Болиоч дээ. Ингэхэд ер нь та хаанаас гараад ирсэн хүн байна аа?

- Конгоос гэж хэлье л дээ.

- Энэ тийм хол газар ч биш ээ.

- Би Парисын нөхрүүдийн зан байдлыг хаанаасаа мэдэх билээ дээ?

- Ай, эрхэм гүн минь, нөхрүүд хаана ч гэсэн адилхан. Та хүний янз бүр байдаг тухай аль нэг оронд судалсан бол бусад бүх орныхыг судалсантай адил юм.

- Тэгвэл Данглар Дебрэ хоёр юунаас болж муудалцдаг юм бол? Гэж Монте-Кристо өнөө гэнэхэн байдлаараа асуугаад—Тэд бие биендээ муугүй л байсан даа гэв.

- Үүнд л хамаг учир байна. Эндээс л Изидын¹ нууц эхэлж байгаа юм. Харин би энэ нууцыг мэдэхгүй юм. Хүү Кавальканти тэдний гэр бүлийн гишүүн болохоор л түүнээс асуугаарай.

Сүйх тэрэг зогслоо.

- За, бид хүрээд ирлээ гэж гүн хэлээд

- Одоо дөнгөж арван цаг хагас болж байна. Манайд ор л доо гэв.

- Дуртайяа зөвшөөрнө.

- Дараа нь сүйх тэрэг таныг хүргээд өгчихнө биз.

- Үгүй, баярлалаа. Миний тэрэг араас ирэх ёстой.

- Өө, тэр ирж явна гэж Монте-Кристо сүйх тэрэгнээс гарангаа хэлэв.

Тэд байшинд орж ирэхэд, зочдын өрөө гэрэлтэй байсан тул тийшээ орлоо.

- Батистен, бидэнд цай өгөөч гэж Монте-Кристо хэлэв.

- Батистен тасалгаанаас дуугүй гарлаа. Хоёрхон хормын дараа шидэт үлгэрт гардаг шиг бүх л хэрэгтэй зүйлийг тавьсан тавиуртай юм барьж ирлээ.

- Таны баялгийг би бахархахгүй байна. Магадгүй, танаас илүү баян хүн олдож болох юм. Таны ухааныг ч бахархдаг юм биш. Бомарше танаас илүү ухаантай биш байлаа ч гэсэн таны зэргийн ухаантай. Харин таны энэ хүнээр үг дуугүй, тэр дорхноо л өөртөө үйлчлүүлж чаддаг чадварыг тань гайхан бахдах юм. Тэд таны хонхны дуугаар, юу хүсэж байгаа, юу хүсэх гэж байгааг нь тааварлан мэдээд бэлэн зэлэн байлгадаг юм шиг санагдах юм.

- Энүүнд үнэний хувь бий. Миний дадал заншлыг сайн судалж мэддэг юм. Та одоо хар л даа. Цай уух үед танд ямар нэг юм хэрэгтэй болно биз дээ?

- Тэгвэл үнэнээ хэлэхэд тамхи татахаас буцахгүй байна.

Монте-Кристо хонхны зүг очиж нэг удаа дарлаа. Секундын дараа хажуугийн хаалга нээгдэж, Али латакиз хэмээх сайхан тамхи нэрсэн хоёр урт гаанс барьсаар орж ирлээ.

- Ёстой гайхамшиг юм аа! гэж Альбер хэлэхэд Монте-Кристо татгалзаж,

- Тийм биш ээ, маш амархан явдал. Али намайг цай, кофе уусны дараа тамхи татдаг заншилтайг мэднэ. Тэгэхээр намайг цай авчир гэж тушаасныг мэднэ. Бас тэгээд тантай ирснийг мэдсэн. Тэгээд л өөрийг нь дуудахаар ямар юм хэрэгтэй, яах гэж дуудаж байгааг тааварлаад нутагт нь хамгийн түрттн тамхиар зочилдог болохоор нэг гаансны оронд хоёрыг барьж орж ирсэн нь тэр.

- Тийм ээ, юм бүрд тайлбар хэлж болно. Гэвч та ганцаараа л ...гэснээ—Энэ чинь юу вэ? хэмээн гитар хөгжмийн дуу шиг дуу гарч байгаа хаалга өөд толгойгоороо дохилоо.

-Эрхэм бэйс та өнөөдөр хөгжим сонсох үйлтэй байжээ. Мадмуазель Дангларын төгөлдөр хуураас дөнгөж салтал Гайдегийн пийпаа хөгжмийн эгшиг сонсох болдог байж.

- Гайде гэнэ ээ! Сайхан нэр байна! Лорд Байроны найраглалд гардгаас өөр Гайде нэртэй хүүхэн байдаг байх нь ээ?

- Байлгүй яах вэ? Францад ийм нэр ховор тохиолддог. Харин Албани, Эпирт бол зэгсэн олон тохиолдоно. Энэ нь ариухан, цэвэр ичимтгий, гэнэ хонгор гэсэн үг юм. Танай энд адислахдаа өгдөг шиг л тийм нэр дээ.

- Ямар сайхан юм бэ! Манай франц бүсгүйчүүл мадмуазель Сайн сэтгэлт, мадмуазель Намуун, мадмуазель Хонгор сэтгэлт гэдэг нэртэй байдаг болоосой! Та бод л доо, хэрвээ мадмуазель Дангларыг Клэр-Мари-Эжени гэж дууддаггүй, харин мадмуазель Ариухан, Даруу, Гэнэн хонгор Данглар гэж дуудаж байвал ямар вэ? Хэлэхэд ёстой чимэг өгч байгаа биз?

- Солиот! Ингэж чанга бүү ярь. Гайде дуулчхаж магадгүй гэж гүн хэлэв.

- Гайде үүнд уурлах гэж үү?

- Үгүй л дээ гэж гүн ихэмсэг байдлаар хэлэв.

- Сайхан сэтгэлтэй хүн үү? Гэж Альбер асуув.

- Энэ сайхан сэтгэлийнх биш, харин үүрэг нь юм. Боол хүүхэн өөрийн эзэнд уурлах ёсгүй.

- Харин одоо та өөрөө тоглоом хийж байна шүү дээ! Одоо боол хүүхэн байдаг юм гэж үү?

- Гайде миний боол хойно байлгүй яах вэ.

- Үгүй ингэхэд таны хийж байгаа юм чинь бусад хүнийхээс огт өөр юм аа! Таны юм бүхэн бусдынхаас өөр юм. Монте-Кристо гүнгийн боол хүүхэн! Францад бүхэл бүтэн эрх ямба байдаг. Та түүнийг алтан дотор бөмбөрүүлж байна. Ийм газар жилд зуун мянган экюгийн орлого оруулдгаас зайлахгүй дээ.

- Зуун мянган экю гэнэ ээ! Хөөхрий охин илүү их хөрөнгөтэй байсан юм. Энэ охин “Мянга нэгэн шөнийн” үлгэрт гардаг баялаг дэргэд нь юу ч биш харагдахаар тийм их баялаг эрдэнэсийн дунд төрсөн юм.

- Тэгэхээр үнэхээр гүнж болж байна уу?

- Тийм ээ. Улс орныхоо дотор хамгийн нэр цуутайн нэг нь байгаа юм.

- Би бас тэгж бодсон юм аа. Гэхдээ цуутай гүнж яагаад таны боол болчихоо вэ?

- Хэмжээгүй эрхт Дионисий яагаад сургуулийн багш болчихлоо доо! Дайны гай, хувь заяаны л оноо юм байж.

- Аа, Гайдегийн гарал нь нууц уу? Бусад бүх хүнд бол тийм. Харин эрхэм бэйс танд бол өөр л дөө. Та миний найз болохоор хэрэв та ам өгвөл... хэнд ч хэлэхгүй дуугүй байж чадна тийм ээ?

- Танд тангараглая.

- Та Яниний пашийн түүхийг дуулсан уу?

- Али-Тебелиний юу? Дуулалгүй яах вэ? Манай аав түүнд алба хааж ийм хөрөнгө мөнгөтэй болсон юм чинь.

- Өө, тийм л дээ, би мартчихаж.

- Гайде Али-Тебелитэй ямар хамаатай юм бэ?

- Гайде ердөө л түүний охин нь юм.

- Юу? Алипашийн охин юм уу?

- Бас гоо үзэсгэлэнт Василикагийн охин.

- Бас таны боол хүүхэн!

- Тийм ээ.

- Яагаад энэ вэ?

- Тэгээд л тэр. Би нэг өдөр Константинополь хотын зээлээр явж байгаад худалдаж авсан юм.

- Догь хэрэг ээ! Эрхэм гүн тантай хамт байхад жирийн амьдралд биш, зүүд нойрон дунд л байгаа юм шиг санагдах юм. Би танаас нэг даруу бус зүйлийг асуухыг зөвшөөрнө үү?

- За, юу вэ?

- Та түүнтэй хамт явж харагддаг, бас Опера театрт дагуулж аваачдаг...

- Тэгээд цааш нь.

- Би танаас энэ тухай гуйж болно биз дээ?

- Дуртай юмаа гуй л даа
- Тэгвэл намайг гүнжтэйгээ танилцуулахгүй юу?
- Дуртайяа зөвшөөрнө. Тэгэхдээ хоёр зүйлийн болзол байна.
- Тэр хоёр болзлыг чинь урьдчилаад хүлээгээд авчихъя.
- Нэгдүгээрт, ингэж танилцсан тухайгаа хэзээ ч хэнд ч хэлэхгүй шүү.
- Их сайн байна. Тангараглая гээд Альбер гараа өргөв.
- Хоёрдугаарт, та аавыгаа түүний эцэгт албахааж байсан гэж хэлж болохгүй.
- Тангараглая.
- Маш сайн, бэйс. Та энэ тангарагаа санаж явна, тийм биз дээ?
- Өө, тэгэлгүй яах вэ гүн минь! гэж Альбер дуу алдлаа.
- Маш сайн. Би таныг үнэнч шударга хүн болохыг мэднэ.

Гүн дахин хонхоо дуугаргахад Али орж ирлээ. Монте-Кристо түүнд,

- Намайг орж кофе уух гэж байна гэж Гайдед хэл. Бас нэг найз нөхрөө танилцуулахыг зөвшөөрнө үү гэж байна гэж хэлээд ир гэв.

Али мэхийн ёслоод гарч одов.

- За, эрхэм бэйс, ямар ч юм шууд асуухгүй гэж тохиръё. Хэрвээ та ямар нэг юм мэдэхийг хүсвэл түүнээс өөрөөс нь биш, харин надаар дажжуулж асуугаарай.

- Тохирлоо.

Али гурав дахь удаагаа орж ирж, эзэн ба Альбер хоёрын орж болохыг зөвшөөрсөн тэмдэг болгож хөшгийг өргөхөд,

- Явъя гэж Монте-Кристо хэлэв.

Альбер халимгаа илж, сахлынхаа үзүүрийг ирмэхэд, гүн бүрх малгайгаа гартаа барьж, бээлийгээ хийгээд, үүдэнд нь Али үнэнч манаачийн ёсоор манаж, цаахан талд нь гурван франц хүүхэн Мартогийн удирдлагын доор харуул шиг зогсож байгаа лавиранд орлоо.

Гайде тэднийг хамгийн эхнийхээ өрөөнд хүлээж байсан бөгөөд Монте-Кристоос өөр эрэгтэй хүн анх орж ирсэн учир гайхан нүд бүлтийлгэж харав. Зөөлөн

олбогт вандан дээр хөлөө доороо нугалан, дорнодын хатгамалтай сайхан торгоор өөртөө үүр засчихаа юу гэлтэй дунд нь суужээ. Хажууд нь түүний байгааг илчилсэн өнөө хөгжим нь хэвтэж байв. Хаанаас нь ч харсан гоо сайхан охин байлаа.

Монте-Кристог хараад охин хүүхэд, сэтгэлт бүсгүйн байдлаар инээмсэглэн өндийв. Монте-Кристо дэргэд нь очоод гараа өгөхөд охин түүнийг урьдын адил уруулдаа хүргэв.

Альбер анх удаа үзэж байгаа бөгөөд, Францад олж үзнэ гэж бодохын аргагүй энэ гоо үзэсгэлэнг харсандаа цэл хөхрөн үүдний дэргэд зогсон хоцорлоо.

- ЧЭ над дээр ямар хүн дагуулж ирээ вэ? гэж охин грег хэлээр асуугаад –Ах дүү юу, найз нөхөр үү, таних хүн үү, эсвэл дайсан уу?гэхэд гүн мөн тэр хэлээр

- Найз нөхөр гэж хариулав.

- Хэн гэдэг юм бэ?

- Альбер, Ромд байхдаа дээрэмчдийн гараас миний гаргаж авсан нөгөө хүн шүү дээ.

- Намайг энэ хүнтэй ямар хэлээр яриулахыг хүсч байна?

Монте-Кристо Альбер өөд эргэж,

- Та орчин үеийн грег хэл мэдэх үү? Гэж асуухад,

- Орчин үеийн байтугай эртний грегийг ч мэдэхгүй, эрхэм гүн минь. Гомер, Платон хоёрт над шиг ийм унхиагүй, тэр бүү хэл хайхрамжгүй сурагч байгаагүй байх аа гэж Альбер хэлэв.

Ингэхэд Гайде Монте-Кристовийн асуулт, Альберын хариултыг ойлгосны гэрч болгож,

- Тэгвэл би гагцхүү өөрийн эзнийг хүсвэл франц, эсвэл итали хэлээр ярих уу? гэв.

- Монте-Кристо хормын хиртэй бодсоноо,

- Чи итали хэлээр яриарай гэж хэлээд дараа нь Альберт

- Та шинэ ба эртний грег хэлний алийг нь ч мэдэхгүй нь харамсалтай. Энэ хэлийг Гайде эрхэм сайн мэддэг юм. Хөөрхий охин тантай итали хэлээр ярих болох нь. Үүнээс та түүний тухай хуурмаг төсөөлөлтэй болчих вий дээ гэж хэллээ.

Тэгээд Гайде өөд дохилоо.

- Миний эзэн захирагчтай минь хамт ирсэн найз нөхөр та тавтай морилогтун гэж охин Дантегийн Гомерын хэл шиг уянга яруу болдог Ром аялгуугаар хэлээд – Алив, кофе, гаанс аваад ир! гэж хСлэв.

Тэгээд Гайде Альберыг ойртож суухыг урив. Али хатагтайнхаа тушаалыг биелүүлэхээр гарч одов. Гүн Альберт эвхмэл сандал за! өгөөд, өөрөө бас нэг тийм сандал авч, амьд цэцэг, зураг, хөгжим тавилсан жижиг ширээний хажууд суув.

Али кофе, гаанс барьж орж ирлээ. Байшингийн энэ хэсэгт Батистеныг орохыг хориглосон ажээ. Нуон хүний өгсөн гаансыг Альбер цааш түлхэв.

-Ав, ав. Гайде бол Парисын хүүхнүүдээс дутахгүй соёлжсон хүн. Муухай үнэрийг нь авч чаддаггүй учраас ороомол навчин тамхинд дургүй байдаг юм. дорнодын тамхи гэдэг чинь хүжийн анхилуун үнэр л гэсэн үг. та үүнийг мэднэ шү дээ.

Али гарч одлоо.

Кофег аяганд хийж ирсэн боловч Альберт чихрийн сав тавьжээ. Гүн, Гайде хоёр араб энэ умдааг араб ёсоор нь буюу өөрөөр хэлбэл чихэргүй ууна. Гайде гараа сунгаж, зэгзгэр нарийхан ягаан хуруугаар япон шаазанд хийсэн клфег авч уруулдаа аваачин онцын дуртай юм аа идэж байгаа хүүхэд шиг энгийн сайхнаар тамшаалав.

Энэ үед үйлчлэгч хоёр хүүхэн тавиур дээр мөс, жимсний ундаа авчраад зориулсан зассан жижиг ширээн дээр тавив.

-Эрхэм хүндэт гэрийн эзэн ба хатагтай миний гайхаж байгааг уучлаарай. Би бүр гайхаж орхиод байна. ингэж гаха ч юм байна. би хэзээ ч үзээгүй боловч хүсэж мөрөөдөж байсан жинхэнэ дорнодыг харж байна. тэгэхдээ Парис хотын төв дунд гээч! Би дөнгөж саяхан хөлсний тэргүүд давхилдаж, амтат ус зардаг худалдаачдын хонх жингэнэхийг сонсож байв... Ай эрхмүүд минь, би яагаад грег хэл сураагүй юм бол? Таны яриа энэ үлгэрийн сайхан байдалтай хослон ээ үдэш ёстой л амьдралын туршид мартаггүй үдэш болж үлдэж байна гэж Альбер итали хэлээр хэлэв.

-Би итали хэлээр хангалттай санй ярьдаг болохоор тантай ярилцаж чадна гэж Гайде тайван хариулаад – Дорнод танд сайхан санагддаг юм бол би таныг дорнодод байгаа юм шиг байлгахыг хичээе гэв.

-Би юун тухай яривал болох вэ? гэж Альбер гүнгээс асуулаа.

-За дуртай юм аа ярь л даа. төрсөн нутгийн нь тухай, залуу насны нь тухай, түүний дуртагалуудын тухай ярихгүй юу. эсвэл Ром, Неополь, Флоренцын тухай яривал дээр гэж бодож байна уу?

-Парисын хүүхнүүдтэй ярьж болох юмыг заавал грег хүүхнүүдтэй ярилцах гээд яах вэ? Тэгэхээр дорнодын тухай ярихыг зөвшөөрнө үү? Гэж Альбер хэлэв.

-Болно, болно эрхэм Альбер. энэ чинь л хамгийн сайхан санагдах байх.

Альбер Гайдегаас,

-Та хэдэн настайдаа Грегийг орхин гарсан бэ? гэж асуув.

-Тэгэхэд би таван настай байсан.

-Та эх орноо санаж байна уу?

-Намайг нүдээ анихаар л тэр нэгэн цагт үзсэн бүхэн маань харагддаг. Хүнд биеийн ба сэтгэлийн хараа гэж байдаг. Биеийн хараа нь харсан юмаа хараад мартдаг. Харин сэтгэлийх нь хэзээ ч мартдаггүй юм.

-Хэдэн настай ямар үеэсээ өөрийгөө мэддэг вэ?

-Би дөнгөж л сурч явж байсан. Миний ээж Василики, энэ үг бол дээд язгуурт гэсэн үг гэж охин хэлээд толгойгоо өргөж – Миний гараас хөтөлж, байсан бүх алтан зоосоо түрийвчиндээ хийгээд, толгойгоо бүтээж хоригдлуудад өгөхөөр олноос хишиг гуйхаар явдаг байсан юм. "Ядуу хүнд өгч байгаа см, бурханд зээлдүүлнэ" гэсэн үг гээд л гар тосдог байлаа. Тэгээд нэмж олсон зоосоор түрийвч дүүрэх дээр нь буцаж ордондоо ирж, өнөө бид хоёрын гуйлгачин гэж бодож өгсөн мөнгийг аавд хэлэлгүй сүмд аваачин өгөн, тэнд хоригдлуудад тарааж өгдөг байсан юм.

-Тэгэхэд та хэдэн настай байсан бэ?

-Гурван настай.

-Та гурван настайгаасаа эхлээд орчин тойрондоо болж байгаа зүйлсийг мэддэг болсон юм уу?

-Бүгдийг нь санадаг.

-Гүн та хатагтайг амьдралаасаа ямар нэг юм ярихыг зөвшөөрөөч. Та намайг эцгийнхээ тухай ярьж болохгүй гэж хориглосон. Гэвч хатагтай өөрөө тэр тухай ярьж магадгүй. Тэгвэл энэ сайхан амнаас зүгийнхээ нэрийг сонсоход надад тааламжтай байх болно гэж Альбер гүнд шивэгнэн хэлэв.

Гүн Гайде өөд эргэж харж хэлж байгаа юмандаа онцгой анхаар гэсэн байдалтай хөмсгөө өргөөд грег хэлээр судрын үгнээс,

-“Урвагчийн нэр, урвасан тухай нэг дурдальгүй хувь заяагаа бидэнд ярьж аль” гэж хэллээ.

Гайде хүндээр санаа алдаад тунгалаг сайхан царайд нь сүүдэр тусах шиг боллоо.

-Та түүнд юу гэж хэлэв? Гэж Морсер шивэгнэн асуув.

-Би таныг миний найз нөхөр болохоор нуугаад байх юм байхгүй гэж хэллээ.

-Тэгэхээр таны хамгийн түрүүчийн дурдатгаль чинь хоригдлуудад зориулж гуйлга гуйдаг байсан байх нь. Дараачийнх нь юу вэ?

-Дараачийнхний? Би нуурын хөвөөн дээр инжир модын дэргэд зогсож байснаа санадаг. Нуурын чичирхийлсэн мандлыг одоо ч гэсэн навчсын завсраар ялган харж байдаг. Хамгийн хөгшин саглагар мод налаад эцэг минь олбог дээр сууж байна. ээж хөлийнх нь дэргэд хэвтэж би аавынхаа цээж рүү унжсан цагаан сахал ба очир алмасаар ишийг нь чимсэн бүсэн дэх хутгаар тоглож байдаг сан. Албани зарц ирж байн байн хэдэн үг хэлэхэд нь би түүнийг огтхон ч хайхрадаггүй байв. Харин аав маань дуугаа өөрчлөхгүйгээр “Түүнийг ал” эсвэл “Би үүнийг өршөөнө” гэж хэлж байдаг сан.

-Театрын тайз дээрээс биш хагин энгийн байдлаар залуухан хүүхэн өөрийнхөө тухай ярьж байх гэж сонин юм. энэ өол зохиомол яриа биш. Харин тийм сонирхолтой өнгөрсөн үетэй тийм алс хол байсан хүнд Франц орон яаж таалагддаг байна аа гэж Альбер хэллээ.

-Франц надад сайхан орон санагддаг. Би одоо нас бие гүйцсэн хүүхэн болохоор Францыг байгаа янзаар нь харж байна. харин хүүхдийн нүдээр харж байсан эх орон минь заримдаа унасан газаар эсвэл заримдаа зовлон зүдүүрийн орон болгон хархаас шадтгаалан нэг бол баргар бараан үүлээр бүрхэгдсэн харагдана.

-Та ийм залуухан байж, хэдийдээ зовж зүдэрч амжсан билээ? гэж Альбер асуув.

Гайде гүн өөд харахад гүн бусдад үл ажиглагдах дохио өгөн грегээр шивгэнэж

-Ярь ярь гэв.

-Анхны дурдатлагаас өөр илүү сэтгэлд хаддгалагдан үлдсэн юм байхгүй. Түрүүчийн ярьсан хоёроос бусад нь миний залуу үед зовж зүдэрч явсан тухай болно.

-Ярь ярь хатагтай. Таны ярихыг сонсоно гэдэг хэлж баршгүй их аз болно гэж Альбер хэ«эхэд Гайде уйтгартайгаар инээмсГглэв.

-Тэгвэл та намайг бусад дурдатгалуудынхаа тухай ярихыг хүсэж байгаа юм уу? гэж бүсгүй асуув.

-Тэгээч гэж гуйж байна.

-За яах вэ. нэг үдэш намайг ээж минь сэрээхд би дөрвөн настай байлаа. Тэгэхэд бид Янина дахь ордодоо сууж байсан юм. ээж минь намайг унтаж байсан гудсан дээрээс өндийлгөхөд би нүдээ нээж ээжийнхээ уйлж байгааг харлаа.

Ээж надад юу ч хэдсэнгүй өргөж аваад явсан юм.

Би ээжийнхээ нулимсыг хараад бас уйлмаар санагдсан. Тэгэхэд ээж “Хүү минь дуугүй” гэв.

Ээжийг өхөөрдөх ч юм уу загнахад бусад хүүхдүүдийн адил би заримдаа дүрсгүйтэж уйлдаг л байсан. Харин энэ удаад ээжийн дуу нэг л аймшигтай санагдаад би тэр дороо уйлахаа байсан.

Ээж намайг өргөөд түргэн явав.

Тэгээд харвал ояд өргөн шатаар бууж явлаа. Бидний өмнө ээийн шивэгчингүүд сав, шуудай, гоёл чимэг% үнэт эдлэл, алттай түрийвч барьж зугтах мэт гүйлдэн явна.

Эмэгтэйчүүдийн араас урт зэвсэг гар буутай би? Хамгаалагч хориод хүн Грегийг дахин тусгаар тогтносон улс болсноос хойш Францынхны мэдэх болсон тийм хувцастайгаа явж байлаа.

Нойрноосоо бүрэн сэрээгүй яваа боол шивэгчингүүдийн энэ цувааг харахад нэг л аямшигтай юм болж байгаа мэь санагдсан билээ. би нойрноосоо бүрэн сэрээгүй болохоор тэд нойрмог ч юм шиг харагдсан байж болох юм гэж Гайде толгой сэгсрэн хувхай цайн өгүүлээд- Давирхайн бамбараас тусаж байгаа гэрлээс үүсэн том том хар сүүдрүүд шатан дээр сүүтэгнэнэ.

“Бушуулаа°ай” гэж нэг хүн хонгилын дундаас хэлэх сонстов.

Тариалангийн талд салхи хөдлөхөд тариан толгой найга бөхийдөг шиг энэ дууг дуулсан хүмүүс тийшээ бөхийж байв.

Би ч гэсэн энэ дууг дуулаад цочив.

Энэ бол миний аавын дуу байв.

Аав намайг тансаг сайхан хувцастайгаа танай эзэн хааны бэлэг болгож өгсөн карбин буу бариад, өөрийн хайртай Селимийг түшин, малчин хүн айсан сүргээ тууж яваа юм шиг биднийг өмнөө хөөнө.

-Миний эцэг бол гэж Гайде толгойгоо өргөж –Яниний паш хаан их хүн байсан юм. Европт түүний нэрийг Али Тебелин гэж мэддэг бөгөөд түрүүнд түүний өмнө чичрэн догдолж байсан гэдэг юм.

энэ өгүүлэн хэлэхийн аргагүй бардан бахархан хэлсэн нэрийг дуулаад Альбер өөрийн эрхгүй цочив.

Аймшигт үхэл, орчин үеийн европын нүдний өмнө тэгж их өндөрт өргөсөн хүний цуст сүүдрийг залуу бүсгүй өндөлзүүлэхдээ нүд нь аймшигтай гялалзаж байв.

-Удалгүй цуваа зогслоо. Бид нуурын эргийн дэргэдэх доод шаьан дээрээ хүрч ирэв. ээж хүндээр санаа алдаж намайг элгэндээ чанга тэвэрч байв. Ээжийн ар талд аав зогсож түгшүүртэй байдлаар тал тал тийш харна.

Бидний өмнө дөрвөн гантиг шат байх бөгөөд доод шатны дэргэд завь даавилзан хөвж байв.

Харанхуйгаас болоод тэгсэн ч юм уу их хол харагдаж байлаа.

Бид завиндаа сууцгаалаа. Сэлүүрүүд огт чимээгүй усанд хүрч байсныг би санаж байна. би сэлүүр харах гэж бөхийлөө. Сэлүүрүүдийг манай зарц нарын бүсээр ороосон байв.

Завь дотор сэлүү°дэгчдээс гадна эмэгтэйчүүд, аав ээж, Селим бид хэд байв.

Хэрвээ хойноос хөөвөл дээд талын гурван шатыг халхалт болгон ашиглахаар цэргүүд шатны хамгийн доод талд эрэг дээр сөхөрсөн хэвээрээ үлдэв.

Манай завь сум шиг хурдлан явав.

“Завь яагаад ийм хурдан явж байна?” гэж би ээжээсээ асуухад,

“Хүү минь, чимээгүй. Бид зугтааж яваа болохоор тэр” гэж хэлсэн юм.

би юу ч ойлгохгүй байв. Бүхнийг яадагч аав минь яагаад зугтаах болов? Түүний өмнө бусад хүмүүс гүйж, тэд надаас айдаг болохоор үзэн ядаж байгаа юм гэдэг уриатай байсан.

Одоо эцэг минь үнэхээр зугтан амь дүйж байв. Сүүлд нь надад Яниний цэргийн анги удаан хугацааны албанаас болж ядраад... гэж хэлэв.

Гайде тэгж хэлээд өөрөөс нь нүд салгалгүй харж байсан гүн өөд учиртайхан харав. Тэгээд залуу бүсгүй ямар нэг юмыг зохиож байгаа буюу орхин ярьж байгаа хүний янзаар үргэжлүүлэн ярих гэтэл маш анхааралтайгаал сонсож суусан Альбер тосож аваад,

-Хатагтай та Яниний цэргийн анги удаан хугацаанаас болж ядраад... гэж хэлээд зогссон шүү дээ гэж хэлэв.

-Тэгээд аавыг минь бариулахаар Султын явуулсан цэргийн сайд Куршидтай үгээ олоцжээ. Тэгэхээр нь миний эцэг бүрэн итгэж байсан франц офицероо урьдчилан Султан хаанд явуулаад, өөртөө урьд нь бултгэсэн байсан амь хорогдох жижиг Файзанд очиж нуугдахаар шийджээ.

-Аа, та тэр франц офицерын нэрийг санаж байна уу? гэж Альбер асуув.

Гүн Гайде хоёр цахилгаан мэт хурдан харц солилцсоныг Альбер ажиглан харж чадсангүй.

-Үгүй би нэрийг нь мартчихаж харин дараа нь санавал хэлье гэж охин хэлэхэд Альбер эцгийнхээ нэриг хэлэхээр завдтал гүн түүн өөд харж болгоомжлуулан хуруугаа гозойлгов. Альбер өгсөн тангаргаа санаад юу ч хэлсэнгүй.

-Тэгээд бид хоргодох газар өөд хөвлөө гэж Гайде хэлэв.

-Биднийг тэрхүү бяцхан ордонд очиход, хээ угалзаар чимэглдэсэн доод давхар, усан дээр цухуйж гарсан саравчит тагт нуур уруу цонх нь харсан хоёрдугаар давхар л харагдаж байв.

Харин доор нь арлын гүн рүү явсан газар доорх агуй байв. Тэр руу ээж бид хоёр, шивэгчингүүдийг оруулав. Тэр жаран мянган ширхгэ түрийвч, хоёр зуун торх байв. Түрийвчинд хорин тавагн сач алтан зоос, торхонд нь мянгаад пүү парь байсан юм.

Эдгээр торхнуудын дэргэд эцгийн хайр хүн, түрүүчийн миний хэлсэн Сеоим зогсов. Тэр үзүүр дээр нь бамбар асаасан жад барьж өдөр шөнөгүй хамгаалан зогсож байв. Эцгийн минь анхын дохиогоо тэнд байсан бүх зүйл: хоригдох газар, бие хамгаалагчид, паш, эмэгтэйчүүд алтыг юуны өмнө устгах тушаал өгсөн байв.

Манай шивэгчингүүд үүнийг мэдчихээд өдөр шөнөгүй уйлан залбирч байсныг би санаж байна.

Тэр мойл хар нудтэй цагаан царайтай залуу дайчин миний нүдэнд дандаа харагддаг юм. Над дээр үхлийн элч чигаа тэнгэр ирэхэд Селим байна гэж би танина даа.

Бид хичнээн хугацаа ингэж өнгөрүүлснийг мэдэхгүй. Би тэр үед цаг хугацааг мэддэггүй байсан юм. хааяа нэг аав маань ээж бид хоёрыг ордны саравчинд дуудаж аваачихад нь их л жаргалтай хэдэн цаг болдог байлаа. Надад газар доорхи хонгил нүдэнд зөвхөн гиншсэн сүүдэр, Селимийн гал улалзсан жад л харагдана. Эцэг маань хонгилын том амсар дээр сууж нуурын мандал дэр гарч ирэх бараан цэг бүхнийг

ажиглан сууна. Ээж минь мөрөнд нь толгойгоо наана налж суух бөгөөд би аавынхаа хөлийн дэргэд тоглож, орчин тойронд байгаа юмнуудаа байгаа хэмжээнээс илүү том болж харагддагийг гайхан, тэнгэрийн хаяанд байгаа Пинда уул, нуурын цэнхэр усан дээр цайран харагдах Яниний цайзыг, холоос бод хөвдөнд хучигдсан асга хад гэлтэй, ойроос бол асар том нарснууд болох бөөн ногоон модыг сонирхон хардаг байв.

Нэг өглөө аав биднийг дуудуулжээ. Нэлээд тайван боловч ердийнхөөсөө цонхигор царайтай байв.

“Василики минь жаахан тэсэж үзээрэй. Өнөөдөр бүх зүйл төгсгөл болно. Өнөөдөр эзний гарын үсэгтэй зарлиг ирж, миний хувь заяа шийдвэрлэгдэнэ. Хэрэв би өршөөл уучлал хүлээн авбал бид Яниндаа баяр баясгалантай буцаж очино. Хэрэв муу мэдээ ирвэл бид өнөө шөнөдөө зугтаана” гэж аав хэлэв.

“Хэрэв биднийг зугтаахгүй бол яах вэ?” гэж ээжийг асуухад аав инээмсэглэж

“Өө битгий зов. Селим өөрийн гал бадарсан жадаараа тэдний өмнөөс хариугий нь өгнө. Тэд зөвхөн намайг үхүүлэх гэж хүсэж байгаагаас биш надтайхамт үхэхийг хүсэхгүй байгаа юм” гэв.

Аавын энэхүү үнэн зүрхнээсээ хэлээд тайвшруулах үгийг сонсоод ээж минь зөвхөн санаа алдлаа.

Ээж түүндмөстэй ус бэлтгэн өгөх бөгөөд аав зугтааж ирснээсээ хойш чичрэг туссан болохоор зогсолтгүй ууна. Ээж түүний буурал сахланд сайхан үнэр шингээж гаанс тамхийг нь асааж өгнө. Тэгэхэд аав мушгиралдан гахар утааг ажиглан бүтэн цаг алмайрч сууна.

Нэг өдөр аав гэнэт хачин давхийн хөдлөхөд би айлаа.

Дараа нь анхаарлыг нь татсан цэгээс нүдээ салгалгүй дуран авай өгөхийг тушаав.

Ээж түүнд дурамбай өгөв. Ээжийн царай түшсэн баганаасаа илүү цагаан байж билээ.

Аавын гар чичирч байсныг би харсан юм.

“Завь!...хоёр!...гурав!..дөрөв!” гэж шивгэнэ тоолов.

Тэгтэл аав босож буугаа шүүрэн аваад дарь хийн цэнэглэснийг нь санаж байна.

“Василики, бидний хувь заяа шийдвэрлэгдэх цаг ирлээ. Бид хагас цагийн дараа эзний хариуг мэдэх болно. Гайдег аваад хонгил руу орж бай” гэж аав хэлэхэд ээж чичирч байх нь харагдаж байлаа.

“Би таныг орхиж явахыг хүсэхгүй байна. миний эзэн та үхэх учиртай юм бол би тантай хамт үхэх хэрэгтэй” гэж ээж хэлэхэд аав,

“Селимийн байгаа тэр газар оч!” гэж хашхирав.

“Захирагч эзэн минь баяртай” гэж ээж дуулгавартай шивгэнээд үхлийг угтайн зрогсох мэт мэхийн ёслол. Тэгэхэд аав цэргүүдэд,

“Василикийг аваад яв” гэж хэлэв.

Тэр зуур мартагчихаад байсан би аав дээрээ гүйн очиж гараа сунгав. Аав намайг хараад бөхийж духан дээр минь уруулаа хүргэсэн юм.

Энэ бол намайг хамгийн сүүлчийн удаа үэссэн нь бөгөөд одоо хүртэл духан дээр минь халуу оргиж байдаг юм.

Бид доошоо бууж явахдаа усан үзмийн моддын завсраар завьнууд ирж явахыг харав. Тэдгээр завьнууд томорч, саяхан хар цэгүүд байснаа усан дээгүүр нисэж байгаа мэт харагдана.

Тэр үед хорин цэцэг эцгийн минь хөлний дэргэд шатны хашилтын ард нуушдан, бууга бэлэг зэлэн барьж цус хурч улайсан нүдээр онгоцнуудыг харж байв. Аав байн байн цаг уруу харж хойш урагшаа түгшүүртэй байдлаар алхална.

Би аавдаа сүүлчийн даа үнсүүлчхээд холдон явахад надад санаанд үлдсэн юм энэ л байлаа.

Ээж бид хоёр газар доорхи хонгил нүхэнд оров. Селим бас л хуучин газраа зогсож байв. Тэр биднийг хараад гунигтагйаар инээмсэглэв. Бид хонгилын үзүүрээс жинтүү авраад Селимийн дэргэд суув. Их аймаар юм болоход үнэнч хүний дэргэд байхыг хүсдэг. Би тэр үед хэдий жаахан байсан ч , бидэнд нэг л их аюул тулгарах нь гэдгийг мэдэж байв...

Альбер Яниний эзний сүүлчийн минуутуудын тухай эцгээсээ биш харин өөр улсаас байнга дуулж, үхлийн тухай олон өгүүллэг уншжээ. Харин эцэг нь энэ тухай юу ч ярьдаггүй байв. Гэтэл Гайдегийн дуу хоолой харцанд амилсан энэ түгшүүр гунигтай туужийг сонсоод айх гахай зэрэгцэнэ.

Аймшигт дурдатгалийн эрхэнд автсан Гайде хэсэг зуур дуугүй болов. толгой нь их салхины өмнө гудайсан цэцэг адил бөхийж, манарсан нүд нь ногоорон байгаа

Пинда уул өөрийн саяхан дүрслэн зурсан гунигт зураг гэрэлтэн байх шиг харатгдах шидэт толь мэт Яниний нуурын цэнхэр усыг харж байх шиг байв.

Гүн бүсгүйг хэмжээлшгүй их өрөвдсөн хариласан байдлаар харж,

-Охин минь, цааш нь ярь гэж грег хэлээр хэлэв.

-Дөрвөн цаг болж байв. Гадаа тунгалаг сайхан өдөр байсан боловч газар доорхи хонгил дотор баргар муухай байлаа.

Агуй дотро өнчин ганц оод мэт нэгэн гэрэл байсан нь Селимийн барьж байсан бамбар байв.

Миний ээж христосын шашинтай хүн байсан болохоор залбирсаар байлаа.

Селим байсхийгээд л гэгээн номын үг “Аугаа их Аллах” гэж хэлнэ.

Ямар ч гэсэн ээж бага зэрэг горьдож байжээ. Ээж хонгил уруу бууж явахдаа аавын өмнө өнөө итгэж Константинополь уруу явуулсан франц хүн ирж байхыг таньжээ. Ер нь франуын султаны дайчдыг бодь сэтгэлтэй сайхан санаатай хүмүүс гэж үздэг байсан юм. ээж шатанд ойртож очоод чагнав.

“Тэд дөхөж явна. Халаг минь, амьдрал найрамдлыг минь л авч ирээсэы” гэж хэлэв.

Тэгэхэд Селим зөөлөн эелдэг боловч бардам байдлаар,

“Юасилики чи юунаас айсан юм бэ? Хэрэв тэд бидэнд энх тайвныг авчирч өгөхгүй юм бол бид тэдэнд үхлийг бэлэглэнэ” гэв.

Тэгээд жадан дээрх галаа асаахад түүний энэ хөдөлгөөн нь эртний Критийн Дионес шиг харагдав.

Гэвч би тэнэг жаахан амьтан болохоороо хатуу ширүүн, ухаангүй юм шиг санагдсан энэ зоримог байдлаас айж агаар тэнгэр гал дөлөнд үхэхээс эмээж байв.

Ээжид ч мөн тэгж санагдав бололтой, чичрэхийг нь би мэдсэн юм.

“Бурхан минь, ээжээ өби ингээд үхэх юм уу” гэж би дуу алдлаа.

ШЁвэгчин боол хүүхнүүд миний хэлэхийг дуулаад улам ангаар гиншин хашхиралдаж залбирч гарав.

“Бурхан чамайг өнөөдөр айж байвч, дараа үхэхийг өөрөө хүсэх тэр өдөр болтол чинь авран тэтгэх болно” гэж ээж надад хэлэв.

Дараа нь ээж Селимээс арай дуулдах төдийгөөр “Эзэн чамд ямар тушаал өгсөн бэ?” гэ асуув.

“Хэрэв тэр надад султан хаан уучлахгүйн тэмдэг болгож чинжаалаа ирүүлбэл би бүгдийг дэлбэлнэ. Хэрвээ бөгжөө ирүүлбэл уучилсны тэмдэг болж би даринь зоорийг тавьж өгнө” гэж Селимиг хэлэхэд,

“Найз минь, хэрвээ эзэн хутгаа ирүүлбэл биднийг тэр аймшигт үхлээр бүү үхүүлээрэй. Бид яамд хоолойгоо тавьж өгөхөд би тэр хутгаараа биднийг алаарай” гэв.

“За Василики” гэж Селим тайван хариулав.

Гэнэт чанга чанга дуугарах дуу сонстлоо. Бид чагнавал баярласан хашхиралдаан байв. Манай цэргүүд Константинопольд явуулсан өнөөх форанц цэргийн нэрийг хэлж хашихиралдан байв. Тэр хүн их эзний хариуг авч ирсэн нь тодорхой бөгөөд энэ хагриу нь тааламжтай сайхан нь илэрхий байв.

-Та нэрийг нь санахгүй байна уу? гэж Морсер ярьж байгаа бүсгүйн санаанд оруулчихад бэлэн байдалтай асуулаа.

Гүн түүнд өөд дохив.

-Би санахгүй байна гэж Гайде хариу өгүүлээд – Дуу чимээ улам нэмэгдэв. Ойртож байгаа хөлийн чимээ сонстож нэг хүн хонгил уруу бууж ирэв.

селим жадаа бэлхэн барьж байв.

Удалгүй хонгилын аман дэр өдрийн гэрлээс болж үүссэн бүрэнхий дунд нэгэн сүүдэр зогсож байв.

“Чи хэн бэ? хэн ч байсан нэг ч алхам урагш бүү хөдөл!” гэж Селим хашхирахад нөгөө сүүдэр,

“Султан хааны алдар бадартугай. Эзэн ноён Али бүрэн өршөөгдсөн. Зөвхөн түүний амийг өршөөгөөд зогсохгүй, эд баялгийг нь буцааж өгсөн” гэж хариу хэлэв.

Ээж минь баяртайгаар хашхираад намайг зүрхэндээ тэврэн наалдууллаа.

Ээжийг үүд рүү гүйхийг хараад Селим,

“Зогсоорой! Би бөгж хүлээн авах ёстойг чи мэднэ шүү дээ” гэв.

“Тэр үнэн” гэж ээж минь хэлээд өвдөг дээрээ мөхөрч, миний төлөө бурханд мөргөхдөө намайг түүнд ойртуулах гэсэн юм шиг намайг дээш өргөж байв.

Сэтгэлийн ийм хөдөлгөөнд автсан Гайде дахин дуугүй болоход цонхийсон удхан дээгүүр нь хөлс бурзайж, хатсан хоолойноос нь дуу гарч чадахгүй байх шиг харагдав.

Гүн мөстэй аяганд ус хийж өгөөд эелдэг боловч захирангүй дуугаар,

-Хүү минь зоригтой бай гэж хэлэв.

Гайде гнүд духаа арчичхаад,

-Тэр завсар харанхуйд дассан бидний нүд пашийн явуулсан хүнийг танив. Энэ бол манай нөхөр найз байв.

Селим түүнийг бас танисан боловч зоригт залуу, зөвхөн захиргдах гэдэг үгийг сайн мэддэг хүн байв.

“Чи хэний нэрийн өмнөөс ирэв?”

“Би манай эзэн Аль-Тебелений нэрийн өмнөөс ирэв.”

“Хэрвээ би Алийн нэрийн өмнөөс ирсэн бол надад юу өгөхөө мэдэх ёстой.”

“Мэднэ ээ, би чамд түүний бөгжийг авчрав” гэж ирсэн мүн хариулав.

Тэгээд гараа толгой дээрээ өргөв. Гэвч бидний зогсож байсан газраас Селим тэр хүний үзүүлж байгаа юмыг ялган танихад дэндүү хол, хүрэлцээтэй гэрэлгүй байв.

“Чиний гарт юу байгаа харахгүй байна” гэж Селим хэлэхэд ирсэн хүн,

“Чи нааш дөхөөд ир, эсвэл би чам уруу очье” гэж хэлэв.

“Аль нь ч болохгүй. чи надад үзүүлж байгаа юм аа гэрэлд харагдах газар өөрийнхөө байгаа газар тавиад намайг харах хооронд цаашаа яв” гэхэд,

“За сайн” гэж ирсэн хүн хэлээд барьж байсан юмаа газар тавиад цаашаа явав.

Бидний зүрх булгилан цохилж байв. Бидэнд нээрээ л бөгж байх шиг харагдав. Гэхдээ эцгийн минь бөгж мөн үү?

Селим асаалттай бамбараа гараасаа салгалгүй дөхөж очоод бөгжийн авч харснаа

“Эзний бөгж мөн байна гэж хэлэнгээ үнэсээж – За сайн” гэж хэлэв.

Тэгээд бамбараа газар уруу хаяж хөлөөр дэвсэн унтраав.

Ирсэн хүн баярлан хашхирч алгаа ташив. Энэ дохиогоор Куршидын дөрвөн цэрэг гүйж ирээд таван чинжаалд сүлбүүлсэн Селим газар унав.

Айн зэвхийрсэн хэвээр байсан боловч ялт хэргэндээ улайрсан цэргүүд хонгил уруу гүйлдэн орж энд тэнд гал байгаа эсэхийг хараад хүүдийтэй зооснууд уруу дайрлаа.

Тэр завсар ээж миний гараас шүүрэн, аймшигт шуугиан дэгдэж байсан тал уруу гардаг зөвхөн бидний мэддэг нууц шатаар гүйв.

Тасалгаа нь маниад дайрсан Куршидийн цэргээр дүрэн байлаа.

Ээж хаалгаа онгойлгох гэтэл аавын аймшигт дуу дуулдана. Тэгэхэд ээж банзны завсраар шагайв.

Миний өмнө санамсаргүй нэгэн нүх тохиолдож би түүгээр харав. Тэгэхэд аав алтан үсэг бичсэн бичиг барьсан хүмүүс өөд харж,

“Та нарт юу хэрэгтэй вэ” гэв.

Тэгэхэд тэдний нэг нь,

“Бид яамд эрхэм дээд эзний санаа зоригийг хэлэх гэсэн юм. Чи энэ зарлигийг харж байна уу?”

“Харж байна” гэж миний аав хэлэв.

“Тэгвэл унш, тэр чиний толгойг авчрахыг шаардаж байна” гэхэд миний аав ямар ч аюул заналхийллээс илүү аймшигтайгаар тачигнатал хөхрөв.

Хоёр гар бууны гохыг дараахдаа бас л инээсээр байв. Буун дуу хоёр дуугарч хоёр хүн үхэдхийн ойчив.

Аавыг тойрон хэвтэж байсан торгон цэргүүд гал нээж, тасалга дүүрэн нүргээн, гал дөл утаа боллоо.

Эгшин зуурын дотор нгөө талаас гал нээж буун сум бидний хажуу талын самбарыг цоо цохив.

Миний эцэг Али-Тебелин дарийн утаанд нүүр нь харлаж, гартаа тахир сэлмээ барин сумны исгэрээн дунд зогсох нь ямар сайхан ямар их агуу байсан гэж санана!

“Селим Селим гал хадгалагч минь, үүргээ биелүүл” гэж хашхирч байв.

“Селим алагдсан эзэн ноён Али минь чи бас өнгөрлөө” гэж хонгилоос нэг хүн хэлэв.

Тэгээд бүдэг чимээ гарч эцгийн минь хөл доорхи шат бутран цацрав.

Цэргүүд шалын завсраар буудаж байв. Гурав дөрвө торгон цэрэг доороосоо буудсан суманд сийчигдэн унав.

Эцэг хүнгэнэн дуугарч, сум цоо цохисон банзны нүхэнд хуруугаа хийж шаднаас бүтэн банз ховх татан авав.

Гэтэл энэ нүхээр нь хориод бууны дуу нирхийж, гал уулын тогооноос утаа оргилох мэт дарийн утаа нүргэлэн бүрхэв.

Энэ аймшигт шуугиан чимээ, хашхиралдааны дундаас бууны хоёр чанга дуу хоёр удаа зүрх шимшрэн хашхирах дуу зүрх хагалчих шахав. Энэ бууны дуу эцгийг минь үхтэл шархдуулж аав минь тийм аймшигтайгаар хашхирсан байв.

Гэвч тэр цонхноос зууран зогссоор байв. Ээж минь түүнтэй хамт үхэх гэж хаалгыг бүх хүчээрээ татсан боловч дотроосоо түгжээтэй байсан тул онгойсонгүй.

Түүний дэргэд торгон цэргүүд үхэхийнхээ өмнө татганан байх нь харагдана. Тэдний дотроос шархдаагүй эсвэл хөнгөн шархадсан хоёр гурван хүн цонхоор үсрэн гарлаа.

Тэр үед доороос нь цохисон хүчтэй цохилтын үед шал дэлбэрлээ. Аав өрөөсөн өвдөг дээр ойчход сэлэм, буу, хутгаар зэвсэглэсэн хориод гар цухуйн гарч, ганц хүнийг хорин хүн цохиж эцгийг минь хөл доор там буцлах галт шуурга хашхиралдаан болов.

Би газар ойчих шиг болсны учир нь ээж ухаан алджээ.

Гайде гиншин дуугарч гар нь өвдөг дээрээ ойчин, түүний үүргийг дуулгавартай биелүүлсэнд сэтгэл хангалттай байна уу гэсэн янзтай гүн өөд харав.

Гүн босож түүний дэргэд очиж гараас нь барьж грег хэлээр,

-Амар хонгор минь. урвагчдийг залхаах бурхан бий гэдгийг санаж бай гэж хэлэв.

-Ямар аймшигтай явдал вэ гүн минь гэж Альбер Гайдегийн цайра зэвхийсэн байхыг хараад – Би ийм аймшигтай юм сонирхсоноо өөрийгөө хатуу ширүүнээр зэмлэж байна гэв.

-Зүгээр гэж гүн хэлээд бүсгүйн гудайсан толгой дээр гара тавиад –Гайде зоригтой охин байгаа юм. заримдаа өөртөө тохиолдсон зовлон зүдгүүрийн тухай ярихаараа дотор нь онгойх шиг болдог юм гэв.

Тэгэхэд Гайде

-Надад тохиолдсон зовлон зүдгүүрийг ярихад таны сайхан сэтгэлийн ач тус санагддаг учраас тэгдэг юм гэж сэргэлэн нь аргагүй хэлэв.

Альбер бүсгүй өөд сонирхон харна. Гайде, түүний хамгийн их сонирхсон юмнаас, өөрөөр хэлбэл яагаад гүнгийн шивэгчин болсон тухай ч ярьсангүй.

Гүн Альбер хоёрын нүдэнд нэгэн янзын хүсэл байхыг хараад Гайде мэдрэв.

Тэгээд цааш үргэлжүүлэн,

-Ээж минь ухаан ороход бид хоёр куршийн цэргийн даргын өмнө ирчихсэн байв.

“Айлын бэлэвсэн эхнэрийн нэр хүндийг бодож намайг алаад орхи” гэж ээж минь хэлэхэд Куршид,

“Надад бүү хэл” гэв.

“Тэгвэл хэнд хэлэх юм бэ?”

“Шинэ эзэндээ хэлэхгүй юу?”

“Хэн юм бэ?”

“Тэр зогсож байна”

тэгээд Куршид эцгийг алагдахад хамгийн их оролцсон нэгэн хүнийг заав гэж хэлээд Гайде хорсолтойгоор нүдээ гялалзуулав.

-Тэгээд та тэр хүнийхээ өмч болоо юу? гэж Альбер асуухад, Гайде,

-Үгүй, тэр биднийг өөртөө авч байхаас айж, Констатинополь орж явсан эзэн хаанд татвар эмс олж өгдөг нэг хүнд худалдчихсан юм. бид бүх Грегийг туулж, хагас үхсэн амьтад эзэн хааны ордны хаалган дээр хүрч ирсэн билээ. ордны өмнө талд сонирхсон хүмүүс бөөгнөрсөн байв. Тэд бидэнд зам тавьж хоёр тийшээ болов. ээж бүхний хараа чиглэсэн тэр зүг рүү хараад хаалган дээр жаданд өлгөсөн хүний толгой өөд заагаад ухаан алдан унав.

Толгойн доор,

“Яниний паш АлиТебелений толгой энэ байна” гэж бичсэн байв.

Би уйлан хайлж ээжийгээ босгох гэсэн боловч тэр минь амьсгаа хураачихсан байв.

Тэгээд намайг зах дээр аваачив. Намайг нэг баян армян хүн худалдан авав. Тэр намайг хүмүүжүүлж, багш нар гарган өгч хичээл заалгаж байгаад арван гурав хүргээд султан Махмудад худалдсан юм.

-Би түүнээс нь танд үзүүлж байсан гашишийн үрэл хийдэг савтай ижил ногоон маргад чулуугаар худалдаж авсан юм гэж гүн хэлэв.

-Өө, миний эзэн та сайн санаатай их хүн гэж Гайде хэлээд гүнгийн гарыг үнсэж – Би таных болсондоо баяртай байдаг юм гэлээ.

Альбер сонссон бүхэндээ алмайран гайхжээ.

-Кофегоо уугаад дуусгачих одоо яриа дууслаа гэж гүн түүнд хэллээ.

Эх сурвалж:

www.e-pada.com

Формат, фонт зэргийг бага зэрэг янзалж pdf
хэлбэр уруу хөрвүүлсэн:

mongolnom.blogspot.com